СЭХ
2026.09.10
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2026-09-02
БҮРТГЭВ-03

ШУНХЛАЙ-4

НЭЭЛТТЭЙ БОНД

Андеррайтер:	Зээлжих зэрэглэлийн компани:	Хуулийн зөвлөх:	Аудитын компани:
Golomt Capital Delivering diversity	Mongolian Investment Rating Agency	LEGAL POLICY Law Firm	

АГУУЛГА

АГУУЛГА 2
ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ 3
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ 4
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ 4
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР 5
ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД 6
ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУД 7
ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА 8
1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ 11
1.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА 11
1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ 11
1.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН БҮТЭЦ 13
1.4 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХАМААРАЛ БҮХИЙ ЭТГЭЭДҮҮД 14
1.5 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ 17
1.6 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУДЫН МЭДЭЭЛЭЛ 18
1.7 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ИХ ХЭМЖЭЭНИЙ, СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ, ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН 5 ХУВИАС ДЭЭШ ДҮНТЭЙ ХЭЛЦЛҮҮД 22
1.8 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ӨМНӨ ГАРГАСАН ҮНЭТ ЦААСНЫ МЭДЭЭЛЭЛ 24
1.9 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА 24
2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ 32
3. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ 44
3.1 ОЛОН НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ 44
3.2 БОНДЫН ХҮҮ ТОГТООСОН ҮНДЭСЛЭЛ 45
3.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛ 46
3.4 ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ 47
3.5 ҮНЭТ ЦААСААР ГЭРЧЛЭГДЭХ ЭРХ, ҮҮРЭГ 47
3.6 ҮНЭТ ЦААСЫГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД АРИЛЖААЛАХ 48
4. БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ 54
4.1 ДУНД БОЛОН УРТ ХУГАЦААНЫ БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ 54
4.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН ТӨСӨӨЛӨЛ 54
5. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНД УЧИРЧ БОЛОХУЙЦ ЭРСДЭЛ 60
6. ҮНЭТ ЦААС ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД 65
6.1 АНДЕРРАЙТЕРИЙН КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА 65
6.2 ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛИЙН КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА 65
6.3 ХУУЛИЙН ФИРМИЙН ТАНИЛЦУУЛГА 66
6.4 АУДИТЫН КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА 67
6.5 ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУД НЬ НЭГДМЭЛ СОНИРХОЛ, БИЗНЕСИЙН ХОЛБОО ХАМААРАЛТАЙ ЭСЭХ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ 68
7. ХАВСРАЛТ 70

2026.08.31

ШУНХЛАЙ
он сар өдөр
2025 09 10
№ 01

МОНГОЛ УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2026 -09- 02
БҮРТГЭВ-03

7. ХАВСРАЛТ 70
7.1 Үнэт цаас гаргах тухай шийдвэр 70
7.2 Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэлийн гэрчилгээ 73
7.3 Үнэт цаас гаргагчийн дүрэм 76
7.4 Үнэт цаас гаргагчийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээ 84
7.5 ТОП-100 аж ахуйн нэгжээр шалгарсан тухай тодорхойлолт 86
7.6 Аудитын компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ 87
7.7 Аудитын компанийн тусгай зөвшөөрөл 89
7.8 Аудитын компанитай хийсэн гэрээ 90
7.9 Аудитын компанийн тодорхойлох захидал 94
7.10 2024 оны аудитын тайлан 96
7.11 2025 оны аудитын тайлан 141
7.12 2026 оны 6-р сарын 30-ны өдрөөр тасалбар болгосон аудитлагдсан санхүүгийн тайлан. 161
7.13 Андеррайтерийн улсын бүртгэлийн гэрчилгээ 181
7.14 Андеррайтерийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээ 183
7.15 Андеррайтерийн гэрээ 185
7.16 Андеррайтерийн тодорхойлох захидал 196
7.17 Зээлжих зэрэглэл тогтоогч компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ 202
7.18 Зээлжих зэрэглэл тогтоогч компанийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээ 204
7.19 Зээлжих зэрэглэл тогтоогч компанитай байгуулсан гэрээ 206
7.20 Зээлжих зэрэглэлийн үнэлгээний тайлан 219
7.21 Хуулийн фирмийн улсын бүртгэлийн гэрчилгээ 232
7.22 Хуулийн фирмийн тусгай зөвшөөрлийн тодорхойлолт 234
7.23 Хуулийн зөвлөх үйлчилгээний гэрээ 235
7.24 Хуулийн дүгнэлт 242
7.25 Оролцогч талуудын сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдэл 346
7.26 Бондын гэрээ 351
7.27 Үнэт цаас гаргагчийн 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайлан 357

УЛААНБААТАР ХОТ
ШҮҮХЛАЙ ХХК
УА3531 ☎ 2028408

Голомт Капитал ХХК
Golomt Capital
Delivering diversity
1119289111 ☎ 5485589
Улаанбаатар хот

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Үнэт цаасны нөхцөл 8
Хүснэгт 2. Үнэт цаас гаргагчийн товч танилцуулга 11
Хүснэгт 3. Толгой компани Шунхлай Холдинг ХХК-ийн товч танилцуулга 13
Хүснэгт 4 .Шунхлай Газрын Тосны бизнес группт хамаарах компаниудын мэдээлэл 14
Хүснэгт 5. Шунхлай Холдинг ХХК-ийн эзэмшилд хамаарах голлох компаниуд 15
Хүснэгт 6. Шунхлай ХХК-ийн ТУЗ-ийн гишүүд 18
Хүснэгт 7. Их хэмжээний хэлцлийн дүн, сая төгрөгөөр 23
Хүснэгт 8. Өмнө гаргасан үнэт цаасны мэдээлэл (транч тус бүрээр) 24
Хүснэгт 9. Үнэт цаас гаргагчийн орлого, үр дүнгийн тайлан, сая төгрөгөөр 25
Хүснэгт 10. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдлын тайлан, сая төгрөгөөр 28
Хүснэгт 11. Үнэт цаас гаргагчийн мөнгөн гүйлгээний тайлангийн голлох үзүүлэлтүүд, сая төгрөгөөр 30
Хүснэгт 12. Монгол улсын макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүд 32
Хүснэгт 13. Бодит ДНБ-ий өсөлтийн төсөөлөл, хувиар 33
Хүснэгт 14. Инфляцын төсөөлөл, хувиар 34
Хүснэгт 15. Дэлхийн газрын тосны эрэлт, боловсруулсан бүтээгдэхүүний төрлөөр 37
Хүснэгт 16. ОХУ-ын газрын тосны бүтээгдэхүүний экспорт, төрлөөр 39
Хүснэгт 17. БНХАУ-ын газрын тосны бүтээгдэхүүний экспорт, төрлөөр 39
Хүснэгт 18. Газрын тосны бүтээгдэхүүний импорт, сая ам.долларoор 40
Хүснэгт 19. Газрын тосны голлох бүтээгдэхүүний импорт, бүтээгдэхүүний нэр төрлөөр 40
Хүснэгт 20. Үнэт цаасны нөхцөл 44
Хүснэгт 21. Үнэт цаас гаргагчийн зээлжих зэрэглэл 46
Хүснэгт 22. Дотоодын зээлжих зэрэглэл тогтоолгосон компаниудын мэдээлэл 46
Хүснэгт 23. Мөнгөн хөрөнгө байршуулах мэдээлэл 50
Хүснэгт 24. Хүүгийн орлогод ногдох албан татвар 50
Хүснэгт 25. Үнэт цаас борлуулсны орлогод ногдох албан татвар 51
Хүснэгт 26. Орлого, үр дүнгийн тайлангийн төсөөлөл, сая төгрөгөөр 54
Хүснэгт 27. Санхүүгийн байдлын тайлангийн төсөөлөл, сая төгрөгөөр 55
Хүснэгт 28. Мөнгөн гүйлгээний тайлангийн төсөөлөл, сая төгрөгөөр 57

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц 14
График 2. Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт 17
График 3. Үнэт цаас гаргагчийн борлуулалтын задаргаа, 2025, 2026У2 26
График 4. Үнэт цаас гаргагчийн нийт ашгийн үзүүлэлт, тэрбум төгрөг 26
График 5. Үнэт цаас гаргагчийн нийт зардлын бүтэц, 2025У2 27
График 6. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны ашгийн үзүүлэлт, тэрбум төгрөг 27
График 7. Үнэт цаас гаргагчийн цэвэр ашгийн үзүүлэлт, тэрбум төгрөг 28
График 8. Нийт хөрөнгийн бүтэц 29
График 9. Эргэлтийн хөрөнгийн бүтэц 29
График 10. Эх үүсвэрийн бүтэц 30
График 11. Өр төлбөрийн бүтэц 30
График 12. Монгол Улсын нэрлэсэн ДНБ (их наяд төгрөгөөр) болон бодит ДНБ-ний өсөлт, хувиар 33
График 13. Монгол Улсын инфляцын түвшин 34
График 14. Төсвийн тэнцэл, тэрбум төгрөгөөр 35
График 15. Гадаад худалдааны тэнцэл, сая ам.долларoор 36
График 16. Дэлхийн газрын тосны батлагдсан нөөц, тэрбум баррель 36
График 17. Дэлхийн газрын тосны эрэлт, сая баррель/өдөр 37
График 18. Газрын тосны үнэ 38
График 19. Дэлхийн улсуудын боловсруулсан газрын тосны экспорт, сая баррель/өдөр 38
График 20. Голлох газрын тосны бүтээгдэхүүний импорт, мянган тонноор 41
График 21. Газрын тосны нөөцийн хэмжээ, тонн 41
График 22. Газрын тосны олборлолт, экспорт, мянган баррель 42
График 23. Хүүгийн түвшний харьцуулалт 45
График 22. Анхдагч эдх зээлийн арилжааны төлөвлөгөө 49
График 23. Үнэт цаасны арилжаанд оролцох, захиалга авах заавар 50

2026.08.31

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
ҮЦК	Үнэт цаасны компани
ХЭХ	Хувьцаа эзэмшигчдийн хурал
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
МХБ	Монголын хөрөнгийн биржс
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
МБ	Монголбанк
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ҮЦТХТ	Үнэт цаас төвлөрсөн хадгаламжийн төв
ШТС	Шатахуун түгээх станц
ҮЦЗЗ	Үнэт цаасны зах зээл

2026.08.31

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД

Үнэт цаас гаргагч нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржийн холбогдох дүрэм, журмуудын дагуу олон нийтэд нээлттэй хүрээнд өрийн хэрэгсэл (цаашид "бонд" эсхүл "өрийн бичиг" гэх) санал болгож байгаа болно.

Энэхүү Үнэт цаасны танилцуулга нь Хөрөнгө оруулагч таны хараат бус үнэлгээ, шинжилгээний дүгнэлтийг орлохгүй бөгөөд тэдгээрт тооцогдохгүй. Хөрөнгө оруулагч та Үнэт цаас гаргагч болоод түүний гаргаж буй үнэт цаас, холбогдох мэдээллийн талаар өөрийн судалгаа шинжилгээг хийсний үндсэн дээр хөрөнгө оруулалт хийх шаардлагатай бөгөөд өөрийн мэргэжлийн санхүүгийн, хуулийн болон бусад зохих мэргэжлийн зөвлөхүүдтэйгээ зөвлөлдөхийг зөвлөж байна.

Энэхүү Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан зарим цаг хугацааны шинж чанартай мэдээлэл, мэдэгдэл, тооцоолол, төсөөлөл нь Андеррайтерийн холбогдох эх сурвалжаас цуглуулсан мэдээлэл, итгэл үнэмшил дээр тулгуурласан бөгөөд санаатайгаар ямар нэгэн мэдээллийг орхигдуулаагүй болно. Андеррайтер нь эдгээр мэдээлэл, мэдэгдэл, тооцоолол, төсөөллийг гаргахдаа аль болох үнэн зөв мэдээллийг ашиглан бодит байдалд нийцүүлэхийг зорьсон боловч цуглуулсан мэдээллийн үнэн зөв байдалд хариуцлага хүлээхгүй бөгөөд тооцоолол, ирээдүйн төсөөллийн биелэлтэд баталгаа өгөөгүй болно.

ЭНЭХҮҮ ТАНИЛЦУУЛГАД ТУСГАСАН ӨРИЙН БИЧГИЙГ СЗХ БОЛОН МХБ БҮРТГЭСЭН НЬ УГ ҮНЭТ ЦААСАНД ГАРГАСАН АЛИВАА БАТАЛГАА БИШ БӨГӨӨД ТҮҮНИЙ АГУУЛСАН МЭДЭЭЛЛИЙН ҮНЭН ЗӨВ, БҮРЭН БҮТЭН БАЙДАЛ БОЛОН АЛИВАА ЭРСДЭЛИЙГ СЗХ БОЛОН МХБ ХАРИУЦАХГҮЙ БОЛОХЫГ АНХААРАХ НЬ ЗҮЙТЭЙ. ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНЫ ХУВЬД ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ ҮЙЛДЭЛ БАЙДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, ӨРИЙН БИЧИГ ГАРГАХ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.

Энэхүү үнэт цаасны танилцуулгад хөрөнгө оруулагч танд тус үнэт цаасыг худалдан авах шийдвэр гаргахад туслах шаардлагатай бүхий л мэдээллийг агуулахыг зорьсон болно. Хөрөнгө оруулагч таны шийдвэр гаргалтад танилцуулгад тусгагдсан мэдээллээс илүү дэлгэрэнгүй, нэмэлт мэдээлэл шаардлагатай болох буюу лавлаж тодруулах зүйл байвал Үнэт цаас гаргагч болон Андеррайтер "Голомт Капитал ҮЦК" ХХК-д хандаж тодруулна уу.

ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУД

АНДЕРРАЙТЕР

Голомт Капитал ҮЦК ХХК
Улаанбаатар хот, Сүхбаатар, 1-р хороо, чингисийн өргөн чөлөө, 24, Парк Плэйс оффисын барилга, 4 давхар, 403,404
+976 7012 1530
www.golomtcapital.com
Info@golomtcapital.com

АУДИТЫН КОМПАНИ

Ниямазон Аудит ХХК
Улаанбаатар, Чингэлтэй, 3-р хороо, Чоймболын гудамж -4, Нийслэл УБ хотын ҮЭ-ийн холбооны байр, 4 давхар, 408 тоот
+976 7014 5906
audit@nmz.mn

ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛИЙН КОМПАНИ

Монголын Хөрөнгө Оруулалтын Зэрэглэлийн Эжинси ХХК
Улаанбаатар, Чингэлтэй, 1-р хороо, жигжиджавын гудамж, Жи И Би ХХК-ийн байр 306 тоот
+976 7774-7700
info@mira.mn

ХУУЛИЙН ЗӨВЛӨХ

Өмгөөллийн Легал Полиси ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот, СБД, 8-р хороо, Бага тойруу-14200, Сүхбаатарын талбай 5, Сити Тауэр, 1304 тоот
+976 9007-7720
admin@legal-policy.mn

2026.08.31

ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн В/14 тоот тогтоолын дагуу нийт 100,000,000,000 /нэг зуун тэрбум/ төгрөгийн дүнтэй өрийн хэрэгслийн хөтөлбөрийг олон нийтэд нээлттэй хүрээнд санал болгон арилжихаар шийдвэрлэсэн бөгөөд 2026 оны 3-р улиралд багтаан арилжихаар төлөвлөж байна.

Хүснэгт 1. Үнэт цаасны нөхцөл

Үнэт цаас гаргагч	ШУНХЛАЙ ХХК
Үнэт цаасны нэр	Шунхлай бонд - 4
Үнэт цаасны төрөл	Энгийн хүүтэй, хөтөлбөртэй бонд
Бондын арилжаа	Монголын хөрөнгийн биржээр олон нийтэд нээлттэй хүрээнд
Бондын хөтөлбөр хэрэгжүүлэх	Хэсэгчлэн гаргах үнийн дүнг Компанийн гүйцэтгэх захирал тухай бүрд шийднэ
Бондын тоо ширхэг	1,000,000 (нэг сая) ширхэг
Бондын нэрлэсэн үнэ, (ширхэг)	100,000 (нэг зуун мянга) төгрөг
Бондын хөтөлбөрийн нийт дүн	100,000,000,000 (нэг зуун тэрбум) төгрөг
Бондын хугацаа	12 сар
Бондын хүү	18.0 хувь
Хүүгийн төлөлт	Хагас жил тутам
Үндсэн төлбөр төлөлт	Хугацааны эцэст
Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулах зориулалт	Эргэлтийн хөрөнгийн санхүүжилт
Үнэт цаасны хүүгийн орлогын татвар	5.0 хувь
Бондын эргэн төлөлт	Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны эргэн төлөлтийг газрын тосны бүтээгдэхүүний борлуулалт буюу үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлогоор санхүүжүүлнэ.
Барьцаа	Барьцаа болон баталгаагүй, зээлжих зэрэглэл тогтоолгосон.
Бондын зэрэглэл	Монголын хөрөнгө оруулалтын зэрэглэлийн эжинси ХХК / Mongolian Investment Rating Agency/ "А тогтвортой"
Хүүгийн төлбөр	Бондын хүүг хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс эхлэн жилийн хүүг 365 хоногоор тооцно. Хэрэв хүү төлөх өдөр амралтын өдөр таарвал дараагийн ажлын өдөр төлөх ба энэ тохиолдолд амралтын өдрүүдэд хүүг нэмж тооцохгүй.

Бондын хадгалалт, төлбөр тооцоо	Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв
Нийтэд санал болгохоор төлөвлөж буй хугацаа	2026 оны 3-р улирал
Хувьцаанд хөрвөх нөхцөлтэй эсэх	Үгүй

СЭХ
2026 .09. 10
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2026 -09- 02
БҮРТГЭВ-03

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ

1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ

1.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хүснэгт 2. Үнэт цаас гаргагчийн товч танилцуулга

Үнэт цаас гаргагчийн оноосон нэр	Шунхлай ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011068082
Регистрийн дугаар	2028468
Бүртгэгдсэн огноо	2005.12.16
Үйл ажиллагааны мэдээлэл	▪ Нефть бүтээгдэхүүний бөөний болон жижиглэн худалдаа ▪ Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа ▪ 0.4-35кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ /2025.08.25 - 2030.08.25/ ▪ 220 кВ болон түүнээс дээш хүчдэлтэй цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх /2025.05.27 - 2030.05.27/ ▪ 100 МВт-аас дээш эрчим хүчний эх үүсвэр барих, угсрах, засварлах, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ барих /2025.05.27 - 2030.05.27/
Гүйцэтгэх захирал	Ж.Мөнхнаран
Хувьцаа эзэмшигч	Шунхлай Холдинг ХХК -100% эзэмшдэг
Эцсийн өмчлөгч	П.Батсайхан
Оршин байгаа газрын хаяг	Монгол улс, Улаанбаатар хот, Чингисийн өргөн чөлөө 48/1, Капитал Хаус

Үнэт цаас гаргагч Шунхлай ХХК нь Монгол Улсын Засгийн газар, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим хамтран шалгаруулсан 2025 оны Монгол Улсын ТОП-100 аж ахуйн нэгжийн жагсаалтад 22-р байраар шалгарсан.

1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Үнэт цаас гаргагч Шунхлай ХХК нь Шунхлай газрын тосны бизнесийн нэгдэлд хамаарах бөгөөд тус нэгдэл нь одоогоор Улаанбаатар хот болон 21 аймагт нийт 110 гаруй шатахуун түгээх станцтайгаар үйл ажиллагаа явуулж байна. Шунхлай газрын тосны бизнес нь бүтээгдэхүүний импорт, хадгалалт, тээвэрлэлт, борлуулалт гэсэн үндсэн 4 чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ба дараах бүтээгдэхүүнүүдийг импортлон дотоодын зах зээлд борлуулж байна. Үүнд:

Бензин	Түлш	Бусад
❖ Евро АИ-92 ❖ Регуляр-92 ❖ Премиум-95 ❖ Супер-98	❖ Дизель түлш /өвөл, зуны/ ❖ Онгоцны түлш ТС-1	❖ Тос, тосолгооны материал ❖ Битум ❖ Мазут ❖ Аккумулятор ❖ Шил цэвэрлэгч шингэн

Импорт

Үнэт цаас гаргагч Шунхлай ХХК нь газрын тосны бүтээгдэхүүнийг ОХУ, БНХАУ, БНСУ, АНУ зэрэг орнуудаас импортолдог бөгөөд Шунхлай газрын тосны бизнесийн 8 агуулах, 110 гаруй шатахуун түгээх станцуудаар дамжуулан борлуулдаг. Компани нь ОХУ-ын "Роснефть", "Газпромнефть" болон бусад нийлүүлэгч, БНХАУ-ын "Петрочайна", БНСУ-ын "SK energy", зэрэг газрын тосны бүтээгдэхүүний салбарт тэргүүлэгч 40 гаруй компанитай хамтран ажиллаж байна.

Хадгалалт

Шунхлай газрын тосны бизнес нь Улаанбаатар хот болон Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Дорноговь, Өмнөговь, Дорнод, Увс аймагт нийт 8 газрын тосны бүтээгдэхүүний агуулахтай. Эдгээр агуулахад 100 сая литр шатахуун хүлээн авах, хадгалах хүчин чадалтай бөгөөд төрийн үйлчилгээний болон аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн захиалгаар газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалж үйлчилдэг. Газрын тосны бүтээгдэхүүний агуулахууд нь газрын тосны бүтээгдэхүүнийг тээвэрлэх салаа төмөр зам, 16 хүртэл вагон зэрэг буулгах эстакад, бүтээгдэхүүн тус бүрээр ачих эстакад, зориулалтын хэвтээ, босоо хадгалах сав, насосын станцтай, гаалийн баталгаат болон түр агуулахын статустай ажиллаж байна.

Монгол улсын Засгийн газрын 327 дугаар тогтоолын дагуу Үнэт цаас гаргагч нь 100,000 метр.куб буюу Монгол улсад хамгийн том хүчин чадалтайд тооцогдох газрын тосны бүтээгдэхүүний агуулахыг Сонгинохайрхан дүүргийн 21-р хороонд барьж байна. Тус бүр нь 14,000 метр.куб бүхий багтаамжтай, 36 метрийн диаметр, 14.5 метрийн өндөртэй долоон босоо ган сав барих ба 2027 оны 12-р сарын 31-нд багтаан бүрэн ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Газрын тосны бүтээгдэхүүний агуулахын санхүүжилтийг Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэх бөгөөд үнэт цаасны танилцуулга бэлдэх үеийн байдлаар агуулахын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 40.0 хувьтай үргэлжилж байна.

Тээвэрлэлт

Шунхлай газрын тосны бизнест хамаарах компаниуд нь газрын тосны бүтээгдэхүүнийг өөрсдийн шатахуун түгээх станцуудад хүргэхээс гадна төрийн үйлчилгээний болон аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн хүсэлтээр хэрэгцээт газарт нь тусгай зориулалтын автомашинаар, технологийн дагуу тээвэрлэн хүргэдэг. Нэг удаагийн тээвэрлэлтээр 4.7 сая литр шатахууныг Монгол улсын хэмжээнд түгээн ажиллах хүчин чадалтай.

Газрын тосны бүтээгдэхүүний борлуулалт

Бөөний худалдаа: Шунхлай газрын тосны бизнес нь Улаанбаатар хот болон орон нутагт байрлах газрын тосны бүтээгдэхүүний нийт 8 агуулахуудаар дамжуулан бүтээгдэхүүнийг бөөнөөр нийлүүлдэг. Салбартаа анх удаа газрын тосны бүтээгдэхүүний агуулахад бүтээгдэхүүн хүлээн авах, хэмжилт хийх, ачих технологийн үйл ажиллагааг бүрэн автоматжуулсан бөгөөд хөдөлмөрийн аюулгүй байдлыг бүрэн хангасан, санхүүгийн үр ашгийг нэмэгдүүлэх, цаг хугацаа хэмнэх зэрэг олон давуу талыг хэрэглэгчдэд санал болгон ажиллаж байна.

Жижиглэнгийн худалдаа: Шунхлай газрын тосны бизнес нь Хэрэглэгчдэд илүү ойр, хүртээмжтэй ажиллахын тулд Улаанбаатар хот болон 21 аймагт нийт 110 гаруй шатахуун түгээх станцын өргөн сүлжээг бий болгон газрын тосны бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд хүргэж байна.

1.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН БҮТЭЦ

Үнэт цаас гаргагч Шунхлай ХХК-ийн нийт гаргасан нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,657 ширхэг энгийн хувьцааг Шунхлай Холдинг ХХК 100 хувь эзэмшдэг.

Хүснэгт 3. Толгой компани Шунхлай Холдинг ХХК-ийн товч танилцуулга

Хуулийн этгээдийн оноосон нэр	Шунхлай Холдинг ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011068075
Регистрийн дугаар	2737779
Бүртгэгдсэн огноо	2005.12.15
Оршин байгаа газрын хаяг	Монгол улс, Улаанбаатар хот, Чингисийн өргөн чөлөө 48/1, Капитал Хаус 4-р давхарт
Үйл ажиллагааны мэдээлэл	❖ Бизнесийн зөвлөгөө өгөх ❖ Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа ❖ Бизнесийн төсөл хэрэгжүүлэх
Гүйцэтгэх захирал	П.Батсайхан

Шунхлай Холдинг ХХК-ийн энгийн хувьцааны 55.7 хувийг Монгол улсын иргэн П.Батсайхан эзэмшдэг бол үлдсэн хувийг доор дурдсан иргэд тус бүр 10-с бага хувийн хувьцааг эзэмшиж байна. Үнэт цаас гаргагчийн эцсийн өмчлөгч нь Шунхлай Холдинг ХХК-ийн 55.7 хувийг эзэмшиж буй иргэн П.Батсайхан юм.

График 1. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц



1.4 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХАМААРАЛ БҮХИЙ ЭТГЭЭДҮҮД

Шунхлай газрын тосны бизнес группт хамаарах 8 компанийн Шунхлай Говь ХХК, Шунхлай Трейдинг ХХК, Шунхлай Петролиум ХХК, Шунхлай ХХК зэрэг 4 компани нь 100 хувь Шунхлай Холдинг ХХК-ийн эзэмшилд байдаг бол Эс Жи Коммодитис ХХК нь Шунхлай Говь ХХК-ийн охин компани, Эс Жи Ханги Гэйт ХХК, Эс Жи Шивээ Хүрэн Депо ХХК нь Шунхлай Петролиум ХХК-ийн охин компани, Шунхлай Ойл ХХК нь Үнэт цаас гаргагч Шунхлай ХХК-ийн 100 хувь эзэмшлийн охин компаниуд юм. Эдгээр компаниуд нь дараах чиг үүргийн хүрээнд газрын тосны бизнест хамтран оролцож байна.

Хүснэгт 4 .Шунхлай Газрын Тосны бизнес группт хамаарах компаниудын мэдээлэл

№	Нэр	Үүсгэн байгуулагдсан огноо	Газрын тосны бизнесийн чиг үүрэг
1	Шунхлай ХХК	2005.12.16	Газрын тосны бүтээгдэхүүний импортыг хариуцах бөгөөд бусад 7 компани руу борлуулдаг.
2	Шунхлай Говь ХХК	2011.08.22	Говийн бүсийн нутгуудад ШТС-үүд , агуулахуудаар жижиглэн болон бөөний борлуулалт хийдэг.

3	Шунхлай Петролиум ХХК	2011.09.14	Эрдэнэт, Дархан, Хөвсгөл аймагт ШТС-үүд, агуулахуудаар жижиглэн болон бөөний борлуулалт хийдэг.
4	Шунхлай Трейдинг ХХК	2011.08.22	Улаанбаатар хотод байрлалтай ШТС-үүдээр шатахууны борлуулалт хийдэг.
5	Эс Жи Ханги Гэйт ХХК	2022.02.11	Говийн бүсийн нутгуудад борлуулалт хийдэг.
6	Эс Жи Шивээ Хүрэн Депо ХХК	2022.02.07	Говийн бүсийн нутгуудад борлуулалт хийдэг.
7	Шунхлай Ойл ХХК	2023.11.28	Шатахуунаас бусад бүтээгдэхүүн буюу тос, тослох материал, битум, мазут, шил арчигч шингэн, аккумлятор зэрэг бүтээгдэхүүний борлуулалт хийдэг.
8	Эс Жи Коммодитис ХХК	2022.04.06	Одоогоор идэвхтэй үйл ажиллагаа явуулж эхлээгүй байна.

Шунхлай Холдинг ХХК нь дээр дурдсан газрын тосны бизнес группт хамаарах компаниудаас гадна дараах компаниудын хувьцааг эзэмшиж байна.

Хүснэгт 5. Шунхлай Холдинг ХХК-ийн эзэмшилд хамаарах голлох компаниуд

Лого	Нэр	Шунхлай Холдинг ХХК-ийн эзэмшлийн хувь	Үйл ажиллагааны чиглэл
APU COMPANY Absolute. Pure. Unique.	АПУ ХК	56.63%	Шингэн хүнс, сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл худалдаа
GS25	Дижитал Концепт ХХК	51.0%	Хүнсний бүтээгдэхүүн жижиглэн болон бөөний худалдаа, хүнсний дэлгүүр, хүнс үйлдвэрлэл
SG	Жи Эс Би Капитал ББСБ ХХК	100%	Зээл, Хөрөнгө оруулалт, санхүүгийн цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ
KIA	КИА Моторс Монгол ХХК	100%	Автомашины худалдаа, сэлбэгийн худалдаа, автомашины түрээс
HYUNDAI	Хьюндай Моторс Монгол ХХК	100%	Автомашины худалдаа, сэлбэгийн худалдаа, автомашины түрээс

2026.08.31

SKYtel	Скайтел ХХК	100%	Үүрэн телефон, пейжерийн холбооны үйлчилгээ, үүрэн телефоны төгсгөлийн төхөөрөмжийн худалдаа үйлчилгээ эрхлэх
MEDIA GROUP	Медиагрупп ХХК	100%	Менежментийн зөвлөгөө, Эн Ти Ви Броадкастинг ХХК-ийг эзэмшдэг, Телевизийн өргөн нэвтрүүлэг бэлтгэх болон дамжуулах үйл ажиллагаа
ТЭНГИС	УБ Синема ХХК	100%	Өргөн дэлгэцийн кино театр
DSG	Ди Эс Жи ХХК	100%	Менежментийн зөвлөх үйлчилгээ, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх
SDEVELOPMENT	Эс Девелопмент ХХК	100%	Бизнесийн зөвлөгөө өгөх, Менежментийн зөвлөгөө өгөх, Төсөл хэрэгжүүлэх
Data Center	Эс Системс ХХК	100%	Мэдээлэл технологийн үйл ажиллагаа, Аюулгүй байдлын зөвлөгөө өгөх, Интернэтийн үйлчилгээ, Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх, Дата төвийн үйлчилгээ
SGIS	Эс Жи Инвестмент Энд Секьюритис ХХК	100%	Үнэт цаасны брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа
ZEROTECH	Зеро Технологи ХХК	100%	Программ хангамж, мэдээллийн технологийн үйл ажиллагаа
SG Power Unit LLC	Пауэр-Юнит ХХК	50%	Цахилгаан түгээх, цахилгаан зохицуулалттай хангах
Suntrans LOGISTICS	Сантранс Ложистикс ХХК	100%	Бөөний худалдаа, олон улсын тээвэр зууч
ЭС ДИ СЕРВИС ХХК	Эс Ди Сервис ХХК	100%	Барилгын засвар, засал чигмэглэл, орон сууц, албан байгууллага, барилгын болон засварын дараах цэвэрлэгээ
SD	Эс Ди Инженеринг Энд Констракшн ХХК	100%	Барилгын засвар хийх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх
Orange Air	Оранж Эйр ХХК	100%	Аялал жуулчлал, нисдэг тэрэгний нислэг зохицуулалт, засвар үйлчилгээ.

2026.08.31

1.5. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

"Шунхлай" ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 3-р сарын 3-ны өдрийн В/02 дугаар тогтоолын дагуу "Шунхлай" ХХК-ийн дотоод зохион байгуулалтын бүтцийг баталж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Үнэт цаас гаргагчийн эрх барих дээд байгууллага нь тус компанийн дүрэмд тусгагдсаны дагуу Хувьцаа эзэмшигчдийн хурал байх бөгөөд Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг ТУЗ хэрэгжүүлдэг. Компанийн гүйцэтгэх захирал нь өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулан явуулах үүрэгтэй ба 6 газар, 5 алба нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь толгой компанийн "Удирдлагын хороо"-ны гишүүдээс бүрдэх бөгөөд ТУЗ-ийн хурал, түүний үйл ажиллагаа, хурлын дэгийг Хувьцаа эзэмшигчийн баталснаар буюу "Шунхлай Холдинг" ХХК-ийн Удирдлагын хорооны журмаар зохицуулахаар заасан байна. "Шунхлай Холдинг" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 11-р сарын 30-ны өдрийн В/21 тоот шийдвэрээр "Шунхлай Холдинг" ХХК-ийн Удирдлагын Хорооны ажиллах журмыг баталж, тус хорооны үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг зохицуулсан. Уг журмын дагуу удирдлагын хороо нь охин компанийн ТУЗ-ийн хувьд шийдвэрлэх асуудлуудыг тусгаж өгсөн байна.

График 2. Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт

Үнэт цаас гаргагч нь Шунхлай Холдинг ХХК-ийн "Газрын тосны бизнесийн групп"-т хамаардаг бөгөөд толгой компани болох "Шунхлай Холдинг" ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны 03-р сарын 31-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор газрын тосны бизнесийн нэгдэлд хамаарах компаниудын удирдлага зохион байгуулалтын тогтолцоог баталсан. Уг бүтцийн дагуу газрын тосны бизнесийн нэгдэлд хамаарах компаниуд нь нэг Гүйцэтгэх захиралтай, нэг Төлөөлөн Удирдах Зөвлөлтэй байх бөгөөд газар, хэлтсүүдийг нэгдмэл байдлаар тодорхойлсон байна. Мөн тус 8 компани нь нэг групп компанийн хэлбэрээр загварчлагдсан, удирдлага менежмент, зохион байгуулалтыг нэг баг хэрэгжүүлж, нэг бүхэл (компанийн нэгдэл) байх ба гуравдагч этгээдийн өмнө нэг хуулийн этгээдийн

чадвартай байх тухай харилцан тохиролцсон байна. “Газрын тосны бизнесийн групп”-д хамаарах 8 компани нь хуулийн дагуу нэгтгэсэн тайлан гаргах үүрэг хүлээгээгүй боловч бизнесийн гүйцэтгэл, үр дүнг үнэлэхийн тулд нэгтгэсэн тайлан бэлтгэж, тус тайланд санхүүгийн тайлангийн аудит хийлгэдэг.

1.6 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУДЫН МЭДЭЭЛЭЛ

Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтанд компанийн дүрмийн дагуу дараах албан тушаалтнуудыг хамруулахаар заасан байна. Үүнд:

- Гүйцэтгэх захирал
- ТУЗ-ийн гишүүд
- Газрын захирлууд
- Ерөнхий нягтлан бодогч
- Ерөнхий аудитор

Тус зохицуулалтын хүрээнд тухайн эрх бүхий албан тушаал дээр ажиллаж буй албан хаагчдын туршлага, хууль тогтоомжоор тодорхойлсон шалгуурыг хангаж буй эсэхийг шүүж үзэхэд ТУЗ-ийн гишүүд нь Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.8-д зааснаар “Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна” гэж заасан шалгуурыг хангасан байна.

Компанийн Гүйцэтгэх захирал Ж.Мөнхнаран нь газрын тосны бизнесийн салбарт 16 гаруй жил ажилласан туршлагатай, мэргэжлээрээ бакалавр болон магистрын зэрэг эзэмшсэн бөгөөд тухайн албан тушаалд ажиллахад шаардлагатай мэдлэг ур чадварыг эзэмшсэн байна.

Мөн бусад эрх бүхий албан тушаалтнуудад Төрийн зохих байгууллагаас баталсан эрх зүйн актын хүрээнд тусгайлан тодорхойлсон ажил мэргэжлийн шалгуур байхгүй болно.

Хүснэгт 6. Шунхлай ХХК-ийн ТУЗ-ийн гишүүд

№	Нэр	ТУЗ-ийн үүрэг	Эрхэлж буй албан тушаал
1	П. Батсайхан	ТУЗ-ийн дарга	“Шунхлай Холдинг” ХХК - Хувьцаа эзэмшигч, Шунхлай Холдингийн Ерөнхийлөгч
2	Б.Батбаяр	ТУЗ-ийн гишүүн	“Шунхлай Холдинг” ХХК - Гүйцэтгэх дэд ерөнхийлөгч бөгөөд Санхүү эрхэлсэн захирал
3	Б.Цэлмэг	ТУЗ-ийн гишүүн	“Шунхлай Холдинг” ХХК - Хувьцаа эзэмшигч
4	Б.Батжаргал	ТУЗ-ийн гишүүн	“Шунхлай Холдинг” ХХК - Дижитал технологи, инновац хариуцсан захирал
5	Ж. Мөнхнаран	ТУЗ-ийн гишүүн	“Шунхлай” ХХК - Гүйцэтгэх захирал
6	Ш. Нэргүй	ТУЗ-ийн гишүүн	“Шунхлай Холдинг” ХХК - Дэд ерөнхийлөгч бөгөөд Санхүү, бүртгэл хариуцсан захирал

7	Ч.Ариунсан	ТУЗ-ийн гишүүн	"Шунхлай Холдинг" ХХК - Ерөнхийлөгчийн ажлын албаны захирал
8	Ц. Эрдэнэбилэг	ТУЗ-ийн гишүүн	"АПУ" ХК - Гүйцэтгэх захирал
9	И.Майнцэцэг	ТУЗ-ийн гишүүн	Шунхлай Групп ХХК-ийн Хууль эрх зүй хүний нөөц хариуцсан захирал

Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнуудын боловсрол, ажлын туршлагын мэдээлэл дараах байдалтай байна:

Ж.Мөнхнаран | Гүйцэтгэх захирал

Боловсрол:
2013 - 2015 – Австрали Сидней, Macquarie University – Бизнесийн удирдлагын магистр
1997 - 2001 -МУИС Эдийн засгийн сургууль – Эдийн засагч, бакалавр

Ажлын туршлага:
2018 - одоо - Шунхлай ХХК -Гүйцэтгэх захирал
2015 - одоо -Эс Девелопмент ХХК - Гүйцэтгэх захирал
2009 - 2013 - Шунхлай ХХК - Стратеги төлөвлөлтийн албаны дарга
2001 - 2009 - АПУ ХК - Эдийн засагч

Ч.Галмөнх | Борлуулалт, маркетинг хариуцсан захирал

Боловсрол:
1992 - 1996 – Хүмүүнлэгийн ухааны их сургууль – Үйлдвэрлэлийн менежер

Ажлын туршлага:
2021 - Одоо -Шунхлай ХХК -Борлуулалт, маркетинг хариуцсан захирал
2009-2021 -Шунхлай ХХК- Борлуулалтын ахлах менежер
2006-2009- Шунхлай ХХК- Борлуулалтын менежер
2004-2006 -Анорад ХХК -Оффис менежер

2026.08.31

Ш.Гэрэлт-Од | Техник, технологи хариуцсан захирал

Боловсрол:
2011 - 2013 – ШУТИС – Нефтийн инженер, магистр
1998 - 2002 – ШУТИС – Нефтийн инженер, бакалавр

Ажлын туршлага:
2019 – Одоо- Шунхлай ХХК -Техник, технологи хариуцсан захирал
2011 –2019 -Шунхлай Трейдинг ХХК -Улаанбаатар газрын тосны бүтээгдэхүүний агуулахын дарга
2009-2010- Шунхлай ХХК -Инженер
2007-2009 -Шунхлай Холдинг ХХК- ТТМ, Шатахууны нярав

Ж.Оюумаа | Санхүү хариуцсан захирал

Боловсрол:
2009 - 2011 – СЭЗИС – Бизнесийн удирдлага, Магистр
2004 - 2008 – СЭЗИС – Нягтлан бодох бүртгэл, бакалавр

Ажлын туршлага:
2025 - Одоо - Шунхлай ХХК -Санхүү хариуцсан захирал
2019 - 2025 –АПУ ХК – Ерөнхий нягтлан бодогч, Санхүүгийн албаны дарга
2017 – 2018 – АПУ ХК – Дотоод аудитын албаны дарга
2014 – 2016 – АПУ ХК – Удирдлагын ахлах нягтлан бодогч
2008 – 2012 – АПУ ХК – Ахлах нягтлан бодогч

А.Жамъянжав | Бизнес төлөвлөлт хариуцсан захирал

Боловсрол:
2005 – 2009 – МУИС – Санхүү менежмент, Бакалавр

Ажлын туршлага:
2021 – Одоо- Шунхлай ХХК- Бизнес төлөвлөлт хариуцсан захирал
2018-2020 -Премиум Бьюлдинг Материалс ХХК- Санхүү хариуцсан захирал
2017-2018- Хаан даатгал ХХК- Санхүү хариуцсан захирал
2013-2017 -М Си Эс Энержи ХХК- Санхүүгийн менежер
2009-2013 -Энержи Ресурс ХХК -Санхүүгийн менежер

2026.08.31

Ц.Болормаа | Ерөнхий нягтлан бодогч

Боловсрол:
2012 – 2016 - Мандах Их Сургууль – Нягтлан бодогч

Ажлын туршлага:
2022 – Одоо- Шунхлай ХХК- Ерөнхий нягтлан бодогч
2020-2022 -Шунхлай ХХК – Ахлах нягтлан бодогч
2017-2020- Шунхлай ХХК- Тооцооны нягтлан бодогч

Г.Алтанзаяа | Захиргаа, хүний нөөц хариуцсан захирал

Боловсрол:
2009 – 2011 – ШУТИС, КТМС – Хүний нөөцийн удирдлагын менежер, магистр
2000 – 2004 – МУБИС, НУС – Философич, Улс төр судлаач, Бакалавр

Ажлын туршлага:
2019 – Одоо- Шунхлай ХХК -Захиргаа, Хүний нөөц хариуцсан захирал
2018-2019- АПУ ХК -Хүн ба байгууллагын хөгжил хариуцсан ахлах менежер
2006-2017 -М-Си-Эс Групп -Захиргаа, Хүний нөөцийн ахлах менежер

С.Сарантуяа | Дотоод аудитын албаны захирал

Боловсрол:
2012 – 2015 – London School of Business and Finance – Олон Улсын Мэргэшсэн Нягтлан Бодох Бүртгэл /ACCA/
2009 – 2015 – СЭЗИС – Олон Улсын Нягтлан Бодох Бүртгэл

Ажлын туршлага:
2024.04 – Одоо- Шунхлай ХХК - Дотоод аудитын албаны захирал
2023-2024.04- М Банк -Үйл ажиллагааны эрсдэл хариуцсан менежер
2015-2023 -Худалдаа хөгжлийн банк -Дотоод Аудитор
2014-2015- Pure Baby Ltd, Лондон хот – Нягтлан бодогч

Д.Норжинсүрэн | Худалдан авалтын албаны захирал

Боловсрол:
2000 – 2002 – Москва-Губкины нэрэмжит нефть хийн их сургууль – Менежмент, магистр
1995 – 2000 – Москва-Губкины нэрэмжит нефть хийн их сургууль – Эдийн засагч, Бакалавр

Ажлын туршлага:
2020 – Одоо- Шунхлай ХХК – Худалдан авалтын албаны захирал
2018-2020 -Шунхлай ХХК -Гадаад худалдааны албаны дарга
2006-2018 -Шунхлай ХХК – Импортын менежер
2004-2006 –Жаст Ойл ХХК – Импортын менежер

О.Жавзан | Шуурхай Зохицуулалтын албаны захирал

Боловсрол:
2004 – 2006 – СЭЗИС, Банк санхүүч, Бакалавр
1998 – 2002 – МУИС – Геологич, Бакалавр

Ажлын туршлага:
2024 оноос - Шунхлай ХХК – Шуурхай зохицуулалтын албаны захирал
2023-2024 - Шунхлай ХХК -Шуурхай зохицуулалтын ахлах менежер
2021-2023 - Шунхлай ХХК – Жижиглэнгийн борлуулалтын ахлах менежер
2013-2021 – Шунхлай ХХК – Борлуулалтын ахлах менежер
2006-2013 – Шунхлай ХХК – Жижиглэнгийн борлуулалтын менежер

Компанийн ТУЗ-ийн гишүүд, эрх бүхий албан тушаалтнууд нь үнэт цаас гаргагчийн энгийн хувьцааг эзэмшдэггүй.

1.7 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ИХ ХЭМЖЭЭНИЙ, СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ, ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН 5 ХУВИАС ДЭЭШ ДҮНТЭЙ ХЭЛЦЛҮҮД

1.7.1 Их хэмжээний хэлцэл

Их хэмжээний хэлцэл гэдэг нь Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлд заасны дагуу хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл /компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй/ юм.

Хүснэгт 7. Их хэмжээний хэлцлийн дүн, сая төгрөгөөр

/сая төгрөг/	Нийт хөрөнгийн дүн	Их хэмжээний хэлцэлд тооцогдох дүн
2023 оны санхүүгийн тайлан	434,574.4	108,643.6
2024 оны санхүүгийн тайлан	396,426.9	99,106.7
2025 оны санхүүгийн тайлан	439,990.7	109,997.7
2026 оны 2-р улирлын санхүүгийн тайлан	647,661.9	161,915.5

Үнэт цаас гаргагч нь сүүлийн 3 жилийн хугацаанд дээрх хуулийн заалтад нийцэх их хэмжээний хэлцэл хийгдээгүй байна.

1.7.2 Сонирхлын зөрчилтэй хэлцэл

Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлийн дагуу Компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанитай дор дурдсан харилцаанд орсон бол компанитай, эсхүл түүний хараат болон охин компанитай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тооцогдоно:

- ✓ Хэлцлийн нөгөө тал, эсхүл хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа;
- ✓ Хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл уг хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл энгийн хувьцааны /ногдол хувийн/ 20-оос дээш хувийг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;
- ✓ Хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн толгой компанийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл уг компанийн энгийн хувьцааны /ногдол хувийн/ 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;
- ✓ Хэлцлийн үр дүнд шууд буюу шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа.

Дээрх хязгаарлалтын хүрээнд үнэт цаас гаргагч нь сүүлийн 3 жилийн хугацаанд нийт 62 сонирхлын зөрчилтэй хэлцлийг байгуулсан байна. "Өмгөөллийн Легал Полиси" ХХК-н зүгээс дээрх 62 хэлцлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгуулагдсан гэж дүгнэжээ. Тус хэлцлүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг хуулийн дүгнэлтээс харна уу.

1.7.3 Хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 болон түүнээс дээш дүнтэй хэлцэл

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн дүрэмд зааснаар компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 165,700,000 төгрөг байна. Иймд 8,285,000 төгрөгөөс дээш үнийн дүн бүхий хэлцлийг хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий хэлцэл гэж үзнэ.

Хуулийн дүгнэлтийн дагуу үнэт цаас гаргагч нь сүүлийн 3 жилийн хугацаанд хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий 91 хэлцэл байгуулсан бөгөөд эдгээр хэлцлүүд нь холбогдох хуульд нийцсэн, аливаа хууль

Тогтоомжийн зөрчилгүй байна гэж дүгнэсэн байна. Тус хэлцлүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг хуулийн дүгнэлтээс харна уу.

1.8 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ӨМНӨ ГАРГАСАН ҮНЭТ ЦААСНЫ МЭДЭЭЛЭЛ

Үнэт цаас гаргагч нь 2022-с 2026 оны 2-р улирлын хооронд 6 удаагийн бондын хөтөлбөрөөр нийт 273.9 тэрбум төгрөгийг Биржийн бус зах зээл болон нээлттэй хүрээнд татан төвлөрүүлсэн байна. Эдгээр бондуудаас нийт 173.9 тэрбум төгрөгийн бондыг хуваарийн дагуу эргэн төлсөн бөгөөд 2026 оны 8-р сарын байдлаар 100.0 тэрбум төгрөгийн бондын үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 8. Өмнө гаргасан үнэт цаасны мэдээлэл (транч тус бүрээр)

Бондын төрөл	Транчийн нэр	Валют	Хүү	Хугацаа	Татан төвлөрүүлсэн огноо	Эргэн төлөгдөх	Татан төвлөрүүлсэн дүн (сая ₮)
Хаалттай	Shunkhlai 1	MNT	14%	12сар	2022.04.13	Төлөгдсөн	3,900
Хаалттай	Shunkhlai 2	MNT	9.5%	12сар	2022.01.21	Төлөгдсөн	20,000
Хаалттай	Shunkhlai 2.1	MNT	18%	12сар	2023.02.17	Төлөгдсөн	5,000
Хаалттай	Shunkhlai 2.2	MNT	18%	12сар	2023.02.17	Төлөгдсөн	5,000
Хаалттай	Shunkhlai 2.3	MNT	18%	12сар	2023.03.17	Төлөгдсөн	5,000
Хаалттай	Shunkhlai 2.4	MNT	18%	12сар	2023.03.22	Төлөгдсөн	5,000
Хаалттай	Shunkhlai 2.5	MNT	18%	12сар	2023.04.06	Төлөгдсөн	5,000
Хаалттай	Shunkhlai 2.6	MNT	18%	12сар	2023.05.04	Төлөгдсөн	5,000
Хаалттай	Shunkhlai 2.7	MNT	18%	12сар	2023.05.08	Төлөгдсөн	5,000
Хаалттай	Shunkhlai 2.8	MNT	18%	12сар	2023.05.19	Төлөгдсөн	5,000
Хаалттай	Shunkhlai 2.9	MNT	18%	12сар	2023.06.15	Төлөгдсөн	5,000
Хаалттай	Shunkhlai 2.10	MNT	18%	12сар	2023.06.16	Төлөгдсөн	5,000
Хаалттай	Shunkhlai 3.1	MNT	17%	12сар	2024.07.08	Төлөгдсөн	5,000
Хаалттай	Shunkhlai 3.2	MNT	17%	12сар	2024.07.09	Төлөгдсөн	6,500
Хаалттай	Shunkhlai 3.3	MNT	17%	12сар	2024.07.19	Төлөгдсөн	3,000
Хаалттай	Shunkhlai 3.4	MNT	17%	12сар	2024.07.22	Төлөгдсөн	5,500
Нээлттэй	Шунхлай /транч 2/	MNT	17%	12сар	2024.12.06	Төлөгдсөн	40,000
Нээлттэй	Шунхлай /транч 1/	MNT	17%	12сар	2024.12.05	Төлөгдсөн	40,000
Нээлттэй	Шунхлай 2.0 /транч 1/	MNT	17%	12сар	2025.09.11	2026.09.11	40,000
Нээлттэй	Шунхлай 2.0 /транч 2/	MNT	17%	12сар	2025.09.17	2026.09.17	10,000
Нээлттэй	Шунхлай 3.0	MNT	18%	12сар	2025.12.11	2026.12.11	50,000
Нийт							**273,900**

1.9 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Үнэт цаас гаргагч Шунхлай ХХК-ийн 2025 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон тусдаа санхүүгийн тайлан болон 2026 оны 6-р сарын 30-ны өдрөөр тасалбар болгосон тусдаа санхүүгийн тайланд Ниямазон Аудит ХХК аудит хийж гүйцэтгэсэн бөгөөд үнэт цаас

гаргагчийн санхүүгийн тайлангууд нь материаллаг зүйлсийн хувьд СТОУС-ын дагуу үнэн, бодитой илэрхийлсэн байна гэж дүгнэсэн байна.

Үнэт цаас гаргагчийн орлогын тайлангийн шинжилгээ

Хүснэгт 9. Үнэт цаас гаргагчийн орлого, үр дүнгийн тайлан, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2023 Аудит	2024 Аудит	2025 Аудит	2026У2 Аудит
Борлуулалтын орлого	1,197,679	1,413,383	1,644,908	1,037,416
Борлуулалтын өртөг	(1,113,405)	(1,322,007)	(1,543,798)	(937,647)
Нийт ашиг	**84,274**	**91,376**	**101,111**	**99,769**
Нийт ашгийн маржин	7.0%	6.5%	6.1%	9.6%
Үйл ажиллагааны зардал	(21,159)	(17,269)	(26,917)	(15,997)
Бусад зардал	(7,082)	(7,592)	(11,652)	(4,880)
Бусад орлого	29	24	929	464
Үйл ажиллагааны ашиг	**56,062**	**66,539**	**63,471**	**79,356**
Үйл ажиллагааны ашгийн маржин	4.7%	4.7%	3.9%	7.6%
Санхүүгийн орлого	239	46	64	481
Санхүүгийн зардал	(33,209)	(51,662)	(53,991)	(28,800)
Татварын өмнөх ашиг	**23,092**	**14,924**	**9,544**	**51,037**
Татварын зардал	(6,696)	(3,350)	(36)	(12,222)
Цэвэр ашиг	**16,396**	**11,574**	**9,508**	**38,816**
Цэвэр ашгийн маржин	1.4%	0.8%	0.6%	3.7%

Үнэт цаас гаргагч Шунхлай ХХК нь Шунхлай газрын тосны бизнест бүтээгдэхүүний импортын үйл ажиллагааг хариуцдаг бөгөөд импортлон авсан бүтээгдэхүүнийг газрын тосны бизнесийн нэгдэлд хамаарах зэрэгцээ компаниудадаа борлуулдаг. Шунхлай ХХК нь газрын тосны бүтээгдэхүүнийг эдгээр компаниудад хүлээлгэн өгч хяналтыг бүрэн шилжүүлсэн үед борлуулалтын орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Эдгээр компаниуд нь Шунхлай ХХК-с газрын тосны бүтээгдэхүүнийг хүлээн авч ШТС болон газрын тосны бүтээгдэхүүний агуулахуудаар дамжуулан зах зээлд буюу эцсийн хэрэглэгчдэд бөөний болон жижиглэнгийн борлуулалт хийдэг. Өөрөөр хэлбэл Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлого нь ихэвчлэн холбоотой талын борлуулалт байдаг ба 2026 оны эхний хагас жилд гэхэд нийт борлуулалтын 93.7 орчим хувийг холбоотой талын борлуулалт бүрдүүлсэн байна.

График 3. Үнэт цаас гаргагчийн борлуулалтын задаргаа, 2025, 2026У2



Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлого 2023–2025 оны хооронд жилд дунджаар 17.2 хувиар өссөн. 2026 оны 2-р улирлын байдлаар 1.03 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.4 дахин өссөн үзүүлэлттэй байна. 2023-2025 оны хооронд нийт ашгийн маржин 6.1-7.0 хувийн хооронд хэлбэлзэж байсан бол 2026 оны 2-р улиралд дотоодын зах зээл дээрх шатахууны хомсдол, гэнэтийн үнийн өсөлтөөс үүдэн нийт ашгийн маржин өсөж, 9.6 хувьд хүрсэн байна. Энэ нь шатахууны үнэ өсөх үед үнэт цаас гаргагч нь бага өртөгтэй, хангалттай шатахууны нөөцтэй байсантай холбоотой. Харин цаашид борлуулсан бүтээгдэхүүний өртөг өсөх, үүнээс улбаалан нийт ашгийн маржин буцаж түүхэн дундаж руугаа очих хандлагатай байна.

График 4. Үнэт цаас гаргагчийн нийт ашгийн үзүүлэлт, сая төгрөг



2025 оны жилийн эцсийн тайлангийн бүрдлээс харахад үйл ажиллагааны зардал нийт зардлын дунджаар 29.1 хувийг, санхүүгийн зардал дунджаар 58.3 хувийг бүрдүүлсэн бол 2026 оны 2-р улирлын байдлаар үйл ажиллагааны зардал 32.2 хувийг, санхүүгийн зардал 58.0 хувийг тус тус бүрдүүлжээ. Үйл ажиллагааны зардлын материаллаг хэсгийг ерөнхий удирдлагын зардал бүрдүүлдэг бөгөөд үүнд, цалин урамшууллын зардал, элэгдэл, хорогдлын зардал, мэргэжлийн үйлчилгээний зардал зэрэг томоохон зардлууд багтдаг.

2026.08.31

График 5. Үнэт цаас гаргагчийн нийт зардлын бүтэц, 2026У2

2023-2025 оны хооронд үйл ажиллагааны ашгийн маржин 3.9-4.7 хувийн хооронд хэлбэлзсэн бөгөөд 2026 оны 2-р улирлын байдлаар үйл ажиллагааны ашгийн маржин 7.6 хувь болсон байна.

График 6. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны ашгийн үзүүлэлт, сая төгрөг

Үнэт цаас гаргагч Шунхлай ХХК нь газрын тосны бизнест мөн эх үүсвэр татан төвлөрүүлэх үүрэгтэй оролцож байгаа бөгөөд Шунхлай газрын тосны бизнесийн нийт банкны зээлийн 90 орчим хувийг Шунхлай ХХК-ийн авсан зээл бүрдүүлдэг. Мөн Шунхлай ХХК нь 273.9 тэрбум төгрөгийн хаалттай өрийн хэрэгслийг 2022-2026У2-ын хооронд татан төвлөрүүлсэн ба тайлант хугацаанд 100.0 тэрбум төгрөгийн бондын үлдэгдэлтэй гарсан байна.

Банкны зээл болон өрийн хэрэгсэл татан төвлөрүүлсэнтэй холбоотой санхүүгийн зардал материаллаг хэмжээгээр нэмэгдсэн бөгөөд 2023-2025 оны хооронд цэвэр ашгийн маржин 0.6-1.4 хувийн хооронд хэлбэлзсэн бол 2026 оны 2-р улирлын байдлаар цэвэр ашгийн хэмжээ 38.8 тэрбум төгрөгт, цэвэр ашгийн маржин 3.7 хувьд хүрсэн.

График 7. Үнэт цаас гаргагчийн цэвэр ашгийн үзүүлэлт, сая төгрөг



Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдлын тайлангийн шинжилгээ

Хүснэгт 10. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдлын тайлан, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2023	2024	2025	2026У2
Эргэлтийн хөрөнгө				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	5,057	2,225	8,819	42,694
Худалдааны болон бусад авлага, урьдчилгаа төлбөр	318,860	267,183	232,016	350,523
Бараа материал	74,403	57,714	80,207	75,266
Бусад эргэлтийн хөрөнгө	17,927	36,757	66,227	117,589
Нийт эргэлтийн хөрөнгө	**416,247**	**363,879**	**387,269**	**586,072**
Эргэлтийн бус хөрөнгө				
Үндсэн хөрөнгө	16,685	30,121	44,780	54,681
Биет бус хөрөнгө	1,142	1,427	1,642	1,109
Урт хугацаат хөрөнгө оруулалт	501	1,000	6,300	5,800
Эргэлтийн бус хөрөнгө	**18,328**	**32,548**	**52,722**	**61,590**
Нийт хөрөнгө	**434,574**	**396,427**	**439,991**	**647,662**
Өр төлбөр				
Дансны өглөг болон бусад өглөг	91,408	64,332	136,286	151,640
Банкны зээл	268,274	195,627	165,047	318,548
Бондын өглөг	50,000	100,000	100,000	100,000
Нийт өр төлбөр	**409,681**	**359,960**	**401,333**	**570,188**
Эздийн өмч				
Хувьцаат капитал	166	166	166	166
Хуримтлагдсан ашиг	24,728	36,301	38,492	77,308
Эздийн өмчийн дүн	**24,893**	**36,467**	**38,658**	**77,474**
Нийт өр төлбөр ба эздийн өмч	**434,574**	**396,427**	**439,991**	**647,662**

2023-2025 оны хооронд үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгийн жилийн дундаж нийлмэл өсөлт 0.6 хувь байсан бөгөөд 2026 оны 2-р улирлын байдлаар нийт хөрөнгө 647.7 тэрбум төгрөгт хүрч, 2025 оны эцсээс 47.2 хувиар өссөн байна. 2026 оны 2-р улирлын байдлаар нийт

хөрөнгийн 9.5 хувийг эргэлтийн бус хөрөнгө, 90.5 хувийг эргэлтийн хөрөнгө бүрдүүлж байна. Тайлант хугацаанд нийт 61.6 тэрбум төгрөгийн эргэлтийн бус хөрөнгөтэй байгаа ба үүний 54.6 тэрбум төгрөг нь үндсэн хөрөнгөөс бүрдэж байна.

Харин холбоотой талын буюу бизнес хоорондын авлага 293.7 тэрбум төгрөг байсан бөгөөд энэ нь нийт авлагын 82.8 хувь, эргэлтийн хөрөнгийн 50.1 хувь юм. Үнэт цаас гаргагч нь холбоотой талууд руу голчлон борлуулалтыг хийдэг тул компани хоорондын авлага үүсдэг. Харин нийт эргэлтийн хөрөнгийн 12.8 хувийг бараа материал бүрдүүлж байна.

I график 8. Нийт хөрөнгийн бүтэц, 2026У2



График 9. Эргэлтийн хөрөнгийн бүтэц, 2026У2

2026 оны 2-р улирлын байдлаар нийт хөрөнгийн 88.0 хувийг өр төлбөрөөр санхүүжүүлсэн бол үлдсэн хэсгийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлсэн байна. Өр төлбөрийн бүтцийн хувьд банкны зээл хамгийн өндөр буюу 55.9 хувийг бүрдүүлж байгаа бол бондын өглөг 17.5 хувийг, худалдааны болон бусад өглөг 26.6 хувийг тус тус бүрдүүлж байна. Шунхлай ХХК нь газрын тосны бизнесийн импортын үйл ажиллагааг хариуцахаас гадна эх үүсвэр бэлтгэх ажлыг мөн голчлон хариуцах, үндсэн зээлдэгчийн үүргийг гүйцэтгэдэг бөгөөд Шунхлай газрын тосны бизнесийн нийт зээлийн эх үүсвэрийн дунджаар 90 орчим хувийг үнэт цаас гаргагч Шунхлай ХХК-ийн зээл бүрдүүлдэг. Үнэт цаас гаргагч нь Шунхлай газрын тосны бизнест импортын үйл ажиллагааг хариуцаж байгаатай холбоотой худалдааны өглөг нь гадаадын бэлтгэн нийлүүлэгчдэд өгөх өглөг байдаг.

График 11. Эх үүсвэрийн бүтэц



График 10. Өр төлбөрийн бүтэц



Хүснэгт 11. Үнэт цаас гаргагчийн мөнгөн гүйлгээний тайлангийн голлох үзүүлэлтүүд, сая төгрөгөөр

(сая төгрөг)	2023	2024	2025	2026У2
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(106,343)	55,845	76,598	(68,665)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(18,076)	(29,248)	(34,743)	(46,076)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	114,681	(27,136)	(33,150)	148,616
Валютын ханшийн зөрүү	128	(2,293)	(2,166)	-
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өөрчлөлт	(9,610)	(2,832)	6,594	33,875
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	14,667	5,057	2,225	8,819
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	**5,057**	**2,225**	**8,819**	**42,694**

Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ сөрөг байгаа нь компани эргэлтэн дэх бараа материалыг нэмэгдүүлэх зорилгоор татан авалтын хэмжээг нэмэгдүүлж байсантай холбоотой. Тус онуудад үндсэн үйл ажиллагааны сөрөг мөнгөн гүйлгээг санхүүгийн үйл ажиллагааны эерэг мөнгөн урсгал буюу банкны зээл, бондын эх үүсвэрээр татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгөөр санхүүжүүлсэн байна. Хөрөнгө оруулалтын мөнгөн урсгал тайлант үеүдэд сөрөг байсан бөгөөд энэ нь үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгөн хөрөнгөтэй холбоотой.

СЗХ
2026 -09- 10
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2026 -09- 02
БҮРТГЭВ-03

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ

2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ

2.1 МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Олон улсад өрнөж буй геополитикийн нөхцөл байдлаас шалтгаалан шатахууны үнэ болон нийлүүлэлтийн тодорхой бус байдал нэмэгдэж, томоохон төв банкууд бодлогын хүүгээ өсгөх хүлээлт өндөр, дотоодын нийлүүлэлтийн гаралтай инфляцын түвшин өндөр зэргийг харгалзан Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2026 оны 8 дугаар сарын 12-ний өдрийн хурлаар бодлогын хүүг 12.5 хувь болгож өсгөх шийдвэрийг гаргалаа.

Хүснэгт 12. Монгол улсын макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Нэгж	2023	2024	2025	2026У2
Бодит сектор					
ДНБ, оны үнээр	тэрбум төг.	70,441.5	80,663.1	89,937.1	52,485.5
ДНБ, 2015 оны зэрэгцүүлэх үнээр	тэрбум төг.	30,567.1	32,132.7	34,331.9	16,428.2
ДНБ-ний бодит өсөлт	хувь	7.4%	5.1%	6.8%	7.7%
Нэг хүнд ногдох ДНБ, оны үнээр	сая төг	20.8	23.5	26.2	14.5
Мөнгөний сектор					
Мөнгө М1	тэрбум төг.	9,853.1	11,687.4	11,227.2	13,582.0
Мөнгө М2	тэрбум төг.	36,831.9	42,551.3	46,776.7	53,145.3
Нэгдсэн төсвийн орлого	тэрбум төг.	23,294.9	29,670.8	30,057.7	14,629.7
Нэгдсэн төсвийн тэнцэл	тэрбум төг.	785.9	(920.2)	(1,231.5)	(2,143.6)
Гадаад валютын албан нөөц	сая ам.дол.	4,921.6	5,509.8	7,005.3	7,656.2
Нийт гадаад өр*	сая ам.дол.	34,569.5	37,237.4	40,277.4	40,217.6
Засгийн газрын гадаад өр*	сая ам.дол.	8,105.1	8,397.1	8,750.2	8,518.6
Гадаад сектор					
Экспорт	сая ам.дол.	15,186.9	15,783.4	15,761.1	10,393.9
Импорт	сая ам.дол.	9,250.2	11,614.7	11,393.8	6,116.9
Худалдааны тэнцэл	сая ам.дол.	5,936.6	4,168.7	4.367.3	4,277.1
Хүүгийн түвшин					
Бодлогын хүү	%	13.0%	10.0%	12.0%	12.0%
Инфляцын түвшин	%	7.9%	8.4%	7.5%	12.0%
Шинээр татсан ₮ хадгаламжийн хүү, 10-12 сартай	%	14.35%	14.40%	13.78%	13.75%
Шинээр олгосон ₮ зээлийн ЖДХ, жилээр	%	16.0%	16.3%	16.7%	17.3%
Төгрөг ам.долларын албан ханш	төг.	3,410.7	3,420.5	3,556.8	3,580.0

** 2026 оны 1-р улирлын статистик мэдээллийг ашиглав.*

Эх сурвалж: ҮСХ, Монголбанк

2026.08.31

ДНБ: Монгол Улсын эдийн засгийн өсөлт, бууралт нь экспортын гол нэрийн бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт, гадаадын шууд хөрөнгө оруулалт, стратегийн ач холбогдолтой томоохон төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтээс шууд хамааралтай байдаг.

Монгол улсын эдийн засаг 2025 онд 6.8 хувиар өссөн бөгөөд тус өсөлтөд нүүрсний идэвхжил буурсан ч Оюу Толгойн зэсийн баяжмалын олборлолт 36.2 хувиар нэмэгдсэнээс үүдсэн уул уурхайн салбарын өсөлт болон 2 жил дараалсан зудын дараах хөдөө аж ахуйн салбарын сэргэлт голлох нөлөөг үзүүллээ.

Уул уурхай болон хөдөө аж ахуйн салбар өсөлтөө хадгалж, үйлчилгээний салбар сэргэснээр 2026 оны 2-р улиралд манай улсын эдийн засаг 7.7 хувиар тэлсэн байна. Тодруулбал, нүүрсний экспорт өндөр түвшинд хадгалагдаж, Оюу Толгойн зэсийн баяжмалын олборлолт нэмэгдсэнээр уул уурхайн салбарын үйлдвэрлэл эрчимжин тайлант хугацаанд 31.5 хувиар, мал аж ахуйн салбарын сэргэлтээс үүдэн хөдөө аж ахуй салбар 11.3 хувиар, үйлчилгээний салбар 3.8 хувиар тус тус өссөн байна.

График 12. Монгол Улсын нэрлэсэн ДНБ (их наяд төгрөгөөр) болон бодит ДНБ-ний өсөлт, хувиар

Эх сурвалж: УСХ

Олон улсын худалдааны тасалдал, геополитикийн хурцадмал байдал өндөр байгаа хэдий ч Дэлхийн банк, ОУВС, АХБ-ны шинжээчид Монгол Улсын эдийн засгийн өсөлтөд Оюу толгойн зэсийн баяжмалын олборлолтын өсөлт болон хөдөө аж ахуйн салбарын сэргэлт, дэд бүтцийн бүтээн байгуулалтууд голлох нөлөөг үзүүлснээр 2026 онд дунджаар 5.4 хувь, 2027 онд 5.7 хувиар сэргэнэ гэж таамаглал дэвшүүлсэн.

Хүснэгт 13. Бодит ДНБ-ий өсөлтийн төсөөлөл, хувиар

	2026Т	2027Т
Дэлхийн банк	5.0%	5.5%
АХБ	5.7%	6.0%
ОУВС	5.5%	5.5%
Дундаж	**5.4%**	**5.7%**

Эх сурвалж: Дэлхийн банк, АХБ, ОУВС

Инфляц, мөнгөний бодлого: Төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэлд инфляцыг дунд хугацаанд 5.0 хувь (+/-2 нэгж хувийн интервальтай)

Өрчимд тогтворжуулах бөгөөд 2027 оноос инфляцын зорилтыг 5.0 хувь болгон бууруулахаар төлөвлөж байна.

Инфляцын түвшин хүнсний бүтээгдэхүүний болон эрчим хүчний үнийн өсөлтөөс үүдэн 2025 оны жилийн эцэст 7.5 хувьд хүрсэн. 2026 он гарснаас хойш Монголбанкнаас мөнгөний хатуу бодлогоо үргэлжлүүлж байгаа хэдий ч хүнсний болон шатахууны үнийн өсөлтийн нөлөөгөөр инфляцын түвшин өсөж, 2026 оны 2-р улирлын байдлаар 12.0 хувь, 2026 оны 7 дугаар сарын байдлаар 13.0 хувьд тус тус хүрлээ. Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2026 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн хурлаар банкуудын гадаад зах зээлээс шинээр татсан 360 хоногоос 3 жил хүртэлх хугацаатай гадаад валютын бонд, зээлийн эх үүсвэрийн 25.0 хувьтай тэнцэх дүнг заавал байлгах нөөц тооцох эх үүсвэрт хамруулахаар шийдвэрлэсэн бол 2026 оны 8-р сарын 12-ны өдрийн хурлаар инфляцын хүлээлтийг тогтворжуулах, нийлүүлэлтийн шалтгаантай үнийн өсөлтийн хоёрдогч нөлөөг хязгаарлах, төгрөгийн өгөөжийн бодлогын зорилттой нийцүүлэх зорилгоор бодлогын хүүг 12.5 хувьд хүргэж, банкнуудын төргөөний заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 14.5 хувьд тус тус хүргэсэн.

Уул уурхайн гол бүтээгдэхүүн болох нүүрс, зэсийн үнэ өсөж, экспортын биет хэмжээ нэмэгдэж байгаа нь худалдааны нөхцөлийг сайжруулах, төлбөрийн тэнцэл ашигтай гарах, эдийн засгийн идэвхижлийг дэмжих хэдий ч шатахууны нийлүүлэлтийн хязгаарлалт удаан үргэлжлэх, гадаад үнийн өсөлт нэмэглэх зэрэг нь инфляцийг цаашид эрчимжүүлэх эрсдэлтэй байна.

График 13. Монгол Улсын инфляцын түвшин

Эх сурвалж: ҮСХ, Монголбанк

Дэлхийн банк, ОУВС, АХБ-ны шинжээчид инфляцын түвшнийг 2026 онд дунджаар 8.2 хувь, 2027 онд дунджаар 7.4 хувьд хүрнэ гэж таамагласан.

Хүснэгт 14. Инфляцын төсөөлөл, хувиар

	2026Т	2027Т
Дэлхийн банк	8.5%	7.8%
АХБ	7.8%	6.8%
ОУВС	8.2%	7.5%
Дундаж	**8.2%**	**7.4%**

Эх сурвалж: Дэлхийн банк, Азийн Хөгжлийн Банк, Олон Улсын Валютын Сан

Төсвийн тэнцэл: Монгол улсын төсвийн орлого 2025 онд 30,057.7 тэрбум төгрөгт, төсвийн зарлага 31,289.2 тэрбум төгрөгт тус тус хүрч, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1,231.5 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Нүүрсний үнэ огцом буурч, уул уурхайн

салбараас олох орлого саарсан, худалдааны салбарын идэвхжил буурснаас үүдэн төсвийн орлогын өсөлтийн хувь удааширсан байна.

2026 оны 2-р улирлын байдлаар улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлого 14,629.7 тэрбум төгрөгт, төсвийн тэнцвэржүүлсэн зарлага 16,773.3 тэрбум төгрөгт хүрснээр төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2,143.6 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Тэнцвэржүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс 10.3 хувиар өсөхөд нийгмийн даатгалын орлого 16.2 хувиар, нэмэгдсэн өртгийн албан татвар 11.7 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Харин тэнцвэржүүлсэн зарлага өмнөх оны мөн үеэс 20.0 хувиар өсөхөд барилга байгууламж, их засвар, бусад хөрөнгийн зардал өссөн нь голлон нөлөөлжээ.

График 14. Төсвийн тэнцэл, тэрбум төгрөгөөр



Гадаад худалдаа: 2025 оны байдлаар гадаад худалдааны нийт бараа эргэлт 27,155.0 сая ам.долларт хүрсэн ба нийт экспорт 15,761.2 сая ам. доллар, нийт импорт 11,393.8 сая ам.доллар хүрснээр гадаад худалдааны тэнцэл эерэг гарсан. Манай улс 2025 онд түүхэн дэх хамгийн их буюу 90.0 сая тонн нүүрс экспортолсон боловч нүүрсний дундаж үнэ 40.0 орчим хувиар буурснаар нүүрсний экспортын орлого 35.0 хувиар багассан бөгөөд энэхүү бууралтыг олон улсын зах зээлд зэс болон алтны үнэ нэмэгдэж, Оюу толгойн зэсийн баяжмалын олборлолт нэмэгдсэн нь нөхсөн хэдий ч экспортын орлого өмнөх оны мөн үеэс 0.5 хувиар буурлаа. Мөн сүүлийн 2 жил огцом өсөөд байсан хүнд даацын машин, механизм болон хэрэглээний импорт буурснаар нийт импорт өмнөх оны мөн үеэс 2.6 хувиар буурсан байна.

2026 оны 2-р улиралд манай улс нийт 150 улстай гадаад худалдаа хийснээр нийт бараа эргэлт 16,510.8 сая ам.долларт хүрч худалдааны тэнцэл 4,277.1 сая ам.долларын ашигтай гарсан. Тайлант хугацаанд Оюу толгойн зэсийн баяжмал болон нүүрсний олборлолт эрчимжсэнээр экспортын орлого өмнөх оны мөн үеэс 57.9 хувиар өсөж, 10,394 сая ам.долларт хүрлээ. Харин суудлын автомашин болон хүнд, машин механизмын импорт буурсан хэдий ч автобензин, лизель түлшний импорт өссөнөөр нийт импорт өмнөх оны мөн үеэс 10.6 хувиар өсөж 6,117 сая ам.долларт хүрсэн байна.

График 15. Гадаад худалдааны тэнцэл, сая ам.долларoор

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

2.2 ДЭЛХИЙН ГАЗРЫН ТОСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Дэлхийн түүхий газрын тосны нөөц: 2025 оны байдлаар Дэлхийн газрын тосны батлагдсан нөөц 1,572.5 тэрбум баррел байна. Үүний 79.1 хувийг буюу дийлэнх хэсгийг ОПЕК-ийн гишүүн улсууд бүрдүүлж байгаа бол 5.1 хувийг ОХУ, 2.2 хувийг БНХАУ, үлдсэн хэсгийг бусад улсын нөөц бүрдүүлж байна. Дэлхийн газрын тосны нөөцийн дийлэнх хэсгийг бүрдүүлж буй ОПЕК-ийн олборлолтын бодлого нь дэлхийн газрын тосны нийлүүлэлт, улмаар Брент зэрэг олон улсын газрын тосны үнийн төлөвт чухал нөлөө үзүүлдэг.

График 16. Дэлхийн газрын тосны батлагдсан нөөц, тэрбум баррель



Эх сурвалж: OPEC, Annual Statistical Bulletin

Дэлхийн газрын тосны эрэлт: 2025 оны байдлаар газрын тосны эрэлт дунджаар 105.2 сая баррель/өдөрт хүрсэн Нийт эрэлтийн 19.7 хувийг АНУ, 16.1 хувийг БНХАУ, 3.8 хувийг ОХУ, 8.9 хувийг ОПЕК-ийн гишүүн орнууд, үлдсэн хэсгийг дэлхийн бусад улс орнуудын эрэлт

бүрдүүлж байна. Газрын тосны эрэлт нь дэлхийн эдийн засгийн өсөлт, тээврийн салбар, аж үйлдвэрлэл, нефть-химийн үйлдвэрлэлийн өсөлттэй нягт холбоотой байдаг. Ялангуяа хөгжиж буй орнуудын эдийн засгийн идэвхжил, тээвэр, аж үйлдвэр, барилга, хөдөө аж ахуйн салбарын түлшний хэрэглээ нь дэлхийн газрын тосны эрэлтийн өсөлтийн гол хүчин зүйлсийн нэг болж байна Цаашид дэлхийн нийт газрын тосны эрэлт 2026 онд 105.7 сая баррель/өдөр, 2027 онд 107.9 сая баррель/өдөр хүрэх тооцоотой байна.

График 17. Дэлхийн газрын тосны эрэлт, сая баррель/өдөр



Эх сурвалж: OPEC, Annual Statistical Bulletin

Түүхий газрын тосыг ашиглан бензин, дизель түлш, тийрэлтэт хөдөлгүүрийн түлш, шингэрүүлсэн хий зэрэг түлшний бүтээгдэхүүнээс гадна тос, тослох материал, нефть-химийн үйлдвэрлэлийн түүхий эд, хуванцар зэрэг бүтээгдэхүүнүүдийг гаргаж авдаг. Нийт эрэлтийг боловсруулсан бүтээгдэхүүний төрлөөр нь авч үзвэл 27.9 хувийг дизель түлш, 26.4 хувийг бензин, үлдсэн хэсгийг бусад төрлийн бүтээгдэхүүн бүрдүүлж байна.

Хүснэгт 15. Дэлхийн газрын тосны эрэлт, боловсруулсан бүтээгдэхүүний төрлөөр

сая.баррел/өдөр	2021	2022	2023	2024	2025
Бензин	25.61	26.13	26.97	27.38	27.72
Керосин	5.46	6.22	7.28	7.77	8.06
Дизель түлш	27.97	28.82	29.01	28.99	29.38
Үлдэгдэл	6.36	6.33	6.64	6.60	6.41
Бусад бүтээгдэхүүн	32.20	32.37	32.45	33.11	33.59
Нийт эрэлт	**97.59**	**99.87**	**102.36**	**103.85**	**105.15**

Газрын тосны /Brent/ үнэ: 2025 онд түүхий нефтийн жилийн дундаж үнэ нэг баррель нь 68.0 ам.долларт хүрч, өмнөх оноос 16.8 хувиар буурсан бөгөөд энэ нь дэлхийн зах зээл дэх нийлүүлэлт харьцангуй өндөр, эрэлт сул байсантай холбоотой байв. Харин 2026 оны эхний хагаст геополитикийн эрсдэл нэмэгдэж, бүс нутгийн нийлүүлэлтийн тодорхой бус байдал өссөнөөр нефтийн үнэ өндөр хэлбэлзэлтэй байлаа. 2026 оны эхний хагас жилд АНУ-с Израйль, Ираны эсрэг цэргийн ажиллагаа явуулж, улмаар түр бус нутгийг хамарсан

ШҮНХЛАЙ
2026.09.10
БҮРТГЭГДСЭН
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2026-09-02
БҮРТГЭГДСЭН

өргөн хүрээний мөргөлдөөнөөс үүдэн Персийн булангийн газрын тосны үйлдвэрлэл болон Ормузын хоолойгоор дамжих газрын тосны тээвэрт хүчтэй нөлөөлснөөр газрын тосны үнэ энэ оны оргилдоо буюу 114.1 ам.долларт хүрсэн бөгөөд 2026 оны 2-р улиралд дундаж ханш 87.0 ам.доллар байв. Улмаар АНУ болон Ираны хооронд энхийн хэлэлцээр хийгдэх мэдэгдлүүд гарч эхэлснээр нийлүүлэлтийн эрсдэл буурч, ханш буурах хандлагатай байна.

Дэлхийн банкны таамаглалаар Брент төрлийн газрын тосны дундаж үнэ 2026 онд 86.0 ам.доллар, 2027онд 70 ам.долларт хүрэхээр байна.

График 18. *Газрын тосны үнэ /Brent/*



Боловсруулсан газрын тосны бүтээгдэхүүний экспорт: Боловсруулсан газрын тосны бүтээгдэхүүний нийт экспорт 2025 оны байдлаар 32.0 сая баррель/өдөр байгаагийн 21.0 хувийг АНУ, 16.6 хувийг ОПЕК-ийн гишүүн орнууд, 6.5 хувийг ОХУ, 3.9 хувийг БНХАУ, үлдсэн хэсгийг бусад улс орнууд бүрдүүлж байна. Бүтээгдэхүүний төрлөөр нь авч үзвэл 17.6 хувийг бензин, 25.6 хувийг дизель, үлдсэн хэсгийг бусад төрлийн бүтээгдэхүүн бүрдүүлж байна.

График 19. *Дэлхийн улсуудын боловсруулсан газрын тосны экспорт, сая баррель/өдөр*



Эх сурвалж: OPEC, Annual Statistical Bulletin

УЛААНБААТАР ХОТ
ШҮНХЛАЙ
ХХК
УТА3531 ☎ 2028468
Golomt Capital
Delivering di
1119289111 ☎ 5481589
Улаанбаатар хот

ОХУ: Манай улсын голлох газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэгч болох ОХУ-ын хувьд Украйнтай эхлүүлсэн дайны нөхцөлөөс шалтгаалан олон улсын хориг арга хэмжээнүүд тавигдаж, экспортын чиглэлээ Европын зах зээлээс Ази болон бусад бүс нутгийн зах зээл рүү чиглүүлэн өөрчилснөөс гадна ОХУ-ын газрын тос боловсруулах үйлдвэрүүдэд гарсан Украйны дроны халдлагаас үүдэн дотоодын шатахууны хэрэглээг хангах зорилгоор хийсэн экспортын хязгаарлалт зэргээс үүдэн 2025 оны газрын тосны бүтээгдэхүүний экспорт 2021 онтой харьцуулахад жилд дунджаар 3.2 хувиар буурч 2.1 сая баррель/өдөр хүрсэн.

Хүснэгт 16. ОХУ-ын газрын тосны бүтээгдэхүүний экспорт, төрлөөр

мянган.баррел/өдөр	2021	2022	2023	2024	2025
Бензин	87.7	123.2	147.2	101.9	69.9
Керосин	50.4	50.1	49.4	52.0	37.4
Дизель түлш	758.5	712.1	869.9	796.9	783.4
Үлдэгдэл	799.8	741.8	678.9	615.9	627.9
Бусад бүтээгдэхүүн	688.8	649.6	554.0	568.9	576.8
Нийт экспорт	**2,385.2**	**2,276.9**	**2,299.4**	**2,135.6**	**2,095.3**

Эх сурвалж: OPEC, Annual Statistical Bulletin

2026 он гарснаас хойш Украйны ОХУ-ын газрын тос боловсруулах үйлдвэр, агуулах, дамжуулах хоолой, эрчим хүчний дэд бүтцэд чиглэсэн дроны халдлагын давтамж, цар хүрээ нэмэгдсэн бөгөөд 2026 оны эхний 5 сарын байдлаар ОХУ-ын 16 газрын тос боловсруулах үйлдвэр дроны халдлагад өртөж, ойролцоогоор өдөрт 700 мянган баррель боловсруулах хүчин чадал бүхий тоног төхөөрөмжийг түр хугацаагаар зогсоосон байна. Үүнээс үүдэн ОХУ-ын газрын тосны экспорт буурч, дотооддоо шатахууны хомсдолтой байгаа ба тус улсын Засгийн газраас бензин, дизелийн экспортын хоригийг 2027 оны 1-р сарын 31-нийг дуустал сунгаад байна.

БНХАУ: БНХАУ-ын хувьд экспортын хэмжээ нь дотоодын шатахууны эрэлт, төрөөс хэрэгжүүлж буй экспортын квотын бодлого, газрын тосны үнийн нөхцлөөс хамаардаг бөгөөд 2024-2025 онуудад харьцангуй тогтвортой буюу дунджаар 1,236.6 мянган баррель/өдөр байна.

Хүснэгт 17. БНХАУ-ын газрын тосны бүтээгдэхүүний экспорт, төрлөөр

мянган.баррел/өдөр	2021	2022	2023	2024	2025
Бензин	340.2	293.3	286.1	226.2	185.8
Керосин	182.3	232.1	336.8	401.8	462.9
Дизель түлш	342.1	216.1	274.9	157.7	131.6
Үлдэгдэл	356.0	338.3	358.4	366.9	372.1
Бусад бүтээгдэхүүн	68.4	66.8	76.8	85.6	82.6
Нийт экспорт	**1,288.9**	**1,146.4**	**1,333.0**	**1,238.2**	**1,235.0**

Эх сурвалж: OPEC, Annual Statistical Bulletin

2026 оны эхний хагаст Ойрх Дорнодын зөрчилдөөн болон газрын тосны нийлүүлэлтийн тодорхой бус байдал нэмэгдсэнтэй холбоотойгоор БНХАУ нь экспортын квот тогтоох бодлогоо үргэлжүүлсэн бөгөөд 7-р сараас экспортын хязгаарлалтыг бууруулаад байна.

2.3 МОНГОЛ УЛСЫН ГАЗРЫН ТОСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Монгол Улсын хувьд газрын тосны бүтээгдэхүүн нь стратегийн өндөр ач холбогдол бүхий бүтээгдэхүүн болохын хувьд сүүлийн 5 жилийн хугацаанд нийт импортын 16.5-18.7 хувийг, 2026 оны 2-р улирлын байдлаар 22.3 хувийг бүрдүүлж байна. Импортолж буй улсаар авч үзвэл 2025 оны байдлаар үнийн дүнгээр 94.6 хувийг, тоо хэмжээгээр 97.3 хувийг, 2026 оны 2-р улирлын байдлаар үнийн дүнгээр 95.6 хувийг, тоо хэмжээгээр 97.6 хувийг ОХУ-с дангаар импортолжээ.

Хүснэгт 18. Газрын тосны бүтээгдэхүүний импорт, сая ам.долларoор

сая ам.доллар	2021	2022	2023	2024	2025	2026У2
Нийт импорт	6,845.5	8,704.4	9,250.2	11,614.7	11,393.8	6,116.9
Газрын тосны бүтээгдэхүүн	1,131.8	1,723.6	1,868.6	2,162.0	2,128.3	1,363.3
ОХУ-с импортолсон нь	*88.6%*	*91.8%*	*90.5%*	*93.3%*	*94.6%*	*95.6%*
Нийт импортод эзлэх хувь	**16.5%**	**19.8%**	**20.2%**	**18.6%**	**18.7%**	**22.3%**

Эх сурвалж: ҮСХ, Гаалийн ерөнхий газар

Монгол Улсын хэмжээнд газрын тосны бүтээгдэхүүний импортын голлох хэсгийг дизель түлш болон автобензиний импорт эзэлж байна. Манай улсын эдийн засаг уул уурхайн салбараас шууд хамааралтай байдаг ба дизель түлшний гол хэрэглэгч нь уул уурхайн салбар байдаг. Олон улсын байгууллагуудаас манай улсын эдийн засгийн өсөлтийг дунджаар 2026 онд 5.4 хувь, 2027 онд 5.7 хувь байна гэж таамагласан бөгөөд тус өсөлтөд уул уурхайн салбарын өсөлт голлох нөлөөг үзүүлэх учир дизель түлшний хэрэглээ нэмэгдэх хүлээлттэй байна.

Хүснэгт 19. Газрын тосны голлох бүтээгдэхүүний импорт, бүтээгдэхүүний нэр төрлөөр

сая ам.доллар	2024 он	%	2025 он	%	2026У2	%
Автобензин	643.2	29.8%	604.6	28.1%	362.8	17.0%
Дизель түлш	1,296.0	59.9%	1,343.2	63.1%	909.1	42.7%
Онгоцны түлш	88.1	4.1%	84.4	4.0%	39.9	1.9%
Бусад	134.7	6.2%	96.1	4.5%	51.5	2.4%
Нийт газрын тосны бүтээгдэхүүн	**2,162.0**	**100.0%**	**2,128.3**	**100.0%**	**1,363.0**	**100.0%**

Эх сурвалж: ҮСХ, Гаалийн ерөнхий газар

Сүүлийн 5 жилийн жинлэсэн дундаж өсөлтөөр импортолсон бүтээгдэхүүний тоо хэмжээ автобензин 10.2 хувиар, Дизель түлш 16.7 хувиар, Онгоцны түлш 35.0 хувиар тус тус өссөн байна.

График 20. Голлох газрын тосны бүтээгдэхүүний импорт, мянган тонноор

Эх сурвалж: УСХ

2026 оны 7-р сарын байдлаар АИ-92 бензиний хилийн үнэ тонн тутамд 780.2 ам.доллар байгаа бол АИ-95 бензин 1,138.8 ам.доллар, Дизель түлш 1,278.5 ам.доллар болж өсөх хандлагатай байна. Тухайн сард АИ-92 бензиний нөөц өмнөх оны мөн үеэс 63.1 хувиар буурч 28.4 мянган тоннд, дизель түлшний нөөц өмнөх оны мөн үеэс 56.3 хувиар буурч 67.1 мянган тоннд хүрч буурсан үзүүлэлттэй байсан бол 2026 оны 8-р сарын 21-ний өдрийн байдлаар АИ-92 бензины нөөц 18.0 мянган тоннд хүрч 8 хоногийн нөөцтэй, дизель түлшний нөөц 63.2 мянган тоннд хүрч 16 хоногийн нөөцтэй, АИ-95 бензиний нөөц 1.9 мянгад хүрч 15 хоногийн нөөцтэй болсноор манай улс шатахууны хомсдол ороод байна.

График 21. Газрын тосны нөөцийн хэмжээ, тонн



Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газар

Шатахууны хомсдолыг бууруулахын тулд Монгол улсын Засгийн Газрын зүгээс дараах арга хэмжээг хэрэгжүүлж байна. Үүнд:

1. 2026 оны 8-р сард ОХУ-ын "Роснефть", "Нефтьхимисервис", "Газпром" нефть болон бусад компани, БНХАУ болон БНСУ-аас нийтдээ 86,460 тонн АИ-92 автобензин, 1,280 тонн АИ-95 автобензин, 178,650 тонн дизель түлш, 7000 тонн онгоцны түлш авахаар захиалгаа баталгаажуулж, гэрээ хэлцэл хийсэн.
2. Ойрх Дорнод дахь геополитикийн нөхцөл байдал, Орос, Украины дайнаас шалтгаалан нефтийн үнийн өсөлт дэлхийн зах зээлд буураагүйгээс шалтгаалан 8 дугаар сард хилийн үнэ тонн тутамд дахин өсөж, ОХУ болон бусад эх үүсвэрээс худалдан авах шатахууны үнэ 1200-2000 ам.долларт хүрчээ. Засгийн газрын зүгээс дотоодын зах зээл дэх үнийн өсөлтийг сааруулах үүднээс бүх төрлийн шатахууны импортын гаалийн албан татварын хувь, хэмжээг 2027 оны 2-р сарын 1-нийг хүртэл тэглэх шийдвэр гаргасан.

3. Газрын тос, шатахууны нөөцийн 22 агуулах барихаар холбогдох аж ахуй нэгжүүдэд хөнгөлөлттэй зээлийг олгосон.

МОНГОЛ УЛСЫН ГАЗРЫН ТОСНЫ ОЛБОРЛОЛТ, ЭКСПОРТ

Монгол улс нь дотооддоо Тосон-Уул, Тамсаг, Зүүнбаян, Цагаан-Элс, Цэн Тогоруу ордуудаараа дамжуулан газрын тос олборлож БНХАУ руу экспортолдог. Сүүлийн жилүүдэд Монгол улсын түүхий газрын тосны олборлолтын хэмжээ буурч байгаагаас үүдэн экспортын хэмжээ буурах хандлагатай байна. Засгийн газрын зүгээс импортын хараат байдлыг бууруулах хүрээнд газрын тосны хайгуул, олборлолтыг ажлыг эрчимжүүлэхээр ажиллаж байна.

График 22. Газрын тосны олборлолт, экспорт, мянган баррель

Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газар

2026.08.31

СЗХ
2026 .09. 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛ УЛСЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2026 -09- 02
БҮРТГЭВ-03

ГУРАВ. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

3. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

3.1 ОЛОН НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн В/14 тоот тогтоолын дагуу нийт 100,000,000,000 /нэг зуун тэрбум/ төгрөгийн дүнтэй өрийн хэрэгслийн хөтөлбөрийг олон нийтэд нээлттэй хүрээнд санал болгон арилжихаар шийдвэрлэсэн бөгөөд 2026 оны 3-р улиралд багтаан арилжихаар төлөвлөж байна.

Хүснэгт 20. Үнэт цаасны нөхцөл

Үнэт цаас гаргагч	ШУНХЛАЙ ХХК
Үнэт цаасны нэр	Шунхлай бонд - 4
Үнэт цаасны төрөл	Энгийн хүүтэй, хөтөлбөртэй бонд
Бондын арилжаа	Монголын хөрөнгийн биржээр олон нийтэд нээлттэй хүрээнд
Бондын хөтөлбөр хэрэгжүүлэх	Хэсэгчлэн гаргах үнийн дүнг Компанийн гүйцэтгэх захирал тухай бүрд шийднэ
Бондын тоо ширхэг	1,000,000 (нэг сая) ширхэг
Бондын нэрлэсэн үнэ, (ширхэг)	100,000 (нэг зуун мянга) төгрөг
Бондын хөтөлбөрийн нийт дүн	100,000,000,000 (нэг зуун тэрбум) төгрөг
Бондын хугацаа	12 сар
Бондын хүү	18.0 хувь
Хүүгийн төлөлт	Хагас жил тутам
Үндсэн төлбөр төлөлт	Хугацааны эцэст
Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулах зориулалт	Эргэлтийн хөрөнгийн санхүүжилт
Үнэт цаасны хүүгийн орлогын татвар	5.0 хувь
Бондын эргэн төлөлт	Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны эргэн төлөлтийг газрын тосны бүтээгдэхүүний борлуулалт буюу үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлогоор санхүүжүүлнэ.
Барьцаа	Барьцаа болон баталгаагүй, зээлжих зэрэглэл тогтоолгосон.
Бондын зэрэглэл	Монголын хөрөнгө оруулалтын зэрэглэлийн эжинси ХХК / Mongolian Investment Rating Agency/- "А тогтвортой"

Хүүгийн төлбөр	Бондын хүүг хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс эхлэн жилийн хүүг 365 хоногоор тооцно. Хэрэв хүү төлөх өдөр амралтын өдөр таарвал дараагийн ажлын өдөр төлөх ба энэ тохиолдолд амралтын өдрүүдэд хүүг нэмж тооцохгүй.
Бондын хадгалалт, төлбөр тооцоо	Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв
Нийтэд санал болгохоор төлөвлөж буй хугацаа	2026 оны 3-р улирал
Хувьцаанд хөрвөх нөхцөлтэй эсэх	Үгүй

3.2 БОНДЫН ХҮҮ ТОГТООСОН ҮНДЭСЛЭЛ

Үнэт цаас гаргагч нь бондын хүүгийн түвшнийг тодорхойлохдоо Монголбанкнаас зарласан бодлогын хүү, зах зээл дэх ижил төстэй өрийн хэрэгслийн хүүгийн түвшин, үнэт цаас гаргагчийн санал болгож буй үнэт цаасны эрсдэлийн хүчин зүйл зэрэгт үндэслэж тооцсон.

2026 оны 8 дугаар сарын байдлаар Монголбанкнаас зарласан бодлогын хүүгийн түвшин 12.5 хувь, 2026 оны 7-р сарын байдлаар улсын инфляцын түвшин 13.0 хувь байна. Монголбанкны статистикийн дагуу арилжааны банкнуудын шинээр татсан төгрөгийн 12 сарын хугацаатай хадгаламжийн жинлэсэн дундаж хүү 13.75 хувь байна.

Үнэт цаас гаргагчийн санал болгож буй Шунхлай-4 бонд нь 18.0 хувийн хүүгийн түвшинд буюу шинээр татаж буй төгрөгийн хадгаламжийн жинлэсэн дундаж хүүтэй харьцуулахад нэрлэсэн хүүгийн түвшинд 4.25 нэгжээр өндөр өгөөжтэй байна.

Шунхлай-4 бондын санал болгож буй хүүгийн түвшнийг арилжааны банкнуудын 12 сарын хугацаатай төгрөгийн хадгаламжийн дундаж хүү болон 2025-2026 онд дотоодын биржүүд дээр бүртгэгдсэн нээлттэй өрийн хэрэгслүүдийн хүүтэй харьцуулан доор харуулав.

График 23. Хүүгийн түвшний харьцуулалт

3.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛ

Монголын Хөрөнгө Оруулалтын Зэрэглэлийн Эжинси ХХК нь үнэт цаас гаргагчийн зээлжих зэрэглэлийг байгууллагын болон үнэт цаасны түвшинд дараах байдлаар тогтоосон байна.

Хүснэгт 21. Үнэт цаас гаргагчийн зээлжих зэрэглэл

Зэрэглэлийн төрөл	Үнэт цаасны төрөл	Үнэт цаасны нэр	Үнэт цаасны дүн	Зэрэглэлийн УА	Хүчинтэй огноо	Зэрэглэл & Төлөв байдал
Байгууллагын зэрэглэл	n/a	n/a	n/a	Тогтоосон	2026.11.24	"А" тогтвортой
Үнэт цаас	Хаалттай болон нээлттэй бонд	Бонд	200.0 тэрбум төгрөг	Шинээр гаргах	2026.11.24	"А" тогтвортой

Зээлжих зэрэглэлийн компани нь байгууллагын, хаалттай болон нээлттэй гаргаж буй бондын зэрэглэлийг 2026 оны 8-р сарын 27-ны өдөр "А тогтвортой" гэж үнэлсэн байна.

Компани нь мөн зээлжих зэрэглэлийн шатлалыг тодорхойлсон бөгөөд тус шатлалын дагуу "А тогтвортой" үнэлгээ нь эрсдэл багатай, хөрөнгө оруулалтын дундаас дээш ангилалд багтаж байна.

Монголын Хөрөнгө Оруулалтын Зэрэглэлийн Эжинси ХХК нь 2026 оны 8-р сарын байдлаар нийт 16 компанийн дотоодын зээлжих зэрэглэлийг тогтоосон бөгөөд Шунхлай ХХК, Инвескор ББСБ ХК болон Аригбанк ХХК нь зээлжих зэрэглэл тогтоолгосон компаниуд дотроос хамгийн өндрөөр буюу "А (тогтвортой)" гэж үнэлэгдсэн байна.

Хүснэгт 22. Дотоодын зээлжих зэрэглэл тогтоолгосон компаниудын мэдээлэл

№	Зээлжих зэрэглэл тогтоолгосон компанийн нэр	Зэрэглэл тогтоолгосон/шинэчилсэн огноо	Зээлжих зэрэглэлийн үнэлгээ
1	Шунхлай ХХК	2026.08.27	А тогтвортой
2	Аригбанк ХХК	2026.06.24	А тогтвортой
3	Инвескор ББСБ ХК	2026.06.03	А тогтвортой
4	Таванбогд Финанс ББСБ ХХК	2026.06.03	А- хувьсах
5	Покет ББСБ ХХК	2026.05.29	BBB+ хувьсах
6	Ашид Капитал ББСБ ХХК	2026.06.03	BBB+ хувьсах
7	Соно Финтек ББСБ ХХК	2026.06.03	BBB+ хувьсах
8	БиДиСек ҮЦК ХК	2026.06.10	BBB хувьсах
9	Веллком ХХК	2026.05.22	BBB хувьсах
10	Нөмөр Кредит ББСБ ХХК	2026.06.03	BBB хувьсах
11	Омни Капитал ББСБ ХХК	2026.05.27	BBB- хувьсах
12	Ти Ди Би Лизинг ХХК	2026.05.22	BBB- хувьсах
13	Ард Кредит ББСБ ХК	2026.06.24	BB+ хувьсах
14	Си И Си Инвестмент ХХК	2026.06.03	BB хувьсах
15	Хатан Суудал Инвест ББСБ ХХК	2026.06.03	BB хувьсах

3.4 ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

Шунхлай ХХК нь нийт татан төвлөрүүлсэн 100.0 тэрбум төгрөгийг бараа материалын татан авалт буюу газрын тосны бүтээгдэхүүн импортоор худалдан авахад зарцуулна. Үнэт цаас гаргагч Шунхлай ХХК нь дотоодын шатахууны эрэлтийг хангахын тулд шатахууны худалдан авалтаа нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Үнэт цаас гаргагч нь үнэт цаас гаргахтай холбоотой зардлыг татан төвлөрүүлэх хөрөнгөөс зарцуулахгүй бөгөөд өөрийн үндсэн үйл ажиллагааны мөнгөн хөрөнгөөс зарцуулна.

3.5 ҮНЭТ ЦААСААР ГЭРЧЛЭГДЭХ ЭРХ, ҮҮРЭГ

Үнэт цаас гаргагч болон үнэт цаас эзэмшигч нь холбогдох хууль, тогтоомж, дүрэм журмууд, Андеррайтер болон үнэт цаас гаргагч нарын хооронд байгуулсан Бондын гэрээний дагуу дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:

Үнэт цаас эзэмшигч нь дараах эрх, үүрэгтэй байна:

- ✓ Үнэт цаасыг худалдан авах, хөрөнгө оруулалт хийх шийдвэрийг бие даан гаргах эрхтэй;
- ✓ Үнэт цаасыг МХБ-ийн арилжааны журмын дагуу худалдан авснаар үнэт цаасыг эзэмшилдээ шилжүүлэн авах, түүнийг шаардах эрхтэй;
- ✓ Эзэмшиж буй үнэт цаасыг чөлөөтэй арилжих, захиран зарцуулах;
- ✓ Үнэт цаасны хүү болон үндсэн төлбөрийг хуваарийн дагуу хүлээн авах, төлбөрийг хуваарийн дагуу төлөхийг үнэт цаас гаргагчаас шаардах;
- ✓ Үнэт цаас эзэмших эрхээ чөлөөтэй арилжаалах, захиран зарцуулах;
- ✓ Үнэт цаас эзэмшиж буй хугацаанд Үнэт цаас гаргагчийн санхүүгийн болон үйл ажиллагааны мэдээллийг хүлээн авах, шаардах, танилцах;
- ✓ Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны танилцуулгад тусгасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бол биелүүлэхийг шаардах;
- ✓ Монгол Улсын аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу бондын хүүгийн орлогоос татвар төлөх;
- ✓ Хууль тогтоомжид заасан бусад.

Үнэт цаас гаргагч нь дараах үүрэгтэй байна:

- ✓ Андеррайтер, бонд эзэмшигчээс хуул тогтоомж болон энэхүү гэрээнд заасан үүргээ биелүүлэхийг шаардах;
- ✓ Үнэт цаас эзэмшигчдийг компанийн үйл ажиллагаа, санхүү, бусад шаардлагатай зүйлсийн талаар үнэн зөв, хоёрдмол утгагүй, бодит мэдээллээр хангах;
- ✓ Үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийг хуваарийн дагуу үнэт цаас эзэмшигчдэд төлөх;
- ✓ Татан төвлөрүүлсэн хөрөнгийг Үнэт цаасны танилцуулгад тусгасны дагуу зориулалтын дагуу зарцуулах;
- ✓ Үнэт цаас гаргагч нь холбогдох гэрээний үүргээ биелүүлээгүйн улмаас үнэт цаас эзэмшигчид учруулсан аливаа хохирлыг төлж барагдуулах;
- ✓ Үнэт цаас гаргагч нь үндсэн болон хүүгийн төлбөрийг төлбөр хийгдэх өдрөөс ажлын 3 хоногийн өмнө ҮЦТХТ-д байрших өөрийн дансанд байршуулах;
- ✓ Үнэт цаасны ханш, арилжааны хэмжээнд мэдэгдэхүйц нөлөөлж болох нөхцөл байдал үүсмэгц энэ тухай нийтэд олон нийтэд болон эрх бүхий байгууллагуудад нэн даруй мэдээлэх;
- ✓ Бондыг бүртгүүлэхтэй холбоотойгоор СЗХ-нд хүргүүлсэн баримт бичиг, түүнд хавсаргасан баримт бичгийг бондын хугацаа дуусаж, үндсэн болон хүүгийн төлбөрийг бүрэн төлж дуусах хүртэлх хугацаанд компанийн байранд, цаашид хуульд заасан хугацаанд хадгалах;
- ✓ Хууль тогтоомжид заасан бусад.

3.6 ҮНЭТ ЦААСЫГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД АРИЛЖААЛАХ

Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа нь МХБ-ийн 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн №2018/01 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам", СЗХ-ны 2021 оны 6 дугаар сарын 11-ны өдрийн 226 дугаар тогтоолоор батлагдсан "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам", МХБ-ийн 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 15 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам" болон 2012 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн №02 тоот тогтоолоор батлагдсан "Арилжааны журам"-ын дагуу явагдана.

СЗХ-ны өрийн хэрэгслийн бүртгэлийн журмын дагуу хэсэгчлэн гаргах өрийн хэрэгслийн эхний нийлүүлэлтийг бондыг СЗХ-нд бүртгүүлснээс хойш 6 сарын дотор гүйцэтгэх бөгөөд бондын хөтөлбөрийг нийт 18 сарын хугацаанд хэрэгжүүлэх дуусах шаардлагатай юм. Андеррайтер нь бондын хөтөлбөрийг хэрэгжүүлж анхдагч зах зээлд санал болгох тухай бүрдээ ажлын 5-с доошгүй өмнө хороонд мэдэгдэх ба анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг ажлын 5 хоногийн дотор хүлээн авна.

График 24. Анхдагч зах зээлийн арилжааны төлөвлөгөө

Бүртгүүлэх	· МХБ,СЗХ-оос үнэт цаасыг бүртгэх шийдвэр гаргах
Roadshow /Нийтэд мэдээллэх аян/	· Олон нийтэд үнэт цаас, үнэт цаас гаргагчийг танилцуулах
Book building /Захиалга авах	· Олон нийтээс захиалга авах, захиалгын санг бүрдүүлэх
Хуваарилалт	· Үнэт цаасны нийлүүлэлт хийж анхдагч зах зээлийн арилжааг хаах
Төлбөр тооцоо	· Арилжааны журмын дагуу арилжааны төлбөр тооцоог гүйцэтгэх

Анхдагч зах зээлийн арилжих арга

Монголын хөрөнгийн биржийн 2018 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 15 тоот тогтоолоор баталсан "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-д заасны дагуу үнэт цаас гаргагчийн тогтоосон тодорхой үнэ (өгөөж)-ээр санал болгох ба захиалга 100 хувь биелсэн тохиолдолд анхдагч зах зээлийн арилжааг хаана.

Үнэт цаасыг бүртгүүлж, холбогдох зөвшөөрөл авах

Үнэт цаас гаргагч нь нийтэд санал болгох үнэт цаасыг бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг СЗХ болон МХБ-д гаргах бөгөөд эдгээр эрх бүхий байгууллагуудаас үнэт цаасыг бүртгэхийг зөвшөөрснөөр үнэт цаасыг нийтэд санал болгон арилжаалах боломжтой болно. Өрийн хэрэгслийг хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх бөгөөд хэсэгчлэн анхдагч зах зээлд санал болгох тухай бүрд СЗХ-нд ажлын 5-с доошгүй өдрийн дотор мэдэгдэнэ.

Олон нийтэд танилцуулах

Үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгох тухай мэдэгдлийг холбогдох журмын дагуу СЗХ-нд хүргүүлж үнэт цаасыг нийтэд санал болгон танилцуулах аяныг зохион байгуулна. Үүнд, хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн оролцогч, олон нийт болон стратегийн хөрөнгө оруулагчдад зориулсан танилцуулга уулзалт болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр үнэт цаасыг танилцуулах мэдээ мэдээлэл зэрэг нь багтана.

Анхдагч зах зээлийн арилжааны захиалга хүлээн авах

Үнэт цаас гаргагч нь анхдагч зах зээлийн захиалга авч эхлэхээс ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө анхдагч зах зээлийн арилжааг эхлүүлэх мэдэгдлийг СЗХ-нд хүргүүлснээр анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг хүлээн авах болно. Анхдагч зах зээлийн захиалгыг Биржийн гишүүн бүх үнэт цаасны компаниар дамжуулан авна.

График 25. Үнэт цаасны арилжааанд оролцох, захиалга авах заавар

Данс нээлгэх
- МХБ-д бүртгэлтэй үнэт цаасны компаниудаас сонгож, үнэт цаасны данс нээлгэнэ.

Төлбөр байршуулах
- Үнэт цаасны компанийн зааварчилгааны дагуу дансандаа мөнгө байршуулна.

Захиалга өгөх
- Өөрийн үйлчлүүлдэг Үнэт цаасны компанид үнэт цаас худалдан авах захиалгаа өгнө.

Үнэт цаас худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нь анхдагч зах зээлийн арилжаанд дараах зааврын дагуу оролцоно.

Мөнгөн хөрөнгө байршуулах заавар

Үнэт цаас худалдан авах хүсэлтэй хөрөнгө оруулагч нь өөрийн Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд бүртгэлтэй дансанд мөнгө байршуулна.

Хүснэгт 23. Мөнгөн хөрөнгө байршуулах мэдээлэл

Дансны нэр:	Таны өөрийн нэр
Дансны дугаар:	**** **** **** /Брокероос авах/
Банкны нэр:	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
Гүйлгээний утга:	Нэр, Регистрийн дугаар, Шунхлай-4 бонд

Арилжааны шимтгэл

Үнэт цаасанд хөрөнгө оруулагч нь гүйлгээний үнийн дүнгийн тодорхой хувиар тооцсон үйлчилгээний хөлс буюу шимтгэлийг өөрийн сонгосон үнэт цаасны компанид төлөх ба уг шимтгэлд зохицуулагч байгууллагуудын болон үнэт цаасны компаниудын шимтгэлийн нийт дүн багтсан байна. Үнэт цаасны компаниудын шимтгэл нь харилцан адилгүй болохыг анхаарна уу.

Албан татвар

Хүүгийн орлогод ногдох албан татвар

Хүүгийн орлогод ногдох албан татварыг Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд зааснаар суутган төлөх буюу орлого олгож байгаа тал суутган төлөхөөр хуульчилсан байна. Ийнхүү суутган төлөхдөө дараах хувь, хэмжээг баримтална. Үүнд:

Хүснэгт 24. Хүүгийн орлогод ногдох албан татвар

№	Татвар төлөгч	Баримтлах хууль, эрх зүйн акт	Татварын дүн
Хувь хүн			
1	Монгол Улсад оршин суугч албан татвар төлөгч	Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16.1.4-т заасан орлого (хүүгийн орлого)-ын нийт дүнгээс тус хуулийн 21.5	5%

2026.08.31

2	Монгол Улсад оршин суугч бус албан татвар төлөгч	Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16.1.4-т заасан орлого (хүүгийн орлого)-ын нийт дүнгээс тус хуулийн 21.2.5	20%
Хуулийн этгээд			
1	Монгол Улсад байрладаг албан татвар төлөгч	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18.6.3-т заасан (хүүгийн орлого) нийт дүнгээс тус хуулийн 20.2.5 (Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг татвар төлөгчид хамаарахгүй. /Үүнд ААНОАТТ Хуулийн 4.1.12, 30.1-д заасан этгээд мөн хамаарна./)	5%
2	Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгч	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 20.2.4	20%

Жич: Монгол Улсад оршин суугч бус албан татвар төлөгч болон Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн хувьд давхар татварын гэрээтэй улсын харьяат хүн, хуулийн этгээд байвал тухайн давхар татварын гэрээнд заасан зохицуулалтыг дагаж мөрдөнө.

Үнэт цаас борлуулсны орлогод ногдох албан татвар

Үнэт цаас борлуулсны буюу ханшийн зөрүүний албан татварыг ҮЦТХТ эсхүл Кастодиан банк суутган төлөхөөр хуульчилсан. Ийнхүү суутган төлөхөд анх тухайн үнэт цаасыг худалдан авахад гарсан зардал буюу баримтаар нотлогдох зардлыг хасаж дараах дүнгээр суутган төлөхөөр хуульчилсан. Үүнд:

Хүснэгт 25. Үнэт цаас борлуулсны орлогод ногдох албан татвар

№	Татвар төлөгч	Баримтлах хууль, эрх зүйн акт	Татварын дүн
Хувь хүн			
1	Монгол Улсад оршин суугч албан татвар төлөгч	Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16.1.4-т заасан орлого (хүүгийн орлого)-ын нийт дүнгээс тус хуулийн 21.2.4	1%
2	Монгол Улсад оршин суугч бус албан татвар төлөгч	Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16.1.4-т заасан орлого (хүүгийн орлого)-ын нийт дүнгээс тус хуулийн 20.5	20%
Хуулийн этгээд			
1	Монгол Улсад байрладаг албан татвар төлөгч	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18.6.3-т заасан (хүүгийн орлого) нийт дүнгээс тус хуулийн 20.2.5	1%
2	Монгол Улсад байрладаггүй	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 20.2.4	20%

Жич: *Ханшийн зөрүүний албан татварын суутган төлөхтэй холбоотой харилцааг СЗХ-ны дарга болон Сангийн сайдын 2024 оны 6 дугаар сарын 07-ны өдөр хамтран баталсан Дугаар А/105/239 тушаалын хавсралт "Дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалсан засгийн газар, аймаг, нийслэлийн болон монгол улсад байрладаг албан татвар төлөгчийн өрийн хэрэгсэл /бонд/, хувьцаа, бусад үнэт цаасыг борлуулсны орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох, суутган тооцох, төсөвт төлөх, тайлагнах журам"-аар зохицуулж байна. Тус журамд зааснаар ханшийн зөрүүний орлогод ногдуулах албан татварыг суутган ногдуулахдаа жигнэсэн дундаж өртгийн аргыг баримтлахаар журамласан болно.*

Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

Үнэт цаасыг анх удаа нийтэд санал болгох ажиллагаа амжилттай болсон тохиолдолд МХБ-ийн журмын дагуу СЗХ-ны зөвшөөрлөөр үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлнэ. Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээр хувьцааг анхдагч зах зээлээс худалдан авсан хөрөнгө оруулагчид хувьцаагаа бусдад худалдаалах эрх нээлттэй болно.

2026.08.31

СЗХ
2026 .09 .10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2026 -09- 02
БҮРТГЭВ-03

ДӨРӨВ. БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ

4. БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1 ДУНД БОЛОН УРТ ХУГАЦААНЫ БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйл ажиллагаа, худалдааны стратеги

Үнэт цаас гаргагч нь газрын тосны бизнесийн стратегийн зорилгодоо хүрэхийн тулд жил бүр бизнес төлөвлөгөө, бодлого, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлан ажилладаг. Үнэт цаас гаргагч нь нийт зах зээлийн 21.7 хувийг эзэлдэг, тэргүүлэх байр суурьтай компани юм. Иймд цаашид дунд хугацаанд зах зээлд эзлэх хувиа 20-с доошгүй түвшинд байлгах, шатахуун түгээх станцуудыг автомат түвшин хэмжигчтэй болгох, газрын тосны агуулахуудыг өргөтгөх зэрэг бодлогыг баримтлан ажиллаж байна.

4.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН ТӨСӨӨЛӨЛ

Хүснэгт 26. Орлого, үр дүнгийн тайлангийн төсөөлөл, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2024	2025	2026Т	2027Т	2028Т
Борлуулалтын орлого	1,413,383	1,644,908	2,056,136	2,179,504	2,397,454
Борлуулалтын өртөг	(1,322,007)	(1,543,798)	(1,881,364)	(2,026,938)	(2,241,620)
Нийт ашиг	**91,376**	**101,111**	**174,772**	**152,565**	**155,835**
Нийт ашгийн маржин	*6.5%*	*6.1%*	*8.5%*	*7.0%*	*6.5%*
Үйл ажиллагааны зардал	(17,269)	(26,917)	(34,009)	(34,960)	(38,456)
Бусад орлого	24	929	397	451	677
Бусад зардал	(7,592)	(11,652)	(7,480)	(7,918)	(8,779)
Үйл ажиллагааны ашиг	**66,539**	**63,471**	**133,680**	**110,138**	**109,277**
Үйл ажиллагааны ашгийн маржин	*4.7%*	*3.9%*	*7%*	*5%*	*5%*
Санхүүгийн орлого	46	64	722	578	462
Санхүүгийн зардал	(51,662)	(53,991)	(70,952)	(63,202)	(64,443)
Татварын өмнөх ашиг	**14,924**	**9,544**	**63,449**	**47,513**	**45,296**
Татварын зардал	(3,350)	(36)	(14,593)	(10,928)	(10,418)
Цэвэр ашиг	**11,574**	**9,508**	**48,856**	**36,585**	**34,878**
Цэвэр ашгийн маржин	*0.8%*	*0.6%*	*2.4%*	*1.7%*	*1.5%*

Үнэт цаас гаргагчийн орлогын тайлангийн төсөөллийг дараах урьдач нөхцлүүдэд үндэслэн бэлтгэлээ.

- **Борлуулалтын орлого:** Компанийн борлуулалтын орлогын төсөөллийг өмнөх онуудын түүхэн өгөгдөл болон 2026 оны эхний хагас жилийн байдлаар борлуулсан байгаа борлуулалтын тоо хэмжээ, мөнгөн дүн болон ашигт ажиллагаанд үндэслэн

тааамагласан. Түүнчлэн бүтээгдэхүүний өртөг, бараа материалын эргэц болон нийт ашгийн түүхэн мэдээлэлд үндэслэв.

- **Борлуулалтын өртөг, үйл ажиллагааны зардал:** Борлуулалтын орлогод харьцуулсан харьцаа үзүүлэлтийг үндэслэн тооцсон бөгөөд тус харьцааг борлуулалтын орлогын төсөөлөлтэй уялдуулан тооцсон. Үнэт цаас гаргагчийн нийт ашгийн маржин дунджаар 6.0-6.5 хувь байдаг бол үнэт цаас гаргагч нь энэ оны эхний хагас жилд нийт ашгийн маржин өндөртэй ажиллаж чадсан тул оны эцсээр нийт ашгийн маржин түүхэн үзүүлэлтээс өндөр байх боломжтой байна.
- **Валютын ханшийн зөрүү:** Валютын ханшнаас үүдэлтэй зардлыг үнэт цаас гаргагчийн бараа материал татан авалттай уялдуулан тооцсон бөгөөд түүхэн хугацаанд валютын ханшийн зөрүүнээс алдагдалтай байхаар төсөөллийг хийв.
- **Санхүүгийн зардал:** Компани нь үйл ажиллагаандаа бондын санхүүжилт болон арилжааны банкны зээл, зээлийн шугамыг тогтмол авч ашиглана гэж тооцсон. Харин одоо санал болгож буй бондыг 2027 онд төлж хаасны дараа үргэлжлүүлэн бонд гаргаж, цаашид мөн адил бонд болон арилжааны банкны зээлийн хүүгийн зардал тогтмол гарна гэж төсөөллийг гүйцэтгэсэн. Бондын хүүг идэвхтэй арилжаалагдаж бондын хүүгээс, харин банкны зээлийн жинлэсэн дундаж хүүг 16.5 хувь байхаар тооцов. Компани нь арилжааны банкуудад энгийн бизнесийн зээл болон төслийн зээлүүд авч ашиглах боломжтой байдаг тул дундаж хүүг ийнхүү төсөөлөх боломжтой байна.

Хүснэгт 27. Санхүүгийн байдлын тайлангийн төсөөлөл, сая төгрөгөөр

Баланс	2024	2025	2026Т	2027Т	2028Т
Эргэлтийн хөрөнгө					
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,225	8,819	4,342	2,123	1,848
Дансны авлага	258,199	227,010	297,991	311,358	342,493
Бараа материал	57,714	80,207	110,668	106,681	117,980
Урьдчилж төлсөн зардал	3,269	11,194	18,620	19,551	20,529
Бусад эргэлтийн хөрөнгө	33,488	55,022	6,953	7,274	7,627
Бусад авлага	8,984	5,006	6,247	6,118	6,345
Нийт эргэлтийн хөрөнгө	**363,879**	**387,258**	**444,822**	**453,104**	**496,822**
Эргэлтийн бус хөрөнгө					
Үндсэн хөрөнгө	30,121	44,780	132,873	133,549	134,358
Биет бус хөрөнгө	1,427	1,642	1,182	1,162	1,123
Урт хугацаат хөрөнгө оруулалт	1,000	6,300	5,800	5,800	5,800
Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	11	11	11	11
Эргэлтийн бус хөрөнгө	**32,548**	**52,733**	**139,867**	**140,522**	**141,292**
Нийт хөрөнгө	**396,427**	**439,991**	**584,690**	**593,627**	**638,114**

Дансны өглөг	60,458	128,793	76,473	91,952	93,872
Богино хугацаат банкны зээл	71,483	128,068	191,729	144,033	146,473
Бондын өглөг	78,677	100,000	100,000	100,000	100,000
Хүүгийн өглөг	4,115	5,307	3,533	3,710	3,895
Бусад өглөг	1,083	2,186	3,430	2,942	2,931
Урт хугацаат зээл	124,144	36,979	122,011	126,891	131,967
Нийт өр төлбөр	**359,960**	**401,333**	**497,176**	**469,528**	**479,137**
Эздийн өмч					
Хувьцаат капитал	166	166	166	166	166
Хуримтлагдсан ашиг	36,301	38,492	87,348	123,933	158,811
Эздийн өмч	**36,467**	**38,658**	**87,514**	**124,099**	**158,977**
Нийт өр төлбөр ба эздийн өмч	**396,427**	**439,991**	**584,690**	**593,627**	**638,114**

Үнэт цаас гаргагч нь санхүүгийн байдлын тайлангийн төсөөллийг дараах урьдач нөхцлүүдэд үндэслэн бэлтгэлээ.

- **Худалдааны авлага, өглөг, бараа материал:** Компанийн хувьд тухайн салбарт олон жил үйл ажиллагаа явуулж байгаа, үндсэн үйл ажиллагаа харьцангуй тогтворжсон учир худалдааны авлага, өглөг, бараа материал зэрэг бизнесийн үндсэн үйл ажиллагааны циклд хамаарах данснуудын үлдэгдлийг түүхэн эргэцийн мэдээлэлд үндэслэн тооцсон.
- **Банкны зээл:** Газрын тосны бизнесийн хувьд бэлтгэн нийлүүлэгчдэд төлөх төлбөрт арилжааны банкны зээлийн шугамыг голлон ашигладаг бөгөөд богино хугацаатай мөнгө зээлэн бэлтгэн нийлүүлэгчдэд төлж, жижиглэн болон бөөний борлуулалтаас цугларсан мөнгөөр тухай бүрт эргүүлэн төлдөг.
- **Бонд:** Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны танилцуулга бэлдэх үеийн байдлаар Монголын хөрөнгийн бирж дээр нээлттэй арилжаалагдаж буй нийт 100.0 тэрбум төгрөгийн бондын үлдэгдэлтэй бөгөөд 2026 онд төлж дуусгана. Харин одоо санал болгож буй Шунхлай-4 бондыг 2027 онд төлж барагдуулах бөгөөд 2028 онд бондын үлдэгдэл мөн 100.0 тэрбум төгрөг байхаар тооцоолов. Үнэт цаас гаргагч нь цаашид бонд болон зээлийн бүтээгдэхүүн хослуулан ашиглах бүрэн боломжтой байна.
- **Үндсэн хөрөнгө:** Үнэт цаас гаргагч нь Шунхлай таур болон Шунхлай плаза оффисын барилгын бүтээн байгуулалтад энэ онд тодорхой хэмжээний хөрөнгө оруулалтыг хийж гүйцэтгээд байна. Эдгээр барилгууд нь 2026 оны хагас жилийн тайлангаар дуусаагүй барилга болон эргэлтийн бус бусад хөрөнгө ангилалд бүртгэлтэй байгаа ба тодорхой хэмжээний нэмэлт хөрөнгө оруулалт хийгдсэний дараа 2026 оны санхүүгийн тайлангаар үндсэн хөрөнгөд шилжин бүртгэгдэж, элэгдэл байгуулж эхлэх төлөвтэй байна. Иймд хөрөнгийг 2026 оны жилийн эцсийн тайлангаар үндсэн хөрөнгөд шилжсэн байхаар төсөөллийг хийв.

Хүснэгт 28. Мөнгөн гүйлгээний тайлангийн төсөөлөл, сая төгрөгөөр

Мөнгөн гүйлгээний тайлан	2026Т	2027Т	2028Т
Цэвэр ашиг	48,856	36,585	34,878
Тохируулга:			
Элэгдлийн зардал	858	3,456	4,731
Хүүгийн зардал	70,952	63,202	64,443
Ажлын капиталын өөрчлөлт:	*(113,118)*	*4,490*	*(42,085)*
Дансны авлагын (өсөлт)/бууралт	(70,981)	(13,367)	(31,136)
Татвар, ндш авлагын (өсөлт)/бууралт	163	244	(110)
Бусад авлагын (өсөлт)/бууралт	(1,404)	(114)	(118)
Бараа материалын (өсөлт)/бууралт	(30,461)	3,988	(11,299)
Урьдчилж төлсөн зардал (өсөлт)/бууралт	(7,427)	(931)	(978)
Бусад эргэлтийн хөрөнгийн (өсөлт)/бууралт	48,068	(321)	(353)
Дансны өглөгийн өсөлт (бууралт)	(52,320)	15,479	1,919
Татварын өглөгийн өсөлт (бууралт)	319	(550)	(76)
Бусад богино хугацаат өр төлбөр өсөлт (бууралт)	925	62	65
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	**7,549**	**107,733**	**61,967**
Үндсэн ба биет бус хөрөнгө борлуулсан	470	-	-
Бусад борлуулсан	500	-	-
Үндсэн хөрөнгө худалдан авахад төлсөн	(88,798)	(3,961)	(5,351)
Биет бус хөрөнгө худалдан авахад төлсөн	(163)	(150)	(150)
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	**(87,992)**	**(4,111)**	**(5,501)**
Зээл авсан	164,379	(29,269)	21,438
Өрийн бичиг гаргаснаас хүлээн авсан	100,000	100,000	100,000
Зээл төлсөн	(15,687)	(13,546)	(13,922)
Өрийн бичгийн эргэн төлөлт	(100,000)	(100,000)	(100,000)
Хүүгийн төлбөрт төлсөн	(72,726)	(63,026)	(64,257)
Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээ	**75,966**	**(105,841)**	**(56,741)**
Цэвэр мөнгөн гүйлгээ	(4,477)	(2,220)	(275)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,819	4,342	2,123
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	**4,342**	**2,123**	**1,848**

Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ: Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ ирэх 3 жилийн хугацаанд дунджаар эерэг байх хүлээлттэй

2026.08.31

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2026 -09- 02
БҮРТГЭВ

ШУНХЛАЙ
2026 .09. 10 өдөр
БҮРТГЭВ

байгаа ба үндсэн үйл ажиллагааны эерэг мөнгөн урсгалаар хөрөнгө оруулалт болон санхүүгийн үйл ажиллагааг санхүүжүүлэх боломжтой байна. Түүнчлэн авлагын эргэц өндөр байх тохиолдолд үйл ажиллагааны мөнгөн урсгал илүү сайн, эерэг байх бүрэн боломжтой байна.

Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ: Үнэт цаас гаргагч нь төв оффисын барилга, шатахуун хадгалах агуулах, шатахуун түгээх станц нэмэх, засвар үйлчилгээ хийх, тоног төхөөрөмж болон тээврийн хэрэгсэл худалдан авах гэх мэт капитал зарцуулалтын хэрэгцээ шаардлагууд үүсэж байдаг. Иймд хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ сөрөг байх бөгөөд үүнийг үндсэн үйл ажиллагааны мөнгөн урсгалаар санхүүжүүлнэ. 2026 оны хувьд хийгдэж буй барилгын ажлын зардлууд нь үл хөдлөх хөрөнгө худалдан авахад зориулсан сөрөг мөнгөн гүйлгээ гэдгээр тусгагдсан болно.

Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ: Бизнесийн хувьд банкны зээл, зээлийн шугамыг олон удаагийн давтамжтайгаар материаллаг хэмжээгээр ашигладаг бөгөөд мөнгөн гүйлгээний гол хэсгийг бүрдүүлж байдаг. Компанийн үйл ажиллагааны хэвийн өсөлтийг хангаж ажиллахын тулд шаардлагатай зээлийн хэмжээг тухайн жилийн мөнгөн урсгалын тооцоо, шинээр санхүүжүүлэх төсөл зэргээс хамааран өөрчилж болно. Санхүүгийн төсөөллийг бондын тогмол байх, харин арилжааны банкны зээл аль болох тогтмол дүнтэй байх хэмжээгээр тооцоолсон болно. Зээл болон
бондын хэмжээ тогтмол өндөр байгаатай холбоотой хүүгийн зардал материаллаг хэмжээгээр өсөж байгаа нь санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал сөрөг гаргахад нөлөөлсөн байна. Тус сөрөг мөнгөн урсгалыг үндсэн үйл ажиллагааны мөнгөн урсгалаар санхүүжүүлнэ.

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
УТА3531 ☎ 2028468

Голомт Капитал ТӨХК
Golomt Capital
Delivering diversity
1119289111 ☎ 5481589
Улаанбаатар хот

СЗХ
2026 .09. 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2026 -09- 02
БҮРТГЭВ-03

ТАВ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНД УЧИРЧ БОЛОХУЙЦ ЭРСДЭЛ

5. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНД УЧИРЧ БОЛОХУЙЦ ЭРСДЭЛ

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа нь газрын тосны бүтээгдэхүүний импорт, хадгалалт, түгээлт, бөөний болон жижиглэн худалдааны онцлогоос хамааран нийлүүлэлт, үнэ, төрийн зохицуулалт, логистик, санхүүжилт болон төлбөрийн чадвартай холбоотой эрсдэлд өртөх боломжтой. Доорх эрсдэлүүд нь бие даан болон харилцан уялдаатайгаар компанийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн урсгал, хөрвөх чадвар, нэр хүнд болон бондын эргэн төлөлтийн чадварт нөлөөлж болзошгүй.

1. Газрын тосны бүтээгдэхүүний нийлүүлэлт, хомсдолын эрсдэл

Эрсдэл

Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээ импортын өндөр хамааралтай бөгөөд нийлүүлэгч улсын экспортын бодлого, бүтээгдэхүүний хуваарилалт, хил гааль, төмөр замын нэвтрүүлэх хүчин чадал болон тээвэр логистикийн нөхцөлөөс шалтгаалан нийлүүлэлт тасалдах эрсдэлтэй. 2026 онд АИ-92 автобензиний нийлүүлэлт тодорхой хугацаанд хязгаарлагдаж, дотоодын зах зээлд хомсдол үүссэн нь импортын хамаарлын эрсдэл бодитоор илэрч болохыг харуулж байна. Нийлүүлэлт тасалдах үед борлуулах бүтээгдэхүүний хэмжээ буурч, ШТС-аар борлуулалтыг хязгаарлах, гэрээт хэрэглэгчийн захиалгыг бүрэн хангаж чадахгүй байх, улмаар борлуулалтын тасалдал болон хэрэглэгчийн сэтгэл ханамжид сөргөөр нөлөөлөх боломжтой.

Эрсдэлийн удирдлага

Компани нийлүүлэгч талуудтай тогтсон харилцааг хадгалах, импортын захиалга, тээврийн хуваарь, агуулахын нөөцийг уялдуулан төлөвлөх, бүтээгдэхүүний нэр төрөл болон татан авалтын эх үүсвэрийг боломжит хүрээнд төрөлжүүлэх замаар нийлүүлэлтийн эрсдэлийг бууруулна. Хомсдолын үед нөөцийг борлуулалтын сувгуудад оновчтой хуваарилах, нэн шаардлагатай болон гэрээт хэрэглэгчийн нийлүүлэлтийг эрэмбэлэх, холбогдох төрийн байгууллага болон нийлүүлэгчтэй шуурхай мэдээлэл солилцох арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2. Үнэ өсөлт болон төрийн зохицуулалтын эрсдэл

Эрсдэл

Импортын шатахууны өртөг нь олон улсын газрын тосны үнэ, нийлүүлэгчийн үнэ, тээврийн зардал болон валютын ханшийн өөрчлөлтөөс хамаардаг. Дэлхийн зах зээл дэх газрын тосны үнэ болон импортын өртөг өсөх үед дотоодын жижиглэнгийн үнийг шууд өөрчлөх боломж хязгаартай тул компанийн нэгж бүтээгдэхүүний ашиг буурах эрсдэлтэй. Нөгөө талаас үнэ өсөх болон хомсдолын үед хэрэглэгчийн худалдан авалтын зан төлөв огцом өөрчлөгдөх, ШТС дээр дараалал, нөөцлөлт, борлуулалтын түр хязгаарлалт үүсэх боломжтой. Шатахуун нь стратегийн ач холбогдолтой бүтээгдэхүүн тул үнэ болон хангамжид төрийн бодлого, зохицуулалтын нөлөө өндөр байна.

2026.08.31

Эрсдэлийн удирдлага

Компани импортын өртөг, бүтээгдэхүүний борлуулалтын үнэ, өрсөлдөгчийн үнэ, нөөцийн түвшинг тогтмол хянаж, бүтээгдэхүүний төрөл, борлуулалтын суваг болон нөөцийн удирдлагыг уялдуулан ажиллана. Төрийн байгууллагын бодлого, шийдвэр, үнийн зохицуулалт болон салбарын шаардлагын өөрчлөлтийг тогтмол хянаж, шаардлагатай мэдээлэл тайланг хугацаанд нь хүргүүлэх, бодлогын өөрчлөлтөд үйл ажиллагааны төлөвлөгөөг шуурхай нийцүүлэх арга хэмжээ авна.

3. Тээвэр, логистик, агуулах болон түгээлтийн тасалдлын эрсдэл

Эрсдэл

Газрын тосны бүтээгдэхүүнийг хилээр нэвтрүүлэх, төмөр замаар тээвэрлэх, агуулахад хүлээн авах, ШТС болон гэрээт хэрэглэгчид түгээх зэрэг бүхий л үе шат нь тасралтгүй ажиллагаа шаардаг. Вагон болон тээврийн хэрэгслийн хүрэлцээ, хил гаалийн саатал, төмөр замын ачаалал, цаг агаар, агуулахын тоног төхөөрөмжийн гэмтэл, замын нөхцөл зэрэг хүчин зүйлээс шалтгаалан бүтээгдэхүүн хугацаандаа хүрэхгүй байх эрсдэлтэй. Нийлүүлэлтийн хомсдолтой үед ийм саатлын нөлөө улам нэмэгдэж, тухайн байршлын ШТС-д бүтээгдэхүүн тасрах эрсдэл бий болно.

Эрсдэлийн удирдлага

Компани импорт, агуулах, түгээлтийн хуваарийг нэгдсэн байдлаар төлөвлөж, бүтээгдэхүүний үлдэгдэл болон тээврийн явцыг тогтмол хянана. Агуулах, ШТС болон тээврийн тоног төхөөрөмжид төлөвлөгөөт үзлэг үйлчилгээ хийх, нөөц тээврийн болон түгээлтийн хувилбар бэлэн байлгах, онцгой нөхцөлд бүтээгдэхүүнийг байршил хооронд дахин хуваарилах зохицуулалтыг хэрэгжүүлнэ. Мөн 2026 оны эхний хагас жилд МУ-ын ЗГ-аас шатахуун импортлогч дотоодын компаниудад агуулах, нөөцийн сав барих зориулалтаар арилжааны банк болон Хөгжлийн банкнаас зээл авахад хүүгийн татаас олгох байдлаар хөнгөлөлттэй зээлийн бүтэц, эх үүсвэрийг шийдвэрлэсэнээр үнэт цаас гаргагч тухайн санхүүжилтэд хамрагдан ажиллаж байна.

4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, галын болон байгаль орчны эрсдэл

Эрсдэл

Газрын тосны бүтээгдэхүүн нь шатамхай, тэсрэмтгий шинж чанартай тул хадгалалт, тээвэрлэлт, буулгалт, түгээлтийн явцад гал түймэр, асгаралт, үйлдвэрлэлийн осол болон хүрээлэн буй орчны бохирдол үүсэх эрсдэлтэй. Томоохон осол, асгаралт нь үйл ажиллагааг түр зогсоох, тусгай зөвшөөрөл болон зохицуулалтын арга хэмжээ авахуулах, нөхөн сэргээлтийн үүрэг хүлээх, мөн компанийн нэр хүндэд сөргөөр нөлөөлөх боломжтой.

Эрсдэлийн удирдлага

ISO 45001:2018 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоо, ISO 14001 болон ISO 9001-ийг хэрэгжүүлдэг. Мөн ХАБЭА-н 13 дотоод журам, 78 заавар, зааварчилгаа мөрддөг, осолд дөхсөн тохиолдлыг мэдээлэх, өндөр эрсдэлтэй ажлын байрны эрсдэлийг тогтмол шинжлэх тогтолцоотой. Тоног төхөөрөмжийн үзлэг, засвар үйлчилгээ, хамгаалах хэрэгслийн бэлэн байдал, ослын үеийн шуурхай ажиллагааны төлөвлөгөө болон байгаль орчны шаардлагын хэрэгжилтэд тогтмол хяналт тавиж ажилладаг.

5. Эргэлтийн хөрөнгө, бараа материал болон авлагын эрсдэл

Эрсдэл

Газрын тосны бүтээгдэхүүний импортын бизнес нь их хэмжээний эргэлтийн хөрөнгө шаарддаг. 2026 оны 2-р улирлын санхүүгийн тайлангаар Үнэт цаас гаргагчийн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл 42.7 тэрбум төгрөг, худалдааны болон бусад авлага, урьдчилгаа төлбөрийн үлдэгдэл 350.5 тэрбум төгрөг, бараа материалын үлдэгдэл 75.3 тэрбум төгрөг байна. Мөн үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ -68.7 тэрбум төгрөг гарсан нь тайлант хугацаанд эргэлтийн хөрөнгийн хэрэгцээ мөнгөн урсгалд дарамт үзүүлж байгааг харуулж байна. Авлагын барагдуулалт удаашрах, импортын үнэ өсөх, нөөц нэмэгдүүлэх шаардлага үүсэх тохиолдолд богино хугацааны төлбөрийн чадвар болон бондын төлбөрийн эх үүсвэрт сөргөөр нөлөөлж болзошгүй.

Эрсдэлийн удирдлага

Компани бараа материалын үлдэгдэл, борлуулалтын хурд, авлагын барагдуулах хугацаа, харилцагчийн зээлийн лимит болон өглөгийн хугацааг уялдуулан хянана. Бараа материалын нөөцийг нийлүүлэлтийн эрсдэл болон борлуулалтын хэрэгцээтэй тэнцвэржүүлэх, авлага барагдуулах хугацааг богиносгох, бэлэн мөнгөний төсөв болон богино хугацааны төлбөрийн хуваарийг тогтмол шинэчлэх замаар мөнгөн урсгалын эрсдэлийг удирдана.

6. Өрийн ачаалал, төлбөрийн чадвар болон дахин санхүүжилтийн эрсдэл

Эрсдэл

2026 оны 2-р улирлын санхүүгийн тайлангаар Үнэт цаас гаргагчийн нийт өр төлбөр 570.2 тэрбум төгрөг, үүнээс банкны зээл 318.5 тэрбум төгрөг, бондын өглөг 100.0 тэрбум төгрөг, эздийн өмч 77.5 тэрбум төгрөг байна. Нийт хөрөнгийн 88.0 хувийг өр төлбөрөөр санхүүжүүлсэн бөгөөд 2025 онд гаргасан нийт 100.0 тэрбум төгрөгийн бонд 2026 оны 9-12 дугаар сард хугацаа дуусахаар байна. Шинээр гаргах бонд мөн 12 сарын хугацаатай, үндсэн төлбөр нь хугацааны эцэст төлөгдөх тул богино хугацаат өрийн төвлөрөл болон дахин санхүүжилтийн хэрэгцээ нь бонд эзэмшигчийн анхаарах гол эрсдэлийн нэг байна. Зах зээлийн хүү өсөх, банкны зээлийн нөхцөл чангарах, хөрөнгө оруулагчдын эрэлт буурах, эсхүл үйл ажиллагааны мөнгөн урсгал төлөвлөсөн түвшинд хүрэхгүй байх нь санхүүжилтийн өртөг болон хүртээмжид сөргөөр нөлөөлж болзошгүй.

Эрсдэлийн удирдлага

Компани өр төлбөрийн хугацааны хуваарь, банкны зээлийн шугам, бондын төлбөр болон үйл ажиллагааны мөнгөн урсгалыг нэгдсэн байдлаар төлөвлөж, санхүүжилтийн эх үүсвэрийг банк болон хөрөнгийн зах зээлийн сувгаар төрөлжүүлнэ. Бондын эргэн төлөлтийн эх үүсвэрийг хугацаанаас өмнө бүрдүүлэх, боломжтой тохиолдолд өрийн хугацааг уртасгах, богино хугацаат өрийн төвлөрлийг бууруулах замаар дахин санхүүжилтийн эрсдэлийг удирдана. Мөн үнэт цаас гаргагч нь богино буюу 12 сарын хугацаатай бондыг санал болгож буй нь зах зээл дэх хүүгийн өөрчлөлт болон хөрөнгө оруулагчдын эрэлтийг харгалзан үзэж үнэт цаасны уян хатан байдлыг нэмэгдүүлэх зорилготой.

7. Гадаад валютын ханш болон хүүгийн түвшний эрсдэл

Эрсдэл	Импортын бүтээгдэхүүний төлбөр гадаад валютаар хийгддэг тул төгрөгийн ханш сулрах нь бараа материалын төгрөгөөр илэрхийлэгдэх өртөг болон эргэлтийн хөрөнгийн хэрэгцээг нэмэгдүүлнэ. Мөн банкны болон зах зээлийн хүүгийн түвшин өсөх нь шинэ болон дахин санхүүжилтийн өртгийг нэмэгдүүлж, ашигт ажиллагаа болон мөнгөн урсгалд дарамт учруулж болзошгүй. Импортын өртгийн өсөлтийг борлуулалтын үнэд бүрэн, цаг тухайд нь шингээх боломжгүй үед уг нөлөө нэмэгдэнэ.
Эрсдэлийн удирдлага	Компани валютын төлбөрийн хуваарь, валютын хэрэгцээ болон ханшийн өөрчлөлтийг тогтмол хянаж, шаардлагатай валютын эх үүсвэрийг урьдчилан төлөвлөнө. Санхүүжилтийн нөхцөл, хугацаа, хүүгийн түвшинг харьцуулж, боломжит эх үүсвэрүүдийн дундаас зардал болон хугацааны хувьд оновчтой хувилбарыг сонгох замаар хүүгийн эрсдэлийг бууруулна.

8. Мэдээллийн систем, хэрэглэгчийн үйлчилгээ болон нэр хүндийн эрсдэл

Эрсдэл	ШТС-ын борлуулалт, төлбөр тооцоо, карт болон урамшууллын систем, агуулахын бүртгэл, түгээлтийн хяналт зэрэг нь мэдээллийн системийн тасралтгүй ажиллагаанаас хамаардаг. Системийн доголдол, кибер халдлага, сүлжээ болон төлбөрийн системийн тасалдал нь борлуулалт саатах, мэдээллийн бүрэн бүтэн байдал алдагдах эрсдэлтэй. Мөн шатахууны хомсдол, үнэ өсөлтийн үед хэрэглэгчийн бухимдал, борлуулалтын хязгаарлалт, мэдээллийн зөрүү нь олон нийтийн сөрөг хандлага болон нэр хүндийн эрсдэлийг нэмэгдүүлж болзошгүй.
Эрсдэлийн удирдлага	Компани үндсэн мэдээллийн системийн нөөцлөлт, хэрэглэгчийн эрхийн удирдлага, мэдээллийн аюулгүй байдал болон тасралтгүй ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлнэ. Хомсдол болон зах зээлийн огцом өөрчлөлтийн үед хэрэглэгчдэд нөөц, борлуулалтын нөхцөл болон үйлчилгээний талаар үнэн зөв, нэг мөр мэдээлэл өгөх, гомдол саналд шуурхай хариу өгөх, олон нийт болон зохицуулагчтай мэдээллийн зохистой харилцаа хадгалах замаар нэр хүндийн эрсдэлийг удирдана.

2026 оны хувьд Шунхлай ХХК-ийн эрсдэлийн орчин нь нийлүүлэлтийн хомсдол, импортын өртөг болон үнийн өсөлт, төрийн зохицуулалт, эргэлтийн хөрөнгийн хэрэгцээ, богино хугацаат өрийн төвлөрөл зэрэг хүчин зүйлсийн харилцан нөлөөллөөр тодорхойлогдож байна. Нийлүүлэлт тасалдах нь борлуулалтын биет хэмжээг хязгаарлах бол үнэ өсөх нь бараа материалын өртөг болон санхүүжилтийн хэрэгцээг нэмэгдүүлнэ. Үүний зэрэгцээ бараа материал болон авлагын эргэлт удаашрах нь мөнгөн урсгалд дарамт үүсгэж, богино хугацаат өр болон бондын төлбөрийн эх үүсвэрт нөлөөлөх боломжтой. Гэсэн хэдий ч компанийн олон жилийн үйл ажиллагааны туршлага, импорт-хадгалалт-түгээлтийн дэд бүтэц, банкны болон хөрөнгийн зах зээлийн санхүүжилтийн суваг, 2026 оны эхний хагас жилийн ашигт ажиллагааны өсөлт нь дээрх эрсдэлийг удирдах суурь хүчин зүйл болж байна. Иймд үнэт цаас гаргагчийн хувьд нийлүүлэлтийн тасралтгүй байдлыг хангах, эргэлтийн хөрөнгийн үр ашгийг сайжруулах, өрийн хугацааны бүтцийг оновчтой удирдах, мөн бондын эргэн төлөлтийн эх үүсвэрийг урьдчилан бүрдүүлэх нь гол анхаарах чиглэл болно.

СЗХ
2026 .09.10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2026 -09- 02
БҮРТГЭВ-03

ЗУРГАА. ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД

6. ҮНЭТ ЦААС ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД

6.1 АНДЕРРАЙТЕРИЙН КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

Голомт Капитал ҮЦК ХХК нь 2011 онд үүсгэн байгуулагдаж, тухайн ондоо СЗХ-оос брокерын үйлчилгээ, 2014 онд хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ, 2015 онд андеррайтерийн үйлчилгээ, 2023 онд уул уурхайн бүтээгдэхүүний биржийн брокерийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус авч одоогийн байдлаар нийт 7 үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн хүрээнд иргэд, аж ахуйн нэгжүүдэд хөрөнгө оруулалтын цогц үйлчилгээг үзүүлж байна.

Улсын бүртгэлийн дугаар	9011287134
Регистрийн дугаар	5481589
Үйл ажиллагааны чиглэл	Брокер, Дилер, Андеррайтер, Хөрөнгө оруулалтын зөвлөх, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагч
Хаяг	Монгол улс, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө 24, Парк плэйс оффис, 403, 404 тоот;
Утас	7012-1530
Веб хуудас	www.golomtcapital.com
Цахим хаяг	info@golomtcapital.com

Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээний тухай

Голомт Капитал ҮЦК ХХК нь 2026 оны 8-р сарын 21-ний өдрийн В/258 тоот Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээг Үнэт цаас гаргагчтай байгуулсан байна. Тус андеррайтерийн гэрээний хүрээнд Андеррайтер нь өрийн хэрэгслийг СЗХ, МХБ-д бүртгүүлж, олон нийтэд нээлттэй хүрээнд санал болгон хөрөнгө татан төвлөрүүлэхэд шаардагдах тооцоолол, судалгаа, бэлтгэл ажлуудыг гүйцэтгэх, зөвлөгөө өгөх, хөрөнгө оруулагч нарт Компанийг танилцуулах, санал болгох, санхүүжилт татаж өгөхөд Андеррайтерийн үйлчилгээ үзүүлнэ.

Үнэт цаас гаргагч нь Андеррайтерийн гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэхэд нь шаардлагатай мэдээлэл, материалыг гаргаж өгөн хамтран ажиллах бөгөөд талуудын хооронд үүсэх харилцааг уг гэрээгээр зохицуулсан байна.

Гэрээний зорилгоо хэрэгжүүлэх явцад бие биеийнхээ хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүндэтгэх, хамгаалах болон шударга байх зарчмыг баримтлан ажиллана.

6.2 ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛИЙН КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

Монголын хөрөнгө оруулалтын зэрэглэлийн эжинси ХХК нь 2021 оны 1 дүгээр сард үүсгэн байгуулагдсан ба “Санхүүгийн чадавхын зэрэглэл тогтоох” тусгай зөвшөөрлийг 2022 оны 6 дугаар сард авсан.

Улсын бүртгэлийн дугаар	9011824434
Регистрийн дугаар	6659659
Үйл ажиллагааны чиглэл	Санхүүгийн чадавхын зэрэглэл тогтоох, санхүүгийн тайлан баланс гаргах, зөвлөгөө өгөх, менежментийн зөвлөгөө өгөх
Хаяг	Монгол улс, Улаанбаатар, Чингэлтэй, 1-р хороо, жигжиджавын гудамж, Жи И Би ХХК-ийн байр 306 тоот
Утас	7774-7700
Веб хуудас	www.mira.mn
Цахим хаяг	info@mira.mn

Монголын хөрөнгө оруулалтын зэрэглэлийн эжинси ХХК нь салбарын эрсдэл, бизнесийн эрсдэл, бизнесийн орчин, стратеги ба санхүүгийн бодлого, аюулгүй байдлын эрсдэл, удирдлагын үнэлгээ, компанийн засаглал, үйл ажиллагааны гүйцэтгэл, санхүүгийн чадавх, хамаарлын эрсдэл, ерөнхий үнэлгээний хүчин зүйлсийг харгалзан үзэн компаниудад санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох үйлчилгээ үзүүлж байна.

Зээлжих зэрэглэл тогтоох үйлчилгээ үзүүлэх гэрээний тухай

Шунхлай ХХК болон Монголын Хөрөнгө Оруулалтын Зэрэглэлийн Эжинси ХХК нь 2025 оны 11-р сарын 28-ны өдөр "Зээлжих зэрэглэл болон компанийн үнэлгээ тогтоох үйлчилгээ үзүүлэх гэрээ"-г байгуулсан. Гэрээний дагуу ажил гүйцэтгэгч нь Захиалагчийн байгууллагын, хаалттай болон нээлттэй хүрээнд гаргах өрийн хэрэгсэлд зэрэглэл тогтоох, шинэчлэх үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээний төлбөр тооцоог гүйцэтгэх, гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой Талуудын эрх, үүрэг, хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулсан байна.

6.3 ХУУЛИЙН ФИРМИЙН ТАНИЛЦУУЛГА

Өмгөөллийн "Легал Полиси" ХХК нь иргэн, Монгол улсад үйл ажиллагаа эрхэлж буй дотоодын болон гадаадын аж ахуйн нэгж, байгууллагуудад хууль зүйн зөвлөх, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 18 жилийн туршлагатай компани юм. Компани нь аж үйлдвэржилт, дэд бүтэц, эрчим хүчний салбарт үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд болон эдгээр чиглэлийн томоохон төслүүдэд эрх зүйн зөвлөгөө өгч ирсэн туршлагатай бөгөөд үүнээс гадна компанийн засаглал, инновац, уул уурхай, компанийн зохистой удирдлага, үнэт цаас, оюуны өмч, төр, хувийн хэвшлийн түншлэл (PPP), хувийн санхүүжилтийн санаачилга (PFI) зэрэг салбарт эрх зүйн зөвлөгөө, өмгөөллийн үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

Улсын бүртгэлийн дугаар	9028001156
Регистрийн дугаар	5271894
Үйл ажиллагааны чиглэл	Өмгөөлөл, хууль зүйн зөвлөгөө өгөх
Хаяг	Монгол Улс, Улаанбаатар хот, СБД, 8-р хороо, Бага тойруу-14200, Сүхбаатарын талбай 5, Сити Тауэр, 1304 тоот
Утас	9007-7720
Веб хуудас	www.legal-policy.mn
Цахим хаяг	admin@legal-policy.mn

Өмгөөллийн "Легал Полиси" ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 109 дүгээр тогтоолоор "Үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээд"-ээр бүртгэгдээд 7 дахь жилдээ ажиллаж байна. Хуулийн фирм нь үнэт цаасны зах зээлд компанийн хувьцаа, компанийн өрийн хэрэгсэл, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, үүсмэл санхүүгийн хэрэгсэлтэй холбоотой үйл ажиллагаанд эрх зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна.

Эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээний тухай

Шунхлай ХХК болон Омгооллийн Легал Полиси ХХК нар нь 2026 оны 8-р сарын 19-ний өдөр "Эрхзүйн туслалцаа үзүүлэх гэрээ"-г байгуулсан бөгөөд гэрээний дагуу хуулийн фирм нь Шунхлай ХХК-ийн өрийн хэрэгсэл гаргах үйл ажиллагаанд хууль зүйн дүгнэлт гаргах, эрх зүйн туслалцаа үзүүлэхээр тохиролцсон байна.

Хуулийн фирм нь гэрээт ажлыг нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн түвшинд үр дүнтэй, зохистой арга зүйг ашиглан гүйцэтгэх, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалан нууц мэдээллийг хадгалан ажиллах, мэргэжлийн ёс зүйг сахин ажиллах зэрэг үүргийг гэрээний дагуу хүлээсэн. Мөн гэрээт ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай мэдээллийг үйлчлүүлэгчээс шаардах, ёс зүй болон хуулийн журамд харшилсан ажлыг гүйцэтгэхээс татгалзах эрхтэй байна.

Шунхлай ХХК нь гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш эрх зүйн туслалцаа үзүүлэхэд нь хуулийн фирмд шаардлагатай мэдээллийг үнэн зөв, шуурхай гарган өгөх, гэрээний дагуу гүйцэтгэх ажлыг ойлгомжтой тодорхойлох, шаардлагатай зааварчилгаагаар хангах зэрэг үүргийг хүлээсэн байна. Түүнчлэн хуулийн фирмээс гэрээт ажлыг тохирсон хугацаанд биелүүлэх, зохих ёсоор гүйцэтгэхийг шаардах, ажлын гүйцэтгэлийн талаар явцын мэдээлэл авах, ажлын даалгавраа өөрчлөх, цуцлах эрхтэй байна.

6.4 АУДИТЫН КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

Регистрийн дугаар	5563348
Үйл ажиллагааны чиглэл	Аудитын үйл ажиллагаа
Хаяг	Улаанбаатар, Чингэлтэй, 3-р хороо, Чоймболын гудамж -4, Нийслэл УБ хотын ҮЭ-ийн холбооны байр, 4 давхар, 408 тоот
Утас	+976 7014 5906
Цахим хаяг	audit@nmz.mn

Ниямазон Аудит ХХК нь 2012 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 408 дүгээр тогтоолоор "Үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд"-ээр бүртгэгдсэн.

Үнэт цаас гаргагч болон Ниямазон Аудит ХХК нь 2026 оны 7-р сарын 27-ны өдөр "Аудитын ажлыг гүйцэтгэх гэрээ"-г байгуулсан бөгөөд гэрээний дагуу аудитын компани нь Үнэт цаас гаргагчийн 2026 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд аудит хийх, мөн энэхүү үнэт цаасны танилцуулга, хавсаргасан баримт бичигт тусгагдсан мэдээллийг нягтлах, холбогдх стандарт, хууль тогтоомжийг баримтлан гүйцэтгэхээр тохиролцсон байна.

2026.08.31

6.5 ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУД НЬ НЭГДМЭЛ СОНИРХОЛ, БИЗНЕСИЙН ХОЛБОО ХАМААРАЛТАЙ ЭСЭХ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцож буй доор дурдсан байгууллагууд нь холбогдох хууль, журам болон талуудын хооронд байгуулагдсан гэрээ, хэлцлийн хүрээнд Үнэт цаас гаргагч Шунхлай ХХК-д холбогдох мэргэжлийн үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд эдгээр байгууллагууд нь аливаа байдлаар нэгдмэл сонирхолгүй, энд дурдсанаас өөрөөр бизнесийн холбоо хамааралгүй болно. Үүнд:

1. Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэгч "Голомт Капитал ҮЦК" ХХК
2. Хөндлөнгийн хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч "Өмгөөллийн Легал Полиси" ХХК
3. Зээлжих зэрэглэл тогтоогч "Монголын Хөрөнгө Оруулалтын Зэрэглэлийн Эжинси" ХХК
4. Аудитын компани "Ниямазон Аудит" ХХК

Оролцогч байгууллагууд нь бизнесийн нэгдмэл сонирхол, холбоо хамааралгүй талаарх мэдэгдлийг хавсралтаас харна уу.

СЗХ
2026 .09.10
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2026 -09- 02
БҮРТГЭЛ-03

ДОЛОО. ХАВСРАЛТ

7. ХАВСРАЛТ

7.1 Үнэт цаас гаргах тухай шийдвэр

ШУНХЛАЙ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 08 сарын 19 өдөр Дугаар 8/14 Улаанбаатар хот

Өрийн хэрэгсэл гаргах,
Гэрээ байгуулахыг зөвшөөрөх тухай

"Шунхлай" ХХК (цаашид **"Компани"** гэх)-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1, 41.2, 41.3, 76 дугаар зүйлийн 76.1, 76.1.5, 76.1.18, Компанийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7, 5.7.7, 5.7.19, 5.7.21-д заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь**:

1. Компанийн эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор нийт 100,000,000,000 *(нэг зуун тэрбум)* төгрөгийн өрийн хэрэгсэл (цаашид **"Өрийн хэрэгсэл"** гэх)-ийг Хавсралтад заасан нөхцөлөөр гарган, хөрөнгийн зах зээлд нээлттэй хүрээнд арилжаалахыг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын 1 дүгээр зүйлд заасан Өрийн хэрэгслийг "Бонд гаргах хөтөлбөр"-өөр "Монголын Хөрөнгийн Биржь" ХК-д бүртгүүлэн гаргасугай.
3. Өрийн хэрэгсэл гарган хөрөнгийн зах зээлд нээлттэй хүрээнд арилжаалах үйл ажиллагаанд андеррайтераар "Голомт Капитал ҮЦК" ХХК-ийг (цаашид **"Андеррайтер"** гэх) сонгосугай.
4. Компани нь Өрийн хэрэгсэл гарган хөрөнгийн зах зээлд нээлттэй хүрээнд арилжаалахтай холбогдуулан Андеррайтерийн компани Голомт капитал ҮЦК, Хуулийн зөвлөх үйлчилгээний компани Өмгөөллийн легал полиси ХХК, Аудитын компани Ниямазон ХХК-тай хамтран ажиллах гэрээ (цаашид **"Гэрээ"** гэх)-г байгуулахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ж.Мөнхнаран)-д зөвшөөрсүгэй
5. Өрийн хэрэгсэл гаргах хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбоотой хэсэгчлэн татан төвлөрүүлэх хэмжээ, үнийн дүн зэргийг тухай бүрд нь энэхүү тогтоолын хавсралтад заасан нөхцөлийн хүрээнд тогтоох бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал (Ж.Мөнхнаран)-д олгосугай.
6. Компанийг төлөөлөн Гэрээ байгуулах, бусад холбогдох баримт бичгүүдэд гарын үсэг зурах бүрэн эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ж.Мөнхнаран)-д олгосугай.
7. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ж.Мөнхнаран)-д даалгасугай

БАТАЛСАН:

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга

П.БАТСАЙХАН

(гишүүд дараагийн хуудсанд гарын үсэг зурна)

УЛААНБААТАР ХОТ ШУНХЛАЙ ХХК

Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital Delivering diversity 1119289111 5481589 Улаанбаатар хот

ШУНХЛАЙ СЗХ 2026 09 10 өдөр БҮРТГЭВ № 31

2026 09 02 БҮРТГЭВ-03

2026 оны 08 -р сарын 19 -ны өдрийн 8/14 тоот Тогтоолын хуудас 2

"Шунхлай" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд

Ч.АРИУНСАН

Б.БАТБАЯР

Б.БАТЖАРГАЛ

Ж.МӨНХНАРАН

И.МАЙНЦЭЦЭГ

Ш.НЭРГҮЙ

Б.ЦЭЛМЭГ

Ц.ЭРДЭНЭБИЛЭГ

УЛААНБААТАР ХОТ ШУНХЛАЙ ХХК ТТА3531 № 2028468

Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital Delivering diversity 1119289111 8481589 Улаанбаатар хот

"Шунхлай" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын
2026 оны ..... -р сарын ..... -ны өдрийн ..... тоот Тогтоолын Хавсралт

"ШУНХЛАЙ" ХХК-ИЙН НЭЭЛТТЭЙ БОНДЫН ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН НӨХЦӨЛ

Үнэт цаас гаргах нөхцөл	Өрийн бичгийн хөтөлбөр
Бондын төрөл	Нээлттэй бонд
Нэрлэсэн үнэ	100,000 төгрөг
Үнэт цаасны ширхэг	1,000,000 ширхэг
Үнэт цаасны нийт үнийн дүн	100,000,000,000 төгрөг
Үнэт цаасны хүү	Жилийн 18.0 хувь
Үнэт цаасны хугацаа	12 сар
Хүү төлөх давтамж	Хагас жил тутам
Үндсэн төлбөр төлөх давтамж	Хугацааны эцэст
Үүргийн гүйцэтгэл хангах арга	Зээлжих зэрэглэл тогтоолгосны дагуу барьцаа, баталгаагүй гаргах
Арилжаалах хэлбэр	Өрийн хэрэгслийг хөтөлбөрийн дагуу хэсэгчлэн татан төвлөрүүлэх

*****

2026.08.31

ШУНХЛАЙ ХХК 2025 09 10 Б 1 2 3 4 5 6 7 8 9 10 № 01

МОНГОЛ УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2026 09 02 БҮРТГЭЛ-03

7.2 Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэлийн гэрчилгээ

УБ-2

Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 20 дугаар тогтоолоор батлав.

МОНГОЛ УЛС
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

2005.12.16
/Бүртгэсэн он, сар, өдөр/

9011038082
/Улсын бүртгэлийн дугаар/

2028468
/Регистрийн дугаар/

Шунхлай — Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр/

Дүрэм
/Үүсгэн байгуулах баримт бичиг/

Шийдвэр — 01 — 1995.11.28
/Шийдвэрийн нэр/ /Дугаар/ /он, сар, өдөр/

605000 — Нийслэл Сүхбаатарын дүүргийн Баянгол хорооны нутаг дэвсгэр
/Хаяг/ /Хуулийн этгээдийн үндсэн оршихуйн газар/

511000 Гадаад худалдаа
511001 Худалдааны зуучлал
602100 Зорчигч тээврийн үйлчилгээ

/Код/ /Үндсэн зориулалт бүхий үйл ажиллагаанд чиглэх/

Хүчинтэй — 1 — 33,333,7
/Хугацаа/ /Хувьцааны ширхэг/ /Хувьцааны нэгж үнэлгээ, төгрөгөөр/

Сүхбаатар дүүрэг, 3-р хороо, Соёлийн гудамж, Брау хаус төвийн байр - 5-р давхар, утас1:312484, утас2:312488, факс:312519
/Хуулийн этгээдийн оршихуйн газрын хаяг/

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

Улсын бүртгэлийн алба
/Бүртгэлийн ажилтны гарын үсэг/

Гаргасан огноо: 2025 он 12 сар 18 өдөр

УЛААНБААТАР ХОТ ШУНХЛАЙ ХХК ГАЗАРЗҮЙ № 2028468

Golomt Capital Delivering diversity 1119289111 Улаанбаатар хот

ШУНХЛАЙ СЭХ 2026 09 10 өдөр БҮРТГЭВ № 01

Үнэт цаасны танилцуулга

MONGOLIAN STOCK EXCHANGE 2026-09-02 БҮРТГЭВ-03

Харилцах банкны бүртгэл:

Харилцагч банкны нэр	Дансны төрөл	Дансны дугаар	Бүртгэсэн Огноо	Бүртгэсэн Ажилтан, тэмдэг
Чингис хаан банк	Төгрөгийн	3920010030	2005.12.26	Г.Мягмар
Чингис хаан банк	Валютын	3920040030	2005.12.26	Г.Мягмар
Худалдаа хөгжлийн банк	Төгрөгийн	499022775	2005.12.16	Ч.Поотой
Худалдаа хөгжлийн банк	Валютын	499035014	2005.12.16	Ч.Поотой
Монгол шуудан тээ банк	Төгрөгийн	1100321842	2005.12.16	Ч.Поотой
Мон.Шууд СБ 130-рсал	Төгрөгийн	1150002010	2005.12.16	Ч.Поотой
Анод банк	Төгрөгийн	212101060000400010	2005.12.16	Ч.Поотой

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн бүртгэл:

Д/д	Нэмэлт, өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн Огноо	Бүртгэсэн Ажилтан, тэмдэг
	Энэ хуулийн этгээдэд 2005.12.16 өдөр олгосон гэрчилгээг хүчингүйд тооцож, шинээр гэрчилгээ олгосон болно.	2006.01.13	С.Баясгалан
1	ХХБ СБД 4х 809-р ТТ 409011792 тоот төгрөгийн дансыг буртгэв.	2007.01.10	Г.Алтантуяа
2	Монгол шуудан банкны 1100321985 тоот төгрөгийн дансыг буртгэв.	2007.08.10	Г.Мягмар
3	Хан-Уул, 2-р хороо, Чингэсийн өргөн чөлөө, 48/1 Капитал хаус 3 [illegible] хаягийн шинээр [illegible] буртгэв.	2007.10.30	[illegible]
4	Дүрмийн сан 1731262.4-р нэмэгдэж 1764951.1.0 мянган төгрөг болж, үүсгэн байгуулагчийн тоо 1 болж өөрчлөгдсөнийг буртгэв.	2008.04.17	Б.Монхтөгшин
5	Салбар-1 Архангай аймаг Өлзийт сум байрлах салбар нэгжийг буртгэв.	2008.08.05	Б.Авирмэд
5	Салбар-2 Орхон аймаг Цагаанчулуут сум байрлах салбар нэгжийг буртгэв.	2008.08.05	Б.Авирмэд
6	Дүрмийн сан 1599251.1-р хасагдаж 165700.0 мянган төгрөг болж, үүсгэн байгуулагчийн тоо 1 болж өөрчлөгдсөнийг буртгэв.	2008.09.04	М.Баяржаргалант
7	Дорж овогтой Мөнгөнсомбо [illegible] захирал -р томилсныг буртгэв.	2009.03.09	Ч.Гэрэлцэцэг
8	ХААН банк 5003565202 тоот төгрөгийн дансыг буртгэв.	2010.05.26	Д.Чулуунтуяа
8	ХААН банк 5003565213 тоот валютын дансыг буртгэв.	2010.05.26	Д.Чулуунтуяа
9	Дүрмийн сан 1287869.4-р нэмэгдэж 1453569.4.0 мянган төгрөг болж, үүсгэн байгуулагчийн тоо 1 болж өөрчлөгдсөнийг буртгэв.	2010.09.27	Б.Авирмэд
10	Дүрмийн сан 2971538.5-р нэмэгдэж 4425107.9.0 мянган төгрөг болж, үүсгэн байгуулагчийн тоо 1 болж өөрчлөгдсөнийг буртгэв.	2010.09.28	Б.Авирмэд
11	9011068077 тоот УБД-тай 2807742 тоот регистертэй Шунхлай-Ийст ХХК-г нэгтгэснийг буртгэв.	2010.09.27	Б.Авирмэд
12	Дүрмийн сан 4259407.0-р хасагдаж 165700.0 мянган төгрөг болж, үүсгэн байгуулагчийн тоо 1 болж өөрчлөгдсөнийг буртгэв.	2010.12.06	Б.Авирмэд
13	Худалдаа хөгжлийн банк 499022775 тоот төгрөгийн дансыг буртгэлээс хасав.	2010.12.13	Б.Авирмэд
	ХХБ СБД 4х 809-р ТТ 409011792 тоот төгрөгийн дансыг буртгэлээс хасав.	2010.12.13	Б.Авирмэд
14	Анод банк 212101060000400010 тоот төгрөгийн дансыг буртгэлээс хасав.	2011.02.21	Н.Энхбаяр
15	Үнэнбурэн овогтой Энхцэцэг -г Гүйцэтгэх захирал -р томилсныг буртгэв.	2011.03.07	Д.Чулуунтуяа

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

2006-09-07 нэз
бүртгэв
Б.Ууе

УЛААНБААТАР ХОТ ШУНХЛАЙ ХХК ТТА3531 ᠔. 2028488

Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital Delivering diversity 1119289117 5481589 Улаанбаатар хот

2026.08.31

ШУНХЛАЙ 2026 09 сар 10 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛ УЛСЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2026-09-02 БҮРТГЭВ-03

9011068082 бүртгэлийн 2028468 регистрийн дугаартай
Шунхлай ХХК хавсралт-1

16	Пүрэвдоо овогтой Батхишиг -а Гүйцэтгэх захирал -р томилсныг бүртгэв.	2011.10.04	Д.Чулуунтуяа
17	Голомт төв банк банкны 2105006206 тоот төгрөгийн	2011.10.31	Д.Чулуунтуяа
18	Голомт төв банк банкны 2105006203 тоот валютын дансыг бүртгэв.	2011.10.31	Д.Чулуунтуяа
18	Голомт төв банк банкны 2105006207 тоот валютын дансыг бүртгэв.	2011.10.31	Д.Чулуунтуяа
19	Хөдөлгөөнгүй банк банкны 10600000717 тоот төгрөгийн дансыг бүртгэв.	2011.10.31	Д.Чулуунтуяа
20	Худалдаа хөгжлийн банк банкны 406073791 тоот валютын дансыг бүртгэв.	2011.10.31	Д.Чулуунтуяа
21	Худалдаа хөгжлийн банк банкны 406073790 тоот төгрөгийн дансыг бүртгэв	2011.10.31	Д.Чулуунтуяа
22	602100, Зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх пуслах үйл ажиллагаа хасагдсныг бүртгэв	2012.07.25	Г.Өлзийбаяр
23	Дүрмийн шинэчлэсэн найруулгыг бүртгэв	2012.07.25	Г.Өлзийбаяр
8	Улаанбаатар банк банкны 2603028086 тоот төгрөгийн дансыг бүртгэв. Улаанбаатар банк банкны 2603028087 тоот валютын дансыг бүртгэв Худалдаа хөгжлийн банк банкны 406079586 тоот төгрөгийн дансыг бүртгэв	2013.05.15	Г.Өлзийбаяр
9	Улаанбаатар банк банкны 2603030112 тоот төгрөгийн дансыг бүртгэв	2014.04.24	Д.Чулуунтуяа
	10. Дүрмийн шинэчлэсэн найруулгыг бүртгэв	2016.02.29	Б.Энхбаяр
11	Жаргалсайхан овогтой Менхнаран -а Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч-р томилсныг бүртгэв.	2018.06.29	Б.Гэрэлчимэг
12	Жаргалсайхан овогтой Менхнаран -а Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв.	2018.12.21	С.Менхсаихан
13	Пүрэв овогтой Батсайхан-а ТУЗ-ийн дарга-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2021.12.10	Э.Баточир
14	Гишүүн тоо нийт 9 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2021.12.10	Э.Баточир
15	46100 Толбор эрдэс горхоны үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа үйл ажиллагаа шинээр бүртгэв. 4610 Гадаад худалдаа үйл ажиллагаа хассныг бүртгэв.	2021.12.10	Э.Баточир
16	Дүрмийн шинэчлэсэн найруулгыг бүртгэв.	2022.03.14	У.Мандахтуяа
17	Гишүүн 1 нэмэгдэж 1 хасагдаж ТУЗ-ийн гишүүдийн тоо нийт 9 болж өөрчлөгдсөнийг бүртгэв	2023.01.26	У.Мандахтуяа
18	Гишүүн 1 нэмэгдэж 1 хасагдаж Гишүүн тоо нийт 9 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2024.09.13	Б.Нарантуяа
19	35109 0.4-35кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, үйлчилгээ, түүний туршилт тохируулга, даалгах ажил үйлчилгээ /2025.08.25-2030.08.25/ үйл ажиллагаа шинээр бүртгэв. 35100-500 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, үйлчилгээ, түүний туршилт тохируулга, даалгах ажил, үйлчилгээ барих /2025.05.27-2030.05.27/ үйл ажиллагаа шинээр бүртгэв.	2025.10.07	Г.Дашхорол
20	35100 220 кВ болон түүнээс дээш хүчдэлтэй цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, үйлчилгээ, түүний туршилт тохируулга, даалгах ажил, үйлчилгээ эрхлэх /2025.05.27-2030.05.27/ үйл ажиллагаа шинээр бүртгэв.	2026.07.20	Э.Баточир

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

УЛААНБААТАР ХОТ ШУНХЛАЙ ХХК ТТА3531 № 2028468

Голомт Капитал ТЦК ХХК Golomt Capital Delivering Diversity 1119289111 № 5481589 Улаанбаатар хот

2026.08.31

Хувьцаа эзэмшигчийн 2026 оны 07-р сарын 06-ны өдрийн 8/11 дугаар Шийдвэрийн Хавсралт

"ШУНХЛАЙ" ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ДҮРЭМ

Улсын бүртгэлийн дугаар 9011068082

2026 07 20

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. "Шунхлай" ХХК (цаашид "**Компани**" гэх) нь Монгол Улсыг Иргэний хууль, Компанийн тухай хууль, түүнд нийцүүлэн баталсан энэхүү Компанийн дүрэм (цаашид "**Дүрэм**" гэх) болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу ашгийн төлөө аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх зорилгоор хаалттай буюу хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр зохион байгуулагдсан хуулийн этгээд юм.

1.2. Энэхүү Дүрмээр Компанийн хэлбэр, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, Компанийн оноосон нэр, оршин байгаа газар, Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах, Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө болон өөрийн хөрөнгө түүний хэмжээг өөрчлөх, Компанийн хувьцаа, Хувьцаа Эзэмшигчийн бүрэн эрх, Компанийн удирдлага, зохион байгуулалт, тэдгээрийн бүрэн эрх, үүрэг, тэдгээрт тавих хяналттай холбогдсон харилцааг зохицуулна.

1.3. Компанийн оноосон нэрийг **"ШУНХЛАЙ" ХХК**, англиар **SHUNKHLAI LLC** гэнэ. Компанийн хэлбэр нь хязгаарлагдмал хариуцлагатай компани буюу "ХХК" байна.

1.4. Компанийн оршин байгаа газар нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэг, 2 дугаар хороо, Чингисийн өргөн чолоо - 48/1 Капитал хаусын 3 дугаар давхар байна.

1.5. Компани нь өөрийн тамга, цорын ганц тэмдэг (лого), бичгийн хэвлэмэл хуудастай байна.

1.6. Компанийг Улсын бүртгэлийн байгууллагад (цаашид "**УББ**" гэх)-д бүртгүүлэн Улсын бүртгэлийн гэрчилгээ авсан өдрийг Компани байгуулагдсан өдөр гэж үзнэ.

1.7. Компани байгуулагдсан өдрөөс Компани нь Хувьцаа Эзэмшигчээс тусгайлан өмчилсөн өөрийн эд хөрөнгөтэй, өөрийн үйл ажиллагаагаар эрх олж, үүрэг хүлээх, үйл ажиллагаанаасаа үүсэн гарах үүргийг өөрийн эд хөрөнгийн хэмжээгээр хариуцах, шүүх, арбитрт өөрийн нэрийн өмнөөс оролцох эрхийн чадвартай, банкинд өөрийн нэр бүхий харилцах данстай, бие даасан тайлан баланстай, Дүрэмд заасан үйл ажиллагаа явуулах чадвартай байна.

1.8. Компани нь компани, нөхөрлөл, холбоо болон бусад (гадаадын иргэд болоод хуулийн этгээдтэй хамтарсан хэлбэрийг оролцуулаад) консерциумд нэгдэн орж болно.

1.9. Компани нь өөрийн хараат болон охин компани, салбар, төлөөлөгчийн газрыг байгуулж болно. Хараат болон охин компани нь бие даасан хуулийн этгээдийн эрхийг эдлэх бөгөөд тэдгээрийн удирдлагаас баталсан дүрмийн дагуу бие дааж үйл ажиллагаагаа явуулна.

2. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

2.1. Компани нь дор дурдсан аж ахуйн үйл ажиллагааг эрхлэн явуулна:

2.1.1. Төлбөр эсхүл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа;

2.1.2. Шатахуун бөөний худалдаа;

2.1.3. Шатахууны жижиглэнгийн худалдаа;

2.1.4. Худалдааны зуучлал;

2.1.5. Зорчигч тээврийн үйлчилгээ;

2.1.6. 0.4-35кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ;

2.1.7. 100МВт-аас дээш эрчим хүчний эх үүсвэр барих, угсрах, засварлах, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ;

2.1.8. 220 кВ болон түүнээс дээш хүчдэлтэй цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ.

2.2. Компани нь 2.1 дэх хэсэгт заасан үйл ажиллагааг амжилттай эрхлэн явуулахад шууд болон шууд бусаар нөлөөлөх, хуулиар хориглоогүй, мөн Хувьцаа Эзэмшигчдийн хурлаар ашигтай, эрхэлвэл зохих аж ахуйн үйл ажиллагаа гэж тодорхойлсон үйл ажиллагааг эрхлэн явуулна.

2.3. Компани нь тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагаа явуулахдаа холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу эрх бүхий этгээдээс тусгай зөвшөөрөл авна.

2.4. Компани нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулна.

3. КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

3.1. Хувьцаа эзэмшигч нь:

№	Нэр	Регистрийн дугаар, хаяг:
1	"Шунхлай Холдинг" ХХК	РД: 2737779 Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө- 48/1 Капитал хаус, 4 дүгээр давхар.

3.2. Хувьцаа Эзэмшигч нь өөрийн эзэмшлийн хувьцааг (хэсэгчлэн болон бүхэлд нь) худалдах, бэлэглэх, шилжүүлэх, өөр бусад замаар барьцаалж болно.

4. ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

4.1. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь 165,700,000 *(зуун жаран таван сая долоон зуун мянган)* төгрөг буюу нэг бүр нь 100,000 *(зуун мянган)* төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,657 *(нэг мянга зургаан зуун тавин долоон)* ширхэг энгийн хувьцаанд хуваагдана.

4.1.1. Компанийн зарласан хувьцаа: нэг бүр нь 100,000 *(зуун мянган)* төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,657 *(нэг мянга зургаан зуун тавин долоон)* ширхэг энгийн хувьцаа;

4.1.2. Компанийн гаргасан хувьцаа: нэг бүр нь 100,000 *(зуун мянган)* төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,657 *(нэг мянга зургаан зуун тавин долоон)* ширхэг энгийн хувьцаа.

2026.08.31

4.2. Хувьцаа эзэмшигчид нь Компанийн хувьцааг дараах байдлаар эзэмшинэ:

№	Нэр	Нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ	Эзэмшиж байгаа хувьцааны тоо	Хувьцаа эзэмшигчдэд ногдох хувь
1.	"Шунхлай Холдинг" ХХК	165,700,000 ₮	1,657	100%

4.3. Хувь Нийлүүлсэн Хөрөнгийн хэмжээг Хувьцаа Эзэмшигчдийн хурлын шийдвэрээр нэгж хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх, эсхүл бууруулах, хувьцаа нэмж гаргах замаар өсгөх, өөрийн гаргасан хувьцааг эргүүлэн худалдан авах, хүчингүй болгох замаар бууруулах зэргээр өөрчилж болно.

4.4. Компанийн үйл ажиллагааны алдагдлыг нөхөх зорилгоор хувьцаа нэмж гаргахыг хориглоно.

4.5. Компанийн өөрийн хөрөнгө нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

4.5.1. Хувьцаа Эзэмшигчдийн оруулсан Хувь Нийлүүлсэн Хөрөнгө;

4.5.2. Аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж олсон орлого;

4.5.3. Бусад.

4.6. Компанийн балансад тусгагдсан үндсэн ба эргэлтийн бүх эд хөрөнгийн өмчлөгч нь Компани өөрөө байна. Хувьцаа Эзэмшигчийн эзэмшиж байгаа Хувьцаа нь Компанийн хөрөнгийн өмчлөлд оролцох эрхийг нотлох ба Компанийн аль нэг хөрөнгийг тусгайлан өмчлөх эрхийг нотлохгүй. Хувьцаа Эзэмшигч нь өөрт оногдох Хувьцаагаа худалдан борлуулах замаар Хувьцаанд оногдох хөрөнгийг авч болно.

4.7. Компани нь өөрийн хөрөнгөө өөрийн хараат ба охин компанид шилжүүлэн өгч болно.

4.8. Компани нь хүлээсэн үүргээ өөрийн өмчлөлд байгаа бүх эд хөрөнгөөрөө хариуцах ба Хувьцаа Эзэмшигчийн өр болон хүлээх үүргийг хариуцахгүй.

5. КОМПАНИЙН УДИРДЛАГА, ТҮҮНИЙ БҮРЭН ЭРХ

5.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал (цаашид "**Хувьцаа Эзэмшигчдийн Хурал**" гэх) байна. Хувьцаа Эзэмшигчдийн Хурал нь Компанийн үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар хангана.

5.2. Хувьцаа Эзэмшигчдийн Хурал нь дараах бүрэн эрхийг эдэлнэ:

5.2.1. Компанийн Дүрмийг батлах, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах буюу Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;

5.2.2. Нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар Компанийг өөрчлөн байгуулах;

5.2.3. Компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох;

5.2.4. Компанийн хэлбэрийг өөрчлөх;

5.2.5. Компанийг татан буулгах татан буулгах комиссыг томилох;

5.2.6. Хувьцааг хуваах буюу нэгтгэх;

5.2.7. Компанийн тухай хуулийн 11 дүгээр бүлэгт заасан их хэмжээний хэлцлийг батлах;

5.2.8. Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан сонирхлын зорчилтэй хэлцлийг батлах;

5.2.9. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;

5.2.10. Компанийн тухай хуульд заасан бусад бүрэн эрх.

5.3. Хувьцаа Эзэмшигчдийн Хурлын чөлөөт цагт Компанийн үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалт, хяналтаар хангах ажлыг гүйцэтгэх зорилгоор 9 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "**ТУЗ**" гэх) нь Компанийн үйл ажиллагааг удирдан явуулна. ТУЗ нь Хувьцаа эзэмшигч буюу "Шунхлай Холдинг" ХХК-ийн Удирдлагын хороо байна.

5.4. ТУЗ-ийн гишүүнийг сонгох чөлөөлөх асуудлыг Компанийн толгой компани буюу Хувьцаа эзэмшигч "Шунхлай Холдинг" ХХК-ийн Дүрэмд заасныг зохицуулна.

5.5. ТУЗ-ийн хурал түүний үйл ажиллагаа, хурлын дэгийг Хувьцаа эзэмшигчийн батлснаар буюу "Шунхлай Холдинг" ХХК-ийн Удирдлагын хорооны журмаар зохицуулна.

5.6. ТУЗ-ийн дарга нь "Шунхлай Холдинг" ХХК-ийн Ерөнхийлөгч байна.

5.7. ТУЗ нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.7.1. Компанийн Дүрэмд тусгайлан заагаагүй үйл ажиллагааны чиглэлийг тогтоох;

5.7.2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, хурлаар хэлэлцэх асуудал, хурлын бүртгэлийн өдөр, хурлын товыг тогтоох;

5.7.3. Компанийн зарласан хувьцааны торол болон хэмжээнд багтаан хувьцаа гаргах;

5.7.4. Компанийн салбар, төлөөлөгчийн газрын байгуулах;

5.7.5. Компани зорилгоо хэрэгжүүлэх, бизнесийн үйл ажиллагаагаа дэмжих, өргөжүүлэх зорилгоор бусад хуулийн этгээд /компани/-тэй хамтрах, нэгдэл байгуулах асуудлыг шийдвэрлэх, үүнтэй холбоотойгоор гэрээ байгуулах, эсвэл бусад этгээдэд иттэмжлэл олгох;

5.7.6. Компанийг өөрчлөн байгуулах төсөл боловсруулж Хувьцаа Эзэмшигчдийн Хурлаар хэлэлцүүлэх, шийдвэрийг хэрэгжүүлэх;

5.7.7. Компанийн дүрэмд заасан хувьцаанд хамаарах болон бусад үнэт цаас гаргах;

5.7.8. Компанийн тухай хуулийн 55-р зүйлд заасны дагуу эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;

5.7.9. Компанийн Гүйцэтгэх захирлыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох;

5.7.10. Компанийн Гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох цалин, шагнал урамшууллын хэмжээг тогтоох;

5.7.11. Компанийн аудиторыг сонгож, түүнтэй хийх гэрээний нөхцөлийг тогтоох;

5.7.12. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах;

5.7.13. Ногдол ашгийн хэмжээ, түүнийг төлөх журмыг тодорхойлох;

5.7.14. Компанийн стратегийн богино, дунд, урт хугацааны төлөвлөлт;

5.7.15. Компанийн бизнес төлөвлөгөө;

5.7.16. Компанийн санхүүгийн төлөвлөлт, төсвийн төсөөлөл;

5.7.17. Компанийн бүтэц, удирдлагын багийн бүрэлдэхүүн, дотоод журам, орон тоо, цалингийн сан, урамшууллын хэмжээ, тэдгээрийг олгох журмыг батлах;

5.7.18. Байгууллагын дотоод хэм хэмжээ тогтоосон засаглал болон бодлогын бичиг баримтуудыг батлан гаргах буюу тодорхой асуудлаар гүйцэтгэх удирдлагад эрх олгох;

5.7.19. Компанийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотойгоос бусад хөрөнгө оруулалтын шинжтэй, нэг удаагийн хэлцэл эсхүл хэд хэдэн төстэй хэлцлийн үр дүн нь нэг нөхцөлийг биелүүлэх зорилготой ба уг хэлцэл эсхүл хэлцлүүдийн нийлбэр дүн нь 100 сая төгрөгөөс хэтэрсэн бол уг хэлцлийг хийх зөвшөөрлийг Гүйцэтгэх захиралд олгох;

5.7.20. Бизнес төлөвлөгөөнд дурдаагүй зорилгоор хэлцэл байгуулах зардал гаргах, батлагдсан төсвөөс хэтэрсэн дүнгээр хэлцэл хийх, Компанийн тухай хуульд заасан их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрлүүдийг Гүйцэтгэх захиралд олгох;

5.7.21. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас эрх олгосон бусад асуудал.

5.8. ТУЗ-ийн гишүүдийг Хувьцаа Эзэмшигчдийн Хурлын шийдвэрээр хэдийд ч огцруулж болно.

5.9. Хувьцаа Эзэмшигчдийн хурал болон ТУЗ хуралтай холбоотой энэхүү Дүрмээр зохицуулаагүй бусад асуудлыг Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу зохицуулна.

6. КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

6.1. Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг Хувьцаа Эзэмшигчээс томилогдсон Гүйцэтгэх Захирал (цаашид "**Гүйцэтгэх Захирал**" гэх) удирдан зохион байгуулна. Гүйцэтгэх Захирал нь Хувьцаа Эзэмшигчийн Хуралд ажлаа шууд тайлагнах бөгөөд түүний шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг хариуцан ажиллана.

6.2. Гүйцэтгэх Захирал нь Хувьцаа Эзэмшигчдийн Хурал, ТУЗ-ын хурлын бүрэн эрхэд хамаарахаас бусад Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдах эрх хэмжээний хүрээнд хамаарах асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд бие даан шийдвэрлэнэ.

6.3. Гүйцэтгэх Захирал нь дараах бүрэн эрхтэй байна.Үүнд:

6.3.1. Гүйцэтгэх Захирал нь Компанийг итгэмжлэлгүйгээр дотоод, гадаадад төлөөлөх, шүүх, арбитрын хуралдаанд оролцох, санхүүгийн баримтад гарын үсэг зурах, банкны байгууллагад данс нээх, итгэмжлэл олгох, тушаал гаргах;

6.3.2. Компанийн ажилтнуудыг ажил, албан тушаалд томилох, чөлөөлөх, шилжүүлэх, урамшуулах, хариуцлага хүлээлгэх, шийтгэл ногдуулах, удирдах, тэдний албан үүрэг болон хариуцлагын хэмжээг тодорхойлох;

6.3.3. Хувьцаа Эзэмшигчийн баталсан Компанийн ажил үйлчилгээний үнэлгээний дагуу худалдааны хөрөнгө оруулалт хийх; Компанийн одор тутмын үйл ажиллагаатай холбоотойгоос бусад хөрөнгө оруулалтын шинжтэй, нэг удаагийн хэлцэл эсхүл хэд хэдэн төстэй хэлцлийн үр дүн нь нэг нөхцлийг биелүүлэх зорилготой ба уг хэлцэл эсхүл хэлцлүүдийн нийлбэр дүн нь 100 сая төгрөгөөс хэтэрсэн бол уг хэлцлийг ТУЗ-өөс олгосон зөвшөөрлийн дагуу хэрэгжүүлэх;

6.3.4. Бизнес төлөвлөгөөнд дурдаагүй зорилгоор хэлцэл байгуулах зардал гаргах, батлагдсан төсвөөс хэтэрсэн дүнгээр хэлцэл хийх, Компанийн тухай хуульд заасан их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрлүүдийг ТУЗ-өөс олгосон зөвшөөрлийн дагуу хэрэгжүүлэх;

6.3.5. ТУЗ, Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх, нийнхүү хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээ авах, шийдвэр гаргах;

6.3.6. Хувьцаа Эзэмшигчдийн Хурлаас олгосон бусад бүрэн эрх;

6.4. Гүйцэтгэх Захирал нь Компанийн өмч хөрөнгөөр бусад этгээдийн өмнөөс батлан даалт, баталгаа гаргах, түүнийг барьцаалах, үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийг бусдад худалдах, шилжүүлэх, худалдан авахад Хувьцаа Эзэмшигчийн хүчин төгөлдөр шийдвэрийг баримтална.

6.5. Гүйцэтгэх Захирал нь Компанийн эрхэлж буй аж ахуйн үйл ажиллагаанаас өөр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, бусад аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч хуулийн этгээдийн үйл ажиллагаанд Хувьцаа Эзэмшигчдийн Хурлын зөвшөөрөлгүйгээр оролцох буюу албан тушаал нэгэн зэрэг хаших эрхгүй.

6.6. Гүйцэтгэх Захирал нь өөрт олгогдсон бүрэн эрхээ зохистой үйл ажиллагаанд зарцуулах ба энэхүү Дүрэмд харшлах хэлбэрээр ажиллаж болохгүй. Гүйцэтгэх Захирал өөрийн эрх үүргийг хэрэгжүүлэхдээ үнэнч шударга байж Компанийн эрх ашгийг тэргүүнд тавьж ажиллана.

6.7. Захирлын бүрэн эрхийг дараах үндэслэлээр хугацаанаас нь өмнө дуусгавар болгоно:

6.7.1. Биеийн болон эрүүл мэндийн байдлын улмаас албан үүргээ цаашид биелүүлэх боломжгүй болсон;

6.7.2. Мэргэжил, чадварын хувьд эрхэлж буй ажил, албан тушаалдаа тэнцэхгүй гэж Хувьцаа Эзэмшигчдийн Хурал үзсэн;

6.7.3. Өөр албан тушаалд томилсон буюу сонгосон;

6.7.4. Чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан;

6.7.5. Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай болох нь нотлогдсон;

6.7.6. Хууль тогтоомж болон Дүрмийн заалт, хөдөлмөрийн гэрээний нөхцөлийг удаа дараа санаатай зөрчсөн.

6.8. Гүйцэтгэх Захирал нь жилд нэгээс доошгүй удаа ТУЗ-д ажлаа тайлагнана.

7. КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН, ТЭДГЭЭРИЙН ЭРХ, ҮҮРЭГ

7.1. Компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад бэлэн болон гэрээ хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдийг Компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно. Үүнд:

7.1.1. Гүйцэтгэх Захирал;

7.1.2. ТУЗ-ийн гишүүн;

7.1.3. Эрхэлсэн/Хариуцсан захирал

7.1.4. Ерөнхий нягтлан бодогч,

7.1.5. Ерөнхий аудитор.

7.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь Компанийн тухай хууль, ажилтантай байгуулсан гэрээ, холбогдох бусад журамд заасан эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.

8. ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

8.1. Аудитын тухай Монгол Улсын хуульд заасны дагуу Компанийн санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор Хувьцаа эзэмшигчдийн хурлаас сонгосон эрх бүхий хөндлөнгийн аудитын байгууллагатай гэрээ байгуулан ажиллана.

8.2. Дараах этгээдийг компанийн хөндлөнгийн аудитороор сонгон ажиллуулахыг хориглоно.

8.2.1. Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн бүлэг нэгдмэл сонирхолтой Компанийн хөлсний ажилтан, эрх бүхий албан тушаалтан;

8.2.2. Компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн гаргасан үнэт цаас, компани болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдэд холбогдох бусад эд хөрөнгө бүлэг хөрөнгийн эрх эзэмшдэг бол;

8.2.3. Хөндлөнгийн аудитын үйлчилгээ үзүүлэхээс бусад асуудлаар гэрээ хэлцэл хийсэн.

9. КОМПАНИЙН САНХҮҮ, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ

9.1. Компанийн санхүүгийн жил нь 01 дүгээр сарын 01-нээс (эхний жилийн хувьд байгуулагдсан өдрөөс) эхэлж, 12 дугаар сарын 31-нд (сүүлийн жилийн хувьд Компанийн үйл ажиллагааг зогсоосон өдөр) дуусна.

9.2. Компани нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу орлогын албан татвар болон бусад төлбөр хураамжийг төлнө.

9.3. Компани нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу тухайн жилийн санхүүгийн тайлан, балансыг гаргана. Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг Гүйцэтгэх Захирал, Санхүү хариуцсан захирал нар хариуцна.

9.4. Балансад тусгагдах хөрөнгө, түүний эх үүсвэр болон орлого, үр дүн, мөнгөн гүйлгээ, хуримтлагдсан ашгийн тайлангуудыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу зохих журмын дагуу тус тус гаргана.

9.5. Компани нь ходөлмөрийн гэрээгээр ажиллагчдын эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэл, хураамжийг холбогдох хууль тогтоомжид заасан хувь хэмжээгээр төлнө.

9.6. Компани нь Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлд заасан бичиг баримтыг зохих ёсоор хадгалах үүрэгтэй бөгөөд түүний хэрэгжилтэд Гүйцэтгэх Захирал хяналт тавина.

10. КОМПАНИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ

10.1. Компанийн тухай хуульд зааснаар Компанийг хуваах, тусгаарлах, болон өөр хуулийн этгээдэд нэгтгэх, нийлүүлэх замаар өөрчлөн байгуулж болно.

10.2. Компанийг хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагын шийдвэрээр эсвэл Хувьцаа Эзэмшигчдийн Хурлын тогтоолоор татан буулгаж болно.

10.3. Татан буулгах комиссыг татан буулгах шийдвэр гаргасан этгээд томилно.

10.4. Татан буулгах комисс томилсноор Компанийн Захирлын бүрэн эрх дуусгавар болж, татан буулгах комисст шилжинэ.

10.5. Татан буулгах комисс дараах үүрэг гүйцэтгэнэ. Үүнд:

10.5.1. Компанийг татан буулгах, нэхэмжлэл гаргах журам, хугацааг зээлдүүлэгчид бичгээр мэдэгдэх;

10.5.2. Өр толбөрийг хуульд заасан дараалал, журмын дагуу барагдуулах;

10.5.3. Зээлдүүлэгч болон бусад үүрэг гүйцэтгүүлэгчийн өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг хуульд заасан журмын дагуу Хувьцаа Эзэмшигчдэд шилжүүлэх;

10.5.4. Татан буулгах баланс, тайлан гаргаж, Хувьцаа Эзэмшигчдэд танилцуулж, батлуулах;

10.5.5. Компанийг татан буулгах замаар үйл ажиллагаа дуусгавар болсон тухай УББ-д мэдэгдэж, татан буулгах балансыг УББ-д хүргүүлэх;

10.6. Нэхэмжлэлийн шаардлагыг Компанийн мөнгөн хөрөнгөөр барагдуулах бөгөөд Компанийн мөнгөн хөрөнгө нь нэхэмжлэлийг барагдуулахад хүрэлцэхгүй бол Компанийн эд хөрөнгийг худалдана.

10.7. Татан буулгах комисс нь үүргээ гүйцэтгэх үедээ өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас Компанид хохирол учруулсан бол уг хохирлыг Иргэний хуульд заасан журмын дагуу хариуцна.

10.8. Компани татан буугдаж байгаа талаар зээлдүүлэгчид бичгээр мэдэгдсэнээс хойш 6 сарын дотор төлбөр, тооцоогоо хийгээгүй бол нэхэмжлэлийн шаардлага хангуулах эрхээ алдана.

10.9. УББ Компанийг улсын бүртгэлээс хассанаар татан буугдсанд тооцно.

11. МЭДЭЭЛЭЛ

11.1. Мэдээ, мэдээлэл, тушаал, шүүхийн зарлан дуудах хуудас болон бусад бичмэл албан бичгүүдийг Компанийн албан ёсны цахим хаяг болон хамгийн сүүлд УББ-д бүртгүүлсэн хаягаар хүлээн авна.

12. БУСАД ЗҮЙЛ

12.1. Энэхүү Дүрмээр зохицуулаагүй аливаа асуудлыг холбогдох Монгол Улсын хууль тогтоомжид заасаар зохицуулна.

12.2. Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсан эсхүл шинэчлэн найруулсан тохиолдолд Хувьцаа Эзэмшигчдийн шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор УББ-д нэмэлт өөрчлөлтийг бүртгүүлнэ.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ "ШУНХЛАЙ ХОЛДИНГ" ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛӨН ЕРӨНХИЙЛӨГЧ

П.БАТСАЙХАН

2026.08.31

7.4 Үнэт цаас гаргагчийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЦАХИМ СИСТЕМИЙН ЛАВЛАГАА ТОДОРХОЙЛОЛТЫН МАЯГТ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2025.10.29

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үндсэн мэдээлэл

Бүртгэлийн дугаар : **2028468**
Нэр : **ШУНХЛАЙ Хязгаарлагдмал хариуцлагатай компани**

Зөвшөөрөлтэй холбоотой мэдээлэл

Хүчинтэй эсэх : **Хүчинтэй**
Авсан огноо : **2019-12-24**
Дуусах огноо : **2030-12-24**
Тусгай зөвшөөрлийн нэр : **БҮХ ТӨРЛИЙН ШАТАХУУН ИМПОРТЛОХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ**

Цахим систем нь бусад төрийн байгууллагуудаас шаардлагатай мэдээллийг татан авч байгаа шалгуур болгон ашиглаж байгаа бөгөөд QR кодыг уншуулах үед тухайн шалгууруудыг хангасан эсэхээс хамааран гэрчилгээний төлөв өөрчлөгдөх буюу тухайн үеийн байдлаар харагдахыг анхаарна уу

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЦАХИМ СИСТЕМИЙН ЛАВЛАГАА ТОДОРХОЙЛОЛТЫН МАЯГТ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2025.07.21

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үндсэн мэдээлэл

Регистрийн дугаар : **2028468**
Нэр : **ШУНХЛАЙ Хязгаарлагдмал хариуцлагатай компани**

Зөвшөөрөлтэй холбоотой мэдээлэл

Авсан огноо : **2022-07-20**
Дуусах огноо : **2030-07-20**
Хүчинтэй эсэх : **Хүчинтэй**
Тусгай зөвшөөрлийн нэр : **БҮХ ТӨРЛИЙН ШАТАХУУНЫ БӨӨНИЙ ХУДАЛДАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ**

Цахим систем нь бусад төрийн байгууллагуудаас шаардлагатай мэдээллийг татан авч байгаа шалгуур болгон ашиглаж байгаа бөгөөд QR кодыг уншуулах үед тухайн шалгууруудыг хангасан эсэхээс хамааран гэрчилгээний төлөв өөрчлөгдөх буюу тухайн үеийн байдлаар харагдахыг анхаарна уу

ШУНХЛАЙ ХХК
2026-09-02
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2026-09-02
БҮРТГЭВ-03

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ
АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар 2608/25

Монгол Улсын Зөвшөөрлийн тухай хуулийг үндэслэн

Улаанбаатар хот аймаг/нийслэл **Хан-Уул дүүрэг** сум/дүүргийн **"Шунхлай" ХХК** -д **(РД: 2028468)**

ТЗ-2.2: 0.4-35 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх

тусгай зөвшөөрлийг **2025** оны **05** сарын **27**-ний өдрөөс эхлэн **5** жилийн хугацаатай олгов.

НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ: Тушаал 2026-А/110

ТЗ-1.3: 100 МВт-аас дээш эрчим хүчний эх үүсвэр барих, угсрах, засварлах, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх

ТЗ-2.4: 220 кВ болон түүнээс дээш хүчдэлтэй цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД Б.НАЙДАЛАА

Эрчим хүчний сайдын 2025 оны 05 сарын 27-ний өдрийн А/119 дугаар тушаал

Хүсэлт гаргасан хэлбэр: Төрийн үйлчилгээний нэгдсэн систем
Төрийн үйлчилгээний нэгдсэн системээс олгосон давтагдашгүй дугаар бүхий цахим баримт бичиг нь цаасан баримт бичгийн нэгэн адил хүчинтэй байна.
Мэдээлэл харуулагч байгууллагын холбоо барих утас; +976-51-263051
Мэдээлэл харуулагч байгууллагын хаяг:
Улаанбаатар хот, 17060, Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө, Засгийн газрын XIV байр

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
УА3531 тоо 2028468

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
11 9289111 5481589
Улаанбаатар хот

2026.08.31

ШУНХЛАЙ
2026 .09. 10 өдөр
№ 01

2026 -09- 02
БҮРТГЭВ-03

Б 715 ТОП-100 аж ахуйн нэгжээр шалгарсан тухай тодорхойлолт

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНТ
МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА
АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ
МҮХАҮТ-ын байр, М.Гандигийн гудамж, 15 дугаар хороо,
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17011
Утас: 7727 7070, Факс: (976-11) 32 46 20,
Цахим шуудан: chamber@mongolchamber.mn

2026. 08. 26 № 02/691
танай _____-ны № _____-т

ТОДОРХОЙЛОЛТ

Монгол Улсын засгийн газар болон Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим /МҮХАҮТ/ хамтран улс орны нийгэм, эдийн засаг, бизнесийн хөгжилд бодит хувь нэмэр оруулж, татвар төлөлт, орлого, ашиг, ажиллагсдын тоо зэрэг үзүүлэлтээрээ тэргүүлсэн аж ахуйн нэгжүүдийг жил бүр эрэмбэлэн шалгаруулж, "ТОП-100 Аж Ахуйн Нэгж"-ээр өргөмжлөн алдаршуулдаг уламжлалтай.

МҮХАҮТ-ын Спонсор гишүүн "Шунхлай" ХХК /РД:2028468/ нь 2023, 2024, 2025 онуудад Монгол Улсын "ТОП-100 Аж Ахуйн Нэгж"-ийн эрэмбэд тус тус багтсаныг үүгээр тодорхойлов.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ц.МАГНАЙБААТАР

0000433

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
РД: 2028468

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
1119289111 5401589
Улаанбаатар хот

2026.08.31

7.6 Аудитын компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ

УБ-2

Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 20 дугаар тогтоолоор батлав.

МОНГОЛ УЛС
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

0000089093

2012.02.10	9018018002
/ Бүртгэсэн он.сар.өдөр /	/ Улсын бүртгэлийн дугаар /
	5563348
	/ Регистрийн дугаар /
Нямбазон аудит	ХХК
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /	
Дүрэм	
/ Үндэсэн баримтын баримт бичиг /	
Шийдвэр	01	2012.02.10
/ шийдвэрийн нэр /	/ дугаар /	/ он, сар, өдөр /
6920	Аудитын үйл ажиллагаа /2018.01.14-ний өдөр хүртэл/
/ код /	/ Үндэсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /
/ код /	/ Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /
Хугацаагүй	1	20.00
/ хугацаа /	/ гишүүдийн тоо /	/ хувьцаа эзэмшигчдийн хяналт, шинжилгээ тогтоогоор /

Улаанбаатар, Баянзүрх, 14-р хороо, намъяанжуугийн, Хангарьд төв 303, Утас1: 99135906, Утас2: 91005906 Факс

/ хуулийн этгээдийн эрхлэх гол ажлын хаяг /

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Бүртгэлийн газар

/ бүртгэсэн байгууллагын нэр /

Гэрчилгээ дахин олгосон 2015 он 1 сар 22 өдөр

УЛААНБААТАР ХОТ

ШУНХЛАЙ ХХК

Голомт Капитал ҮЦК ХХК

Golomt Capital

Delivering diversity

1119289111

Улаанбаатар хот

ШУНХЛАЙ СЗХ
2026.09.10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2026-09-02
БҮРТГЭЛ-03

Үнэт цаасны танилцуулга

Харилцах дансны бүртгэл

Харилцагч банкны нэр	Дансны төрөл	Дансны дугаар	Бүртгэсэн ажилтан тэмдэг
Голомт банк	Төгрөгийн	1705026253	Б.Оюун-Эрдэнэ

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичиг оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэл	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Зөвлөрөөс баталгаажуулсан-р тушаалтай бүртгэл	2012.02.10	Б.Оюун-Эрдэнэ
2	Дахин гэрчилгээ олгов	2015.01.22	С.Ундрах
3	Улаанбаатар, Чингэлтэй, 3-р хороо, Чойжамцын гудамж -4, Нийслэл УБ хотын ҮЭ-ийн холбооны байр, 4 давхар, 408 тоот Утас1: 99135906, Утас2: 91005906, Факс: хаягийг шинээр бүртгэв.	2019.11.06	Г.Санжаа
4	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 8180 мян.төг-р нэмэгдэж нийт 8200 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв.	2019.11.06	Г.Санжаа
5	Эцсийн өмчлөгч 1 иргэн бүртгэв.	2020.03.20	С.Цолмон
6	6920 Аудитын үйл ажиллагаа үйл ажиллагааны чиглэлийн хугацаа 2018.02.02-2021.02.02 болгож сунгав.	2020.03.20	С.Цолмон
7	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 30000 мян.төг-р нэмэгдэж нийт 38200 мян.төг болсон өөрчлөлт тийг бүртгэв.	2021.12.01	М.Монголжин
8	6920 Аудитын үйл ажиллагаа үйл ажиллагааны чиглэлийн хугацаа 2021.02.02-2024.02.02 болгож сунгав.	2021.12.01	М.Монголжин
9	6920 Аудитын үйл ажиллагаа үйл ажиллагааны чиглэлийн хугацаа 2024.02.02-2027.02.12 болгож сунгав.	2024.04.18	Б.Мягмарсүрэн

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
ТТА3531 ᠓ 2028468

88

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
1119289111 – 5181589
Улаанбаатар хот

2026.08.31

7.7 Аудитын компанийн тусгай зөвшөөрөл

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЦАХИМ СИСТЕМИЙН ЛАВЛАГАА ТОДОРХОЙЛОЛТЫН МАЯГТ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2024.02.05

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үндсэн мэдээлэл

Регистрийн дугаар :	**5563348**
Нэр :	**НИЯМАЗОН АУДИТ Хязгаарлагдмал хариуцлагатай компани**

Зөвшөөрөлтэй холбоотой мэдээлэл

Авсан огноо :	**2015-01-14**
Дуусах огноо :	**2027-02-12**
Хүчинтэй эсэх :	**Хүчинтэй**
Тусгай зөвшөөрлийн нэр :	**АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ**

Цахим систем нь бусад төрийн байгууллагуудаас шаардлагатай мэдээллийг татан авч байнгын шалгуур болгон ашиглаж байгаа бөгөөд QR кодыг уншуулах үед тухайн шалгууруудыг хангасан эсэхээс хамааран гэрчилгээний төлөв өөрчлөгдөх буюу тухайн үеийн байдлаар харагдахыг анхаарна уу

2026.08.31

7.8 Аудитын компанитай хийсэн гэрээ

НИЯМАЗОН АУДИТ ХХК

АУДИТЫН АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

8/294

ШУНХЛАЙ ХХК

ГЭРЭЭНИЙ ДУГААР:
26/2026468-Б

+976-70145906, +976-99135906
Чингэлтэй дүүрэг, 2 дугаар хороо, Чоймболын гудамж, Нийслэлийн үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны байр, 406 тоот
audit@nmz.mn

2026.08.31

ШУНХЛАЙ СЭХ 2026.09.10 БҮРТГЭВ

№ Ниямазон аудит ХХК

Аудитын ажлыг гүйцэтгэх гэрээ

НИЯМАЗОН АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

ШУНХЛАЙ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

АУДИТЫН АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

Улаанбаатар хот Дугаар-26/2026468-Б 2026 оны 07-р сарын 27-ны өдөр

Энэхүү гэрээг НЭГ ТАЛААС 5563348 тоот регистрийн дугаартай, Монгол Улс, Чингэлтэй дүүрэг, 3 дугаар хороо, Чоймболын гудамж, НҮЭХ-ны 406 тоот хаягт байрлах Ниямазон аудит ХХК (цаашид "гүйцэтгэгч" гэх)-г толгойлж менежер Ж.Батцасан, НӨГӨӨ ТАЛААС 2028468 регистрийн дугаартай, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 19-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Капитал хаус, 5 давхар хаягт байрлах Шунхлай ХХК (цаашид "үйлчлүүлэгч" гэх)-г толгойлж Санхүү хариуцсан захирал Ж.Оюумаа нар 2026 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд аудит хийлгэхээр харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү гэрээгээр Гүйцэтгэгч нь Үйлчлүүлэгчийн 2026 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд "Шунхлай бонд"-ын үнэт цаасны танилцуулгатай холбоотой нягтлах ажлыг холбогдох стандарт, хууль, тогтоомжийг баримтлан чанартай хийж гүйцэтгэн үйлчлүүлэгчид хүлээлгэн өгөх, үйлчлүүлэгч нь түүнд ажлын хөлсийг төлөхтэй холбогдох үүссэн харилцааг зохицуулна.

1.2 Гэрээгээр гүйцэтгэх аудитын ажил гэж:
-"Шунхлай бонд"-ын үнэт цаасны танилцуулга, хавсаргасан барим бичгт тусгасан 2026 оны эхний хагас жилийн санхүүгийн мэдээллийг нягтлах, компанийн нягтлан бодох бүртгэлийн боллого, дотоод хяналтын тогтолцоо нь СТОУС-д нийцэж буй эсэх, хувь нийлүүлсэн хөрөнгө болон түүний ашиглалтын үр ашигтай байдлыг хангаж чадаж буй эсэхийг үнэлэх

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ҮНЭ, ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

2.1 Гэрээний үнийн дүн төгрөг байна. Гэрээний ажил гүйцэтгэхтэй холбогдон гарах бүх зардал, татвар суутгал багтсан болно. Талууд гэрээт хугацаанд үнэд өөрчлөлт оруулахгүй.

2.2 Үйлчлүүлэгч нь төлбөрийг Монгол Улсын Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуульд заасныг үндэсний мөнгөн тэмдэгт "Төгрөг"-өөр гүйцэтгэнэ.

2.3 Төлбөрийг гүйцэтгэгчийн Голомт банкин дахь MN090015001705026253 тоот дансанд хийнэ.

2.4 Гэрээ байгуулснаас хойш урьдчилгаа 50% буюу төгрөгийг ажлын 5 өдрийн дотор аудитын үйлчилгээний төлбөрийг төлнө.

2.5 Гэрээт ажил бүрэн, хугацаандаа дуусснаас хойш гэрээ дүгнэсэн акт, нэхэмжлэхэд үндэслэн үлдэгдэл 50% буюу төгрөгийг ажлын 5 өдрийн дотор төлнө.

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

3.1 Ажил гүйцэтгэх хугацаа 2026 оны 07-р сарын 27-ны өдрөөс 2026 оны 08-р сарын 27-ны өдрийг дуустал хугацаатай байна.

3.2 Талууд тохиролцож гэрээний хугацааг сунгаж болно. Ийнхүү сунгасан тохиолдолд нэмэлт гэрээ байгуулна.

ДӨРӨВ. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1 Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, мэргэжлийн стандарт, ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн гэж үзвэл энэ тухай гүйцэтгэгчид бичгээр мэдэгдэж, шалгуулах
4.2 Аудитад шаардагдах материалыг 2026 оны 07 дугаар сарын 28-ны дотор гүйцэтгэгчид өгөх
4.3 Аудиттай холбоотой мэдээлэл, судалгаа, тайлбар, тодорхойлолт, холбогдох бусад баримт бичгийг шуурхай гаргаж өгөх ба холбогдох ажилтнуудыг шаардлагатай үед бэлэн байлгах.
4.4 Энэхүү гэрээний 4.3, 5.1-т заасан шаардлагатай бичиг баримтыг цаг хугацаанд гаргаж өгөөгүйгээс үүдэн гарах ажлын чанар үр дүн, хохиролыг үйлчлүүлэгч тал өөрөө бүрэн хариуцна.
4.5 Гүйцэтгэгчийг ажиллах нөхцөл бололцоогоор хангах

ТАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

5.1 Аудитын ажилд шаардлагатай мэдээлэл, судалгаа, тайлбар тодорхойлолт холбогдох бусад баримт бичгийг үйлчлүүлэгч байгууллагаас бүрэн хэмжээгээр, чөлөөтэй, шуурхай, үнэ төлбөргүй гаргуулан авах
5.2 Санхүүгийн тайлангийн аудитын ажлыг чанарын болон мэргэжлийн зохих түвшинд гүйцэтгэх
5.3 Аудитыг гүйцэтгэхдээ Аудитын тухай хууль болон Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын гарын авлага, Мэргэшсэн нягтлан бодогчийн ёс зүйн дүрэм, аудитын ажил гүйцэтгэхтэй холбогдох бусад дүрэм, журмыг мөрдөж ажиллах
5.4 Аудит хийх явцад олж авсан төрийн болон байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээллийг уг мэдээллийг өгсөн байгууллагынхтай нь ижил түвшинд нууцалж хамгаалах үүрэгтэй.
5.5 Гүйцэтгэгч аудитын төгсгөлд захиалагчид аудит хийгдсэн санхүүгийн тайлан, аудитын гэрчилгээ тус бүр 1 хувь хүлээлгэн өгнө.

ЗУРГАА. ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

6.1 Гэрээгээр тохирсон аудтын ажлыг бүрэн гүйцэтгээгүй байхад үйлчлүүлэгч тал гэрээг хугацаанаас нь өмнө цуцласан тохиолдолд ажил гүйцэтгэхтэй холбогдон гарсан зардал, учирсан хохирлыг гүйцэтгэгчийн ажлын үнээр бүрэн хариуцлага хүлээнэ.
6.2 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бол үүрэг гүйцэтгэвэл зохих тал нөгөө талын нэхэмжлэлээр хариуцлага хүлээнэ.

ДОЛОО. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

7.1 Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл / тухайлбал : газар хөдлолт , үер, гал түймэр, далайн шуурга, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт / -ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд талууд тохиролцон гэрээний үүрэг биелүүлэх боломжит хугацааг харилцан тохиролцоно.
7.2 Дээрх давагдашгүй хүчин зүйл бий болсон тухай нотолгоог тухайн орны холбогдох байгууллагын шийдвэр, тогтоолоор батална.

НАЙМ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ, ЦУЦЛАХ

8.1 Гэрээгээр тохирсон ажлыг гүйцэтгэснээр гэрээ дуусгавар болно.
8.2 Үйлчлүүлэгч тал гэрээний төлбөрийн нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор төлөөгүй бол гүйцэтгэгч талын санаачилгаар гэрээг цуцлана.
8.3 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн бөгөөд энэхүү зөрчлийг арилгах талаар мэдэгдэл хүлээн авснаас хойш 30 хоногт зөрчлөө арилгаагүй бол зөрчил арилгуулах эрх бүхий талын санаачилаар гэрээг цуцлана.

ЕС. НУУЦ ХАДГАЛАХ

2026.08.31

9.1 Аудитын явцад аудиторт гаргаж өгсөн бүхий л мэдээллийн нууцыг АОУС-ын нэг үндсэн зарчмын дагуу чандлан хадгална. Тусгай мэргэжлийн стандарт болон хуульд дүрэм журмын дагуу шаардсанаас бусад тохиолдолд аудитор нь үйлчлүүлэгчийн мэдээллийг бусад талуудад задруулахгүй байх үүрэгтэй.

9.2 Гүйцэтгэгч нь гэрээний хугацаанаас гадна түүнийг дуусгаавар болсноос хойш хугацаагүйгээр энэхүү гэрээтэй холбоотой аливаа өмчлөл буюу нууц мэдээлэл, үйлчлүүлэгчийн бизнес буюу үйл ажиллагааны талаар үйлчлүүлэгчийн бичгэн зөвшөөрөлгүйгээр бусдад задруулахгүй байх үүрэг хүлээнэ.

АРАВ. БУСАД

10.1 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, баталснаас хойш гэрээний үүрэг хэрэгжиж дуусах хүртэл хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.

10.2 Гэрээний хугацаа, нөхцөл байдлын талаар өөрчлөлт оруулахаар бол хоёр тал харилцан тохиролцож нэмэлт гэрээ бичгээр байгуулна.

10.3 Талуудын хооронд маргаан гарвал талууд үл маргах журмаар шийдвэрлэх ба маргаанаа шийдвэрлэж чадахгүйд хүрвэл аливаа маргаантай асуудлыг Монголын улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

10.4 Талууд энэхүү гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд энэ нэмэлт нь гэрээний салшгүй хэсэг байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ	ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ
Байгууллагын нэр Ниямазон аудит ХХК	Байгууллагын нэр: Шунхлай ХХК
Менежер Ж.Батнасан	Санхүү хариуцсан захирал Ж.Оюумаа
Гарын үсэг	Гарын үсэг .....
Утас: 70145906 Мэйл хаяг: audit@nmz.mn	Утас: 99042622 Мэйлхаяг: oyumaa.j@shunkhlai.mn

Үнэт цаасны танилцуулга

Б Үнэт цаасны 7.9 Аудитын компанийн тодорхойлох захидал

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД

NIYAMAZON AUDIT LLC
#408, Building of Trade Union Federation,
Choimbol street, Chingeltei district,
Ulaanbaatar 15172, Mongolia
Tel: (976) 70145608, 91005906
E-mail: audit@nmz.mn

2026.08.28 № 08/28

Тодорхойлох захидал

Бид Шунхлай ХХК-ийн 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөр тасалбар болсон санхүүгийн тайланд аудит хийсэн бөгөөд тус компанийн зүгээс нийтэд санал болгон гаргах "Шунхлай-4" нээлттэй бондтой холбогдуулан Санхүүгийн зохицуулах хороо /СЗХ/ болон Монголын хөрөнгийн биржид бүртгүүлэхээр хүргүүлж буй үнэт цаасны танилцуулга, уг танилцуулгад багтсан санхүүгийн мэдээлэл нь аудит хийгдсэн санхүүгийн тайлангийн мэдээлэлтэй тохирч байгаа эсэхэд СЗХ-ны даргын 2021 оны 225 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын дагуу хяналт хийлээ.

Энэхүү захидалтай холбогдуулж дараах зүйлсийг мэдэгдэж байна. Үүнд:

- Бидний Нягтлан бодогчдын Ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол Улсын Аудитын тухай хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагуудын дагуу тус компаниас хараат бус, ашиг сонирхлын зөрчилгүй үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн.
- Бид үнэт цаас гаргагч Шунхлай ХХК-тай аливаа сонирхлын зөрчилгүй бөгөөд үүсэж болзошгүй сонирхлын зөрчлөөс сэргийлэх арга хэмжээг тухай бүрд нь холбогдох хууль, тогтоомж, дүрэм журмын дагуу авч хэрэгжүүлсэн.
- Бид тус компанийн 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөрх санхүүгийн тайланд аудитыг хийж гүйцэтгэсэн ба үнэт цаасны танилцуулгад хавсаргасан аудит хийгдсэн санхүүгийн тайлан нь материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/-д нийцсэн гэж дүгнэсэн.
- Үнэт цаасны танилцуулгын 1.9-д дурдсан үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагааны хэсгийн санхүүгийн тайлантай холбоотой түүхэн мэдээллүүд нь бидний аудит хийсэн санхүүгийн тайлангийн дүнтэй тохирч байна.
- Бид 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөр тасалбар болсон санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналтын тогтолцоо нь СТОУС-д нийцсэн, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, түүний үр ашигтай байдлыг хангаж байна гэж дүгнэсэн. Үүнтэй холбоотой дараах горимуудыг гүйцэтгэсэн. Үүнд:
  -Компанийн санхүүгийн тайлангийн дотоод хяналт, үүнд хяналтын орчин, эрсдэлийн үнэлгээ, хяналтын үйл ажиллагаа, мэдээлэл болон харилцаа, мониторинг зэргийн талаар ойлголт олж авсан ба эдгээр хяналтуудын талаар даган мөшгөх сорил гүйцэтгэсэн.

Гүйцэтгэсэн аудитын горимуудтай холбоотой хязгаарлалтууд

-Үнэт цаасны танилцуулгыг хянаж, аудитын горимууд нь зөвхөн санхүүгийн түүхэн мэдээллийг хамарсан ба бизнес төлөвлөгөө болон санхүүгийн хэтийн төсөөллийг хамраагүй болно.
-Бид 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс хойш хугацааны санхүүгийн тайланд аудит хийгээгүй учир уг өдрөөс хойш энэхүү захидал гарах хүртэлх завсар үеийн санхүүгийн мэдээлэл аудитад хамааралгүй юм.
-Дээр дурдсан горимууд нь хууль тогтоомж болон СЗХ-ны дүрэм журмын шаардлагын хүрээнд хийгдсэн ба эдгээр горимуудаа бид үнэт цаасны танилцуулгатай холбоотой бүх

2026.08.31

ШУНХЛАЙ
2026 .09.10 өдөр
БҮРТГЭВ
№ 21

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2026-09-02
БҮРТГЭВ-03

асуудлуудыг илрүүлэх шаардлагагүй бөгөөд танилцуулгад орсон бүх мэдээллүүд нь үнэн зөв эсэхэд ямар нэг баталгаа өгөхгүй.

-Эдгээр горимын үр дүнд бидний анхааралд өртсөн зөрүүтэй илэрхийлэл илрээгүй боловч үнэт цаасны танилцуулгад дурдсан хяналт хийгдээгүй, бусад мэдээллүүд нь бидний хяналт хийсэн санхүүгийн мэдээлэл болон холбогдох дүрэм, журамд нийцэж байгаа гэдэгт итгэж байна.

-Энэхүү тайланг зөвхөн үнэт цаас гаргахтай холбоотой андеррайтерийн үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх зорилгоор бэлтгэсэн бөгөөд өөр бусад зорилгоор бэлтгээгүй болно.

Хүвийг. Монголын хөрөнгийн бирж ХК-д

Ниямазон аудит ХХК
УЛААНБААТАР ХОТ

З.Цээнээ
Захирал
Ниямазон аудит ХХК

Улаанбаатар хот, Монгол Улс
2026 оны 08 дугаар сарын 28

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК

Голомт Капитал ҮЦК ХХК
Голомт Capital
Delivering Diversity
Улаанбаатар хот

ШУНХЛАЙ ХХК

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн

ТУСДАА САНХҮҮГИЙН ТАЙЛАН

(Хараат бус аудиторын тайлангийн хамт)

Агуулга

	Хуудас
Удирдлагын Хариуцлагын Мэдэгдэл	
Хараат бус Аудиторын Тайлан	
Түсдаа Санхүүгийн Байдлын Тайлан	1
Түсдаа Ашиг, Алдагдал болон Бусад Дэлгэрэнгүй Орлогын Тайлан	2
Түсдаа Өмчийн Өөрчлөлтийн Тайлан	3
Түсдаа Мөнгөн Гүйлгээний Тайлан	4
Түсдаа Санхүүгийн Тайлангийн Тодруулга	5

ШУНХЛАЙ
2026 .09. 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Үнэт цаасны Танилцуулга

2026 -09- 02
БҮРТГЭВ-03

Удирдлагын Хариуцлагын Мэдэгдэл

Компанийн удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Шунхлай ХХК ("Компани" гэх)-ийн тусдаа санхүүгийн тайлан нь СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудын дагуу бэлтгэгдсэн. Компанийн удирдлага нь энэхүү тусдаа санхүүгийн тайлан нь Компанийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв илэрхийлсэн гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.

Компанийн удирдлага нь Компанийн санхүүгийн байдлыг үндэслэлтэй, үнэн зөв илэрхийлж чадах, санхүүгийн тайлангууд нь тодруулга 2 ба 3-т дурьдсан шаардлагуудад нийцсэн гэдгийг баталгаажуулах боломжийг хангах зөв зохистой нягтлан бодох бүртгэлийг хөтөлж байгаа гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.

Мөн Компанийн удирдлага нь Компанийн эд хөрөнгийг хадгалан хамгаалах, аливаа заль мэх, зүй бус үйлдлээс сэргийлэх, ийм үйлдлийг илрүүлэхэд шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх ерөнхий үүрэгтэй.

Компанийн удирдлага нь тусдаа санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогыг сонгон, тууштайгаар даган мөрдөж, үндэслэлтэй, нягт нямбай тооцоолол, үнэлгээ хийж, бүх холбогдох нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдсөн гэж үзэж байна.

Компанийн удирдлагаас Шунхлай ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн тусдаа санхүүгийн тайланг зөвшөөрч батлав.

Ж. Мөнхнаран
Гүйцэтгэх Захирал

Ж. Оюумаа
Санхүүгийн Газрын Захирал

Монгол Улс,
Улаанбаатар хот

2025 оны 7 дугаар сарын 7-ны өдөр

2026.08.31

ШҮНХЛАЙ
2026 09 19 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Үнэт цаасны танилцуулга

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2026 -09- 02
БҮРТГЭВ-03

KPMG

Кэй Пи Эм Жи Аудит ХХК
Монгол Улс, Улаанбаатар-14240,
Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо,
Энхтайваны өргөн чөлөө 17,
Блю Скай Тауэр, 602 тоот

Утас : +976 7011 8101
Факс: +976 7011 8102
www.kpmg.com/mn

Хараат Бус Аудиторын Тайлан

Шүнхлай ХХК-ын Хувьцаа Эзэмшигч болон Төлөөлөн Удирдах Зөвлөлд:

Дүгнэлт

Бид Шүнхлай ХХК-ийн (цаашид "Компани" гэх) 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх тусдаа санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн тусдаа ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, тусдаа өмчийн өөрчлөлтийн тайлан, тусдаа мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд ба бусад тайлбар мэдээллүүдийг агуулсан тодруулгуудаас бүрдсэн тусдаа санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, энэхүү тусдаа санхүүгийн тайлан нь Компанийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх тусдаа санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн тусдаа санхүүгийн гүйцэтгэл болон тусдаа мөнгөн гүйлгээг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс батлагдсан СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартууд (цаашид "СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартууд" гэх)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн Үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (цаашид "АОУС" гэх)-ын дагуу хийж гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн *Тусдаа Санхүүгийн Тайлангийн Аудитад Хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага* хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Дүрэм (Хараат Бус Байдлын Олон Улсын Стандарт үүнд хамаарна) (цаашид "НБЁЗОУСЗ-ийн Ёс зүйн Дүрэм" гэх) болон тусдаа санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой Монгол Улс дахь ёс зүйн зохих шаардлагуудын дагуу Компаниас хараат бус байж, НБЁЗОУСЗ-ийн Ёс Зүйн Дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт өгөхөд хангалттай бөгөөд зохих үндэслэл болно гэдэгт бид итгэж байна.

Аудитын Гол Онцлох Зүйлс

Аудитын гол онцлох зүйлс гэдэг нь бидний мэргэжлийн үнэлэмжээр тайлант жилийн тусдаа санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал ач холбогдол бүхий зүйлс юм. Бид тусдаа санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр аудитын гол онцлох зүйлсийг бүхэлд нь авч үзсэн ба дүгнэлт гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн тусдаа дүгнэлт гараагүй болно.

Кэй Пи Эм Жи Аудит ХХК нь Монгол Улсын хязгаарлагдмал хариуцлагатай компани бөгөөд баталгаагаар хязгаарлагдсан Англи Улсын хувийн компани болох KPMG International Limited-д харьяалагдах бие даасан нэгжүүд байгуулагдсан тусгаа KPMG олон улсын байгууллагын гишүүн юм. Эдгээр хуулиар хамгаалагдсан.

УЛААНБААТАР ХОТ
ШҮНХЛАЙ ХХК
УГА3531 Ш. 2029488

Голомт Капитал УЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
1119289111 ☎ 5181589
Улаанбаатар хот

2026.08.31

Аудитын Гол Онцлох Зүйлс, Үргэлжлэл

Борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөлт

Тусдаа санхүүгийн тайлангийн Тодруулга 18, мөн Тодруулга 3 (и)-т тусгагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулгуудыг харна уу.

Гол онцлох зүйлс	Тэдгээрийг шийдвэрлэсэн аудитын арга хэмжээ
Аудитын Олон Улсын Стандартад борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөлттэй холбоотой залилангийн эрсдэл аливаа байгууллагад зайлшгүй байдаг гэж үздэг. Бид борлуулалтын орлого бодитоор үүссэн эсэх болон борлуулалтыг зөв тайлант үед бүртгэсэн эсэх эрсдэлийг удирдлагад үүсч бүй төлөвлөсөн санхүүгийн үр дүнд хүрэх шахалтаас үүссэн байж болзошгүй гэж тодорхойлсон. Дээрх зүйлстэй холбоотойгоор бид борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөлтийг тусдаа санхүүгийн тайлангийн гол онцлох зүйл гэж авч үзсэн.	Борлуулалтын орлогын хувьд гүйцэтгэсэн аудитын горимууд: • Санхүүгийн тайланг санаатайгаар буруу илэрхийлэх эрсдэлтэй холбоотойгоор борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөлтийн үйл явцад эрсдэл үүсэхээс сэргийлсэн хяналтын үйл явцын загварчлал, түүний хэрэгжилтийг үнэлсэн. • Компанийн хэрэгжүүлсэн борлуулалтын орлого хүлээн зөвшөөрөх бодлогыг удирдлагатай ярилцлага хийх, борлуулалтын орлогыг хүлээн зөвшөөрч буй цаг хугацааг холбогдох стандартын шаардлагад нийцэж буй эсэхийг борлуулалтын гэрээнүүдээс түүвэр байдлаар сонгон ажил гүйлгээний хүргэлтийн нөхцөлүүдийг ойлгох үүднээс нягтлан шалгасан. • Борлуулалтын орлогыг зохих санхүүгийн жилд борлуулалтын гэрээний нөхцөлийн дагуу хүлээн зөвшөөрсөн эсэхийг шалгах үүднээс жилийн дүүсгавар болох хугацааны үед хийгдсэн борлуулалтын ажил гүйлгээнүүдээс түүврээр сонгон авч бараа материалын зарлагыг илэрхийлэх баримтууд, борлуулсан бараа материалын хүргэлтийг худалдан авагч талаас хүлээн зөвшөөрсөн холбогдох баримт бичигүүдтэй тулган шалгасан. • Компанийн жилийн туршид хүлээн зөвшөөрсөн борлуулалтын орлогыг Компанийн арилжааны банк дахь харилцах дансаар хүлээн авсан мөнгөн хөрөнгөтэй тулгах замаар борлуулалтын орлогын бодит байдлыг үнэлсэн. • Компанийн хүлээн зөвшөөрсөн борлуулалтын орлогод аудитын гормыг гүйцэтгэх, тухайлбал худалдан авагчидтай борлуулалтын орлогыг тулган баталгаажуулах. • Компанийн борлуулалтын тоо хэмжээ болон үнийн мэдээлэлд үндэслэн хүлээгдэж буй холбоотой

Гол онцлох зүйлс	Тэдгээрийг шийдвэрлэсэн аудитын арга хэмжээ
	талуудаас олсон борлуулалтын орлогыг тодорхойлох байдлаар аудитын горим гүйцэтгэж шалгасан. • Орлого хүлээн зөвшөөрөх ердийн үйл явцаас гадуур борлуулалтын орлогын журналын бичилтүүд хийгдсэн эсэхийг шалгасан. • Тусдаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгуудыг СТОУС 15-ын хүрээнд тавигдсан борлуулалтын шаардлагыг хангасан эсэхийг үнэлж шалгасан.

Бусад Мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээллийн хувьд үүрэг, хариуцлага хүлээх юм. Бусад мэдээлэл гэдэгт жилийн тайланд орсон мэдээллийг хамруулж ойлгох ба тусдаа санхүүгийн тайлан болон манай аудиторын тайлан үүнд хамаарахгүй болно. Жилийн тайлан нь энэхүү аудиторын тайлангийн өдрөөс хойш бидэнд танилцуулагдахаар хүлээгдэж байна.

Тусдаа санхүүгийн тайлан дахь бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамрахгүй бөгөөд үүнд бид ямар нэгэн баталгаажуулалт илэрхийлэхгүй юм.

Бусад мэдээллийг уншиж танилцан, уг мэдээлэл нь тусдаа санхүүгийн тайлан эсвэл аудитын явцад олж авсан бидний ойлголттой материаллаг хэмжээгээр нийцэхгүй эсвэл материаллагаар буруу илэрхийлэгдсэн зүйлс байгаа эсэхийг шалгах нь тусдаа санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой бидний хүлээх үүрэг, хариуцлага юм.

Жилийн тайлантай танилцах үед хэрэв бусад мэдээлэлд материаллаг буруу илэрхийлэл байна гэж үзвэл бид засаглах эрх бүхий этгээдүүдэд мэдэгдэх үүрэгтэй.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Тусдаа Санхүүгийн Тайланд Хүлээх Үүрэг Хариуцлага

Тусдаа санхүүгийн тайланг СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Алдаа, зальт ажиллагааны улмаас материаллагаар буруу илэрхийлэгдээгүй тусдаа санхүүгийн тайланг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх үүрэг хариуцлагыг мөн удирдлага хүлээнэ.

Тусдаа санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлагын зүгээс Компанийн тасралтгүй үйл ажиллагаа эрхлэх чадамжийг үнэлэн, шаардлагатай гэж үзвэл тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг тусдаа санхүүгийн тайланд тодруулж, Компанийн татан буулгах юм уу үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан тусдаа санхүүгийн тайлангаа бэлтгэх үүргийг Компанийн удирдлага хүлээнэ.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Түсдаа Санхүүгийн Тайланд Хүлээх Үүрэг Хариуцлага, Үргэлжлэл

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хүлээнэ.

Түсдаа Санхүүгийн Тайлангийн Аудитад Хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага

Түсдаа санхүүгийн тайлан нь залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй нотолгоог олж авах, бидний дүгнэлтийг агуулж буй аудиторын тайланг танилцуулах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт хэдий ч АОУС-ын дагуу гүйцэтгэсэн аудит нь бүхий л материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдааны улмаас үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ уг түсдаа санхүүгийн тайланд үндэслэн гаргах мэдээлэл хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөхөөр хүлээгдэж байвал материаллаг гэж үзнэ.

АОУС-ын дагуу аудит хийх үед мэргэжлийн үнэлэмж гаргах, мэргэжлийн үл итгэх үзлээр хандахыг аудитын ажлын явцад шаарддаг. Бид мөн:

- Түсдаа санхүүгийн тайланд залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авдаг. Залилан нь хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах зэрэг явдлуудыг агуулсан байдаг тул залилангаас үүсэх материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдааны улмаас үүсэх буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг.

- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горимыг боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.

- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын үндэслэл болон холбогдох тодруулгуудыг үнэлдэг.

- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн бид олж авсан нотолгоондоо тулгуурлан Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа эрхлэх чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Материаллаг тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл бид аудиторын тайланд түсдаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл энэхүү тодруулга нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Бид дүгнэлтээ аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд үндэслэн гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал нь Компанийг тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.

- Түсдаа санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц болон агуулгыг тодруулгуудын хамт үнэлж, түсдаа санхүүгийн тайлан нь холбогдох ажил гүйлгээнүүд болон үйл явдлуудыг үнэн зөв илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

ШУНХЛАЙ СЗХ
2026 09 19 өдөр
БҮРТГЭВ
№ 1

Үнэт цаасны танилцуулга

МОНГОЛЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2026 -09- 02
БҮРТГЭВ-03

KPMG

Түсдаа Санхүүгийн Тайлангийн Аудитад Хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага, Үргэлжлэл

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн цар хүрээ, хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Мөн бид засаглах эрх бүхий этгээдүүдэд хараат бус байдлын талаарх холбогдох ёс зүйн шаардлагыг биелүүлсэн талаарх мэдэгдлийг хийдэг бөгөөд шаардлагатай үед бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц бүхий л харилцаа болон бусад асуудлууд, хараат бус байдлын эрсдэлийг бууруулсан эсвэл түүний эсрэг авсан хамгаалалтын хариу үйлдлүүдийн талаарх мэдэгдлийг хийдэг.

Засаглах эрх бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас бид тайлант жилийн түсдаа санхүүгийн тайлангийн аудитад хамгийн өндөр ач холбогдолтой гэж үзсэн зүйлсийг аудитын гол онцлох зүйлс хэмээн тодотгосон болно. Бид аудитын гол онцлох зүйлсийг хууль тогтоомжоор нийтэд ил болгохыг хориглоогүй үед эсвэл маш ховор тохиолдолд тайланд тодруулахгүй байх нь тодруулснаас илүүтэйгээр олон нийтийн эрх ашигт нийцнэ гэж үзсэнээс үг онцлох зүйлсийг тайланд оруулахгүй хэмээн шийдвэр гаргаснаас бусад тохиолдолд эдгээр зүйлсийг тайландаа оруулдаг.

Энэхүү хараат бус аудиторын тайлангийн аудитын гэрээт ажлын партнер нь Жу Сан Ён, аудитын комиссийн гүйцэтгэх захирал нь Г. Соёлмаа нар болно.

КЭЙ ПИ ЭМ ЖИ АУДИТ ХХК
KPMG AUDIT LLC
Кэй Пи Эм Жи Аудит ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот
УЛААНБААТАР ХОТ
ТТ33977 ☎ 5543495

Баталгаажуулсан:

Г. Соёлмаа
Гүйцэтгэх Захирал

Баталсан:

Жу Сан Ён
Партнер

Энэхүү түсдаа тайлан нь аудитын тайлангийн өдөр буюу 2025 оны 7 дугаар сарын 7-ны өдрөөр хүчин төгөлдөр үйлчилнэ. Аудитын тайлангийн өдөр болон энэхүү тайланг хэрэглэх хугацааны хооронд тохиолдож болох аливаа тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдал нь үг түсдаа санхүүгийн тайлан болон тодруулгад материаллаг нөлөө үзүүлж болох юм. Тиймээс аудитын тайланг хэрэглэгчид нь үг тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдлын нөлөөллийг дээрх аудитын тайланд тусгаагүйг анхаарна уу. Энэхүү тайлан нь зөвхөн Компанийн хувьцаа эзэмшигчид болон төлөвлөн удирдах зөвлөлд зориулагдсан болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө үүрэг, хариуцлага хүлээхгүй болно.

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
ТТА3531 ☎ 2028488

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
1119289111 ☎ 5481589
Улаанбаатар хот

2026.08.31

ШУНХЛАЙ ХХК
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх
Түсдаа Санхүүгийн Байдлын Тайлан

(Мянган төгрөгөөр)	***Тодруулга***	**2024.12.31**	**2023.12.31**
Хөрөнгө			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	*6*	2,225,236	5,057,027
Дансны авлага	*7*	259,714,552	317,985,370
Бусад авлага	*8*	570,286	874,777
Бараа материал	*9*	57,713,825	74,403,140
Бусад хөрөнгө	*10*	10,451,479	959,529
Эргэлтийн хөрөнгө		**330,675,378**	**399,279,843**
Үндсэн хөрөнгө	*11*	30,248,930	16,824,606
Биет бус хөрөнгө	*12*	1,298,579	1,001,956
Охин компаниуд дах хөрөнгө оруулалт	*13*	1,000,000	501,000
Урт хугацаат бусад хөрөнгө	*10*	33,488,205	16,967,022
Эргэлтийн бус хөрөнгө		**66,035,714**	**35,294,584**
Нийт хөрөнгө		**396,711,092**	**434,574,427**
Өр төлбөр			
Дансны өглөг	*14*	60,457,505	79,819,166
Бусад өглөг	*15*	102,197	3,809,760
Богино хугацаат зээл	*16*	174,275,738	304,455,039
Орлогын албан татварын өглөг		1,932,184	5,999,858
Гэрээний өр төлбөр		71,851	-
Түрээсийн өр төлбөр		15,234	587,800
Богино хугацаат өр төлбөр		**236,854,709**	**394,671,623**
Урт хугацаат зээл	*16*	124,143,992	15,000,000
Хойшлогдсон татварын өглөг		14,175	9,489
Урт хугацаат өр төлбөр		**124,158,167**	**15,009,489**
Нийт өр төлбөр		**361,012,876**	**409,681,112**
Эздийн өмч			
Хувьцаат капитал	*17*	165,700	165,700
Хуримтлагдсан ашиг	*17*	35,532,516	24,727,615
Нийт эздийн өмч		**35,698,216**	**24,893,315**
Нийт өр төлбөр ба эздийн өмч		**396,711,092**	**434,574,427**

Хавсаргасан тодруулга нь энэхүү тусдаа санхүүгийн тайлангийн салшгүй бүрдэл хэсэг болно.

ШУНХЛАЙ ХХК
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Түсдаа Ашиг, Алдагдал болон Бусад Дэлгэрэнгүй Орлогын Тайлан

(Мянган төгрөгөөр)	*Тодруулга*	2024	2023
Борлуулалтын орлого	*18*	1,413,383,372	1,197,679,060
Борлуулалтын өртөг	*19*	(1,322,007,088)	(1,113,404,786)
Нийт ашиг		**91,376,284**	**84,274,274**
Борлуулалт ба түгээлтийн зардал	*20*	(2,683,880)	(3,595,008)
Удирдлагын зардал	*21*	(19,161,721)	(14,460,090)
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн (бууралт) / бүцаалт	*7*	2,900,882	(3,104,190)
Бусад орлого	*22*	144,637	28,732
Бусад зардал	*23*	(5,691,093)	(4,411,945)
Үйл ажиллагааны ашиг		**66,885,109**	**58,731,773**
Санхүүгийн орлого	*24*	37,549	282,502
Санхүүгийн зардал	*24*	(54,184,966)	(35,922,261)
Татварын өмнөх ашиг		**12,737,692**	**23,092,014**
Орлогын албан татварын зардал	*25*	(1,932,791)	(6,695,817)
Тайлант жилийн цэвэр ашиг		**10,804,901**	**16,396,197**
Бусад дэлгэрэнгүй орлого		-	-
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого		**10,804,901**	**16,396,197**

Хавсаргасан тодруулга нь энэхүү тусдаа санхүүгийн тайлангийн салшгүй бүрдэл хэсэг болно.

ШУНХЛАЙ ХХК

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дүүсгавар болсон тайлант жилийн

Түсдаа Өмчийн Өөрчлөлтийн Тайлан

(Мянган төгрөгөөр)	Хувьцаат капитал (Тодруулга 17)	Хуримтлагдсан ашиг	Нийт эздийн өмч
2023 оны 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл	165,700	8,331,418	**8,497,118**
Тайлант жилийн ашиг	-	16,396,197	**16,396,197**
2023 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	**165,700**	**24,727,615**	**24,893,315**
2024 оны 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл	165,700	24,727,615	**24,893,315**
Тайлант жилийн ашиг	-	10,804,901	**10,804,901**
2024 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	**165,700**	**35,532,516**	**35,698,216**

Хавсаргасан тодруулга нь энэхүү тусдаа санхүүгийн тайлангийн салшгүй бүрдэл хэсэг болно.

106

2026.08.31

ШУНХЛАЙ СЗХ 2026 09 10 БҮРТГЭВ № 31

МОНГОЛЫН ХӨРӨНГӨ ОГТЛОЛЫН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2026-09-02 БҮРТГЭВ-03

ШУНХЛАЙ ХХК

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн

Түсдаа Мөнгөн Гүйлгээний Тайлан

(Мянган төгрөгөөр)	*Тод-руулга*	2024	2023
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Тайлант жилийн татварын өмнөх ашиг		12,737,692	23,092,014
Тохируулгууд:			
Хүүгийн орлого	*24*	(37,549)	(239,369)
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт / (буцаалт)	*26*	(2,900,882)	3,104,190
Хүүгийн зардал	*24*	51,311,606	32,539,065
Түрээсийн өр төлбөрийн хүүгийн зардал	*24*	52,563	130,845
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн (олз) / гарз	*24*	(522,429)	408,072
Элэгдлийн зардал	*11*	1,235,338	1,112,168
Хорогдуулгын зардал	*12*	118,836	121,231
Үндсэн хөрөнгө борлуулсны олз	*23*	(23,583)	(1,531)
		61,971,592	**60,266,685**
Хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлт:			
- Дансны болон бусад авлага		61,476,191	(59,912,538)
- Бараа материал		16,689,315	(29,987,801)
- Бусад хөрөнгө		(9,491,950)	(697,688)
- Дансны болон бусад өглөг		(23,069,224)	(42,944,784)
- Гэрээний өр төлбөр		71,851	-
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		**107,647,775**	**(73,276,126)**
Төлсөн хүү		(49,568,291)	(29,473,476)
Хүлээн авсан хүү		33,794	29,781
Төлсөн орлогын албан татвар		(5,992,024)	(2,351,847)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		**52,121,254**	**(105,071,668)**
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Худалдан авсан үндсэн хөрөнгө		(29,782,702)	(18,340,764)
Худалдан авсан биет бус хөрөнгө		(415,459)	(106,493)
Үндсэн хөрөнгийн борлуулалт		157,426	371,033
Охин компани дах хөрөнгө оруулалт		(499,000)	(1,000)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		**(30,539,735)**	**(18,076,224)**
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Хүлээн авсан зээл	*16*	1,518,280,313	1,870,078,938
Гаргасан бонд	*16*	99,867,498	51,722,629
Зээлийн эргэн төлөлт	*16*	(1,591,940,482)	(1,799,130,654)
Бондын эргэн төлөлт	*16*	(50,000,000)	(7,542,923)
Төлсөн түрээсийн өр төлбөр		(625,129)	(446,561)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		**(24,417,800)**	**114,681,429**
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр бууралт		**(2,836,281)**	**(8,467,463)**
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	*6*	5,057,027	13,396,577
Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө		4,490	127,913
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	*6*	**2,225,236**	**5,057,027**

Хавсаргасан тодруулга нь энэхүү тусдаа санхүүгийн тайлангийн салшгүй бүрдэл хэсэг болно.

УЛААНБААТАР ХОТ ШУНХЛАЙ ХХК ТТА3531 ᠓ 2025468

Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital Delivering diversity 1119289111 ᠓ 5481589 Улаанбаатар хот

ШУНХЛАЙ ХХК
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Түсдаа Санхүүгийн Тайлангийн Тодруулга

1. Тайлагнагч аж ахуйн нэгж

Шунхлай ХХК (цаашид "Компани" гэх) нь хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр Монгол Улсад үүсгэн байгуулагдаж, үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээд юм. Компани 1995 оноос үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд үндсэн үйл ажиллагаагаа Улаанбаатар хотод явуулдаг. Компанийн албан ёсны хаяг нь Монгол Улс, Улаанбаатар хот 17040, Хан-Уул дүүрэг, Капитал Хаус болно. 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр Компанийн цор ганц хувь нийлүүлэгч бөгөөд эцсийн шатны толгой компани нь Шунхлай Холдинг ХХК (100%) юм.

Компанийн үндсэн үйл ажиллагаа нь өөрийн охин компаниуд болон зэргэлдээ охин компаниудын өмнөөс ОХУ, БНХАУ-аас шатахуун, нефтийн бүтээгдэхүүн импортлох, тэдэнд шатахуун, нефтийн бүтээгдэхүүн борлуулах юм.

Компанийн охин компаниудын талаарх мэдээллийг Тодруулга 13-с харна уу.

2. Санхүүгийн тайлагналын зарчим

(а) Тайлагналын нийцэл

Энэхүү түсдаа санхүүгийн тайланг СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартууд ("СТОУС")-ын дагуу бэлтгэсэн. Компанийн удирдлага түсдаа санхүүгийн тайланг 2025 оны 7 дугаар сарын 07-ны өдөр зөвшөөрч батлав.

Тайлант жилийн толилуулгатай нийцүүлэх зорилгоор тодорхой харьцуулагдах дүнг дахин ангилсан.

(б) Үнэлгээний суурь

Энэхүү түсдаа санхүүгийн тайланг, холбогдох тодруулгад тусгайлан зааснаас бусад зүйсийн хувьд түүхэн өртгийн зарчимд үндэслэн бэлтгэсэн.

(в) Тасралтгүй үйл ажиллагаа

Түсдаа санхүүгийн тайланг удирдлагын зохистой гэж үзсэний дагуу тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэсэн.

(г) Бүртгэлийн болон толилуулгын валют

Энэхүү түсдаа санхүүгийн тайланг бэлтгэж, тайлагнахдаа Компанийн бүртгэлийн валют бөгөөд Компанийн үйл ажиллагаа эрхэлж буй эдийн засгийн орчны үндсэн валют болох Монгол Улсын мөнгөн тэмдэгт Төгрөгөөр илэрхийлсэн. Түсгайлсан хэсэгт онцлон зааснаас бусдаар түсдаа санхүүгийн тайланг мянгачилж толилуулсан.

(д) Таамаглал, тооцоолол ба үнэлгээг хэрэглэх нь

Түсдаа санхүүгийн тайланг СТОУС-д нийцүүлэн бэлтгэх үйл явц нь таамаглал, тооцоолол, үнэлгээ хэрэглэхийг удирдлагаас шаарддаг ба энэхүү таамаглал, тооцоолол, үнэлгээ нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт, мөн хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын зүйлсийн дүнг тодорхойлоход нөлөөлдөг. Гүйцэтгэлээрх үр дүн нь эдгээр тооцооллоос зөрүүтэй байж болно.

Тооцоолол болон холбогдох таамаглалуудыг тогтмол хянадаг. Нягтлан бодох бүртгэлийн тооцоололд хийсэн өөрчлөлтийн нөлөөллийг тухайн өөрчлөлт хийгдсэн тайлант жил болон ирээдүйд нөлөөлсөн аливаа тайлант жилүүдэд тусгадаг.

108

2026.08.31

ШУНХЛАЙ ХХК
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Тусдаа Санхүүгийн Тайлангийн Тодруулга

2. Санхүүгийн тайлагналын зарчим, үргэлжлэл

(д) Таамаглал, тооцоолол ба үнэлгээг хэрэглэх нь, үргэлжлэл

Санхүүгийн тайланд мэдэгдэхүйц нөлөө бүхий нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд хэрэглэсэн таамаглал, тооцоолол, үнэлэмжийн талаарх мэдээлэл болон дараагийн тайлант үед хамаарах материаллаг залруулгын нөлөө бүхий эрсдэлийн үндэслэл болон тооцооллын талаарх мэдээллийг доорх тодруулгуудад тусгасан:

- Тодруулга 7 – Дансны авлагын үнэ цэнийн бууралтын нөөц;
- Тодруулга 11 – Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа;

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд

Доор хураангуйлсан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудыг энэхүү түсдаа санхүүгийн тайланд толилуулсан бүх тайлант жилүүдэд тусгайлан зааснаас бусдаар тууштай хэрэглэсэн болно.

(а) Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээ

Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг түхайн ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлсийг тайлагналын өдрийн хаалтын ханшаар төгрөгт хөрвүүлж илэрхийлдэг. Хөрвүүлэлтээс үүссэн ханшийн зөрүүний олз, гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн ба түүхэн өртгөөр бүртгэгдсэн мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрийг үг хөрөнгө, өр төлбөрийг анх бүртгэсэн өдрийн ханшаар төгрөгт хөрвүүлдэг.

(б) Санхүүгийн хэрэглүүр

Компани үүсмэл бус санхүүгийн хөрөнгийг дараах ангиллын дагуу ангилдаг. Үүнд: хорогдуулсан өртгөөр хэмжсэн; бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнэ (БДОБҮЦ) болон ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр (ААБҮЦ) хэмжсэн санхүүгийн хөрөнгө зэрэг багтана. Компани үүсмэл бус санхүүгийн өр төлбөрийг хорогдуулсан өртгөөр хэмжсэн болон ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн өр төлбөр гэж ангилдаг.

(i) Үүсмэл бус санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр – хүлээн зөвшөөрөлт ба үл хүлээн зөвшөөрөлт

Компани дансны авлага болон өрийн үнэт цаасыг анх үүссэн өдөр нь хүлээн зөвшөөрнө. Бусад бүх санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг анх гэрээний нөхцөл Компанид хамааралтай болох тэр үед хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн хөрөнгийн мөнгөн гүйлгээнд хамаарах гэрээний эрхийн хүчинтэй хугацаа дууссан эсвэл үг санхүүгийн хөрөнгийн мөнгөн гүйлгээг хүлээн авах гэрээний эрхийг шилжүүлсэн бөгөөд санхүүгийн хөрөнгийн эзэмшилтэй холбоотой бүх эрсдэл, өгөөжийг бараг бүгдийг нь шилжүүлсэн эсвэл шилжүүлээгүй бөгөөд эрсдэл, өгөөжийг хадгалаагүй бөгөөд хяналтыг авч үлдээгүй бол үг санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрдөг.

Компани нь санхүүгийн өр төлбөрийг гэрээнд тодорхойлсон үүрэг хариуцлага дуусгавар болсон, цуцлагдсан эсвэл хугацаа дуусгавар болсон үед санхүүгийн байдлын тайланд үл хүлээн зөвшөөрдөг. Компани нь санхүүгийн өр төлбөрийн нөхцөл өөрчлөгдөж, өөрчлөгдсөн өр төлбөрийн мөнгөн урсгал материаллаг хэмжээнд ялгаатай бөгөөд өөрчлөгдсөн нөхцөлд үндэслэн шинэ санхүүгийн өр төлбөрийг бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрсөн тохиолдолд өмнөх санхүүгийн өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрдөг.

ШУНХЛАЙ ХХК
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Түсдаа Санхүүгийн Тайлангийн Тодруулга

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд, үргэлжлэл

(б) Санхүүгийн хэрэглүүр, үргэлжлэл

(i) Үүсмэл бус санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр – хүлээн зөвшөөрөлт ба үл хүлээн зөвшөөрөлт, үргэлжлэл

Санхүүгийн өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрөх үед, дансны үнэ ба төлсөн төлбөр (үүнд шилжүүлсэн мөнгөн бус хөрөнгө эсвэл таамагласан өр төлбөр багтана)-ийн зөрүүг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

(ii) Үүсмэл бус санхүүгийн өр төлбөр

Компани үүсмэл бус санхүүгийн өр төлбөрийг хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн өр төлбөр, эсвэл ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн өр төлбөр гэж ангилдаг. Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн өр төлбөр гэдэгт арилжаалах зориулалтаар эзэмших нөхцөлийг хангасан эсвэл анх хүлээн зөвшөөрөх үед үг өр төлбөрийг ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр нь тодорхойлсон байвал энэ ангиллын санхүүгийн өр төлбөрт хамааруулна. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн өр төлбөр нь бодит үнэ цэнээрээ хэмжигдэх бөгөөд гарсан аливаа өөрчлөлтийг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн өр төлбөрөөс бусад үүсмэл бус санхүүгийн өр төлбөрийг бусад санхүүгийн өр төлбөрийн ангилалд хамааруулдаг. Анхны хүлээн зөвшөөрөлтийн өдөр бусад санхүүгийн өр төлбөрийг хорогдуулсан өртгөөр хэмждэг ба анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа үед бусад санхүүгийн өр төлбөрийг үр ашигт хүүгийн аргаар хорогдуулсан өртгөөр хэмждэг. Хүүгийн зардал, гадаад валютын ханшийн зөрүүгийн олз, гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Бусад цэвэр олз, гарзыг мөн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

(iii) Санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг цэвэр дүнгээр тусгах нь

Компани хүлээн зөвшөөрөгдсөн дүнг хооронд нь хааж, цэвэр дүнгээр тусгах, хууль, эрх зүйн үндэслэлтэй эсэх, мөн цэвэр дүнгээр нь төлбөр хийх эсвэл нэгэн зэрэг хөрөнгийг борлуулах, өр төлбөрийг барагдуулах зорилготой үед санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хааж санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр нь тусгадаг.

(в) Үнэ цэнийн бууралт

(i) Үүсмэл бус санхүүгийн хөрөнгө

Компани хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын санг (i) хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө, (ii) БДОБҮЦ-ээр хэмжсэн өрийн хөрөнгө оруулалт (iii) гэрээний хөрөнгийн хувьд хүлээн зөвшөөрдөг.

Компани алдагдлын санг 12 сарын хугацаанд хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын сангаар хэмжсэн дараахаас бусад хөрөнгийн хувьд үг хөрөнгийн эзэмших эрх дуусах хүртэлх хугацаанд хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын санг хэмждэг. Үүнд:

- Тайлангийн өдрөөр хүлээгдэж буй эрсдэлийг бага гэж тодорхойлсон өрийн үнэт цаас; болон
- Анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш түхайн хөрөнгийн эрсдэлд мэдэгдэхүйц өсөлт үүсээгүй бусад өрийн үнэт цаас болон банкны үлдэгдэл

Анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш тухайн санхүүгийн хөрөнгийн эрсдэлд мэдэгдэхүйц өсөлт үүссэн эсэх-ийг тодорхойлж, хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын санг тооцохын тулд Компани нь холбоотой бөгөөд аливаа нэмэлт зардал эсвэл хүчин чармайлт гаргахгүйгээр олж авах боломж бүхий үндэслэлтэй бөгөөд нотлогдохүйц мэдээллүүдийг харгалзан үздэг. Үүнд Компанийн түүхэн мэдээлэлд үндэслэн чанарын болон тоон үзүүлэлтэд шинжилгээ хийх, мэдээлсэн эрсдэлийн үнэлгээ болон ирээдүйн тоон мэдээлэл багтана.

ШУНХЛАЙ ХХК
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Түсдаа Санхүүгийн Тайлангийн Тодруулга

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд, үргэлжлэл

(в) Үнэ цэнийн бууралт, үргэлжлэл

(i) Үүсмэл бус санхүүгийн хөрөнгө, үргэлжлэл

Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн алдагдлын санг тухайн хөрөнгийн нийт дансны үнээс хасна. БДОБҮЦ-шээр хэмжсэн өрийн үнэт цаасын хувьд алдагдлын санг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрч, санхүүгийн байдлын тайлан дах санхүүгийн хөрөнгийн дансны үнийг бууруулахгүй.

Компани авлагын үнэ цэнийн бууралтын талаарх боломжтой түүхэн мэдээлэл, үйл ажиллагаа явуулж бүй бүс нутаг болон салбарын мэдээлэл, ирээдүйг чиглэсэн хүчин зүйлсээр тохируулсан түүхэн авлага цуглуулалтын түвшин зэргийг харгалзан үзэж авлагын үнэ цэнийн бууралтыг тооцолоход матрицын аргачлалыг ашигладаг. Үнэ цэнийн бууралтын нөөцийг өөр өөр хувь ашигласан хугацаа хэтрэлтийн өдрүүдэд үндэслэн тооцно. Шаардлагатай тохиолдолд тодорхой харилцагчдын тусгайлсан нөхцөл байдлыг харгалзан үзэж нөөцийн санд тохируулга хийдэг.

Компанийн санхүүгийн хөрөнгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн нөхөх хангалттай хүлээлт байхгүй тохиолдолд санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнийг данснаас хасна. Данснаас хассан санхүүгийн хөрөнгө нь Компанийн эргэн төлөгдөх хугацаа нь болсон хөрөнгийг эргэн төлүүлэхтэй холбоотой гүйцэтгэдэг горимын дагуу албадлагын ажиллагааг хийх боломжтой.

(ii) Санхүүгийн бус хөрөнгө

Бараа материал болон хойшлогдсон татварын хөрөнгөөс бусад санхүүгийн бус хөрөнгүүдийн дансны үнэд хөрөнгийн үнэ цэнэ буурч болзошгүй болохыг илтгэх шинж тэмдэг байгаа эсэхийг тайлант үе бүрийн эцэст үнэлдэг. Хэрэв ийм шинж тэмдэг илэрвэл хөрөнгийн нөхөгдөх дүнг тооцоолдог.

Компани бие даасан хөрөнгийн нөхөгдөх дүнг тооцдог ба хэрэв хөрөнгийн бие даасан нөхөгдөх дүнг тооцоолох боломжгүй бол Компани хөрөнгөтэй хамааралтай мөнгөн хөрөнгө бий болгогч нэгжийн нөхөгдөх дүнг тодорхойлдог. Мөнгөн хөрөнгө бий болгогч нэгж гэдэг нь бусад хөрөнгө буюу хөрөнгийн бүлгээс орох мөнгөн орлогын урсгалаас ихээхэн хамааралтай мөнгөн орлогыг үүсгэдэг хөрөнгийн тодорхойлж болох хамгийн бага бүлэг юм.

Мөнгөн хөрөнгө бий болгогч нэгжийн хувьд нөхөгдөх дүн нь мөнгөн хөрөнгө бий болгогч нэгжийн борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнэ болон ашиглалтын үнэ цэнийн аль их нь байдаг. Ашиглалтын үнэ цэнийг тооцохдоо хөрөнгийн хувьд онцлог эрсдэл болон мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн одоогийн зах зээлийн үнэлгээг тусгасан татварын өмнөх хувь хэмжээг ашиглан хөрөнгийг тасралтгүй ашигласнаас болон ашиглагдахаар тооцсон хугацааны эцэст данснаас хасах үед үүсэхээр хүлээгдэж бүй тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнээр хэмждэг.

Үнэ цэнийн бууралтын гарзыг хөрөнгө эсвэл мөнгөн хөрөнгө бий болгогч нэгжийн дансны үнэ нь нөхөгдөх дүнгээс хэтэрсэн үед хүлээн зөвшөөрдөг. Үнэ цэнийн бууралтын гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг. Нөхөгдөх дүнг тодорхойлоход хийгдсэн тооцоололд өөрчлөлт орсон бол үнэ цэнийн бууралтын гарзыг бүцаана. Үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд хөрөнгийн байх байсан дансны үнээс элэгдэл, хорогдлыг хассан цэвэр дүнгээс хэтрэхгүй хэмжээгээр бүцаана.

(г) Бараа материал

Бараа материалын өртгийг жигнэсэн дундаж өртгийн аргаар тодорхойлдог ба бараа материалын өртөгт худалдан авалтын өртөг, хувиргалтын зардал болон одоогийн байршил ба нөхцөлд бараа материалыг авчрахтай холбогдож гарсан зардал багтдаг. Үйлдвэрлэсэн бараа материал, дүүсаагүй үйлдвэрлэлийн өртөгт хэвийн хүчин чадлаар ажиллах үеийн үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлын зохих хэсгийг хуваарилдаг.

111

2026.08.31

СЭХ ШУНХЛАЙ 2026 оны 09 сар 10 өдөр БҮРТГЭВ № 01

2026 -09- 02 БҮРТГЭВ-03

ШУНХЛАЙ ХХК
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Түсдаа Санхүүгийн Тайлангийн Тодруулга

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд, үргэлжлэл

(г) Бараа материал, үргэлжлэл

Бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар хэмждэг. Цэвэр боломжит үнэ цэнэ гэж бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад борлуулахаар тооцсон үнээс түүнийг иж бүрдэл болгохоор тооцсон зардал ба борлуулахад шаардагдах тооцсон зардлыг хассан дүн юм. Бараа материалын өртгийг цэвэр боломжит үнэ цэнэ хүртэл бууруулсан дүн болон бараа материалын аливаа алдагдлыг тухайн тайлант хугацаанд нь зардлаар хүлээн зөвшөөрдөг. Цэвэр боломжит үнэ цэнийн өсөлтөөс үүссэн бараа материалын бууралтын аливаа буцаалт нь тухайн буцаалт хийгдсэн тайлант хугацаанд зардал хэмээн хүлээн зөвшөөрч бүртгэсэн бараа материалын дүнгийн бууралтаар хүлээн зөвшөөрөгддөг.

(д) Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг анх өртгөөр нь илэрхийлэх ба анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа үндсэн хөрөнгийг түүний өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр тайлагнадаг. Үндсэн хөрөнгийн өртөгт тухайн хөрөнгийг худалдан авах, барьж байгуулахтай шууд холбогдон гарсан зардал, мөн удирдлагын зорилгоор үйл ажиллагаа явуулахад бэлэн болгож түүнийг байршуулах болон шаардлагатай нөхцөлийг хангахтай холбогдон гарсан бусад зардлууд, мөн тухайн хөрөнгийг задлах, зайлуулах болон байрлаж байсан талбайг нь сэргээн засварлахад гарах зардлуудыг хамааруулна.

Үндсэн хөрөнгийн мэдэгдэхүйц хэсэг нь тусдаа ашиглалтын хугацаатай бол тусдаа ангиллаар үндсэн хөрөнгийн дансанд бүртгэнэ.

Компани нь дараа үеийн зардлаас эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг хүртэх магадлалтай бөгөөд тухайн зардлыг үнэн зөв хэмжих боломжтой болсон үед түүнийг үндсэн хөрөнгийн дансны үнэ дээр нэмэгдүүлэх буюу эсвэл тусдаа хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Солигдсон эд ангийн дансны үнээр хөрөнгийн дансны үнийг бууруулна. Өдөр тутмын үйлчилгээний зардлыг тухайн зардал гарсан тайлант үеийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг түүний ирээдүйд авчрах эдийн засгийн үр өгөөжөөс нь хамаарч ашиглах хугацаанд шулуун шугамын аргаар тооцон байгуулдаг. Үндсэн хөрөнгийн нийт өртгийн дүнд багтсан гол бүрэлдэхүүн хэсгийн ашиглах хугацаа ялгаатай байгаа тохиолдолд тэдгээрт тусад нь элэгдэл байгуулдаг.

Үндсэн хөрөнгийг ашиглахаар тогтоосон хугацаа дараах байдалтай байна:

	Ашиглалтын жил
Барилга	40
Тавилга, эд хогшил	10
Тоног төхөөрөмж	10
Тээврийн хэрэгсэл	10
Компьютер болон дагалдах хэрэгсэл	3-10

Үндсэн хөрөнгийн дансны үнэ болон данснаас хассан цэвэр орлогын зөрүүгээр үндсэн хөрөнгийг данснаас хассаны олз, гарзыг тухайн жилийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

Элэгдэл тооцох арга, ашиглалтын жил болон үлдэх өртгийг санхүүгийн жил бүр хянаж үздэг ба шаардлагатай бол залруулдаг. Өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтөөр тайлагнадаг.

УЛААНБААТАР ХОТ ШУНХЛАЙ ХХК ТЕЛ: 3531 9, 2028468

Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital Delivering diversity 1119289111 Улаанбаатар хот

ШУНХЛАЙ
2026 .09. 10 өдөр
БҮРТГЭВ
№ 21

2026 -09- 02
БҮРТГЭВ-03

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд, үргэлжлэл

(е) Биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрч бүртгэх ба анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа түүний өртгөөс нь хуримтлагдсан хорогдуулга ба үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр бүртгэнэ.

Биет бус хөрөнгийн хорогдуулгыг тэдгээрийг ашиглах боломжтой болсон өдрөөс эхлэн ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргаар тооцдог. Биет бус хөрөнгийн үлдэх өртөг тэг байна.

	Ашиглалтын жил
Программ хангамж	3-5

Тодорхой ашиглагдах жил бүхий биет бус хөрөнгийн хорогдуулга тооцох арга, ашиглалтын жилийг санхүүгийн жил бүр хянаж үздэг. Хорогдуулга тооцдоггүй биет бус хөрөнгийн ашиглагдах жилийн хувьд тэдгээр хөрөнгийн тодорхой бус ашиглалтын жилийн үнэлгээг цаашид нотлох аливаа үйл явдал, нөхцөл байдал байгаа эсэхийг тодорхойлохын тулд санхүүгийн жил бүр хянаж үздэг. Өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтөөр тайлагнадаг.

Компани нь дараа үеийн зардлаас эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг хуртэх магадлалтай үед зардлыг капиталжуулдаг. Дотоодод бий болсон гүүдвилл болон брэндийн зардлыг хамруулсан бусад бүхий л зардлыг гарсан тухайн үед нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

(ё) Ажилчдын тэтгэвэр, тэтгэмж

(i) Ажилчдын богино хугацаат тэтгэмж

Холбогдох үйлчилгээ үзүүлсэн үед ажилчдын богино хугацаат тэтгэмжийг зардлаар бүртгэдэг. Компани нь ажилтны үзүүлсэн үйлчилгээний дагуу Компанид үүрэг хариуцлага үүссэнээс найдвартайгаар тооцоолж болох Компанийн төлөх ёстой дүнгээр өр төлбөрөө хүлээн зөвшөөрдөг.

(ii) Улсад төлөх тэтгэвэр, тэтгэмжийн төлөвлөгөө

Ажилчдын тэтгэвэр, тэтгэмж нь Монгол Улсын Нийгмийн Даатгалын Сан төвлөрүүлэх хуулиар тогтоосон нийгмийн даатгалын шимтгэлээс бүрдэнэ. Тэтгэвэр, тэтгэмжийн хөтөлбөрт төвлөрүүлэх шимтгэлийг түүнийг төлөх үүрэг хүлээсэн тайлант үеийн ажилчдын зардлаар бүртгэдэг.

(ж) Нөөц

Компани өнгөрсөн үйл явдлын үр дүнд өнөөгийн хуулиар хүлээсэн эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн, уг үүрэг хариуцлагын төлбөрийг барагдуулахад эдийн засгийн өгөөж бүхий нөөц шаардлагатай гэдэг нь тодорхой болсон ба үүрэг хариуцлагын дүнг найдвартай тооцоолох боломжтой болсон үед нөөцийг хүлээн зөвшөөрдөг.

Нөөцийн хамгийн сайн тооцооллыг хийхийн тулд үйл явдал, нөхцөл байдлын хүрээлэн байгаа эрсдэл, тодорхойгүй байдал зэргийг тус тус харгалзаж үзэх ёстой. Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ нь материаллаг нөлөөтэй бол нөөцийн дүн нь ирээдүйд хүлээгдэж буй мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ байдаг.

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
ТТА3531 ш. 2028488

113

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
1119289111 ☎ 5481589
Улаанбаатар хот

2026.08.31

ШУНХЛАЙ ХХК
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Түсдаа Санхүүгийн Тайлангийн Тодруулга

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд, үргэлжлэл

(ж) Нөөц, үргэлжлэл

Нөөцийн төлбөрийг барагдуулахад шаардагдах зарлагыг бүхэлд нь эсвэл зарим хэсгийг нь өөр нэг талаас нөхөн авахаар хүлээгдэж байгаа үед, хэрэв Компани үүрэг хариуцлагынхаа дагуу төлбөрийг барагдуулсан үед нөхөн олговор хүлээн авах нь тодорхой байх нөхцөлд л зөвхөн нөхөн олговрыг хүлээн зөвшөөрөх ёстой. Нөхөн олговрыг тусад нь хөрөнгө гэж үздэг.

Нөөцийн дүнг тайлангийн хугацааны эцэс бүрт давтан шалгаж, тайлангийн үеийн хамгийн сайн тооцооллыг тусгахын тулд тохируулж байдаг. Хэрэв үүрэг хариуцлагын төлбөрийг барагдуулахад шаардагдах эдийн засгийн өгөөж бүхий нөөцийн гадагшлах урсгал нь магадлал багатай бол нөөцийн дүнг бүцаадаг.

(з) Хувьцаат капитал

Энгийн хувьцаа нь эздийн өмчийн хэсэгт ангилагддаг. Энгийн хувьцаа болон хувьцааны опцион (худалдан авах эрх) гаргахад шууд холбогдон гарах өсөн нэмэгдэх зардлыг аливаа татварын нөлөөллөөс цэвэр дүнгээр өмчийн дүнгээс бууран байдлаар хүлээн зөвшөөрдөг.

(и) Орлого

Орлого нь нефтийн бүтээгдэхүүний бөөний борлуулалт болон холбоотой түлшний компаниудад үзүүлэх менежментийн үйлчилгээний төлбөрөөс бүрддэг.

(i) Нефтийн бүтээгдэхүүний бөөний борлуулалт

Хэрэглэгчийн худалдан авалтын нөхцөлийг тодорхойлсон бөөний борлуулалтын гол баримт бичиг нь Худалдах, худалдан авах гэрээ юм. Борлуулалтын орлого нь нефтийн бүтээгдэхүүний борлуулалтаас хөнгөлөлтийг хассан дүнгээс бүрдэнэ. Худалдах, худалдан авах гэрээгээр үүсэх гүйцэтгэлийн үүргийг хэрэглэгчид барааны хяналт шилжсэн үед хүлээн зөвшөөрдөг ба энэ нь худалдан авагчид хяналт шилжихтэй давхацдаг. Орлогыг гэрээнд тохиролцсон гүйлгээний үнэ эсвэл тооцоолсон үнийн дагуу хэмжинэ. Бүтээгдэхүүний хүргэлт хийгдсэн үед харилцагчид нэхэмжлэх илгээнэ.

Худалдах, худалдан авах гэрээ болон холбогдох захиалгын хуудаснууд нь хууль ёсны дагуу хэрэгждэг ба СТОУС 15-ын дагуу гэрээний бүх шалгуурыг хангасан байдаг.

Борлуулалтын үнэ нь Компани бүтээгдэхүүнийг хэрэглэгчид шилжүүлсний үр дүнд хүлээн авахаар хүлээгдэж буй хөнгөлөлт ба бүцаалтын дараах цэвэр үнийг хэлнэ. Хэрэглэгчид барааны хяналт шилжих үед гүйцэтгэлийн үүрэг хангагдсанаар Компани борлуулалтыг хүлээн зөвшөөрдөг. Хэрэглэгч барааны хяналтыг авах үед Компани барааг шилжүүлдэг бөгөөд энэ нь барааны эрсдэл болон өгөөж шилжихтэй давхацдаг. Тиймээс барааны хяналт хэрэглэгчид шилжих үед Компани борлуулалтыг хүлээн зөвшөөрдөг.

(ii) Менежментийн үйлчилгээ

Менежментийн үйлчилгээг зохицуулдаг мөн гүйцэтгэлийн үүргийг тогтоодог гол баримт бичиг нь Үйлчилгээний гэрээ юм. Орлого нь холбоотой талууд болох шатахууны Компаниудад үзүүлсэн менежментийн үйлчилгээний төлбөрөөр илэрхийлэгдэнэ. Үйлчилгээг гүйцэтгэлийн үүргийг биелүүлсэн үед хүлээн зөвшөөрдөг бөгөөд үйлчилгээний гэрээнд тохиролцсон гүйлгээний үнийн дагуу хэмжинэ. Менежментийн үйлчилгээ авч буй холбоотой талуудад сар бүр нэхэмжлэх илгээнэ.

Холбоотой талуудад үйлчилгээг үзүүлсэн үед гүйцэтгэлийн үүрэг хангагдсанаар Компани орлогыг хүлээн зөвшөөрдөг. Холбоотой талууд үйлчилгээний үр дүнгийн хяналтыг авах үед Компани үйлчилгээг тэдэнд үзүүлсэнд тооцно.

ШУНХЛАЙ ХХК
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Тусдаа Санхүүгийн Тайлангийн Тодруулга

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд, үргэлжлэл

(и) Орлого, үргэлжлэл

(iii) Компани агент үүрэг гүйцэтгэх нь

Хэрэв Компани нь агентын үүрэг гүйцэтгэгч бол гүйцэтгэлийн үүрэг нь тодорхой бараа, үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах юм. Тиймээс орлогоо хүлээн зөвшөөрөхдөө өөрийн авахаар хүлээгдэж буй аливаа төлбөр, шимтгэлд харгалзах цэвэр дүнгээр илэрхийлэгдэнэ. Компанийн хүлээн авах төлбөр эсвэл шимтгэл нь бусад талуудад төлбөр хийсний дараа Компанид хадгалагдах цэвэр төлбөрийн дүн байж болно. Компани нь тухайн бараа, үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах үүргээ биелүүлсний дараа орлогоо хүлээн зөвшөөрдөг.

(й) Санхүүгийн орлого ба санхүүгийн зардал

Санхүүгийн орлого нь хүүгийн орлого ба ногдол ашгийн орлогоос бүрддэг. Хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргыг ашиглан ашиг, алдагдлаар хуримтлүүлан хүлээн зөвшөөрдөг. Ногдол ашгийн орлогыг Компанид ногдол ашиг хүлээн авах эрх үүссэн үед нь хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Санхүүгийн зардал нь зээлийн хүүгийн зардлаас бүрддэг. Хөрөнгө худалдан авах, бүтээн босгох болон бэлтгэл шаардагдах хөрөнгийг бий болгоход гарсан шууд ногдох зардалд ордоггүй зээлийн хүүгийн зардлуудыг үр ашигт хүүгийн аргыг ашиглан ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

Гадаад валютын ханшийн зөрүүний олз, гарзыг цэвэр дүнгээр нь санхүүгийн орлого эсвэл санхүүгийн зардлын аль нэгэнд нь тухайн гадаад валютын хөдөлгөөний олз, гарзад нөлөөлөх цэвэр үр дүнд нь тулгуурлан тайлагнадаг.

(к) Орлогын татвар

Орлогын татварын зардал нь тайлант үеийн татвар болон хойшлогдсон татвараас бүрддэг. Орлогын татварын зардлыг өмчийн дансанд шууд хүлээн зөвшөөрдөг зүйлстэй холбоотойгоос бусад тохиолдолд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

(i) Тайлант үеийн татвар

Тайлант үеийн татвар гэдэг нь өмнөх жилүүдийн татварын өрийн тохируулга болон тайлант үеийн эцэст хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан эсвэл мөрдөгдөж байгаа татварын хувь хэмжээг ашиглан тухайн жилийн татвар ногдох ашиг, татварын алдагдалд суурилан хүлээгдэж буй татварын өр эсвэл авлага юм. Татвар ногдох ашгийг тооцохдоо ирээдүйн тайлант үеийн татвар ногдох ашиг (татварын алдагдал)-ийг тодорхойлоход хэрэглэгдэх татвар ногдох орлого эсвэл татвараас хасагдах зардлаар тооцогдох түр зөрүү, мөн нягтлан бодох бүртгэлийн ашгийн татвар ногдохгүй орлого, татвараас хасагдахгүй зардал зэргийг харгалзан үздэггүй учраас татвар ногдох ашиг нь нягтлан бодох бүртгэлийн ашгаас ялгаатай байдаг.

(ii) Хойшлогдсон татвар

Хойшлогдсон татварыг хөрөнгө-өр төлбөрийн аргыг ашиглан хүлээн зөвшөөрч бүртгэдэг бөгөөд энэ арга нь санхүүгийн тайлангийн зорилгоор хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ болон татварын зорилгоор ашиглагдах дүн хоёрын хоорондох түр зөрүүн дээр үндэслэдэг арга юм. Бүх татвар ногдох түр зөрүүнд хойшлогдсон татварын өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөг.

Гэвч дараах түр зөрүүнүүдэд хойшлогдсон татварыг хүлээн зөвшөөрдөггүй. Үүнд гүүдвиллийн анхдагч хүлээн зөвшөөрөлт, эсвэл бизнесийн нэгдэл биш бөгөөд ажил гүйлгээ гарах үед нягтлан бодох бүртгэлийн ашиг болон татвар ногдох ашиг, татварын алдагдлын аль алинд нөлөөлөхгүй ажил гүйлгээн дэх хөрөнгө буюу өр төлбөрийн анхдагч хүлээн зөвшөөрөлт.

ШУНХЛАЙ ХХК
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Түсдаа Санхүүгийн Тайлангийн Тодруулга

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд, үргэлжлэл

(к) Орлогын татвар, үргэлжлэл

(ii) Хойшлогдсон татвар, үргэлжлэл

Хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг тайлант хугацааны эцэс бүрт дахин хянаж үздэг ба хойшлогдсон татварын хөрөнгийн бүх эсвэл зарим өгөөжийг хүртэх хангалттай хэмжээний татвар ногдох ашиг олох магадлал үгүй болох үед Компани хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг бууруулдаг.

Тайлант үеийн эцэст хүчин төгөлдөр болсон эсвэл хүчин төгөлдөр мөрдөж байгаа татварын хувь хэмжээ (татварын хууль)-нд үндэслэн хөрөнгө нь хэрэгжих буюу өр төлбөрийг төлөх тайлант үед мөрдөгдөхөөр хүлээгдэж буй татварын хувь хэмжээгээр хойшлогдсон татварын хөрөнгө болон өр төлбөрийг хэмждэг. Тайлант үеийн эцэст Компани нь хойшлогдсон татварын өр төлбөр болон хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг нөхөх буюу барагдуулах арга хэлбэрээс үүсэж байгаа татварын үр нөлөөг хойшлогдсон татварын өр төлбөр болон хойшлогдсон татварын хөрөнгийн хэмжилтэд тусгадаг.

Компани нь тайлант үеийн татварын өр төлбөрийг тайлант үеийн татварын хөрөнгөөр суутган тооцох хууль ёсны хүчин төгөлдөр эрхтэй байх, орлогын татвараар тооцоо хийдэг ижил татварын албатай харьцдаг ба тайлант үеийн татварын өр төлбөр болон хөрөнгийг цэвэр сууриар барагдуулахаар төлөвлөсөн тохиолдолд хойшлогдсон татварын өр төлбөр болон хөрөнгийг цэвэр дүнгээр тооцдог.

(л) Түрээс

Гэрээг анх байгуулах үед Компани нь тухайн гэрээ нь түрээсийн гэрээ юу эсвэл түрээс агуулсан гэрээ юу гэдгийг үнэлдэг. Хэрэв гэрээ нь тодорхой төлбөр хүлээн авснаар тухайлсан хөрөнгийн хэрэглээг тодорхой хугацаанд хянах эрхийг олгож байвал тухайн гэрээ нь түрээсийн гэрээ эсвэл түрээсийг агуулсан гэрээ гэж үзнэ. СТОУС 16-ын дагуу түрээсийг 'тодорхой хугацаанд хөрөнгө ашиглах эрхээ төлбөрийн солилцоогоор шилжүүлэх гэрээ эсвэл гэрээний нэг хэсэг' гэж тодорхойлсон.

Түрээсийн бүрэлдэхүүнийг агуулсан гэрээг эхлэх эсвэл өөрчлөх үед Компани гэрээнд тусгасан үнийг үндэслэн түрээсийн бүрэлдэхүүн хэсэг бүрт хуваарилдаг. Оффисын түрээсийн хувьд Компани нь түрээсийн бус бүрэлдэхүүн хэсгүүдийг салгаагүй ба түрээсийн болон түрээсийн бус бүрэлдэхүүн хэсгүүдийг нэг бүрэлдэхүүн хэсэг гэж бүртгэдэг.

Компани нь түрээс эхлэх өдөр ашиглах эрхтэй хөрөнгө болон түрээсийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөг. Ашиглах эрхтэй хөрөнгийг анх өртгөөр нь хэмжих бөгөөд үүнийг түрээсийн эхний өдөр болон түүнээс өмнө хийсэн түрээсийн төлбөрөөр тохируулсан түрээсийн өр төлбөрийн анхны дүн, аливаа анхдагч шууд зардлууд болон хөрөнгийг салгаж бүулгах, сэргээн засварлахад түрээслэгчээс гарах аливаа тооцоолсон болон түрээсийн урамшууллыг хассан дүнгээр илэрхийлдэг.

Ашиглах эрхтэй хөрөнгийг гэрээ эхэлсэн өдрөөс дуусах өдөр хүртэл шулуун шугамын аргаар элэгдүүлнэ. Мөн ашиглах эрхтэй хөрөнгийг цаашид үнэ цэнийн бууралт байгаа тохиолдолд тайлант хугацаанд бууруулж бүртгэх ба түрээсийн өр төлбөрийн дахин хэмжилтээс шалтгаалан тохируулагдана.

Түрээсийн өр төлбөрийг анх хэмжихдээ түрээсийн эхний өдрөөрх төлөгдөөгүй түрээсийн төлбөрүүдийг түрээст агуулагдсан нуугдмал хүүгийн хувь хэмжээ эсвэл уг хувь хэмжээг тодорхойлох боломжгүй бол Компанийн өсөн нэмэгдэх зээлийн хүүгийн хувь хэмжээг ашиглан дискаунталсан өнөөгийн үнэ цэнээр хэмжинэ.

ШУНХЛАЙ ХХК
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Түсдаа Санхүүгийн Тайлангийн Тодруулга

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд, үргэлжлэл

(л) Түрээс, үргэлжлэл

Компани нь өсөн нэмэгдэх зээлийн хүүгийн хувь хэмжээг хэд хэдэн хөндлөнгийн санхүүгийн эх үүсвэрээс хүүгийн хувь хэмжээг авах замаар тодорхойлдог бөгөөд түрээсийн нөхцөл, түрээсэлсэн хөрөнгийн төрлийг илэрхийлэх тодорхой тохируулгуудыг хийдэг.

Түрээсийн өр төлбөрийн хэмжилтэд багтсан түрээсийн төлбөрт дараах зүйлүүд багтана:

- тогтмол төлбөр (мөн чанарын хувьд тогтмол төлбөр хамаарна);
- индекс эсвэл хувь хэмжээнээс хамаарах хувьсах түрээсийн төлбөр, эхний өдөр индекс эсвэл хувь хэмжээг ашиглан хэмжсэн анхны хэмжилтээр
- үлдэх өртгийн үнэ цэнийн баталгааны хүрээнд хүлээгдэж буй өглөгийн дүн
- компанийн худалдан авах сонголтоо хэрэгжүүлэх нь үндэслэлтэйгээр тодорхой бол уг сонголтыг хэрэгжүүлэх үнэ. Үүнд компани түрээсийг сунгана гэж үзвэл сунгалтын нэмэлт төлбөр, түрээсийн хугацааг эрт цуцлах торгууль.

Түрээсийн өр төлбөрийг үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр хэмждэг. Хэрэв индекс эсвэл хувь хэмжээнээс шалтгаалан Компанийн ирээдүйн түрээсийн төлбөр өөрчлөгдөх, үлдэх өртгийн үнэ цэнийн баталгааны хүрээнд хүлээгдэж буй өглөгийн дүнд өөрчлөлт орсон тохиолдолд худалдан авалт хийх, сунгах эсвэл цуцлах эсэхэд өөрчлөлт орсон эсвэл үндсэн түрээсийн төлбөрийг шинэчилсэн тохиолдолд дахин хэмждэг.

Түрээсийн өр төлбөрийг ийм байдлаар дахин хэмжихэд ашиглах эрхтэй хөрөнгийн дансанд холбогдох тохируулгыг хийх ба хэрэв ашиглах эрхтэй хөрөнгийн дансны үнэ тэг болж бүрсан тохиолдолд ашиг, алдагдал бүртгэдэг.

Компани нь санхүүгийн байдлын тайланд ашиглах эрхтэй хөрөнгийг 'үндсэн хөрөнгө'-ийн ангилалд, түрээсийн өр төлбөрийг 'бусад өглөг'-ийн ангилалд бүртгэдэг.

Богино хугацааны түрээс, бага өртөг бүхий түрээс

Компани бага үнэтэй хөрөнгийн түрээс болон богино хугацаат түрээсийн хувьд ашиглах эрхтэй хөрөнгө болон түрээсийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй байх аргыг сонгосон. Компани эдгээр түрээстэй холбоотой түрээсийн төлбөрүүдийг түрээсийн хугацааны турш шулуун шугамын аргаар зардлаар хүлээн зөвшөөрдөг.

4. Тайлант жилд хэрэгжиж эхэлсэн СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудад орсон шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд

Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл ("НББОУСЗ")-өөс гаргасан 2024 оны 01 дүгээр 01-ний өдөр болон тухайн өдрөөс хойш хэрэгжиж эхэлсэн СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудын шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүдийг Компани тайлант жилд хэрэгжүүлсэн.

4. Тайлант жилд хэрэгжиж эхэлсэн СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудад орсон шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд, үргэлжлэл

Хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн огноо	Нягтлан бодох бүртгэлийн шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд
2024 оны 01 дүгээр сарын 01	• Шалгуур үзүүлэлт бүхий эргэлтийн бус өр төлбөр – НББОУС 1-ийн нэмэлт өөрчлөлтүүд • Эргэлтийн ба эргэлтийн бус өр төлбөрийн ангилал – НББОУС 1-ийн нэмэлт өөрчлөлтүүд • Борлуулаад бүцаан түрээслэх ажил гүйлгээний түрээсийн өр төлбөр – СТОУС 16-ийн нэмэлт өөрчлөлтүүд • Бэлтгэн нийлүүлэгчийн санхүүжилтийн тохиролцоо – НББОУС 7 болон СТОУС 7-ийн нэмэлт өөрчлөлтүүд

Тайлант жилд хэрэгжүүлсэн СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудад орсон шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд нь тайлант жилийн Компанийн санхүүгийн байдал болон гүйцэтгэл, тэдгээр санхүүгийн тайлангийн тодруулгуудад материаллаг нөлөө үзүүлээгүй болно.

5. Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудад орсон шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд

Нягтлан бодох бүртгэлийн хэд хэдэн шинэ стандартууд нь 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойших тайлант жилүүдэд хэрэгжиж эхлэх бөгөөд мөрдөгдөж эхлэх хугацаанаас нь өмнө хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн. Гэхдээ Компани санхүүгийн тайланг бэлтгэхдээ дараах шинэ эсвэл нэмэлт өөрчлөлт орсон стандартуудыг хэрэгжүүлж эхлээгүй байна.

Хэрэгжиж эхэлсэн хугацаа	Шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд
2025 оны 01 дүгээр сарын 01	• Арилжаалагдах боломж бага – НББОУС 21-ийн нэмэлт өөрчлөлтүүд
2026 оны 01 дүгээр сарын 01	• Санхүүгийн хэрэглүүрийн ангилал ба хэмжилт – СТОУС 9 болон СТОУС 7-ийн нэмэлт өөрчлөлтүүд • СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудын жил бүрийн сайжруулалт – 11-р хэвлэл
2027 оны 01 дүгээр сарын 01	• СТОУС 18 Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга • СТОУС 19 Олон нийтийн үүрэг хариуцлага хүлээгээгүй охин компаниуд: Тодруулга
Сонголттойгоор мөрдөх боломжтой / мөрдөх хугацааг тодорхойгүйгээр хойшлуулсан	• Хөрөнгө оруулагч болон түүний хараат эсвэл хамтарсан компани хоорондын борлуулалт болон хувь оруулсан хөрөнгө – СТОУС 10 болон НББОУС 28-ын нэмэлт өөрчлөлтүүд

Компани СТОУС 18 Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга стандартаас бусдаар дээрх шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд нь Компанийн санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхгүй гэсэн хүлээлттэй байна.

ШУНХЛАЙ 2026.09.10 БҮРТГЭВ

MONGOLIAN STOCK EXCHANGE 2026-09-02 БҮРТГЭЛ-03

ШУНХЛАЙ ХХК
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Түсдаа Санхүүгийн Тайлангийн Тодруулга

5. Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудад орсон шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд, үргэлжлэл

СТОУС 18 Санхүүгийн Тайлангийн Толилуулга ба Тодруулга

2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэх болон түүнээс хойших тайлант жилүүдэд СТОУС 18 нь НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга стандартыг орлоно. Шинэ стандартаар дараах үндсэн шинэ шаардлагуудыг танилцуулсан.

- Компаниуд бүх орлого, зардлыг ашиг, алдагдлын тайланд үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, санхүүжилт, зогсоосон үйл ажиллагаа болон орлогын татвар гэсэн таван үндсэн төрөлд ангилах шаардлагатай. Компаниуд мөн шинээр тодорхойлсон үйл ажиллагааны ашгийн дүнг толилуулах шаардлагатай болсон. Компанийн цэвэр ашгийн дүн өөрчлөгдөхгүй.
- Удирдлагын тодорхойлсон гүйцэтгэлийн хэмжүүр ("УТГХ") нь санхүүгийн тайланд тусдаа тодруулгаар толилуулагдана.
- Санхүүгийн тайланд мэдээллийг хэрхэн бүлэглэх талаар дэлгэрэнгүй удирдамж гарсан.

Түүнээс гадна, үйл ажиллагааны мөнгөн гүйлгээг шууд бус аргаар толилуулж байгаа тохиолдолд компаниуд мөнгөн гүйлгээний тайланг үйл ажиллагааны ашгийн дүнгээс эхлэх шаардлагатай. Компани шинэ стандартын, ялангуяа Компанийн ашиг, алдагдлын тайлан, мөнгөн гүйлгээний тайлангийн бүтэц болон УТГХ-ээр шаардсан нэмэлт тодруулгын нөлөөг үнэлэх шатандаа явж байна. Мөн Компани санхүүгийн тайлангийн мэдээллийг хэрхэн цаашид бүлэглэх, тэр дундаа одоогоор 'бусад' гэж тэмдэглэсэн зүйлсүүдэд үзүүлэх нөлөөллийг үнэлж байна.

6. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө дансны үлдэгдэл дараах байдалтай байна:

(Мянган төгрөгөөр)	2024.12.31	2023.12.31
Касс дахь бэлэн мөнгө	912,141	528,373
Харилцах дахь мөнгө	1,313,095	4,528,654
	2,225,236	**5,057,027**

Компани мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нь зээлийн эрсдэл багатай гэж үздэг.

7. Дансны авлага

Дансны авлагын дүн дараах байдалтай байна:

(Мянган төгрөгөөр)	2024.12.31	2023.12.31
Гүравдагч талаас авах авлага	63,979,127	114,768,968
Холбоотой талаас авах авлага (Тодруулга 28)	198,837,075	209,218,934
Үнэ цэнийн бууралтын нөөц	(3,101,650)	(6,002,532)
	259,714,552	**317,985,370**

Компани болон түүний зэргэлдээ охин компаниуд болох Шунхлай Петролиум ХХК, Шунхлай Трейдинг ХХК болон Шунхлай Говь ХХК-ийн хамтаар 54,589,555 мянган төгрөгийн (2023: 221,302,507 мянган төгрөг) дансны авлагыг Компанийн шугамын зээлийн барьцаанд 2024 онд байршуулсан. Тодруулга 16-г харна уу.

УЛААНБААТАР ХОТ ШУНХЛАЙ ХХК ТТА3531 ☎ 2028483

Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital Delivering Diversity 1119289111 ☎ 5481589 Улаанбаатар хот

ШУНХЛАЙ ХХК
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Тусдаа Санхүүгийн Тайлангийн Тодруулга

7. Дансны авлага, үргэлжлэл

Компанийн зээлийн эрсдэл, зах зээлийн эрсдэл ба дансны болон бусад авлагын үнэ цэнийн бууралтыг Тодруулга 26-д тусгасан болно.

8. Бусад авлага

Бусад авлагын дүн дараах байдалтай байна:

(Мянган төгрөгөөр)	2024.12.31	2023.12.31
Эцсийн шатны толгой компаниас авах бусад авлага	534,907	831,306
Холбоотой талаас авах бусад авлага (Тодруулга 28)	32,220	27,226
Гуравдагч талаас авах бусад авлага	650	11,800
Ажилчдаас авах бусад авлага	2,509	4,445
	570,286	**874,777**

9. Бараа материал

Бараа материал дансны үлдэгдэл дараах байдалтай байна:

(Мянган төгрөгөөр)	2024.12.31	2023.12.31
Замд яваа бараа материал	57,455,599	74,193,895
Хангамжийн материал	258,226	209,245
	57,713,825	**74,403,140**

2024 онд Компани нь зэргэлдээ охин компани болох Шунхлай Трейдинг ХХК-ийн хамтаар өөрийн шугамын зээлүүдийн барьцаанд 69,386,800 мянган төгрөг (2023: 93,631,427 мянган төгрөг)-ийн бараа материал барьцаалсан. Тодруулга 16-г харна уу.

10. Бусад хөрөнгө

Бусад хөрөнгийн үлдэгдэл дараах байдалтай байна:

(Мянган төгрөгөөр)	2024.12.31	2023.12.31
Бусад эргэлтийн хөрөнгө:		
Урьдчилгаа	3,269,078	421,899
Бусад татварын авлага	7,182,401	537,630
Бусад эргэлтийн хөрөнгийн дүн	**10,451,479**	**959,529**
Бусад эргэлтийн бус хөрөнгө:		
Үндсэн хөрөнгийн урьдчилгаа	31,215,325	15,830,623
Нэмэгдсэн өртгийн албан татвар	2,272,880	1,136,399
Бусад эргэлтийн бус хөрөнгийн дүн	**33,488,205**	**16,967,022**
Нийт бусад хөрөнгө	**43,939,684**	**17,926,551**

ШУНХЛАЙ СЭХ
2026 оны 09 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 21
ШУНХЛАЙ ХХК

MONGOLIAN STOCK EXCHANGE
2026 -09- 02
БҮРТГЭЛ-03

ШУНХЛАЙ ХХК
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Түсдаа Санхүүгийн Тайлангийн Тодруулга

11. Үндсэн хөрөнгө

(1) 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусгавар болсон тайлант жилийн үндсэн хөрөнгийн хөдөлгөөн дараах байдалтай байна:

(Мянган төгрөгөөр)

Өртөг	Ашиглах эрхтэй хөрөнгө	Барилга	Газар ашиглах эрх	Тавилга, эд хогшил	Тоног төхөөрөмж	Тээврийн хэрэгсэл	Компьютер	Дуусаагүй барилга	Нийт
2024 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	1,932,025	182,025	186,662	673,560	657,140	4,897,624	1,221,124	12,277,792	**22,027,952**
Нэмэгдсэн	-	-	-	26,575	31,913	575,407	195,663	13,963,947	**14,793,505**
Хасагдсан	-	-	-	-	-	(297,778)	-	-	**(297,778)**
Данснаас хассан	-	-	-	-	-	-	(2,290)	-	**(2,290)**
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	**1,932,025**	**182,025**	**186,662**	**700,135**	**689,053**	**5,175,253**	**1,414,497**	**26,241,739**	**36,521,389**
Хуримтлагдсан элэгдэл									
2024 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	1,438,675	24,548	46,675	274,879	366,394	2,015,732	1,036,443	-	**5,203,346**
Тайлант жилийн элэгдэл	480,042	4,567	11,980	54,776	65,765	483,680	134,528	-	**1,235,338**
Хасагдсан	-	-	-	-	-	(163,935)	-	-	**(163,935)**
Данснаас хассан	-	-	-	-	-	-	(2,290)	-	**(2,290)**
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	**1,918,717**	**29,115**	**58,655**	**329,655**	**432,159**	**2,335,477**	**1,168,681**	**-**	**6,272,459**
Үлдэгдэл өртөг									
2024 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	**493,350**	**157,477**	**139,987**	**398,681**	**290,746**	**2,881,892**	**184,681**	**12,277,792**	**16,824,606**
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	**13,308**	**152,910**	**128,007**	**370,480**	**256,894**	**2,839,776**	**245,816**	**26,241,739**	**30,248,930**

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
ТТА3531 ☎ 2029488

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
1119289111 ☎ 5481589
Улаанбаатар хот

11. Үндсэн хөрөнгө, үргэлжлэл

(2) 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусгавар болсон тайлант жилийн үндсэн хөрөнгийн хөдөлгөөн дараах байдалтай байна:

(Мянган төгрөгөөр)

Өртөг	Ашиглах эрхтэй хөрөнгө	Барилга	Газар ашиглах эрх	Тавилга, зд хогшил	Тоног төхөөрөмж	Тээврийн хэрэгсэл	Компьютер	Дуусаагүй барилга	Нийт
2023 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	1,222,594	95,433	186,662	582,886	633,379	3,286,776	1,149,501	2,694,645	9,851,876
Нэмэгдсэн	709,431	86,592	-	90,674	23,761	2,020,998	114,989	9,583,147	12,629,592
Хасагдсан	-	-	-	-	-	(410,150)	(43,366)	-	(453,516)
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,932,025	182,025	186,662	673,560	657,140	4,897,624	1,221,124	12,277,792	22,027,952
Хуримтлагдсан элэгдэл									
2023 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	974,454	17,880	42,121	228,952	304,381	1,674,444	932,960	-	4,175,192
Тайлант жилийн элэгдэл	464,221	6,668	4,554	45,927	62,013	381,936	146,849	-	1,112,168
Хасагдсан	-	-	-	-	-	(40,648)	(43,366)	-	(84,014)
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,438,675	24,548	46,675	274,879	366,394	2,015,732	1,036,443	-	5,203,346
Үлдэгдэл өртөг									
2023 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	248,140	77,553	144,541	353,934	328,998	1,612,332	216,541	2,694,645	5,676,684
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	493,350	157,477	139,987	398,681	290,746	2,881,892	184,681	12,277,792	16,824,606

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Компани болон түүний зэргэлдээ компаниуд болох Шунхлай Трейдинг ХХК, Шунхлай Петролиум ХХК-ийн нийт 63,023,988 мянган төгрөгийн (2023: 50,458,525 мянган төгрөг) дансны үнэ бүхий үл хөдлөх хөрөнгө зээлийн барьцааны байна. Барьцааны бүх үл хөдлөх хөрөнгө нь шатахуун түгээх станцуудтай холбогдох газар ашиглах эрхээс бүрдэнэ. Тодруулга 16-г харна уу.

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
ТТД 3531 ☎ 2028488

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
1119289111 ☎ 5401589
Улаанбаатар хот

2026.08.31

ШУНХЛАЙ ХХК
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Тусдаа Санхүүгийн Тайлангийн Тодруулга

12. Биет бус хөрөнгө

(1) Биет бус хөрөнгийн хөдөлгөөн дараах байдалтай байна:

(Мянган төгрөгөөр)	**Программ хангамж**
Өртөг	
2023 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	1,107,729
Нэмэгдсэн	702,956
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	**1,810,685**
Нэмэгдсэн	415,459
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	**2,226,144**
Хуримтлагдсан хорогдуулга	
2023 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	687,498
Тайлант жилийн хорогдол	121,231
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	**808,729**
Тайлант жилийн хорогдол	118,836
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	**927,565**
2023 оны 12-р сарын 31-ний өдрөөрх дансны цэвэр үнэ	**1,001,956**
2024 оны 12-р сарын 31-ний өдрөөрх дансны цэвэр үнэ	**1,298,579**

13. Охин компаниуд дах хөрөнгө оруулалт

Охин компаниуд дах хөрөнгө оруулалт дараах байдалтай байна:

(Мянган төгрөгөөр)	**2024.12.31**	**2023.12.31**
Эс Жи Ханги Гэйт ХХК	300,000	300,000
Эс Жи Шивээ Хүрэн Депо ХХК	200,000	200,000
Шунхлай Ойл ХХК (*)	500,000	1,000
Нийт охин компани дах хөрөнгө оруулалт	**1,000,000**	**501,000**

*2024 оны 6 дугаар сарын 21-ний өдөр Компанийн хувьцаа эзэмшигчид "Шунхлай ойл" ХХК-ийн дүрмийн санг 499,000 мянган төгрөгөөр нэмэгдүүлэх шийдвэр гаргасан.

ШУНХЛАЙ ХХК
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Тусдаа Санхүүгийн Тайлангийн Тодруулга

13. Охин компани дах хөрөнгө оруулалт, үргэлжлэл

(Мянган төгрөгөөр)

Охин компанийн нэр	Үндсэн үйл ажиллагаа	Бүртгэлтэй Улс	2024.12.31 Эзэмш-лийн хувь	2023.12.31 Эзэмш-лийн хувь
Эс Жи Ханги Гэйт ХХК	Шатахуун, газрын тосны бүтээгдэхүүн бөөний болон жижиглэн худалдаа	Монгол Улс	100%	100%
Эс Жи Шивээ Хүрэн Депо ХХК	Шатахуун, газрын тосны бүтээгдэхүүн бөөний болон жижиглэн худалдаа	Монгол Улс	100%	100%
Шунхлай Ойл ХХК	Моторын тосны бөөний болон жижиглэн худалдаа	Монгол Улс	100%	100%

14. Дансны өглөг

Дансны өглөг дансны дүн дараах байдалтай байна:

(Мянган төгрөгөөр)	2024.12.31	2023.12.31
Гуравдагч талд өгөх дансны өглөг	60,456,446	79,819,166
Холбоотой талд өгөх дансны өглөг (Тодруулга 28)	1,059	-
	60,457,505	**79,819,166**

15. Бусад өглөг

Бусад өглөг дансны дүн дараах байдалтай байна:

(Мянган төгрөгөөр)	2024.12.31	2023.12.31
Гуравдагч талд өгөх бусад өглөг	99,031	157,174
Холбоотой талд өгөх бусад өглөг (Тодруулга 28)	2,430	1,250
НӨАТ болон бусад татварын өглөг	736	3,651,336
	102,197	**3,809,760**

16. Зээл

Энэхүү тодруулга нь Компанийн хүүтэй зээлийн гэрээний нөхцлийн талаарх мэдээллийг агуулсан. Хүүгийн түвшин болон гадаад валютын ханшийн эрсдэлийн талаарх дэлгэрэнгүйг Тодруулга 26–аас харна уу.

(Мянган төгрөгөөр)	2024.12.31	2023.12.31
Урт хугацаат зээл		
Барьцаатай банкны зээл	124,143,992	15,000,000
	124,143,992	**15,000,000**
Богино хугацаат зээл		
Барьцаатай банкны зээл	73,006,769	254,455,039
Барьцаагүй гаргасан бонд	101,268,969	50,000,000
	174,275,738	**304,455,039**

ШУНХЛАЙ ХХК
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дүүсгавар болсон тайлант жилийн
Тусдаа Санхүүгийн Тайлангийн Тодруулга

16. Зээл, үргэлжлэл

Богино хугацаат зээлийн дүн дараах байдалтай байна.

(Мянган төгрөгөөр)

Банкны нэр	Валют	Нэрлэсэн хүүгийн хувь	Дуусах хугацаа	2024.12.31	2023.12.31
Хас Банк	Төгрөг	16.8%	2025	15,000,000	15,000,000
Голомт Банк	Ам.доллар	10.2%	2025	486,712	3,768,600
Голомт Банк	Төгрөг	16.8%	2025	50,196,691	52,051,611
Голомт Банк	Төгрөг	17.0%	2024	-	20,000,000
Худалдаа Хөгжлийн Банк	Төгрөг	15.0%	2025	5,800,000	16,760,965
Худалдаа Хөгжлийн Банк	Төгрөг	15.0%	2026	32,500,341	-
Худалдаа Хөгжлийн Банк	Төгрөг	17.0%	2024	-	110,692,339
Хаан Банк	Төгрөг	16.8%	2026	79,130,800	-
Хаан Банк	Төгрөг	17.4%	2028	12,512,851	50,000,000
Хаалттай бонд*	Төгрөг	18.0%	2024	-	50,000,000
Хаалттай бонд**	Төгрөг	17.0%	2025	20,000,000	-
Нээлттэй бонд***	Төгрөг	17.0%	2025	78,677,750	-
Барьцаатай банкны зээлийн хүүгийн өглөг				1,523,366	1,181,524
Барьцаагүй гаргасан бондын хүүгийн өглөг				2,591,219	-
Нийт зээл болон хүүгийн өглөг				**298,419,730**	**319,455,039**

Зээл дуусах он нь тухайн зээлийн эцсийн төлбөр хийгдэх үеийг хэлнэ.

Барьцаатай банкны зээлүүд нь Компани болон зэргэлдээ компаниуд болох Шунхлай Трейдинг ХХК, Шунхлай Петролиум ХХК, Шунхлай Говь ХХК-ууд ул хөдлөх хөрөнгө, тоног төхөөрөмж, бараа материал, дансны авлага болон ирээдүйн борлуулалтаас орох мөнгөн орлогоор барьцаалагдсан бөгөөд эдгээрийн дүн нь тус тусдаа 63,023,988 мянган төгрөг (2023: 50,458,525 мянган төгрөг) (Тодруулга 11), 69,386,800 мянган төгрөг (2023: 93,631,427 мянган төгрөг) (Тодруулга 9), 54,589,555 мянган төгрөг (2023: 221,302,507 мянган төгрөг) (Тодруулга 7), 17,020,000 мянган төгрөг (2023: 48,503,746 мянган төгрөг) (Тодруулга 18) байна.

Компанийн барьцаатай банкны зээлүүд нь төрөл бүрийн гэрээний нөхцөл, шаардлагуудыг биелүүлэх шаардлагатай бөгөөд 2024 болон 2023 онд эдгээр нөхцөл, шаардлагуудыг зөрчөөгүй болно.

* Шунхлай ХХК нь 2023 оны 01 дүгээр сард 50 тэрбум төгрөгийн хаалттай бондыг гаргасан. Бонд нь 12 сарын хугацаатай, барьцаагүй. Жилийн хүү нь 18% бөгөөд хүүгийн төлбөрийг хагас жил тутамд төлнө. Бондын гэрээнд хөрвөх, хугацаа сунгах зэрэг ямар нэгэн сонголт агуулаагүй. Үндсэн төлбөр болон хуримтлагдсан хүүг бондын хугацаа дуусахад бэлнээр бүрэн төлнө. Хаалттай бондыг 2024 онд бүрэн төлсөн.

** Шунхлай ХХК нь 2024 оны 4 дүгээр сард 20 тэрбум төгрөгийн хаалттай бондыг гаргасан. Бонд нь 12 сарын хугацаатай, барьцаагүй. Жилийн хүү нь 17% ба хүүгийн төлбөрийг хагас жил тутамд төлнө. Бондын гэрээнд хөрвөх, хугацаа сунгах зэрэг ямар нэгэн сонголт агуулаагүй. Үндсэн төлбөр болон хуримтлагдсан хүүг бондын хугацаа дуусахад бэлнээр бүрэн төлнө

ШУНХЛАЙ ХХК
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Түсдаа Санхүүгийн Тайлангийн Тодруулга

16. Зээл, үргэлжлэл

*** Шунхлай ХХК нь 2024 оны 12 дугаар сард Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан нэгжийн 100 мянган төгрөгийн нэрлэсэн үнэтэй 800,000 ширхэг нээлттэй бонд гаргасан. Нээлттэй бонд нь 12 сарын хугацаатай бөгөөд барьцаагүй. Жилийн хүү нь 17% ба хүүгийн төлбөрийг хагас жил тутамд төлнө. Бондын гэрээнд хөрвөх, хугацаа сунгах зэрэг ямар нэгэн сонголт агуулаагүй. Үндсэн төлбөр болон хуримтлагдсан хүүг бондын хугацаа дуусахад бэлнээр бүрэн төлнө.

Санхүүжилтийн үйл ажиллагаанаас үүссэн өр төлбөрийн тохируулга:

(Мянган төгрөгөөр)	Зээл	Бонд	Нийт
2023 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	**197,706,896**	**3,962,636**	**201,669,532**
Санхүүгийн мөнгөн урсгалын өөрчлөлт:			
Тайлант жилд авсан зээл	1,870,078,938	-	**1,870,078,938**
Тайлант жилд гаргасан барьцаагүй бонд	-	51,722,629	**51,722,629**
Үндсэн төлөлт	(1,799,130,654)	(7,542,923)	**(1,806,673,577)**
Бусад өөрчлөлтүүд:			
Хуримтлагдсан хүү	27,760,195	4,778,870	**32,539,065**
Хүүгийн төлөлт	(26,578,671)	(2,894,805)	**(29,473,476)**
Валютын ханш	(381,665)	(26,407)	**(408,072)**
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	**269,455,039**	**50,000,000**	**319,455,039**
Санхүүгийн мөнгөн урсгалын өөрчлөлт:			
Тайлант жилд авсан зээл	1,518,280,313	-	**1,518,280,313**
Тайлант жилд гаргасан барьцаагүй бонд	-	99,867,498	**99,867,498**
Үндсэн төлөлт	(1,591,940,482)	(50,000,000)	**(1,641,940,482)**
Бусад өөрчлөлтүүд:			
Капиталжуулсан зээлийн өртөг	1,531,986	-	**1,531,986**
Хуримтлагдсан хүү	44,095,251	7,216,355	**51,311,606**
Хүүгийн төлөлт	(43,753,407)	(5,814,884)	**(49,568,291)**
Валютын ханш	(517,939)	-	**(517,939)**
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	**197,150,761**	**101,268,969**	**298,419,730**

ШУНХЛАЙ ХХК
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Тусдаа Санхүүгийн Тайлангийн Тодруулга

17. Эздийн өмч

(1) Хувьцаат капитал

Компанийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр гаргахаар зөвшөөрөгдсөн бөгөөд гаргасан хувьцаа нь 1,657 (2023: 1,657) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэж байна. Нэгж хувьцааны нэрлэсэн үнэ 100,000 төгрөг бөгөөд нийт хувьцаат капиталын дүн 165,700 мянган төгрөг (2023: 165,700 мянган төгрөг) байна.

Эцсийн шатны толгой компани болох Шунхлай Холдинг ХХК-ийн Монгол Банкны бондын барьцаанд өмчлөгчийн зүгээс Компанийн хувьцааны 34% (563 хувьцаа)-ийг байршуулсан.

(2) Хуримтлагдсан ашиг

Компани 2024 болон 2023 онд ногдол ашиг зарлаагүй болно.

18. Борлуулалтын орлого

12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн борлуулалтын орлогын дэлгэрэнгүй дараах байдалтай байна:

(Мянган төгрөгөөр)	**2024**	**2023**
Шатахуун болон тос	1,394,503,366	1,172,937,046
Шимтгэлийн орлого	13,676,571	16,331,117
Бусад	4,721	3,279,537
Менежментийн төлбөрийн орлого	5,198,714	5,131,360
	1,413,383,372	**1,197,679,060**

2024 онд Компани нь зэргэлдээ охин компаниуд болох Шунхлай Говь ХХК, Шунхлай Петролиум ХХК, Шунхлай Трейдинг ХХК-ийн хамтаар 17,020,000 мянган төгрөгийн (2023: 48,503,746 мянган төгрөг) ирээдүйн борлуулалтын орлогоо Хаан Банк болон Худалдаа, Хөгжлийн Банкны шугамын зээлийн барьцаанд байршуулсан. Тодруулга 15-г харна уу.

19. Борлуулалтын өртөг

12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн борлуулсан бүтээгдэхүүний өртөг дансны дэлгэрэнгүй дараах байдалтай байна:

(Мянган төгрөгөөр)	**2024**	**2023**
Шатахуун болон тос	1,321,987,929	1,113,256,591
Бусад	19,159	148,195
	1,322,007,088	**1,113,404,786**

2026.08.31

ШУНХЛАЙ
он 2026 сар 9. 1 өдөр
БҮРТГЭВ
№ 21

МОНГОЛЫН ХӨРӨНГӨ ЗАХ БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2026 -09- 02
БҮРТГЭЛ-03

ШУНХЛАЙ ХХК
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Түсдаа Санхүүгийн Тайлангийн Тодруулга

20. Борлуулалт болон түгээлтийн зардал

12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилд гарсан борлуулалт болон түгээлтийн зардал дараах байдалтай байна:

(Мянган төгрөгөөр)	2024	2023
Брокерын төлбөр	1,813,521	2,781,585
Маркетинг, зар сурталчилгааны зардал	870,359	813,423
	2,683,880	**3,595,008**

21. Удирдлагын зардал

12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилд гарсан удирдлагын зардал дараах байдалтай байна:

(Мянган төгрөгөөр)	2024	2023
Цалингийн зардал	7,472,437	6,763,177
Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	5,431,856	3,480,634
Элэгдлийн зардал	1,235,338	1,112,168
Нийгмийн даатгалын зардал	942,261	976,110
Томилолтын зардал	720,463	599,506
Сургалтын зардал	720,185	-
Эрхийн шимтгэлийн төлбөр (Тодруулга 28)	210,180	224,892
Түлш шатахууны зардал	428,803	343,937
Даатгал	259,877	194,790
Сэлбэг хэрэгслийн зардал	216,897	217,894
Менежментийн төлбөр	144,700	48,000
Хорогдуулгын зардал	118,836	121,231
Хангамжийн материалын зардал	107,181	89,246
Шуудан, харилцаа холбооны зардал	61,377	80,084
Бичиг хэргийн зардал	52,703	46,103
Хөрөнгийн татвар, газрын төлбөр	41,261	-
Банкны үйлчилгээний шимтгэл	37,084	118,368
Засвар үйлчилгээний зардал	2,407	-
Бусад зардал	957,875	43,950
	19,161,721	**14,460,090**

22. Бусад орлого

12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн бусад орлогын дэлгэрэнгүй дараах байдалтай байна:

(Мянган төгрөгөөр)	2024	2023
Үндсэн хөрөнгө борлуулсны олз	135,855	1,531
Бусад орлого	8,782	27,201
	144,637	**28,732**

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
3631 № 2028468

128

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering Diversity
1119289111
Улаанбаатар хот

2026.08.31

ШУНХЛАЙ ХХК
2026 .09. 10 өдөр
БҮРТГЭВ
№ 21

2026 -09- 02
БҮРТГЭВ-03

ШУНХЛАЙ ХХК
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Түсдаа Санхүүгийн Тайлангийн Тодруулга

23. Бусад зардал

12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн бусад зардлын дэлгэрэнгүй дараах байдалтай байна:

(Мянган төгрөгөөр)	2024	2023
Хандив	2,544,462	125,084
Үндсэн хөрөнгө борлуулсны гарз	112,272	-
Тэмцээн уралдаан болон баяр ёслолын зардал	1,189,352	1,492,253
Торгуулийн зардал	1,845,007	881,577
Бусад зардал	-	1,913,031
	5,691,093	**4,411,945**

24. Санхүүгийн орлого болон зардал

12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн орлого дараах байдалтай байна:

(Мянган төгрөгөөр)	2024	2023
Хүүгийн орлого	37,549	239,369
Гадаад валютын ханшийн зөрүүний олз	-	43,133
	37,549	**282,502**

12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн зардал дараах байдалтай байна:

(Мянган төгрөгөөр)	2024	2023
Зээлийн хүүгийн зардал	44,095,251	27,760,195
Бондын хүүгийн зардал	7,216,355	4,778,870
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	2,523,320	2,713,380
Түрээсийн өр төлбөрийн хүүгийн зардал	52,563	130,845
Бусад санхүүгийн зардал	297,477	538,971
	54,184,966	**35,922,261**

25. Орлогын татварын зардал

12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн орлогын албан татварын зардлын дэлгэрэнгүй дараах байдалтай байна.

(Мянган төгрөгөөр)	2024	2023
Тайлант жилийн татварын зардал	1,928,105	6,651,110
Хойшлогдсон татварын зардал	4,686	44,707
Орлогын татварын зардлын дүн	**1,932,791**	**6,695,817**

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
ТТА3531 ☎ 2028488

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
1119289111 ☎ 5481589
Улаанбаатар хот

25. Орлогын татварын зардал, үргэлжлэл

12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн татварын зардлын тохируулга:

(Мянган төгрөгөөр)	2024	2023
Татварын өмнөх ашиг	12,737,692	23,092,014
- Нийтлэг хувь хэмжээгээр тооцсон татвар (*)	3,184,423	5,773,004
- Татварын бага түвшний татварын нөлөө (*10%)	(900,000)	(900,000)
- Түсгай хувь хэмжээгээр тооцсон татвар	4,633	26,657
- Татвар ногдох орлогоос хасагдахгүй зардалд ногдох татварын нөлөө	1,072,334	1,796,156
- Татвар ногдохгүй орлогын татварын нөлөөлөл	(11,583)	-
- Татварын урамшуулал	(1,417,016)	-
Орлогын татварын зардлын дүн	**1,932,791**	**6,695,817**

(*) Монгол Улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд зааснаар 6 тэрбум төгрөг хүртэлх албан татвар ногдох ашигт 10 хувийн, 6 тэрбум төгрөгөөс дээш албан татвар ногдох ашигт 25 хувийн татвар ногдуулдаг.

Монгол Улсын татвар, валют болон гаалийн тухай хуулиудын талаарх ойлголтууд нь ялгаатай байх тохиолдлууд байдаг ба тэдгээр хуулиуд нилээд өөрчлөгдөж байдаг. Эдгээр хуулиудыг удирдлага нь Компанийн ажил гүйлгээ, үйл ажиллагаанд өөрсдийн ойлголт, тайлбарын хүрээнд хэрэгжүүлж байгаа болов аливаа татварын эрх бүхий байгууллагуудын сорилттой тулгарч болно.

Монгол Улсын татварын эрх бүхий байгууллага нь өөрийн хуулийн талаарх тайлбар болон байр сууриндаа илүү хатуу хандаж болох бөгөөд өмнө нь татварын аливаа асуудал үүсч байгаагүй ажил гүйлгээ, үйл ажиллагаанд татварын аливаа асуудал үүсэхийг үгүйсгэхгүй юм. Үүний үр дүнд, нөлөөлөхүйц хэмжээний нэмэлт татвар, торгууль болон хүүг ногдуулж болох юм. Татварын шалгалт хийх хугацааны хувьд шалгалт хийх тайлант жилээс өмнөх 4 (2023 он: 4 жил байсан) жилийн хугацааг хамарч болно. Зарим тухайлсан тохиолдолд түүнээс ч урт хугацааг хамарч болно.

Үнэ шилжилттэй холбоотой Монгол Улсын хуулийн заалтууд нь 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн ба тодорхой онцлог шинж чанарыг агуулсан ч Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагаас боловсруулсан олон улсын үнэ шилжилттэй холбоотой зарчимд ерөнхийдөө суурилсан. Үнэ шилжилттэй холбоотой хуулийн зохицуулалт нь тухайн байгууллагын хяналтанд байгаа ажил гүйлгээнүүд (холбоотой талуудын хооронд хийгдсэн ажил гүйлгээ, мөн зарим холбоогүй талуудын хооронд хийгдсэн ажил гүйлгээ) хэрэв сунгасан гарын зарчмаар хэрэгжээгүй бол татварын аливаа эрсдэл үүсэх зохицуулалттай. Удирдлага нь одоогийн үнэ шилжилттэй холбоотой хууль тогтоомжийг дагаж мөрдөх төлөвлөгөө, журмыг хэрэгжүүлж байгаа.

Монгол Улсын татварын хууль тогтоомжийн зарим хэсэгт илт тодорхой удирдамж байдаггүйгээс тухайн хуулийн тодорхойгүй хэсгийг Компанийн зүгээс ойлгон хэрэгжүүлсэн нь татварын хувь хэмжээг бууруулсан үр дүнд хүргэсэн байж болно. Компанийн удирдлага нь өөрийн хэрэгжүүлж буй татварын байр суурь, тайлбарыг үндэслэлтэй гэж тооцоолж байгаа болов татварын эрх бүхий байгууллагын зүгээс үг байр суурь, тайлбартай холбоотой асуудал үүсгэвэл татварын боломжит эрсдэл үүсч болзошгүй юм. Үүсч болох үг татварын эрсдэлийн үр нөлөөг найдвартай тооцоолох боломжгүй болов энэ нь Компанийн санхүүгийн байдал эсвэл ерөнхий үйл ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөөтэй байх магадлалтай юм.

26. Санхүүгийн эрсдэлийн удирдлага

Бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад Компани зээлийн, хүүгийн болон валютын ханшийн эрсдэлүүдэд өртөж байдаг. Компани нь эдгээр эрсдэлүүдэд хейджинг хийдэггүй.

Тойм

Санхүүгийн хэрэглүүрээс үүдэн компанид дараах төрлийн эрсдэлүүд тулгарч байдаг:

- зээлийн эрсдэл
- хөрвөх чадварын эрсдэл
- зах зээлийн эрсдэл

Энэхүү тодруулга нь дээрх эрсдэл тус бүрийн компанид нөлөөлөх нөлөөлөл, үг эрсдэлийг тооцоолох, удирдах компанийн зорилго, бодлого, авах арга хэмжээ, мөн компанийн капиталын удирдлагын талаарх мэдээллийг агуулсан. Түүнчлэн тоон утга бүхий нэмэлт тодруулгуудыг энэхүү санхүүгийн тайлангийн хүрээнд хамруулсан болно.

Эрсдэлийн удирдлагын тогтолцоо

Компанийн удирдлага нь компанийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгох, түүнийг хянах ерөнхий үүрэг хариуцлагыг хүлээж байдаг. Компанийн эрсдэлийн удирдлагын бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх, хянах зэрэг өдөр тутмын үйл ажиллагаанд удирдлага хариуцлага хүлээдэг. Удирдлага Төлөөлөн Удирдах Зөвлөлд үйл ажиллагааныхаа талаар тогтмол тайлагнадаг.

Компанийн эрсдэлийн удирдлагын бодлого нь Компанид тулгарч буй эрсдэлүүдийг тодорхойлох, шинжлэх, тохиромжтой эрсдэлийн хязгаар, хяналтыг бий болгох, эрсдэлийг хянах, хязгаарыг мөрдөхөд чиглэгдсэн байдаг. Эрсдэлийн удирдлагын бодлого болон системийг зах зээлийн нөхцөл байдал болон компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх аливаа өөрчлөлтүүдийг тусгахын тулд тогтмол хянаж байдаг. Компани өөрийн сургалт, удирдлагын стандарт болон горимыг ашиглан ажилчид өөрсдийн үүрэг хариуцлагыг бүрэн ойлгосон дэг журамтай, бүтээлч хяналтын орчныг бий болгохоор зорьж ажилладаг.

(1) Зээлийн эрсдэл

Зээлийн эрсдэл гэдэг нь гэрээ байгуулагч тал гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүйгээс компанид санхүүгийн алдагдал үүсэх эрсдэл бөгөөд энэ нь голдуу компанийн зээл болон бусад авлагаас үүдэлтэй байна. Компанийн зээлийн эрсдэл нь голдуу гэрээ байгуулагчийн хувийн онцлогоос хамааралтай байна. Гэрээ байгуулагчийн үйл ажиллагаа эрхэлж буй бизнесийн салбар болон улс орны нөхцөл байдлаас шалтгаалан үүргээ биелүүлэхгүй байх эрсдэл нь зээлийн эрсдэлд бага нөлөөтэй байна.

Компанийн зээлийн эрсдэл нь дансны авлага, зээлийн авлага ба бусад хөрөнгө оруулалтуудад төвлөрсөн байна.

ШУНХЛАЙ ХХК
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Тусдаа Санхүүгийн Тайлангийн Тодруулга

26. Санхүүгийн эрсдэлийн удирдлага

(1) Зээлийн эрсдэл, үргэлжлэл

Зээлийн эрсдлийн тодруулга

Санхүүгийн хөрөнгийн дансны үнэ нь зээлийн хамгийн их эрсдэлийг илэрхийлж байдаг. Компанийн хамгийн их хүлээх зээлийн эрсдэлийг санхүүгийн хөрөнгө тус бүрийн дансны үнээр илэрхийлэв:

(Мянган төгрөгөөр)	2024	2023
Харилцах дахь мөнгө	1,313,095	4,528,654
Дансны авлага	259,714,552	317,985,370
Бусад авлага	570,286	874,777
	261,597,933	**323,388,801**

Дансны болон бусад авлагын тайлагналын өдрөөрх насжилт:

(Мянган төгрөгөөр)	2024.12.31		2023.12.31	
	Дансны болон бусад авлага	Үнэ цэнийн бууралтын нөөц	Дансны болон бусад авлага	Үнэ цэнийн бууралтын нөөц
Хэвийн бөгөөд үнэ цэнийн бууралт үүсээгүй	230,577,165	(89,621)	245,816,417	(2,623,229)
Хугацаа хэтэрсэн (0 - 30 өдөр)	30,230,757	(451,780)	32,877,568	(352,106)
Хугацаа хэтэрсэн (31 - 90 өдөр)	18,398	(81)	37,086,543	(397,182)
Хугацаа хэтэрсэн (91 - 150 өдөр)	-	-	6,521,983	(69,847)
Хугацаа хэтэрсэн (151 - 365 өдөр)	-	-	-	-
Хугацаа хэтэрсэн (365-аас дээш өдөр)	2,560,168	(2,560,168)	2,560,168	(2,560,168)
	263,386,488	**(3,101,650)**	**324,862,679**	**(6,002,532)**

12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн дансны авлагын үнэ цэнийн нөөц дансны хөдөлгөөн дараах байдалтай байна.

(Мянган төгрөгөөр)	2024	2023
01 сарын 01-ний үлдэгдэл	6,002,532	2,898,342
Найдваргүй авлагын нөөцийн нэмэгдэл	-	3,104,190
Найдваргүй авлагын нөөцийн бүцаалт	(2,900,882)	-
12 сарын 31-ний үлдэгдэл	**3,101,650**	**6,002,532**

Дансны болон бусад авлага

Компанийн зээлийн эрсдэл нь харилцагч бүрийн онцлог шинж чанараас хамаардаг. Үүнээс гадна удирдлага нь харилцагчийн багцын зээлийн эрсдэлд нөлөөлж болохуйц хүчин зүйлсийг авч үзсэн.

Компани нь харилцагч бүрт хамгийн ихдээ 90 хоногийн төлбөрийн дээд хугацаа тогтоон дансны авлагаас үүсэх зээлийн эрсдэлээ хязгаарладаг.

ШУНХЛАЙ ХХК
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Тусдаа Санхүүгийн Тайлангийн Тодруулга

26. Санхүүгийн эрсдэлийн удирдлага, үргэлжлэл

(1) Зээлийн эрсдэл, үргэлжлэл

Компани нь дансны болон бусад авлагад барьцаа шаардаггүй. Компанид барьцаа хөрөнгийн үлмаас алдагдлын нөөц хүлээн зөвшөөрсөн дансны авлага байхгүй.

Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлс

Компани 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр 1,313,095 мянган төгрөгийн банкин дах мөнгөн хөрөнгөтэй (2023 онд 4,528,654 мянган төгрөг). Компани олонд танигдсан санхүүгийн байгууллагад мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг байршуулах, харилцагч бүрт зээлийн хязгаарыг тогтоож батлах замаар зээлийн эрсдэлд өртөхийг хязгаарладаг.

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг 12 сарын хүлээгдэж буй алдагдлын аргаар хэмжих ба богино хугацаат зээлийн эрсдэлийг харуулсан. Компани нь мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн зээлийн эрсдэлийг оролцогч талуудын гадаад зээлийн үнэлгээнээс хамааруулан бага гэж үздэг. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн үнэ цэнийн бууралт нь маш бага байхаар байна.

(2) Хөрвөх чадварын эрсдэл

Хөрвөх чадварын эрсдэл нь санхүүгийн өр төлбөртэй хамаарал бүхий үүрэг хариуцлагаа биелүүлэхэд компанид тулгарч болох аливаа хүндрэлүүд юм. Компанийн хөрвөх чадвараа удирдах арга хандлага нь хэвийн болон ачаалалтай аль ч үед аль болох хугацаанд нь өөрийн өр төлбөрийг барагдуулах хангалттай хөрвөх чадвартай байх, үл хүлээн зөвшөөрөгдөх аливаа алдагдлыг хүлээхгүй байх, компанийн нэр хүндэд сөргөөр нөлөөлөхгүй байх явдал юм.

Санхүүгийн өр төлбөрүүдийн гэрээгээр дуусах хугацааг доорх байдлаар илэрхийлэв. Тооцоолсон хүүгийн төлбөрийг хамруулсан ба гэрээг хооронд нь цэвэрлэх үр нөлөөг тусгаагүй болно.

(Мянган төгрөгөөр)	Дансны үнэ	Гэрээгээрх мөнгөн урсгал	1 жил ба түүнээс доош	1-ээс дээш жил
2024 оны 12-р сарын 31				
Дансны өглөг	60,457,505	60,457,505	60,457,505	-
Бусад өглөг *	101,461	101,461	101,461	-
Зээл	298,419,730	309,987,596	180,076,892	129,910,704
Түрээсийн өр төлбөр	15,234	16,257	16,257	-
	358,993,930	**370,562,819**	**240,652,115**	**129,910,704**
2023 оны 12-р сарын 31				
Дансны өглөг	79,819,166	79,819,166	79,819,166	-
Бусад өглөг*	158,424	158,424	158,424	-
Зээл	319,455,039	339,308,628	319,455,039	19,853,589
Түрээсийн өр төлбөр	587,800	686,080	686,080	-
	400,020,429	**419,972,298**	**400,118,709**	**19,853,589**

(*) 2024 оны татварын өглөг болох 736 мянган төгрөг (2023 онд 3,651,336 мянган төгрөг) ороогүй болно.

ШУНХЛАЙ
2026 .09. 10
БҮРТГЭВ
№ 01

Үнэт цаасны танилцуулга
2026 -09- 02
БҮРТГЭВ-03

26. Санхүүгийн эрсдэлийн удирдлага, үргэлжлэл

(3) Зах зээлийн эрсдэл

Зах зээлийн эрсдэл нь гадаад валютын ханш, хүүгийн түвшин зэрэг зах зээлийн үнийн өөрчлөлт компанийн орлого, санхүүгийн хэрэглүүрийн үнэ цэнэд нөлөөлөх эрсдэл юм. Зах зээлийн эрсдэлийн удирдлагын зорилго нь өгөөжийг оновчтой байлгах хугацаанд зах зээлийн эрсдэлийг хүлээн зөвшөөрөгдөхүйц хэмжээнд удирдаж, хянах явдал юм.

Валютын ханшийн эрсдэл

Компани төгрөгөөс бусад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө, дансны өглөг болон зээлд гадаад валютын ханшийн эрсдэлийг хүлээж байдаг. Эрсдэлийг бий болгож буй гадаад валют нь Ам.доллар, Оросын Рубль болон Хятадын Юань юм.

Валютын ханшийн эрсдэл 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дараах байдалтай байна.

(Мянган төгрөгөөр)	Ам.доллар	Юань	Рубль
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	656,374	286,450	21,456
Дансны авлага	17,937,382	216,941	14,708,785
Дансны өглөг	(59,875,212)	-	-
Зээл	(486,712)	-	-
	(41,768,168)	**503,391**	**14,730,241**

Валютын ханшийн эрсдэл 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дараах байдалтай байна.

(Мянган төгрөгөөр)	Ам.доллар	Юань	Рубль
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	816,239	16,559	2,365
Дансны авлага	2,909,723	702,114	270,592
Дансны өглөг	(74,581,823)	-	-
Зээл	(3,768,600)	-	-
	(74,624,461)	**718,673**	**272,957**

Тайлант жилд хэрэглэсэн голлох валютын ханш:

(Төгрөгөөр)	Тайлагналын өдрийн ханш	
	2024	2023
Ам. доллар	3,420.25	3,410.69
Рубль	32.85	37.67
Юань	468.57	480.01

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
УЗ-0551 № 2026406

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
1119289111
Улаанбаатар хот

ШУНХЛАЙ ХХК
2026 .09. 10
БҮРТГЭВ
№ 11

MONGOLIAN STOCK EXCHANGE
2026 -09- 02
БҮРТГЭВ-03

ШУНХЛАЙ ХХК
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Тусдаа Санхүүгийн Тайлангийн Тодруулга

26. Санхүүгийн эрсдэлийн удирдлага, үргэлжлэл

(3) Зах зээлийн эрсдэл, үргэлжлэл

Мэдрэмжийн шинжилгээ

Гадаад валютаар илэрхийлэгдсэн санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бүсад бүх хувьсагч хүчин зүйлс тогтмол байх үед ам.долларын ханш 10%-иар сулрах эсвэл чангарахад татварын өмнөх ашигт дараах байдлаар нөлөөлөхөөр байна.

(Мянган төгрөгөөр)	2024		2023	
	10% чангарах	10% сулрах	10% чангарах	10% сулрах
Ам. Доллар	(4,176,817)	4,176,817	(7,462,446)	7,462,446
Юань Рубль	50,339	(50,339)	71,867	(71,867)
Рубль	1,473,024	(1,473,024)	27,296	(27,296)

Хүүгийн эрсдэл

Хүүгийн эрсдэл нь голдуу хөвөгч хүүтэй хадгаламж, зээлд тохиолдож болох хүүгийн түвшний ирээдүйд гарах өөрчлөлтийн хэлбэлзлийн эрсдэл юм. Хүүгийн эрсдэлийн удирдлагын зорилго нь санхүүгийн зардал болон хүүгийн түвшний өөрчлөлттэй холбоотой тодорхой бус байдлыг хамгийн бага түвшинд байлгахад чиглэдэг. Компанийн хүүгийн түвшний өөрчлөлттэй холбоотойгоор хүлээх зах зээлийн эрсдэл нь голдуу Компанийн зээлтэй хамааралтай байдаг. (Тодруулга 16–аас харна уу)

Компанийн тухайн эрсдэлийг бууруулах бодлого нь тогтмол хүүтэй зээл авах явдал юм. Тайлагналын өдрөөрх Компанийн хүүтэй санхүүгийн хэрэгслийн хүүгийн байдал дараах байдалтай байна.

(Мянган төгрөгөөр)	2024.12.31	2023.12.31
Тогтмол хүүтэй хэрэглүүр		
Санхүүгийн хөрөнгө	1,313,095	4,528,654
Санхүүгийн өр төлбөр	(298,419,730)	(319,455,039)
	(297,106,635)	**(314,926,385)**

(4) Капиталын удирдлага

Компанийн капиталын удирдлагын гол зорилго нь Компанийн тасралтгүй үйл ажиллагааг хангах ба хувьцаа эзэмшигчид болоод компанийн ашиг сонирхлын талуудад үр өгөөжийг бий болгосоор байх явдал юм. Компани нь капиталын бүтцээ тогтмол хянаж ажилладаг. Компани ирэх жилүүдэд сөрөг эздийн өмчийн асуудлыг шийдвэрлэхээр төлөвлөж байна. Компанид гадаад капиталын шаардлага үүсээгүй.

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ
ТТАЙ 2028486

135

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering directly
1119289111 ☎ 5481589
Улаанбаатар хот

2026.08.31

26. Санхүүгийн эрсдэлийн удирдлага, үргэлжлэл

(4) Капиталын удирдлага, үргэлжлэл

Компанийн өр капиталын харьцаагаар тайлант хугацааны эцэст илэрхийлбэл:

(Мянган төгрөгөөр, өр капиталын харьцаанаас бусад)	**2024.12.31**	**2023.12.31**
Нийт өр төлбөр	361,012,876	409,681,112
Нийт өмч	35,698,216	24,893,315
Өр капиталын харьцаа	**10.11**	**16.46**

27. Санхүүгийн хэрэглүүрийн ангилал

Бодит үнэ цэнийн тодорхойлолт ба бодит үнэ цэнийн ангилал

Компани доорх шатлалыг санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг тодорхойлж, тодруулахдаа хэмжилтэнд ашигласан мэдэгдэхүйц өгөгдлүүдийн түвшинд үндэслэнэ.

Түвшин 1: Ижил төрлийн хөрөнгө, өр төлбөрийн зах зээлийн жишиг үнэ дээр суурилна.
Түвшин 2: Бодит үнэ цэнийн хэмжилтэнд мэдэгдэхүйц нөлөөтэй зах зээлийн хамгийн бага өгөгдлийг шууд болон шууд бус мэдээлэлд жишиж болохуйц үнэлгээний арга.
Түвшин 3: Бодит үнэ цэнийн хэмжилтэнд мэдэгдэхүйц нөлөөтэй зах зээлийн хамгийн бага өгөгдлийг шууд болон шууд бус мэдээлэлд жишиж харьцуулах боломжгүй үнэлгээний арга.

Компани нь бодит үнэ цэнээрээ тайлагнаагүй санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийг дараах байдлаар тодорхойлдог.

(i) Бодит үнэ цэнэ нь дансны үнэтэйгээ ойролцоо санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр

Тургэн борлогдох болон нэг жилээс богино хугацаанд дуусах санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн хувьд дансны үнэ нь ойролцоогоор бодит үнэ цэнэтэй ижил байдаг.

(ii) Тогтмол хүүтэй санхүүгийн хэрэглүүр

Хорогдуулсан өртгөөр бүртгэлд тусгагддаг тогтмол хүүтэй санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг тооцохдоо хүүгийн түвшинг Монголын зах зээл дээрх ижил төстэй санхүүгийн хэрэглүүрийн одоогийн үнэ ханштай харьцуулдаг.

27. Санхүүгийн хэрэглүүрийн ангилал, үргэлжлэл

Бодит үнэ цэнийг дансны үнэтэй харьцуулах нь

Санхүүгийн хөрөнгийн ангиллыг харуулбал:

(Мянган төгрөгөөр)	2024.12.31		2023.12.31	
	Дансны үнэ	Бодит үнэ цэнэ	Дансны үнэ	Бодит үнэ цэнэ
Хорогдуулсан өртгөөр илэрхийлсэн санхүүгийн хөрөнгө				
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	2,225,236	2,225,236	5,057,027	5,057,027
Дансны авлага	259,714,552	259,714,552	317,985,370	317,985,370
Бусад авлага	570,286	570,286	874,777	874,777
	262,510,074	**262,510,074**	**323,917,174**	**323,917,174**

Санхүүгийн өр төлбөрийн ангиллыг харуулбал:

(Мянган төгрөгөөр)	2024.12.31		2023.12.31	
	Дансны үнэ	Бодит үнэ цэнэ	Дансны үнэ	Бодит үнэ цэнэ
Хорогдуулсан өртгөөр илэрхийлсэн санхүүгийн өр төлбөр				
Дансны өглөг	60,457,505	60,457,505	79,819,166	79,819,166
Бусад өглөг	101,461	101,461	158,424	158,424
Зээл	298,419,730	298,419,730	319,455,039	319,455,039
Түрээсийн өр төлбөр	15,234	15,234	587,800	587,800
	358,993,930	**358,993,930**	**400,020,429**	**400,020,429**

Бодит үнэ цэнийг хөрөнгийг борлуулж байгаа эсвэл өр төлбөрөөр тооцож буй гүйлгээ хийгдэж байгаа зах зээлийн таамаглал дээр үндэслэн хэмждэг ба энэхүү зах зээл нь:

- Хөрөнгө, өр төлбөрийн арилжаа хийгдэж буй үндсэн зах зээл; эсвэл
- Хөрөнгө, өр төлбөрийн арилжаа хийгдэж буй үндсэн зах зээл байхгүй тохиолдолд хамгийн ашигтай зах зээл байна.

Санхүүгийн тайланд хөрөнгө болон өр төлбөрийг тогтмол сууриар хүлээн зөвшөөрөхийн тулд Компани нь ангиллыг дахин үнэлэх байдлаар гүйлгээг шатлалын түвшин хооронд шилжсэн эсэхийг тайлант үеийн эцэст тодорхойлдог (энэ нь бодит үнэ цэнийг бүхэлд нь хэмжихэд чухал ач холбогдол үзүүлэх хамгийн доод түвшний өгөгдөлд тулгуурласан байдаг).

Шатлал хоорондын шилжилт

Бодит үнэ цэнээр хэмжигдсэн хөрөнгө, өр төлбөрийн 1-ээс 3 хүртэлх шатлал хооронд ямар нэгэн шилжих хөдөлгөөн байгаагүй.

ШУНХЛАЙ ХХК
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Түсдаа Санхүүгийн Тайлангийн Тодруулга

28. Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ

(1) 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилд ажил гүйлгээ хийсэн холбоотой талуудын үндсэн ангилал дараах байдалтай байна:

Компанийн нэр	2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх хамаарал
(а) Толгой компани	
Шунхлай Холдинг ХХК	Эцсийн өмчлөгч
(б) Компанийн охин компаниуд	
Эс Жи Шивээ Хүрэн Депо ХХК	100% эзэмшлийн охин компани
Эс Жи Ханги Гэйт ХХК	100% эзэмшлийн охин компани
Шунхлай Ойл ХХК	100% эзэмшлийн охин компани
(в) Зэргэлдээ охин компаниуд	
Шунхлай Трейдинг ХХК	Шунхлай Холдинг ХХК-ийн охин компани
Шунхлай Говь ХХК	Шунхлай Холдинг ХХК-ийн охин компани
Шунхлай Петролиум ХХК	Шунхлай Холдинг ХХК-ийн охин компани
АПУ ХК	Шунхлай Холдинг ХХК-ийн охин компани
Ди Эс Жи ХХК	Шунхлай Холдинг ХХК-ийн охин компани
Жи Эс Би Капитал ББСБ ХХК	Шунхлай Холдинг ХХК-ийн охин компани
Пауэр-Юнит ХХК	Шунхлай Холдинг ХХК-ийн охин компани
Эс Девелопмент ХХК	Шунхлай Холдинг ХХК-ийн охин компани
Эс Системс ХХК	Шунхлай Холдинг ХХК-ийн охин компани
Эс Ди Инженеринг ХХК	Шунхлай Холдинг ХХК-ийн охин компани
Сантранс Ложистик ХХК	Шунхлай Холдинг ХХК-ийн охин компани
Зеро Технологи ХХК	Шунхлай Холдинг ХХК-ийн охин компани
(г) Бусад холбоотой талуудаа*	
Эн Ти Ви Броакастинг ХХК	Медиа Групп ХХК-ийн охин компани

*Тайлант жилд Компанитай ажил гүйлгээ хийгээгүй бусад холбоотой талуудыг дээрх жагсаалтад оруулаагүй болно.

МОНГОЛЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГЭРЭЭ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2026 -09- 02
БҮРТГЭВ-03
СЗХ
2026 .09. 1 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Түсдаа Санхүүгийн Тайлангийн Тодруулга

28. Холбоотой талууд, үргэлжлэл

(2) 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилд холбоотой компаниудтай хийсэн ажил гүйлгээ дараах байдалтай байна:

(Мянган төгрөгөөр)	Ажил гүйлгээний дүн	
	2024	**2023**
Борлуулалт		
Охин компаниуд	23,785,905	2,855,646
Зэргэлдээ охин компаниуд	1,369,322,342	1,167,202,872
Нийт	**1,393,108,247**	**1,170,058,518**
Худалдан авалт		
Охин компаниуд	246,285	-
Зэргэлдээ охин компаниуд	-	3,070,411
Нийт	**246,285**	**3,070,411**
Үл хөдлөх хөрөнгийн худалдан авалт		
Зэргэлдээ охин компаниуд	1,259,770	-
Менежментийн төлбөр төлсөн		
Зэргэлдээ охин компаниуд	48,000	48,000
Эрхийн шимтгэлийн төлбөр		
Эцсийн өмчлөгч	210,180	224,892
Менежментийн төлбөр хүлээн авсан		
Охин компаниуд	191,263	78,262
Зэргэлдээ охин компаниуд	5,007,451	5,053,098
Нийт	**5,198,714**	**5,131,360**

(3) Холбоотой компаниудтай хийсэн ажил гүйлгээний дансны үлдэгдэл дараах байдалтай байна.

(Мянган төгрөгөөр)	Үлдэгдэл дүн	
	2024.12.31	**2023.12.31**
Дансны болон бусад авлага		
Эцсийн өмчлөгч	534,907	831,306
Охин компаниуд	40,130,945	17,554,347
Зэргэлдээ охин компаниуд	158,706,303	191,664,587
Бусад холбоотой талууд	32,047	27,226
Нийт	**199,404,202**	**210,077,466**
Дансны болон бусад өглөг		
Охин компаниуд	-	1,000
Зэргэлдээ охин компаниуд	3,489	-
Бусад холбоотой талууд	-	250
Нийт	**3,489**	**1,250**

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ
ТТА 531 ᠔ 2028468
139
Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
1119289111 ᠔ 5481589
Улаанбаатар хот
2026.08.31

ШУНХЛАЙ
2026 09 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛ УЛСЫН ХӨРӨНГӨ ОНЦГОЙ БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2026 -09- 02
БҮРТГЭВ-03

ШУНХЛАЙ ХХК
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дүүсгавар болсон тайлант жилийн
Түсдаа Санхүүгийн Тайлангийн Тодруулга

28. Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ, үргэлжлэл

(4) 12 дугаар сарын 31-ний өдрөөр дүүсгавар болсон тайлант жилд удирдах гол албан тушаалтнуудад олгосон цалин хөлс дараах байдалтай байна:

(Мянган төгрөгөөр)	**2024**	**2023**
Цалин	2,133,643	2,220,309
Нийгмийн даатгалын шимтгэл	265,942	315,523
Нийт	**2,399,585**	**2,535,832**

29. Үүрэг хариуцлага болон болзошгүй зүйлс

(1) Капитал

Компани 2024 болон 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрүүдийн байдлаар үндсэн хөрөнгө худалдан авах үүрэг хүлээгээгүй байна.

(2) Хуулль, эрх зүй

Компани нь үйлчлүүлэгчдээс төлөгдөөгүй авлагыг нөхөхийн тулд ердийн бизнесийн үйл ажиллагааны явцад янз бүрийн хуулийн ажиллагаанд оролцдог. Удирдлага нь ийм үйлдлийн үр дүн нь санхүүгийн байдал эсвэл үйл ажиллагааны үр дүнд материаллаг нөлөө үзүүлнэ гэдэгт итгэдэггүй.

(3) Борлуулалтын үүрэг хариуцлага

Компани 2024 болон 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрүүдийн байдлаар ямар нэгэн борлуулалтын үүрэг хариуцлага хүлээгээгүй байна.

30. Тайлангийн дараах үйл явдал

2025 оны 5 дугаар сарын 12-ны өдөр Шунхлай ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс нэгж хувьцаанд 1,700 мянган төгрөгийн, нийт 2,816,948 мянган төгрөгийн ногдол ашиг зарлахаар шийдвэрлэсэн.

31. Монгол орчуулга

Энэхүү түсдаа санхүүгийн тайлангууд нь Англи болон Монгол хэл дээр бэлтгэгдсэн бөгөөд Англи болон Монгол орчуулгын хооронд утга агуулгын зөрүү үүссэн тохиолдолд Англи орчуулга нь хүчин төгөлдөр байна.

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
УБ-А3531 эц 2028466

140

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
1119289111
Улаанбаатар хот

2026.08.31

ШУНХЛАЙ ХХК

Санхүүгийн тайлан болон
Хараат бус аудиторын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31

АГУУЛГА	ХУУДАС
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	
УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ	
ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	1
ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН	2
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	3
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	4
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД	5

ШУНХЛАЙ СЗХ 2026.09.10 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР MONGOLIAN STOCK EXCHANGE 2026-09-02 БҮРТГЭВ-03

Ерөнхий мэдээлэл

КОМПАНИЙН НЭР	Шунхлай ХХК
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	П.Батсайхан
ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА	Ж.Мөнхнаран
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ДУГААР	9011038082
РЕГИСТРИЙН ДУГААР	2028468
АЛБАН ХАЯГ	Шунхлай ХХК Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 19 дүгээр хороо, Чингисийн өргөн чөлөө, Капитал хаус 3 дугаар давхар
АУДИТОР	Ниямазон Аудит ХХК Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2 дугаар хороо, Чойнболын гудамж, Нийслэлийн үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны байр, 406 тоот

УЛААНБААТАР ХОТ ШУНХЛАЙ ХХК ТТА3531 ☎ 2028468

Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital Delivering diversity 1119289111 ☎ 5481589 Улаанбаатар хот

2026.08.31

ШУНХЛАЙ ХХК
2026 09. 10
БҮРТГЭВ
№ 01

БҮРТГЭЛ ХАРИУЦЛАГЫН ЗУЧХ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2026 -09- 02
БҮРТГЭВ-03

Шунхлай

Хаяг: УБ шуудан-101 040 128, Үйлдвэр-2-1, Чингисийн өргөн чөлөө-48/1, Улаанбаатар-17040, Хан-Уул дүүрэг, 19-р хороо,
Капитал хуч, 3 дүгээр давхар
Утас: 976-70071003, 976-91973003
Цахим хаяг: info@shunkhlai.com, www.shunkhlai.com

2026-06-06 № 8/1026

танай _____ -ны № _____

УДИРДЛАГЫН ХАРИУЦЛАГЫН МЭДЭГДЭЛ

2026 оны 06–р сарын 10 өдөр

ШУНХЛАЙ ХХК-ийн

Гүйцэтгэх захирал Ж.Менхнаран болон ерөнхий Санхүү хариуцсан захирал Ж.Оюумаа, Ерөнхий нягтлан бодогч О.Золбоо бид нар энд хавсаргасан санхүүгийн тайлан нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн болохыг батламжилж байна.

Ж.Менхнаран
Гүйцэтгэх захирал

Ж.Оюумаа
Санхүү хариуцсан захирал

О.Золбоо
Ерөнхий нягтлан бодогч

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
УБ0531 ᠓ 2028460

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
1119289111 ᠓ 281589
Улаанбаатар хот

ШУНХЛАЙ СЗХ 2025 .09. 10 өдөр БҮРТГЭВ № 01

2026 -09- 02 БҮРТГЭВ-03

ШУНХЛАЙ ХХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

NIYAMAZON AUDIT LLC
#406, Building of Trade Union Federation,
Choimbol street, Chingeltei district,
Ulaanbaatar 15172, Mongolia
Tel: (976) 70145908, 91005908
E-mail: audit@nmz.mn

2026.06.10 № A/26-64

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Дүгнэлт

Бид Шунхлай ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусвар болсон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр хавсаргасан санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Шунхлай ХХК-ийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусвар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (СТОУС)-ын дагуу үнэн, бодитой илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэлээ. Энэхүү стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагын талаар тус тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт тусгасан. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс батлагдсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол Улсын Аудитын тухай хуулийн шаардлагын дагуу компаниас хараат бус байж бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болсон гэдэгт бид итгэлтэй байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэлд жилийн тайланд орсон мэдээллийг хамруулж ойлгох ба санхүүгийн тайлангуудын талаарх аудитын дүгнэлтэд бусад мэдээлэл хамрагдаагүй бөгөөд бид түүнтэй холбоотой аудитын аливаа төрлийн баталгаа дүгнэлтийг илэрхийлэхгүй.

Санхүүгийн тайланд хүлээх удирдлагын үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу залилан болон алдаанаас улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийллээс ангид бэлтгэхэд шаардлагатай гэж тодорхойлсон дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага нь компанийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх ба нөлөөлөх асуудлыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримтлах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналаас санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Хэдийгээр үндэслэлтэй баталгаа нь өндөр түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг олж илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй. Буруу илэрхийлэл нь залилан болон алдааны улмаас үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцно.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

2026.08.31

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл иттэх байр сууринаас хандаж, мэргэжлийн иттэл үнэмшил бүхий үнэлэлтийг хийдэг. Бид мөн:

- Залилан болон алдааны улмаас үүсэж болох санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, тохирох аудитын горимыг боловсруулж, дүгнэлтийн үндэслэл болохуйц нотолгоог олж авдаг. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэгтэй холбоотой үүсдэг тул алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлгож олж авдаг.
- Удирдлагын зүгээс мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал болон хийсэн тооцооллуудын үндэслэлтэй байдал, холбогдох тодруулгуудыг үнэлдэг.
- Компанийн үйл ажиллагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Тодруулгуудыг оролцуулан санхүүгийн тайлангийн ерөнхий агуулга болон бүтцийг бүхэлд нь үнэлдэг ба ач холбогдол бүхий ажил гүйлгээ, үйл явдлуудыг санхүүгийн тайланд үнэн зөв тодруулах шаардлагыг хангахуйц байдлаар илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид засаглал хариуцсан эрх бүхий этгээдэд аудитын үйл ажиллагааны төлөвлөсөн цар хүрээ, аудит гүйцэтгэх цаг хугацаа болон аудитын явцад олж илрүүлсэн томоохон асуудлуудын талаар мэдээлдэг бөгөөд үүнд дотоод хяналтын дутагдалтай талууд мөн багтдаг.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг талуудын хооронд байгуулсан аудитын ажлын гэрээт захидалд заасны дагуу компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

З.Цээнэ
Захирал
Ниямазон аудит ХХК

Улаанбаатар хот, Монгол Улс
2026 оны 06 дугаар сарын 10

Шунхлай ХХК

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

	Тодруулга	2024 мян.төг	2025 мян.төг
хөрөнгө			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	3	2,225,235.4	8,819,241.6
Дансны авлага	4	258,198,711.8	227,009,669.0
Татвар, НДШ-ийн авлага	5	4,712,246.0	2,603,103.5
Бусад авлага	6	4,272,127.9	2,403,131.0
Бараа материал	7	57,713,825.0	80,207,021.2
Урьдчилж төлсөн зардал тооцоо	8	3,269,078.0	11,193,659.5
Үндсэн хөрөнгө	9	30,120,922.4	44,779,786.6
Биет бус хөрөнгө	10	1,426,585.4	1,641,918.5
Урт хугацаат хөрөнгө оруулалт		1,000,000.0	6,300,000.0
Хойшлогдсон татварын хөрөнгө		-	11,320.2
Бусад эргэлтийн хөрөнгө		33,488,205.0	55,021,806.4
нийт хөрөнгө		**396,426,936.9**	**439,990,657.5**
өр төлбөр			
Дансны өглөг	11	60,457,503.8	128,792,650.2
Татварын өр	12	879,783.3	1,870,017.8
Богино хугацаат зээл	13	170,161,152.6	228,067,776.1
Хүүний өглөг		4,114,585.1	5,306,935.7
Урьдчилж орсон орлого		71,850.9	-
Бусад богино хугацаат өр төлбөр		116,696.5	310,617.1
Урт хугацаат зээл	14	124,143,991.8	36,979,000.0
Хойшлогдсон татварын өр		14,174.5	5,652.4
Бусад урт хугацаат өр төлбөр		-	-
нийт өр төлбөр		**359,959,738.5**	**401,332,649.3**
эздийн өмч			
Хувийн өмч		165,700.0	165,700.0
Хуримтлагдсан ашиг		36,301,498.4	38,492,308.2
нийт эздийн өмч		**36,467,198.4**	**38,658,008.2**
нийт өр төлбөр ба эздийн өмч		**396,426,936.9**	**439,990,657.5**

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

НИЙМАЗОН АУДИТ ХХК 1

2026.08.31

Шунхлай ХХК

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСВАР БОЛГОСОН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

	Тодруулга	2024 мян.төг	2025 мян.төг
Борлуулалтын орлого	15	1,413,383,372.4	1,644,908,483.5
Борлуулалтын өртөг	16	1,322,007,088.0	1,543,797,978.0
Нийт ашиг		**91,376,284.4**	**101,110,505.5**
Түрээсийн орлого			
Хүүний орлого		46,331.5	64,066.5
Бусад орлого		-	929,253.9
Борлуулалт, маркетингийн зардал	17	870,359.4	1,711,320.3
Ерөнхий ба удирдлагын зардал	18	16,398,863.5	25,205,507.9
Санхүүгийн зардал		51,661,645.9	53,990,689.9
Бусад зардал		5,068,319.3	7,147,380.7
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		(2,523,318.6)	(4,420,726.6)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		23,582.6	(10,501.2)
Бусад ашиг (алдагдал)		-	(73,524.8)
Татварын төлөхийн өмнөх ашиг		**14,923,691.8**	**9,544,174.5**
Орлогын татварын зардал		3,349,808.1	35,944.0
Цэвэр ашиг (алдагдал)		**11,573,883.7**	**9,508,230.5**

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

2026.08.31

ШУНХЛАЙ СЭХ 2026.09.19 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГӨ ОГЛОГЧДЫН ЭРХЭМ MONGOLIAN STOCK EXCHANGE 2026-09-02 БҮРТГЭВ-03

Шунхлай ХХК

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСВАР БОЛГОСОН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт эздийн өмч
	мян.төг	мян.төг	мян.төг
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	**165,700.0**	**24,727,614.7**	**24,893,314.7**
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг	-	11,573,883.7	11,573,883.7
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	**165,700.0**	**36,301,498.4**	**36,467,198.4**
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	(4,500,472.7)	(4,500,472.7)
Тайлант үеийн цэвэр ашиг	-	9,508,230.5	9,508,230.5
Зарласан ногдол ашиг	-	2,816,948.0	2,816,948.0
2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	**165,700.0**	**38,492,308.2**	**38,658,008.2**

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

УЛААНБААТАР ХОТ ШУНХЛАЙ ХХК 2028466

Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital Delivering diversity 1119289111 5481589 Улаанбаатар хот

Шунхлай ХХК

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСВАР БОЛГОСОН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

	2024 мян.төг	2025 мян.төг
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,007,701,033.4	2,096,302,843.1
Бусад мөнгөн орлого	19,138,335.0	28,112,333.9
Ажиллагчдад төлсөн	5,820,282.7	7,152,833.0
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,575,881.1	2,000,859.0
Бараа материал худалдан авахад төлсөн	1,855,394,832.3	1,931,686,792.7
Ашиглалтын зардалд төлсөн	1,860.8	7,526.7
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	438,718.8	497,813.3
Хүүний төлбөрт төлсөн	40,915,841.5	52,867,592.3
Татварын байгууллагад төлсөн	29,966,383.2	7,196,254.0
Даатгалын төлбөрт төлсөн	592,907.7	775,201.4
Бусад мөнгөн зарлага	36,287,319.8	45,632,408.4
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	**55,845,340.5**	**76,597,896.2**
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
Хүлээн авсан хүүний орлого	44,686.1	54,895.0
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	28,742,644.8	34,512,602.6
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	50,758.2	-
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	499,000.0	230,000.0
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	**(29,247,716.9)**	**(34,687,707.6)**
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	2,010,955,477.2	2,282,144,792.7
Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	682,845.1	520,255.4
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	2,038,091,726.9	2,312,759,843.0
Төлсөн ногдол ашиг	-	2,535,253.3
Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	2,976,010.2	2,686,134.2
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	**(29,429,414.8)**	**(35,316,182.4)**
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	**(2,831,791.2)**	**6,594,006.2**
МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	5,057,026.6	2,225,235.4
МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	2,225,235.4	8,819,241.6

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

НИЯМАЗОН АУДИТ ХХК 4

2026.08.31

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

1. Танилцуулга

Шунхлай ХХК /Компани/ нь 1995 онд байгуулагдсан бөгөөд хүчин төгөлдөр дүрмийн дагуу компанийн үндсэн үйл ажиллагаа нь:

-шатахууны бөөний худалдаа
-шатахууны жижиглэнгийн худалдаа
-худалдааны зуучлал
-зорчигч тээврийн үйлчилгээ

Компанийн хувьцааг 100 хувь Шунхлай холдинг ХХК эзэмшдэг ба хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 165.7 сая төгрөг.

Эдгээр санхүүгийн тайлангууд нь Компанийн Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан заавар, маягтын дагуу бэлтгэгдсэн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлангуудаас бүрдэнэ.

Бид аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, Монгол Улсад мөрдөж буй аудитын хууль тогтоомжийг баримтлан ажилласан. Аудитын дүгнэлт гаргахдаа тус компаниас бидэнд танилцуулсан санхүүгийн баримт, материалд үндэслэсэн болно. Аудитын явцад бидэнд танилцуулаагүй аливаа баримт материалаас үүсэх хариуцлагыг манай аудитын байгууллага хүлээхгүй юм.

2. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд

Санхүүгийн тайлан бэлтгэсэн суурь

Компанийн тайлангууд нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу түүхэн өртгөөр бүртгэх тогтсон зарчмыг баримтлан бэлтгэгдсэн ба энэ зарчим нь бодит үнэ цэнээрх тодорхой санхүүгийн хэрэгслүүдийн бодит үнэ цэнэ болон бодит үнэ цэнийн үнэлгээн дээр үндэслэн санхүүгийн анхлан хүлээн зөвшөөрөх өөрчлөлтийг тусгасан. Компани өөрийн санхүүгийн байдлын тайланг хөрвөх чадварын дараалаар толилуулдаг. Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн хураангуйлсан үндсэн бодлогуудыг дор толилуулав. Өөрөөр заагаагүй санхүүгийн тайлагналын хугацааны туршид эдгээр бодлогыг тогтмол баримталдаг.

Нягтлан бодох бүртгэлийн гол үнэлэмж, тооцоолол, таамаглалууд

Компанийн санхүүгийн тайланг бэлтгэхийн тулд удирдлага нь санхүүгийн тайланд орлого ба зардал, хөрөнгө ба өр төлбөр, болзошгүй өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх, холбогдох тодруулгуудыг бэлтгэхэд шаардлагатай үнэлэмж, таамаглал тооцооллуудыг хийдэг. Нягтлан бодох бүртгэлийн тооцоололд хийсэн өөрчлөлтийг зөвхөн нөлөөлж байгаа тайлант үед эсхүл ирээдүйн болон одоогийн тайлант үеүдэд нөлөөлөх бол ирээдүйн болон одоогийн тайлант үеүдэд тус тус тусгадаг.

Тайлангийн мөнгөн тэмдэгт

Эдгээр санхүүгийн тайлангуудыг барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа явуулдаг эдийн засгийн анхдагч орчны мөнгөн тэмдэгт буюу үндэсний мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөгөөр илэрхийлсэн.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь дуусвар хугацаа нь худалдан авч эзэмшсэнээс хойш 3 сар болон түүнээс богино хугацаагаар тодорхойлогдсон бөгөөд бодит үнэ цэнэ өөрчлөгдөхөд өчүүхэн төдий эрсдэлийг мэдэрдэг, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хувирдаг, компанийн удирдлага богино хугацаат өр төлбөрийг барагдуулах зорилгоор эзэмшиж буй бэлэн мөнгө болон банк санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгөн хөрөнгөөс бүрдэнэ.

Бараа материал
Бараа материалын өртгийг дундаж өртгийн аргаар тодорхойлдог ба бараа материалыг анх олж эзэмшсэн өртгөөр нь бүртгэлд тусгана. Байнгын системээр бараа материалын бүртгэлийг хөтөлж буй үед тайлант үеийн эцэс бүр бараа материалын бүртгэлээр тодорхойлсон дүн нь биет тооллогын дүнгээс зөрүүтэй байвал бараа материалын дүнд залруулах бичилт хийдэг. Хэрэв бараа материалын цэвэр боломжит үнэ цэнэ нь анх олж эзэмшсэн өртгөөс бага тохиолдолд бараа материалын үнэ цэнийн бууралтын гарз үүсэх бөгөөд уг гарзыг тухайн тайлант хугацаанд үйл ажиллагааны зардлаар хүлээн зөвшөөрдөг.

НИЙМАЗОН АУДИТ ХХК 5

УЛААНБААТАР ХОТ ШУНХЛАЙ ХХК ТТА3931 ☎ 2028488

151

Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital Delivering diversity 1119289111 ☎ 5481589 Улаанбаатар хот

2026.08.31

Үнэт цаасны танилцуулга

Цэвэр болонжит үнэ цэнэ гэж бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад бараа материалыг худалдан борлуулахаар тооцоолж буй үнээс түүнийг иж бүрдэл болгохоор тооцсон зардал ба борлуулахад шаардагдах тооцсон зардлыг хассан дүн юм.

Урьдчилгаа төлбөр

Урьдчилгаа төлбөр нь мөнгөн хэлбэрээр төлөгдсөн боловч зардал нь хараахан гараагүй төлбөр эсвэл хүлээн аваагүй бараа материалын төлбөрөөс бүрдэнэ. Урьдчилгаа төлбөрийг анх өртгөөр бүртгэх ба төлөгдсөн мөнгөн дүнгээр нь хэмжинэ. Уг төлбөрийг тухайн зардал нь гарсан тохиолдолд эсвэл хугацаа дусах үед ашиг, алдагдал руу болон бараа материалыг хүлээн авсан тохиолдолд холбогдох хөрөнгөнд ангилдаг.

Урьдчилгаа төлбөртэй холбоотой бүтээгдэхүүний өртөг эсвэл үйлчилгээ нь нэг жилийн дотор зарлагадах бол урьдчилгаа төлбөрийг санхүүгийн байдлын тайланд эргэлтийн хөрөнгөөр ангилна. Бусад тохиолдолд эргэлтийн бус хөрөнгөөр ангилна.

Тайлант жилийн эцэст компани урьдчилгаа төлбөрийн дансны үнэд хяналт тавьж, үнэ цэний бууралт гарсан эсэхийг тодорхойлдог.

Үндсэн хөрөнгө

Тайлант хугацаа бүрийн эцэст үйлчилгээ үзүүлэх эсхүл захиргааны зорилгоор эзэмшиж буй барилга болон газраас бүрдсэн үл хөдлөх хөрөнгийг бодит үнэ цэнээс хуримтлагдсан элэгдэл болон үнэ цэний бууралтын алдагдлыг хассан дүнгээр тусгадаг. Бусад бүх үндсэн хөрөнгө ба тоног төхөөрөмжийг анхны өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон үнэ цэний бууралтын алдагдлыг (хэрэв байгаа бол) хассан дүнгээр тусгадаг.

Үйлчилгээ үзүүлэх эсхүл захиргааны зорилгоор ашиглагдах дуусаагүй барилгыг анхны өртгөөс бүртгэгдсэн үнэ цэний бууралтыг хассан дүнгээр тусгадаг. Эдгээр дуусаагүй барилгыг ашиглагдах зорилготой нь нийцүүлэн тохирох үндсэн хөрөнгө ба тоног төхөөрөмжийн ангилалд баригдаж дуусан үед нь ангилна. Эдгээр хөрөнгийг ашиглагдах зорилгод хэрэглэх боломжтой болсон үеэс бусад үндсэн хөрөнгүүдийн адил сууриар тооцон элэгдүүлж эхэлнэ.

Үндсэн хөрөнгөтэй холбоотой гарсан дараа үеийн зардал нь тухайн хөрөнгийн анх тооцсон бүтээмжийн түвшнийг нэмэгдүүлэх замаар компанид эдийн засгийн ирээдүйн өгөөжийг авчрах магадлалтай үед өртгөөр үндсэн хөрөнгийн дансны үнийг нэмэгдүүлдэг. Бусад бүх худалдан авалтын дараа гарсан зардлуудыг гарсан тайлант үед нь зардлаар бүртгэнэ.

Хөрөнгө тус бүрийн өртгийг үлдэх өртөг хүртэл нь, ойролцоолон тооцоолсон дараах ашиглалтын хугацааны туршид, шулуун шугамын аргаар элэгдүүлнэ.

Барилга	40 жил
Тоног төхөөрөмж	10 жил
Тавилга, эд хогшил	10 жил
Тээврийн хэрэгсэл	10 жил
Компьютер, техник хэрэгсэл	2 жил

Тооцоолсон ашиглалтын жил, үлдэх өртөг болон элэгдлийг тооцох аргыг тайлан гаргах өдрөөр хянаж үздэг ба тооцооллыг өөрчлөх шаардлагатай байвал нөлөөллийг нь ирэх жилүүдэд залруулдаг.

Үндсэн хөрөнгийг ашиглалтаас хасах үед болон тухайн хөрөнгийг үргэлжлүүлэн ашигласнаар ямар нэгэн эдийн засгийн үр өгөөж олохгүй гэж үзвэл бүртгэлээс хасдаг. Үндсэн хөрөнгийн зүйлийг ашиглалтаас хассан, зарж борлуулснаас үүсэх ашиг, алдагдлыг худалдан борлуулсан үнэ ба хөрөнгийн дансны үнэ хоёрын зөрүүгээр тодорхойлох ба тухайн жилийн ашиг, алдагдалд тусгана.

Биет бус хөрөнгө

Ашиглагдах жил нь тодорхой, тусад нь худалдан авсан биет бус хөрөнгийг өртгөөс нь хуримтлагдсан элэгдэл ба үнэ цэний бууралтын алдагдлыг хассан дүнгээр хэмжинэ. Биет бус хөрөнгийн хорогдлыг шулуун шугамын аргаар биет бус хөрөнгийн ашиглалтын жилээр тооцоолон хүлээн зөвшөөрдөг. Тооцоолсон ашиглалтын жил болон хорогдол бодох аргыг тайлан гаргах өдрөөр хянаж үздэг ба тооцооллыг өөрчлөх шаардлагатай байвал нөлөөллийг нь ирэх жилүүдэд залруулдаг.

Ашиглагдах жил нь тодорхойгүй, тусад нь худалдан авсан биет бус хөрөнгийг өртгөөс нь үнэ цэний бууралтын алдагдлыг хассан дүнгээр хэмжинэ.

Биет бус хөрөнгийн ашиглалтын жил нь 2-10 жил байна.

Биет бус хөрөнгийг ашиглалтаас хасах үед болон тухайн хөрөнгийг үргэлжлүүлэн ашигласнаар ямар нэгэн эдийн засгийн үр өгөөж олохгүй гэж үзвэл бүртгэлээс хасдаг. Биет бус хөрөнгийн зүйлийг ашиглалтаас хассан, зарж борлуулснаас үүсэх ашиг, алдагдлыг худалдан борлуулсан үнэ ба хөрөнгийн дансны үнийн зөрүүгээр тодорхойлох ба тухайн жилийн ашиг, алдагдалд тусгана.

Санхүүгийн хэрэглүүр

Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрүүдийг компани тухайн хэрэглүүртэй холбоотой гэрээт тал болох үед нь хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг анх бодит үнэ цэнээр нь бүртгэх ба үүнд гэрээт харилцагчдаас үүссэн дансны авлагыг СТОУС 9-ийн дагуу анх бүртгэнэ. Санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөр/ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр бүртгэдэг санхүүгийн хөрөнгө ба өрийн хэрэгслээс бусад/-ийг гаргах эсвэл худалдан авахтай шууд холбоотой гарсан зардлыг анх бүртгэлд тусгахдаа санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэ дээр нэмж эсвэл өр төлбөрийн бодит үнэ цэнээс хасаж бүртгэнэ.

Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр бүртгэдэг санхүүгийн хөрөнгө ба өрийн хэрэгслийг гаргах эсвэл худалдан авахтай шууд холбоотой гарсан зардлыг тухайн жилийн ашиг, алдагдлаар бүртгэнэ.

Санхүүгийн хөрөнгө

Ердийн журмаар худалдах, худалдан авах санхүүгийн хөрөнгийг бодит гүйлгээ гарсан өдрөөр нягтлан бодох бүртгэлд тусгах эсвэл бүртгэлээс хасдаг.

Ердийн журмаар худалдах, худалдан авах гэдэг нь тогтоосон хугацааны дотор эсвэл тухайн зах зээл дээр тогтсон дүрэм журмаар хөрөнгийг шилжүүлэх нөхцөлөөр санхүүгийн хөрөнгийг худалдах, худалдан авахыг хэлнэ.

Санхүүгийн хөрөнгийг ангиллаас нь хамааран анх бүртгэсний дараа хорогдуулсан өртгөөр эсвэл бодит үнэ цэнээр нь хэмждэг.

Дараах нөхцөлүүдийг хангасан өрийн хэрэгслүүд нь дараа үеүдэд хорогдуулсан өртгөөр хэмжигдэнэ.

- Мөнгөн урсгалыг цуглуулахын тулд санхүүгийн хөрөнгийг эзэмших зорилготой бизнесийн загвараар эзэмшдэг болон
- Зөвхөн үндсэн төлбөрийн төлөлт ба гэрээний нөхцөлөөр тодорхой заасан өдрөөрх төлөгдөөгүй үндсэн төлбөрийг үлдэгдэлд тооцсон хүүгийн төлбөрөөс бүрдэх төлбөрүүдийн мөнгөн урсгалыг тогтоосон хугацаанд хуваарийн дагуу хүлээн авах нөхцөлтэй байх

Дараах нөхцөлүүдийг хангасан өрийн хэрэгслүүдийг бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжинэ./БДОБҮЦ/

- Мөнгөн урсгалыг цуглуулахын тулд эсвэл арилжаалах зорилгоор санхүүгийн хөрөнгиийг эзэмших зорилго бүхий бизнесийн загвараар эзэмшдэг болон
- Зөвхөн үндсэн төлбөрийн төлөлт ба гэрээний нөхцөлөөр тодорхой заасан өдрөөрх төлөгдөөгүй үндсэн төлбөрийг үлдэгдэлд тооцсон хүүгийн төлбөрөөс бүрдэх төлбөрүүдийн мөнгөн урсгалыг тогтоосон хугацаанд хуваарийн дагуу хүлээн авах нөхцөлтэй байх

Хүүгийн орлогыг тайлант үеийн ашиг, алдагдлаар тайлагнадаг ба санхүүгийн орлого хэсэгт ангилна.

Компани нь зөвхөн санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгалыг хүлээн авах эрх дуусвар болсон эсвэл санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгалыг хүлээн авах эрх ба хөрөнгийг эзэмшихтэй холбоотой бүх эрсдэл болон өгөөжийг бусдад шилжүүлсэн үед санхүүгийн хөрөнгийг данснаас хасна. Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгийг данснаас хасахдаа тухайн хөрөнгийн дансны үнэ ба хүлээн авсан дүн болон авлагын нийлбэрийн зөрүүг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн өр төлбөр ба өмч

Гэрээний зохицуулалтын агуулга болон санхүүгийн өр төлбөр болон өмчийн хэрэгслийн тодорхойлолтын дагуу өр болон өмчийн хэрэгслийг санхүүгийн өр төлбөр эсвэл өмч гэж ангилдаг.

Өмчийн хэрэгсэл

2026.08.31

Үнэт цаасны танилцуулга
MONGOLIAN STOCK EXCHANGE
2026 -09- 02
БҮРТГЭЛ-03

Компанийн бүх хөрөнгөөс өр төлбөрийг хассаны дараа үлдэх хэсгээс хувь хүртэх нөхцөл бүхий аливаа гэрээг өмчийн хэрэгсэл гэдэг. Группээс гаргаж байгаа өмчийн хэрэгслийг хүлээн авсан мөнгөнөөс санхүүгийн хэрэгслийг гаргахтай холбоотой шууд зардлыг хассан дүнгээр хэмжиж бүртгэдэг.

Энгийн хувьцаа

Энгийн хувьцааг эздийн өмчийн хэсэгт ангилж бүртгэдэг. Энгийн хувьцаа нэмж гаргахтай холбоотой нэмэгдэл зардлыг татварын аливаа нөлөөллийн дараах цэвэр дүнгээр нь эздийн өмчийн бууралтаар хүлээн зөвшөөрдөг.

Хувьцаат капиталыг буцаан худалдан авах /халаасны хувьцаа/

Хувьцаат капиталыг буцаан худалдан авсан үед аливаа татварын нөлөөллийн дараах худалдан авахтай холбоотой гарсан шууд зардлыг багтаасан дүнгээр эздийн өмчийн бүртгэл гэж бүртгэдэг.

Буцаан худалдан авсан хувьцааг халаасны хувьцаа гэж нэрлэх бөгөөд өмчийн өөрчлөлтийн тайланд халаасны хувьцаа гэж тайлагнадаг.

Хувьцаат хувьцааг дахин борлуулсан эсвэл дахин эргэлтэд гаргасан үед хүлээн авсан дүнг өмчийн өсөлтөөр бүртгэдэг бөгөөд тухайн ажил гүйлгээтэй холбогдон гарсан өсөлт, бууралтыг нэмж төлөгдсөн капитал гэж толилуулдаг.

Хуримтлагдсан ашиг

Хуримтлагдсан ашиг нь компанийн өмчийн эздэд ногдох ашгаас зарласан ногдол ашгийг хассан дүн болно. Стандартад шилжилтийн шаардлагын дагуу нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөс үүссэн нөлөөллийг хуримтлагдсан ашигт бүртгэдэг.

Эздийн оруулсан хөрөнгө оруулалт

Хувьцаа эзэмшигчдийн зүгээс өмнө болон бусад мөнгөн бус хөрөнгөөр сайн дурын үндсэн дээр оруулсан хөрөнгө оруулалт нь тухайн хөрөнгийн бодит үнэ цэнээр эздийн өмчид шууд бүртгэгддэг.

Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц

Хөрвүүлэлтийн нөөц нь гадаад үйл ажиллагааны санхүүгийн тайлангийн хөрвүүлэлтээс үүссэн гадаад валютын ханшийн зөрүү болон компанийн гадаадын охин компанид оруулсан цэвэр хөрөнгө оруулалтыг хэйджинг хийсэн өр төлбөрийн хөрвүүлэлтээс үүссэн гадаад валютын хашийн зөрүүнээс бүрдэнэ.

Санхүүгийн өр төлбөр

Бүх санхүүгийн өр төлбөрийг анх бүртгэсний дараа үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр бүртгэдэг. Компанийн санхүүгийн өр төлбөр нь үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хэрэгслүүдээс бүрддэг.

Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн өр төлбөр

Үр ашигт хүүгийн арга гэдэг нь санхүүгийн өр төлбөрийн хорогдуулсан өртгийг тооцож холбогдох хугацааны туршид хүүгийн зардлыг хуваарилах арга юм. Үр ашигт хүүгийн хувь нь ирээдүйд төлөхөөр тооцоолсон бүх мөнгөн төлбөр /үр ашигт хүүгийн хувьд нөлөөлөх бүхий л төлбөр хураамж, ажил гүйлгээний зардал, хөнгөлөлт ураншууллыг багтаасан/-ийг санхүүгийн өр төлбөрийн хугацааны туршид эсвэл шаардлагатай тохиолдолд түүнээс богино хугацаанд хорогдуулахад хэрэглэдэг хүүгийн хувь юм.

Санхүүгийн өр төлбөрийг данснаас хасах

Компани нь санхүүгийн өр төлбөрийг гэрээний үүрэг биелэгдсэн, цуцлагдсан эсвэл гэрээний хугацаа дуусан тохиолдолд данснаас хасна. Данснаас хасаж буй санхүүгийн өр төлбөрийг дансны үнэ ба төлсөн дүн болон өглөгийн нийлбэрийн зөрүүг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

Орлого хүлээн зөвшөөрөлт

Бараа борлуулсны орлого, хөрөнгөө бусдад ашиглуулсны болон үйлчилгээ үзүүлсний орлогыг хүлээн авсан эсвэл хүлээн авахаар хүлээгдэж буй төлбөрийн бодит үнэ цэнээр нь хэмжих ба гарсан аливаа худалдаа, үйлчилгээний бүцаалт, хөнгөлөлт, үнийн бууралт зэргийг хассан цэвэр дүнгээр орлогыг хүлээн зөвшөөрнө.

Үйлчилгээ үзүүлсний орлого

Үйлчилгээний орлогод гэрээгээр гүйцэтгэсэн үйлчилгээний орлого хамаарна.Эдгээр орлогууд нь үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд орлогоор хүлээн зөвшөөрөгдөнө.

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
УА3531 ж 2025468
Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
1119289111
Улаанбаатар хот

Үйлчилгээнээс орох орлогыг тухайн ажил гүйлгээний тайлагналын өдрөөрх гүйцэтгэлийн үйл явцтай нь уялдуулан ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Үйлчилгээний гүйцэтгэлийн үйл явцыг гүйцэтгэсэн ажилд хийсэн судалгаанд үндэслэн үнэлдэг.

Бараа борлуулалтын орлого

Компани барааны өмчлөлтэй холбогдон үүсэх мэдэгдэхүйц эрсдэл эсвэл өгөөжийг худалдан авагч талд шилжүүлсэн, борлуулсан барааныхаа өмчлөлд холбогдох аливаа удирдлагын болон хяналтын үүргийг өөртөө хадгалаагүй, орлогын дүнг найдвартай хэмжих боломжтой, тухайн ажил гүйлгээний эдийн засгийн өгөөжийг хүртэх магадлалтай бөгөөд тухайн ажил гүйлгээтэй уялдаж гарсан ба цаашид гарах зардлыг найдвартай хэмжин тодорхойлж болохоор байгаа үед орлогыг хүлээн зөвшөөрдөг.

Гадаад валютын ажил гүйлгээ

Компанийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ компанийн тайлагналын валютаас бусад валютыг (гадаад валют) ажил гүйлгээ гарсан өдрийн ханшаар хөрвүүлэн бүртгэсэн.

Төгрөгөөс бусад мөнгөн тэмдэгт нь гадаад валют гэж тооцогддог ба гадаад валютаар хийгдсэн гүйлгээнүүдийг тухайн гүйлгээний өдрийн зах зээлийн ханшаар төгрөг рүү хөрвүүлдэг.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө болон өр төлбөрийг санхүүгийн байдлын тайлангийн өдрийн ханшаар төгрөг рүү хөрвүүлдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгө, хөрөнгө болон өр төлбөрүүдийн гүйлгээ хийгдсэн өдрөөс хойших ханшийн өөрчлөлтөөс үүсэн гарах өөрчлөлтийг гарсан цаг хугацаанд нь ашиг алдагдлаар бүртгэнэ.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийн хөрөнгө ба өр төлбөрийг тухайн гүйлгээний өдрийн зах зээлийн ханшаар хөрвүүлдэг. Ханшийн зөрүүнээс үүссэн зөрүүг орлогын дэлгэрэнгүй тайланд тусган эздийн өмчийн хэсэгт хуримлуулан бүртгэнэ.

Зардал хүлээн зөвшөөрөлт

Зардлыг орлогын дэлгэрэнгүй тайланд зардлын чиг үүргийн аргыг ашиглан тайлагнадаг. Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт борлуулсан барааны бүтээгдэхүүнтэй шууд холбоотой зардлууд багтдаг. Компанийн үйл ажиллагааны зардалд ерөнхий ба удирдлагын, борлуулалт ба маркетингийн болон бусад бизнесийн үйл ажиллагааны зардлууд ордог.

Санхүүгийн орлого ба санхүүгийн зардал

Санхүүгийн орлого нь хүүгийн орлого ба ногдол ашгийн орлогоос бүрдэх ба ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөн бүртгэлд тусгагддаг. Хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргыг ашиглан орлогын тайланд хуримтлуулан хүлээн зөвшөөрдөг. Ногдол ашгийн орлогыг Компанид ногдол ашиг хүлээн авах эрх үүссэн үед нь хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

Санхүүгийн зардал нь зээлийн хүүгийн зардлаас бүрдэх ба ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрөгдөн бүртгэлд тусгагддаг. Шалгуурт нийцсэн хөрөнгийн олж бэлтгэх, барьж байгуулах ба үйлдвэрлэхэд шууд холбоотой хүүгийн зардлыг тэдгээр хөрөнгийн өртөгт оруулж бүртгэдэг. Шалгуурт нийцсэн хөрөнгө гэдэг нь түүнийг зориулалтаар нь ашиглах эсвэл борлуулахад бэлэн болгоход их хэмжээний хугацаа зарцуулдаг хөрөнгийг хэлэх ба үг хөрөнгийг ашиглах ба борлуулахад бэлэн болгох хүртэлх хугацаанд хүүгийн зардлыг хөрөнгийн өртөгт оруулдаг.

Зориулалт нь тодорхой зээлийг холбогдох хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж эхлэх хүртэл эсвэл борлуулахад бэлэн болсон нь тодорхой болсон үед зээлийг ерөнхий зээлийн капиталжуулалтын түвшинг тооцох зорилгоор зээлийн ерөнхий санд байлгадаг. Тодорхой зээлийг тур хугацаагаар хөрөнгө оруулалт хийх зорилгоор олж авсан хөрөнгө оруулалтын орлого нь шаардлага хангасан хөрөнгөнд зарцуулагдах хүртэл хүлээгдэж байна. Зээлийн хүүгийн зардлаас хасаж хөрөнгийн зориулалт нь тодорхой зээлээрх тур хөрөнгө оруулалтаас олсон хөрөнгө оруулалтын орлогын зарцуулалтыг зээлийн өртөөс хасаж капиталжуулан хөрөнгийн өртөгт бүртгэнэ.

Орлогын татвар

Орлогын татварын зардал нь тайлант үеийн татвар болон хойшлогдсон татвараас бүрддэг. Орлогын татварын зардлыг өмчийн дансанд шууд хүлээн зөвшөөрдөг зүйлстэй холбоотойгоос бусад тохиолдолд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА
2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Тайлант үеийн татвар гэдэг нь өмнөх жилүүдийн татварын өрийн тохируулга болон тайлант үеийн эцэст хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан эсвэл мөрдөгдөж байгаа татварын хувь хэмжээг ашиглан тухайн жилийн татвар ногдох ашиг, татварын алдагдалд суурилан хүлээгдэж буй татварын өр эсвэл авлага юм.

Татвар ногдох орлого бий болох нь тодорхой болсон бүх татвар ногдох түр зөрүүнд хойшлогдсон татварыг хүлээн зөвшөөрдөг. Тайлант үеийн эцсээр хүчин төгөлдөр болсон эсвэл хүчин төгөлдөр мөрдөж байгаа татварын хувь хэмжээ (татварын хууль)-нд үндэслэсэн хөрөнгө нь хэрэгжих буюу өр төлбөрийг төлөх тайлант үед мөрдөгдөхөөр хүлээгдэж буй татварын хувь хэмжээгээр хойшлогдсон татварыг хэмждэг.

Компани тайлант жилийн болон хойшлогдсон татварын дүнг тодорхойлохдоо татвартай холбоотой тодорхойгүй нөхцөл байдал, нэмэлт татвар болон хүү төлөгдөх магадлал гэх мэт хүчин зүйлсийн нөлөөг тооцож үздэг. Татварын хууль тогтоомжийн тайлбар, өмнөх жилүүдийн туршлага гэх мэт олон хүчин зүйлсийг үнэлсний үндсэн дээр компани татварын өр төлбөрөө нэмэлттэй татварын жилүүдэд хангалттай хэмжээнд хуримтлуулсан гэж үзэж байна. Энэхүү үнэлгээ нь компанийн ирээдүйн үйл явдлын талаарх тооцоолол, таамаглал болон олон хувилбарт үндэслэдэг.Одоогийн хуримтлуулсан татварын өр төлбөрийн хангалттай байдлын талаарх компанийн үнэлэмжид нөлөө үзүүлж болохуйц шинэ мэдээлэл, нөхцөл байдал үүсэж болох юм. Энэхүү нөлөө нь тухайн өр төлбөрийг тодорхойлсон тайлант хугацааны татварын зардалд нөлөөлнө.

Компани хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн цэвэр дүнг гаргах хууль ёсны хүчин төгөлдөр эрхтэй бөгөөд түүнд ногдуулсан татварыг тухайн компанийг хариуцсан татварын байгууллагаас ногдуулсан тохиолдолд хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг цэвэр дүнгээр тайлагнаж болно. Ашиглагдаагүй татварын алдагдал, хөнгөлөлт болон татвар ногдох орлогоос хасагдах түр зөрүүг тэдгээрийг ашиглаж болохуйц хэмжээний ирээдүйн татвар ногдох орлого олох нь магадлалтай хэмжээгээр хойшлогдсон татварын хөрөнгөөр хүлээн зөвшөөрдөг.

СЭХ 2026 оны 1 дэх БҮРТГЭВ № 01

2026 -09- 02 БҮРТГЭВ-03

Шунхлай ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар

3. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

(мян.төг)

Ангилал	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
КАСС ДАХЬ МӨНГӨ		
Бэлэн мөнгө-Төгрөг	712,719.5	76,589.9
Бэлэн мөнгө-Ан доллар	196,325.1	58,509.9
Бэлэн мөнгө-Юань	3,097.2	3,363.0
Бэлэн мөнгө-Рубль	-	1,604.0
БАНКИН ДАХЬ МӨНГӨ		
Харилцах данс-Төгрөг	548,236.8	7,450,708.9
Харилцах данс-Ан доллар	460,047.6	744,777.5
Харилцах данс-Юань	283,353.0	459,748.1
Харилцах данс-Рубль	21,456.2	23,940.3
Нийт дүн	2,225,235.4	8,819,241.6

4. ДАНСНЫ АВЛАГА

(мян.төг)

Ангилал	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
Дансны авлага	261,300,361.5	231,212,962.5
Найдваргүй авлагын хасагдуулга	(3,101,649.7)	(4,203,293.5)
Нийт дүн	258,198,711.8	227,009,669.0

5. ТАТВАРЫН АВЛАГА

(мян.төг)

Ангилал	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын	-	2,601,542.7
Нэмэгдсэн өртгийн албан татварын	4,712,246.0	-
Нийгмийн даатгалын шимтгэлийн	-	1,560.8
Нийт дүн	4,712,246.0	2,603,103.5

6. БУСАД АВЛАГА

(мян.төг)

Ангилал	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
Холбоотой талаас авах авлага	2,082,968.4	177,891.8
Ажилчдаас авах авлага	2,509.5	39,239.2
Бусад талуудаас авах авлага	2,186,000.0	2,186,000.0
Бусад төрөл	650.0	-
Нийт дүн	4,272,127.9	2,403,131.0

7. БАРАА МАТЕРИАЛ

(мян.төг)

Ангилал	Бараа	Хангамжийн материал	Нийт дүн
2025 оны 1 сарын 1	57,455,598.5	258,226.5	57,713,825.0
Нэмэгдсэн	2,164,015,685.8	205,969.2	2,164,221,655.0
Хасагдсан	2,141,609,444.0	119,014.8	2,141,728,458.8
2025 оны 12 сарын 31	79,861,840.3	345,180.9	80,207,021.2

8. УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ/ТООЦОО

(мян.төг)

Ангилал	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
Урьдчилж төлсөн зардал	2,893,845.2	1,599,557.3
Урьдчилж төлсөн түрээс	254,215.2	265,732.7
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн урьдчилгаа төлбөр	121,017.6	9,328,369.5
Нийт дүн	3,269,078.0	11,193,659.5

НИЯМАЗОН АУДИТ ХХК 11

УЛААНБААТАР ХОТ ШУНХЛАЙ ХХК

Голомт Капитал ХХК Golomt Capital Delivering Diversity 1119289111 5481589 Улаанбаатар хот

Шунхлай ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар

9. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

(мян.тг)

Ангилал	Барилга байгууламж	Машин, тоног төхөөрөмж	Тээврийн хэрэгсэл	Тавилга эд хогшил	Компьютер, бусад хэрэгсэл	Бусад үндсэн хөрөнгө	Дуусаагүй барилга	Нийт дүн
Анхны өртөг								
2025 оны 1 сарын 1	182,025.6	694,770.2	5,175,252.2	700,498.8	1,398,461.5	1,706,405.8	26,241,738.7	**36,099,152.8**
Нэмэгдсэн	6,488,810.5	263.8	588,666.7	32,415.4	167,552.8	1,791,129.8	17,885,640.0	**26,954,479.0**
Дахин ангилсан				-	-	-		-
Хасагдсан		35,020.8	-	40,161.8	217,354.2	3,481,499.4	9,627,688.4	**13,401,724.6**
2025 оны 12 сарын 31	**6,670,836.1**	**660,013.2**	**5,763,918.9**	**692,752.4**	**1,348,660.1**	**16,036.2**	**34,499,690.3**	**49,651,907.2**
Хуримтлагдсан элэгдэл								
2025 оны 1 сарын 1	29,115.5	433,734.1	2,335,475.9	334,161.4	1,166,119.6	1,679,623.9		**5,978,230.4**
Тайлант онд байгуулсан элэгдэл	152,895.6	65,686.4	409,044.4	54,794.0	137,019.3	757,516.9		**1,576,956.6**
Хасагдсан	-	4,710.8	-	35,562.5	209,816.2	2,432,976.8		**2,683,066.3**
2025 оны 12 сарын 31	**182,011.1**	**494,709.7**	**2,744,520.3**	**353,392.9**	**1,093,322.7**	**4,184.0**	-	**4,872,120.7**
Дансны үнэ	**6,488,825.0**	**165,303.5**	**3,019,398.6**	**339,359.5**	**255,337.4**	**11,872.2**	**34,499,690.3**	**44,779,786.5**

10. БИЕТ БУС ХӨРӨНГӨ

(мян.тг)

Ангилал	Компьютерийн програм хангамж	Тусгай зөвшөөрөл	Газар эзэмших эрх	Бусад биет бус хөрөнгө	Нийт дүн
Анхны өртөг					
2025 оны 1 сарын 1	1,151,985.2	-	186,662.0	1,078,295.0	**2,416,942.2**
Нэмэгдсэн	-	50,000.0	-	291,889.0	**341,889.0**
2025 оны 12 сарын 31	**1,151,985.2**	**50,000.0**	**186,662.0**	**1,370,184.0**	**2,758,831.2**
Хуримтлагдсан хорогдол					
2025 оны 1 сарын 1	930,318.3	-	58,654.2	1,384.3	**990,356.8**
Тайлант онд байгуулсан хорогдол	110,593.0	4,490.7	11,472.2	-	**126,555.9**
Хасагдсан					-
2025 оны 12 сарын 31	**1,040,911.3**	**4,490.7**	**70,126.4**	**1,384.3**	**1,116,912.7**
Дансны үнэ	**111,073.9**	**45,509.3**	**116,535.6**	**1,368,799.7**	**1,641,918.5**

11. ДАНСНЫ ӨГЛӨГ

(мян.тг)

Ангилал	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
Тологдох хугацаандаа байгаа	60,457,503.8	128,789,346.5
Бусад ангилал		3,303.7
Нийт дүн	**60,457,503.8**	**128,792,650.2**

2026.08.31

Голомт Капитал ҮЦК ХХК
Голомт Капитал
Delivering Reality
1119289111 ᠬᠤᠪᠢᠳᠠᠯ
Улаанбаатар хот

УПРАНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
13531 ᠣᠨ 2026488

ШУНХЛАЙ
2026 ᠣᠨ 08 ᠰᠠᠷ 1 ᠥᠳᠥᠷ
БҮРТГЭЛ
№ 51

НИЙМАЗОН АУДИТ ХХК 12

Үнэт цаасны танилцуулга
2026 -08- 07
БҮРТГЭЛ-03

ШУНХЛАЙ
2026 .09. 10
БҮРТГЭВ
№ 01

2026 -09- 02
БҮРТГЭЛ-03

Шунхлай ХХК
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар

12. ТАТВАРЫН ӨР

(мян.төг)

Ангилал	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын	879,047.3	-
Нэмэгдсэн өртгийн албан татварын	-	1,336,565.5
Хувь хүний орлогын албан татварын	736.0	25,869.5
Бусад татварын өр	-	253,496.4
Бусад төрөл	-	254,086.4
Нийт дүн	879,783.3	1,870,017.8

13. БОГИНО ХУГАЦААТ ЗЭЭЛ

(мян.төг)

Ангилал	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
Худалдаа хөгжлийн банк	5,800,000.0	17,800,860.8
Голомт банк	50,683,403.1	46,350,528.9
Хас банк	15,000,000.0	-
Хаан банк	-	65,179,897.9
Гаргасан бонд	100,000,000.0	100,000,000.0
Бондын хөнгөлөлт	(1,322,250.5)	(1,263,511.5)
Нийт дүн	170,161,152.6	228,067,776.1

14. УРТ ХУГАЦААТ ЗЭЭЛ

(мян.төг)

Ангилал	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
Худалдаа хөгжлийн банк	32,500,340.9	-
Хаан банк	91,643,650.9	36,979,000.0
Нийт дүн	124,143,991.8	36,979,000.0

15. БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО

(мян.төг)

Ангилал	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
Бараа борлуулсны орлого	1,394,172,236.9	1,609,813,405.6
Үйлчилгээ үзүүлсний орлого	19,211,135.5	35,095,077.9
Нийт дүн	1,413,383,372.4	1,644,908,483.5

16. БОРЛУУЛАЛТЫН ӨРТӨГ

(мян.төг)

Ангилал	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
Материалын зардал	1,321,987,928.9	1,543,797,978.0
Тээвэр, шатахууны зардал	19,159.1	-
Нийт дүн	1,322,007,088.0	1,543,797,978.0

17. БОРЛУУЛАЛТ МАРКЕТИНГИЙН ЗАРДАЛ

(мян.төг)

Ангилал	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
Зар сурталчилгаа	870,359.4	1,711,320.3
Нийт дүн	870,359.4	1,711,320.3

18. ЕРӨНХИЙ УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

(мян.төг)

Ангилал	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
Ажиллагчдын цалин	7,472,436.3	9,275,944.5
Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн	942,261.5	1,215,250.5
Албан татвар, төлбөр, хураамжийн	43,823.9	15,604.4
Тоноглол	720,462.8	1,008,353.5
Бичиг хэрэг	52,702.9	71,473.8
Шуудан холбоо	61,376.8	51,563.9
Мэргэжлийн үйлчилгээ	4,591,828.0	10,459,112.9
Даатгал	259,876.7	278,927.2
Ашиглалтын зардал	1,860.8	8,264.3
Засварын зардал	217,443.1	3,959.1

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
УТА3531 ☎ 2028488

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
1119289111 ☎ 5481589
Улаанбаатар хот

ШУНХЛАЙ он 2026 сар 09, 1 өдөр БҮРТГЭВ № 01

MONGOLIAN STOCK EXCHANGE 2026 -09- 02 БҮРТГЭВ-03

18. ЕРӨНХИЙ УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

(мян.төг)

Ангилал	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
Элэгдэл хорогдлын зардал	1,354,174.7	1,580,828.9
Шатахууны зардал	428,803.6	418,520.5
Хүлээн авалт	144,630.1	463,797.2
Хөдөлмөр аюулгүй байдал	78,088.4	-
Бусад зардал	29,093.9	353,907.2
Нийт дүн	16,398,863.5	25,205,507.9

19. ХОЛБООТОЙ ТАЛУУДТАЙ ХИЙСЭН ГҮЙЛГЭЭ

Тайлант хугацаанд холбоотой талуудтай гүйлгээ хийсэн ба эдгээр нь санхүүгийн тайланд тусгагдсан, зохих тодруулга хийгдсэн.

20. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР

Тус компанид 2025 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар болзошгүй өр төлбөр байхгүй байна.

21. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВЦ

Компаний 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан гарснаас хойш санхүүгийн тайланд нөлөө үзүүлэхүйц үйл явдал гараагүй байна.

УЛААНБААТАР ХОТ ШУНХЛАЙ ХХК УТА3531 № 2025488

160

Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital Delivering diversity 1119289111 ☎ 5481589 Улаанбаатар хот

2026.08.31

ШУНХЛАЙ ХХК

он 7.12 2026 оны 6-р сарын 30-ны өдрөөр тасалбар болгосон аудитлагдсан санхүүгийн тайлан

ШУНХЛАЙ ХХК

Санхүүгийн тайлан болон Хараат бус аудиторын тайлан

2026 оны 06 дугаар сарын 30

2026.08.31

ШУНХЛАЙ ХХК
2026 09 10 сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

2026 -09- 02
БҮРТГЭВ-03

АГУУЛГА	ХУУДАС
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	
УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ	
ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	1
ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН	2
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	3
2.1.4. "Үнэт цаас гаргагч" гэж энэ хуульд заасны дагуу үнэт цаасны зах зээлд арилжих үнэт цаасаа Бирж, Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлсэн, эсхүл бүртгүүлэх хүсэлт гаргаж байгаа этгээдийг;

2.1.5. "Нийтэд санал болгох" гэж Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон журмын дагуу үнэт цаасаа 50-аас дээш тооны этгээдэд санал болгон худалдахаа цахим орчин дахь олон нийтийн сүлжээ, мэдээлэх хэрэгслээр нийтэд мэдэгдэхийг;

2.1.6. "Бирж" гэж "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийг;

2.1.7. "Хороо" гэж Санхүүгийн Зохицуулах Хороог;

2.1.8. "ҮЦТХТ" гэж Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төвийг;

ГУРАВ. АНДЕРРАЙТЕРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦАР ХҮРЭЭ

3.1. Андеррайтерийн зүгээс үзүүлэх үйлчилгээнүүд нь гэрээний хүчинтэй хугацаанд үнэт цаас гаргах бэлтгэл ажил, үнэт цаасыг анхдагч зах зээлд нийтэд санал болгох гэсэн дараах хэсгээс бүрдэнэ. Үүнд:

3.1.1. Андеррайтер нь Үнэт цаас гаргах бэлтгэл ажлын хүрээнд дараах ажил үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:

3.1.1.1. Компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны чадавх, хууль эрх зүйн асуудлаар магадлан шинжилгээ (due diligence) хийх;

3.1.1.2. Үнэт цаасыг нийтэд санал болгох үйлчилгээг үзүүлэх ажлын нарийвчилсан төлөвлөгөөг бэлтгэн, тухайн хамтарсан төлөвлөгөөний дагуу оролцогч талуудын үйл ажиллагаанд хяналт тавих;

3.1.1.3. Хороо, Биржэд хүргүүлэх Үнэт цаасны танилцуулгыг боловсруулах, зөвшөөрөл авахад хүчин чармайлт гарган ажиллах, компанийн өрийн хэрэгслийг худалдан авах боломжит хөрөнгө оруулагчдыг тодорхойлж үнэт цаас худалдан авах захиалга авах, холбогдох хууль журамд заасан андеррайтерийн цогц үйлчилгээг үзүүлэх;

3.1.1.4. Хорооны 2026 оны 9-р сарын 10-ны өдрийн хуралдаанаар зөвшөөрөл авч, бондын эхний транчийн хоёрдогч арилжааг 2026 оны 9-р сарын 25-ны өдрийн дотор зохион байгуулахыг зорьж ажиллана.

3.1.1.5. Энэхүү гэрээний 3.1.1.4-т заасан хуваарийн дагуу зорин ажиллахад үнэт цаас гаргагч болон оролцогч талуудаас шаардлагатай бүхий л материалыг 2026 оны 8-р сарын 25-ны өдрийн дотор бүрэн бүрдүүлэн өгсөн байх ба Андеррайтераас үл хамаарах шалтгаанаар (оролцогч талуудын материал бүрдүүлэлт удаашрах, Хороо болон Биржээс нэмэлт материал шаардах зэрэг) дээрх хугацаа хойшилсон тохиолдолд андеррайтер нь хариуцлага хүлээхгүй.

186

2026.08.31

3.1.2. Андеррайтер нь үнэт цаасыг анхдагч зах зээлд нийтэд санал болгох ажлын хүрээнд дараах ажил үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:

3.1.2.1. Гадаад, дотоодын боломжит хөрөнгө оруулагчдыг тодорхойлох, тэдгээрээс хөрөнгө оруулалт татан төвлөрүүлэх, Компанийг төлөөлөн танилцуулга хийх, санал тавих, уулзалт зохион байгуулах, зуучлах, хөрөнгө оруулагчидтай хэлцэл хийхэд болон гэрээ байгуулахад зуучлах, хамтран ажиллах замаар түүнийг худалдахад шаардлагатай бүх хүчин чармайлт гаргах /Best Effort/ хэлбэрээр зохион байгуулна;

3.1.2.2. Компаниас нийтэд нээлттэй гаргах өрийн хэрэгслийг танилцуулах, сурталчлах, хөрөнгө оруулагчдад борлуулах;

3.2. Компани нь энэ Гэрээний дагуу дээр дурдсан үйлчилгээний хүрээнд дараах нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн болно. Үүнд:

3.2.1. Гэрээний хүчинтэй хугацаанд Компани нь Андеррайтерт Компанийг төлөөлөн энэхүү Гэрээний зорилгын дагуу хөрөнгө оруулагчид болон холбогдох зохицуулалтын байгууллагуудтай уулзалт, танилцуулга хийх эрх олгох бөгөөд ижил төрлийн Андеррайтерийн үйлчилгээг өөр бусад андеррайтераас авах бол Андеррайтерт урьдчилан мэдэгдэх;

3.3. Талууд энэхүү Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор төслийн багийг томилж энэхүү гэрээний Хавсралт №2-оор батлан хамтран ажиллана.

3.4. Гэрээний явцад төслийн багт өөрчлөлт орсон тухай бүр багийн ахлагчид харилцан баталгаат и-мэйлээр мэдэгдэж төслийн багт өөрчлөлтийг оруулж ажиллана.

3.5. Талуудын томилсон төслийн багийн гишүүд үүрэгт ажлаа зохион байгуулахад мэргэжлийн ур чадвар дутагдсан нь баримтаар нотлогдсон тохиолдолд, нөгөө Талын саналаар тухайн Тал нь өөрийн багт өөрчлөлт оруулах үүрэгтэй.

ДӨРӨВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

4.1 Гэрээнд талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

4.2 Гэрээг аль нэг талын санаачилгаар цуцалсан эсхүл талууд харилцан тохиролцож дуусгавар болгосноос бусад тохиолдолд талуудын гэрээний дагуу хүлээсэн үүрэг, хамтын ажиллагааны зорилго бүрэн биелснээр Гэрээ дуусгавар болно.

4.3 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээний хугацааг дахин сунгах боломжтой.

ТАВ. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР

5.1 Компаниас Андеррайтерт төлөх үйлчилгээний төлбөр нь Хавсралт 3-т заасан андеррайтерийн үйлчилгээний хувьсах төлбөрөөс бүрдэнэ.

5.2 Компани нь өрийн хэрэгслийн анхдагч зах зээлийн арилжааг амжилттай зохион байгуулж, татан төвлөрүүлэх хөрөнгө Компанийн дансанд бүрэн орсон өдрөөс хойш ажлын 3 /гурав/ өдрийн дотор энэхүү гэрээний 5.1 дэх хэсэгт заасан хувьсах төлбөрийг Андеррайтерийн нэхэмжлэхийг үндэслэн доорх дансанд төлнө.

Андеррайтерийн данс:

Банкны нэр:	Голомт банк
Дансны дугаар:	2005002269 /MNT/

IBAN дугаар: MN40001500
Данс эзэмшигч: Голомт Капитал ҮЦК

5.3 Компани нь Энэхүү гэрээний зорилтот үр дүнг бий болгохтой холбоотой дараах төлбөр, зардлуудыг бүрэн хариуцна. Үүнд:

5.3.1 Компани нь үнэт цаасыг нийтэд гаргах үйл ажиллагаатай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хороо, "Монголын хөрөнгийн биржь" ХК, "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ТӨХК зэрэг эрх бүхий байгууллагуудын шимтгэл, зохицуулалтын хөлс, татвар, хураамжийг холбогдох хууль, журамд заасны дагуу тухай бүр бүрэн хариуцан төлнө.

5.3.2 Компани нь өрийн хэрэгслийг нийтэд санал болгох үйл ажиллагаатай холбоотойгоор Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны бүртгэлийн журмын дагуу хөндлөнгийн дүгнэлт гаргах байгууллагуудтай гэрээ байгуулан ажиллах ба тайлан, дүгнэлт гаргахтай холбоотой зардлыг бүрэн хариуцна.

5.4 **Үйлчилгээний төлбөрийг шинэчлэн тогтоох**

5.4.1 Гэрээг хэрэгжүүлэх явцад дараах үндэслэлээр зайлшгүй зардал нэмэгдэж гарах тохиолдолд талууд үйлчилгээний төлбөрийг харилцан тохиролцож шинэчлэн тогтооно. Үүнд:

5.4.1.1 Компани нь гэрээнд заасан үйлчилгээнээс бусад нэмэлт зөвлөх үйлчилгээ авахаар Андеррайтерт хүсэлт гаргасан;

5.4.1.2 Гэрээнд заагдаагүй бусад ажил.

ЗУРГАА. КОМПАНИЙН ЭРХ, ҮҮРЭГ

6.1 Компани нь дараах **<u>үүрэгтэй</u>** байна. Үүнд:

6.1.1 Андеррайтерийн ажил, үүргээ гүйцэтгэхэд шаардагдах аливаа зөвшөөрөл, түүнчлэн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай гэж үзсэн эрх бүхий этгээдийн тогтоол, шийдвэр, мэдээ мэдээлэл, баримт бичгүүдийг Андеррайтераас тогтоосон хугацаанд түргэн шуурхай, бүрэн гүйцэд гаргаж өгөх бөгөөд Андеррайтерийг гагцхүү үнэн зөв мэдээллээр хангах;

6.1.2 Андеррайтерт Гэрээнд заасан үйлчилгээг үзүүлэхэд нь шаардлагатай үнэн зөв, бодит мэдээлэл, бичиг баримт болон материалуудын эх хувь болон баталгаажсан хуулбарыг цаг тухайд нь түргэн шуурхай бүрэн гаргаж өгөх;

6.1.3 Компанийн хөрөнгө оруулагчдад үйл ажиллагааны талаар үнэн зөв, бодит мэдээллээр хангах ажиллах;

6.1.4 Гэрээ хүчин төгөлдөр байх хугацаанд ижил төрлийн Андеррайтерийн үйлчилгээ авах бол Андеррайтерт урьдчилан мэдэгдэх;

6.1.5 Гэрээний 4 болон 5 дугаар зүйлд тусгагдсан Компанийн хариуцах бүхий л үүргээ биелүүлэх;

6.1.6 Компани талаас шаардлагатай тохиолдолд стратегийн хөрөнгө оруулагчийг Андеррайтерт холбож өгөх бөгөөд Андеррайтер нь тухай бүр Компанийн өрийн хэрэгслийн танилцуулга хийх;

6.1.7 Хороо, Бирж болон бусад эрх бүхий байгууллагаас гаргасан холбогдох дүрэм, журмын дагуу хүлээх бусад үүрэг;

~~6.2 Компани нь дараах **<u>эрхтэй</u>** байна. Үүнд:~~

188

2026.08.31

6.2.1 Андеррайтерийн буруутай үйл ажиллагаа, зөвлөгөөний улмаас Компанид учирсан бодит хохирлыг Андеррайтераас нэхэмжлэн төлүүлэх замаар барагдуулах;

6.2.2 Хороо, Бирж болон бусад эрх бүхий байгууллагаас гаргасан холбогдох дүрэм, журмын дагуу хүлээх бусад эрх.

ДОЛОО. АНДЕРРАЙТЕРИЙН ЭРХ ҮҮРЭГ

7.1 Андеррайтер нь дараах **үүрэгтэй** байна.Үүнд:

7.1.1 Андеррайтераас үл хамаарах шалтгаанаар Андеррайтерийн үйлчилгээний чанар, үр дүнд муугаар нөлөөлөх ямар нэг нөхцөл байдал бий болсон тохиолдолд Компанид нэн даруй мэдэгдэх;

7.1.2 Гэрээний дагуу Компаниас ирүүлсэн бичиг баримт, материалын бүрэн бүтэн байдлыг хангах талаар өөрөөс шалтгаалах бүхий л арга хэмжээг авах;

7.1.3 Эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авахад хүчин чармайлт гарган ажиллах;

7.1.4 Компанийн бизнесийн нууцад хамаарах мэдээ, мэдээлэл, нийтэд тараагдаагүй байгаа мэдээллийн нууцыг чанд хадгалах;

7.1.5 Гэрээт ажлыг хийж гүйцэтгэх, хөрөнгө оруулагчидтай уулзалт, танилцуулга хийх, санал таавх бүрд Компанид урьдчилан мэдэгдэж, компанийн эрх, ашиг сонирхлын эсрэг үйлдэл хийхгүй байх;

7.1.6 Энэхүү гэрээт ажлыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл эрхийн гэрчилгээтэй байх бөгөөд тэдгээр нь гэрээний хугацаанд хүчин төгөлдөр байх;

7.1.7 Компанийн өрийн хэрэгслийг амжилттай арилжаалахад холбогдох бүхий л ажилд хүчин чармайлт гарган ажиллаж, тухай бүр ажлын тайланг нарийвчилсан төлөвлөгөөний дагуу Компанид хүргүүлэх;

7.1.8 Хууль тогтоомж, дүрэм, журам зөрчсөнөөс үүдэн гарах хариуцлагыг бүрэн хүлээх, Компанийг үүнээс ангид байлгах;

7.1.9 Хороо, Бирж болон бусад эрх бүхий байгууллагаас гаргасан холбогдох дүрэм, журмын дагуу хүлээх бусад үүрэг;

7.2 Андеррайтер нь дараах **эрхтэй** байна.Үүнд:

7.2.1 Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай бүхий л мэдээ мэдээлэл, тоо баримт, санхүүгийн тайлангууд болон бусад холбогдох бичиг баримтуудыг Компаниас гаргуулан авах;

7.2.2 Компанид хөрөнгө босгох зорилгоор боломжит хөрөнгө оруулагч нарт Компанийг танилцуулах;

7.2.3 Компанийг Гэрээнд заасан бүхий л үүргээ биелүүлэхийг шаардах;

7.2.4 Андеррайтерийн үйлчилгээний хүрээнд Компанийн ажлын байр болон гэрээний үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор холбогдох газарт саадгүй, үнэ төлбөргүй нэвтрэх хүсэлт гаргах;

7.2.5 Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах, хуваарилалт хийх зарчмыг тогтоох, хуваарилалтыг хийх;

7.2.6 Компанийн буруутай үйл ажиллагааны улмаас Андеррайтерт учирсан хохирлыг Компаниас нэхэмжлэн төлүүлэх замаар барагдуулах;

7.2.7 Хороо, Бирж болон бусад эрх бүхий байгууллагаас гаргасан холбогдох дүрэм, журмын дагуу хүлээх бусад эрх.

НАЙМ. НУУЦ ХАДГАЛАХ

8.1 Талууд эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд байгууллагын нууцыг хамаарах мэдээллийг энэхүү Гэрээний бус зорилгоор шууд болон шууд бус замаар ашиглахгүй, задруулахгүй эсхүл гуравдагч этгээд болон олон нийтэд мэдээлэхгүй байх үүргийг Гэрээний хугацаанд болон гэрээт ажил дууссанаас хойших бүхий л хугацаанд хүлээнэ.

8.2 Гэрээний дор хүлээж буй Андеррайтерийн нууц хадгалах үүрэгт дараах нөхцөл байдал хамаарахгүй буюу Андеррайтер хариуцлага хүлээхгүй болно. Үүнд:

8.2.1 Андеррайтерт мэдээлэл өгөх үед болон дараа нь тухайн мэдээлэл Андеррайтераас хамааралгүйгээр олон нийтэд зарлагдсан;

8.2.2 Компанийн бусад эх үүсвэрээр дамжин нууцын бус зэрэглэлтэй материал Андеррайтерт хүрсэн;

8.2.3 Гэрээгээр хүлээсэн ямар нэгэн үүргээ зөрчилгүйгээр Андеррайтер нь өөрөө тухайн мэдээллийг олж авсан эсхүл боловсруулсан;

8.2.4 Хуулийн дагуу эрх бүхий байгууллагын шийдвэрээр тухайн нуущлалын зэрэглэлийн мэдээлэл олон нийтэд ил болсон.

8.3 Андеррайтерийн үйлчилгээний хүрээнд хийгдэх танилцуулга материал болон бусад нийтэд нээлттэй болох шаардлагатай мэдээллүүдийг нийтэд танилцуулснаар энэхүү Гэрээнд заасан нууц мэдээллийг задруулсан гэж үзэхгүй.

8.4 Нууцад тооцогдох мэдээллийг эрх бүхий байгууллагаас шаардсан тохиолдолд, талууд энэ талаар урьдчилж харилцан бие биедээ мэдэгдэнэ.

8.5 Нууц мэдээллийг аливаа гуравдагч этгээдэд задруулсан эсхүл шууд болон шууд бус замаар Гэрээний бус зорилгоор ашигласнаас үүдэн Компанид учирсан хохирлыг Андеррайтер хариуцна.

ЕС. ХАРИУЦЛАГА

9.1 Монгол Улсын Иргэний хуульд заасан гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн улмаас аль нэг тал Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон бол хариуцлагаас чөлөөлөгдөнө. Энэ тохиолдолд тэрхүү нөхцөл байдлаа нэн даруй нөгөө талдаа мэдэгдэж, нотлох үүрэгтэй. Нотолж чадаагүй тохиолдолд Гэрээгээр хүлээсэн үүргээсээ чөлөөлөгдөхгүй.

9.2 Компанийн буруутай, хууль бус үйл ажиллагааны улмаас үүссэн гарсан аливаа хохирол, өр төлбөрийг Андеррайтер хариуцахгүй болно.

9.3 Компанийн ирүүлсэн бөгөөд мэргэжлийн байгууллага (хуульч, санхүүгийн шинжээч, үнэлгээний байгууллага, эсхүл аудитын дүгнэлт гэх мэт)-аас баталгаажсан мэдээлэл нь худал буюу бодит байдалд нийцээгүй, төөрөгдүүлсэн байсны улмаас ирээдүйд учрах хохирлыг Андеррайтер хариуцахгүй болно. Хөндлөнгийн магадлан шинжилгээ хийх байгууллагуудын гаргасан дүгнэлтээс үүдэн Хороо, Биржийн бүртгэлийн шаардлагыг хангаагүйгээс үүдэн гарах хариуцлагыг буруутай тал хариуцна. Хугацаа хойшлох тухай бүр төлөвлөгөөт ажлын хугацааг хамтран сунгаж ажиллана.

АРАВ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ

10.1 Гэрээ нь дор дурдсан үндэслэлээр дуусгавар болно. Үүнд:

10.1.1 Талууд Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлснээр;

10.1.2 Талууд харилцан тохиролцсоноор Гэрээг дуусгавар болсон өдрөөр;

10.1.3 Аль нэг тал Гэрээний үүргээ зөрчсөн бөгөөд тухайн зөрчлийг арилгах тухай нөгөө талдаа албан ёсоор мэдэгдсэн тохиолдолд тус зөрчлийг боломжит

хугацаанд арилгаагүй, арилгах боломжгүй бол нэг талын санаачилгаар Гэрээг цуцалснаар;

10.1.4 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр шинээр Андеррайтерийн үйлчилгээний гэрээ байгуулснаар;

10.1.5 Хуульд заасан бусад үндэслэлээр.

10.2 Гэрээний үүргээ зөрчсөний улмаас гэрээ цуцалснаас үүсэх үр дагаврыг тухайн буруутай тал бүрэн хариуцна.

10.3 Дараах үндэслэлээр Компани гэрээг цуцлах шаардлага гаргах эрхтэй. Үүнд:

10.3.1 Андеррайтер доголдолтой ажил гүйцэтгэсэн эсхүл харилцан тохирсон нэмэлт хугацаанд ажлын гүйцэтгэлийн доголдлыг арилгаагүй;

10.3.2 Компани өрийн хэрэгслийг арилжаалахтай холбоотой шийдвэрийг хүчингүй болгох тухай шийдвэр гаргасан.

10.4 Талуудын гэрээт ажил зорилтот үр дүнд хүрээгүй, Гэрээнд заасан хугацаанаас өмнө Андеррайтерийн буруутай үйлдлээс шалтгаалан Компанийн санаачилгаар гэрээ цуцлагдсан тохиолдолд Компани нь гэрээний хугацаанд учирсан бодит хохирлыг Андеррайтераас шаардах эрхтэй.

10.5 Дараах үндэслэлээр Андеррайтер гэрээг цуцлах шаардлага гаргах эрхтэй. Үүнд:

10.5.1 Компани энэ Гэрээний 6 дугаар зүйлийн 6.1.1-т заасан баримт бичгүүдийг 30 хоногийн дотор эсхүл Андеррайтерийн заасан хугацаанд хүргүүлээгүй, тус баримт бичгүүдийг хуурамчаар бүрдүүлсэн эсхүл нуун дарагдуулсан нь илэрсэн;

10.5.2 Хөндлөнгийн дүгнэлт гаргах байгууллагын гаргасан дүгнэлт нь эрх бүхий байгууллагын шаардлагыг хангаагүйгээс үүдэн үнэт цаас гаргах үйл ажиллагаа амжилтгүй болох нөхцөл үүссэн;

10.5.3 Эрх бүхий байгууллагын зүгээс үнэт цаас гаргах үйл ажиллагааг түдгэлзүүлсэн.

10.6 Компани нь гэрээний дагуу хүлээсэн аль нэг үүргээ зохих ёсоор биелүүлээгүй буюу (a) Компани эсхүл түүний эрх барих дээд байгууллагаас Андеррайтерын шаардлагатай гэж үзсэн зөвшөөрөл, шийдвэр, баримт бичгийг гаргаж өгөөгүй буюу тодорхой бус шалтгаанаар гаргалгүй 30-иас дээш хоног болсон, (b) Компанийн үйл ажиллагаа явуулахтай холбоотой тусгай зөвшөөрөл болон бусад томоохон хөрөнгөтэй холбоотой хууль, шүүхийн маргаан үүссэн, эсхүл одоо байгаа маргаан нь шийдвэрлэгдэхгүй удсан буюу энэ нь үнэт цаас гаргах бэлтгэл ажилд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй гэж Андеррайтер үзсэн бол гэрээг түдгэлзүүлэх мэдэгдлийг бичгээр үйлдэж, гэрээний хэрэгжилтийг түр түдгэлзүүлж болно.

АРВАН НЭГ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

11.1 Талуудын аль нэг нь гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд нэн даруй нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ. Андеррайтер нь дээрх нөхцөл байдал болон түүний үр дагавар арилмагц гүйцэтгээгүй үүргээ нэн даруй бодитойгоор биелүүлнэ. Үүнтэй холбоотойгоор гэрээний хугацаанд өөрчлөлт орохоор бол хоёр тал харилцан тохиролцоно.

11.2 Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл гэдэгт дараах нөхцөл байдлыг хамруулж ойлгоно. Үүнд: газар хөдлөлт, үерийн аюул, дайн байлдаан, байгалийн гамшиг, үймээн самуун, эрх бүхий байгууллагаас гаргасан хорио, цээр зэрэг болно.

11.3 Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас энэхүү гэрээ саатсан буюу хэрэгжээгүй тохиолдолд гэрээний аль нэг тал нөгөө талаасаа алданги, торгууль зэрэг аливаа хохирлыг нөхөн төлөхийг шаардахгүй болно.

АРВАН ХОЁР. БУСАД ЗҮЙЛ

12.1 Энэхүү Гэрээний Хавсралт №1, 2, 3, 4 нь Гэрээний салшгүй хэсэг байх бөгөөд хамтдаа нэг баримт бичиг байна.

12.2 Энэхүү Гэрээ нь сайн дурын үндсэн дээр, талуудын эрх, ашиг сонирхлын төлөө байгуулагдсан бөгөөд талуудын хувьд зайлшгүй дагаж мөрдөх баримт бичиг мөн.

12.3 Талууд Гэрээтэй холбоотойгоор үүссэн санал зөрөлдөөн, үл ойлголцол, маргааныг харилцан тохиролцож, эв зүйгээр шийдвэрлэх ба тохиролцоонд хүрч чадахгүй тохиолдолд маргааныг Монгол Улсын хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

12.4 Гэрээнд тусгагдаагүй бусад асуудлыг дээр дурдсан холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

12.5 Гэрээг Монгол хэл дээр, ижил хүчинтэй 2 хувь үйлдэх ба Компанид 1 хувь, Андеррайтерт 1 хувь хадгалагдана.

Гагцхүү бичгээр үйлдэн талууд гарын үсэг зурж баталгаажуулсан тохиолдолд Гэрээний нөхцөл, болзол болон үйлчилгээний цар хүрээг засварлах, өөрчлөх болон үүнтэй холбоотойгоор гэрээнд өөрчлөлт оруулж болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

КОМПАНИЙГ ТӨЛӨӨЛЖ: “ШУНХЛАЙ” ХХК-ИЙН	АНДЕРРАЙТЕРИЙГ ТӨЛӨӨЛЖ: “ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:	ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:
Ж.МӨНХНАРАН	А.НЯМСҮРЭН

192

2026.08.31

ШУНХЛАЙ

СЗХ 2026 оны 08 сар 1 өдөр БҮРТГЭВ № 01

2026 -09- 02 БҮРТГЭВ-03

2026 оны 8 сарын 21-ны өдрийн 8/258 тоот
Андеррайтерийн үйлчилгээний
гэрээний Хавсралт
№1

ӨРИЙН ХЭРЭГСЛИЙГ ГАРГАХТАЙ ХОЛБООТОЙ ХИЙГДЭХ АЖЛУУД

№	Гүйцэтгэх ажил	Эхлэх огноо	Дуусах огноо
1	**Гэрээ байгуулах**		
1.1	Андеррайтерийн үйлчилгээний гэрээг байгуулах	2026.08.17	2026.08.18
1.2	Магадлан шинжилгээний материал хүлээн авах	2026.08.18	2026.08.27
1.2.1	Аудитын тайлан хүлээн авах	2026.08.18	2026.08.25
1.2.2	Зээлжих зэрэглэлийн тайлан хүлээн авах	2026.08.18	2026.08.27
1.2.3	Бусад материалыг хүлээн авах	2026.08.18	2026.08.24
2	**Магадлан шинжилгээг хийж гүйцэтгэх**		
2.1	Санхүүгийн болон үйл ажиллагааны магадлан шинжилгээг хийж гүйцэтгэх	2026.08.18	2026.08.27
2.2	Зах зээлийн судалгааг гүйцэтгэх	2026.08.18	2026.08.19
2.3	Өрийн хэрэгслийн мөнгөн урсгалын шинжилгээг гүйцэтгэх	2026.08.25	2026.08.27
3	**Үнэт цаасны танилцуулга боловсруулах**		
3.1	Үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцогчидтой хийсэн гэрээний хувийг компаниас гаргуулах	2026.08.18	2026.08.24
3.2	Үнэт цаасны танилцуулгад тусгах шаардлагатай мэдээллийг компаниас гаргуулах, хавсаргах	2026.08.18	2026.08.24
3.3	Аудитын болон Хуулийн дүгнэлтийг хавсаргах	2026.08.25	2026.08.30
3.4	Үнэт цаас гаргах тухай ТУЗ-ийн шийдвэрийг гаргуулах	2026.08.21	2026.08.24
3.5	Үнэт цаасны танилцуулга боловсруулах	2026.08.18	2026.08.29
3.6	Андеррайтерийн дүгнэлтийг боловсруулах	2026.08.29	2026.08.30
3.7	Үнэт цаасны танилцуулгад Компани болон Хуулийн фирмээс санал авах	2026.08.29	2026.08.30
3.8	Хороо, Биржэд хүргүүлэх ҮЦТ хэвлэж бэлтгэж, гарын үсгээр баталгаажуулах	2026.08.30	2026.08.31
4	**Зохицуулах байгууллагуудаас холбогдох зөвшөөрөл авах**		
4.1	Хороо, Биржэд бүртгүүлэх өргөдөл гаргах, хураамж төлөх, үнэт цаасны танилцуулга, гэрээнүүд хүргүүлэх	2026.08.31	2026.08.31
4.2	Хороо, Биржэд зөвшөөрөл авах, бүртгүүлэх	2026.08.31	2026.09.10
5	**Арилжааны үе шат**		
5.1	Хөрөнгө оруулагчдад зориулсан үнэт цаасны хураангуй танилцуулга болон брошюр бэлтгэх	2026.08.31	2026.09.10
5.2	Хаалттай хөрөнгө оруулагчдад зориулсан илтгэл бэлтгэх	2026.08.31	2026.09.10
5.3	Олон нийтэд зориулсан илтгэл бэлтгэх	2026.08.31	2026.09.10
5.4	Боломжит хөрөнгө оруулагчидтай санамж бичиг, үнэт цаас худалдан авах урьдчилсан захиалгын гэрээ байгуулах /Cold Call/	2026.08.31	2026.09.10
5.5	Роуд шоу-г эхлүүлэх зөвшөөрөл авч, үнэт цаасны мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй түгээх, хөрөнгө оруулагчидтай уулзалт зохион байгуулах.	2026.09.11	2026.09.12
5.6	МХБ-ын гадна сурталчилгаа байршуулах	2026.09.12	2026.09.19
5.7	Анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг гүйцэтгэх	2026.09.19	2026.09.20
6	**Арилжаг хаах**		
6.1	Андеррайтер арилжааны тайланг СЗХ-нд хүргүүлэх	2026.09.20	2026.09.21
6.2	Үнэт цаас гаргагч үнэт цаасны гүйлгээний товч тайланг нийтэд мэдээлэх	2026.09.20	2026.09.21
6.3	СЗХ нь ҮЦТХТ-д үнэт цаасны бүртгэл хийх, МХБ-д үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаг эхлүүлэх зөвшөөрөл олгох	2026.09.21	2026.09.24
6.4	Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаг эхлүүлэх	2026.09.25	

УЛААНБААТАР ХОТ ШУНХЛАЙ ХХК ТТД 3531 ш. 2023.08.08

Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital Delivering diversity 1119289111 5481589 Улаанбаатар хот

2026 оны 8 сарын 21-ны өдрийн 8/258 тоот
Андеррайтерийн үйлчилгээний
гэрээний Хавсралт №2

ӨРИЙН ХЭРЭГСЛИЙГ ГАРГАХ ТӨСЛИЙН БАГ

№	Овог / Нэр	Албан тушаал	Утас	И-мэйл
		Компани		
1	Ж.Мөнхнаран	Гүйцэтгэх захирал	99119100	munkhnaran.j@shunkhlai.mn
2	А.Жамъяанжав	Бизнес төлөвлөлтийн газрын захирал	88889906	jamiyanjav.a@shunkhlai.mn
3	Б.Энхболд	Санхүүгийн менежер	90011711	enkhbold.b@shunkhlai.mn
4	Э.Гантулга	Хуулийн зөвлөх	91979991	gantulga.e@shunkhlai.mn
		Андеррайтер		
1	А.Нямсүрэн	Гүйцэтгэх захирал	99003679	nyamsuren@golomtcapital.com
2	Н.Нарангэрэл	Хөрөнгө оруулалтын газрын захирал	89043735	narangerel@golomtcapital.com
3	Ё.Нямдулам	Хөрөнгө оруулалтын хэлтсийн захирал	99223375	nyamdulam@golomtcapital.com
4	Г.Оюунбилэг	Хөрөнгө оруулалтын шинжээч	99445826	oyunbileg@golomtcapital.com

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

КОМПАНИЙГ ТӨЛӨӨЛЖ:
"ШУНХЛАЙ" ХХК-ИЙН

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:

Ж.МӨНХНАРАН

АНДЕРРАЙТЕРИЙГ ТӨЛӨӨЛЖ:
"ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК"
ХХК-ИЙН

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:

А.НЯМСҮРЭН

ШУНХЛАЙ СЗХ 2026.09.10 өдөр БҮРТГЭВ № 01

Үнэт цаасны танилцуулга

2026-09-02 БҮРТГЭВ-03

2026 оны 8 сарын 21-ны өдрийн 8/20 тоот
Андеррайтерийн үйлчилгээний
гэрээний Хавсралт №4

"ШУНХЛАЙ" ХХК-ийн өрийн хэрэгслийн ерөнхий нөхцөл

Өрийн хэрэгслийн үнийн дүн	100,000,000,000.0 (нэг зуун тэрбум) төгрөг;
Өрийн хэрэгслийн татан төвлөрүүлэх хэлбэр	Монголын хөрөнгийн биржээр олон нийтэд нээлттэй;
Өрийн хэрэгслийн хүүгийн түвшин	Жилийн 18.0% (арван найман хувь)
Өрийн хэрэгслийн хүү төлөх давтамж	Хагас жил тутам
Өрийн хэрэгслийн хугацаа	12 сар
Өрийн хэрэгслийг баталгаа хэлбэр	"Бонд баталгаа хөтөлбөр" хэлбэрээр;

ХАВСРАЛТ БАТАЛГААЖУУЛСАН:

КОМПАНИЙГ ТӨЛӨӨЛЖ:
"ШУНХЛАЙ" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:

Ж.МӨНХНАРАН

АНДЕРРАЙТЕРИЙГ ТӨЛӨӨЛЖ:
"ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК"
ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:

А.НЯМСҮРЭН

УЛААНБААТАР ХОТ ШУНХЛАЙ ХХК ТТА 531 ☎ 2023488

195

Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital Delivering diversity 1119289111 ☎ 5011589 Улаанбаатар хот

2026.08.31

ШУНХЛАЙ СЗХ 2026 09 10 БҮРТГЭВ № 01

2026 -09- 02 БҮРТГЭВ-03

Golomt Capital
Delivering diversity

Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Чингисийн өргөн чөлөө 24, Парк Плэйс
оффисын барилга, 4 давхар, 403 тоот,
Утас: 7012-1530, 7012-1529
И-мэйл: info@golomtcapital.com,
Вэбсайт: www.golomtcapital.com

ХӨРЕНГӨ ОРУУЛАГЧДАД

2026 08 31 № ГК/26/330

-ны № т

АНДЕРРАЙТЕРИЙН ТОДОРХОЙЛОХ ЗАХИДАЛ

Андеррайтер "Голомт Капитал ҮЦК" ХХК нь (цаашид "Андеррайтер" гэх) Үнэт цаас гаргагч Шунхлай ХХК-тай (цаашид "Үнэт цаас гаргагч" гэх) 2026 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн 8/258 тоот "Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ" байгуулж, 100,000,000,000 (нэг зуун тэрбум) төгрөгийн үнийн дүн бүхий нээлттэй өрийн хэрэгслийг хөтөлбөрийн хүрээнд хэсэгчлэн Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй арилжаалахаар тохиролцсон.

Үнэт цаасыг олон нийтэд санал болгох үйл ажиллагаа нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хорооны (СЗХ) 2021 оны 06 сарын 11-ний өдрийн 226 дугаар тоот тогтоолоор батлагдсан "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам", Монголын Хөрөнгийн Биржийн (МХБ) 2018 оны 1 сарын 25-ны өдрийн 2018/01 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам", болон бусад холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгэж байна.

Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг МХБ-ийн 2018 оны 10-р сарын 25-ны өдрийн 15 тоот тогтоолоор батлагдан журмын дагуу үнэт цаас гаргагчийн тогтоосон тодорхой үнэ (өгөөж)-ээр санал болгох ба захиалга 100 хувь биелсэн тохиолдолд анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдсанд тооцож, анхдагч зах зээлийн арилжааг хаах нөхцөлтэй.

Нээлттэй өрийн хэрэгслийг олон нийтэд санал болгон хөрөнгө оруулалт татах бэлтгэл ажлын хүрээнд Андеррайтер нь Үнэт цаасны танилцуулгыг боловсруулан, дараах мэргэжлийн дүгнэлтийг танилцуулж байна. Үүнд:

1. Үнэт цаасны гаргагчийн бизнес, үйл ажиллагаа
2. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй зах зээлийн төлөв байдал
3. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдал
4. Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт
5. Үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөө, санхүүгийн төсөөлөл
6. Хөрөнгө оруулалтын өгөөж, эрсдэл
7. Эргэн төлөлтийн баталгаа
8. Ерөнхий дүгнэлт

УЛААНБААТАР ХОТ ШУНХЛАЙ ХХК

Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital Delivering diversity 1119289111 5481589 Улаанбаатар хот

196

2026.08.31

ШУНХЛАЙ СЗХ 2026 09 10 өдөр БҮРТГЭВ № 01

2026 -09- 02 БҮРТГЭВ-03

НЭГ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Шунхлай ХХК нь анх 2005 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд одоогийн байдлаар газрын тосны бүтээгдэхүүний бөөний болон жижиглэн худалдаа, төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа гэх тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Мөн 2025 оны 5-р сард Эрчим хүчний яамнаас дараах тусгай зөвшөөрлүүдийг авсан. Үүнд:

- 0.4-35кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ /2025.08.25 - 2030.08.25/
- 220 кВ болон түүнээс дээш хүчдэлтэй цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх /2025.05.27 - 2030.05.27/
- 100 МВт-аас дээш эрчим хүчний эх үүсвэр барих, угсрах, засварлах, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ барих /2025.05.27 - 2030.05.27/

Үнэт цаас гаргагчийн нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,657 ширхэг хувьцаа бүхэн компанийн энгийн хувьцааг 100 хувь Шунхлай Холдинг ХХК эзэмшдэг.

Үнэт цаас гаргагч нь Шунхлай газрын тосны бизнесийн нэгдэлд хамаарах бөгөөд тус нэгдэл нь одоогоор Улаанбаатар хот болон 21 аймагт нийт 110 гаруй шатахуун түгээх станцтайгаар үйл ажиллагаа явуулж байна. Шунхлай газрын тосны бизнес нь бүтээгдэхүүний импорт, хадгалалт, тээвэрлэлт, борлуулалт гэсэн үндсэн 4 чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

Доорх хэсэгт Шунхлай газрын тосны нэгдэлд хамаарах компаниудын мэдээллийг оруулав.

№	Нэр	Үүсгэн байгуулагдсан огноо	Газрын тосны бизнесийн чиг үүрэг
1	Шунхлай ХХК	2005.12.16	Газрын тосны бүтээгдэхүүний импортыг хариуцах бөгөөд бусад 7 компани руу борлуулдаг.
2	Шунхлай Говь ХХК	2011.08.22	Говийн бүсийн нутгуудад ШТС-үүд , агуулахуудаар жижиглэн болон бөөний борлуулалт хийдэг.
3	Шунхлай Петролиум ХХК	2011.09.14	Эрдэнэт, Дархан, Хөвсгөл аймагт ШТС-үүд, агуулахуудаар жижиглэн болон бөөний борлуулалт хийдэг.
4	Шунхлай Трейдинг ХХК	2011.08.22	Улаанбаатар хотод байрлалтай ШТС-үүдээр шатахууны борлуулалт хийдэг.
5	Эс Жи Ханги Гэйт ХХК	2022.02.11	Говийн бүсийн нутгуудад борлуулалт хийдэг.
6	Эс Жи Шивээ Хүрэн Депо ХХК	2022.02.07	Говийн бүсийн нутгуудад борлуулалт хийдэг.
7	Шунхлай Ойл ХХК	2023.11.28	Шатахуунаас бусад бүтээгдэхүүн бүхэн тос, тослох материал, битум, мазут, шил арчигч шингэн, аккумлятор зэрэг бүтээгдэхүүний борлуулалт хийдэг.

УЛААНБААТАР ХОТ ШУНХЛАЙ ТТА 2022468

Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital Delivering diversity 1119289111 54011589 Улаанбаатар хот

8	Эс Жи Коммодитис ХХК	2022.04.06	Одоогоор идэвхтэй үйл ажиллагаа явуулж эхлээгүй байна.

ХОЁР. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа нь дэлхийн газрын тосны үнийн хэлбэлзлээс шууд хамаардаг. Дэлхийн газрын тосны бүтээгдэхүүний нөөцийн 79.1 хувийг бүрдүүлдэг ОПЕК нь үнэ, нийлүүлэлтийг тогтворжуулах зорилготой байгууллага бөгөөд зах зээлийн эрэлт хэрэгцээнд тохируулан олборлолтоо зохицуулдаг.

2025 онд түүхий нефтийн жилийн дундаж үнэ нэг баррель нь 68.0 ам.долларт хүрч, өмнөх оноос 16.8 хувиар буурсан бөгөөд энэ нь дэлхийн зах зээл дэх нийлүүлэлт харьцангуй өндөр, эрэлт сул байсантай холбоотой байв. 2026 оны эхний хагас жилд АНУ-с Израйль, Ираны эсрэг цэргийн ажиллагаа явуулж, улмаар тус бүс нутгийг хамарсан өргөн хүрээний мөргөлдөөнөөс үүдэн Персийн булангийн газрын тосны үйлдвэрлэл болон Ормузын хоолойгоор дамжих газрын тосны тээвэрт хүчтэй нөлөөлснөөр газрын тосны үнэ энэ оны оргилдоо буюу 114.1 ам.долларт хүрсэн. АНУ болон Ираны хооронд энхийн хэлэлцээр хийгдэх мэдэгдлүүд гарч эхэлснээр нийлүүлэлтийн эрсдэл буурч, ханш буурах хандлагатай байна. Дэлхийн банкны таамаглалаар Брент төрлийн газрын тосны дундаж үнэ 2026 онд 86.0 ам.доллар, 2027онд 70 ам.долларт хүрэхээр байна.

Манай улсын голлох газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэгч болох ОХУ-ын хувьд Украйны ОХУ-ын газрын тос боловсруулах үйлдвэр, агуулах, дамжуулах хоолой, эрчим хүчний дэд бүтцэд чиглэсэн дроны халдлагын давтамж, цар хүрээ нэмэгдсэнээс үүдэн тус улсын газрын тосны экспорт буурч, дотооддоо шатахууны хомсдолтой байгаа ба ОХУ-ын Засгийн газраас бензин, дизелийн экспортын хоригийг 2027 оны 1-р сарын 31-нийг дуустал сунгаад байна.

ОХУ-д үүссэн нөхцөл байдлаас үүдэн 2026 оны 7-р сарын байдлаар манай улсын АИ-92 бензиний нөөц өмнөх оны мөн үеэс 63.1 хувиар буурч 28.4 мянган тоннд, дизель түлшний нөөц өмнөх оны мөн үеэс 56.3 хувиар буурч 67.1 мянган тоннд хүрснээр шатахууны хомсдолд ороод байна. Мөн нийлүүлэлтийн асуудлаас үүдэн АИ-92 бензиний хилийн үнэ тонн тутамд 780.2 ам.доллар байгаа бол АИ-95 бензин 1,138.8 ам.доллар, Дизель түлш 1,278.5 ам.доллар болж өсөх хандлагатай байна. Монгол улсын Засгийн газрын зүгээс шатахууны хомсдолыг арилгахын тулд импортыг нэмэгдүүлэх, бүх төрлийн шатахууны импортын гаалийн албан татварын хувь, хэмжээг 2027 оны 2-р сарын 1-ний өдрийг хүртэл тэглэх, шатахууны нөөцийн агуулах барихад хөнгөлөлттэй зээл олгох зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж байна.

ГУРАВ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Шунхлай ХХК-ийн 2026 оны 6-р сарын 30-ны өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайланд "Ниямазон Аудит" ХХК аудит хийж санхүүгийн тайлангууд нь материаллаг зүйлсийн хувьд СТОУС-ын дагуу үнэн, бодитой илэрхийлсэн байна гэж дүгнэсэн байна.

Үнэт цаас гаргагч нь газрын тосны бүтээгдэхүүний импортыг хариуцан, импортолсон бүтээгдэхүүнээ Шунхлай газрын тосны нэгдлийн бусад компаниудад борлуулдаг бөгөөд нийт орлогын 93-98 хувийг холбоотой талын борлуулалт бүрдүүлдэг. Үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлого 2023–2025 оны хооронд жилдээ дунджаар 17.2 хувиар өссөн бол 2026 оны 2-р улирлын байдлаар 1.03 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.4 дахин өссөн байна. 2023-2025 оны хооронд нийт ашгийн маржин 6.1-7.0 хувийн

хооронд хэлбэлзэж байсан бол 2026 оны 2-р улирлын байдлаар шатахууны үнийн өсөлтөөс үүдэн өсөж, нийт ашгийн маржин 9.6 хувьд хүрсэн байна. Тайлант хугацаанд үйл ажиллагааны зардал 32.2 хувийг, санхүүгийн зардал 58.0 хувийг тус тус бүрдүүлжээ. 2026 оны 2-р улирлын байдлаар цэвэр ашгийн хэмжээ 38.8 тэрбум төгрөг, цэвэр ашгийн маржин 3.7 хувьд тус тус хүрсэн.

2026 оны 2-р улирлын байдлаар нийт хөрөнгө 647.7 тэрбум төгрөг хүрч, 2025 оны эцсээс 47.2 хувиар өссөн байна. 2026 оны 2-р улирлын байдлаар нийт хөрөнгийн 9.5 хувийг эргэлтийн бус хөрөнгө, 90.5 хувийг эргэлтийн хөрөнгө бүрдүүлж байна. Эх үүсвэрийн хувьд нийт хөрөнгийн 88.0 хувийг өр төлбөрөөр санхүүжүүлсэн бол үлдсэн хэсгийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлсэн байна. Өр төлбөрийн бүтцийн хувьд банкны зээл хамгийн өндөр буюу 55.9 хувийг бүрдүүлж байгаа бол бондын өглөг 17.5 хувийг, худалдааны болон бусад өглөг 26.6 хувийг тус тус бүрдүүлж байна. Шунхлай ХХК нь газрын тосны бизнесийн импортын үйл ажиллагааг хариуцахаас гадна эх үүсвэр бэлтгэх ажлыг мөн голчлон хариуцдаг бөгөөд Шунхлай газрын тосны бизнесийн нийт зээлийн эх үүсвэрийн дунджаар 90 орчим хувийг үнэт цаас гаргагч Шунхлай ХХК-ийн зээл бүрдүүлдэг.

ДӨРӨВ. ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

Шунхлай ХХК нь нийт татан төвлөрүүлсэн 100.0 тэрбум төгрөгийг бараа материалын татан авалт буюу газрын тосны бүтээгдэхүүн импортоор худалдан авахад зарцуулна. Үнэт цаас гаргагч Шунхлай ХХК нь дотоодын шатахууны эрэлтийг хангахын тулд шатахууны худалдан авалтаа нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Үнэт цаас гаргагч нь үнэт цаас гаргахтай холбоотой зардлыг татан төвлөрүүлэх хөрөнгөөс зарцуулахгүй бөгөөд өөрийн үндсэн үйл ажиллагааны мөнгөн хөрөнгөөс зарцуулна.

ТАВ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ, САНХҮҮГИЙН ТӨСӨӨЛӨЛ

Үнэт цаас гаргагч нь газрын тосны бизнесийн стратегийн зорилгодоо хүрэхийн тулд жил бүр бизнес төлөвлөгөө, бодлого, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлан ажилладаг. Шунхлай ХХК-ийн борлуулалтын орлогын төсөөллийг бараа материалын эргэц, авлагын эргэц болон нийт ашгийн түүхэн мэдээлэлд үндэслэн бэлтгэсэн бөгөөд 2026 онд борлуулалтын орлого, эхний хагас жилийн өсөлтөөс үүдэн огцом өсөлттэй байхаар төсөөлсөн бол 2027–2028 онуудад жигд, тогтвортой өсөлттэй байна гэж үзсэн. Борлуулалтын өртөг, үйл ажиллагааны зардлыг орлогын түүхэн харьцаанд үндэслэн тооцсон.

Компанийн санхүүгийн зардал нь банкны зээл, зээлийн шугам, бондын хүүгийн төлбөрөөс бүрддэг бөгөөд үнэт цаас гаргагчийн хувьд санхүүжилтийн зардал нийт зардалд томоохон хувь эзэлж байна. Арилжааны банкны зээлийн жинлэсэн дундаж хүү ойролцоогоор 16.5%, зээлийн хэмжээ жил бүр тогтвортой хадгалагдах боломжтой гэж төлөвлөгдсөн. Үнэт цаас гаргагч нь бонд санал болгох үеийн байдлаар биржийн бус зах зээлд санал болгосон бондын үлдэгдэлгүй, харин Монголын хөрөнгийн биржээр дамжуулан нийтэд санал болгосон нээлттэй 100.0 тэрбум төгрөгийн бондын үлдэгдэлтэй. Андеррайтерийн зүгээс үнэт цаас гаргагчийг хуучин бондыг амжилттай төлж барагдуулсны дараа шинэ бонд гаргах замаар, жил бүр ойролцоогоор 100.0 тэрбум төгрөгийн бондын үлдэгдэлтэй байна гэж төсөөлж байна.

Компанийн үндсэн үйл ажиллагаа тогтвортой өсөлттэй, мөнгөн урсгал дунд хугацаанд эерэг байх хүлээлттэй байна. Хөрөнгө оруулалтын урсгал нь агуулах, ШТС, тоног төхөөрөмжийн шинэчлэл, оффисын барилгын ажилтай холбоотойгоор энэ онд сөрөг байх боловч ирэх жилүүдэд гарах мөнгөн урсгал буурна. Санхүүгийн урсгалын хувьд, зээл

болон бондын хэмжээ нэмэгдсэнээр хүүгийн зардал өсөж сөрөг мөнгөн урсгал үүсэх хандлагатай боловч компани үүнийг мөн үндсэн үйл ажиллагааны эерэг урсгалаар нөхөх боломжтой гэж үзэж байна.

ЗУРГАА. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ӨГӨӨЖ

Үнэт цаас гаргагч нь бондын хүүгийн түвшнийг тодорхойлохдоо Монголбанкнаас зарласан бодлогын хүү, зах зээл дэх ижил төстэй өрийн хэрэгслийн хүүгийн түвшин, үнэт цаас гаргагчийн санал болгож буй үнэт цаасны эрсдэлийн хүчин зүйл зэрэгт үндэслэж тооцсон.

2026 оны 8 дугаар сарын байдлаар Монголбанкнаас зарласан бодлогын хүүгийн түвшин 12.5 хувь, 2026 оны 7-р сарын байдлаар улсын инфляцын түвшин 13.0 хувь байна. Монголбанкны статистикийн дагуу арилжааны банкнуудын шинээр татсан төгрөгийн 12 сарын хугацаатай хадгаламжийн жинлэсэн дундаж хүү 13.75 хувь байна.

Үнэт цаас гаргагчийн санал болгож буй Шунхлай-4 бонд нь 18.0 хувийн хүүгийн түвшинд буюу шинээр татаж буй төгрөгийн хадгаламжийн жинлэсэн дундаж хүүтэй харьцуулахад нэрлэсэн хүүгийн түвшинд 4.25 нэгжээр өндөр өгөөжтэй байна.

ДОЛОО. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЭРСДЭЛ

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа нь газрын тосны бүтээгдэхүүний импортын хамаарал, нийлүүлэлтийн тасалдал, импортын үнэ болон валютын ханшийн өөрчлөлт, төрийн зохицуулалт, тээвэр логистикийн саатал, ХАБЭА болон байгаль орчны эрсдэлд үүсэх боломжтой. Эдгээр хүчин зүйл нь борлуулалтын хэмжээ, ашигт ажиллагаа, бараа материалын нөөц болон эргэлтийн хөрөнгийн хэрэгцээнд нөлөөлж, улмаар компанийн мөнгөн урсгал болон төлбөрийн чадварт дарамт үүсгэх боломжтой.

Санхүүгийн хувьд 2026 оны II улирлын байдлаар Үнэт цаас гаргагчийн нийт өр төлбөр 570.2 тэрбум төгрөг, эздийн өмч 77.5 тэрбум төгрөг байгаа бөгөөд 2025 онд гаргасан 100.0 тэрбум төгрөгийн бонд 2026 оны 9-12 дугаар сард эргэн төлөгдөх хуваарьтай. Мөн тайлант хугацаанд үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ сөрөг гарсан тул эргэлтийн хөрөнгийн удирдлага, авлагын барагдуулалт болон богино хугацаат өрийн дахин санхүүжилт нь анхаарах гол санхүүгийн эрсдэл байна.

Гэсэн хэдий ч компанийн олон жилийн үйл ажиллагааны туршлага, импорт-хадгалалт-түгээлтийн дэд бүтэц, банк болон хөрөнгийн зах зээлийн санхүүжилтийн сувгийг ашиглаж ирсэн туршлага, 2026 оны эхний хагас жилийн ашигт ажиллагааны өсөлт нь дээрх эрсдэлийг бууруулах хүчин зүйл болж байна. Цаашид нийлүүлэлтийн тасралтгүй байдлыг хангах, авлага болон бараа материалын эргэлтийг сайжруулах, өрийн хугацааны бүтцийг оновчтой удирдах, бондын эргэн төлөлтийн эх үүсвэрийг урьдчилан бүрдүүлэх нь гол анхаарах чиглэл байна.

НАЙМ. ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТ

Үнэт цаас гаргагч нь олон нийтэд санал болгохоор төлөвлөж буй өрийн хэрэгслийн эргэн төлөлтийг үндсэн үйл ажиллагааны орлого буюу газрын тосны бүтээгдэхүүн борлуулснаас хүлээн авсан мөнгөн хөрөнгөөс эргэн төлнө.

Монголын Хөрөнгө Оруулалтын Зэрэглэлийн Эжинси ХХК нь 2026 оны 8-р сарын байдлаар нийт 16 компанийн дотоодын зээлжих зэрэглэлийг тогтоосон бөгөөд Шунхлай ХХК, Инвескор ББСБ ХК болон Аригбанк ХХК нь зээлжих зэрэглэл тогтоолгосон компаниуд дотроос хамгийн өндөөр буюу "А (тогтвортой)" гэж үнэлэгдсэн байна. А (тогтвортой)" ангилал нь Монголын Хөрөнгө Оруулалтын Зэрэглэлийн Эжинси ХХК-ийн зэрэглэлийн хувьд эрсдэл багатай, хөрөнгө оруулалтын дундаас дээш зэрэглэлд тооцогддог.

200

2026.08.31

НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Андеррайтер нь судалгаа шинжилгээ болон бусад хөндлөнгийн байгууллагуудын дүгнэлт, тайланд үндэслэн Үнэт цаас гаргагчийн гаргаж буй өрийн хэрэгсэл нь МХБ-ээр нээлттэй арилжаалагдах шалгуурыг хангасан бөгөөд олон нийтэд санал болгох боломжтой гэж үзлээ.

Энэхүү дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн төлөвлөгөө тайланд үндэслэн хийгдсэн ба төсөөлөл, таамаглал болон биелэлтийн баталгаа болохгүй. Иймд хөрөнгө оруулагчдыг компанийн үйл ажиллагаа, үнэт цаасны танилцуулга, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар судалсны үндсэн дээр шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.

Хүлээн авсан: Монголын Хөрөнгийн Бирж ХК-д

Баталгаажуулсан:

Андеррайтер Голомт Капитал ҮЦК ХХК-ийн Гүйцэтгэх захирал:

АРИУНБОЛД овогтой НЯМСҮРЭН

Гарын үсэг:

201

2026.08.31

7.17 Зээлжих зэрэглэл тогтоогч компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ

Хууль зүйн сайдын 2016 оны
А/204 дүгээр тушаалтаар батлав.

МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ
00021625 7

2021.02.01
/ Бүртгэсэн он,сар,өдөр /

9011824434
/ Хувийн хэрэгчийн дугаар /

6659659
/ Регистрийн дугаар /

Монголын хөрөнгө оруулалтын зэрэглэлийн эжинси

Хязгаарлагдмал хариуцлагатай компани

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр
/ шийдвэрийн нэр /

01
/ дугаар /

2021.01.21
/ он, сар, өдөр /

70200
82990
/ Код/

Менежментийн зөвлөгөө өгөх
Санхүүгийн тайлан баланс гаргах, зөвлөгөө өгөх
/ Үйл ажиллагааны чиглэл /

400

2021 оны 01 сар 26 өдөр Бүртгэлийн № 2094
Нэйсэлийн тойргийн нотариатч
Д.Хишигжаргал би энэ хуулбарын
үнэн эхийг баталлаа.
Нотариатч .....

Хугацаагүй
/ хугацаа /

3
/ вишүүдийн тоо /

100,000.00
/ хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Чингэлтэй, 1-р хороо, Жиглийн гудамж, Жи И Би ХХК-ийн байр 306 тоот,
Утас1: 99030338, Утас2: , Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг/

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗАР
/ Бүртгэсэн байгууллагын нэр /

Э.БАТОЧИР
/ гарын үсэг/

ШУНХЛАЙ
он сар өдөр
2026 09 10
БҮРТГЭВ
№ 01

2026 -09- 02
БҮРТГЭВ-03

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичиг оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Чулуундорж овогтой ХашЧулуун-г ТУЗ-ийн дарга-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв. Цэдэвсүрэн овогтой Менхбаяр-г Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2021.02.01 2021.02.01	Э.Баточир Э.Баточир
2	66190 Санхүүгийн чадавхын зэрэглэл тогтоох /2022-06-22/ Санхүүгийн зохицуулах хороо/ № ТЗ 314/02 үйл ажиллагаа шинээр бүртгэв.	2022.09.20	Б.Довдорлхам
3	Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө-1, Алтай бүлдинг, 8 давхар, 607 тоот Утас1: 99030338, Утас2: , Факс: хаягийг шинээр бүртгэв.	2023.11.21	Э.Баточир
4	Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, Жамьян ван гудамж, Даун таун барилга, 11 давхар 1103 тоот Утас1: 99030338, Утас2: , Факс: хаягийг шинээр бүртгэв.	2024.02.23	G.Баасандулам

Энэхүү баримтаар үйлдсэн эх хувийг Монгол Улсын Хууль зүйн яамны харьяанд хүлээлгэж өгсөн.
Улсын бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч бүх хүчинтэй.

УЛААНБААТАР ХОТ
ТТА3531 № 2028466

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
1119269111 № 5481589
Улаанбаатар хот

2026.08.31

7.18 Зээлжих зэрэглэл тогтоогч компанийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээ

МОНГОЛ УЛСЫН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар ТЗ 314/02

2022 оны 06 сарын 22 өдөр

Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 06 сарын 22 өдрийн 359 дугаар тогтоолоор "МОНГОЛЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗЭРЭГЛЭЛИЙН ЭЖИНСИ" ХХК -д Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА Б.БАЯРСАЙХАН

"Тамга"

Энэхүү гэрчилгээ нь хавсралтын хамт хүчинтэй

УЛААНБААТАР ХОТ

Голомт Капитал ҮЦК ХХК

ШУНХЛАЙ СЗХ 2026.09.10 өдөр БҮРТГЭВ № 01

2026-09-02 БҮРТГЭЛ-03

(Энэхүү хавсралт нь тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хамт хүчинтэй)

МОНГОЛ УЛС САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ТЗ 314/02 ТООТ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТ

"Тэмдэг"

Тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдэд зориулсан тэмдэглэлүүд

НЭГ. Хуулийн этгээдийн оноосон нэр: "МОНГОЛЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗӨРӨГЛӨЛИЙН ЭЖИНСИ" ХХК

ХОЁР. Хуулийн этгээдийн ангилал: ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗӨӨЛД ЗОХИЦУУЛАЛТТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ГУРАВ. Үйл ажиллагааны төрөл,хэлбэрийн тэмдэглэл:

Д/д	Үйл ажиллагааны төрөл, хэлбэр	Олгосон огноо	Олгосон шийдвэрийн дугаар	Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, сунгасан хүчингүй болгосон огноо, шийдвэрийн дугаар
1.	Санхүүжих чадахын зөрөглөл тогтоох	2022.06.22	№359 тогтоол	

УЛААНБААТАР ХОТ ШУНХЛАЙ СЗХ ТЛ 3551 Ш. 2028438

Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital Delivering Diversity 1119289111 ☎5481580 Улаанбаатар хот

Үнэт цаасны танилцуулга

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо Жамьян Гүн гудамж, Даун таун барилга, 11 давхар 1103 тоот, 7774-7700, info@mira.mn

ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛ БОЛОН КОМПАНИЙН ҮНЭЛГЭЭ ТОГТООХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр № 20 Улаанбаатар хот

Энэхүү Зээлжих зэрэглэл болон компанийн үнэлгээ тогтоох үйлчилгээ үзүүлэх гэрээ /цаашид "Гэрээ" гэх/-г Монгол Улсын Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн:

Нэг талаас Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо Жамьян Гүн гудамж, Даун таун барилга, 11 давхар 1103 тоот хаягт байрлах 6659659 регистрийн дугаартай "Монголын хөрөнгө оруулалтын зэрэглэлийн эжинси ҮЦК" ХХК /цаашид "Ажил гүйцэтгэгч" гэх/, түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Ц.Мөнхбаяр,

Нөгөө талаас Монгол Улс, Улаанбаатар, Хан-Уул, 2-р хороо, 3-р давхарт тоот хаягт байрлах /2028468/ регистрийн дугаартай "Шунхлай" ХХК / цаашид "Захиалагч" гэх/, түүнийг төлөөлөн Гүйцэтгэх захирал Ж.Мөнхнаран /цаашид хамтад нь "Талууд" гэх/ нар дараах нөхцөлүүдийн талаар харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1.1.Энэхүү Гэрээгээр Ажил гүйцэтгэгч Гэрээний 1.2 болон 1.3-т заасан ажлыг /цаашид "Гэрээт ажил" гэх/ хийж гүйцэтгэх, Захиалагч нь Гэрээт ажилтай холбоотой шаардлагатай мэдээллээр Ажил гүйцэтгэгчийг хангах, Гэрээт ажлыг хүлээн авах, үйлчилгээний төлбөр тооцоог гүйцэтгэх зэрэг Талуудын эрх, үүрэг, хариуцлагатай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1.2.Ажил гүйцэтгэгч нь Захиалагчийн байгууллагын хаалттай, болон нээлттэй хүрээнд гаргах өрийн хэрэгсэлд зэрэглэл тогтооно.

1.3.Гэрээний дагуу тогтоосон зээлжих зэрэглэл нь олон нийтэд нээлттэй байна.

1.4.Зэрэглэлийн дэлгэрэнгүй тайлан болон үндэслэл хэсгийг Захиалагчийн зөвшөөрлөөр олон нийтэд мэдээлж болно.

1.5.Ажил гүйцэтгэгчийн тогтоосон зээлжих зэрэглэл нь Захиалагч болон бусад хуулийн этгээд, иргэнд шууд ба шууд бусаар аливаа хөрөнгө оруулалт хийх, зээл, үнэт цаасыг худалдан авах, худалдах, эсвэл аливаа хөрөнгө оруулалтын стратеги хэрэгжүүлэх зөвлөмж болохгүй.

1.6.Ажил гүйцэтгэгчийн зэрэглэл тогтоосон нь батлан даах байгаа гэсэн баталгаа биш болно.

1.7.Талуудын аль нэг хуулийн этгээдийн хувьд өөрчлөн байгуулагдсан нь энэхүү Гэрээг цуцлах болон үүргээ биелүүлэхгүй байх үндэслэл болохгүй.

1.8.Талуудын аль нэг нь нөгөө Талын зөвшөөрөлгүйгээр Гэрээний эрх үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо Жамьян Гүн гудамж, Даун таун барилга, 11 давхар 1103 тоот, 7774-7700, info@mira.mn

1.9.Дараах баримт бичгүүд нь Гэрээний салшгүй хэсэг болно. Үүнд:

1.9.1. Хавсралт №1: Нэр томьёоны тодорхойлолт;

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

2.1.Талууд энэхүү Гэрээг 2027 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр хүртэл */2 жилийн/* хугацаатай байгуулж байна.

2.2.Энэхүү Гэрээний хугацааг Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт гэрээ байгуулан сунгаж болно.

2.3.Энэхүү Гэрээг хугацаанаас нь өмнө дараах үндэслэлээр цуцалж болно. Үүнд:

2.3.1.Гэрээнд заасан хугацаанд Захиалагч төлбөрөө төлөөгүй тохиолдолд Ажил гүйцэтгэгч нь тухайн нөхцөлийг Захиалагчид албан ёсоор бичгээр мэдэгдэж, нэг талын санаачилгаар Гэрээг цуцалж болно.

2.3.2.Захиалагч нь ажил гүйцэтгүүлэхээс татгалзсан тухайгаа Ажил гүйцэтгэгчид Гэрээт ажил эхлэхээс өмнө албан ёсоор бичгээр мэдэгдсэн эсхүл Ажил гүйцэтгэгч нь Гэрээний хугацаанд Гэрээт ажлыг гүйцэтгээгүй тохиолдолд Захиалагч талын санаачилгаар Гэрээг цуцалж болно.

ГУРАВ. ГЭРЭЭТ АЖЛЫН ТӨЛБӨР

3.1.Гэрээт ажлын нийт төлбөр төгрөг байна.

3.2.Захиалагч Гэрээний 1.2 болон 3.1-д заасан 1 эрээт ажлын нийт төлбөрийн төгрөгийг дараах хуваарийн дагуу 2 хэсэг хуваан төлнө. Үүнд:

3.2.1. Эхний хэсгийн төлбөр болох төгрөгийг энэхүү гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор шилжүүлнэ. Захиалагчийн хүсэлтээр дээрх хугацааг Талууд харилцан тохиролцож сунгаж болно.

3.2.2. Хоёр дах хэсгийн төлбөр болох төгрөгийг эхний хэсгийн төлбөр Ажил гүйцэтгэгчийн дансанд шилжүүлэгдсэн өдрөөс хойш 1 /нэг жилийн/ дараа Талууд гэрээ дүгнэсэн актыг үйлдэж, түүнд үндэслэн ажлын 5 хоногийн дотор шилжүүлнэ. Гэрээ дүгнэсэн акт нь Ажил гүйцэтгэгч нь энэхүү Гэрээнд заасан хугацаанд холбогдох тайлан, дүгнэлтийг гаргасан эсэхийг дүгнэсэн байна.
/Эхний хэсгийн төлбөр 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр шилжүүлэгдсэн бол 2026 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Талууд гэрээг дүгнэсэн актыг үйлдэнэ/

3.2.3. Захиалагч энэхүү гэрээний 3.2.1. болон 3.2.2. дах хэсэгт заасан хуваарийн дагуу Ажил гүйцэтгэгчээс ирүүлсэн төлбөрийн И-баримтын нэхэмжлэхийг үндэслэн Худалдаа Хөгжлийн Банкны 452639897 /IBAN: MN910004000 452639897/ тоот дансанд шилжүүлнэ.

3.3.Энэхүү Гэрээний 3.1-д заасан төлбөрийн нийт дүнд НӨАТ, холбогдох татвар, хураамж, шимтгэл багтсан бөгөөд Ажил гүйцэтгэгч нь Гэрээт ажлын төлбөр төлөгдсөн өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор НӨАТ-ын баримтыг Захиалагчид өгнө.

ШУНХЛАЙ
2026 .09. 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2026 -09- 02
БҮРТГЭВ 03

ГЭРЭЭНИЙ ДУГААР
№ 20
Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо Жамьян Гүн гудамж, Даун таун барилга, 11 давхар 1103 тоот, 7774-7700, info@mira.mn

3.4.Ажил гүйцэтгэгч төлбөрийг энэхүү Гэрээ болон хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд буцаан олгох боломжгүй.

3.5.Захиалагч нь энэхүү Гэрээний 3.1, 3.2-д заасан төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутам гүйцэтгээгүй үнийн дүнгээс 0.1%-ийн алдангийг тооцож, Ажил гүйцэтгэгчид төлөх үүрэгтэй.

ДӨРӨВ. ГЭРЭЭТ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА

4.1 Ажил гүйцэтгэгч нь Гэрээний хугацаанд давтан баталгаажуулалтын тайланг улирал өнгөрснөөс хойш хоёр сарын дотор тухай бүр захиалагчид хүргүүлнэ.

ТАВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

5.1.Захиалагч нь Гэрээнд заасан хугацаанд зээлжих зэрэглэлийг улирал тутам шинэчлэн тогтоохыг Ажил гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.

5.2.Захиалагч нь ажлын гүйцэтгэлтэй танилцах, тодруулга хүсэх эрхтэй.

5.3.Захиалагч нь зээлжих зэрэглэлийн тайлан хүлээн авахаас ажлын 2 хоногийн өмнө тайлангийн төслийг хүлээн авч, мэргэжлийн болон техникийн алдаа байгаа эсэхийг шалгаж, баталгаажуулах эрхтэй.

5.4.Захиалагч нь Ажил гүйцэтгэгчид өгсөн санхүүгийн болон бусад мэдээлэлд материаллаг өөрчлөлт орсон тохиолдолд тухай бүрд нь мэдэгдэх үүрэгтэй. Материаллаг мэдээлэлд банкнаас зээл авах, өрийн бичиг гаргах зэрэг мэдээллүүд хамаарах бөгөөд материаллаг мэдээлэл нь зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй болно.

5.5.Захиалагч нь (i) бодит баримтын талаар худал мэдэгдэл агуулаагүй, мөн ийм мэдээллийг гаргахад шаардлагатай материаллаг баримтыг орхигдуулаагүй, (ii) гуравдагч этгээдийн оюуны өмчийн болон бусад эрхийг зөрчөөгүй, (iii) бусад холбогдох хууль, журмыг зөрчөөгүй мэдээлэл, баримтыг Ажил гүйцэтгэгчид гаргаж өгөх үүрэгтэй.

5.6.Захиалагчийн Ажил гүйцэтгэгчид өгсөн санхүүгийн тайлан, мэдээлэл нь жилийн эцсийн аудитлагдсан мэдээлэл байна. Улирал бүрийн холбогдох санхүүгийн мэдээлэл аудитлагдсан байх шаардлагагүй.

5.7.Захиалагч нь зэрэглэлийн үнэлгээний хүчинтэй хугацаанд улирал бүр Гэрээний хавсралт 2-т заасан мэдээллийг Ажил гүйцэтгэгчид гаргаж өгөх үүрэгтэй.

5.8.Захиалагч нь сүүлийн гурван жилийн хугацаанд Ажил гүйцэтгэгчтэй ижил үйл ажиллагаа явуулдаг этгээдээр тогтоолгосон зэрэглэл, өөрсдөө хүлээн зөвшөөрөөгүй зэрэглэлийн талаарх мэдээлэл байгаа тохиолдолд Ажил гүйцэтгэгчид мэдээлж, түүнтэй холбоотой шаардлагатай баримт бичгийг гаргаж өгөх үүрэгтэй.

5.9.Захиалагч нь зэрэглэлийн үнэлгээний тайланг хүлээн авснаас хойших аливаа эрсдэлийг дангаар хариуцах үүрэгтэй.

5.10. Захиалагч нь Гэрээний төлбөрийг зээлжих зэрэглэлийн үнэлгээний үр дүнгээс үл хамааран гэрээнд заасны дагуу төлөх үүрэгтэй.

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ
ХОТ
2026 -09- 02 № 2026/488

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering Diversity
1119289111 5481569
Улаанбаатар хот

ШУНХЛАЙ 2026 .09. сар 10 өдөр БҮРТГЭВ № 01
MONGOLIAN STOCK EXCHANGE 2026 -09- 02 БҮРТГЭВ-03

ГЭРЭЭНИЙ ДУГААР № 20
Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо Жамьян Гүн гудамж, Даун таун барилга, 11 давхар 1103 тоот, 7774-7700, info@mira.mn

5.11. Захиалагч нь Ажил гүйцэтгэгчийн зэрэглэлийн хорооны гишүүдийн мэдээллийг борлуулалт, маркетингийн зорилгоор ашиглахгүй байх үүрэгтэй.

ЗУРГАА. АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

6.1.Ажил гүйцэтгэгч нь ажил үйлчилгээний төлбөрийг Гэрээнд заасны дагуу шаардах эрхтэй.

6.2.Ажил гүйцэтгэгч нь гүйцэтгэх ажлын хүрээнд Захиалагч талын эрх бүхий албан тушаалтнуудтай ярилцлага хийж, мэдээлэл цуглуулах эрхтэй.

6.3.Ажил гүйцэтгэгч нь олон нийтэд нээлттэй зарласан аргачлалаар зээлжих зэрэглэл тогтоож, Захиалагч уг үнэлгээний тайланг хүлээн зөвшөөрсөн эсэхээс үл хамаарч хүлээлгэн өгөх эрхтэй.

6.4.Захиалагч энэхүү Гэрээний 5.5-т заасан үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд Ажил гүйцэтгэгч нь Гэрээний 4.1-т заасан хугацааг өөрчилж, өөрийн санал болгосон хугацаанд зэрэглэлийн үнэлгээний тайланг хүлээлгэн өгөх эрхтэй.

6.5.Ажил гүйцэтгэгч нь хараат бус, бие даасан байдлаа хадгалж, өөрийн дотоод журмын дагуу зээлжих зэрэглэлийг тогтоох ба шаардлагатай тохиолдолд холбогдох баримтад тулгуурлан зэрэглэлийг өсгөж, бууруулж болно.

6.6.Ажил гүйцэтгэгч нь аливаа андеррайтинг, зээл, зээл худалдан авалт, стратегийн болон бусад хөрөнгө оруулалтын шийдвэрт хариуцлага хүлээхгүй.

6.7.Ажил гүйцэтгэгч нь Захиалагчид аливаа санхүүгийн зөвлөгөө өгөх, хууль эрх зүй, аудит, нягтлан бодох бүртгэл зэрэг Гэрээнд зааснаас өөр ажил, үйлчилгээг үзүүлэхгүй.

6.8.Ажил гүйцэтгэгч нь Гэрээт ажлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, стандартын дагуу мэргэжлийн өндөр түвшинд хийж гүйцэтгэн Гэрээнд заасан хугацаанд нь Захиалагчид хүлээлгэн өгөх үүрэгтэй.

6.9.Ажил гүйцэтгэгч нь зээлжих зэрэглэлийн үнэлгээний тайланг Захиалагч хүлээн зөвшөөрсөн эсэхээс үл хамааран Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэх үүрэгтэй.

6.10. Ажил гүйцэтгэгч нь зэрэглэлийн үнэлгээг олон нийтэд нээлттэй аргачлалаар тогтоох ба Захиалагчаас өгсөн болон бусад албан ёсны эх сурвалжаас авсан үнэн зөв, бодит мэдээлэл, баримт бичигт тулгуурлан тогтоох үүрэгтэй.

6.11. Ажил гүйцэтгэгч нь зээлжих зэрэглэлийн үнэлгээний тайлан болон бусад материалуудыг холбогдох журмын дагуу өөрийн архивд 5 хүртэлх жилийн хугацаанд хадгалах үүрэгтэй.

6.12. Ажил гүйцэтгэгч нь Захиалагчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр зэрэглэл тогтооход ашигласан мэдээллийг задруулахгүй байх үүрэгтэй. Харин дараах тохиолдолд (i) Эрх зүйн акт болон холбогдох төрийн эрх бүхий байгууллагын шаардлагын дагуу олон нийтэд ил болгохыг үүрэг болгосон мэдээлэл, (ii) Ажил гүйцэтгэгчийн зүгээс үнэлгээ эсвэл үнэлгээний шинжилгээний аль нэг хэсэг нь олон нийтэд мэдэгдэж байх шаардлагатай гэж үзсэн мэдээлэл (iii) хуульд заасан бусад үндэслэлээр мэдээлнэ.

6.13. Ажил гүйцэтгэгч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажлыг хойшлуулах, удаашруулсан тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутам Гэрээний үнийн дүнгээс 0.1%-ийн алдангийг тооцож, Захиалагчид төлөх үүрэгтэй.

УЛААНБААТАР ХОТ ШУНХЛАЙ ХХК
Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital Delivering diversity 1119289111 Улаанбаатар хот

2026.08.31

6.14. Ажил гүйцэтгэгч нь төлбөрийн нөхцөлд нэмэлт өөрчлөлт оруулахаар бол Захиалагчид урьдчилан мэдэгдэж, харилцан тохиролцсоны үндсэн дээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

6.15. Захиалагчийн зэрэглэл тогтооход бүрдүүлж өгсөн мэдээллийн үнэн зөв, бодит, бүрэн бүтэн байдалд Ажил гүйцэтгэгч тал хариуцлага хүлээхгүй.

6.16. Ажил гүйцэтгэгч нь хууль болон гэрээнд зааснаас бусад тохиолдолд Захиалагчийн зөвшөөрөлгүйгээр энэхүү Гэрээ байгуулсантай холбоотойгоор олж мэдсэн байгууллагын болон харилцагчийн нууцад хамаарах баримт бичиг, мэдээллийг Гэрээнд зааснаас бусад зорилгоор ашиглах, хувилах, тараахгүй, задруулахгүй байх үүрэгтэй.

ДОЛОО. ХАРИУЦЛАГА

7.1. Ажил гүйцэтгэгч нь Захиалагчийн бусдын өмнө хүлээх үүрэг, хариуцлагыг хүлээхгүй ба Гэрээт ажлыг Захиалагчийн гарган өгсөн баримт бичиг, мэдээлэл дээр үндэслэн хийж гүйцэтгэнэ. Захиалагчийн санаатай болон болгоомжгүй үйлдэл, эс үйлдэхүйн улмаас дээрх баримт бичиг, мэдээлэл нь худал, алдаатай байснаас үүсэх аливаа хариуцлагыг Ажил гүйцэтгэгч хариуцахгүй болно.

7.2. Ажил гүйцэтгэгч нь 6.16-д заасан үүргээ зөрчсөний улмаас захиалагч талд учирсан бодит хохирлыг бүрэн хариуцан барагдуулна.

7.3. Аль нэг Тал нь энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс нөгөө Талдаа хохирол учруулсан тохиолдолд буруутай Тал нь учруулсан бодит хохирлыг бүрэн хариуцан барагдуулна.

НАЙМ. АВЛИГА, АШИГ СОНИРХОЛ

8.1. Талууд энэхүү Гэрээг байгуулах, хэрэгжүүлэхтэй холбогдуулан мөнгөн буюу мөнгөн бус хэлбэрээр шагнал, шан харамж, урамшуулал зэрэг Гэрээнд тусгагдаагүй аливаа төлбөрийг харилцан төлөөгүй болно.

8.2. Ажил гүйцэтгэгчид энэхүү Гэрээнд заасан ажил үүрэг гүйцэтгэхдээ холбогдох албан Захиалагчийн удирдлагын баг болон ажилтанд хөнгөлөлттэй ажил үйлчилгээ амлах, бэлэг, шан харамжийн зүйл болон бусад хууль бус хангамж, урамшуулал өгөх, авахыг хориглоно. Хэрэв үүнээс үүдэн Захиалагч болон гуравдагч этгээдэд хохирол учирсан тохиолдолд хохирлыг бүрэн хариуцах үүрэгтэй.

8.3. Ажил гүйцэтгэгч нь Захиалагчийн гүйцэтгэх удирдлага, дэд захирал болон бусад эрх бүхий этгээд, ажилтантай урьд өмнө хамтран ажиллаж байсан эсхүл гэрээ, хэлэлцээр хийж байсан болон аливаа хэлбэрээр харилцан хамааралтай ажиллаж байсан тохиолдолд энэ талаар ашиг сонирхлын зөрчил үүсгэхээс өмнө урьдчилан /Info@mira.mn/ хаягаар мэдээлэх үүрэгтэй.

8.4. Захиалагч нь Ажил гүйцэтгэгч талаас энэхүү Гэрээний ажил үүрэг гүйцэтгэхтэй холбогдуулан хөнгөлөлттэй ажил үйлчилгээ, бэлэг шан харамжийн зүйл болон бусад хууль бус хангамж, урамшуулал өгөхийг шаардсан тохиолдолд үүнийг /Info@mira.mn/, /khaliun@mira.mn/ хаягаар мэдээлэх үүрэгтэй.

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
TA3531 № 2023608

210

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
1119289111 ☎ 5481589
Улаанбаатар хот

2026.08.31

ГЭР ЭЭНИЙ ДУГААР №20
Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо Жамьян Гүн гудамж, Даун таун барилга, 11 давхар 1103 тоот, 7774-7700, info@mira.mn

8.5. Ажил гүйцэтгэгч нь Захиалагч талаас энэхүү Гэрээний ажил үүрэг гүйцэтгэхтэй холбогдуулан хөнгөлөлттэй ажил үйлчилгээ, бэлэг шан харамжийн зүйл болон бусад хууль бус хангамж, урамшуулал өгөхийг шаардсан тохиолдолд үүнийг /Info@mira.mn/, /khaliun@mira.mn/ хаягаар мэдээлэх үүрэгтэй.

8.6. Ажил гүйцэтгэгч нь дээр дурдсан мэдээлэх үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд үүдэн гарах хохирлыг Захиалагчийн өмнө бүрэн хариуцна.

ЕС. ГЭНЭТИЙН БОЛОН ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛС

9.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас Талуудын аль нэг нь Гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй, биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд нөгөө Талдаа ажлын 10 хоногийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.

9.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлс бий болсон нь хуанлийн 1 нэг сараас дээш хугацаагаар үргэлжилсэн бол Талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

9.3. Гэрээний аль нэг Тал гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд Гэрээний үүргийн гүйцэтгэлийн хангаагүйтэй холбоотой аливаа хариуцлагаас чөлөөлөгдөнө.

АРАВ. БУСАД ЗҮЙЛ

10.1. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах ба аливаа нэмэлт, өөрчлөлтийг оруулахаар санал гаргасан Тал нөгөө Талд бичгээр мэдэгдсэн байна. Гэрээний нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэж, Талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр ба болох энэхүү Гэрээний салшгүй хэсэг байна.

10.2. Талууд шударга бус өрсөлдөөнөөс сэргийлэх үүднээс энэхүү Гэрээ болон түүний хавсралтуудыг нууцлах ба бусдад задруулахгүй байх үүрэг хүлээнэ.

10.3. Энэхүү Гэрээний талаар гарсан маргааныг Талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Зөвшилцөлд хүрэхгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

10.4. Аль нэг Тал гэрээг сунгах тухай санал гаргаагүй бол энэхүү Гэрээнд заасан хугацаагаар Гэрээ дуусгавар болно. Мөн зэрэглэлийн үнэлгээ нь Гэрээний хүчинтэй хугацаа дуусгавар болоход хүчингүй болно.

10.5. Энэхүү Гэрээ нь Талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

10.6. Талууд Гэрээг 3 хувь үйлдэх ба Тал тус бүр нэг хувийг хадгалсан нь хуулийн адил хүчинтэй байна.

10.7. Энэхүү гэрээнд талуудын Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар болон НӨАТ төлөгчийн гэрчилгээний хуулбарыг тус тус хавсаргана.

211

2026.08.31

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо Жамьян Гүн гудамж,
Даун таун барилга, 11 давхар 1103 тоот, 7774-7700, info@mirai.mn

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

"Монголын хөрөнгө оруулалтын зөрэглэлийн эжинси ҮЦК" ХХК:

Гүйцэтгэх захирал: Ц.Монхбаяр

Гарын үсэг:

Утас: 7774-7700, 9903-0338

Хаяг: УБ, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Жамъян гүн гудамж, Даун таун барилга, 11 давхар 1103 тоот

"Шунхлай" ХХК:

Гүйцэтгэх захирал: Ж.Монхнаран

Гарын үсэг:

Утас: 9911-9100

Хаяг: УБ, Хан-Уул, 2-р хороо, 3-р давхарт

ШУНХЛАЙ
2026 .09 .19
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

2026 -09- 02
БҮРТГЭВ-03

ГЭРЭЭНИЙ ДУГААР
№ 20
Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо Жамьян Гүн гудамж,
Даун таун барилга, 11 давхар 1103 тоот, 7774-7700, info@mira.mn

2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн
№20 дугаар "Зээлжих зэрэглэл тогтоох үйлчилгээ үзүүлэх"
Гэрээний Хавсралт №01

1. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

1.1 Энэхүү гэрээнд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

1.1.1 "Зээлжих зэрэглэл тогтоох үйл ажиллагаа" гэж хуулийн этгээдийн зээлжих зэрэглэлийг тусгайлан боловсруулсан аргачлалд үндэслэн тогтоох хөндлөнгийн, хараат бус үйл ажиллагааг;

1.1.2 "Зээлжих зэрэглэл" гэж хуулийн этгээдийн үйл ажиллагаа, түүний аливаа өр төлбөр, түүнтэй адилтгах өрийн бичгийн ирээдүйд төлбөр төлөх чадварын богино болон дунд хугацааны төлөв байдал, төсөөллийг тодорхойлох замаар тухайн байгууллагад өгсөн үнэлэлт, дүгнэлтийг;

1.1.3 "Өрийн хэрэгсэл" гэж гэж үнэт цаас гаргагчаас тогтоосон хугацаа дуусмагц үндсэн төлбөр болон хүүг мөнгөн хэлбэрээр, эсхүл тодорхой эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн хэлбэрээр тухайн үнэт цаасыг эзэмшигчид эргүүлэн төлөх үүргийг гэрчилсэн болон түүнтэй адилтгах бусад үнэт цаасыг;

1.1.4 "Материаллаг мэдээлэл" гэж тухайн байгууллагын санхүүгийн тайланд тулгуурлан гаргах гэж буй эдийн засгийн шийдвэрээ өөрчлөхөд хүргэж буй материаллаг чанартай мэдээллүүдийг;

1.1.5 "Зэрэглэлийн үнэлгээний хүчинтэй хугацаа" гэдэгт байгууллагын зэрэглэл болон бондын зэрэглэлийг хамааруулах бөгөөд байгууллагын зэрэглэл нь гэрээний хугацаанд хүчинтэй байх бол бондын зэрэглэл нь бондын хугацааны туршид хүчинтэй байхыг;

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
ТТА3531 ☎ 2028488

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering Diversity
1119289111 ☎ 5481589
Улаанбаатар хот

ГЭРЭЭНИЙ ДУГААР №20
Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо Жамьян Гүн гудамж, Даун таун барилга, 11 давхар 1103 тоот, 7774-7700, info@mira.mn

2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн
№20 дугаар "Зээлжих зэрэглэл тогтоох үйлчилгээ үзүүлэх"
Гэрээний Хавсралт №02

1. ШААРДЛАГАТАЙ МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

1.1 Улирал бүрийн санхүү балансын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээний тайлан

1.2 Улирал бүрийн элэгдэл, хорогдлын дүн , санхүүгийн түрээсийн хүүгийн зардал

1.3 Улирал бүрийн борлуулалтын бүтээгдэхүүн тус бүрээрх задаргаа

1.4 Улирал бүрийн Жижиглэн, бөөний борлуулалтын задаргаа

1.5 Улирал бүрийн шатахууны нөөцийн мэдээлэл

1.6 Улирал бүрээрх үлдэгдэлтэй байгаа банк санхүүгийн байгууллагуудаас авсан зээлийн дэлгэрэнгүй мэдээлэл

1.7 Санхүүгийн төлөвлөгөөнд өөрчлөлт орсон бол орсон өөрчлөлтийн мэдээлэл

1.8 Зээлжих зэрэглэлд нөлөөлөхүйц гэж үзэж буй бусад материал (ТУЗ-ийн гишүүдэд өөрчлөлт орсон эсэх, гүйцэтгэх удирдлагад өөрчлөлт орсон эсэх, хувьцаа эзэмшигчдэд өөрчлөлт орсон эсэх мэдээлэл).

ШУНХЛАЙ
2026 .09. 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Үнэт цаасны танилцуулга

2026 -09- 02
БҮРТГЭВ-03

ГЭРГЭЭНИЙ ДУГААР
Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо Жамьян Гүн гудамж,
Даун таун барилга, 11 давхар 1103 тоот, 7774-7700, info@mira.mn

Хуулийн этгээдийн 2016 оны
№294 дугаар тушаалаар баталсан.

МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ
000216257

2021.02.01
/ Бүртгэсэн он,сар,өдөр /

9011824434
/ Хувийн хэрэгчийн дугаар /

6659659
/ Регистрийн дугаар /

Монголын хөрөнгө оруулалтын зэрэглэлийн эхлэл

Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дурэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр
/ шийдвэрийн нэр /

01
/ дугаар /

2021.01.21
/ он, сар, өдөр /

70200
82990
/ Код/

Менежментийн зөвлөгөө өгөх
Санхүүгийн тайлан баланс гаргах, зөвлөгөө өгөх
/ Үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй
/ хугацаа /

3
/ эзэмшигчдийн тоо /

100,000.00
/ хөрөнгийн хэмжээ, мөнгөн тэмдэгт /

Улаанбаатар, Чингэлтэй, 1-р хороо, жигжидсүрэн гудамж, Жи И Би ХХК-ийн байр 306 тоот,
Утас1: 99030338, Утас2: , Факс:
/ хуулийн этгээдийн хаяг, холбоо барих хаяг/

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗАР
/ Бүртгэсэн байгууллагын нэр /

ҮЛСЫН БҮРТГЭГЧ
/ эмэгтэй /
Э.БАТОЧИР
/ гарын үсэг /

10/13

УЛААНБААТАР ХОТ
ТТА3531 ᠣ. 2028468

215

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
1119289111 5481588
Улаанбаатар хот

2026.08.31

ШУНХЛАЙ СЗХ 2026 .09.10 өдөр БҮРТГЭВ № 01

MONGOLIAN STOCK EXCHANGE 2026-09-02 БҮРТГЭВ-03

ТӨРӨЭНИЙ ДУРААР № 20

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо Жамьян гүн гудамж, Даун таун барилга, 11 давхар 1103 тоот, 7774-7700, info@mira.mn

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичгийг оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан гэмтэг
1	Чулуунбарих овогтой Хишчулуун-г ТУЗ-ийн дарга-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв. Цэдэсүрэн овогтой Менхбаяр-г Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2021.02.01 2021.02.01	Э.Батчимэг Э.Батчимэг
2	66190 Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэр /2022-06-22/ Сонгинохайрхан хороо/ № ТЗ 314/02 үйл ажиллагаа шинээр бүртгэв.	2022.09.20	Б.Долгорцэцэг
3	Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, Чингисийн аргын чанга-1, Алтай бизнесийн, 6 давхар, 607 тоот Утас1: 99030338, Утас2: , Факс: хаягийг шинээр бүртгэв.	2023.11.21	Э.Батчимэг
4	Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, Жамьян гүн гудамж, Даун таун барилга, 11 давхар 1103 тоот Утас1: 99030338, Утас2: , Факс: хаягийг шинээр бүртгэв.	2024.02.23	С.Баясгалан
5	Монгол улсын хөрөнгө оруулалтын зөвлөлийн зөвшөөрсөн нэр Монголын хөрөнгө оруулалтын зөвлөлийн зөвшөөрөл УЦК балж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2025.04.01	Ш.Оюнцэцэг

УЛААНБААТАР ХОТ ШУНХЛАЙ ХХК ГГА3531 № 2026488

Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital Delivering diversity 1119289111 Улаанбаатар хот

2026.08.31

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо Жамьян Гүн гудамж, Даун таун барилга, 11 давхар 1103 тоот, 7774-7700, info@mira.mn

Татвар төлөгчийн бүртгэлийн журмын 1 дүгаар хавсралт

Монголын Татварын Алба

Маяг ТБ-01

ТАТВАР ТӨЛӨГЧИЙН ГЭРЧИЛГЭЭ
Дугаар 251120192709

Татвар төлөгч хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагын мэдээлэл:

Нэр:	Монголын хөрөнгө оруулалтын зэрэглэлийн эжинси	Улсын харьяалал:	Монгол улс
Регистрийн дугаар:	6659659	Өмчийн хэлбэр:	Хувийн
Татвар төлөгчийн дугаар:	11200050816	Хариуцлагын хэлбэр:	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
Харьяалах татварын алба:	Чингэлтэй	Татвар төлөгчөөр бүртгэгдсэн он, сар, өдөр:	2021 оны 2 сарын 4 өдөр.

Татвар төлөгч хуулийн этгээдийн удирдлагын мэдээлэл:

Татвар төлөгчийн дугаар:	111941020962	Эцэг /эх/-ийн нэр:	Цэдэвсүрэн
Регистрийн дугаар:	МЮ80030830	Нэр:	МӨНХБАЯР
		Овог:	Боржигин

Татвар төлөгч хуулийн этгээдийн хаяг, холбоо барих мэдээлэл:

Аймаг, хот:	Улаанбаатар	Утас:	99030338
Сум, дүүрэг:	Чингэлтэй	Факс:	
Баг, хороо:	1-р хороо	Шуудангийн хайрцаг:	
Гудамж, хороолол:		И-мэйл хаяг:	otgoo08111@gmail.com
Байшин, хашаа, хаалга:	жигжиджавын гудамж, Жи И Би ХХК-ийн байр 306 тоот	Вэб хаяг:	

Татвар төлөгч хуулийн этгээдийн бүртгэгдсэн татварын төрлийн мэдээлэл:

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ
ТТА3581 № 2028468

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
1119289111 ☎ 5481589
Улаанбаатар хот

ШУНХЛАЙ СЗХ 2026.09.сар 10 өдөр БҮРТГЭЛ №21

MONGOLIAN STOCK EXCHANGE 2026-09-02 БҮРТГЭЛ-03

ГЭРЭЭНИЙ ДУГААР № 20

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо Жамьян Гүн гудамж, Даун таун барилга, 11 давхар 1103 тоот, 7774-7700, info@mira.mn

Алба	Татварын төрөл	Бүртгүүлсэн он, сар, өдөр	Хасагдсан он, сар, өдөр
Чингэлтэй	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	2021-02-04	
Чингэлтэй	Дотоодын бараа, үйлчилгээний суутгасан НӨАТ	2023-11-23	
Чингэлтэй	Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татвар	2023-12-01	
Чингэлтэй	Цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татвар	2021-02-04	

25.1003.ed7d0d16-9dce-4fb5-838d-d2babe099fe9

Санамж

Энэхүү баримт бичгийг хуулийн дагуу үйлдэхийг зориглоно
Хэрэв хуулийн дагуу үйлдсэн технологийн хуулийн хариуцлага хүлээлгэнэ

Үүсгэсэн огноо 2025-11-20 17:39:38

УЛААНБААТАР ХОТ ШУНХЛАЙ ХХК

Голомт Капитал ХХК Golomt Capital Delivering diversity 1119289114 5481589 Улаанбаатар хот

2026.08.31

СЗХ 2026 09 10 БҮРТГЭВ № 01

2026 -09- 02 БҮРТГЭВ-03

7.20 Зээлжих зэрэглэлийн үнэлгээний тайлан

ISSUER RATING

Mongolian Investment Rating Agency

Зээлжих Зэрэглэлийн Үнэлгээний Тайлан
"Шунхлай" ХХК

МИРА компанийн Зэрэглэлийн Хорооны 2026 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар "Шунхлай" ХХК-ийн байгууллагын, хаалттай болон нээлттэй гаргаж буй бондын зэрэглэлийг "А" /тогтвортой/ төлөвтэйгөөр тогтоов.

Зээлжих Зэрэглэл[1]

Зэрэглэлийн төрөл	Үнэт цаасны төрөл	Үнэт цаасны нэр	Үнэт цаасны дүн	Зэрэглэлийн УА	Хүчинтэй огноо	Зэрэглэл & Төлөв байдал
Байгууллагын зэрэглэл	n/a	n/a	n/a	Тогтоосон	11/24/2026	А Тогтвортой
Шинээр гаргах үнэт цаасны дүн[2]	Хаалттай болон нээлттэй	Бонд	200.0 тэрбум төгрөг	Шинээр гаргах	11/24/2026[3]	А Тогтвортой

Арилжаалагдаж буй зэрэглэлтэй бондын мэдээлэл

Бонд №	Эхлэх огноо	Дуусах огноо	Үнэт цаасны дүн	Зэрэглэлийн УА	Арилжаалсан биржь	Зэрэглэл & Төлөв
1	9/11/2025	9/11/2026	40,000,000,000	Хянасан	МХБ	А Тогтвортой
2	9/17/2025	9/17/2026	10,000,000,000	Хянасан	МХБ	А Тогтвортой
3	12/11/2025	12/11/2026	50,000,000,000	Хянасан	МХБ	А Тогтвортой

Компанийн тухай

"Шунхлай" ХХК (*РД: 2028468, Хаяг: Монгол Улс, Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 2-р хороо, 3 давхарт*) нь 1993 онд үүсгэн байгуулагдаж үйл ажиллагаа явуулж байна. Тус байгууллага нь Ашигт малтмал газрын тосны газраас газрын тосны бүтээгдэхүүн импортлох, бөөний худалдаа эрхлэх, жижиглэн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшдэг.

---

[1] *Энэхүү зээлжих зэрэглэлийн үнэлгээнд "Шунхлай" ХХК-ийн 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн нэгтгэсэн аудитлагдаагүй тайлан болон 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн нэгтгэсэн аудитлагдаагүй санхүүгийн тайланг ашигласан болно. Үнэлгээ гаргахад зээлжих зэрэглэлийн тайлангийн өдөр хүртэлх хөлбөгдөх гоон болон чанарын мэдээллийг мөн харгалзан үзсэн. Тогтоосон зээлжих зэрэглэл нь үнэт цаас гаргагч болон дээр дурдсан өрийн бичгийн зэрэглэл юм.*

[2] *Бондын зэрэглэл нь бонд гаргаж буй байгууллагын зэрэглэлээс ялгаатай байж болно. Бондын зэрэглэл нь тухайн бонд гаргаж буй байгууллагын өр төлбөрийн дараалал, санал болгож буй бондын нөхцөлөөс хамааран тогтоогдох бөгөөд зэрэглэлийн ялгаатай байдал нь зах зээлийн эрсдэлээс хамаардагүй.*

[3] *Талуудын хооронд байгуулсан гэрээний хүрээнд хүчинтэй огноо хүртэлх хугацаанд компанийн гаргаж болох боломжит зээлжих зэрэглэлтэй бондын дүн*

УЛААНБААТАР ХОТ ШУНХЛАЙ ХХК ТТА3531 ☎ 2028468

Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital Delivering diversity 1119289111 ☎ 5481589 Улаанбаатар хот

Зээлжих зэрэглэлийн төлөв: Тогтвортой (Stable)

Зээлжих зэрэглэлийн тогтмол буюу stable төлөв нь компанийн олон жилийн туршлага, тогтвортой бизнесийн загвар, болон эх үүсвэрийн төрөлжилт сайтай зэргээс хамаарсан богино хугацааны төлөвийн үнэлгээ юм. Компани өрийн удирдлагыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд 2025 онд Монголын Хөрөнгийн Биржид 100.0 тэрбум төгрөгийн бонд арилжаалсан байна.

Компанийн 2025 оны санхүүгийн тайланд "Прайсуотерхаускуперс-аудит" ХХК олон улсын компани аудит хийж байгаа бөгөөд аудитлагдсан тайлан 2026 оны 9 дүгээр сарын сарын 30-нд гарахаар байна.

Зэрэглэлийн ерөнхий мэдээлэл

2026 оны 02 дугаар сарын 28-ны өдөр АНУ болон Израилын хамтарсан цэргийн ажиллагаа Иран улсыг довтолсонтой холбоотойгоор Ойрх Дорнодын бүс нутагт тогтворгүй байдлыг нэмэгдүүлж дэлхийн газрын тосны нийлүүлэлтэд огцом нөлөөлөл үзүүлсэн. Сөргөлдөөний улмаас дэлхийн зах зээл дээр газрын тосны үнэ өсөж байгаа бөгөөд Зүүн өмнөд азийн зарим орнуудад нийлүүлэлтийн тасалдал үүссэн байна.

2025 оны жилийн эцсийн байдлаар брент маркийн газрын тосны үнийн баррель тутам нь 60 ам.доллар байсан бол 2026 оны 03 дугаар сарын 31-ний байдлаар 104.0 ам.доллар болж 73%-иар нэмэгдсэн байна. Зэвсэгт мөргөлдөөн үргэлжилж байгаа ч нөхцөл байдлаас шалтгаалан 8-р сарын байдлаар баррель тутам нь 89 ам.доллар болж буурсан үзүүлэлттэй байна.

Монгол Улсын хувьд дизель түлшний 97% ОХУ-ын импортоос хамааралтай байдаг бөгөөд Аи-92 шатахууны хувьд импортоос давсан хэрэглээтэй холбогдуулан 2026 оны 7-р сараас эхлэн Монгол Улс шатахууны нөөцийн хомсдолд орсон. Дизель түлшний хувьд нөөцийн асуудалгүй байна. Дотоодод худалдаалж байгаа дизель түлш болон Аи-92 шатахууны жижиглэнгийн үнийг доорх графикт тусгав.

Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан - 1212.mn, 2026 оны 8-р сарын 17-ны өдөр

Дизель түлшний борлуулалтын үнэ 2026 он гарсаар тогтмол 3140 төгрөг байсан боловч 03-р сарын 16-ны өдрөөс өсөж 5-р сард хамгийн өндөр түвшин буюу 4335 төгрөгт хүрсэн бол 7-р сарын байдлаар бага зэрэг буурч литр тутам нь 4185 төгрөг байна. Аи-

220

2026.08.31

92 шатахууны хувьд үнийн хувьд өөрчлөлтгүй буюу литр тутмыг 2590 төгрөгөөр худалдаалж байсан боловч хомсдолоос шалтгаалан литр тутмын үнэ 2840 төгрөг болсон байна.

"Шунхлай" ХХК-ийн ашигт ажиллагаа, орлого үр дүнгийн байдал нь литр тутмын түлш, шатахууны үнэ, Монгол Улсын уул уурхайн салбар, экспортын орлогоос хамаарч байна. 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт экспортын дүн 15.76 тэрбум ам.доллар болж өмнө оны мөн үетэй харьцуулахад 0.1%-иар буурсан үзүүлэлттэй гарсан. Тэгвэл 2026 оны 2 дугаар улирлын байдлаар нийт экспортын дүн 10.39 тэрбум ам.доллар гарсан бөгөөд өмнөх оны мөн үеэс 57.9%-иар өссөн үзүүлэлттэй байна. Экспортын голлох нэр төрлийн бараануудын экспортын дүн болон нэг жилийн өмнөх үетэй харьцуулсан өөрчлөлтийг хүснэгтэд тусгав.

Мянган ам.доллар	2025.II	2026.II	Өөрчлөлт
Зэсийн хүдэр, баяжмал	**2,352,284.97**	**4,645,657.27**	**97.5%**
Молибдены хүдэр ба баяжмал	42,596.74	34,651.46	-18.7%
Жоншны хүдэр ба баяжмал	153,077.70	150,278.58	-1.8%
Гянтболдын хүдэр баяжмал	3,357.14	28,717.50	755.4%
Төмрийн хүдэр, баяжмал	275,776.58	307,917.56	11.7%
Цайрын баяжмал	114,112.38	138,075.68	21.0%
Тунгаасан зэс ба хайлш	67,086.75	31,232.56	-53.4%
Нүүрс	**2,652,813.15**	**4,015,529.97**	**51.4%**

2026 оны 2 дугаар улирлын байдлаар зэсийн экспорт болон нүүрсний экспорт өссөн үзүүлэлттэй байна. Нүүрсний экспорт үнийн дүнгээр өмнөх оны мөн үеэс 51.4%-иар өссөн үзүүлэлттэй байгаа бол зэсийн баяжмалын экспорт 97.5%-иар өссөн үзүүлэлттэй байна. Мэдээлэл технологийн салбарын өсөлтийн хурдацтай уялдуулан зэсийн үнэ дэлхийн зах зээлд сүүлийн нэг жилийн хугацаанд 44.3%-иар өссөн үзүүлэлттэй байна. Дэлхийн банк болон Азийн хөгжлийн банкнаас 2026 онд Монгол Улсын эдийн засгийг 5.3%-иар өсөх төсөөлөл гаргасан байна.

Ашигт ажиллагааны шинжилгээ

Маш сайн | Сайн | Хангалттай | Хүрэлцээтэй | Муу

"Шунхлай" ХХК-ийн орлого үр дүнгийн тайлангийн голлох тоон болон харьцаа үзүүлэлтүүдийг хүснэгтэд тусгав. Компанийн 2026 оны 2 дугаар улирлын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт ашгийг нийт орлогод харьцуулсан харьцаа үзүүлэлт 6.88 пунктээр, цэвэр ашгийн маржин 5.3 пунктээр, эздийн өмчид ноогдох өгөөж 16.84 пунктээр, нийт хөрөнгөд ноогдох өгөөж 5.26 пунктээр тус тус өссөн үзүүлэлтүүдтэй байна. Жилийн өсөлтийг аваад үзэхэд нийт орлогын дүн цар тахлын үед буюу 2020 онд 18.5%-иар буурсан үзүүлэлттэй байгаа бол бусад жилүүдэд өссөн үзүүлэлттэй байна. Тайлант огнооны байдлаар өнгөрсөн нэг жилийн хугацаанд борлуулалтын орлого 32.4%-иар, нийт ашиг 115%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Сая төгрөг	2025.II	2025	2026.II
Борлуулалтын орлого	797,930	1,825,654	1,056,280
Борлуулалтын өртөг	(709,944)	(1,579,912)	(867,109)
Нийт ашиг	87,985	245,742	189,171
Цэвэр ашиг	**2,312**	**50,346**	**59,105**
Нийт ашгийн маржин	11.03%	13.46%	17.91%
EBITDA маржин	4.73%	6.93%	10.98%
Цэвэр ашгийн маржин	0.29%	2.76%	5.60%
ROE	1.13%	18.75%	17.97%
ROA	0.37%	6.82%	5.63%
Орлогын жилийн өсөлт*	3.60%	9.32%	32.38%
Нийт ашгийн жилийн өсөлт*	-13.20%	9.50%	115.00%
Цэвэр ашгийн жилийн өсөлт*	-90.50%	-3.24%	2456.60%

*Өмнөх оны мөн үеэс тооцов.

Эргэлтийн хөрөнгө болон эргэлтийн өр төлбөрийн удирдлагын шинжилгээг хийхэд 2026 оны 2 дугаар улирлын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад дансны авлага цуглуулах дундаж хугацаа 85 хоногоос 81 хоног болсон, дансны өглөг төлөх дундаж хугацаа 29 хоногоос 57 хоног болж өссөн, бараа материалын худалдан борлуулах хугацаа 65 хоногоос 113 хоног болон өссөн байна. Мөн мөнгөн хөрөнгийн эргэлтийн хоног 121 хоногоос 138 хоног болж өссөн байна.

	2025.II	2025	2026.II
Борлуулалт / дансны авлага	4.3	10.73	4.49
Дансны авлага цуглуулах дундаж хугацаа /хоног/	85	34	81
Худалдан авалт / дансны өглөг	12.81	11.45	6.41
Дансны өглөг төлөх дундаж хугацаа /хоног/	29	32	57
ББӨ / Бараа материал	5.6	10.14	3.22
Бараа материалын худалдан борлуулах хугацаа /хоног/	65	36	113
Мөнгөн хөрөнгийн эргэлтийн мөчлөг (CCC)	121	38	138

Балансын Тайлангийн шинжилгээ

Маш сайн | Сайн | Хангалттай | Хүрэлцээтэй | Муу

"Шунхлай" ХХК-ийн санхүүгийн тайлангийн голлох тоон болон харьцаа үзүүлэлтүүд, жилийн өөрчлөлтийг хүснэгтэд тусгав. 2026 оны 2 дугаар улирлын байдлаар компанийн нийт хөрөнгийн 68.7%-ийг өр төлбөрөөр, 31.3%-ийг эздийн өмчөөр санхүүжүүлсэн үр дүнтэй байна. 2026 оны 2 дугаар улирлын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт хөрөнгийн өсөлт 67.1%, нийт өр төлбөрийн өсөлт 70.4%, эздийн өмчийн өсөлт 60.3% тус тус байна. Өр төлбөрийн өсөлтийг аваад үзвэл 2026 оны 2 дугаар улирлын байдлаар эргэлтийн өр төлбөр өмнө жилийн мөн үеэс 93%-иар, эргэлтийн бус өр төлбөр 25%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

222

2026.08.31

Сая төгрөг	2025.II	2025	2026.II
Хөрөнгө			
Эргэлтийн хөрөнгө	416,280	365,426	637,330
Эргэлтийн бус хөрөнгө	211,904	372,751	412,610
Нийт хөрөнгө	**628,185**	**738,176**	**1,049,940**
Өр төлбөр			
Эргэлтийн өр төлбөр	285,461	417,831	548,863
Эргэлтийн бус өр төлбөр	137,601	51,838	172,177
Нийт өр төлбөр	**423,062**	**469,669**	**721,039**
Нийт эздийн өмч	**205,123**	**268,508**	**328,900**
Нийт өр төлбөр ба эздийн өмч	**628,185**	**738,176**	**1,049,940**
Өр төлбөр, хөрөнгийн харьцаа	67.35%	63.63%	68.67%
Эздийн өмч, хөрөнгийн харьцаа	32.65%	36.37%	31.33%
Нийт хөрөнгийн жилийн өсөлт*	5.00%	19.90%	67.14%
Нийт өр төлбөрийн жилийн өсөлт*	3.00%	17.38%	70.43%
Нийт өөрийн хөрөнгийн жилийн өсөлт*	9.50%	24.59%	60.34%

*Өмнөх оны мөн үетэй харьцуулсан

Мөнгөн гүйлгээний тайлангийн шинжилгээ

Маш сайн | Сайн | **Хангалттай** | Хүрэлцээтэй | Муу

"Шунхлай" ХХК-ийн мөнгөн гүйлгээний тайлангийн голлох үзүүлэлтүүдийг хүснэгтэд тусгав. 2026 оны 2 дугаар улирлын байдлаар үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн сөрөг гарсан бөгөөд бараа материалын худалдан авалт өссөнтэй холбоотой байна.

Үзүүлэлт	2025.II	2025	2026.II
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн / Нийт ашиг	(0.26)	0.46	(0.39)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн / Нийт хөрөнгө	(0.04)	0.15	(0.07)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн / Үйл ажиллагааны ашиг	(0.71)	0.99	(0.69)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн / Урт болон богино хугацаат зээл	(0.07)	0.40	(0.15)
Хүүг нөхөх харьцаа	0.47	3.62	(0.97)

Өр төлбөрийн шинжилгээний харьцаа үзүүлэлтүүд

Маш сайн | Сайн | **Хангалттай** | Хүрэлцээтэй | Муу

2026 оны 2 дугаар улирлын байдлаар "Шунхлай" ХХК-ийн нийт хөрөнгийг ааваад үзвэл 52.3% нь богино хугацаат өр төлбөр, 16.4% нь урт хугацаат өр төлбөр, өөрийн хөрөнгө 31.3% тус тус байна. Богино хугацаат зээлийн дүн 548.9 тэрбум төгрөг байгаа бол урт хугацаат зээлийн дүн 172.2 тэрбум төгрөг байна. 2026 оны 2 дугаар улирлын байдлаар

компани нь нийт 455.8 тэрбум төгрөгийн зээлийн шугамын эрх арилжааны банкнууд дээр нээлттэй байгаагаас зээл, баталгаа, батлан даалт оруулан 368.1 тэрбум төгрөг буюу 81%-ийг ашигласан байна.

Debt Service Coverage Ratio (DSCR) харьцаа нь компанийн зээлээ төлөх, шинэ санхүүжилт авах, ногдол ашиг төлөх чадварыг тодорхойлох үзүүлэлт билээ. "Шунхлай" ХХК-ийн хувьд DSCR нь 2025 оны 2 дугаар улирлын байдлаар 8.06% байсан бол 2026 оны 2 дугаар улирлын байдлаар 13.23% болж өссөн байгаа нь нийт өр төлбөр болон хүүгийн төлбөрийн 13.23 хувийг хоёрдугаар улирлын байдлаарх үйл ажиллагааны ашгаар төлөх боломжтойг харуулж байна.

"Шунхлай" ХХК-ийн голлох өр төлбөрийн үзүүлэлтүүдийг хүснэгтэд тусгав.

	Зохистой харьцаа	2025.II	2025	2026.II
FFO[1]/нийт санхүүжилт	>20%	2.33%	22.19%	14.45%
нийт санхүүжилт /EBITDA[2]	<4.0	9	2.34	4.09
FFO/хүүгийн зардлын мөнгөн гүйлгээ	>5.0	0.29	1.14	2.31
EBITDA/Хүүгийн зардал	>5.0	1.34	2.14	3.79
CFO[3]/нийт санхүүжилт	>20%	-6.64%	39.72%	-15.35%
FOCF[4]/нийт санхүүжилт	>10%	-14%	5%	-26%
DCF[5]/нийт санхүүжилт	>5%	11.07%	42.69%	24.42%
Үйл ажиллагааны ашиг/Хүүгийн зардал		112%	201%	246%

[1]Funds from operations – Үйл ажиллагаанаас үүссэн санхүүжилт
[2]Earnings before interest, tax, depreciation, and amortization – Элэгдэл, татвар, хүүгийн зардлын өмнох ашиг
[3]Cash flow from operations – Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ
[4]Free operating cash flow – Үйл ажиллагаанд ашиглах боломжтой мөнгөн гүйлгээ
[5]Discretionary cash flow – Үндсэн хэрэгцээг хангасны дараах цэвэр мөнгөн гүйлгээ

Өр төлбөрийн зарим харьцаа үзүүлэлт болон 2026 оны гүйцэтгэлийн хамт хүснэгтэд тусгав.

	2023	2024	2025	2026.II
Өр төлбөр / EBITDA	2.94	2.50	2.36	4.22
Компанийн үнэлгээ / өр төлбөр	1.81	2.04	2.48	2.14
EBITDA маржин	8.57%	7.22%	6.93%	10.98%
Татварын өмнох ашиг / хүүгийн зардал	2.80	2.01	2.01	3.46
Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/	17,542	20,248	12,067	74,456

Зээлжих зэрэглэлд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс

Эерэг нөлөөлөх магадлалтай хүчин зүйлс:

- Авлага барагдуулалтын хугацааг богиносгох
- Хөрвөх чадвар сайтай хөрөнгийн дүнг нэмэгдүүлэх
- Урт хугацаат, тогтвортой эх үүсвэрээр санхүүжилтийг бүрдүүлэх.

Сөргөөр нөлөөлж болзошгүй хүчин зүйлс:

- ОХУ-аас газрын тосны бүтээгдэхүүний импортын хэмжээнд хориг, хязгаарлалт тавих
- Санхүүжилтийн сорилттой тулгарч өр төлбөрийг төлөх эх үүсвэр татан төвлөрүүлж чадахгүй байх
- Авлага барагдуулалтын хугацаа уртсах.

224

2026.08.31

Шинжээчид:
З. Дагмэдмаа
dagmedmaa@mira.mn
Б. Халиун
khaliun@mira.mn

Холбогдох мэдээлэл:
И-Мейл: info@mira.mn,
Цахим хуудас: www.mira.mn,
Утас: +976 7774-7700

Үнэлгээний мэдээлэл:
www.mira.mn

Хавсралт 1

Зээлжих зэрэглэлийн шатлал

Үнэлгээ	Зэрэглэл	Тайлбар
AAA	Хөрөнгө оруулалтын	Хамгийн бага эрсдэлтэй, хөрөнгө оруулалтын зэрэглэл
AA+		Маш бага эрсдэлтэй, хөрөнгө оруулалтын зэрэглэл
AA		
AA-		
A+		Эрсдэл багатай, хөрөнгө оруулалтын дундаас дээш зэрэглэл
A		
A-		
BBB+		Дунд зэргийн эрсдэлтэй, хөрөнгө оруулалтын дундаж зэрэглэл
BBB		
BBB-		
BB+	Спекулятив	Ихээхэн эрсдэлтэй, спекулятив шинжтэй
BB		
BB-		
B+		Өндөр эрсдэлтэй, спекулятив
B		
B-		
CCC+		Маш өндөр эрсдэлтэй, спекулятив
CCC		
CCC-		
CC+		Үндсэн төлбөр болон хүүгийн нөхөн төлбөрийг барагдуулах магадлал багатай эсвэл барагдуулах магадлал маш бага байна.
CC		
CC-		
C+		Үндсэн болон хүүгийн төлбөрийг төлөх магадлал бага.
C		
C-		
D	Дефольт	

**Тэмдэглэл: MIRA нь AA-аас C хүртэлх ерөнхий үнэлгээний ангилал бүрт эерэг, тогтвортой, хувьсах, сөрөг хэтийн төлөв хавсаргана. Эерэг төлөв нь тухайн шатлалын дээд ангилал, тогтвортой төлөв нь дунд ангилалд; хувьсах төлөв нь дундаас доош ангилалд; сөрөг төлөв нь доод ангилалд багтана.*

'AAA' шатлалаас 'BBB' хүртэл хөрөнгө оруулалтын зэрэглэл, 'BB' шатлалаас 'D' хүртэл спекулятив буюу хөрөнгө оруулалтын бус гэж үздэг. "Хөрөнгө оруулалтын зэрэглэл" нь зээлийн эрсдэл дунд юм уу бага байгааг илэрхийлдэг бол "спекулятив" нь зээлийн эрсдэл өндөр байгааг илэрхийлдэг.

Хөрөнгө оруулалтын зэрэглэл нь хөрөнгө оруулалтын зорилгоор үнэт цаас болон бусад өрийн хэрэгсэл худалдан авах талаар ямар нэгэн санал зөвлөмж болохгүй болно.

226

2026.08.31

Зээлжих зэрэглэлийн төлөв

MIRA компанид зээлжих зэрэглэл тогтоохдоо 1 жилийн хугацаанд тухайн тогтоосон зээлжих зэрэглэл нь аль шатлал руу өөрчлөгдөх боломжтойг илэрхийлсэн төлөвийг (эерэг, тогтвортой, сөрөг болон хувьсах) тодорхойлно.

Төлөв	Төлөвийн тэмдэгт
Эерэг	✚
Сөрөг	▬
Хувьсах	●
Тогтвортой	■

227

2026.08.31

ШУНХЛАЙ
2026 .09. 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Үнэт цаасны танилцуулга
MONGOLIAN STOCK EXCHANGE
2026 -09- 02
БҮРТГЭВ-03

Хавсралт 2

(сая төгрөг)

Үзүүлэлт	2025.II Аудитлагдаагүй	2025 Аудитлагдаагүй	2026.II Аудитлагдаагүй
Менгөн орлогын дүн (+)	**988,193**	**2,271,847**	**1,125,640**
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	956,710	2,268,210	1,112,117
Буцаан авсан албан татвар	0	0	4
Бусад менгөн орлого	31,484	3,637	13,502
Менгөн зарлагын дүн (-)	**(1,010,854)**	**(2,159,436)**	**(1,198,537)**
Ажиллагчдад төлсөн	(12,757)	(29,031)	(16,527)
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(3,955)	(8,892)	(5,051)
Бараа материал худалдан авахад төлсөн	(904,992)	(1,949,220)	(1,101,758)
Ашиглалтын зардалд төлсөн	(899)	(1,573)	(961)
Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	(338)	(582)	(245)
Хүүний төлбөрт төлсөн	(27,292)	(55,294)	(29,669)
Татварын байгууллагад төлсөн	(8,212)	(32,618)	(14,460)
Даатгалын төлбөрт төлсөн	(527)	(790)	(178)
Бусад менгөн зарлага	(51,883)	(81,436)	(29,689)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр менгөн гүйлгээний дүн	**(22,660)**	**112,411**	**(72,898)**
Менгөн орлогын дүн (+)	**101**	**146**	**145**
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0		0
Хүлээн авсан хүүний орлого	101	146	145
Менгөн зарлагын дүн (-)	**(26,285)**	**(98,119)**	**(49,317)**
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(26,285)	(98,119)	(49,304)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр менгөн гүйлгээний дүн	**(26,184)**	**(97,973)**	**(49,172)**
Менгөн орлогын дүн (+)	**1,069,665**	**2,376,491**	**1,682,893**
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	1,069,261	2,375,970	1,682,702
Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	404	522	191
Менгөн зарлагын дүн (-)	**(1,033,873)**	**(2,399,110)**	**(1,498,435)**
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	(1,033,533)	(2,396,422)	(1,494,529)
Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	(341)	(2,688)	(3,907)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр менгөн гүйлгээний дүн	**35,792**	**(22,619)**	**184,458**
Бүх цэвэр менгөн гүйлгээ	**(13,052)**	**(8,181)**	**62,389**
Менгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	20,248	20,248	12,067
Менгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,196	12,067	74,456

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
ТТД 531 ам 2038496

228

Голомт Капитал ХХК
Golomt Capital
Delivering diversity
1119289111 5481589
Улаанбаатар хот

2026.08.31

САНАМЖ

МИРА-гийн шинжээчид нь үнэт цаас гаргагчаас гаргаж өгсөн баримт материалууд болон нийтэд ил байгаа хөрөнгийн зах зээлийн албан ёсны мэдээлэл, эх сурвалжууд дээр үндэслэн хараат бусаар зэрэглэл тогтоох үйл ажиллагааг тусгайлан боловсруулсан аргачлалын дагуу үнэлсэн бөгөөд тус тайланд дурдагдсан ирээдүйн төсөөллийн шинжтэй тоон болон чанарын мэдээллийн биелэлтэд баталгаа өгөх боломжгүй болно. Зэрэглэл тогтооход ашигласан тусгайлан боловсруулсан аргачлалтай https://mira.mn/wp-content/uploads/2023/05/General-framework-rating-methodology.pdf дэлгэрэнгүй танилцана уу. Үнэт цаас гаргаж буй үнэт цаас гаргагч, харилцагч байгууллагын гаргаж өгсөн баримт материалын үнэн зөв байдлыг МИРА хариуцахгүй.

МИРА-гийн Зэрэглэлийн хорооны тогтоосон зэрэглэл нь МИРА ХХК-ийн тусгайлан боловсруулсан аргачлалд үндэслэн үнэт цаас гаргагч, түүний эрх бүхий албан тушаалтнуудаас хараат бус мэргэжлийн шинжээчдийн үнэлгээнд тулгуурласан санхүүжих чадавхын зэрэглэлийг үнэлсэн хамтын үнэлгээ, дүгнэлт бөгөөд тус зэрэглэлийн үнэлгээ нь хөрөнгө оруулалтын шийдвэр хийх зөвлөмж, зөвлөгөөнд тооцогдохгүй бөгөөд заавал дагаж мөрдөгдөхгүй шинжийг агуулаагүй.

Хөрөнгө оруулалт хийхийг сонирхож буй хөрөнгө оруулагч нарт хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахаас өмнө үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны бүхий л мэдээлэл, үнэт цаасны танилцуулга болон МИРА-гийн зэрэглэл тогтоосон үндэслэлтэй сайтар танилцаж судлан, хөрөнгө оруулалтын мэргэжлийн зөвлөгөө авсны үндсэн дээр шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.

Үнэт цаас гаргагч болон үнэт цаасанд МИРА-гийн Зэрэглэлийн хорооны зүгээс зэрэглэл тогтоосон нь үнэт цаас гаргагчийн болон гаргахаар зорьж буй үнэт цаас, санхүүгийн хэрэгсэлд гаргасан баталгаанд тооцогдохгүй бөгөөд хөрөнгө оруулагчийн өмнө МИРА нь аливаа хариуцлага хүлээхгүй болно.

МИРА-гийн зүгээс үнэт цаас гаргагч болон түүний эрх бүхий албан тушаалтан, шийдвэр гаргах этгээдүүдээс хараат бус бөгөөд аливаа хэлбэрээр нэгдмэл сонирхолгүй, ашиг сонирхлын зөрчилгүй болохоо баталгаажуулан илэрхийлж байна.

Зэрэглэлийн тэмдэглэгээ болон түүний тайлбар нь веб хуудсанд нээлттэй байна. МИРА-гийн тогтоосон зэрэглэл, зэрэглэл тогтооход ашигласан аргачлал, ёс зүйн кодекс, ашиг сонирхлын зөрчил, мэдээллийн нууцлал болон холбогдох бусад журам болон мэдээллийг веб хуудаснаас https://mira.mn/index.php/mn/disclaimer-mn/ орж дэлгэрэнгүй танилцана уу.

Мөн дараах холбоос, линкээр орж нэмэлт анхааруулга, тодруулгатай танилцахыг хүсье.

2026.08.31

Тайлан бэлтгэсэн:

Гүйцэтгэх захирлын
түр орлон гүйцэтгэгч: _____ (З.Дагмэдмаа)

Шинжээч: _____ (Б.Халиун)

Зэрэглэлийн хорооны шийдвэр: A /Тогтвортой/

Шийдвэр гаргасан огноо: 2026/08/27

230

2026.08.31

ШУНХЛАЙ ХХК
2026 оны 09 сарын 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Үнэт цаасны танилцуулга

MONGOLIAN STOCK EXCHANGE
2026 -09- 02
БҮРТГЭВ-03

Mongolian Investment
Rating Agency

"МОНГОЛЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗЭРЭГЛЭЛИЙН ЭЖИНСИ ҮЦК" ХХК-ИЙН ЗЭРЭГЛЭЛИЙН ХОРООНЫ ХУРЛЫН ШИЙДВЭР

2026 оны 08 дугаар сарын 27-ны өдөр | Дугаар 39 | Улаанбаатар хот

"ШУНХЛАЙ" ХХК-ИЙН БАЙГУУЛЛАГЫН БОЛОН БОНДЫН ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛИЙГ ДАВТАН БАТАЛГААЖУУЛАХ ТУХАЙ

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2 дахь хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 529 дүгээр тогтоолоор батлагдсан "Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох үйл ажиллагааны зохицуулалтын журам"-ын 4.5 дахь хэсгийг тус тус үндэслэн "Монголын хөрөнгө оруулалтын зэрэглэлийн эжинси ҮЦК" ХХК-ийн Зэрэглэлийн хорооноос ТОГТООХ нь:

1. "Шунхлай" ХХК-ийн байгууллагын болон бондын зээлжих зэрэглэлийг А /Тогтвортой/ хэвээр үлдээсүгэй.

Зэрэглэлийн хорооны дарга — Ч.Өнөржаргал

Зэрэглэлийн хорооны гишүүд:
- Ч.Энхбаяр
- Б.Баасандорж
- Э.Цогбаяр
- И.Мохаммед Тажул

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
ТА3531 № 2028498

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering Diversity
1119289111 ⚡ 5481589
Улаанбаатар хот

2026.08.31

ШУНХЛАЙ
2026 .09.р 10 өдөр
№ 01

2026 -09- 02
БҮРТГЭЛ-03

7.2. Хуулийн фирмийн улсын бүртгэлийн гэрчилгээ

МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000273475

2008.11.19	9028001156
/ Бүртгэсэн он,сар,өдөр /	/ Хувийн хэргийн дугаар /
	5271894
	/ Регистрийн дугаар /

Өмгөөллийн легал полиси — Хязгаарлагдмал хариуцлагатай компани

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Тогтоол	01	2008.11.19
/ шийдвэрийн нэр /	/ дугаар /	/ он, сар, өдөр /

6910	Өмгөөлөл, хууль зүйн зөвлөгөө өгөх
/ Код/	/ Үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй	3	2,500.00
/ хугацаа /	/ ажилчдын тоо /	/ хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Сүхбаатар, 8-р хороо, бага тойруу, Сүхбаатарын талбай 5, Сити тауэр, 1304 тоот, Утас1: 90077720, Утас2: 90077721, Факс:

/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг/

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗАР

/ Бүртгэсэн байгууллагын нэр /

УЛСЫН БҮРТГЭГЧ С.БААСАНДУЛАМ

/гарын үсэг/

Гэрчилгээ дахин олгосон 2023 он 09 сар 26 өдөр

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
ТТД 2029406

Голомт Капитал ХХК
Golomt Capital
Delivering Diversity
1119289111 5481589
Улаанбаатар хот

ШУНХЛАЙ

Үнэт цаасны танилцуулга

2026 -09- 02

БҮРТГЭВ-03

ОЗА 2026 09. 10 өдөр БҮРТГЭВ № 01

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Батбаяр овогтой Дэваажанцан-г Захирал-р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2015.09.15	Б.Хандсүрэн
2	Дахин гэрчилгээ олгов.	2023.09.26	С.Баясандулам
3	Хувьцаа эзэмшигч 1 хасагдаж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 2 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2023.10.24	Ш.Очирсүрэн
4	Эцсийн өмчлөгч 1 иргэн бүртгэв.	2023.10.24	Ш.Очирсүрэн
5	Хувьцаа эзэмшигч 1 хасагдаж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 1 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2024.04.25	Э.Баторцэр
6	Эцсийн өмчлөгч 1 иргэн бүртгэв.	2024.04.25	Э.Баторцэр
7	Хувьцаа эзэмшигч 1 нэмэгдэж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 2 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2026.02.26	Б.Ариунболд
8	Эцсийн өмчлөгч бүртгэв.	2026.02.26	Б.Ариунболд

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

000273475

УЛААНБААТАР ХОТ ШУНХЛАЙ ХХК 1113531 ☎ 2025466

Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital Delivering digital 1119289111 ☎ 5491509 Улаанбаатар хот

2026.08.31

ШУНХЛАЙ

СЗХ
2026 оны 10 сар
БҮРТГЭВ
№ 01

Үнэт цаасны танилцуулга

2026 -09- 02
БҮРТГЭВ-03

7.22 Хуулийн фирмийн тусгай зөвшөөрлийн тодорхойлолт

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2018 оны 03 сарын 14 өдөр Дугаар 109 Улаанбаатар хот

Үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль
зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн
этгээдээр бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15, 24.3, Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 451 дүгээр тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх тухай журам"-ын 4.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Өмгөөллийн Легал Полиси" ХХН-ийг үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэсүгэй.

2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг "Өмгөөллийн Легал Полиси" ХХН /Б.Даваажанцан/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА

С.ДАВААСҮРЭН

УХА0410 5043239

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
ТТА0531 ☎ 2023468

234

Голомт Капитал ТЦК ХХК
Golomt Capital
Delivering excellency
1119289111 ☎ 5431589
Улаанбаатар хот

2026.08.31

ШУНХЛАЙ

Үнэт цаасны танилцуулга

7.23 Хуулийн зөвлөх үйлчилгээний гэрээ

БҮРТГЭВ
№ 01

2026 -09- 02
БҮРТГЭВ-03

LEGAL POLICY
Law Firm

ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

"ШУНХЛАЙ" ХХК

болон

ӨМГӨӨЛЛИЙН "ЛЕГАЛ ПОЛИСИ" ХХК

2026 оны 08-р сарын 19-ний
өдөр

В/257

ЛП-Г/26/59

Улаанбаатар хот
2026 он

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
2028468

235

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering Diversity
1119289111
Улаанбаатар хот

2026.08.31

ШУНХЛАЙ

СЗХ
2026 .09. 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Үнэт цаасны танилцуулга

2026 -09- 02
БҮРТГЭВ-03

ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

(Тодорхой нэг ажлыг хийж гүйцэтгэх хүрээнд)

2026 оны 08 сарын 19-ний өдөр №ЛП-Г/26/59 Улаанбаатар хот

Энэхүү ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ (цаашид "гэрээ" гэх)-г Иргэний хууль болон Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох зүйл заалтыг тус, тус үндэслэн,

Нэг талаас Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо, 3 давхар тоот хаягт орших "Шунхлай" ХХК, түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Ж.Мөнхнаран (РД:2028468) (цаашид "Үйлчлүүлэгч" гэх);

Нөгөө талаас Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай, Сити тауэр, 1304 тоот хаягт байрлах Өмгөөллийн "Легал Полиси" ХХК-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Б.Даваажанцан (цаашид "Зөвлөх", хамтад нь "Талууд" гэх) нар нь дор дурдсан нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү гэрээний зорилго нь Зөвлөхийн зүгээс Үйлчлүүлэгчид гэрээний Хавсралт №1-д заасан ажилд шаардлагатай эрх зүйн зөвлөх үйлчилгээг мэргэжлийн, чанартай үзүүлэх, Үйлчлүүлэгч гэрээний Хавсралт №1-д заасан төлбөр төлөхтэй холбогдсон хэлцлийн нөхцөл, Талуудын эрх үүрэг, хүлээх хариуцлага, тэдгээртэй холбоотойгоор үүсэх бусад харилцааг зохицуулахад оршино.

1.2 Үйлчлүүлэгч нь гүйцэтгэх ажил, үйлчилгээний даалгавар (цаашид "Даалгавар" гэх)-ыг тухайн шаардлагатай тохиолдол бүрт Зөвлөх талд бичгээр эсхүл амаар мэдэгдэнэ.

- "Бичгээр" гэдэгт цаасан дээр болон и-мэйл, факс зэрэг электрон арга хэрэгслийг ашиглан бичмэл хэлбэрээр илэрхийлснийг ойлгоно.
- "Амаар" гэдэгт утсаар болон уулзалтын үед сонсогдохоор ярьж илэрхийлснийг ойлгоно.

1.3 Хэрэв амаар Даалгавар өгсөн бол Зөвлөх нь Даалгаврыг бичгийн хэлбэрт оруулж Үйлчлүүлэгчээр дахин баталгаажуулна. Даалгавар тухайн нөхцөл байдлаас шалтгаалан өөрчлөгдөж, нэмэгдэж болно.

1.4 Зөвлөх нь ажлыг биечлэн гүйцэтгэх ба Үйлчлүүлэгчийн зөвшөөрснөөс бусад тохиолдолд эрх, үүргээ гуравдагч этгээд /өөр хуулийн этгээд/-д шилжүүлэхгүй.

1.5 Энэхүү гэрээг байгуулсан нь Талуудын хооронд өмнө байгуулагдсан бусад гэрээ, түүгээр хүлээсэн үүрэг, үр дагаварт нөлөөлөхгүй.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

2.1 Гэрээ нь Талууд гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох ба гэрээт ажлыг ажлын 20 одрийн дотор хийж гүйцэтгэхээр тохиролцов. Гэрээт ажил гүйцэтгэх хугацааг зөвлөхийн шаардсан баримт бичгийн бүрдэл бүрэн хангагдсан хугацаанаас тооло.

ГУРАВ. ТӨЛБӨР ТООЦОО

3.1 Зөвлөх нь Үйлчлүүлэгчийн даалгаврын дагуу энэхүү гэрээний Хавсралт №1-д заасан үйлчилгээг үзүүлэх ба Үйлчлүүлэгч нь Хавсралт №1-д заасан үйлчилгээний төлбөрийн 50 хувийг урьдчилгаа болгож гэрээ байгуулагдсан өдрийн дотор, үлдэгдэл төлбөрийг ажил гүйцэтгэж дуусснаас хойш ажлын 2 одрийн дотор харилцагчын цахим татварын системээр гаргасан төлбөрийн баримт, нэхэмжлэх, гэрээ дүгнэсэн актын зэргийг үндэслэн Зөвлөхийн **Төрийн банк дахь 341303316849** тоот төгрөгийн дансанд шилжүүлнэ.

3.2 Үйлчлүүлэгч нь энэхүү гэрээний хавсралт №1-д заасан төлбөрийг гэрээний 3.1-д заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд Зөвлөхөд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувьтай тэнцэх хэмжээний алданги төлнө.

Энэхүү гэрээ нь байгуулагдсан нуугдах хамаарах мэдээлэл нуу өөр бусад этгээдэд хуулж шаардах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Эдгээр шаардлагыг биелүүлэхгүй алдвал этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
ГТА 3531 ш. 2028468

236

Голомт капитал ББСБХК
Golomt Capital
Delivering diversity
1119289111 ⁂ 5481589
Улаанбаатар хот

2026.08.31

3.3 Үйлчилгээ үзүүлэх явцад зайлшгүй шаардагдах дараах зардлыг нөхөн төлөгдөх зардал гэх бөгөөд энэхүү зардал нь үйлчилгээний төлбөрт хамаарахгүй. Нөхөн төлөгдөх зардлыг тухайн хугацаанд хэрхэн төлөх талаар талууд тухай бүр харилцан тохиролцож шийдвэрлэнэ. Үүнд:

- орчуулгын зардал,
- хууль тогтоомжид заасан улсын тэмдэгтийн хураамж,
- нотариатын хөлс гэх мэт нотлох баримтын үндсэн дээр нотлогдох бусад зардал хамаарна.

3.4 Үйлчлүүлэгч нь хэрэг маргаанд өмгөөллийн болон шүүхийн шийдвэрлэх ажиллагаатай холбоотой үйлчилгээ авах тохиолдолд талууд энэхүү гэрээнээс тусад нь "Өмгөөллийн үйлчилгээний гэрээ"-г байгуулж, хамтран ажиллана.

ДӨРӨВ. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1 Үйлчлүүлэгч нь үйлчилгээний төлбөрийг энэхүү гэрээний 3.1-т заасан хугацаанд толох үүрэгтэй. Уг хугацаанд Үйлчилгээний төлбөрийг төлөөгүй 3.2-т зааснаар алданги төлөх үүрэгтэй.

4.2 Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш эрх зүйн туслалцаа үзүүлэхэд нь Зөвлөхөд шаардлагатай мэдээллийг үнэн зөв шуурхай гарган өгөх, гэрээний дагуу гүйцэтгэх ажлыг ойлгомжтой тодорхойлох, шаардлагатай зааварчилгаагаар хангах үүрэг хүлээнэ.

4.3 Хэрэв Зөвлөхөд өгсөн Үйлчлүүлэгчийн зааварчилгаа, мэдээлэл буруу эсхүл дутуу, зохих ёсоор шаардлагатай мэдээллийг өгөөгүйн улмаас Үйлчлүүлэгчид учрах хохирол, аливаа үр дагаврыг Үйлчлүүлэгч өөрөө хариуцна.

4.4 Үйлчлүүлэгч нь гэрээт ажлыг тохиролцсон хугацаанд биелүүлэх, зохих ёсоор гүйцэтгэхийг Зөвлөхөөс шаардах эрхтэй.

4.5 Үйлчлүүлэгч нь гүйцэтгэлийн явцын талаар мэдээлэл шуурхай авах, ажлын даалгавраа өөрчлөх цуцлах эрхтэй.

ТАВ. ЗӨВЛӨХИЙН ЭРХ, ҮҮРЭГ

5.1 Зөвлөх нь гэрээний дагуу гүйцэтгэвэл зохих үүрэг болон үзүүлэх үйлчилгээг нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн төвшинд үр дүнтэй, зохистой арга зүйг ашиглан үйл ажиллагааны шуурхай удирдлагыг ханган ажиллах үүрэгтэй.

5.2 Зөвлөх нь энэхүү гэрээний дагуу үүргээ гүйцэтгэхдээ Үйлчлүүлэгчийн эрх ашиг, үйл ажиллагааны явцад олж авсан нууц мэдээллийг чанд хадгалж, энэхүү гэрээний хугацаанд Үйлчлүүлэгчийн эрх ашгийг бүрэн туушгай хамгаалан ажиллах үүргийг хүлээнэ.

5.3 Зөвлөх нь гэрээт ажлыг хуульчийн мэргэжлийн ёс зүйг сахих үндсэн дээр энэхүү гэрээнд заасан хугацаанд чанартай, мэргэжлийн өндөр төвшинд хийж гүйцэтгэнэ.

5.4 Үйлчлүүлэгчийн хүлээлгэн өгсөн мэдээ баримтыг өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас хаяж, үрэгдүүлсэн тохиолдолд тухайн мэдээ баримтыг буцаан олж авахад гарах зардлыг хариуцна.

5.5 Зөвлөх нь Үйлчлүүлэгчээс гэрээний төлбөрийг 3.1-т заасан хугацаанд төлөхийг шаардах эрхтэй.

5.6 Үйлчлүүлэгч үйлчилгээний төлбөрийг гэрээний 3.1-т заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд Үйлчлүүлэгчээс энэхүү гэрээний 3.2-т зааснаар алданги шаардах эрхтэй.

5.7 Гүйцэтгэх ажлын талаар үнэн зөв, бүрэн мэдээлэл өгөхийг Үйлчлүүлэгчээс шаардах, хуульчийн ёс зүйд харшилсан, хууль бус эсхүл бислэх боломжгүй ажлыг гүйцэтгэхээс татгалзах эрхтэй.

5.8 Ажил гүйцэтгэхэд шаардагдах мэдээлэл, судалгаа, тайлбар, тодорхойлолт, холбогдох бусад баримт бичгийг Үйлчлүүлэгчээс авах тохиолдолд энэ тухай холбогдох баримт бичиг хүлээлцсэн актад тусгана.

5.9 Үйлчлүүлэгчээс авсан бүх төрлийн мэдээ, мэдээллийг баримтаар буцаан өгөх үүрэгтэй.

ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

ШУНХЛАЙ СЗХ 2026 оны 09 сар 19 өдөр БҮРТГЭВ № 01

MONGOLIAN STOCK EXCHANGE 2026 09 02 БҮРТГЭВ-03

6.1 Зөвлөх нь Үйлчлүүлэгчийн даалгаврын дагуу гүйцэтгэсэн ажлын үр дүн, баримт бичиг Үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үүднээс нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл Үйлчлүүлэгчид даруй мэдэгдэх үүрэгтэй.

6.2 Талууд энэ гэрээний үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бусад тохиолдолд хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

ДОЛОО. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ, ДУУСГАВАР БОЛОХ НӨХЦӨЛ

7.1 Үйлчлүүлэгчээс үл хамаарах шалтгаанаар Зөвлөх гэрээний үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүй 2 буюу түүнээс дээш удаа гэрээний үүргээ ноцтой зөрчсөн бол Үйлчлүүлэгч гэрээг дангаар цуцлах эрхтэй.

7.2 Үйлчлүүлэгч нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд Зөвлөх гэрээг дангаар цуцлах эрхтэй.

7.3 Аль нэг талын буруутай үйлдэл, эс үйлдлийн улмаас энэхүү гэрээ хугацаанаас өмнө цуцлагдвал буруутай тал нь нөгөө талдаа учруулсан хохирлыг үл маргах журмаар толох үүрэгтэй.

7.4 Энэхүү гэрээний хугацаа дуусан бөгөөд талууд цаашид сунгахгүй болсон эсвэл гэрээг аль нэг талын санаачилгаар цуцалсан бол гэрээ дуусгавар болсонд тооцно.

НАЙМ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛС

8.1 Холбогдох хууль тогтоомжид заасан гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас Талуудын аль нэг нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол нөгөө талдаа ажлын гурав хоногийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.

8.2 Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс бий болсон нь хуанлийн нэг сараас дээш хугацаагаар үргэлжилбэл Талууд гэрээний хугацаа болон ажлын гүйцэтгэлийн талаар харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

8.3 Гэнэтийн давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийн хамарсан үймээн, эсэргүүцлийн хөдөлгоон, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио, цээр зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах шалтгаануудыг ойлгоно.

ЕС. НУУЦ ХАДГАЛАХ

9.1 Талууд энэхүү гэрээг байгуулсантай холбоотой болон гэрээг хэрэгжүүлэх явцад шууд болон шууд бусаар олж мэдсэн байгууллага, хувь хүний нуущад хамааралтай (техник, санхүү, бизнесийн нууц гэх мэт) аливаа мэдээ, мэдээллийг бусдад бичгэн, аман болон бусад хэлбэрээр задруулахгүй, хувийн болон бусад этгээдийн ашиг сонирхлын төлөө ашиглахгүй байх үүргийг хугацаагүй хүлээнэ.

9.2 Энэхүү гэрээний 9.1-д заасан нөхцөлийг аль нэг тал зөрчсөн тохиолдолд үүнтэй холбоотойгоор үүсэх аливаа хохирлыг бүрэн барагдуулна.

АРАВ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

10.1 Энэхүү гэрээтэй холбогдон гарч болзошгүй бүх санал зөрөлдөөн, маргааныг Талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ. Санал зөрөлдөөн, маргааныг зөвшилцөөнөөр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд харьяалах шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

АРВАН НЭГ. БУСАД ЗҮЙЛ

Энэхүү гэрээ нь байгууллагын нуущад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

УЛААНБААТАР ХОТ ШУНХЛАЙ ХХК ТА 2531 Ж 2025468

Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital Delivering diversity 1119289111 Улаанбаатар хот

СЗХ
2026 -09- 1 өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2026 -09- 02
БҮРТГЭЛ-03

11.1 Гэрээний гүйцэтгэлийн явцад аль ч тал гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах саналаа нөгөө талдаа бичгээр мэдэгдэж болох ба саналыг хүлээн авсан тал ажлын 5-аас доошгүй хоногийн дотор нэмэлт өөрчлөлт оруулах эсэх талаар өөрийн саналыг хариу мэдэгдэнэ. Талууд гэрээний нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэж, гарын үсэг зурж, харилцан тохиролцсон нөхцөлд гэрээнд болон түүний хавсралтад өөрчлөлт оруулж болно.

11.2 Талуудын төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал, үүсгэн байгуулагчид, хуульчид нь өөрчлөгдсөнөөс үл хамааран энэхүү гэрээ нь үйлчлэх хугацааны туршдаа хүчин төгөлдөр байна.

11.3 Энэхүү гэрээг монгол хэл дээр 2 хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Талууд энэхүү гэрээнд заасан бүхий л нөхцөл, заалтуудыг хүлээн зөвшөөрч байгаагаа нотлон доор гарын үсэг зурж, баталгаажуулав.

Үйлчлүүлэгчийг төлөөлж:
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ж.МӨНХНАРАН

Зөвлөхийг төлөөлж:
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.ДАВААЖАНДАН

Энэхүү гэрээ нь байгуулагдсан нуцад хамаарах мэдээлэл нуун өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлэхгүй алдсан этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
2028468

239

Голомт Капитал УЦК ХХК
Golomt Capital
Delivering Diversity
1119289111
Улаанбаатар хот

2026.08.31

ШУНХЛАЙ

2026.09.10 он сар өдөр
БҮРТГЭВ
№ 1

Үнэт цаасны танилцуулга

2026-09-02
БҮРТГЭВ-03

Эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээний хавсралт №1

ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖИЛ БА ГЭРЭЭНИЙ ТӨЛБӨР

№	Хийгдэх ажлын нэр	Гэрээний төлбөр
1	Компанийн өрийн хэрэгсэл гаргахад дараах агуулгаар хуульзүйн дүгнэлт боловсруулах үйлчилгээг үзүүлнэ. **Үүнд:** 1. Үнэт цаас гаргагч нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн эсэх, үнэт цаас гаргах шийдвэр нь хуулийн дагуу гарсан эсэх; 2. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж, Хорооноос батлагдсан тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шаардлага хангаж байгаа эсэх; 3. Үнэт цаас гаргагчийн дотоод дүрэм, журмууд нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх, нийтэд санал болгон нэмж хувьцаа гаргаж буй үнэт цаас гаргагчийн хувьд түүний дотоод дүрэм, журмууд нь Хорооноос батлагдсан компанийн засаглалын кодекст нийцсэн эсэх 4. Бусадтай байгуулсан худалдах болон худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх; 5. Сүүлийн 3 жилийн дотор хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх; 6. Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний гэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл буй эсэх; 7. Үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн эсэх; 8. Үнэт цаасыг бүртгүүлэх танилцуулгад тусгагдсан хууль зүйн мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх; 9. Компанийн толгой, охин, хараат, зэрэгцээ компанийн талаарх мэдээлэлд үндэслэн үнэт цаас гаргагч компанийн хяналтыг хэрэгжүүлэгч, эцсийн өмчлөгч этгээдийг тодорхойлох; 10. Үнэт цаас гаргагч нь аж ахуйн үйл ажиллагааны эрэг гэмт хэрэг, иргэн, захиргааны хэрэгт хариуцагчаар татагдаж байсан эсэх;	

Энэхүү гэрээ нь байгуулагчын нууцад хамаарах мэдээлэл нуун өөр бусад этгээдэд хувиргаж тарааж, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
УБ-3531 ☎ 2028468

Голомт Капитал ХХК
Golomt Capital
Delivering diversity
1119289111 ☎ 5481589
Улаанбаатар хот

2026.08.31

	11. Татвар, нийгмийн даатгал болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт өр төлбөртэй эсэх.	

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Талууд энэхүү гэрээнд заасан бүхий л нөхцөл, заалтуудыг хүлээн зөвшөөрч байгаагаа нотлон доор гарын үсэг зурж, баталгаажуулав.

Үйлчлүүлэгчийг төлөөлж:
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ж.МӨНХНАРАН

Зөвлөхийг төлөөлж:
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.ДАВААЖАВГАЛАН

Энэхүү гэрээ нь байгуулагдсан нууцад хамаарах мэдээлэл тун өндөр бусад этгээдэд хувиаж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно. Энэ шаардлагыг биелүүлээгүй аливаа этгээдэд хууль заасны дагуу хариуцлага хүлээлгэх болно.

ШУНХЛАЙ

7.24 Хуулийн дүгнэлт

Үнэт цаасны танилцуулга

Хэнээс: Өмгөөллийн "Легал Полиси" ХХК
Монгол улс, Улаанбаатар 14193, СБД, 8-р хороо,
Бага тойруу-14200 Сүхбаатарын нэрэмжит талбай 05,
Сити тауэр 1304 тоот
Утас: +976 9007-7721
Цахим шуудан: info@legalpolicy.mn
Цахим хуудас: www.legal-policy.mn

LEGAL POLICY
Law Firm

Хэнд: "ШУНХЛАЙ" ХХК,
"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ХК,
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Огноо: **2026.08.31**

ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ

/"ШУНХЛАЙ" ХХК-ИАС КОМПАНИЙН ӨРИЙН ХЭРЭГСЭЛ ГАРГАЖ БҮЙТАЙ ХОЛБООТОЙ/

УЛААНБААТАР ХОТ

2026 ОН

2026.08.31

ШУНХЛАЙ
2026 .09. 10 өдөр
БҮРТГЭВ
No 01

2026 -09- 02
БҮРТГЭВ-03

АГУУЛГА

I. УДИРТГАЛ 4

1.1. ХУУЛИЙН ФИРМИЙН ТАНИЛЦУУЛГА 4

1.2. ХУУЛЬЧДЫН БАГ 5

1.3. ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТИЙН ЗОРИЛГО 5

1.4. ДҮГНЭЛТИЙН ХҮРЭЭ 6

1.5. ТОВЧИЛСОН ҮГСИЙН ТОВЪЁОГ 6

II. ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТИЙН ХУРААНГУЙ 7

III. ХУУЛЬ ЗҮЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ 11

3.1.Үнэт цаас гаргагч нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн эсэх, үнэт цаас гаргах шийдвэр нь хуулийн дагуу гарсан эсэх: 11

3.1.1.Үнэт цаас гаргагч нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн эсэх: 11

3.1.2.Үнэт цаас гаргах шийдвэр нь хуулийн дагуу гарсан эсэх: 13

3.2. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос батлсан тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шаардлагыг хангаж байгаа эсэх: 17

3.2.2. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнууд нь санхүүгийн зохицуулах хорооноос батлсан Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам, Компанийн засаглалын кодексд заасан эрх бүхий албан тушаалтны шаардлагыг хангаж байгаа эсэх: 26

3.3. Үнэт цаас гаргагчийн дотоод дүрэм, журмууд нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх, нийтэд санал болгон нэмж хувьцаа гаргаж буй үнэт цаас гаргагчийн хувьд түүний дотоод дүрэм, журмууд нь Хорооноос батлсан компанийн засаглалын кодекст нийцсэн эсэх: 28

3.3.1. Компанийн дүрэм нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх: 28

3.3.2. Компанийн засаглал нь Компанийн засаглалын кодексд нийцсэн эсэх: 30

3.3.3. Компанийн дотоод журмууд нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх: 31

3.3.4. Компанийн бизнесийн үйл ажиллагаанд холбогдох журмууд нь хууль тогтоомжид нийцсэн эсэх: 45

3.4. Бусадтай байгуулсан худалдах болон худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх: 48

3.4.1. Үйлчлүүлэгчтэй байгуулдаг гэрээнд хийсэн дүгнэлт 48

3.4.1.1. Худалдах, худалдан авах гэрээний тухайд: 49

3.4.1.2. Барьцааны гэрээний тухайд: 50

3.4.1.3. Фидуцийн гэрээний тухайд: 50

3.4.1.5. Тээвэрлэлтийн гэрээний тухайд: 51

3.4.2. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх гэрээ, үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
ТТА3531 ☎ 2028468

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Deliver University
1119209111 ☎ 5681589
Улаанбаатар хот

ШУНХЛАЙ СЭХ 2026 .09.01 өдөр БҮРТГЭЛ № 01

2026 -09- 02 БҮРТГЭЛ-03

үнийн дүн бүхий сүүлийн 3 жилийн хугацаанд байгуулсан, хүчин төгөлдөр үүрэг хүлээсэн гэрээ хэлцэл, тэдгээрийн хэрэгжилтийн талаарх дүгнэлт. 51

3.5 Сүүлийн 3 жилийн дотор хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зорчилтэй хэлцэл нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх: 56

3.5.1. Их хэмжээний хэлцлийн тухайд 56

3.5.2. Сонирхлын зөрчилтэй хэлцэлийн тухайд: 57

3.6 Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл буй эсэх: 64

3.6.1. Үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухайд 64

3.6.2. Оюуны өмчийн эрхийн тухайд 65

3.7. Үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн эсэх: 66

3.7.1. Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн тухай: 66

3.7.2. Эд хөрөнгө өмчлөх эрхийн тухай: 69

3.7.3. Үнэт цаас өмчлөх эрхийн тухай: 74

3.8. Үнэт цаасыг бүртгүүлэх танилцуулгад тусгагдсан хууль зүйн мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх: 75

3.9. Компанийн толгой, охин, хараат, зэрэгцээ компанийн талаарх мэдээлэлд үндэслэн үнэт цаас гаргагч компанийн хяналтыг хэрэгжүүлэгч, эцсийн өмчлөгч этгээдийг тодорхойлох: 81

3.9.1. Үнэт цаас гаргагчийн толгой компанийн тухай: 81

3.9.2. Үнэт цаас гаргагчийн охин, хараат компанийн тухай: 81

3.9.3. Үнэт цаас гаргагчийн зэрэгцдээ компанийн тухай: 82

3.9.4. Үнэт цаас гаргагчийн эцсийн өмчлөгчийн тухай: 93

3.10. Үнэт цаас гаргагч нь аж ахуйн үйл ажиллагааны эсрэг гэмт хэрэг, иргэн, захиргааны хэрэгт хариуцагчаар татагдаж байсан эсэх: 94

3.10.1. Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК нь Эрүүгийн хэрэгт хариуцлага хүлээж байсан эсэх: 94

3.10.2. Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК нь иргэний хэрэгт хариуцагчаар оролцож байсан эсэх: 95

3.10.3. Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК нь захиргааны хэрэгт нэхэмжлэгч болон гуравдагч этгээдээр оролцож байсан эсэх: 96

3.11. Татвар, нийгмийн даатгал болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт өр төлбөртэй эсэх: 96

IV. ТАНИЛЦСАН БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ 99

V. ЭРХ ЗҮЙН ЭХ СУРВАЛЖ 102

VI. САНАМЖ: 104

VII. "ШУНХЛАЙ" ХХК-ИАС ӨРИЙН ХЭРЭГСЭЛ ГАРГАЖ БУЙТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ 105

УЛААНБААТАР ХОТ ШУНХЛАЙ ТТА 5531 ☎ 2028408

244

Голомт Капитал ХХК Golomt Capital Delivering Diversity 1119289111 ☎ 5481589 Улаанбаатар хот

2026.08.31

I. УДИРТГАЛ

1.1. ХУУЛИЙН ФИРМИЙН ТАНИЛЦУУЛГА

Өмгөөллийн "Легал Полиси" ХХК (цаашид "хуулийн фирм" эсхүл "зөвлөх" гэх) нь иргэд, Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж буй дотоодын болон гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад эрх зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Анх 2008 онд Монголын тэргүүлэх хуулийн сургуулийн багш, судлаач, арилжааны банкны зөвлөх, өмгөөлөгчид нэгдэж тус фирмийг үүсгэн байгуулсан нь өнөөдөр үйл ажиллагааны 18 жилийн туршлагатай, үйлчлүүлэгчдийнхээ итгэлийг хүлээсэн байгууллага болжээ.

Манай хуулийн фирм нь аж үйлдвэржилт, дэд бүтэц, эрчим хүчний салбарт үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд болон энэ чиглэлийн томоохон төсөлд эрх зүйн зөвлөгөө өгч ирсэн туршлагатай бөгөөд үүнээс гадна компанийн засаглал, инновац, уул уурхай, компанийн зохистой удирдлага, үнэт цаас, оюуны өмч, төр, хувийн хэвшлийн түншлэл (PPP), хувийн санхүүжилтийн санаачилга (PFI) зэрэг салбарт эрх зүйн зөвлөгөө, өмгөөллийн үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

Өмгөөллийн "Легал Полиси" ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 109 дүгээр тогтоолоор "Үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээд"-ээр бүртгэгдээд 8 дахь жилдээ ажиллаж байгаа ба мэргэжлийн багаар бүрдүүлсэн хуульчид үнэт цаасны зах зээлд үнэт цаас буюу компанийн хувьцаа, компанийн өрийн хэрэгсэл, хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа, хадгаламжийн бичиг, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, хөрөнгө оруулагчид санал болгох тодорхой тооны хувьцаа бусад үүсмэл санхүүгийн хэрэгсэлтэй холбоотой үйл ажиллагаанд эрх зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна.

Түүнчлэн үнэт цаас арилжих болон түүгээр гэрчлэгдсэн эрхийг шилжүүлэх, үнэт цаас болон үүсмэл үнэт цаасаар төлбөр, тооцоо гүйцэтгэхтэй холбогдсон харилцаанд гэрээ, бусад эрх зүйн баримт бичиг боловсруулах, үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль, эрх зүйн зөвлөгөө үзүүлэх үйл ажиллагааны журмын дагуу хууль зүйн зөвлөгөөг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэх туршлага, ур чадвартай хуульчдын бүрэлдэхүүнтэй юм.

1.2. ХУУЛЬЧДЫН БАГ

Хуулийн фирм нь хөндлөнгийн хуулийн дүн шинжилгээг 4 гишүүдийн бүрэлдэхүүнтэй хийж гүйцэтгэсэн бөгөөд хууль зүйн дүгнэлттэй холбоотой нэмэлт лавлагаа, тодруулга, тайлбар шаардлагатай болсон тохиолдолд дараах мэдээллийн дагуу холбогдоно уу. Үүнд:

№	Овог, нэр	Албан тушаал	Мэйл хаяг
1	Батбаяр Даваажанцан	Партнер, Гүйцэтгэх захирал	davaajantsan@legal-policy.mn
2	Сангаа Эрдэнэсувд	Дэд захирал	s.erdenesuvd@legal-policy.mn
3	Даваадорж Болормаа	Хуульч, Үйл ажиллагаа эрхэлсэн захирал	bolormaa@legal-policy.mn
4	Хүрэлбаатар Энхтайван	Хуульч	enkhtaivan@legal-policy.mn

1.3. ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТИЙН ЗОРИЛГО

Энэхүү хууль зүйн дүгнэлтийн зорилго нь Өмгөөллийн "Легал Полиси" ХХК нь "Шунхлай" ХХК (цаашид "Үнэт цаас гаргагч" гэх)-тай 2026 оны 08 дугаар сарын 19-ний өдөр байгуулсан ЛП-Г/26/59 тоот "Эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ"-ний дагуу "Шунхлай" ХХК-иас компанийн өрийн хэрэгсэл олон нийтэд нээлттэй санал болгон арилжаалах гэж буйтай холбоотой Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.14 дэх заалт, "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн ТУЗ-ийн 2025 оны 08 дүгээр сарын 13-ны өдрийн 43 дугаартай тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2, 2.6 дахь заалтын дагуу хууль зүйн дүгнэлтийг боловсруулж, "Монголын хөрөнгийн бирж" ХК, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхэд оршино.

Энэхүү дүгнэлт нь "Шунхлай" ХХК-иас компанийн өрийн хэрэгсэл олон нийтэд нээлттэй санал болгон эрх бүхий байгууллагад бүртгүүлэх ажиллагаанд зориулагдсан бөгөөд дүгнэлтийг хараат бус бие даасан байдлаар гаргасан болно.

ШУНХЛАЙ СЗХ 2026 09. 1 өдөр БҮРТГЭВ № 01

2026 -09- 02 БҮРТГЭВ-03

1.4. ДҮГНЭЛТИЙН ХҮРЭЭ

Хууль зүйн зөвлөгөө үзүүлэгч хуулийн этгээд нь энэхүү дүгнэлтийг боловсруулахад дараах нөхцөл бүрдэж, түүнийг үндэслэл болгон хөндлөнгийн хууль зүйн дүгнэлтийг гаргах боломжтой гэж үзсэн болно. Үүнд:

- Ашигласан бүх баримт бичиг нь хууль, журмын шаардлага хангасан ба баримт бичигт дурдсан мэдээлэл үнэн зөв, бүрэн гүйцэт, тэдгээрт зурагдсан эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, дарагдсан тамга, тэмдэг хууль ёсны бөгөөд үнэн зөв, бүрэн гүйцэт ирсэн;
- Бидэнд файл хэлбэрээр ирүүлсэн аливаа баримт бичгийн хуулбар нь тухайн баримт бичгийн эх хувиас бүрэн хуулбарласан ба ямар нэгэн өөрчлөлт орохгүйгээр хүчин төгөлдөр хэрэгжих боломжтой. Хэрэв баримт бичигт нэмэлт, өөрчлөлт орвол дүгнэлтийн агуулга өөрчлөгдөнө;
- Хуулийн дүгнэлт гаргах үндэслэл болсон баримт материалд дурдагдсан нөхцөл байдал нь дүгнэлт гарснаас хойш эсхүл тухайн баримт бичгийг үйлдсэн огноо, хугацаанаас хойш өөрчлөгдөөгүй бөгөөд аливаа байдлаар талуудын эрх ашигт сөргөөр нөлөөлөл үүсгэх үйл явдал болоогүй;
- Аливаа дарагдсан тамга, тэмдэг нь үнэн, зөв, жинхэнэ, ашиглах эрхтэй эрх бүхий этгээдийн зөвшөөрлөөр дарагдсан;
- Энэхүү дүгнэлт нь олон нийтэд үнэт цаасаа санал болгон гаргаж, үнэт цаасны танилцуулгын зайлшгүй хэсэг байх бөгөөд дүгнэлт гаргах үеийн байдлаарх Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, эрх зүйн эх сурвалж, аливаа үйл баримт өөрчлөгдсөнтэй холбоотой зөвлөмжийн утга агуулга, үндэслэл гажуудсан тохиолдолд Хууль зүйн зөвлөгөө үзүүлэгч хуулийн этгээд аливаа хариуцлага хүлээхгүй болно.

Дүгнэлтийг илэрхийлэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэх, нэг нэр томьёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх, хууль тогтоомжид утгыг тодорхойлж ишлээгүй нийтлэг үг хэллэгийг нийтлэг утгаар илэрхийлж бичсэн болно.

Хуулийн дүгнэлтэд тусгасан санаа, утга агуулга, илэрхийлэмж нь хоёрдмол утгатай, ойлгомжгүй, нэмж тодруулах зүйл байвал эргэж чөлөөтэй холбогдох, лавлахыг хүсэж байна.

1.5. ТОВЧИЛСОН ҮГСИЙН ТОВЬЁОГ

Уг хууль зүйн дүгнэлтэд ашигласан товчилсон үгсийг дараах утгаар ойлгож хэрэглэнэ. Үүнд:

КтХ	- Компанийн тухай хууль /2011/
ИХ	- Иргэний хууль /2002/
СЗХ	- Санхүүгийн зохицуулах хороо
МХБ	- Монголын хөрөнгийн бирж
ХЭХ	- Хувьцаа эзэмшигчдийн хурал
ХЭЭБХ	- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал
ТУЗ	- Төлөөлөн удирдах зөвлөл
ҮЦТХТ ХХК	- Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК
ҮЦЗЗтХ	- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль

УЛААНБААТАР ХОТ ШУНХЛАЙ ХХК ТТА2531 ☎ 2022468

Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital Delivering certainty 1119209111 ☎ 5481589 Улаанбаатар хот

II. ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТИЙН ХУРААНГУЙ

- Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК (РД:2028468)
- Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн хувьцаа эзэмшигч "Шунхлай Холдинг" ХХК (РД: 2737779)
- Үнэт цаасны төрөл: Компанийн өрийн хэрэгсэл
- Өрийн хэрэгслийн үнийн дүн: 100,000,000,000 төгрөг (нэг зуун тэрбум)
- Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн 1,657 ширхэг, нэг бүрийн 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий, 100 хувийн хувьцааг "Шунхлай холдинг" ХХК эзэмшиж байна.
- Үнэт цаас гаргагч нь холбогдох тусгай зөвшөөрлийн дагуу Нефть бүтээгдэхүүний бөөний болон жижиглэн худалдаа, /код: 4730/, Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа /код: 46100/, 0.4-35кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ /2025.08.25 - 2030.08.25/ /код: 35109/, 220 кВ болон түүнээс дээш хүчдэлтэй цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх /2025.05.27 - 2030.05.27/, /код: 35100/, 100 МВт-аас дээш эрчим хүчний эх үүсвэр барих, угсрах, засварлах, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ барих /2025.05.27 - 2030.05.27/ /код: 35106/ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.
- Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн ТУЗ-ийн 2026 оны 08 сарын 19-ний өдрийн В/14 дугаартай "*Өрийн хэрэгсэл гаргах, Гэрээ байгуулахыг зөвшөөрөх тухай*" тогтоолоор Компанийн эргэлтийн хөрөнгийн санхүүжүүлэх зорилгоор 100,000 (нэг зуун мянга) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий, 1,000,000 (нэг сая) ширхэг, нийт 100,000,000,000 (нэг зуун тэрбум) хүртэлх төгрөгийн бондыг жилийн 18 хувийн хүүтэйгээр, 12 сарын хугацаатайгаар, хагас жил тутам хүү төлөх, үндсэн төлбөрийн эргэн төлөлтийг хугацааны эцэст төлөх нөхцөлтэйгөөр Монголын хөрөнгийн биржид бүртгүүлэн нээлттэй арилжаалахаар шийдвэрлэсэн тогтоол нь хуулийн дагуу гарсан, хүчин төгөлдөр баримт бичиг гэж үзэхээр байна.
- "Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох" үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй "Монголын Хөрөнгө оруулалтын зэрэглэлийн эжинси" ХХК-ийн зэрэглэлийн хорооны 2026 оны 08 сарын 27-ны өдрийн "*"Шунхлай" ХХК-ийн байгууллагын болон бондын зээлжих зэрэглэл давтан баталгаажуулах тухай*" тогтоолоор "Шунхлай" ХХК-ийн байгууллагын болон бондын зээлжих зэрэглэлийг А /тогтвортой/ төлөвтэйгөөр тогтоогдсон нь ҮЦЗЗтХ-ийн 16 дугаар зүйлийн 16.3.2-т заасан шаардлагыг хангасан тул өөр үүргийн гүйцэтгэлийг хангах барьцаа, эсхүл баталгаагүйгээр өрийн хэрэгслээ гаргах боломжтой байна.
- Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн ТУЗ-ийн гишүүд нь компанийн засаглалын сургалтад хамрагдаж ажиллаж байгаа нь КтХ-ийн 75 дугаар зүйлийн 75.8-д заасан "*Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна*" гэх шаардлагыг хангаж байна.
- Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Ж.Мөнхнаран нь КтХ-ийн 83 дугаар зүйлийн 83.4[1]-д заасан шаардлагыг хангасан, бусад эрх бүхий албан тушаалтнууд болох Санхүү хариуцсан захирал Ж.Оюумаа, Бизнес төлөвлөлт

[1] КтХ-ийн 83 дугаар зүйлийн 83.4. Компанийн гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэгч этгээд нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байж болох бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн дарга байхыг хориглоно.

хариуцсан захирал А.Жамъянжав, Борлуулалт, маркетинг хариуцсан захирал Ч.Галмөнх, Захиргаа, хүний нөөц хариуцсан захирал Г.Алтанзаяа, Худалдан авалтын албаны захирал Д.Норжинсүрэн, Шуурхай зохицуулалтын албаны захирал О.Жавзан, Техник, технологи хариуцсан захирал Ш.Гэрэлт-Од, Дотоод аудитын албаны захирал С.Сарантуяа, Ерөнхий нягтлан бодогч О.Золбоо нар нь мөн хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1[2]-д заасан шаардлагыг тус тус хангасан, мөн хуулийн 84 дүгээр зүйлийн 84.3[3] дахь хэсэгт заасан эрх бүхий албан тушаалд ажиллахыг хориглох үндэслэлд хамаарахгүй байна.

- Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн эрх бүхий албан тушаалтнууд нь Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 179 тоот "Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.2-т заасан мэдлэг боловсролтой, ажлын туршлагатай, гэмт хэрэгт холбогдож байгаагүй, ёс зүйн нэр хүндтэй, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байна.
- Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн дотооддоо мөрдөг дүрэм, журмууд нь Компанийн тухай хууль, Иргэний хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн, аливаа зөрчилгүй байна. Эдгээр дүрэм, журам, зааварчилгаанууд нь хоорондоо уялдаа холбоо сайтай, компанийн аливаа үйл ажиллагаанд шаардагдах бүхий л мэдээлэл, дагах ёстой заавруудыг агуулсан, үйл ажиллагаа болгоны үе шат, тэдгээрт гүйцэтгэх албан тушаалтны үүрэг хариуцлагыг тодорхойлсон, тэдгээрийн ажиллагааг тайлагнах, хянах этгээд, ажлын процесс хэрхэн явагдах нь тодорхой тусгагдсан, бизнесийн үйл ажиллагааг амжилттай явуулахад үр нөлөө бүхий байна.
- Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн голлох үйл ажиллагаа нь бүх төрлийн шатахуун импортлох, шатахууны бөөний худалдаа, жижиглэнгийн худалдаа байх тул тус ач холбогдол үзүүлэх гэрээ нь борлуулалтын гэрээ, худалдах, худалдан авах гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ, хөдөлмөрийн гэрээнүүд байна. Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн бусадтай байгуулдаг Худалдах, худалдан авах гэрээ, Зээлээр худалдах, худалдан авах гэрээ, Барьцааны гэрээ, Фидуцийн гэрээ, Хөдөлмөрийн гэрээ, Тээвэрлэлтийн гэрээ, Ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээний төслүүдийн агуулга нь Иргэний хуульд заасан шаардлагыг хангасан, талуудын гэрээний чөлөөт байдалд үндэслэсэн бөгөөд хууль тогтоомжийн зөрчилтэй нөхцөл байдал илрээгүй болно.
- Үнэт цаас гаргагч нь сүүлийн 3 жилийн хугацаанд хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий 91 гэрээг байгуулснаас түүврийн аргаар 35 сонгон авч хууль зүйн дүгнэлт хийлээ. Эдгээр гэрээ, хэлцлүүдэд Иргэний хууль болон бусад хууль тогтоомж зөрчсөн нөхцөл байдал

[2] КтХ-ийн 84 дүгээр зүйлийн 84.1. Компанийн толгойлох удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, толгойлох удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.

[3] КтХ-ийн 84 дүгээр зүйлийн 84.3.Дараах этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалд ажиллахыг хориглоно: 84.3.1.хуульд оороор заагаагүй бол төрийн болон нутгийн захиргааны байгууллага, цэрэг, цагдаа, шүүх, прокурорын байгууллагад удирдах албан тушаал хашдаг; 84.3.2.ял шийтгэл эдлэж байгаа.

ШУНХЛАЙ ХХК 2026 09 10 БҮРТГЭВ № 01

MONGOLIAN STOCK EXCHANGE 2026 -09- 02 БҮРТГЭВ-03

илрээгүй, хэрэгжилттэй холбоотой аливаа хугацаа хэтэрсэн өр төлбөр, бусад үүргийн зөрчилтэй холбоотой ямар нэгэн шаардах эрх үүсээгүй, эвлэрүүлэн зуучлах ажиллагаа эхлээгүй, шүүхэд болон арбитрт нэхэмжлэл, шаардлага гаргаагүй, иргэний хэрэг үүсээгүй, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаагүй, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй байна.

- "Шунхлай" ХХК нь сүүлийн 3 жил буюу 2023 оны 08 дугаар сараас 2026 оны 08 дугаар сар хүртэлх хугацаанд их хэмжээний хэлцэл байгуулаагүй, 62 сонирхлын зөрчилтэй хэлцлийг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу байгуулсан байна.
- Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК нь Бүх төрлийн шатахуун импортлох тусгай зөвшөөрөл /2019.12.24-2030.12.24/, Бүх төрлийн шатахууны бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл /2022.07.20-2030.07.20/, 4-35кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ /2025.08.25 - 2030.08.25/, 220 кВ болон түүнээс дээш хүчдэлтэй цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх /2025.05.27 - 2030.05.27/, 100 МВт-аас дээш эрчим хүчний эх үүсвэр барих, угсрах, засварлах, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ барих /2025.05.27 - 2030.05.27/ тусгай зөвшөөрлүүдийг эзэмшдэг нь хүчин төгөлдөр байх бөгөөд хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл байдал илрээгүй болно.
- Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК нь Улсын бүртгэлийн 40-0028092, Мэдүүлгийн бүртгэлийн 40-2023-0032777 дугаартай "ORANGE" гэх бичвэр бүхий барааны тэмдгийн онцгой эрхтэй байна. Тус барааны тэмдгийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл байдал байхгүй болно. Мөн үнэт цаас гаргагч нь өөрийн ирүүлсэн албан бичгээр дүгнэлт гаргах үеийн байдлаар лиценз, зохиогчийн эрх, патент эзэмшдэггүй болно.
- Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК нь нийт 20 ширхэг үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхтэй болох нь үл хөдлөх хөрөнгө тус бүрийн лавлагаагаар тогтоогдож байна. Эдгээрээс 17 хөрөнгө нь үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар барьцаанд байх бөгөөд тус зээлийн гэрээний харилцаа хэвийн хэрэгжиж байгаа. "Шунхлай" ХХК-ийн өмчлөлийн нэг ширхэг үл хөдлөх хөрөнгө буюу 2206100593, Y-2201070793, Y-2206108285 дугаартай хөрөнгө нь аливаа хэлцлийн үүргийн гүйцэтгэлийг хангуулах арга хэрэгсэл болоогүй байна.
- Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн тодорхой хэд хэдэн үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгөд арилжааны банк болон бусад этгээдийн барьцааны эрх үүссэн боловч гэрээ болон хуульд заасан үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс хангуулах тохиолдол үүсээгүй, холбогдох зээлүүд нь төрийн байгууллагын мэдээллийн сайтад "хэвийн" ангилалтай байна.
- Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн өмчлөх эрхийг үгүйсгэсэн аливаа баримт, мэдээлэл байхгүй тул уг эрхийг хүчин төгөлдөр гэж үзнэ.
- "Шунхлай" ХХК нь Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд бүртгэлтэй, нээлттэй болон хаалттай хэлбэрийн үнэт цаас эзэмшээгүй, "Шунхлай ойл" ХХК-ийн 100

УЛААНБААТАР ХОТ ШУНХЛАЙ ХХК УТА3531 Д.2028668

250

Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital Delivering diversity 11192891 Улаанбаатар хот

2026.08.31

хувийн хувьцааг эзэмших эрх нь хүчин төгөлдөр байх бөгөөд аливаа үүргийн гүйцэтгэл хангуулах үүрэг хүлээгээгүй байна.

- Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн үнэт цаасны танилцуулгад Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ-ны 2021 оны 06 сарын 11-ний өдрийн 225 дугаартай тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-д заавал тусгахаар заасан мэдээллүүд тусгагдсан байх бөгөөд хууль зүйн ач холбогдол бүхий мэдээлэл нь үнэн зөв, хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байна. Андеррайтер "Голомт Капитал ҮЦК" ХХК нь үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-тай нэгдмэл сонирхолтой этгээд, холбогдох болон хуулийн этгээдийн нэгдэлд тус тус хамаарахгүй байх тул "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 2.2-т "Үнэт цаас гаргагчтай гэрээ байгуулан ажиллах үндсэн андеррайтер нь түүний холбогдох этгээд байж болохгүй ..." гэж заасан шаардлагыг хангаж байна.
- Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн эцсийн өмчлөгчөөр П.Батсайхан 2020 оны 12 сарын 23-ны өдөр бүртгүүлсэн нь хүчинтэй байна. Үнэт цаас гаргагчийн толгой компани болох "Шунхлай Холдинг" ХХК-ийн компаниудын нэгдлийн нийт 56 компанийг үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компани гэж үзэхээр байна. Үнэт цаас гаргагч нь "Шунхлай ойл" ХХК-ийн хувьцааг дангаараа эзэмшдэг тул энэ нь үнэт цаас гаргагчийн охин компани байна.
- Төрийн үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia-аас 2026 оны 08 сарын 19-ний өдөр авсан "Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт", "Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт", Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн тусгай архивын 2026 оны 08 сарын 19-ний өдрийн 05/4698 тоот албан бичиг, Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрын 2026 оны 08 сарын 20-ны өдрийн 4/2633 албан бичиг, Нийслэл дэх захиргааны хэргийн Анхан шатны шүүхийн тамгын газрын 2026 оны 08 сарын 20-ны өдрийн 746 тоот албан бичиг зэрэг эрх бүхий байгууллагаас, холбогдох журмын дагуу олгогдсон, хүчинтэй тодорхойлолт, лавлагаагаар үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК нь эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй ба иргэний, арбитрын хэрэгт хариуцагч, захиргааны хэрэгт нэхэмжлэгч, гуравдагч этгээдээр оролцож байгаагүй болох нь тогтоогдож байна.
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Шийдвэр гүйцэтгэх албаны 2026 оны 08 сарын 19-ний өдрийн тодорхойлолт, Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2026 оны 08 сарын 21-ний өдрийн лавлагаа, Гаалийн ерөнхий газрын 2026 оны 08 сарын 19-ний өдрийн тодорхойлолт, Татварын ерөнхий газрын 2026 оны 08 сарын 25-ны өдрийн тодорхойлолт, Зээлийн мэдээллийн сангийн 2026 оны 08 сарын 20-ны өдрийн лавлагаагаар үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, татвар, нийгмийн даатгалын байгууллагад өр төлбөргүй, зээлүүд нь хэвийн ангилалтай болох нь тогтоогдож байна.

III.ХУУЛЬ ЗҮЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

3.1. Үнэт цаас гаргагч нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн эсэх, үнэт цаас гаргах шийдвэр нь хуулийн дагуу гарсан эсэх:

3.1.1. Үнэт цаас гаргагч нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн эсэх:

Иргэний хуулийн 25 дугаар зүйл[4], КтХ-ийн 3-р зүйлийн 3.1[5]-д зааснаар өөрөө тусгайлан захиран зарцуулах хөрөнгөтэй, ашгийн болон ашгийн бус үйл ажиллагаа явуулах, өөрийн оноосон нэртэй, эрх үүрэг, хариуцлага хүлээх, тодорхой зорилго бүхий зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэнэ.

КтХ-ийн 34 дүгээр зүйлд хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, өөрийн тусгайлсан хөрөнгөтэй, ашгийн төлөө үндсэн зорилготой хуулийн этгээдийг компани гэж тодорхойлсон.

"Шунхлай" ХХК нь КтХ-ийн 13, 14 дүгээр зүйлд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулж, хязгаарлагдмал хариуцлагатай компанийг үүсгэн байгуулах шийдвэр гарган, компанийн дүрмийг баталж, үүсгэн байгуулагдсан байна.

Иргэний хуулийн 26 дугаар зүйлийн 26.1[6], Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1[7]-т хуулийн этгээдийн эрх зүйн чадвар улсын бүртгэлд бүртгүүлснээр үүснэ гэж заасан.

"Шунхлай" ХХК нь улсын бүртгэлийн 9011068082 дугаартай, регистрийн 2028468 дугаартайгаар 2005 оны 12 сарын 16-ны өдөр, тус хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан хууль тогтоомжийн дагуу улсын бүртгэлийн байгууллагад бүртгэгдэж, иргэний эрх зүйн чадвартай болсон байна. Тиймээс хуулийн этгээдийн бүртгэл нь хүчин төгөлдөр, аливаа татан буулгах, дампуурах шийдвэр гараагүй болох нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, компанийн дүрэм, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн дэлгэрэнгүй лавлагаа, хуулийн этгээдийн нээлттэй мэдээлэл болох www.opendata.burtgel.gov.mn зэргээр батлагдаж байна.

Түүнчлэн Монголын Үндэсний Худалдаа Аж үйлдвэрийн танхимын 2026 оны 08 сарын 26-ны өдрийн 02/691 тоот албан бичгээр "... "Шунхлай" ХХК нь 2023, 2024, 2025 онуудад Монгол Улсын "ТОП-100 Аж ахуйн нэгж"-ийн эрэмбэд тус тус багтсаныг үүгээр тодорхойлов" гэж тодорхойлсон.

Хүснэгт №1. Үнэт цаас гаргагчийн мэдээлэл.

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн мэдээлэл	
Улсын бүртгэлийн дугаар	9011068082

[4] Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 "Өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагааныхаа бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэнэ"

[5] Компанийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 "Хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, өөрийн тусгайлсан эд хөрөнгөтэй, үндсэн зорилго нь ашгийн төлөө хуулийн этгээдийг компани гэнэ"

[6] Иргэний хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 "Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсч, хуульд заасан журмын дагуу татан буугдаж, улсын бүртгэлээс хасагдсанаар дуусгавар болно."

[7] Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийнм 5.1 "Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар нь улсын бүртгэлд бүртгүүлснээр үүснэ"

Регистрийн дугаар	2028468
Хуулийн этгээдийн нэр, харилцлагын хэлбэр	"Шунхлай" Хязгаарлагдмал хариуцлагатай компани
Хувьцаа эзэмшигчийн тоо	1
Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ /төгрөг/	165,700,000 (нэг зуун жаран таван сая долоон зуун мянга) төгрөг
Хуулийн этгээдийн хаяг	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2-р хороо, Чингисийн өргөн чөлөөний – 48/1, Капитал хаус, 4 дүгээр давхар
ТУЗ-ийн дарга	П.Батсайхан
Гүйцэтгэх захирал	Ж.Мөнхнаран
Үйл ажиллагааны чиглэл	- Нефть бүтээгдэхүүний бөөний болон жижиглэн худалдаа, /код: 4730/, - Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа /код: 46100/, - 0.4-35кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ /2025.08.25 - 2030.08.25/ /код: 35109/ - 220 кВ болон түүнээс дээш хүчдэлтэй цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх /2025.05.27 - 2030.05.27/, /код: 35100/ - 100 МВт-аас дээш эрчим хүчний эх үүсвэр барих, угсрах, засварлах, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ барих /2025.05.27 - 2030.05.27/ /код: 35106/
Тусгай зөвшөөрөл	-Бүх төрлийн шатахуун импортлох тусгай зөвшөөрөл; -Бүх төрлийн шатахууны бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл - 0.4-35кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ эрхлэх - 220 кВ болон түүнээс дээш хүчдэлтэй цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх - 100 МВт-аас дээш эрчим хүчний эх үүсвэр барих, угсрах, засварлах, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн хувьцаа, түүний эзэмшил дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт №2. Үнэт цаас гаргагчийн хувьцаа, түүний эзэмшил

№	Хувьцаа эзэмшигч	РД	Тоо	Нэрлэсэн үнэ	Эзлэх Хувь
1	"ШУНХЛАЙ ХОЛДИНГ" ХХК	2737779	1,657	100,000	100%

Дүгнэлт: "Шунхлай" ХХК нь улсын бүртгэлийн 9011068082 дугаартай, регистрийн 2028468 дугаартайгаар улсын бүртгэлийн байгууллагад бүртгэгдэж, иргэний эрх зүйн чадвартай болсон байх бөгөөд хуулийн этгээдийн бүртгэл нь хүчин төгөлдөр, аливаа

ШУНХЛАЙ
2026 .09. 10 өдөр
БҮРГЭВ
№ 11
MONGOLIAN STOCK EXCHANGE
2026 -09- 02
БҮРТГЭВ-03

татан буулгах, дампуурах шийдвэр гараагүй байгааг хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан гэж үзнэ.

Дүгнэлт гаргах үеийн байдлаар "Шунхлай" ХХК-ийн 1,657 ширхэг, нэг бүрийн 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий, 100 хувийн хувьцааг "Шунхлай холдинг" ХХК эзэмшиж байна.

Үнэт цаас гаргагч нь холбогдох тусгай зөвшөөрлийн дагуу Нефть бүтээгдэхүүний бөөний болон жижиглэн худалдаа, /код: 4730/, Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа /код: 46100/, 0.4-35кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ /2025.08.25 - 2030.08.25/ /код: 35109/, 220 кВ болон түүнээс дээш хүчдэлтэй цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх /2025.05.27 - 2030.05.27/, /код: 35100/, 100 МВт-аас дээш эрчим хүчний эх үүсвэр барих, угсрах, засварлах, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ барих /2025.05.27 - 2030.05.27/ /код: 35106/ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

3.1.2. <u>Үнэт цаас гаргах шийдвэр нь хуулийн дагуу гарсан эсэх:</u>

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн ТУЗ-ийн 2026 оны 08 сарын 19-ний өдрийн В/14 дугаартай "*Өрийн хэрэгсэл гаргах, гэрээ байгуулахыг зөвшөөрөх тухай*" тогтоолоор гишүүд болох Ч.Ариунсан, Б.Батбаяр, Б.Батжаргал, Ж.Мөнхнаран, Ш.Нэргүй, Б.Цэлмэг, Ц.Эрдэнэбилэг, И.Майнцэцэг болон ТУЗ-ийн дарга П.Батсайхан нарын 100 хувийн саналаар дараах асуудлыг шийдвэрлэсэн байна. Үүнд:

1. Компанийн эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор нийт 100,000,000,000 (нэг зуун тэрбум) төгрөгийн өрийн хэрэгсэл (цаашид "Өрийн хэрэгсэл" гэх)-ийг Хавсралт 1-д заасан нөхцөлөөр гарган, хөрөнгийн зах зээлд нээлттэй хүрээнд арилжаалахыг зөвшөөрсөн.
2. Энэхүү тогтоолын 1 дүгээр зүйлд заасан Өрийн хэрэгслийг "Бонд гаргах хөтөлбөр"-өөр "Монголын Хөрөнгийн Бирж" ХК-д бүртгүүлэн гаргах.
3. Өрийн хэрэгсэл гарган хөрөнгийн зах зээлд нээлттэй хүрээнд арилжаалах үйл ажиллагаанд андеррайтераар "Голомт Капитал ҮЦК" ХХК-ийг (цаашид "Андеррайтер" гэх) сонгох.
4. Компани нь Өрийн хэрэгсэл гарган хөрөнгийн зах зээлд нээлттэй хүрээнд арилжаалахтай холбогдуулан Андеррайтерийн компани, Хуулийн зөвлөх үйлчилгээний компани, Аудитын компанитай хамтран ажиллах гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-г байгуулахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ж.Мөнхнаран)-д зөвшөөрөх.
5. Өрийн хэрэгсэл гаргах хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбоотой хэсэгчлэн татан төвлөрүүлэх хэмжээ, үнийн дүн зэргийг тухай бүрд нь энэхүү тогтоолын хавсралтад заасан нөхцөлийн хүрээнд тогтоох бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал (Ж.Мөнхнаран)-д олгосон.
6. Компанийг төлөөлөн Гэрээ байгуулах, бусад холбогдох баримт бичгүүдэд гарын үсэг зурах бүрэн эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ж.Мөнхнаран)-д олгосон.
7. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ж.Мөнхнаран)-д даалгасан.

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
УТА 3531 № 2023408
254
Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering Diversity
1119289111 ☎ 5481589
Улаанбаатар хот
2026.08.31

Хүснэгт №3. "Шунхлай" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 8 сарын 19-ний өдрийн В/19 тоот тогтоолын Хавсралт №1 "Өрийн хэрэгсэл"-ийн нөхцөл

№	Үнэт цаас гаргах нөхцөл	Өрийн бичгийн хотолбор
1	Бондын төрөл	Нээлттэй бонд
2	Нэрлэсэн үнэ	100,000 төгрөг
3	Үнэт цаасны ширхэг	1,000,000 ширхэг
4	Үнэт цаасны нийт үнийн дүн	100,000,000,000 төгрөг
5	Үнэт цаасны хүү	18 хувь
6	Үнэт цаасны хугацаа	12 сар
7	Хүү төлөх давтамж	Хагас жил тутам
8	Үндсэн төлбөр төлөх давтамж	Хугацааны эцэст
9	Үүргийн гүйцэтгэл хангах арга	Зээлжих зэрэглэл тогтоолгосны дагуу барьцаа, баталгаагүй гаргах
10	Арилжаалах хэлбэр	Өрийн хэрэгслийг хөтөлбөрийн дагуу хэсэгчлэн татан төвлөрүүлэх

Бонд буюу өрийн хэрэгсэл /өрийн бичиг/ нь ҮЦЗЗтХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.8[8], 4.1.9[9], 5 дугаар зүйлийн 5.1.2[10]-т заасан санхүүгийн хэрэгсэлд хамаарна. КтХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.3[11], 41 дүгээр зүйлийн 41.1[12], ҮЦЗЗтХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1[13], 16 дугаар зүйлийн 16.1[14]-т зааснаар "Шунхлай" ХХК нь тодорхой хугацааны дараа тогтоосон хүү төлж, бондын хугацааны эцэст эргүүлэн худалдаж авах нөхцөлтэйгөөр өрийн бичиг буюу өрийн хэрэгслийг нийтэд санал болгон гаргах эрхтэй тул төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор компанийн эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор нийт 100,000,000,000 (нэг зуун тэрбум) төгрөгийн үнийн дүн бүхий өрийн хэрэгсэл /цаашид "бонд" гэх/-ийг Монголын Хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй санал болгон арилжаалахаар шийдвэрлэсэн нь хууль тогтоомжид нийцэж байна.

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн 2026 оны 08 сарын 19-ний өдрийн В/14 дугаартай "*Өрийн хэрэгсэл гаргах, гэрээ байгуулахыг зөвшөөрөх тухай*" тогтоол нь КтХ-

[8] Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 ""үнэт цаас" гэж энэ хуулийн 5.1-д заасан санхүүгийн хэрэгслийг"

[9] Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 ""өрийн хэрэгсэл" гэж үнэт цаас гаргагчаас тогтоосон нөхцөлийн дагуу үндсэн төлбөр болон хүүг мөнгөн хэлбэрээр, эсхүл тодорхой эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн хэлбэрээр тухайн үнэт цаасыг эзэмшигчид эргүүлэн төлөх үүргийг гэрчилсэн болон түүнтэй адилтгах бусад үнэт цаасыг"

[10] Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 "компанийн өрийн хэрэгсэл;"

[11] КтХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.3 "Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол нээлттэй хувьцаат компани нь нээлттэй буюу хаалттай захиалгын үндсэн дээр хувьцаа болон бусад үнэт цаас гаргаж болно."

[12] КтХ-ийн 41 дүгээр зүйлийн 41.1 "Компани тодорхой хугацааны дараа тогтоосон хүү төлж, эргүүлэн худалдаж авах нөхцөлтэйгөөр өрийн бичиг гаргаж болно."

[13] Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Үнэт цаасыг нийтэд санал болгон, эсхүл нийтэд санал болгохгүйгээр хаалттай хүрээнд худалдахаар гаргаж болно."

[14] Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 "Компанийн өрийн хэрэгслийг биржийн болон биржийн бус зах зээл дээр энэ хуульд нийцүүлэн гаргана."

255

2026.08.31

ийн 41 дүгээр зүйлийн 41.2[15], 41.3[16], 42.1[17], 76 дугаар зүйлийн 76.1.5[18], 80 дугаар зүйлийн 80.2[19], 80.5[20] болон "Шунхлай" ХХК-ийн дүрмийн 5.7[21], 5.7.7[22]-т заасан компанийн өрийн хэрэгсэл гаргахаар шийдвэрлэх журмын дагуу гарсан хүчин төгөлдөр тогтоол байна.

Түүнчлэн хагас жил тутамд хүү төлөх, бондын хугацааны эцэст буюу 12 сарын дараа үндсэн төлбөрийг эргэн төлөхөөр шийдвэрлэсэн нь КтХ-ийн 41 дүгээр зүйлийн 41.4[23]-т заасанд нийцсэн байна.

Мөн КтХ-ийн 41 дүгээр зүйлийн 41.6 дугаар зүйлд "*Өрийн бичиг гаргах шийдвэрт заасан бол компани гаргасан өрийн бичгээ төлөгдөх хугацаанаас нь өмнө эргүүлэн худалдаж авч болно*" хэмээн заасан ба үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн ТУЗ-ийн тогтоолоор бондыг хугацаанаас нь өмнө эргүүлэн худалдах, худалдан авах нөхцөлийн талаар тодорхойлоогүй тул тус бондыг хугацаанаас өмнө эргүүлэн худалдаж авах нөхцөлгүй гаргаж байна.

"Монголын Хөрөнгө Оруулалтын Зэрэглэлийн Эжинси" ХХК-аас үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн байгууллагын, хаалттай болон нээлттэй гаргаж буй бондын зэрэглэлийг тогтоохоор 2025, 2026 оны санхүүгийн үзүүлэлтүүдийг хянаж "Зээлжих зэрэглэлийн үнэлгээний тайлан" боловсруулсан байх бөгөөд Компанийн зэрэглэлийн хорооны 2026 оны 8 дугаар сарын 27-ны өдөр "Шунхлай" ХХК-ийн байгууллагын болон бондын зээлжих зэрэглэлийг "А" /тогтвортой/ төлөвтэйгөөр тогтоосон байна.

Уг "Монголын Хөрөнгө Оруулалтын Зэрэглэлийн Эжинси" ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооноос 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 359 дугаартай тогтоолоор "Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох" үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээ авсан байх тул ҮЦЗЗтХ-ийн 24 дүгээр зүйлийн 24.1.14 [24] -т заасан зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд гэж үзэхээр байна.

Ийнхүү "Монголын Хөрөнгө Оруулалтын Зэрэглэлийн Эжинси" ХХК-ийн зэрэглэлийн хорооноос 2026 оны 8 дугаар сарын 27-ны өдөр "Шунхлай" ХХК-ийн байгууллагын болон бондын зээлжих зэрэглэлийн үнэлгээг давтан баталгаажуулж, зээлжих зэрэглэлийг А /тогтвортой/ төлөвтэйгөөр хэвээр үлдээсэн шийдвэр нь ҮЦЗЗтХ-ийн 50 дугаар зүйлийн 50.2[25] дахь хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 12

---

[15] КтХ-ийн 41 дүгээр зүйлийн 41.2 "Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 41.1-д заасны дагуу орийн бичиг гаргах шийдвэрийг толоолон удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ гаргана."

[16] КтХ-ийн 41 дүгээр зүйлийн 41.3 "Энэ хуулийн 41.2-т заасан шийдвэрт орийн бичгийн хэмжээ, төрөл, хугацаа, гаргасан үнэ, хүүгийн хэмжээ, хүү төлөх хугацаа, эргүүлэн худалдаж авах үнэ, бусад мэдээллийг заана."

[17] КтХ-ийн 42.1 "Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол зарласан хувьцаанаас гүйлгээнд гаргах, компанийн дүрэмд заасан бусад торлийн үнэт цаас болон орийн бичиг гаргах тухай шийдвэрийг толоолон удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ гаргах бөгөөд уг шийдвэрт үнэт цаасны төрөл, тоо, гаргах хугацаа, нөхцөлийг заана."

[18] КтХ-ийн 76 дугаар зүйлийн 76.1.5 "компанийн дүрэмд заасан хувьцаанд хамаарах болон бусад үнэт цаас гаргах;"

[19] КтХ-ийн 80 дугаар зүйлийн 80.2 "Толоолон удирдах зөвлөлийн хурлаас тогтоол гаргах бөгөөд түүнд толоолон удирдах зөвлөлийн хурлын дарга гарын үсэг зурна"

[20] КтХ-ийн 80 дугаар зүйлийн 80.5 "Толоолон удирдах зөвлөлийн хурал гишүүдийнх нь дийлэнх олонх ороцсоноор хүчин төгөлдөр болно."

[21] "Шунхлай" ХХК-ийн дүрмийн 5.7 "ТУЗ нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ"

[22] "Шунхлай" ХХК-ийн дүрмийн 5.7.7 "Компанийн дүрэмд заасан хугацаанд хамаарах болон бусад үнэт цаас гаргах"

[23] КтХ-ийн 41 дүгээр зүйлийн 41.4 "Компани нь нэг удаа бүрэн тологдох, эсхүл хэсэгчлэн тологдох орийн бичиг гаргаж болно."

[24] ҮЦЗЗтХ-ийн 24 дүгээр зүйлийн 24.1.14 "санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох"

[25] ҮЦЗЗтХ-ийн 50 дугаар зүйлийн 50.2 "Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд зохих нөхцөл, шаардлагыг хангасан бол үнэт цаасны зах зээл дэх тодорхой төрлийн санхүүгийн хэрэгсэлд дүн шинжилгээ хийж, гэдгээрийн чанар, эрсдэл, өгөөж зэрэг үзүүлэлтээр зэрэглэл тогтоож болно."

256

2026.08.31

ШУНХЛАЙ ХХК 2026.09.10 БҮРТГЭВ № 01

2026-09-02 БҮРТГЭВ-03

дугаар сарын 18-ны өдрийн 529 дүгээр тогтоолоор батлагдсан "Санхүүгийн чадавхын зэрэглэл тогтоох үйл ажиллагааны зохицуулалтын журам" -д тус тус нийцсэн байна.

ҮЦЗЗтХ-ийн 16 дугаар зүйлийн 16.3-т зааснаар компанийн нийтэд санал болгон гаргах өрийн хэрэгсэл нь дараах нөхцөлийн аль нэгийг хангасан байх шаардлагатай. Үүнд:

- Үүргийн гүйцэтгэлийг хангах барьцаа, эсхүл баталгаатай байх;
- Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр зэрэглэл тогтоолгосон байх.

Түүнчлэн Санхүүгийн Зохицуулах хорооны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 226 дугаартай тогтоолоор батлагдсан "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 2.8-т "*Бонд гаргагч нь дотоодын эсхүл олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрх бүхий байгууллагаар санхүүжих чадавхын зэрэглэл тогтоолгосон бол үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болгож эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийг барьцаалахгүй байж болно*" гэж заасан.

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК нь дээрх ҮЦЗЗтХ-ийн 16 дугаар зүйлийн 16.3.2, Санхүүгийн Зохицуулах хорооны 2021 оны 06 сарын 11-ний өдрийн 226 дугаартай тогтоолоор батлагдсан "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 2.8-т зааснаар байгууллагын болон бондын зээлжих зэрэглэлийг "Монголын Хөрөнгө Оруулалтын Зэрэглэлийн эжинси" ХХК-аар А /тогтвортой/ төлөвтэйгөөр тогтоолгосон тул өөр үүргийн гүйцэтгэлийг хангах барьцаа, эсхүл баталгаагүйгээр өрийн хэрэгслээ гаргах боломжтой байна.

Дүгнэлт: Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн ТУЗ-ийн 2026 оны 08 сарын 19-ний өдрийн В/14 дугаартай "*Өрийн хэрэгсэл гаргах, Гэрээ байгуулахыг зөвшөөрөх тухай*" тогтоолоор Компанийн эргэлтийн хөрөнгийн санхүүжүүлэх зорилгоор 100,000 (нэг зуун мянга) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий, 1,000,000 (нэг сая) ширхэг, нийт 100,000,000,000 (нэг зуун тэрбум) хүртэлх төгрөгийн бондыг жилийн 18 хувийн хүүтэйгээр, 12 сарын хугацаатайгаар, хагас жил тутам хүү төлөх, үндсэн төлбөрийн эргэн төлөлтийг хугацааны эцэст төлөх нөхцөлтэйгөөр Монголын хөрөнгийн биржид бүртгүүлэн нээлттэй арилжаалахаар шийдвэрлэсэн тогтоол нь хуулийн дагуу гарсан, хүчин төгөлдөр баримт бичиг гэж үзэхээр байна.

"Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох" үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй "Монголын Хөрөнгө оруулалтын зэрэглэлийн эжинси" ХХК-ийн зэрэглэлийн хорооны 2026 оны 08 сарын 27-ны өдрийн "*"Шунхлай" ХХК-ийн байгууллагын болон бондын зээлжих зэрэглэл давтан баталгаажуулах тухай*" тогтоолоор "Шунхлай" ХХК-ийн байгууллагын болон бондын зээлжих зэрэглэлийг А /тогтвортой/ төлөвтэйгөөр тогтоогдсон нь ҮЦЗЗтХ-ийн 16 дугаар зүйлийн 16.3.2-т заасан шаардлагыг хангасан тул өөр үүргийн гүйцэтгэлийг хангах барьцаа, эсхүл баталгаагүйгээр өрийн хэрэгслээ гаргах боломжтой байна.

Улаанбаатар хот Шунхлай ХХК МА2531 № 2009463

Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital Delivering diversity 1119289111 5481569 Улаанбаатар хот

3.2. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос батлагдсан тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шаардлагыг хангаж байгаа эсэх:

3.2.1. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомжид заасан шаардлага хангаж буй эсэх:

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт компанийн эрх бүхий албан тушаалтныг тодорхойлсон бөгөөд энэхүү тодорхойлолт нь КтХ-ийн 84 дүгээр зүйлийн 84.1[26] болон 84.2[27] дахь хэсэгт заасан эрх бүхий албан тушаалтны тодорхойлолттой нийцэж байна.

"Шунхлай" ХХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт зааснаар эрх бүхий албан тушаалтан нь Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн гишүүн, Эрхэлсэн/Хариуцсан захирал, Ерөнхий нягтлан бодогч, Ерөнхий аудитор нар байна.

Мөн дүрмийн 5.3-т зааснаар 9 хүний бүрэлдэхүүнтэй Төлөөлөн удирдах зөвлөл ажиллах бөгөөд ТУЗ нь Хувьцаа эзэмшигч буюу "Шунхлай Холдинг" ХХК-ийн Удирдлагын хороо байна. Гүйцэтгэх захирал, Санхүү хариуцсан захирал, Бизнес төлөвлөлт хариуцсан захирал, Борлуулалт, маркетинг хариуцсан захирал, Захиргаа, хүний нөөц хариуцсан захирал, Шуурхай зохицуулалтын албаны захирал, Худалдан авалтын албаны захирал, Техник, технологи хариуцсан захирал, Дотоод аудитын албаны захирал, Ерөнхий нягтлан бодогч гэх 10 албан тушаал, ТУЗ-ийн бүрэлдэхүүнтэй нийт 18 албан тушаал нь эрх бүхий албан тушаалтанд хамаарч байна. Уг албан тушаалуудад дараах 18 хүн ажиллаж байна.

Хуулийн фирмээс энэхүү хэсэгт эрх бүхий албан тушаалтан тус бүрийн иргэний үнэмлэхийн лавлагаа, дээд боловсролын гэрчилгээ, диплом, ажилд томилсон тушаал, шийдвэр, сургалтын гэрчилгээ, анкет, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй тухай лавлагаа, шүүхийн шийдвэрээр тогтоогдсон өр төлбөртэй эсэх лавлагаа, албан тушаалтнууд нь ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй тухай үнэт цаас гаргагчийн албан бичиг бүхий тодорхойлолт, хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх лавлагаа болон холбогдох тайлбар, бусад мэдээллийг авч, тохиромжтой этгээдийг тодорхойлох асуулгыг бөглүүлсний үндсэн дээр дүгнэлт хийв.

Хүснэгт №4. Компанийн эрх бүхий албан тушаалтны мэдээлэл.

№	Эзэг /эх/-ийн нэр, өөрийн нэр	Албан тушаал	Албан тушаалд томилсон тогтоол
1.	П.Батсайхан	ТУЗ-ийн дарга	"Шунхлай Холдинг" ХХК-ийн Ерөнхийлөгчийн 2021 оны 09 сарын 30-ны өдрийн В/32 дугаар тушаал
2.	Ч.Ариунсан	ТУЗ-ийн гишүүн	"Шунхлай Холдинг" ХХК-ийн Ерөнхийлөгчийн 2024 оны 08 сарын 30-ны өдрийн В/29 дугаар тушаал

[26] КтХ-ийн 84 дүгээр зүйлийн 84.1 "Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно."

[27] КтХ-ийн 84 дүгээр зүйлийн 84.2. "Компани өөрийн онцлогтоо тохируулан эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг компанийн дүрэмдээ заасан байна."

3.	Б.Батбаяр	ТУЗ-ийн гишүүн	"Шунхлай Холдинг" ХХК-ийн Ерөнхийлөгчийн 2021 оны 09 сарын 30-ны өдрийн В/32 дугаар тушаал
4.	Б.Батжаргал	ТУЗ-ийн гишүүн	"Шунхлай Холдинг" ХХК-ийн Ерөнхийлөгчийн 2021 оны 09 сарын 30-ны өдрийн В/32 дугаар тушаал
5.	И.Майнцэцэг	ТУЗ-ийн гишүүн	"Шунхлай Холдинг" ХХК-ийн Ерөнхийлөгчийн 2021 оны 09 сарын 30-ны өдрийн В/32 дугаар тушаал
6.	Ш.Нэргүй	ТУЗ-ийн гишүүн	"Шунхлай Холдинг" ХХК-ийн Ерөнхийлөгчийн 2021 оны 09 сарын 30-ны өдрийн В/32 дугаар тушаал
7.	Б.Цэлмэг	ТУЗ-ийн гишүүн	"Шунхлай Холдинг" ХХК-ийн Ерөнхийлөгчийн 2023 оны 01 сарын 09-ний өдрийн В/03 дугаар тушаал
8.	Ц.Эрдэнэбилэг	ТУЗ-ийн гишүүн	"Шунхлай Холдинг" ХХК-ийн Ерөнхийлөгчийн 2021 оны 09 сарын 30-ны өдрийн В/32 дугаар тушаал
9.	Ж.Мөнхнаран	ТУЗ-ийн гишүүн , Гүйцэтгэх захирал	"Шунхлай Холдинг" ХХК-ийн Ерөнхийлөгчийн 2021 оны 09 сарын 30-ны өдрийн В/32 дугаар тушаал, "Шунхлай" ХХК-ийн ТУЗ-ийн 2018 оны 10 сарын 25-ны өдрийн 15 дугаар хурлын тогтоол
10.	Ж.Оюумаа	Санхүү хариуцсан захирал	Гүйцэтгэх захирлын 2025 оны 05 сарын 07-ны өдрийн В/88 дугаар тушаал
11.	А.Жамъянжав	Бизнес төлөвлөлт хариуцсан захирал	Гүйцэтгэх захирлын 2021 оны 06 сарын 23-ны өдрийн В/266 дугаар тушаал
12.	Ч.Галмөнх	Борлуулалт, маркетинг хариуцсан захирал	Гүйцэтгэх захирлын 2021 оны 07 сарын 02-ны өдрийн В/287 дугаар тушаал
13.	Г.Алтанзаяа	Захиргаа, хүний нөөц хариуцсан захирал	Гүйцэтгэх захирлын 2019 оны 11 сарын 04-ний өдрийн В/363 дугаар тушаал
14.	Д.Норжинсүрэн	Худалдан авалтын албаны захирал	Гүйцэтгэх захирлын 2018 оны 04 сарын 26-ны өдрийн А18/0822 дугаар тушаал
15.	О.Жавзан	Шуурхай зохицуулалтын албаны захирал	Гүйцэтгэх захирлын 2024 оны 01 сарын 11-ний өдрийн В/6 дугаар тушаал
16.	Ш.Гэрэлт-Од	Техник, технологи хариуцсан захирал	Гүйцэтгэх захирлын 2019 оны 11 сарын 18-ны өдрийн В/378 дугаар тушаал
17.	С.Сарантуяа	Дотоод аудитын албаны захирал	Гүйцэтгэх захирлын 2024 оны 07 сарын 19-ний өдрийн В13/40 дугаар тушаал
18.	О.Золбоо	Ерөнхий нягтлан бодогч	Гүйцэтгэх захирлын 2022 оны 06 сарын 28-ны өдрийн В/184 дугээр тушаал

- ***ТУЗ-ийн дарга П.Батсайханы тухайд:***

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн ТУЗ-ийн дарга Пүрэвийн Батсайхан нь 1966 оны 10 дугаар сарын 17-ны өдөр төрсөн, 1974-1984 онд бүрэн дунд боловсрол эзэмшиж, 1984-1990 онд Техникийн Их сургуульд тээврийн инженер, эдийн засагч мэргэжлээр, 1991-1995 онд Техникийн Их сургуульд механик инженер мэргэжлээр суралцаж бакалаврын зэрэг хамгаалсан.

Ажлын туршлагын хувьд 1997-2008 онд "Шунхлай Групп" ХХК-д ерөнхий захирал, 2004-2008 онд "АПУ" ХК-д гүйцэтгэх захирал, 2008-2017 онд "Натур-Агро" ХХК-д ТУЗ-ийн даргын албан тушаалд тус тус ажилласан туршлагатай бөгөөд 2008 оноос хойш өнөөдрийг хүртэл "АПУ" ХК-ийн ТУЗ-ийн дарга, 2012 оноос өнөөдрийг хүртэл "Шунхлай Холдинг" ХХК-ийн ерөнхийлөгчийн албыг тус тус хашиж байна.

ТУЗ-ийн дарга П.Батсайхан нь 2012 оны 02-р сарын 12-ны өдөр Компанийн засаглалын хөгжлийн төвийн Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга нарт зориулсан Компанийн засаглалын сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна.

- ***ТУЗ-ийн гишүүн Ч.Ариунсангийн тухайд:***

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн эрх бүхий албан тушаалтан Чадраабалын Ариунсан нь 1974 оны 02 дугаар сарын 01-ний өдөр төрсөн бөгөөд 1989-1991 онд БНХАУ-ын Бээжин хотноо байрлах ОХУ-ын ЭСУ-ны дэргэдэх 10 жилийн дунд сургуульд бүрэн дунд боловсрол эзэмшиж, 1994-1998 онд БНХАУ-ын Бээжин хотын Ардын Их сургуульд олон улсын харилцаа, эдийн засаг мэргэжлээр суралцаж бакалаврын зэрэг, 2000-2002 онд АНУ-ын Виржиниа мужид байрлах РадФорд Их сургуульд бизнесийн удирдлага мэргэжлээр суралцаж магистрын зэрэг хамгаалсан. Мөн 2017-2018 онд Санхүү Эдийн Засгийн Их сургуульд Бизнесийн удирдлагын чиглэлээр магистрын зэрэгт суралцаж төгссөн байна.

Ажлын туршлагын хувьд 2004-2007 онд "Жэй Кэй Си" ХХК-д төслийн менежер, 2007-2008 онд "Дерой консалтинг"-д хөрөнгө оруулалтын шинжээч, 2008-2009 онд Чингисхаан банканд төслийн шинжээч, 2009.02.19-2024.08.31хугацаанд "АПУ" ХК-д гадаад харилцааны албаны дарга, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын албыг тус тус хашиж 2024.09.01-нээс одоог хүртэл "Шунхлай холдинг" ХХК-ийн ерөнхийлөгчийн албаны захирлын албан тушаалыг хашиж байна.

ТУЗ-ийн гишүүн Ч.Ариунсан нь 2012 оны 02-р сарын 12-ны өдөр Компанийн засаглалын хөгжлийн төвийн Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга нарт зориулсан Компанийн засаглалын сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна.

- ***ТУЗ-ийн гишүүн Б.Батбаярын тухайд:***

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн эрх бүхий албан тушаалтан Бүрэнтогтохын Батбаяр нь 1972 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр төрсөн, 1980-1990 онд 18-р дунд сургуульд бүрэн дунд боловсрол эзэмшиж, 1990-1994 онд Монгол Улсын Их сургуульд Үйлдвэрийн эдийн засаг, Удирдлага чиглэлээр суралцаж бакалаврын зэрэг хамгаалсан, 1997-1998 онд Австрали улсын Сидней хот дахь University of New South Wales сургуульд Бизнесийн удирдлага мэргэжлээр суралцаж магистрын зэрэг хамгаалсан байна.

Ажлын туршлагын хувьд 1994-1996 онд МУИС-Эдийн засгийн сургуульд Менежментийн Тэнхимийн багш, 1999-2001 онд Эдийн Засгийн Бодлогыг Дэмжих Төсөл (Монгол Улсын Засгийн Газар, USAID-н хамтарсан төсөл)-д Арилжааны банкны зөвлөх, 2002-2012 онд Европын сэргээн босголт, хөгжлийн банканд Ерөнхий банкирын албыг хашиж байсан туршлагатай бөгөөд 2017 оноос одоог хүртэл "АПУ" ХК-ийн ТУЗ-ийн

гишүүн, 2012 оноос одоог хүртэл "Шунхлай Холдинг" ХХК-ийн Гүйцэтгэх дэд Ерөнхийлөгч бөгөөд Санхүү эрхэлсэн захирлын албыг тус тус хашиж байна.

ТУЗ-ийн гишүүн Б.Батбаяр нь 2013 оны 01-р сарын 18-наас 19-ний хооронд Компанийн засаглалын хөгжлийн төвийн Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга нарт зориулсан Компанийн засаглалын сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна.

- ***ТУЗ-ийн гишүүн Б.Батжаргалын тухайд:***

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн эрх бүхий албан тушаалтан Бямбасүрэн овогтой Батжаргал нь 1985 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр төрсөн бөгөөд 1992-2002 онд Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын арван жилийн 4 дүгээр сургуульд бүрэн дунд боловсрол эзэмшсэн, 2002-2006 онд Шинжлэх ухаан, Технологийн Их сургуулийн харьяа Холбоо мэдээллийн технологийн сургуульд Мэдээллийн сүлжээний инженер мэргэжлээр суралцаж бакалаврын зэрэг хамгаалсан, 2006-2009 онд БНСУ-ын Гуан-Үн Их сургуульд Электроник, сүлжээний инженер мэргэжлээр суралцсан.

Ажлын туршлагын хувьд 2009-2010 онд "Үндэсний дата төв" УТҮГ-т Мэдээллийн аюулгүй байдлын хэлтсийн ажилтан, 2010-2012 онд "Үндэсний дата төв" УТҮГ-т Мэдээллийн аюулгүй байдлын хэлтсийн ахлах ажилтан, 2012-2016 онд мөн газар Мэдээллийн аюулгүй байдлын хэлтсийн дарга, 2016-2019 онд мөн газарт Захирлын албыг тус тус хашиж байсан туршлагатай. 2019 оноос одоог хүртэл "Шунхлай холдинг" ХХК-д Дэд ерөнхийлөгч, Дижитал технологи/инновац хариуцсан захирал, 2022 оноос одоог хүртэл "Эс Системс" ХХК-д Гүйцэтгэх захирал, 2015 оноос одоог хүртэл "Цахим аюулгүй байдлын мэдээлэл удирдлагын төв" ТББ (MNCERT/CC)-ын удирдах зөвлөлийн даргын албыг тус тус хашиж байна.

ТУЗ-ийн гишүүн Б.Батжаргал нь 2021 оны 12-р сарын 06-ны өдөр Компанийн засаглалын хөгжлийн төвийн Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга нарт зориулсан Компанийн засаглалын богино хугацааны сургалтад хамрагдаж № 0131751 дугаартай гэрчилгээ авсан байна.

- ***ТУЗ-ийн гишүүн И.Майнцэцэгийн тухайд:***

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн эрх бүхий албан тушаалтан Ишдорж овогтой Майнцэцэг нь 1974 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр төрсөн бөгөөд 1997-2001 онд МУИС-ийн харьяа Хууль зүйн сургуульд Эрх зүйч мэргэжлээр суралцаж, бакалаврын зэрэг хамгаалж, Австрали улсын Мэлбурн хотноо ЛаТроб Их сургуульд Олон улсын худалдааны хуулийн чиглэлээр, Английн Манчестр хотын Метрополитан Их сургуульд Төслийн менежмент чиглэлээр тус тус магистрын зэрэг хамгаалсан байна.

Ажлын туршлагын хувьд 2002-2004 онд "Петровис" ХХК-д Хуулийн зөвлөх, 2004-2009 онд "АПУ" ХК-д хуульч, 2008-2012 онд "АПУ" ХК-ийн Хянан шалгах зөвлөлийн гишүүн, "Скайтел" ХХК-ийн Хянан шалгах зөвлөлийн гишүүн, "Капитал Групп" ХХК-ийн Тамгын хэлтсийн дарга, 2009-2012 онд "Шунхлай Групп" ХХК-ийн Ахлах хуульч, 2011-2012 онд "Капитал Групп" ХХК-ийн Гүйцэтгэх захирлын албан тушаалыг хашиж байсан туршлагатай ба 2015 оноос одоог хүртэл "Шунхлай Холдинг" ХХК-ийн Хууль, эрх зүй, хүний нөөц хариуцсан захирлын албыг хашиж байна.

ТУЗ-ийн гишүүн И.Майнцэцэг нь 2012 оны 02-р сарын 12-ны өдөр Компанийн засаглалын хөгжлийн төвийн Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга нарт зориулсан Компанийн засаглалын сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна.

- ***ТУЗ-ийн гишүүн Ш.Нэргүйн тухайд:***

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн эрх бүхий албан тушаалтан Шар овогтой Нэргүй нь 1977 оны 06 дугаар сарын 28-ны өдөр төрсөн, 1984-1994 онд Сүхбаатар аймгийн 1-р Арван жилийн дунд сургуульд бүрэн дунд боловсрол эзэмшсэн, 1994-1998 онд МУИС-ийн Эдийн Засгийн Дээд сургуульд Санхүү, эдийн засагч мэргэжлээр суралцаж, бакалаврын зэрэг хамгаалсан, 2010-2011 онд Англи улсад Cardiff Metropolitan University-д Бизнесийн удирдлагын мэргэжлээр суралцаж магистрын зэрэг хамгаалсан байна.

Ажлын туршлагын хувьд 1998-1999 онд "Газар трейд" ХХК-д нягтлан бодогч, 2000-2001 онд "Монхангай" ХХК-д Ерөнхий нягтлан бодогч, 2002-2012 онд "Шунхлай групп" ХХК-д Санхүү хариуцсан захирлын албан тушаалыг тус тус хашиж, 2013 оноос "Шунхлай Холдинг" ХХК-д Санхүү бүртгэл хариуцсан захирлаар ажиллаж байна.

ТУЗ-ийн гишүүн Ш.Нэргүй нь 2021 оны 12-р сарын 06-ны өдөр Компанийн засаглалын хөгжлийн төвийн "*Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга*" нарт зориулсан Компанийн засаглалын богино хугацаат сургалтад хамрагдаж № 0131749 дугаартай гэрчилгээ авсан байна.

- ***ТУЗ-ийн гишүүн Б.Цэлмэгийн тухайд:***

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн эрх бүхий албан тушаалтан Батхүү овогтой Цэлмэг нь 1996 оны 01 сарын 06-ны өдөр төрсөн. 2011-2013 онд Швейцар улсын Лугано хот дахь "The American School in Switzerland" сургуульд бүрэн дунд боловсрол эзэмшсэн, 2013-2016 онд Англи улсын Лондон хот дахь "Queen Mary University, University of London" их сургуульд Улс төр болон бизнес менежментийн мэргэжлээр суралцаж бакалаврын зэрэг хамгаалсан, 2017-2018 онд "University College London, University of London"-д Төрийн бодлого мэргэжлээр суралцаж магистрын зэрэг хамгаалсан, 2016-2022 онд МУИС-ийн салбар Хууль зүйн сургуульд Эрх зүйч мэргэжлээр суралцаж, бакалаврын зэрэг хамгаалсан байна.

Ажлын туршлагын хувьд Монгол Улсын Сангийн яаманд Төслийн туслах ажилтнаар 5 сар, "Батган Агро" ХХК-д 2 жил тус тус ажиллаж, 2022 оноос "Фандиа" ХХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

ТУЗ-ийн гишүүн Б.Цэлмэг нь 2022 оны 12-р сарын 26-ны өдөр Компанийн засаглалын хөгжлийн төвийн Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга нарт зориулсан Компанийн засаглалын богино хугацаат сургалтад хамрагдаж № 0132703 гэрчилгээ авсан байна.

- ***ТУЗ-ийн гишүүн Ц.Эрдэнэбилэгийн тухайд:***

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн эрх бүхий албан тушаалтан Цэвээнжав овогтой Эрдэнэбилэг нь 1971 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр Өмнөговь аймгийн Манлай суманд төрсөн. 1978-1988 онд Өмнөговь аймгийн 1-р арван жилийн сургуульд

бүрэн дунд боловсрол, 1988-1989 онд МУИС-ЗИБ-д Үйлдвэрлэл, автоматик инженер, техникийн ухааны магистр мэргэжлээр, 1989-1994 онд Украйн улсын КИСИ-д Хэл шинжлэл мэргэжлээр суралцаж, бакалаврын зэрэг хамгаалсан, 2000-2001 онд Удирдлагын академид Бизнесийн удирдлагын чиглэлээр суралцсан байна.

Ажлын туршлагын хувьд 1996-1998 онд "Говь" ХК-д Худалдааны менежер, 1998-2000 онд "Говь" ХК-д МХА-ны ахлах менежер, 2000-2006 онд "Эрдэнэт хивс" ХК-д Гүйцэтгэх захирал, 2007-2008 онд "АПУ" ХК-д Дэд захирал, 2008-2017 онд "Улаанбаатар спирт" ХХК-д Гүйцэтгэх захирлын албан тушаалыг тус тус хашиж, 2008 оноос өнөөдрийг хүртэл "АПУ" ХК-д гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

ТУЗ-ийн гишүүн Ц.Эрдэнэбилэг нь 2012 оны 02-р сарын 12-ны өдөр Компанийн засаглалын хөгжлийн төвийн Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга нарт зориулсан Компанийн засаглалын сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна.

- ***ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал Ж.Мөнхнарангийн тухайд:***

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн эрх бүхий албан тушаалтан Жагдагдагва овогтой Мөнхнаран нь 1979 оны 07 сарын 21-ний өдөр Хэнтий аймагт төрсөн бөгөөд 1997-2001 онд МУИС-ийн салбар Эдийн засгийн сургуульд эдийн засагч мэргэжлээр суралцаж, бакалаврын зэрэг хамгаалж, 2013-2015 онд Австрали улсын Сидней хотноо Macquirie University сургуульд бизнесийн удирдлагаар магистрын зэрэг тус тус хамгаалсан байна.

Ажлын туршлагын хувьд 2001-2009 онд "АПУ" ХК-д эдийн засагч, 2009-2013 онд "Шунхлай" ХХК-д стратеги төлөвлөлтийн албаны даргын албыг тус тус хашсан ба 2015 оноос одоог хүртэл "Эс Девелопмент" ХХК-д гүйцэтгэх захирал, 2018 оноос одоог хүртэл "Шунхлай" ХХК-д гүйцэтгэх захирлын албыг тус тус хашиж байна.

ТУЗ-ийн гишүүн Ж.Мөнхнаран нь 2021 оны 12-р сарын 06-ны өдөр Компанийн засаглалын хөгжлийн төвийн Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга нарт зориулсан Компанийн засаглалын богино хугацаат сургалтад хамрагдаж № 0131750 дугаартай гэрчилгээ авсан байна.

- ***Санхүү хариуцсан захирал Ж.Оюумаагийн тухайд:***

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн эрх бүхий албан тушаалтан Ж.Оюумаа нь 1986 оны 09 сарын 11-ний өдөр төрсөн бөгөөд 2004-2008 онд Санхүү эдийн засгийн их сургуулийг Бизнесийн удирдлага нягтлан бодогч мэргэжлээр суралцаж, 2009-2011 онд Санхүү эдийн засгийн их сургуулийг Бизнесийн удирдлагаар магистрын зэрэг тус тус хамгаалсан байна.

Ажлын туршлагын хувьд 2008-2012 онд "Апу" ХК-д Ахлах нягтлан бологч, 2014-2016 онд "Апу" ХК-д Удирдлагын ахлах нягтлан бологч, 2017-2018 онд "Апу" ХК-д Дотоод аудитын албаны дарга, 2019-2025 онд "Апу" ХК-д Ерөнхий нягтлан бодогч Санхүүгийн тайлагналын албаны даргын албан тушаалыг тус тус хашиж, 2025 оноос одоог хүртэл "Шунхлай" ХХК-ийн Санхүү хариуцсан захирлын албыг хашиж байна.

- ***Бизнес төлөвлөлт хариуцсан захирал А.Жамъянжавын тухайд:***

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн эрх бүхий албан тушаалтан А.Жамъянжав нь 1987 оны 10 сарын 17-ны өдөр төрсөн. 1998-2005 онд Мэргэд цогцолбор сургуульд бүрэн дунд боловсрол эзэмшсэн, 2005-2009 онд Монгол Улсын Их Сургуульд санхүүгийн менежмент мэргэжлээр суралцаж бакалаврын зэрэг хамгаалсан.

Ажлын туршлагын хувьд 2009-2013 онд "Энержи Ресурс" ХХК-д санхүүгийн менежер, 2013-2017 онд "М-Си-Эс Энержи" ХХК-д санхүүгийн менежер, 2017-2018 онд "Хаан даатгал" ХХК-д санхүү хариуцсан захирал, 2018-2020 онд "Премиум бьюлдинг материалс" ХХК-д санхүү хариуцсан захирлын албыг тус тус хашиж, 2021 оноос одоог хүртэл "Шунхлай" ХХК-д бизнес төлөвлөлт хариуцсан захирлын алба хашиж байна.

- ***Борлуулалт, маркетинг хариуцсан захирал Ч.Галмөнхийн тухайд:***

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн эрх бүхий албан тушаалтан Ч.Галмөнх нь 1975 оны 02 сарын 04-ний өдөр төрсөн бөгөөд 1982-1992 онд Сэлэнгэ аймгийн 2 дугаар дунд сургуульд бүрэн дунд боловсрол эзэмшиж, 1992-1996 онд Хүмүүнлэгийн ухааны их сургуульд үйлдвэрлэлийн менежерээр суралцсан.

Ажлын туршлагын хувьд 2004-2006 онд "Анорад" ХХК-д оффис менежер, 2006-2009 онд "Шунхлай" ХХК-д борлуулалтын менежер, 2009-2021 онд "Шунхлай" ХХК-д борлуулалтын ахлах менежерийн албыг тус тус хашиж, 2021 оноос одоог хүртэл "Шунхлай" ХХК-д борлуулалт, маркетинг хариуцсан захирлын албыг хашиж байна.

- ***Захиргаа, хүний нөөц хариуцсан захирал Г.Алтанзаяагийн тухайд:***

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн эрх бүхий албан тушаалтан Г.Алтанзаяа нь 1983 оны 03 сарын 11-ний өдөр төрсөн бөгөөд 1990-2000 онд Архангай аймгийн 2-р сургуульд бүрэн дунд боловсрол эзэмшиж, 2000-2004 онд Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн харьяа Нийгмийн ухааны сургуульд философич, улс төр судлаач мэргэжлээр суралцаж бакалаврын зэрэг хамгаалсан, 2009-2011 онд Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн харьяа Компьютерын техник, менежментийн сургуульд хүний нөөцийн удирдлагын менежментийн мэргэжлээр суралцаж, магистрын зэрэг хамгаалсан.

Ажлын туршлагын хувьд 2006-2017 онд "М-Си-Эс Групп"-д захиргаа, хүний нөөцийн ахлах менежер, 2018-2019 онд "АПУ" ХК-д хүн ба байгууллагын хөгжил хариуцсан ахлах менежерийн албыг тус тус хашиж, 2019 оноос одоог хүртэл "Шунхлай" ХХК-д захиргаа, хүний нөөц хариуцсан захирлын албыг хашиж байна.

- ***Худалдан авалтын албаны захирал Д.Норжинсүрэнгийн тухайд:***

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн эрх бүхий албан тушаалтан Д.Норжинсүрэн нь 1977 оны 07 сарын 31-ний өдөр төрсөн бөгөөд 1985-1995 онд Архангай аймгийн 1-р сургуульд бүрэн дунд боловсрол эзэмшиж, 1995-2000 онд Москва-Губкины нэрэмжит нефть хийн их сургуульд эдийн засагч мэргэжлээр суралцаж бакалаврын зэрэг хамгаалсан, 2000-2002 онд Москва-Губкины нэрэмжит нефть хийн их сургуульд менежментийн мэргэжлээр суралцаж магистрын зэрэг хамгаалсан.

Ажлын туршлагын хувьд 2004-2006 онд "Жаст ойл" ХХК-д импортын менежер, 2006-2018 онд "Шунхлай" ХХК-д импортын менежер, 2018-2020 онд "Шунхлай" ХХК-

д гадаад худалдааны албаны даргын албыг тус тус хашиж, 2020 оноос одоог хүртэл "Шунхлай" ХХК-д худалдан авалтын албаны захирлын албыг хашиж байна.

- ***Шуурхай зохицуулалтын албаны захирал О.Жавзаны тухайд:***

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн эрх бүхий албан тушаалтан О.Жавзан нь 1981 оны 06 сарын 09-ний өдөр төрсөн бөгөөд 1989-1998 онд 13-р сургуульд бүрэн дунд боловсрол эзэмшсэн, 1998-2002 онд Монгол Улсын Их сургуульд геологич мэргэжлээр суралцаж бакалаврын зэрэг хамгаалсан, 2004-2006 онд Санхүү Эдийн Засгийн Дээд сургуульд банк санхүүч мэргэжлээр суралцаж бакалаврын зэрэг хамгаалсан.

Ажлын туршлагын хувьд 2006-2013 онд "Шунхлай" ХХК-д жижиглэнгийн борлуулалтын менежер, 2013-2021 онд "Шунхлай" ХХК-д борлуулалтын ахлах менежер, 2021-2023 онд "Шунхлай" ХХК-д жижиглэнгийн борлуулалтын ахлах менежерийн албыг тус тус хашиж, 2024 оноос одоог хүртэл "Шунхлай" ХХК-д шуурхай зохицуулалтын албаны захирлын албыг хашиж байна.

- ***Техник, технологи хариуцсан захирал Ш.Гэрэлт-Одын тухайд:***

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн эрх бүхий албан тушаалтан Ш.Гэрэлт-Од нь 1980 оны 12 сарын 01-ний өдөр төрсөн бөгөөд 1988-1998 онд Тосонцэнгэл суманд бүрэн дунд боловсрол эзэмшсэн, 1998-2002 онд Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургуульд нефтийн инженер мэргэжлээр суралцаж бакалаврын зэрэг хамгаалсан, 2011-2013 онд Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургуульд нефтийн инженер мэргэжлээр суралцаж магистрын зэрэг хамгаалсан.

Ажлын туршлагын хувьд 2007-2009 онд "Шунхлай групп" ХХК-д ТТМ, Шатахууны нярав, 2009-2010 онд "Шунхлай" ХХК-д инженер, 2011-2019 онд "Шунхлай Трейдинг" ХХК-д Улаанбаатар газрын тосны бүтээгдэхүүний агуулахын даргын албыг тус тус хашиж, 2019 оноос одоог хүртэл "Шунхлай" ХХК-д техник, технологи хариуцсан захирлын албыг хашиж байна.

- ***Дотоод аудитын албаны захирал С.Сарантуяагийн тухайд:***

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн эрх бүхий албан тушаалтан С.Сарантуяа нь 1992 оны 07 сарын 31-ний өдөр төрсөн бөгөөд 2005-2009 онд Дархан Монгол Туркийн хамтарсан 21-р сургуульд бүрэн дунд боловсрол эзэмшиж, 2009-2015 онд Санхүү Эдийн Засгийн Их Сургуульд олон улсын нягтлан бодох бүртгэл мэргэжлээр суралцаж бакалаврын зэрэг хамгаалсан, 2012-2015 онд London School of Business and Finance-д олон улсын мэргэшсэн нягтлан бодох бүртгэл /ACCA/ мэргэжлээр суралцаж төгссөн.

Ажлын туршлагын хувьд 2014-2015 онд Pure baby limited, Лондон хот, ИБУИНВУ-д нягтлан бодогч, 2014-2015 онд Alex Paramitas&Co, Лондон хот, ИБУИНВУ-д нягтлан бодогч, 2015-2023 онд Худалдаа хөгжлийн банканд дотоод аудитор, 2023-2024 онд М Банканд үйл ажиллагааны эрсдэл хариуцсан менежерийн албыг тус тус хашиж, 2024 оноос одоог хүртэл "Шунхлай" ХХК-д дотоод аудитын албаны захирлын албыг хашиж байна.

- ***Ерөнхий нягтлан бодогч О.Золбоогийн тухайд:***

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн эрх бүхий албан тушаалтан О.Золбоо нь 1995 оны 03 сарын 16-ны өдөр төрсөн бөгөөд 2002-2012 онд Өмнөговь аймгийн 3-р

УЛААНБААТАР ХОТ ШУНХЛАЙ ХХК ТТД 5531 ☎ 2029483

Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital Delivering diversity 1119289111 Улаанбаатар хот

2026.08.31

сургуульд бүрэн дунд боловсрол эзэмшсэн, 2012-2016 онд Мандах Их сургуульд нягтлан бодогч мэргэжлээр суралцаж төгссөн.

Ажлын туршлагын хувьд 2017-2020 онд "Шунхлай" ХХК-д тооцооны нягтлан бодогч, 2020-2022 онд "Шунхлай" ХХК-д ахлах нягтлан бодогчийн албыг тус тус хашиж, 2022 оноос одоог хүртэл "Шунхлай" ХХК-д ерөнхий нягтлан бодогчийн албыг хашиж байна.

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн эрх бүхий албан тушаалтнууд Компанийн тухай хуульд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг дараах хүснэгтээр харуулав.[28] Үүнд:

Хүснэгт №5. КЭБАТ-ууд КтХ-д заасан шаардлага хангаж буй эсэх тухай

№	КтХ		Торгийн болон нуттийн захиргааны байгууллага, цэрэг, цагдаа, шүүх, прокурорын байгууллагад удирдах албан тушаал хашдаг эсэх: (КтХ §84.3.1)	Ял шийтгэл эдэлж байгаа эсэх: (КтХ §84.3.2)	Хувь хүн байх: (КтХ §77.3)
	Албан тушаал	КЭБАТ-уудын овог, нэр			
1.	ТУЗ-ийн дарга	П.Батсайхан	Үгүй	Үгүй	Тийм
2.	ТУЗ-ийн гишүүн	Ч.Ариунсан	Үгүй	Үгүй	Тийм
3.		Б.Батжаргал	Үгүй	Үгүй	Тийм
4.		Б.Батбаяр	Үгүй	Үгүй	Тийм
5.		Ш.Нэргүй	Үгүй	Үгүй	Тийм
6.		И.Майнцэцэг	Үгүй	Үгүй	Тийм
7.		Б.Цэлмэг	Үгүй	Үгүй	Тийм
8.		Ц.Эрдэнэбилэг	Үгүй	Үгүй	Тийм
9.	ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал	Ж.Мөнхнаран	Үгүй	Үгүй	Тийм
10.	Санхүү хариуцсан захирал	Ж.Оюумаа	Үгүй	Үгүй	Тийм
11.	Бизнес төлөвлөлт хариуцсан захирал	А.Жамъянжав	Үгүй	Үгүй	Тийм
12.	Борлуулалт, маркетинг хариуцсан захирал	Ч.Галмөнх	Үгүй	Үгүй	Тийм
13.	Захиргаа, хүний нөөц хариуцсан захирал	Г.Алтанзаяа	Үгүй	Үгүй	Тийм

[28] Үнэт цаас гаргагч Компаниас ирүүлсэн мэдээлэл, эрх бүхий албан тушаалтны товч намтрыг үндэслэл болгов.

14.	Худалдан авалтын албаны захирал	Д.Норжинсүрэн	Үгүй	Үгүй	Тийм
15.	Шуурхай зохицуулалтын албаны захирал	О.Жавзан	Үгүй	Үгүй	Тийм
16.	Техник, технологи хариуцсан захирал	Ш.Гэрэлт-Од	Үгүй	Үгүй	Тийм
17.	Дотоод аудитын албаны захирал	С.Сарантуяа	Үгүй	Үгүй	Тийм
18.	Ерөнхий нягтлан бодогч	О.Золбоо	Үгүй	Үгүй	Тийм

Дүгнэлт: Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн ТУЗ-ийн гишүүд нь компанийн засаглалын сургалтад хамрагдаж ажиллаж байгаа нь КтХ-ийн 75 дугаар зүйлийн 75.8-д заасан "*Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна*" гэх шаардлагыг хангаж байна.

"Шунхлай" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Ж.Мөнхнаран нь КтХ-ийн 83 дугаар зүйлийн 83.4[29]-д заасан шаардлагыг хангасан, бусад эрх бүхий албан тушаалтнууд болох Санхүү хариуцсан захирал Ж.Оюумаа, Бизнес төлөвлөлт хариуцсан захирал А.Жамъянжав, Борлуулалт, маркетинг хариуцсан захирал Ч.Галмөнх, Захиргаа, хүний нөөц хариуцсан захирал Г.Алтанзаяа, Худалдан авалтын албаны захирал Д.Норжинсүрэн, Шуурхай зохицуулалтын албаны захирал О.Жавзан, Техник, технологи хариуцсан захирал Ш.Гэрэлт-Од, Дотоод аудитын албаны захирал С.Сарантуяа, Ерөнхий нягтлан бодогч О.Золбоо нар нь мөн хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1[30]-д заасан шаардлагыг тус тус хангасан, мөн хуулийн 84 дүгээр зүйлийн 84.3[31] дахь хэсэгт заасан эрх бүхий албан тушаалд ажиллахыг хориглох үндэслэлд хамаарахгүй байна.

3.2.2. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнууд нь санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам, Компанийн засаглалын кодексд заасан эрх бүхий албан тушаалтны шаардлагыг хангаж байгаа эсэх:

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 179 дүгээр тогтоолоор батлагдсан "Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам"-ын 1.2 дугаар зүйлийн 1.2.1 дэх хэсэгт зааснаар Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгч, бүртгүүлэхээр хүсэлт гаргагч, тусгай

[29] КтХ-ийн 83 дугаар зүйлийн 83.4. Компанийн гүйцэтгэх удирдлагыг хөрөнгөжүүлэгч этгээд нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байж болох бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн дарга байхыг хориглоно.

[30] КтХ-ийн 84 дүгээр зүйлийн 84.1. Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга эсэх компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.

[31] КтХ-ийн 84 дүгээр зүйлийн 84.3.Дараах этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалд ажиллахыг хориглоно: 84.3.1.хуульд өөрөөр заагаагүй бол төрийн болон нутгийн захиргааны байгууллага, цэрэг, цагдаа, шүүх, прокурорын байгууллагад удирдах албан тушаал хашдаг; 84.3.2.ял шийтгэл эдэлж байгаа.

зөвшөөрөл өгөмшигч, бүртгэлтэй этгээд, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан, комплайнсын ажилтныг тохиромжтой этгээдийн шалгуурыг хангаж байгаа эсэхэд хяналт тавина.

"Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1-д зохицуулалттай этгээд болон үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтны тохиромжтой этгээдийг тодорхойлоход хуулийн этгээд болон хувь хүнд дараах шаардлагыг тавьсан байна. Үүнд:

Хүснэгт №6. Тохиромжтой этгээдэд тавигдах шаардлага

№	Хувь иргэнд тавигдах шаардлага	Хуулийн этгээдэд тавигдах шаардлага
1	Мэдлэг боловсрол, ажлын туршлагатай байх	Санхүүгийн тогтвортой байдал, төлбөрийн чадвартай байх
2	Гэмт хэрэгт холбогдож байгаагүй байх;	Бодлого зохицуулалт, баталгаатай байх;
3	Ёс зүйн нэр хүндтэй байх;	Төрийн эрх бүхий байгууллагаас албадлагын эсхүл захиргааны шийтгэлгүй байх;
4	Ашиг сонирхлыг зөрчлөөс ангид байх;	Бизнесийн болон ёс зүйн нэр хүндтэй байх;
5	Хуульд заасан бусад.	Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх.

Хуулийн фирмд ирүүлсэн мэдээлэл, баримтын хүрээнд дүгнэж үзвэл "Шунхлай" ХХК-ийн эрх бүхий албан тушаалтнууд дараах байдлаар тохиромжтой этгээдийн шалгуурыг хангаж байна. Үүнд:

Хүснэгт №7. Эрх бүхий албан тушаалтнууд тохиромжтой этгээдийн шалгуур хангаж байгаа эсэх

№	Эрх бүхий албан тушаалтнуудын мэдээлэл	Мэдлэг боловсрол, Ажлын туршлагатай байх	Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх	Гэмт хэрэгт холбогдож байгаагүй байх	Ёс зүйн нэр хүндтэй байх
1	П.Батсайхан	Тийм	Тийм	Үгүй	Тийм
2	Ч.Ариунсан	Тийм	Тийм	Үгүй	Тийм
3	Б.Батбаяр	Тийм	Тийм	Үгүй	Тийм
4	Б.Батжаргал	Тийм	Тийм	Үгүй	Тийм
5	Ц.Эрдэнэбилэг	Тийм	Тийм	Үгүй	Тийм
6	И.Майнцэцэг	Тийм	Тийм	Үгүй	Тийм
7	Ш.Нэргүй	Тийм	Тийм	Үгүй	Тийм
8	Б.Цэлмэг	Тийм	Тийм	Үгүй	Тийм
9	Ж.Мөнхнаран	Тийм	Тийм	Үгүй	Тийм
10	Ж. Оюумаа	Тийм	Тийм	Үгүй	Тийм
11	А.Жамъянжав	Тийм	Тийм	Үгүй	Тийм
12	Ч.Галмөнх	Тийм	Тийм	Үгүй	Тийм

13	Г.Алтанзаяа	Тийм	Тийм	Үгүй	Тийм
14	Д.Норжинсүрэн	Тийм	Тийм	Үгүй	Тийм
15	О.Жавзан	Тийм	Тийм	Үгүй	Тийм
16	Ш.Гэрэлт-Од	Тийм	Тийм	Үгүй	Тийм
17	С.Сарантуяа	Тийм	Тийм	Үгүй	Тийм
18	О.Золбоо	Тийм	Тийм	Үгүй	Тийм

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-иас ирүүлсэн лавлагаа, тодорхойлолтуудаар компанийн эрх бүхий албан тушаалтнууд нь эрүүгийн хэрэгт холбогдож байгаагүй, ял шийтгэл эдэлж байгаагүй, хугацаа хэтэрсэн зээлийн өргүй, шүүхийн шийдвэрээр бусдад өр төлбөргүй болох нь нотлогдож байгаа болно. Уг хүрээндээ эрх бүхий албан тушаалтнууд нь "Компанийн засаглалын кодекс"-ийн 1.2-т "*Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна*" гээд "*Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх этгээдийг сонгохдоо тэдгээрийн ёс зүй, зан суртахуун, ажлын туршлага, мэргэжлийн ур чадвар, боловсрол, гэмт хэрэг үйлдэж байсан эсэх, шүүхээр тогтоосон хугацаа хэтэрсэн зээлтэй эсэх талаарх мэдээллийг нэг бүрчлэн шалгана*" гэж заасан шаардлагыг хангаж байна.

СЗХ-ны 2022 оны 03 сарын 23-ны өдрийн 145 дугаар тогтоолоор "Компанийн засаглалын кодекс"-ийг батлахдаа уг кодексийг үйл ажиллагаандаа дагаж мөрдөхийг нээлттэй хувьцаат компани, даатгагч, банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээ болон хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхэлдэг компанид тус тус үүрэг болгож, бусад компаниудад зөвлөсөн байна. Үүний дагуу үнэт цаас гаргагч нь үйл ажиллагаандаа "Компанийн засаглалын кодекс"-ийг мөрдлөг болгон ажиллах үүрэг хүлээгээгүй болно. Хуулийн фирмийн зүгээс цаашид үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг үнэт цаас гаргагчид зөвлөж байна.

Дүгнэлт: Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн эрх бүхий албан тушаалтнууд нь Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 179 тоот "Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.2-т заасан мэдлэг боловсролтой, ажлын туршлагатай, гэмт хэрэгт холбогдож байгаагүй, ёс зүйн нэр хүндтэй, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байна.

3.3. Үнэт цаас гаргагчийн дотоод дүрэм, журмууд нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх, пийтэд сапал болгон нэмж хувьцаа гаргаж буй үнэт цаас гаргагчийн хувьд түүний дотоод дүрэм, журмууд нь Хорооноос батлагдсан компанийн засаглалын кодекст нийцсэн эсэх:

3.3.1. Компанийн дүрэм нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх:

"Шунхлай" ХХК-ийн дүрэм нь Хувьцаа эзэмшигчийн 2026 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн В/11 дугаар шийдвэрээр шинэчлэгдэн батлагдаж, 2026 оны 07 дугаар сарын 20-ны өдөр Хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн газарт бүртгэгдсэн тул КтХ-ийн 17

дугаар зүйлийн 17.9[32] дэх хэсэгт заасны дагуу хэлбэрийн хувьд хүчин төгөлдөр болсон байна.

Компанийн дүрэм нь 12 бүлэгтэй байна. Үүнд:

1. Нийтлэг үндэслэл;
2. Үйл ажиллагааны чиглэл;
3. Компанийн хувьцаа эзэмшигчид;
4. Хувь нийлүүлсэн хөрөнгө болон өөрийн хөрөнгө;
5. Компанийн удирдлага, түүний бүрэн эрх;
6. Компанийн гүйцэтгэх удирдлага;
7. Компанийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээрийн эрх, үүрэг;
8. Хяналт, шалгалт;
9. Компанийн санхүү, нягтлан бодох бүртгэл;
10. Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах;
11. Мэдээлэл;
12. Бусад зүйл.

КтХ-ийн 16 дугаар зүйлийн 16.2[33] дахь хэсэгт заасан "Компанийн дүрэмд заавал тусгах зүйлс"-ийг "Шунхлай" ХХК нь өөрийн дүрэмд тусгаж, холбогдох шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

Хүснэгт №8. "Шунхлай" ХХК-ийн дүрмийн агуулга

№	КтХ-ийн 16 дугаар зүйлийн 16.2. Компанийн дүрэмд дараах зүйлсийг заавал тусгана	КтХ-д заасан компанийн дүрмийн шаардлагыг үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн дүрэм хангаж байгаа тухайд
1.	**16.2.1. Компанийн бүрэн болон товчилсон оноосон нэр, түүний хэлбэрийг тодорхойлсон товчилсон ялгах тэмдэглэгээ**	"Шунхлай" ХХК-ийн дүрмийн 1.3 дахь хэсэгт: Компанийн оноосон нэрийг "ШУНХЛАЙ" ХХК, англиар "SHUNKHLAI" LLC гэнэ. Компанийн хэлбэр нь хязгаарлагдмал хариуцлагатай компани буюу "ХХК" байна.
2.	**16.2.2. Компанийн зарласан болон гаргасан хувьцааны тоо, тэдгээрийн төрөл, нэрлэсэн үнэ, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ**	"Шунхлай" ХХК-ийн дүрмийн 4.1 дэх хэсэгт: Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь 165,700,000 (*нэг зуун жаран таван сая долоон зуун мянга*) төгрөг буюу нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,657 ширхэг энгийн хувьцаанд хуваагдана. 4.1.1. Компанийн зарласан хувьцаа: нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,657 ширхэг энгийн хувьцаа; 4.1.2. Компанийн гаргасан хувьцаа: нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,657 ширхэг энгийн хувьцаа.

[32] КтХ-ийн 17 дугаар зүйлийн 17.9. "Компанийн дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, шинэчлэн найруулсан дүрэм нь улсын бүртгэлд бүртгэснээр хүчин төгөлдөр болно.

[33] КтХ-ийн 16 дугаар зүйлийн 16.2 "Компанийн дүрэмд дараах зүйлийг заавал тусгана: 16.2.1.компанийн бүрэн болон товчилсон оноосон нэр, түүний хэлбэрийг тодорхойлсон товчилсон ялгах тэмдэглэгээ; 16.2.2.компанийн зарласан болон гаргасан хувьцааны тоо, тэдгээрийн төрөл, нэрлэсэн үнэ, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ; 16.2.3.компанийн дүрмээр давуу эрхийн хувьцааг зарласан нохцолд давуу эрхийн хувьцааны зарласан тоо, түүний эзэмшигчийн эрх; 16.2.4.хэрэв төлөөлөн удирдах зөвлөлтэй байхаар шийдвэрлэсэн бол толоолон удирдах зөвлөлийн гишүүдийн тоо; 16.2.5.хувьцаа эзэмшигчдийн хурал, толоолон удирдах зөвлөлийн энэ хуулиар тодорхойлсноос бусад бүрэн эрх; 16.2.6.компанийн үйл ажиллагааны чиглэл; 16.2.7.компанийн дүрэмд тусгахаар энэ хуульд заасан бусад зүйл."

3.	**16.2.3. Хэрэв төлөөлөн удирдах зөвлөлтэй байхаар шийдвэрлэсэн бол толоолөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоо**	"Шунхлай" ХХК-ийн дүрмийн 5.3 дахь хэсэгт: "…үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалт, хяналтаар хангах ажлыг гүйцэтгэх зорилгоор 9 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн үйл ажиллагааг удирдан явуулна."
4.	**16.2.4. Хувьцаа эзэмшигчдийн хурал, толоолөн удирдах зовлолийн энэ хуулиар тодорхойлсноос бусад бүрэн эрх**	"Шунхлай" ХХК-ийн дүрмийн 5 дугаар бүлэгт Компанийн удирдлага, түүний бүтцийг тодорхойлж 5.2 дахь хэсэгт Хувьцаа Эзэмшигчдийн Хурлын бүрэн эрх, 5.7 дугаар зүйлд ТУЗ-ийн бүрэн эрхийг тус тус заасан байна.
5.	**16.2.5. Компанийн үйл ажиллагааны чиглэл**	"Шунхлай" ХХК-ийн дүрмийн 2.1 дэх хэсэгт: Компани нь дор дурдсан аж ахуйн үйл ажиллагааг эрхлэн явуулна. - Төлбөр эсхүл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа; - Шатахууны бөөний худалдаа; - Шатахууны жижиглэнгийн худалдаа; - Худалдааны зуучлал; - Зорчигч тээврийн үйлчилгээ; - 0.4-35кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ эрхлэх; - 220 кВ болон түүнээс дээш хүчдэлтэй цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх; - 100 МВт-аас дээш эрчим хүчний эх үүсвэр барих, угсрах, засварлах, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх;
6.	**16.2.6. Компанийн дүрэмд тусгахаар энэ хуульд заасан бусад зүйл**	"Шунхлай" ХХК-ийн дүрмийн 7 дугаар бүлэгт компанийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээрийн эрх, үүрэг, 8 дугаар бүлэгт хяналт, шалгалт, 9 дүгээр бүлэгт компанийн санхүү, нягтлан бодох бүртгэл зэрэг журмын талаар тус тус заасан байна.

Түүнчлэн "Шунхлай" ХХК-ийн дүрэмд тусгагдсан Хувьцаа эзэмшигчдийн эрх, үүрэг, Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцаа бусад үнэт цаас гаргах, түүнийг худалдах болон эргүүлэн авах, Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл, түүний бүрэн эрх, Гүйцэтгэх удирдлага, түүний эрх, үүрэг, Компанийг өөрчлөн байгуулах татан буулгах талаарх зохицуулалтууд нь Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

3.3.2. Компанийн засаглал нь Компанийн засаглалын кодексд нийцсэн эсэх:

Компанийн засаглалын хувьд үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК нь хэлбэрийн хувьд Хязгаарлагдмал хариуцлагатай компани тул Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 145 дугаар "Компанийн засаглалын кодекс"-ийг шинэчлэн батлах тухай тогтоолын 2 дугаар зүйлд *"Энэ тогтоолын 1-д заасан*

"Компанийн засаглалын кодекс" /цаашид "Кодекс" гэх/-ийг үйл ажиллагаандаа дагаж мөрдөхийг нээлттэй хувьцаат компани, даатгагч, банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээ болон хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхэлдэг компанид тус тус үүрэг болгож, бусад компаниудад зөвлөсүгэй" хэмээн заасны дагуу СЗХ-ноос батлагдсан КЗК-ийг дагаж мөрдөх шаардлага тавигдахгүй байна.

Цаашид Үнэт цаас гаргагч нь СЗХ-ноос батлагдсан КЗК-ийг дагаж мөрдөх дотоод дүрэм, журмуудыг баталж ажиллахыг зөвлөж байна.

3.3.3. Компанийн дотоод журмууд нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх:

3.3.3.1. Дотоод аудитын журам

"Шунхлай Групп" ХХК-ийн Ерөнхийлөгчийн 2020 оны 05 сарын 01-ний өдрийн 04 дүгээр тушаалаар Ж-ДАА-02-03 дугаартай "Дотоод аудитын журам"-ыг баталсан байна. Тус журмын 1.1 дэх хэсэгт "*Энэхүү "Дотоод аудитын журам"-аар Шунхлай ХХК, Шунхлай Трейдинг ХХК, Шунхлай Петролиум ХХК, Шунхлай говь ХХК-уудын нэгж хэсгүүд болон бизнес процесст дотоод аудит хийхтэй холбоотойгоор холбогдох этгээдүүдийн хооронд үүсэх харилцааг зохицуулна*" хэмээн зааснаар Ж-ДАА-02-03 дугаар Дотоод аудитын журмыг үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК нь дотоод үйл ажиллагаандаа дагаж, мөрдөхөөр байна.

Тус дотоод аудитын журмын 7.1 дэх хэсэгт компанийн дотоод аудит нь дараах чиглэлээр аудит хийж гүйцэтгэхээр заасан байна. Үүнд:

- Компанийн хэмжээнд мөрдөгдөж буй эрх зүйн баримт бичгүүдийг үнэлэх, сайжруулах зөвлөмж өгөх, баталгаажилт хийх;
- Дотоод хяналтын үйл явцын үр нөлөөтэй байдлыг үнэлэх, баталгаажуулах, сайжруулахад дэмжлэг үзүүлэх;
- УНТ-ны стандартуудын хэрэгжилтэд дотоод аудит хийх, мөн хөндлөнгийн ОУ-ын аудитыг зохион байгуулж, аудитын дагуу хийсэн сайжруулалтын үр нөлөөтэй байдлыг үнэлэх.

Мөн "Дотоод аудитын журам"-ын 7.3 дахь хэсэгт Компанийн засаглал, эрсдэлийн удирдлага ба хяналтын үйл явцад хараат бус үнэлгээ хийх зорилготой нотлох баримтад үндэслэн хийгдэх аудит бөгөөд аудитын шинж чанараас хамаарч дараах байдлаар ангилна гэжээ. Үүнд:

Санхүүгийн аудит – Компани, газар, алба нэгжийн нягтлан бодох бүртгэл, тайлан, төсөв, хөрөнгө оруулалт, худалдан авалтын хэрэгжилтэд хийж буй баримтын тулгах баталгаажуулалтын аудит;

Нийцлийн аудит – Хууль тогтоомж, компанийн журам, бодлого, УНТ-ны үр нөлөөтэй байдал, тогтоосон заавар, гэрээний нөхцөл, эсвэл санхүүжилтийн хэлэлцээрийн нөхцөл зэрэг эрх зүйн бичиг баримтын мөрдөлтийн аудит;

Гүйцэтгэлийн аудит – Компанийн нөөцийн зориулалтын хэмнэлттэй, үр ашигтай ба үр дүнтэй байдал, газар нэгжийн бодлого, стратеги, зорилтын гүйцэтгэлд хийх аудит */санхүү, хүний нөөц, тээвэр бусад нөөцийн үр ашиг, компани, нэгжийн зорилго, зорилтын гүйцэтгэл, үр дүнгийн хүлээгдэж буй гүйцэтгэлд хийх аудит/*

Системийн аюулгүй байдлын аудит – Компанийн дотоод цахим мэдээллийн урсгалын оновчтой зохион байгуулалт, үр ашигтай байдал, хариуцлага, мэдээллийн хамгаалалт, аюулгүй байдал зэрэгт хийж буй аудит;

УНТ-ны дотоод аудит – Чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001, Байгаль орчны удирдлагын тогтолцоо ISO 14001, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоо ISO 45001 стандартын хэрэгжилт, үр нөлөөтэй байдал, сайжруулалтад хийгдэж буй аудит юм гэжээ. Иймхүү аудит хийх хүрээ хязгаарыг ялгамжтай зааглаж, аудит тус бүрийг хяналт хийх хүрээгээр чиг үүргийг нь салгасан нь үнэт цаас гаргагч компанийн дотоод хяналтыг үр ашигтай, үнэн зөв хийх боломжийг бий болгож байна.

Мөн үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн дотоод аудитын журамд нэр томьёо, товчилсон үгийн тодорхойлолт оруулж, аудитын үндсэн процесс, тайлбарыг схемээр болон үгээр дэлгэрэнгүй тайлбарлаж, аудитын ажлын баримт, нууц хадгалах, аудитын тайлагнал, аудитын эргэн хяналт, оролцогч талуудын эрх үүргийг тодорхой тусгаж өгсөн байх бөгөөд хавсралтаар аудитын үйл ажиллагаанд холбогдох маягтуудыг баталжээ.

Иймхүү дотоод аудитын журам нь дэлгэрэнгүй, тодорхой, үйл ажиллагааны чиглэл болгонд аудитын хяналтыг хийхээр тусгасан нь компанийн дотоод хяналт нэг стандартаар, компанийн бүхий л үйл ажиллагаанд үр нөлөөтэй, бодитой хяналт хийх нөхцөлийг бий болгох ач холбогдолтой байна. Иймд уг журам нь холбогдох хууль тогтоомжийг зөрчөөгүй, нийцсэн гэж үзлээ.

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК нь "Дотоод аудитын журам"-тай холбогдуулан дараах бодлого, зааварчилгааг мөн дагаж мөрддөг байна.

Хүснэгт №9. "Шунхлай" ХХК-ийн Дотоод аудиттай холбогдох журмууд.

№	Баримт бичгийн дугаар	Баримт бичгийн нэр
1.	Б-ДАА-03-2020	Дотоод аудитын бодлого
2.	А3-ДАА-03-1	Аудитын бараа материалын үлдэгдэл баталгаажуулах тооллого, тооцоо шалгах ажлын заавар
3.	Ж-УНТ-05-02	Үл тохирлын бүртгэл, хяналтын журам
4.	ТХЖ-УНТ-02-2	Удирдлагын дүн шинжилгээ хийх журам

3.3.3.2. Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг

"Шунхлай" ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2020 оны 05 сарын 30-ны өдрийн В/122 дугаар тушаалаар Б-ДАА-02-01 дугаар "Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг"-ийг баталсан байна. Тус баримт бичгийн 1.1 дэх хэсэгт "*Энэхүү бодлогын баримт бичгийн зорилго нь Шунхлай ХХК...-ийн стратегийн болон бизнесийн зорилго, зорилт биелүүлэхэд эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах, болзошгүй алдагдлыг хамгийн бага түвшинд байлгах зэрэг эрсдэлийн харилцаа, удирдахтай холбогдсон харилцаа, ажилтнуудын оролцоо, эрх үүргийг зохицуулахад оршино*" гэжээ.

Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичгийн 2.1 дэх хэсэгт "*Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг нь компанийн бүх үйл ажиллагааг хамаарна. Өөрөөр хэлбэл компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд учирсан, учирч болзошгүй эрсдэлийг*

эрсдэлийн хүлээн зөвшөөрөгдөх түвшинд багтаан удирдах цогц үйл ажиллагаа юм" гэжээ. Мөн баримт бичгийн 3.1 дэх хэсэгт эрсдэлийн удирдлагын баримт бичгийг Дотоод аудитын албаны захирал хариуцан хяналт тавьж, Захирлуудын зөвлөлийн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэхээр заасан байна.

Тус баримт бичигт эрсдэлийн удирдлагын зарчим, компанийн ажилчид, удирдах албан тушаалтнуудын үүрэг, эрсдэл ба эрсдэлт хүчин зүйлс гарах үр дагаврыг тус тус тодорхойлж, эрсдэлийн удирдлагын үе шат, ангиллыг зааж, бодлогын хэрэгжүүлэлт болон хариуцлагыг тусгасан нь компанийн үйл ажиллагааны явцад эрсдэлийг тооцоолох, түүнээс урьдчилан сэргийлэх, учирсан үед авах хариу арга хэмжээ болон ажилтнууд эрсдэлийн үед ямар үүрэгтэй болохыг тус бүр дэлгэрэнгүй, тодорхой заасан байна.

Ийнхүү үүсэж болзошгүй эрсдэлийг тооцохоос эхлээд түүнд хариу арга хэмжээ төлөвлөх хүртэл бүхий л эрсдэлийн хүчин зүйл, нийт ажилчдын үүргийг тодорхой заасан нь үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн бизнесийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг багасгах, түүнээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой байна. Иймд үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг нь үр нөлөө бүхий ач холбогдолтой журам байна.

Мөн үнэт цаас гаргагч нь эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичгийг мөрдөж байгаатай холбогдуулан дараах журам, зааварчилгааг дагаж мөрддөг байна.

Хүснэгт №10. "Шунхлай" ХХК-ийн Эрсдэлийн удирдлагатай холбогдох журмууд.

№	Баримт бичгийн дугаар	Баримт бичгийн нэр
1.	АЗ-ДАА-01-2020	Эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал
2.	АЗ-УНТ-01-01	Эрсдэлийн үнэлгээ хийх ажлын заавар
3.	АЗ-БТГ-01-05	Компанийн хөрөнгө, эрсдэлийг даатгалд хамруулах ажлын заавар
4.	Ж-ЗЭЗА-02-01	Эрх зүйн эрсдэлээс урьдчилан сэргийлэх тухай журам
5.	Ж-ХАБУТ-02-01	Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдэлийн үнэлгээний журам

3.3.3.3. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журам

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1[34] дэх хэсэгт заасны дагуу үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн Гүйцэтгэх захирал 2017 оны 05 сарын 05-ны өдөр Ж-СГ-01-1 дугаартай "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг батлсан байна. Тус баримт бичгийн 1 дэх хэсэгт "*Энэхүү баримт бичгээр Шунхлай компанийн санхүү, бүртгэлийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, дотоод хяналтын тогтолцоог бий болгож эрсдэлээс хамгаалах, санхүүгийн мэдээллийг үнэн гэдэгт итгэл төрүүлэх, санхүүгийн тайланг бэлтгэх болон толилуулахтай холбоотой үйл ажиллагаанд бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэх оролцогчдын баримтлах зарчмыг тодорхойлох, нэгдсэн удирдамжаар хангахад оршино*" гэжээ.

Тус баримт бичгээр Нэг. Ерөнхий зүйл, Хоёр. Зорилго, Гурав. Хамрах хүрээ, Дөрөв. Баримт бичгийн хариуцагч, Тав. Нэр томьёоны тодорхойлолт, Зургаа. Чиг үүрэг, Долоо. Санхүүгийн газрын бүтэц, зохион байгуулалт, удирдлагын тогтолцоо, Найм. Бодлогын

[34] Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1. Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.

ШУНХЛАЙ 2026 09 10 БҮРТГЭЛ № 01
2026 -09- 02 БҮРТГЭЛ-03

баримтлах ерөнхий зүйл, Ес. Санхүүгийн газрын үүрэг, хариуцлага, Арав. Санхүүгийн ажилтнуудын ёс зүйн хэм хэмжээ, Арван нэг. Санхүүгийн тайлагналын НББ-ийн бодлого, Арван хоёр. Нягтлан бодох бүртгэлийн тусгай бодлогууд гэх арван хоёр бүлэг бүхий харилцааг зохицуулжээ.

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-т нягтлан бодох бүртгэлийн зарчмыг тусгасан байх бөгөөд санхүүгийн тайлан бэлтгэхэд хоёр талт, мөнгөөр хэмжигдэхүйц, аж ахуйн бие даасан, үл тасалдах буюу тасралтгүй байх, жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлахаар заасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1[35] дэх хэсэгт заасан зарчимтай нийцэж байна.

Тус баримт бичгийн арван нэгдүгээр бүлэгт "Санхүүгийн тайлагналын НББ-ийн бодлого"-ыг тодорхой, дэлгэрэнгүйгээр тусгасан байх бөгөөд тус бодлогыг НББ-ийн Олон улсын стандарт, холбогдох бусад хуульд нийцүүлэн баталж санхүүгийн тайлангийн зорилго, НББ-ийн суурь, НББ-ийн зарчим, НББ-ийн хэмжилтийн нэгж, тайлангийн хугацаа, цэвэр дүн, санхүүгийн тайлан бэлтгэх төсөөлөл, санхүүгийн тайланд тавигдах шаардлага, санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн, тайлангийн үзүүлэлтүүд, санхүүгийн тайлангийн элементүүдийн тодорхойлолт, санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга, санхүүгийн тайланг бэлтгэх, мэдээлэх, балансын өдрийн дараах үйл явдал зэргийг нэг бүрчлэн тусгаж, санхүүгийн тайлан гаргах үе шат бүрт хийх алхмыг тодорхой заасан нь үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь тус компанийн санхүүгийн тайлан бодитой, үнэн зөв гарахад ач холбогдолтой байх ба Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хуульд нийцжээ.

Мөн баримт бичгээр үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК нь Нягтлан бодох бүртгэлийн тусгай бодлогууд буюу мөнгөн хөрөнгийн НББ-ийн бодлого, дансны авлагын НББ-ийн бодлого, урьдчилж төлсөн тооцооны НББ-ийн бодлого, бараа материалын НББ-ийн бодлого, үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгийн НББ-ийн бодлого, хөрөнгө оруулалтын НББ-ийн бодлого, өр төлбөрийн НББ-ийн бодлого, эзэмшигчийн өмчийн НББ-ийн бодлого зэргээр тусгайлан зааж, тус бүрд хамаарах хөрөнгийг хэрхэн үнэлэх, тухайн хөрөнгөд хамаарах зүйлс, түүний тодорхойлолт, тайлан гаргах, тодруулга хийхэд анхаарах зүйлсийг зохицуулжээ.

Дээрхээс гадна үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2017 оны 05 сарын 05-ны өдөр баталсан Ж-СГ-03-2 дугаартай "Нягтлан бодох бүртгэлийн журам"-ыг дагаж мөрдөж байна.

Тус журмаар санхүүгийн тайлан гаргах процесс, процессын алхмуудын тайлбар, дансны төлөвлөгөө тохируулах бичилтийг тооцох, оролцогч талуудын эрх, үүргийг тодорхойлсон байна.

Мөн үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2021 оны 08 сарын 16-ны өдрийн В/337 дугаар тушаалаар шинэчлэн баталсан Ж-СГ-02-1 дугаартай

[35] Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.1.бие даасан байх; 5.1.2.тасралтгүй байх; 5.1.3.жинхэнэ хэрэгжилтийн; 5.1.4.үнэн зөв байх; 5.1.5.хэмжигдэхүйц байх; 5.1.6.зохицох.

УЛААНБААТАР ХОТ ШУНХЛАЙ ХХК
Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital Delivering Diversity 11192691111 Улаанбаатар хот

"Нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын журам" -ыг дагаж мөрдөж байна. Түс журмаар компанийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтын ажлыг хийх зохион байгуулах болон түүний хэрэгжилтэд хяналт тавих, нягтлан бодогч нарын дотоод хяналтын үнэлгээг бүртгэлийн журам, зааврын дагуу хийж, зөвлөмж өгч, бүртгэлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх харилцааг зохицуулсан.

Дээрх байдлаар магадлан үзвэл "Шунхлай" ХХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, нягтлан бодох бүртгэлийн журмын агуулга, үндэслэл нь хууль тогтоомж зөрчсөн зөрчил илрээгүй болно.

Үнэт цаас гаргагч нь компанийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтын ажлыг хийх, зохион байгуулах болон түүний хэрэгжилтэд хяналт тавих, нягтлан бодогч нарын дотоод хяналтын үнэлгээг журам, зааврын дагуу хийж, зөвлөмж өгч, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор гүйцэтгэх захирлын 2021 оны 08 сарын 16-ны өдрийн В/337 дугаар тушаалаар батлагдсан Ж-СГ-02-1 дугаартай "Нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын журам"-ыг дагаж мөрддөг байна.

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК нь нягтлан бодох бүртгэлтэй холбоотойгоор дээр дурдсанаас гадна дараах журам, зааварчилгааг мөн дагаж мөрддөг байна. Үүнд:

Хүснэгт №11. "Шунхлай" ХХК-ийн Нягтлан бодох бүртгэлтэй холбогдох журам, зааварчилгаа.

№	Баримт бичгийн дугаар	Баримт бичгийн нэр
1.	Ж-СГ-04-03	Шатахууны мөнгөн талоны журам
2.	Ж-СГ-04-01	Сэлбэгийн төсвийн хяналт, сэлбэг хангалт хийх журам
3.	Ж-СГ-05-01	Хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хяналтын журам
4.	АЗ-СГ-18-01	Төлбөрийн баримт олгох ажлын заавар
5.	АЗ-СГ-06-3	Мөнгөн хөрөнгө бүртгэлийн ажлын заавар
6.	АЗ-СГ-07-2	Авлагын бүртгэлийн ажлын заавар
7.	АЗ-СГ-08-2013	Бараа материал бүртгэх ажлын заавар
8.	АЗ-СГ-05-3	Өртөг, зардлын бүртгэлийн ажлын заавар
9.	АЗ-СГ-11-03	ШТС-ын өдөр тутмын мэдээ өгөх, тайлан гаргах ажлын заавар
10.	АЗ-СГ-10-2013	Цалин бодох, НДШ, ХХОАТ тайлан гаргах ажлын заавар
11.	АЗ-БТГ-03-03	Бүтээгдэхүүний үнэ, өртөг тооцох ажлын заавар
12.	АЗ-БТГ-03-04	Салбар нэгжийн төсвийн зардлын норм тогтоох, тайлан гаргах, зардлын хяналт хийх ажлын заавар
13.	Ж-СГ-05-01	Хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хяналтын журам
14.	Ж-СГ-19-01	Кассын үйл ажиллагааны журам
15.	Ж-СГ-20-01	Харилцах дансны үйл ажиллагааны журам
16.	Ж-СГ-21-01	Төсөв батлуулах, дараа тайлан хаах үйл ажиллагааны журам

3.3.3.4. ***<u>Хөдөлмөрийн дотоод журам нь хууль тогтоомжид нийцэж буй эсэх:</u>***

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК нь Хөдөлмөрийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1[36] дэх хэсэгт заасны дагуу гүйцэтгэх захирлын 2022 оны 01 сарын 10-ны

[36] Хөдөлмөрийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1. Ажил олгогч ажилтны толоодогчийн санаатай харгалзан хууль тогтоомжид нийцүүлэн тухайн аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд үйлчлэх хөдөлмөрийн дотоод журмыг батлаж мөрдүүлнэ.

ШУНХЛАЙ ХХК
2026 оны 09 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2026 09 02
БҮРТГЭВ-03

өдрийн В/44 дүгээр тушаалаар Ж-ЗХНГ-01-03 дугаартай "Хөдөлмөрийн дотоод журам"-ыг баталсан байна. Тус журмын нэг дэх хэсэгт " "Хөдөлмөрийн дотоод журам"-аар "*Шунхлай" ХХК, .../цаашид "Компани" эсвэл "Ажил олгогч" гэх/-ийн хөдөлмөрийн харилцаанд оролцогч талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлага, сахилгын болон ноцтой зөрчил, эд хөрөнгийн хариуцлага, компанийн хөдөлмөрийн удирдлага, зохион байгуулалт, дотоод үйл ажиллагааны хэм хэмжээг тогтоож, тэдгээрт холбогдох харилцааг зохицуулна*" хэмээн зааж, Хоёр. Нийтлэг үндэслэл, Гурав. Хамрах хүрээ, Дөрөв. Баримт бичгийн хариуцагч, Тав. Нэр томьёоны тодорхойлолт, товчилсон үгс, Зургаа. Үндсэн зүйл, Долоо. Хөдөлмөрийн харилцаанд оролцогч талуудын эрх, үүрэг, Найм. Хамаарах баримт бичгүүд, Ес. Хариуцлага, Арав. Хадгалалт гэх асуудлуудыг журамлан зохицуулахаар заасан нь Хөдөлмөрийн тухай хуульд нийцэж байна.

Журмын 6.1-т "*Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг Гүйцэтгэх захирал удирдана*" гэж заасан нь КтХ-ийн 83 дугаар зүйлийн 83.1[37]-т заасантай нийцэж байна.

Журмын 6.3.2.1-д "*Компанийн хэмжээнд дагаж мөрдөх ажил, амралтын цаг, ажлын цагийн горим тогтоох, ажилтны ирц бүртгэх, илүү цаг тооцох, чөлөө олгох, ээлжийн амралт олгох зэрэг ажлын цаг ашиглалттай холбоотой харилцааг "Ажлын цаг ашиглалтын журам", "ШТС-ын хөдөлмөрийн харилцаа зохицуулах журам"-аар тус тус зохицуулна*" гэжээ. Тус журмын дагуу "Шунхлай" ХХК-д Гүйцэтгэх захирлын 2023 оны 06 сарын 12-ны өдрийн В/135 дугаар тушаалаар батлагдсан Ж-ЗХНГ-07-05 дугаартай "Ажлын цаг ашиглалтын журам" мөрдөгдөж байна.

"Ажлын цаг ашиглалтын журам"-ийн 7.1.1-д "*Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд заасны дагуу долоо хоногийн ердийн ажлын цаг нь 40-өөс илүүгүй байна. Ердийн ажлын өдрийн үргэлжлэл 8 цагаас илүүгүй байна*", 7.1.2-т "*Ажлын байрны чиг үүрэг, онцлогоос шалтгаалан /ээлжийн болон бусад/ ажлын байрны ажил, амралтын цаг нь өдөр, цаг, ээлжийн графикаар тогтоогдоно*", 7.1.3-т "*Компанийн үндсэн ажлын цаг 09:00 цагаас эхэлж 18:00 цагт тарах ба үдийн цайны завсарлага 13:00-14:00 цагийн хооронд 1 цаг байна*", 7.1.4-т "*Газрын тосны бүтээгдэхүүний агуулахууд улирлын онцлогтой холбоотой ажил эхлэх, дуусах цагийг гүйцэтгэх захирлын шийдвэрийн дагуу өөрчилж болно*" гэж заасан нь ХтХ-ийн 84 дүгээр зүйлийн 84.1[38], мөн зүйлийн 84.2[39], 94 дүгээр зүйлийн 94.3[40]-т тус тус заасантай нийцэж байна.

"Шунхлай" ХХК-ийн "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 6.3.2.1-д заасны дагуу мөрдөгдөж буй "Шунхлай" ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2022 оны 04 сарын 01-ний өдрийн Т/194 дүгээр тушаалаар батлагдсан Ж-ЗХНГ-13-01 дугаартай "Шатахуун түгээх станцын хөдөлмөрийн харилцаа зохицуулах журам"-аар ШТС-ын хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалт, дотоод шилжилт хөдөлгөөн, ажлын цаг ашиглалт, цалин хөлс, хөнгөлөлт хангамж, тэтгэмж болон ажлаас чөлөөлөхтэй холбоотой бүхий л харилцааг зохицуулж байна.

---

[37] КтХ-ийн 83 дугаар зүйлийн 83.1 "Гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон тогтоолон удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна"

[38] Хөдөлмөрийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1 "Долоо хоногийн ердийн ажлын 40-өөс илүүгүй байна."

[39] Хөдөлмөрийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.2 "Ердийн ажлын өдрийн үргэлжлэл 8 цагаас илүүгүй байна."

[40] Хөдөлмөрийн тухай хуулийн 94 дүгээр зүйлийн 94.3 "Амрах, хооллох завсарлага эхлэх, дуусах цаг, үргэлжлэх хугацааг хөдөлмөрийн дотоод журмаар тогтооно. Өдрийн хооллох завсарлага нэг цагаас багагүй байна."

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
УТА3531 № 2023408

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering Diversity
1119289111 5081589
Улаанбаатар хот

2026.08.31

Шатахуун түгээх станцын хөдөлмөрийн харилцаа зохицуулах журмын 7.6.1.3-т "*ШТС-ын Эрхлэгч, Автосервисийн Автозасварчин, Худалдагч албан тушаалтай ажилтнуудын 7 хоногийн ажлын цаг нь 40 цаг, 1 өдрийн бүтэн ажлын цаг 8 байна*", 7.6.1.4-т "*Компанийн хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс нийтээр амрах баярын өдрүүдэд ШТС-ын Эрхлэгч нараар хариуцлагатай эргүүл томилон ажиллуулж болно. Хариуцлагатай эргүүлээр ажилласан ажилтанд 1 өдөрт 2 цагаар тооцож илүү цагийн нэмэгдэл олгох бөгөөд илүү цагийн хөлсийг холбогдох хуулийн дагуу тооцож олгоно*" гэж заасан нь КтХ-ийн 84 дүгээр зүйлийн 84.1, 109 дүгээр зүйлийн 109.4[41]-т тус тус заасантай нийцэж байна.

Хөдөлмөрийн дотоод журмын 6.5-д хөдөлмөрийн сахилгын зөрчил, сахилгын шийтгэлийн харилцааг зохицуулсан байх бөгөөд 6.5.1-д "*Хөдөлмөрийн хууль тогтоомж, Хөдөлмөрийн дотоод журам, Хөдөлмөрийн гэрээ, Компанийн бусад дотоод дүрэм, журам, заавар зааварчилгаа, Ажлын байрны тодорхойлолтыг зөрчсөн ажилтны буруутай үйлдэл, эс үйлдэхүйг сахилгын зөрчилд тооцно*", 6.5.3-т "*Хөдөлмөрийн сахилгын зөрчлийн акт, Аудитын дүгнэлт, Техникийн комиссын акт, Төлбөр зөрчлийн акт, Нэгжийн удирдлага болон харилцагч байгууллага, бусад ажилтнуудаас бичгээр ирүүлсэн мэдээлэл, өргөдөл, гомдлын талаар Захиргаа, хүний нөөцийн газар хянан үзэх ба хөдөлмөрийн сахилгын зөрчил гаргасан нь нотлогдож, энэ үйлдэл нь шийтгэл ногдуулах үндэслэлтэй байвал Гүйцэтгэх захирал буюу түүнээс эрх олгосон удирдах ажилтан сахилгын зөрчил гаргасан ажилтанд дараах хөдөлмөрийн сахилгын шийтгэлийг тушаал /бичгээр/ хэлбэрээр ногдуулна*", 6.5.5-д "*Сахилгын шийтгэлийн хэлбэрийг сонгохдоо зөрчлийн шинж чанар, түүний үр дагавар, хор уршиг, учруулсан хохирлын хэмжээ, хохирол төлбөр барагдсан байдал, зөрчил гаргасан ажилтны хувийн байдал, хүндэтгэн үзэх шалтгаан зэрэг хүчин зүйлсийг харгалзан үзэж, шат дараалан болон дараалал харгалзахгүйгээр сахилгын шийтгэлийг ногдуулж болно*" хэмээн тус тус заасан ба эдгээр нь Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.1[42], 123.2[43], 123.3[44] зэрэг Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлд зохицуулсан хөдөлмөрийн сахилгын шийтгэлийн харилцааг зохицуулсан бүхий л заалттай нийцэж байна.

Хөдөлмөрийн дотоод журмын 6.6-д заасан ажилтны хүлээх эд хөрөнгийн хариуцлага нь Хөдөлмөрийн тухай хуулийн 129 дүгээр зүйлийн 129.1 дэх хэсэгт "*Ажил үүргээ гүйцэтгэх үедээ аж ахуйн нэгж, байгууллагад өөрийн буруугаас эд хөрөнгийн хохирол учруулсан ажилтанд сахилгын, зөрчлийн, эрүүгийн хариуцлага ногдуулсан эсэхийг харгалзахгүйгээр эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэж болно*" хэмээн заасантай нийцэж байна.

---

[41] Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.4. Нийтээр амрах баярын одор ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг хоёр дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж олгоно.

[42] Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.1 Хөдөлмөрийн хууль тогтоомж, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ, ажлын байрны тодорхойлолтыг зөрчсөн ажилтны буруутай үйлдэл, эс үйлдэхүйг сахилгын зөрчилд тооцно.

[43] Мөн хуулийн 123 дугаар зүйлийн 123.2 Ажил олгогч буюу түүнээс эрх олгосон удирдах ажилтан сахилгын зөрчил гаргасан ажилтанд дараах хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулна: 123.2.1.оорт нь ганцаарчилсан хэлбэрээр хаалттай сануулах; 123.2.2.нийт ажилтанд нь зарлах хэлбэрээр нээлттэй сануулах; 123.2.3.үндсэн цалинг гурван сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах; 123.2.4.албан тушаал бууруулах; 123.2.5.ажил олгогчийн санаачилгаар хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлах.

[44] Мөн хуулийн 123 дугаар зүйлийн 123.3. Ажил олгогч хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулахаас өмнө ажилтанд мэдэгдэж, тайлбар авч, сахилгын зөрчлийн шинж, үр дагаврыг харгалзан энэ хуулийн 123.2-т заасан хөдөлмөрийн сахилгын шийтгэлийг сонгож хэрэглэнэ. Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэрийг бичгээр, эсхүл цахим хэлбэрээр гаргана.

Хөдөлмөрийн дотоод журмын 6.7-д заасан хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгох, хөдөлмөрийн гэрээ цуцлах ноцтой зөрчил зэргийг хөдөлмөрийн тухай хуулийн 78 дугаар зүйл[45], 79 дүгээр зүйл[46], 80 дугаар зүйлийг[47] тус тус баримтлан зохицуулсан байна.

Хөдөлмөрийн дотоод журмын Долоо дугаар бүлэгт ажилтны эрх, үүрэг, ажил олгогчийн эрх, үүргийг тус тус зохицуулсан байх бөгөөд тэдгээр зохицуулалт нь ХтХ-ийн 42 дугаар зүйл[48] болон 43 дугаар зүйлтэй[49] нийцэж байна.

ХтХ-ийн 120 дугаар зүйлийн 120.1-д "*Ажил олгогч нь ажилтны амь нас, эрүүл мэндийг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үр дүнтэй, шат дараалсан арга хэмжээ авч хэрэгжүүлнэ*", 120.2-т "*Ажил олгогч ажилтныг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандарт хангасан хөдөлмөрийн хэвийн нөхцөлөөр хангах үүрэгтэй*" хэмээн заасны дагуу ажил олгогч "Шунхлай" ХХК нь компанийн аливаа ажил, үйл ажиллагааны ХАБЭА-тай холбоотой аюулыг илрүүлж, эрсдэлийг тодорхойлон, хяналтад байлгах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохицуулах зорилгоор Ж-ХАБУТ-02-01 дугаартай "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдэлийн үнэлгээний журам", компанийн хэмжээнд ХАБЭА-д нөлөөлөх үйл явцуудыг тодорхойлох, хяналттай нөхцөлд явуулахын тулд үйл ажиллагааны хяналтын тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх, хадгалах зорилгоор Ж-ХАБУТ-06-01 дугаартай "Үйл ажиллагаанд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналт тавих журам" болон доор дурдсан бусад журмуудыг дагаж мөрддөг байна. Үүнд:

Хүснэгт №12. "Шунхлай" ХХК-ийн Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангахтай холбогдох журам, зааврууд

№	Баримт бичгийн дугаар	Баримт бичгийн нэр
1.	Ж-ХАБУТ-03-02	Компанийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бүтэц үүрэг, хариуцлагын журам
2.	Ж-ХАБУТ-05-01	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэдээлэл солилцоо, оролцоо, зөвлөгөөний журам
3.	Ж-ХАБУТ	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мониторинг, хэмжилтийн журам
4.	Ж-ХАБУТ-09-01	Ажлын хувцас, хамгаалах хэрэгслийг олгох, цэвэрлэх, актлах журам
5.	Ж-ХАБУТ-10-03	Үйлдвэрийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх, дүгнэлт гаргах комиссын журам
6.	Ж-ХАБУТ-08-02	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн өглөөний мэдээлэл, явцын хяналтын журам
7.	Ж-ХАБУТ-11-02	Онцгой байдлын бэлэн байх, хариу арга хэмжээ авах журам
8.	Ж-ХАБУТ-08-02	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн өглөөний мэдээлэл, явцын хяналтын журам
9.	ҮАЖ-ТТГ-03-2013	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн журам

[45] Хөдөлмөрийн тухай хуулийн 78 дугаар зүйл. Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгавар болох үндэслэл.
[46] Мөн хуулийн 79 дүгээр зүйл. Хөдөлмөр эрхлэлтийн харилцааг ажилтны санаачилгаар цуцлах.
[47] Мөн хуулийн 80 дугаар зүйл. Хөдөлмөр эрхлэлтийн харилцааг ажил олгогчийн санаачилгаар цуцлах.
[48] Мөн хуулийн 42 дугаар зүйл. Ажилтны үндсэн эрх, үүрэг.
[49] Мөн хуулийн 43 дугаар зүйл. Ажил олгогчийн үндсэн эрх, үүрэг.

10.	Д-ХАБУТ-01-01	Амь нас хамгаалах дүрэм
11.	ҮАЖ-ЛАБ-05-2014	Тоног төхөөрөмжтэй харьцах журам
12.	ҮАЖ-ЛАБ-06-2014	Дээжтэй харьцах журам
13.	ҮАЖ-ЛАБ-03-2014	Ажлын байр, орчин нөхцлийн хяналтын журам
14.	Д-ТТГ-01-2020	Компанийн байгаль орчин, ХАБЭА-н орон тооны бус зөвлөлийн дүрэм
15.	ААЗ-ХАБУТ-56-02	Сургалтын аюулгүй ажиллагааны зааварчилгаа
16.	АЗ-ХАБУТ-01-01	Агуулахын технологийн шугам хоолой, худагнуудад үйлчилгээ хийх үеийн аюулгүй ажиллагааны заавар
17.	АЗ-ХАБУТ-02-01	Сав тоног төхөөрөмжийн засварчны ажлын заавар
18.	АЗ-ХАБУТ-03-01	Газрын тосны бүтээгдэхүүн шахах насосыг ажиллуулах аюулгүй ажиллагааны заавар
19.	АЗ-ХАБУТ-04/2-01	ГТБА-уудад хатуу болон шингэн түлш хосолсон үүх ашиглах үед аюулгүй ажиллагааг хангах ажлын заавар
20.	АЗ-ХАБ-04/1-01	ШТС-уудад ердийн галлагаатай пийшин, цахилгаан халаалтын хэрэгсэл ашиглах үед аюулгүй ажиллагааг хангах ажлын заавар
21.	АЗ-ХАБУТ-05-01	Агуулахын шалгагчын ажлын заавар
22.	АЗ-ХАБУТ-10-01	Автомашины будгийн ажил хийх заавар
23.	АЗ-ХАБУТ-07-01	Тээврийн хэрэгслийн галын аюулгүй байдлыг хангах ажлын заавар
24.	АЗ-ХАБУТ-08-01	Шатахууны түгээгүүрийн засварын ажлын заавар
25.	АЗ-ХАБУТ-09-01	Осол, хурц хордлого гарсан үед үзүүлэх эмнэлгийн анхны тусламжийн заавар
26.	АЗ-ХАБУТ-11-01	Биет хамгаалалт, харуулын ажлын заавар
27.	АЗ-ХАБУТ-12-01	Сантехникч, мужаан, галч, бусад туслах ажилтны ажлын заавар
28.	АЗ-ХАБУТ-13-01	Хүчилтөрөгч /кислород/ болон бусад ахуйн хийн баллоныг ашиглах заавар
29.	ТАЗ-ХАБУТ-05-01	"Плот-3Б-1П" автомат хувийн жин, температур хэмжигчийн ашиглалтын заавар
30.	ТШ-ХАБУТ-01-01	Автобаазын тоноглол төхөөрөмж ба багаж хэрэгсэлд тавигдах техникийн шаардлага
31.	ТАЗ-ХАБУТ-03-01	Дохиолол, хамгаалалтын автомат системийн тоноглолын ашиглалтын заавар
32.	ААЗ-ХАБУТ-51-04	Спортын тэмцээний үеийн зааварчилгаа
33.	ААЗ-УБГТБА-01-01	Авто гараж дахь аюулгүй ажиллагааны зааварчилгаа
34.	ААЗ-ХАБУТ-01-01	ГТБА-д шинээр ажилд орж байгаа хүмүүст өгөх аюулгүй ажиллагааны зааварчилгаа
35.	ААЗ-ХАБУТ-02-01	Авто гараж дахь аюулгүй ажиллагааны зааварчилгаа
36.	ААЗ-ХАБУТ-03-01	Ачилт хийх, буулгах үеийн жолоочийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа
37.	ААЗ-ХАБУТ-04-01	Агуулах, шатахуун түгээх станцад ажиллагсдын галын аюулаас урьдчилан сэргийлэх зааварчилгаа
38.	ААЗ-ХАБУТ-05-01	Шатахууны хэмжилт хийх үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
УТА3531 эл. 2023468

280

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering Diversity
111928911 5181589
Улаанбаатар хот

2026.08.31

39.	ААЗ-ХАБУТ-06-01	Этилтэй бензинтэй харьцах үеийн аюулгүй ажиллагааны заварчилгаа
40.	ААЗ-ХАБУТ-07-01	Шатахуун хүлээн авах, хадгалах, ачилт хийх оператор, няравын аюулгүй ажиллагааны ерөнхий заварчилгаа
41.	ААЗ-ХАБУТ-08-01	Шатахуун ачигч, буулгагч нарын аюулгүй ажиллагааны заварчилгаа
42.	ААЗ-ХАБУТ-09-01	Тосолгооны материал ачигч, буулгагч нарын аюулгүй ажиллагааны заварчилгаа
43.	ААЗ-ХАБУТ-10-01	ГТБ-нйг торхонд /БОЧЕК/ савлах ажилтны аюулгүй ажиллагааны заварчилгаа
44.	ААЗ-ХАБУТ-11-01	Агуулахын засварын хэсэг /ЦЕХ/-д ажиллах үеийн аюулгүйн заварчилгаа
45.	ААЗ-ХАБУТ-12-01	Автомат төхөөрөмжийг ажиллуулах үеийн аюулгүй ажиллагааны заварчилгаа
46.	ААЗ-ХАБУТ-13-01	Том оврын автомашины мотор, дугуй , үндсэн эд ангийг засварлах үеийн аюулгүй ажиллагааны заварчилгаа
47.	ААЗ-ХАБУТ-51-04	Спортын тэмцээний үеийн заварчилгаа
48.	ААЗ-ХАБУТ-01-01	ГТБА-д шинээр ажилд орж байгаа хүмүүст өгөх аюулгүйн ажиллагааны заварчилгаа
49.	ААЗ-УБГТБА-01-01	Авто гараж дахь аюулгүй ажиллагааны заварчилгаа
50.	ААЗ-ХАБУТ-04-01	Агуулах, шатахуун түгээх станцад ажиллагсдын галын аюулаас урьдчилан сэргийлэх заварчилгаа
51.	ААЗ-ХАБУТ-05-01	Шатахууны хэмжилт хийх үеийн аюулгүй ажиллагааны заварчилгаа
52.	ААЗ-ХАБУТ-08-01	Шатахуун ачигч буулгагч нарын аюулгүй ажиллагааны заварчилгаа
53.	ААЗ-ХАБУТ-11-01	Агуулахын засварын хэсэг {цех}-д ажиллах үеийн аюулгүйн заварчилгаа
54.	ААЗ-ХАБУТ-12-01	Автомат ачих төхөөрөмжийг ажиллуулах үеийн ажиллагааны заварчилгаа
55.	ААЗ-ХАБУТ-17-01	Насосчны аюулгүй ажиллагааны заварчилгаа
56.	ААЗ-ХАБУТ-18-01	АСН-5 төхөөрөмжийг ажиллуулах аюулгүй ажиллагааны заварчилгаа
57.	ААЗ-ХАБУТ-19-01	Агуулахын ачих, буулгах байгууламж /эстакад/ дээр ажиллах үеийн аюулгүй заавар
58.	ААЗ-ХАБУТ-20-01	Шатахууны сав ашиглалтын үеийн аюулгүй ажиллагааны заварчилгаа
59.	ААЗ-ХАБУТ-22-01	ГТБ хадгалах сав засварлах, цэвэрлэх үед мөрдөх аюулгүй ажиллагааны заварчилгаа
60.	ААЗ-ХАБУТ-23-01	Агуулах, ШТС-д ил гал гаргаж ажил гүйцэтгэх үеийн аюулгүй ажиллагааны заварчилгаа
61.	ААЗ-ХАБУТ-24-01	Шатахуун түгээх станцад ажиллагсдын өдөр тутмын аюулгүй ажиллагааны заварчилгаа
62.	ААЗ-ХАБУТ-25-01	Агуулахын засварын хэсгийн засварчны аюулгүй ажиллагааны заварчилгаа
63.	ААЗ-ХАБУТ-27-01	Цахилгаанчны аюулгүйн техникийн заавар

281

2026.08.31

64.	ААЗ-ХАБУТ-30-01	Том оврын болон хүнд жинтэй ГТБ-ээс бусад төрлийн янз бүрийн ачааг өргөх тээвэрлэх аюулгүй ажиллагааны зааварчилгаа
65.	ААЗ-ХАБУТ-31-01	Өндөр ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа
66.	ААЗ-ХАБУТ-33-01	Компьютер дээр ажиллах үеийн аюулгүйн ажиллагааны зааварчилгаа
67.	ААЗ-ХАБУТ-35-01	Аюуумляртай харьцаж ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа
68.	ААЗ-ХАБУТ-36-01	Авто ачих төхөөрөмжийг ажиллуулах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа
69.	ААЗ-ХАБУТ-37-02	Зөөврийн насосоор савнаас шатахуун судлах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа
70.	ААЗ-ХАБУТ-40-01	Авлага барагдуулах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа
71.	ААЗ-ХАБУТ-41-01	Мэдээлэл технологийн үйлчилгээний үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа
72.	ААЗ-ХАБУТ-42-01	Сервер, пак, сүлжээний өрөөний а юулгүй ажиллагааны зааварчилгаа
73.	ААЗ-ХАБУТ-43-01	Архивын өрөөнд ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа
74.	ААЗ-ХАБУТ-44-01	Санхүүгийн баримт цэгцлэх, зөөх хураах аюулгүй ажиллагааны зааварчилгаа
75.	ААЗ-ХАБУТ-45-01	Хурц ир, үзүүртэй зүйл цахилгаан өрөмтэй ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа
76.	ААЗ-ХАБУТ-46-01	Цэвэр ба бохир ус савны далангийн хурын ус зайлуулах худагт үзлэг, засвар хийх үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа
77.	ААЗ-ХАБУТ-47-01	Үйлчлэгчийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа
78.	ААЗ-ХАБУТ-48-01	Шатахуун түгээх станцад онцгой тохиолдлын үед ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгаа
79.	ААЗ-ХАБУТ-49-01	Цахилгаан ба хийн гагнуурчны ААЗ
80.	ААЗ-ХАБУТ-50-01	ШТС-ын ажилтнуудын ажлын байран дахь аюулгүй ажиллагааны зааварчилгаа
81.	ААЗ-ХАБУТ-53-01	Тогоочийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа
82.	ААЗ-ХАБУТ-55-01	АХЦС аюулгүй ажиллагааны зааварчилгаа
83.	ААЗ-ХАБУТ-56-02	Сургалтын аюулгүй ажиллагааны зааварчилгаа
84.	ААЗ-ХАБУТ57-01	Тусгай хэрэгсэл ашиглах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа
85.	ААЗ-ХАБУТ-58-01	Газын плитка ажиллуулах аюулгүй ажиллагааны зааварчилгаа
86.	ААЗ-ХАБУТ-58-01	Ковид-19-Халдварт өвчний үед шатахуун тээврийн жолооч нарын мөрдөх халдвар хамгаалалын зааварчилгаа
87.	ААЗ-ХАБУТ-03-01	Ачилт хийх буулгах үеийн жолоочийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа
88.	ААЗ-ХАБУТ-06-01	Этилтэй бензинтэй харьцах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа
89.	ААЗ-ХАБУТ-13-01	Том оврын автомашины дугуй, үндсэн эд хөрөнгийг засварлах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа
90.	ААЗ-ХАБУТ-14-01	Өргөх машин механизмын жолооч, засварчны ажлын байран дахь аюулгүй ажиллагааны зааварчилгаа
91.	ААЗ-ХАБУТ-15-01	Лаборантын аюулгүй ажиллагааны зааварчилгааны

2026.08.31

92.	ААЗ-ХАБУТ-16-01	Лаборантын шил, сав угаах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа
93.	ААЗ-ХАБУТ-26-01	Томилолтоор явах гадуур ажиллах үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа
94.	ААЗ-ХАБУТ-28-01	Дээж авах, сав торх хэмжих шалгах ажил хийх үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа
95.	ААЗ-ХАБУТ-29-01	Автын засварчны аюулгүй ажиллагааны зааварчилгаа
96.	ААЗ-ХАБУТ-32-01	Жолоочийн аюулгүй ажиллагааны ерөнхий зааварчилгаа
97.	ААЗ-ХАБУТ-38-01	Химичийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа
98.	ААЗ-ХАБУТ-39-01	Автоцистерний торхыг цэвэрлэх гагнуур хийх зааварчилгаа
99.	ААЗ-ХАБУТ-54-01	Цоожлох, пайз хамгаалалтын тууз хэрэглэх зааварчилгаа
100.	ААЗ-УБ ГТБА-04-01	Шатахууны ачигч буулгагчийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа
101.	ААЗ-УБ ГТБА-04-01	Технологийн ажилтны ААЗ
102.	ААЗ- УБ ГТБА-02-01	ТТМ, битум аккумляторын буулгах, ачих үеийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа
103.	АЗ-ЗЭЗА-27-01	Архивын ажлын заавар
104.	ААЗ-ХАБУТ-50	ШТС-ын аюулгүй ажиллагааны зааварчилгаа
105.	ААЗ-ХАБУТ-51-05	Спортын тэмцээний үеийн зааварчилгаа
106.	Ж-ЗХНГ-11-04	Сайшаал, шагналын журам

Дээрх байдлаар магадлан үзвэл "Шунхлай" ХХК-ийн Хөдөлмөрийн дотоод журам болон хөдөлмөрийн харилцааг зохицуулсан бусад журам нь холбогдох хууль тогтоомж зөрчсөн зөрчилгүй тул хууль тогтоомжид нийцсэн гэж үзнэ.

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК нь Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн дотоод журамтай холбогдуулан дээр дурдсан журмуудаас гадна дараах журам, зааварчилгааг дагаж мөрддөг байна. Үүнд:

Хүснэгт №13. "Шунхлай" ХХК-ийн Хөдөлмөрийн дотоод журамтай холбогдох журам, зааврууд.

№	Баримт бичгийн дугаар	Баримт бичгийн нэр
1.	Ж-ЗХНГ-17-02	Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгавар болгох журам
2.	Ж-ЗХНГ-21-03	Хөнгөлөлт тусламж, тэтгэмж олгох журам
4.	Ж-ЗХНГ-06-01	Ажилтан сонгон шалгаруулах, ажилд авах журам
5.	Ж-ЗХНГ-26-01	Гол ажилтан, гол ажлын байрыг тодорхойлох, гол ажлын байрны залгамж халааг бэлтгэх тухай журам
6.	Ж-ЗХНГ-20-01	Дасан зохицуулах үйл ажиллагааны журам
7.	Ж-ЗХНГ-23-02	Хууль, эрх зүйн хэмжээний бүртгэл, үнэлгээ, үйл ажиллагааны журам
9.	Ж-ЗХНГ-01-02	ШТС-ын ажилтнуудын үнэлгээний журам
10.	Ж-ЗХНГ-22-01	Сургалт, хөгжлийн журам
11.	Ж-ЗХНГ-25-01	Гүйцэтгэлийн урамшууллын журам
12.	Ж-ЗХНГ-10-02	Цалин хөлсний журам
13.	Ж-ЗХНГ-29-01	Зуучлалын хөлс олгох журам
14.	Ж-ЗХНГ-12-01	Шатахуун түгээх станцын ажилтнуудын ур чадварын түвшин тогтоох үнэлгээний журам

15.	Ж-ЗХНГ-05-02	Үнэлгээний тухай журам
16.	Ж-ЗХНГ-30-01	Шунхлай компанийн ёс зүйн багц дүрэм
17.	Ж-ЗХНГ-15-02	Архивын үйл ажиллагааны журам
18.	ҮАЖ-ЗХНГ-10-2013	Ажилтан ажлаас гарах болон шилжин ажиллах үед баримтлах журам
19.	Ж-ХНА-06-2018	Зөвлөх хөтөлбөрийн үйл ажиллагааг зохицуулах журам
20.	АЗ-ЗХНГ-03-2013	Зөрчигдсөн эрхийг сэргээх ажлын заавар
21.	АЗ-ЗХНГ-05-2021	Албан хэрэгцээнд автомашин ашиглах зааварчилгаа
22.	АЗ-ЗХНГ-01-01	Ажлын байрны тодорхойлолт боловсруулах заавар
23.	Б-ТТГ-01-04	Техник технологийн бодлого
24.	Б-ТТГ-02-01	Тээврийн байдлын баримтлах бодлого
25.	ҮАЖ-ТТГ-01-2013	Шинээр барих, өргөтгөл шинэчлэл хийх журам
26.	Ж-ТТГ-02-02	Техникийн бэлэн байдал хангах журам
27.	Ж-ТТГ-16-01	Харуул, хамгаалалтын журам
28.	Ж-ТТГ-13-03	Эзэлж хүлээлцэх, тооллогог хийх, тооцоо бодох журам
29.	ҮАЖ-ЛАБ-02-2014	Хавсран гүйцэтгүүлэх журам
30.	Ж-ГТБА-01-03	ГТБА-уудад мөрдөгдөх технологийн үйл ажиллагааны журам
31.	ҮАЖ-ТГ-01-2013	Тээврийн газрын баримтлах бодлого
32.	ҮАЖ-ТГ-02-2013	Тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг хангах журам
33.	ҮАЖ-ТГ-03-2013	Тээвэрлэлт ба хяналтын журам
34.	ҮАЖ-ТГ-04-2013	Ачаа хуваарилах журам
35.	ҮАЖ-ТТГ-05-2013	Төсөл хэрэгжүүлэх журам
36.	Ж-ШЗА-01-02	Шуурхай зохицуулалтын албаны үйл ажиллагааны журам
37.	ҮАЖ-ГХГ-02-2013	Гадаад худалдааны газрын бодлого
39.	Ж-ЗХНГ-02-02	Бүтээмжийн үйл ажиллагааны журам
42.	Ж-ШТС-02-01	ШТС-д орлого хүлээн авах журам
43.	Ж-ШТС-04-01	Автомашин хийгээр цэнэглэх станцад шингэрүүлсэн хийн түлшний орлого хүлээн авах журам
44.	Ж-ЗХНГ-08-03	Баримт бичиг боловсруулах, хяналт тавих журам
45.	Ж-ЗХНГ-02-03	Компанийн нууцын тухай журам
46.	АЗ-ТТГ-05-01	Шатахууны хадгалах саванд геометр хэмжилт хийх ажлын заавар
47.	Ж-ШТС-03-02	Шөнийн цагаар газрын тосны бүтээгдэхүүнийг ачуулах, тээвэрлэх, хүлээн авах журам
48.	ТАЗ-УБГТБА-01-01	Эко зурган халаагуурын техник ашиглалтын зааварчилгаа
49.	АЗ-ТГ-01-2013	Ачаа буулгах заавар
50.	АЗ-ТТГ-01-2015	Дулаан хэмжигч электрон багажны ашиглалтын заавар
51.	АЗ-ТГ-02-2013	Засвар техникийн үйлчилгээ хийх ажлын заавар
52.	АЗ-ТТГ-02-2015	Нөөцийн цахилгаан үүсгүүр /генератор/-ийн ашиглалтын заавар
53.	АЗ-ТГ-03-2013	Техникийн оношилгоо, АТБӨЯХАТ-ын заавар
54.	АЗ-ТТГ-03-01	Автоцистернээр тээвэрлэгдэн ирсэн гадаад ачааг хүлээн авах, тооцоолох заавар
55.	АЗ-ТГ-04-2013	Норм тогтоох ажлын заавар
56.	АЗ-ТГ-05-2013	Тээврийн нэгтгэл бэлтгэх ажлын заавар
57.	АЗ-ТГ-07-2013	Төв замын зөвшөөрөл авах заавар
58.	Ж-БТГ-07-01	Мэдээллийн технологи ашиглалтын журам
59.	Ж-БТГ-08-01	Мэдээллийн аюулгүй байдлын журам
60.	Ж-БТГ-09-01	Мэдээллийн технологийн үйл ажиллагааны журам

61.	АЗ-БТГ-05-03	Компанийн жилийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих ажлын заавар
62.	АЗ-ТТГ-04-02	ШТС-д хүлээн авсан шатахууны орлогын тооцооллыг шалгах заавар
63.	АЗ-ЗХНГ-04-2016	Албан бланк ашиглах заавaрчилгаа
64.	АЗ-ЗХНГ-04-03	Журам бичих заавар
65.	ГА-НМТ-01-3	Нэгдсэн менежментийн тогтолцооны гарын авлага
66.	ТХЖ-УНТ-02-2	Удирдлага дүн шинжилгээ хийх журам
67.	Ж-ЗХНГ-31-01	Гэрээний хяналтын журам
68.	ГА-НМТ-01-4	Нэгдсэн менежментийн тогтолцооны гарын авлага
69.	Ж-БТГ-01-2026	Ажлын компьютерын үзүүлэлт, чадамжийн стандарт
70.	Ж-ЗХНГ-08-04	Баримт бичиг боловсруулах, хяналт тавих журам
71.	Ж-ЗХНГ-15-01	ШТС-ын сэлгэн ажиллуулах харилцааг зохицуулах журам

3.3.3.5. Компанийн дотооддоо мөрддөг бусад дүрэм, журмууд нь хууль тогтоомжид нийцсэн эсэх:

Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5, 11 дүгээр зүйлийн 11.2.1, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасан "газрын тосны бүтээгдэхүүнтэй холбоотой үйл ажиллагаа эрхлэгч нь дахин ашиглахаа больсон агуулах, сав, тоног төхөөрөмжийг зайлуулах, газрын тосны бүтээгдэхүүний үлдэгдлийг цэвэрлэх, газрыг тэгшилж хөрсийг хэвийн байдалд оруулан хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд хоргүй болгох, бохирдсон болон эвдэрч гэмтсэн газрын хөрсийг нөхөн сэргээж ургамалжуулах", Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан "эрх бүхий байгууллагаас баталсан байгаль орчны холбогдолтой стандарт, хэм хэмжээ, дүрэм, журмыг чанд сахин биелүүлж, дотоодын хяналтыг хэрэгжүүлэх", мөн зүйлийн 3 дахь хэсэгт заасан "үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх явцад байгаль орчинд гаргаж байгаа хорт бодис, физикийн хортой нөлөөлөл, хог хаягдлын хэмжээг бүртгэж, тэдгээрийг багасгах, цэвэрлэх талаар авсан арга хэмжээ, хянах төхөөрөмжийн ажиллагааны тухай тайлан мэдээг хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагад өгөх" үүргийг тус тус хүлээж байна.

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК нь байгаль орчин хамгаалах үндсэн үүргийн хүрээнд 2021 оны 06 сарын 10-ны өдрийн В/245 дугаар тушаалаар батлагдсан Ж-БОУТ-02-02 дугаар "Байгаль орчны бодлого, хөтөлбөрийн журам"-ыг дагаж мөрдөж байна.

Тус журмын нэг дүгээр бүлэгт "*Энэхүү журам нь ISO14001 Байгаль орчны удирдлагын тогтолцооны стандартын 4.3.3 шаардлагыг үндэслэн байгууллагын үндсэн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг буруулахаар байгаль орчны зорилго, зорилт, удирдлагын төлөвлөгөө боловсруулан үр дүнтэй хэрэгжүүлж, хяналт тавин сайжруулахад оршино*" гэжээ.

Мөн үнэт цаас гаргагч нь "Шунхлай" ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2014 оны 11 сарын 14-ний өдрийн В/204 дүгээр тушаалаар батлагдсан Ж-БОУТ-04-01 дугаартай "Байгаль орчны ажиглалт хэмжилтийн журам"-ийг дагаж мөрддөг бөгөөд тус журмын нэг дүгээр бүлэгт "*Байгаль орчны удирдлагын тогтолцооны ISO 14001:2004 стандартын 4.5.1 шаардлагын дагуу Компанийн байгаль орчны удирдлагын тогтолцооны гүйцэтгэл, үйл ажиллагааны хяналт, байгуулагын байгаль орчны зорилго, зорилтын биелэлтийг байнгын болон давтамжтайгаар ажиглалт болон хэмжилт хийж хянах, байгаль орчны нөлөөллийн бүртгэлд ажиглалт, хэмжилтээр тодорхойлогдсон дүнг бүртгэхэд оршино*" гэж, "Шунхлай" ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2014 оны 11

2026.08.31

сарын 14-ний өдрийн В/204 дүгээр тушаалаар батлагдсан Ж-БОУТ-03-01 дугаартай "Байгаль орчны үйл ажиллагааны хяналтын журам"-ийн нэг дүгээр бүлэгт *"Энэхүү журам нь байгаль орчны удирдлагын тогтолцооны ISO 14004:2004 стандартын 4.4.6 шаардлагыг үндэслэн байгууллагын үндсэн үйл ажиллагаанаас агаар, ус, хөрс, хаягдал эд, дуу чимээ, чичиргээ, эрчим хүч зэрэгт үр ашигтайгаар хяналт тавих үүднээс байгаль орчинд хортой нөлөөлөл үүсгэхээс сэргийлэх үйл ажиллагааг тогтоосон журмуудын шаардлагын дагуу нийцүүлэх, хяналт тавих, нөлөөллийг тодорхойлон багасгахад чиглэгдсэн үйл ажиллагааг зохицуулахад оршино"* хэмээн тус тус заажээ.

Мөн эдгээрээс гадна дараах журмуудыг дагаж мөрддөг байна. Үүнд:

Хүснэгт №14. "Шунхлай" ХХК-ийн байгаль орчныг хамгаалахтай холбогдох журмууд.

№	Баримт бичгийн дугаар	Баримт бичгийн нэр
1.	ҮАЖ-ТТГ-06-2013	Байгаль орчин хамгаалах үйл ажиллагааг зохицуулах журам
2.	Ж-БОУТ-05-01	Байгаль орчны мэдээлэл хүлээн авах, түгээх үйл ажиллагааны журам
3.	Ж-БОУТ-06-03	Хог хаягдлын хяналтын журам
4.	Ж-БОУТ-07-01	Химийн хорт бодисын хяналтын журам
7.	Ж-БОУТ-09-01	Эрчим хүч ашиглалт хяналтын журам
12.	Ж-ХАБУТ-01-02	Аюул, байгаль орчны асуудал, аюултай тохиолдлыг бүртгэх, судлах журам
13.	ҮАЖ-ТТГ-07-2013	Галын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг зохицуулах журам

Дээрхээс дүгнэвэл, үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК нь Байгаль орчин хамгаалах тухай хууль болон Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулиар хүлээсэн газрын тосны бүтээгдэхүүнтэй холбоотой үйл ажиллагаа эрхлэгчийн үндсэн үүргийг биелүүлдэг, тийнхүү биелүүлэх үндэслэл буюу байгаль орчныг хамгаалахтай холбоотой журмууд нь холбогдох хууль тогтоомжид нийцэж байна.

3.3.4. Компанийн бизнесийн үйл ажиллагаанд холбогдох журмууд нь хууль тогтоомжид нийцсэн эсэх:

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн бизнесийн үйл ажиллагаанд мөрдөгддөг журмуудыг дараах хүснэгтэд жагсаав.

Хүснэгт №15. "Шунхлай" ХХК-ийн бизнесийн үйл ажиллагаатай холбогдох журмууд.

№	Баримт бичгийн дугаар	Баримт бичгийн нэр
1.	Ж-ЗХНГ-27-01	Газрын эрх шилжүүлэн авах харилцаанд мөрдөх журам
2.	Ж-ЗХНГ-24-01	Харилцагчийн үйлчилгээний стандартын журам
3.	Ж-БТГ-01-02	Газрын тосны бүтээгдэхүүний гадаад захиалгын журам
4.	Ж-ДАА-06-03	Тендерийн журам
5.	Ж-БМГ-07-05	Газрын тосны бүтээгдэхүүний борлуулалтад урамшуулал олгох журам
6.	Ж-БМГ-01-03	Картаар үйлчлэх журам
7.	Ж-БМГ-03-03	Газрын тосны бүтээгдэхүүнийг худалдан борлуулах журам
8.	Ж-БМГ-08-02	Тос тосолгооны материал, аккумлятор, битумыг хүргэх,хадгалах, борлуулах журам

9.	Ж-БМГ-12-02	Газрын тосны бүтээгдэхүүний дотоод захиалга хийх журам
10.	АЗ-БМГ-01-03	Тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа
11.	ҮС-ТСТ-01-01	Тос солих төвийн үйлчилгээний стандарт
12.	АЗ-ГТБА-02-2013	Шунхлай Трейдинг ХХК-ний УБГТБА-ын автомат ачих төхөөрөмж /TAS/-өөр ачилт хийх, хүлээн авах ажлын заавар
13.	Ж-ТТГ-12-02	Газрын тосны бүтээгдэхүүний илүүдэл, дутагдлыг шийдвэрлэх журам
14.	Ж-ТТГ-11-02	Газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналтын журам
15.	АЗ-ЛАБ-01-02	Ажлын стандартчилсан загвар дээж бэлтгэх, стандарт уусмал худалдан авах, тээвэрлэх, хадгалах, ашиглах заавар
16.	ҮАЖ-ЛАБ-04-2014	Сорилтын арга, аргын баталгаажуулалтын журам
17.	ҮАЖ-ЛАБ-07-2014	Сорилтын үр дүнгийн чанар хангах журам
18.	ҮАЖ-ЛАБ-08-2014	Сорилтын үр дүнг тайлагнах журам
19.	Ж-ЛАБ-09-01	Газрын тосны бүтээгдэхүүний лабораторийн шинжилгээний хэмжлийн эргэлзээ тооцох заавар
20.	АЗ-ТГ-08-2013	Торхны багтаамжийг баталгаажуулах журам
21.	Ж-ТТГ-04-02	Хэмжүүр хэрэгслийн журам
22.	Ж-ТТГ-06-02	Комисс ажиллах журам
23.	Ж-ТТГ-09-02	Засвар үйлчилгээ хийх журам
24.	Ж-БМГ-04-04	Бүсийн судалгааны журам
25.	Ж-БМГ-13-02	Маркетингийн хөтөлбөр хэрэгжүүлэх журам
26.	Ж-ХАА-01-02	Худалдан авалтын журам

1.Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК нь компанийн бизнесийн гол үйл ажиллагаанд буюу худалдан авах, бэлтгэн нийлүүлэгч, ажил гүйцэтгэгчийг сонгох үйл ажиллагаанд "Шунхлай" ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2021 оны 03 сарын 12-ны өдрийн тушаалаар батлагдсан Ж-ДАА-06-03 дугаартай Тендерийн журмыг дагаж мөрддөг байна.

Тус журмын 1 дэх хэсэгт "*Журмын зорилго нь "Шунхлай" ХХК...-ийн худалдан авалтын үйл ажиллагаанд бэлтгэн нийлүүлэгч, ажил гүйцэтгэгчийг өрсөлдөх тэгш боломжоор ханган, ил тод, нээлттэй сонгон шалгаруулахад оршино*" гэжээ.

Тус журмаар зохицуулснаар "Шунхлай" ХХК нь 50,000,001 төгрөгөөс дээш үнийн дүнтэй бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үед бэлтгэн нийлүүлэгч/ажил гүйцэтгэгчийг тендер зарлан сонгон шалгаруулах бөгөөд тийнхүү сонгон шалгаруулалтыг үнэт цаас гаргагчийн тендерийн хороо явуулна. Тендерийн хороо нь гүйцэтгэх захирал, Дотоод аудитын албаны захирал, Санхүү хариуцсан захирал, Бизнес төлөвлөлт хариуцсан захирал, захиалагч газар, нэгжийн захирал байх ба тендерийг хараат бусаар, аливаа ашиг сонирхлын зөрчлөөс ангид явуулж, 100 хувийн ирцээр шийдвэрлэхээр журамд заажээ.

Мөн тус журамд тендер сонгон шалгаруулалтын бүхий л алхмуудыг тайлбарлан тусгасан байх ба тендер шалгаруулалтыг ил тод, нээлттэй явуулж, тендерийн үнэлгээг компанид мөрдөгдөх М-01-Ж-ДАА-06 дугаартай тендерийн үнэлгээний хуудасны дагуу үнэлэхээр заасан байна.

Иймд энэхүү тендерийн журам нь компанийн худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, ажил гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулахад гол ач холбогдолтой байх бөгөөд компанийн бизнесийн голлох ач холбогдол бүхий харилцааг компанийн аливаа эрх бүхий

2026.08.31

ШУНХЛАЙ БҮРТГЭЛ № 03
2026-09-02 БҮРТГЭЛ-03

албан тушаалтны ашиг сонирхлоос гадуур, компанийн зорилт, төсөвт үндэслэж үйл ажиллагааг шударга, үнэн зөв явуулах ач холбогдолтой байна.

2.Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн бизнесийн гол үйл ажиллагаа нь шатахуун импортлох, түүнийг борлуулах үйл ажиллагаа юм. Тус үйл ажиллагааны хүрээнд АЗ-ЛАБ-01-02 дугаартай "Ажлын стандартчилсан загвар дээж бэлтгэх, стандарт уусмал худалдан авах, тээвэрлэх, хадгалах, ашиглах заавар", Ж-ЛАБ-09-01 дугаартай "Газрын тосны бүтээгдэхүүний лабораторийн шинжилгээний хэмжилтийн эргэлзээ тооцох заавар", шатахуунд хийх шинжилгээ, сорил, түүний чанартай холбоотой журмууд, Газрын тосны бүтээгдэхүүний дотоод захиалга хийх журам болон Газрын тосны бүтээгдэхүүний гадаад захиалгын журмуудыг дагаж мөрддөг байна.

"Шунхлай" ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2021 оны 03 сарын 15-ны өдөр батлсан Ж-БМГ-12-02 дугаартай "Газрын тосны бүтээгдэхүүний дотоод захиалга хийх журам"-аар "Шунхлай" ХХК-ийн Монгол улсад импортолсон шатахууны нөөцийг "Шунхлай" ХХК-ийн үйл ажиллагааны нэгж, салбар бүр тооцоолох, худалдан авалтын хэмжээ, тооцооллоос хамаарч нэгж хооронд шатахууны захиалга өгөх, шатахууныг зөөлөөр худалдаж байгаа тохиолдолд гэрээний төлбөр төлөлтийн үүргээс хамаарч шатахууныг нийлүүлэх, хөнгөлөлттэй худалдаж байгаа тохиолдолд эрх бүхий албан тушаалтны зөвшөөрлийг заавал авах зэрэг компанийн шатахуун борлуулахад бүтээгдэхүүний зохицуулалт, хүртээмжтэй байдлыг хангахтай холбоотой харилцааг зохицуулдаг байна. Энэхүү журмын зохицуулалт нь Иргэний хуулийн худалдах, худалдан авах гэрээ, зөөлөөр худалдах, худалдан авах гэрээний зохицуулалтад нийцэж байна.

Мөн үнэт цаас гаргагч нь Ж-БМГ-03-03 дугаартай "Газрын тосны бүтээгдэхүүнийг худалдан борлуулах журам"-ыг дагаж мөрддөг бөгөөд тус журмаар Газрын тосны бүтээгдэхүүний үнийг тогтоох, түүнийг худалдан борлуулах үйл ажиллагааг гүйцэтгэхтэй холбоотой үүсэх харилцааг зохицуулж байна. Тодруулбал, тус журмын 7.3 дахь хэсэгт "*Бүх шатны менежер нь газрын тосны бүтээгдэхүүн, тос, тосолгооны материал, аккумулятор, битумын үнийн судалгааг компаниас баталсан маягтын дагуу хийж ахлах менежерт хүргүүлнэ*", 7.1 дэх хэсэгт "*ГТБА, ШТС болон Тос солих төв дээр мөрдөх үнэ буюу газрын тосны бүтээгдэхүүнийг худалдан борлуулах үнийг Гүйцэтгэх захирлын тушаалаар батална*", 8.2 дахь хэсэгт "*Менежер нь тухайн харилцагчийн талаар хийсэн судалгаа, цуглуулсан баримт мэдээлэл, харилцагчийн санал хүсэлтийг үндэслэн хамтран ажиллах эсэхэд дүн шинжилгээ хийнэ*", 8.4 дэх хэсэгт "*Менежер нь тухайн харилцагчтай хамтран ажиллах боломжтой гэж дүгнэсэн тохиолдолд энэхүү журмын "Менежерийн судалгаа, дүгнэлт, саналын хуудас" /М-07-Ж-БМГ-03 дугаартай/-ыг бөглөнө, түүнд шаардлагатай бүхий л мэдээллийг тэмдэглэж, хамтран ажиллах үндэслэл, санал, дүгнэлтээ тодорхой дэлгэрэнгүй тусгана*" хэмээн заажээ. Тус журмын Худалдах, худалдан авах гэрээний зохицуулалтын хувьд гэрээ байгуулахад бүрдүүлэх материал болон гэрээ байгуулахад анхаарах зүйлсийг тусгасан бөгөөд эдгээр нь Иргэний хуулийн зохицуулалттай нийцэж байна.

Дүгнэлт: Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн дотооддоо мөрддөг дүрэм, журмууд нь Компанийн тухай хууль, Иргэний хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн, аливаа зөрчилгүй байна.

УЛААНБААТАР ХОТ ШУНХЛАЙ ХХК ТТА3531 эх 2028498

288

Голомт Капитал ТЦК ХХК Golomt Capital Delivering Excellence 1119269111 Улаанбаатар хот

2026.08.31

Эдгээр дүрэм, журам, зааварчилгаанууд нь хоорондоо уялдаа холбоо сайтай, компанийн аливаа үйл ажиллагаанд шаардагдах бүхий л мэдээлэл, дагах ёстой зааврыг агуулсан, үйл ажиллагаа болгоны үе шат, тэдгээрт гүйцэтгэх албан тушаалтны үүрэг хариуцлагыг тодорхойлсон, тэдгээрийн ажиллагааг тайлагнах, хянах этгээд, ажлын процесс хэрхэн явагдах нь тодорхой тусгагдсан, бизнесийн үйл ажиллагааг амжилттай явуулахад үр нөлөө бүхий байна.

3.4. Бусадтай байгуулсан худалдах болон худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх:

Энэхүү хэсэгт үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК нь бусадтай байгуулдаг гэрээний төсөлд болон үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 жилийн хугацаанд байгуулсан хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 болон түүнээс дээш хувьтай тэнцэх үнийн дүн бүхий 91 гэрээнээс түүврийн аргаар 35 гэрээг сонгож хууль зүйн дүгнэлт хийлээ.

Хуулийн фирм нь үнэт цаас гаргагчаас ирүүлсэн гэрээ, хэлцлийн хуулбарыг эх сурвалж болгож, холбогдох тайлбар, мэдээллийн хүрээнд Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн эсэхийг шалгав. Харин тэдгээр гэрээ, хэлцлийн үүргийн гүйцэтгэлд дүгнэлт хийгээгүй болно.

3.4.1. Үйлчлүүлэгчтэй байгуулдаг гэрээнд хийсэн дүгнэлт

Хүснэгт №16. Үйлчлүүлэгчтэй байгуулдаг гэрээний төсөл

№	Гэрээний төрөл	Гэрээний агуулга
1	Худалдах, худалдан авах гэрээ	Худалдагчаас худалдан авагчид чанар стандартын шаардлагыг хангасан бүтээгдэхүүн болох бүх төрлийн шатахуун, тос, тосолгооны материал, аккумляторыг нийлүүлэх, худалдан авагчаас үнийг төлөх үүргийн гүйцэтгэлийг хангахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.
		Худалдагч тал худалдан авагчид мөнгөн талон, "Шунхлай шатахууны Т карт"-аар шатахуун, тос, тосолгооны материал, аккумлятор нийлүүлэх харилцааг зохицуулна.
		Тос, тосолгооны материал, аккумлятор зээлээр худалдах, худалдан авах гэрээ.
2	Үл хөдлөх хөрөнгийн Барьцааны гэрээ /ипотек/	"Шунхлай" ХХК болон үүрэг гүйцэтгэгч нарын хооронд байгуулсан гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор барьцаалуулагчийн өмчлөлийн үл хөдлөх эд хөрөнгийн барьцаалах, түүгээр үүргийн гүйцэтгэлийг хангах, үүнтэй холбоотой талуудын эрх, үүрэг, холбогдон гарах бусад харилцааг зохицуулна.
3	Барьцааны гэрээ /хөдлөх болон эдийн бус хөрөнгийн /	"Шунхлай" ХХК болон үүрэг гүйцэтгэгч нарын хооронд байгуулсан гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор үүрэг гүйцэтгэгч өөрийн эд хөрөнгийг барьцаалуулах, түүнтэй холбоотой талуудын эрх, үүрэг, холбогдон гарах бусад харилцааг зохицуулна.
4	Фидуцийн гэрээ	"Шунхлай" ХХК-тай байгуулсан гэрээний дагуу үүсэх үүргийг зохих ёсоор бүрэн гүйцэтгэх баталгаа болгож өөрийн өмчлөлийн хөдлөх хөрөнгийг үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжүүлэх, буцаан авахтай холбогдон үүссэн харилцааг зохицуулна.

5	Хөдөлмөрлөх харилцаа, хөдөлмөрийн үр дүнд тохирсон цалин хөлс олгох, хууль тогтоомж болон хамтын гэрээ, хэлэлцээрт заасан хөдөлмөрийн нөхцөлөөр хангах тухай харилцан үүрэг хүлээх харилцааг зохицуулна.	
6	Тээвэрлэлтийн гэрээ	"Шунхлай" ХХК-тай байгуулсан гэрээний дагуу тээвэрлэгч нь ачаа, тээшийг тогтоосон газарт хүргэх, нөгөө талаас ачаа, тээш эзэмшигч "Шунхлай" ХХК нь тээвэрлэлтийн үйлчилгээ үзүүлсний төлөө хэлэлцэн тохиролцсон хөлс төлөхөөр үүрэг хүлээсэн харилцааг зохицуулна.
7	Ажил гүйцэтгэх гэрээ	"Шунхлай" ХХК-тай байгуулсан гэрээний дагуу ажил гүйцэтгэгч гэрээнд заасан ажлыг хийж гүйцэтгэх, "Шунхлай" ХХК нь хариу төлбөрийг төлж барагдуулах харилцааг зохицуулна.

3.4.1.1. Худалдах, худалдан авах гэрээний тухайд:

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол бүхий гэрээний нэг төрөл нь худалдах, худалдан авах гэрээ байх бөгөөд тус гэрээгээр голчлон бүх төрлийн шатахуун, тос тосолгооны материал, аккумлятор худалдан борлуулдаг байна. Худалдах, худалдан авах гэрээний төслүүдээс харвал худалдагч "Шунхлай" ХХК нь өөрийн нийлүүлж буй бүтээгдэхүүнийг шууд болон зээлээр худалддаг төдийгүй мөнгөн талон, "шатахууны ₮ карт"-аар бүтээгдэхүүн нийлүүлдэг байна.

Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйлд худалдах, худалдан авах гэрээний харилцааг зохицуулсан байдаг бөгөөд тус хуулиар худалдагч нь биет байдлын доголдолгүй, эрхийн зөрчилгүй хөрөнгө, түүнтэй холбоотой баримт бичгийг худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх, худалдан авагч нь худалдагчид хэлэлцэн тохирсон үнийг төлж, худалдан авсан хөрөнгөө хүлээн авах үүргийг тус тус хүлээхээр зохицуулжээ.

"Шунхлай" ХХК-ийн худалдах, худалдан авах гэрээний төсөлд гэрээний гол зүйл болон түүний чанарын талаар заасан байх ба худалдагч нь гэрээгээр тогтсон газар, хаягт чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг тогтоосон хугацаанд нийлүүлэх, худалдан авагч төлбөрийг төлөх үүргийг тус тус хүлээж, гэрээгээр төлбөрийн журмыг талууд хэлэлцэн тохирохоор байна. Мөн талууд бүтээгдэхүүнийг хүлээлцэх үед худалдан авагч нь бүтээгдэхүүний бүрэн бүтэн байдал, чанарыг шалгаж хүлээн авах, бүтээгдэхүүнийг хүлээн авснаас хойш чанарыг худалдагч хариуцахгүй байхаар тус тус зохицуулжээ.

Мөн "Шунхлай" ХХК нь үйл ажиллагааг уян хатан байлгах зорилгоор тос тосолгооны материал, аккумляторыг зээлээр нийлүүлэх гол нөхцөл бүхий худалдах, худалдан авах гэрээг байгуулдаг байна. Иргэний хуулийн 261-264 дүгээр зүйлд зээлээр худалдах, худалдан авах гэрээний харилцааг зохицуулдаг. Тус зохицуулалтуудаар худалдагч нь худалдан авагчид үнийг төлөхөөс өмнө эд хөрөнгийг шилжүүлэх, худалдан авагч нь үнийг гэрээнд заасны дагуу тодорхой цаг хугацаанд хэсэгчлэн буюу бүрэн төлөх үүргийг тус тус хүлээхээр зохицуулжээ.

Иргэний хуулийн 263 дугаар зүйлийн 263.2 дахь хэсэгт бэлэн мөнгөөр төлөх төлбөрийн хэмжээ, хэсэгчлэн хийх төлбөрийн хэмжээ, хугацаа, төлбөл зохих хүүгийн хэмжээ, үнэ, эсхүл үнийг тодорхойлох журмыг гэрээнд заавал тусгахаар заажээ. Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК нь зээлээр худалдах, худалдан авах гэрээний 4.1-т "*Тос, тосолгооны материал, аккумлятор, тосны шүүр, шил цэвэрлэгч шингэний нэгжийн үнийг гэрээний Хавсралтад заасан үнэ тарифын дагуу үндэслэн тооцно*", 4.4-т "*Худалдан авагч тал Худалдагч талтай сар бүрийн 05-10-ны өдрийн хооронд тооцоо нийлж төлбөрт хугацаанд борлогдсон нийт барааны үнийн дүн, төлбөр, барааны*

үлдэгдлийг баталгаажуулан 15-ны дотор бүрэн төлж барагдуулна" зэргээр гэрээнд тусгаж Иргэний хуулийн 263 дугаар зүйлийн 263.2-т заасан шаардлагуудыг хангасан байна.

Дээрхээс дүгнэвэл үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн байгуулдаг худалдах, худалдан авах гэрээ нь Иргэний хуульд нийцэж байна.

3.4.1.2. Барьцааны гэрээний тухайд:

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК нь гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах зорилгоор үл хөдлөх эд хөрөнгө, хөдлөх хөрөнгө, эдийн бус хөрөнгө зэргийг барьцааны гэрээ байгуулах замаар барьцаалдаг байна. Энэхүү барьцааны эрхтэй холбоотой харицлааг Иргэний хуулийн арван гуравдугаар бүлгийн 153-160 дугаар зүйлээр зохицуулдаг. Ингэхдээ Иргэний хуулийн 153 дугаар зүйлийн 153.1-т "*Үүрэг гүйцэтгэгч барьцаагаар хангагдсан үүргийг хууль буюу гэрээнд заасны дагуу гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй бол барьцаалагч буюу үүрэг гүйцэтгүүлэгч нь бусад үүрэг гүйцэтгүүлэгчдээс тэргүүн ээлжид барьцааны зүйлийн үнээс шаардлагаа хангуулах эрхтэй*" хэмээн заажээ.

Барьцааны гэрээг бичгээр байгуулж буй нь Иргэний хуулийн 156 дугаар зүйлийн 156.1-т, гэрээний төслийн агуулга нь мөн зүйлийн 156.2-т "*Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээг, улсын бүртгэлд бүртгүүлэх бөгөөд гэрээнд талуудын нэр, оршин суугаа /оршин байгаа/ газар, барьцаагаар хангагдах шаардлага, түүний хэмжээ, үүргийг хангах хугацаа, барьцааны зүйл, түүний байгаа газар, үнийг заана*" гэж заасанд нийцэж байна.

Үл хөдлөх эд хөрөнгийн Барьцааны гэрээг улсын бүртгэлд бүртгүүлээгүй тохиолдолд хүчин төгөлдөр бус болохыг анхаарах шаардлагатай байна.

3.4.1.3. Фидуцийн гэрээний тухайд:

Иргэний хуулийн 235 дугаар зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх гэрээг зохицуулсан байдаг ба уг гэрээгээр үүрэг хүлээгч нь мөнгө төлөх үндсэн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор хөдлөх эд хөрөнгийг үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжүүлэх, үүрэг хүлээгч үндсэн үүргээ хугацаанд гүйцэтгэсэн тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч уг эд хөрөнгийг түүнд буцаан өгөх үүргийг тус тус хүлээдэг. Энэхүү гэрээг бичгээр байгуулж буй нь Иргэний хуулийн 235 дугаар зүйлийн 235.5 дахь хэсэгт заасанд нийцэж байх тул Үнэт цаас гаргагчийн үйлчлүүлэгчтэй байгуулдаг фидуцийн гэрээ нь Иргэний хуульд заасан гэрээний шаардлагыг хангаж байна гэж үзнэ.

3.4.1.4. Хөдөлмөрийн гэрээний тухайд:

Энэхүү хэсэгт "Шунхлай" ХХК-ийн байгуулдаг хөдөлмөрийн гэрээний төслүүдийг авч хянаж үзлээ.

Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-д хөдөлмөрийн гэрээнд дараах гол нөхцөлийг тусгана хэмээн заажээ. Үүнд:

1. ажлын байрны нэр, ажлын байрны тодорхойлолтод заасан гүйцэтгэх ажил үүрэг;

2. ажил үүрэг гүйцэтгэх байршил;

3. цалин хөлсний хэмжээ;

4. хөдөлмөрийн нөхцөл.

Үнэт цаас гаргагчийн ажилтантай байгуулдаг хөдөлмөрийн гэрээ нь хөдөлмөрийн гэрээнд заавал тусгах гол нөхцөлүүдийг тусгасан байна.

Гэрээний төслүүдийн хоёр дахь хэсэгт "талуудын эрх, үүрэг", гурав дахь хэсэгт "цалин хөлс, бусад нэмэгдэл", дөрөв дэх хэсэгт "ажил, амралтын цаг", тав дахь хэсэгт "хөдөлмөрийн гэрээ дуусгавар болох, цуцлах үндэслэл", зургаа дахь хэсэгт "эд хөрөнгийн хариуцлага", долоо дахь хэсэгт "хэд хэдэн ажил үүрэг зэрэг гүйцэтгэх үеийн зохицуулалт", ес дэх хэсэгт "нууц хадгалах үүрэг", арав дахь хэсэгт "өрсөлдөөнийг хязгаарлах", арван нэг дэх хэсэгт "бусад зүйл"-ийн талаар тус тус тусгасан нь ажилтны эрхийг дордуулсан, хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцээгүй байдал илрээгүй болно.

3.4.1.5. Тээвэрлэлтийн гэрээний тухайд:

Иргэний хуулийн 380 дугаар зүйлээр тээвэрлэгч нь зорчигч буюу ачаа, тээшийг тогтоосон газарт хүргэх, нөгөө талаас ачаа, тээш эзэмшигч, зорчигч буюу гуравдагч этгээд тээвэрлэлтийн үйлчилгээ үзүүлсний төлөө хэлэлцэн тохиролцсон хөлсийг өгөх үүргийг тус тус хүлээдэг. Энэхүү гэрээг бичгээр байгуулж буй нь Иргэний хуулийн 386 дугаар зүйлийн 386.1 дахь хэсэгт заасанд нийцэж байна.

Үнэт цаас гаргагчийн тээвэрлэгчтэй байгуулдаг "Газрын тосны бүтээгдэхүүн тээвэрлэх, тээвэрлүүлэх гэрээ"-нд Иргэний хуульд заасан Ачаа тээвэрлэлтийн гэрээний шаардлага болон бусад зохицуулалтад нийцээгүй байдал илрээгүй болно.

3.4.1.6. Ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээний тухайд

Иргэний хуулийн 343-358 дугаар зүйлд ажил гүйцэтгэх гэрээ, мөн хуулийн 359-368 дугаар зүйлээр хөлсөөр ажиллах гэрээтэй холбоотой харилцааг зохицуулсан байна.

Иргэний хуулийн 343 дугаар зүйлийн 343.1 дэх хэсэгт зааснаар ажил гүйцэтгэгч нь захиалагчийн буюу өөрийн материалаар гэрээнд заасан ажил гүйцэтгэх, захиалагч нь уг ажлын үр дүнг хүлээн авч, хэлэлцэн тохирсон хөлс төлөх үүргийг хүлээдэг байна.

Мөн Иргэний хуулийн 359 дүгээр зүйлийн 359.1 дэх хэсэгт зааснаар хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллагч нь тохиролцсон ажил, үйлчилгээг гүйцэтгэх, ажиллуулагч хөлс төлөх үүргийг тус тус хүлээнэ.

"Шунхлай" ХХК-ийн байгуулдаг ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээнд Иргэний хуульд заасны дагуу ажил гүйцэтгэх гэрээний хугацаа, гүйцэтгэх ажлын хөлс, хөлс төлөх хугацаа, гүйцэтгэгч болон захиалагчийн, ажиллуулагч, ажиллагчийн эрх, үүрэг, гэрээг цуцлах, дуусгавар болгох нөхцөлүүдийг бүрэн тусгасан нь хуульд нийцэж байна.

3.4.2. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх гэрээ, үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий сүүлийн 3 жилийн хугацаанд байгуулсан, хучин төгөлдөр үүрэг хүлээсэн гэрээ хэлцэл, тэдгээрийн хэрэгжилтийн талаарх дүгнэлт.

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн дүрэмд зааснаар компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 165,700,000 төгрөг байна. Үүнээс 8,285,000 төгрөгөөс

дээш үнийн дүн бүхий хэлцлийг хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий хэлцэл гэж үзнэ.

Иргүүлсэн баримтаас үзвэл сүүлийн 3 жилийн хугацаанд үнэт цаас гаргагч нь хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий 91 хэлцэл байгуулсан байх бөгөөд тэдгээрээс түүврийн арга ашиглан 35 гэрээг сонгон авч хууль зүйн дүгнэлт хийлээ. Үүнээс 15 хэлцэл нь "Шунхлай" ХХК-ийн борлуулалттай холбоотой гэрээ, 20 нь бараа, ажил үйлчилгээний худалдан авалттай холбоотой хэлцлүүд байна. Эдгээр нь үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол бүхий гэрээнүүд болно. Үүнд:

Хүснэгт №17. Сүүлийн 3 жилд "Шунхлай" ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий борлуулалттай холбоотой гэрээнүүд, тэдгээрийн хэрэгжилтийн мэдээлэл.

Гэрээлэгч талууд			Гэрээний огноо	Гэрээний нэр	Гэрээний үнийн дүн	Гэрээний хэрэгжилт
1.	"Шунхлай" ХХК	Иргэний нисэхийн ерөнхий газар /"Шунхлай Трейдинг" ХХК/	2024.03.25	Түншлэлийн гэрээ /Хамтран ДТ нийлүүлэх/	276,400,000₮	Хэрэгжиж дууссан
2.		"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ /Шунхлай Петролиум ХХК/	2024.05.16	Түншлэлийн гэрээ /Хамтран ДТ нийлүүлэх/	3,635,000,000₮	Хэрэгжиж дууссан
3.		"Автозамын засвар арчлалтын нэгтгэл" ТӨХК	2025.04.25	Шингэн битум нийлүүлэх АЗЗАНТӨХК/20250102003 дугаартай гэрээ	1,845,975,000	Хэрэгжиж байгаа
4.		"Автозамын засвар арчлалтын нэгтгэл" ТӨХК	2025.04.25	Өтгөн битум нийлүүлэх АЗЗАНТӨХК/20250102002 дугаартай гэрээ	2,763,600,000	Хэрэгжиж байгаа
5.		"Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ	2025.06.20	Худалдах, Худалдан авах гэрээ	52,938,622,458 төгрөг	Хэрэгжиж байгаа
6.		"Амбер" ХХК	2026.01.01	Үйлчилгээ үзүүлэх гэрээ	Ерөнхий гэрээ	Хэрэгжиж байгаа
7.		"Монголиан транс лайн" ХХК	2026.01.01	Тээвэрлэлтийн үйлчилгээний гэрээ	Ерөнхий гэрээ	Хэрэгжиж байгаа

8.		"Юбикаб Холдинг" ХХК	2026.01.06	Шатахуун худалдах, худалдан авах гэрээ	Ерөнхий гэрээ	Хэрэгжиж байгаа
9.		"Жава Вишн" ХХК	2026.01.26	Ажил, үйлчилгээ үзүүлэх гэрээ	Ерөнхий гэрээ	Хэрэгжиж байгаа
10.		Ю би петрогас	2026.01.26	Зураг төсөл боловсруулах гэрээ	4.785.000 төгрөг	Хэрэгжиж дууссан
11.		"Нэмүн бат" ХХК	2026.01.27	Ажил, үйлчилгээ үзүүлэх гэрээ	160.100.000 төгрөг	Хэрэгжиж байгаа
12.		"Бест шүүс" ХХК	2026.02.23	Худалдах. Худалдан авах гэрээ	34.260.000 төгрөг	Хэрэгжиж дууссан
13.		"Скай резорт" ХХК	2026.02.24	Үйлчилгээ үзүүлэх гэрээ	405.435.000 төгрөг	Хэрэгжиж дууссан
14.		Airbus helicopters china hk limited	2026.03.27	Purchase contract	65,000 euro	Хэрэгжиж байгаа
15.		"Грийт Эмпайр" ХХК	2026.03.16	Үйлчилгээ үзүүлэх гэрээ	Ерөнхий гэрээ	Хэрэгжиж байгаа

Хүснэгт №18. Сүүлийн 3 жилд "Шунхлай" ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий байгуулсан хэлцэл/худалдан авалт, бараа, ажил үйлчилгээтэй холбоотой гэрээ.

№	Гэрээлэгч талууд		Гэрээний огноо	Гэрээний нэр	Гэрээний үнийн дүн	Гэрээний хэрэгжилт
1.	" Шунхлай" ХХК	"Угтаал өгөөмөр" ХХК	2024.09.13	Ажил гүйцэтгэх гэрээ	160,000,000₮	Хэрэгжиж дууссан
2.		"Эс Ди инженеринг" ХХК	2024.09.04	Ажил гүйцэтгэх гэрээ	261,250,000₮	Хэрэгжиж дууссан
3.		"Угтаал өгөөмөр"ХХК	2024.08.13	Ажил гүйцэтгэх гэрээ	400,000,000₮	Хэрэгжиж дууссан
4.		"Ондилт" ХХК	2024.08.07	Ажил гүйцэтгэх гэрээ	152,121,000₮	Хэрэгжиж дууссан
5.		"Жой тройзон" ХХК	2024.07.18	Худалдах, худалдан авах гэрээ	126,373,611₮	Хэрэгжиж дууссан
6.		"Erenhot guangshunmingda colored steel structure" co.,LTD	2024.07.18	Худалдах, худалдан авах гэрээ	69,321.75 (юань)	Хэрэгжиж дууссан
7.		"АБОО" ХХК	2024.07.09	Ажил гүйцэтгэх гэрээ	8,261,880₮	Хэрэгжиж дууссан
8.		"Нью Телеком" ХХК	2024.06.25	Ажил гүйцэтгэх гэрээ	72,985,000₮	Хэрэгжиж дууссан
9.		"Ренержи ар и ти" ХХК	2024.06.17	Худалдах, худалдан авах гэрээ	10,082,100₮	Хэрэгжиж дууссан

10.		"Erenhot hongkunhe import and export trade" co.LTD general manager	2024.06.12	Худалдах, худалдан авах гэрээ	17,962.7 (юань)	Хэрэгжиж дууссан
11.		"Саммит компьютер" ХХК	2025.01.01	Хамтран ажиллах гэрээ	Ерөнхий гэрээ	Хэрэгжиж байгаа
12.		"Роснефть Монголия" ХХК	2026.01.12	Худалдах, худалдан авах гэрээ	723,840 usd	Хэрэгжиж дууссан
13.		"Чатбот" ХХК	2026.01.14	Үйлчилгээ үзүүлэх гэрээ	5,280,000 төгрөг	Хэрэгжиж дууссан
14.		Auctus Trading Limited HK	2026.01.22	Supply contract	1,180,000 usd	Хэрэгжиж байгаа
15.		"Гэрэл гранд хөгжил" ХХК	2026.01.27	Худалдах, худалдан авах гэрээ	38,794,000 төгрөг	Хэрэгжиж дууссан
16.		"Хьюндай моторс монголиа" ХХК	2026.03.10	Худалдах, худалдан авах гэрээ	150,000,000 төгрөг	Хэрэгжиж байгаа
17.		"Роснефть Монголия" ХХК	2026.04.02	Худалдах, худалдан авах гэрээ	7,050,000 usd	Хэрэгжиж дууссан
18.		"Оптимал Эн Макс" ХХК	2026.04.20	Ажил, үйлчилгээ үзүүлэх гэрээ	50,140,000 төгрөг	Хэрэгжиж байгаа
19.		"Ди Эс Жи" ХХК	2026.04.23	Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт гүйцэтгэх гэрээ	88,800,000 төгрөг	Хэрэгжиж байгаа
20.		"Роснефть Монголия" ХХК	2026.05.05	Худалдах, худалдан авах гэрээ	16,625,460 usd	Хэрэгжиж дууссан

Энэхүү дүгнэлт гаргахтай холбоотойгоор төрийн байгууллагаас авсан дараах лавлагаа тодорхойлолтын агуулгаас харахад эдгээр гэрээ, хэлцлүүд, тэдгээрийн хэрэгжилттэй холбоотой аливаа хугацаа хэтэрсэн өр төлбөр, бусад үүргийн зөрчилтэй холбоотой ямар нэгэн шаардах эрх үүсээгүй, эвлэрүүлэн зуучлах ажиллагаа эхлээгүй, шүүхэд болон арбитрт нэхэмжлэл, шаардлага гаргаагүй, иргэний хэрэг үүсээгүй,

шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаагүй, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй байна.

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2026 оны 08 сарын 19-ний өдрийн "Шүүхийн шийдвэрээр бусдад төлбөргүй эсэх тодорхойлолт (ААНБ)"-оор "*Регистрийн 2028468 дугаартай Шунхлай Хязгаарлагдмал хариуцлагатай компани нь шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд төлбөргүй болохыг тодорхойлов*" гэсэн.
2. Цагдаагийн ерөнхий газрын 2026 оны 08 сарын 19-ний өдрийн "Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт", мөн өдрийн "Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт"-оор эрүүгийн хариуцлага хүлээгээгүй болохыг тодорхойлсон.
3. Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрын 2026 оны 08 сарын 20-ны өдрийн 4/2633 тоот албан бичгээр "*...Шунхлай" ХХК /РД:2028468/ нь 2026 оны 08 сарын 20-ны өдрийн байдлаар нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцоогүй болно*" гэж тодорхойлсон.
4. Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн тусгай архиваас 2026 оны 08 сарын 19-ний өдрийн 05/4698 тоот албан бичгээр "Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн *9011068082 хувийн хэргийн дугаартай "Шунхлай" ХХК /РД:2028468/ нь сүүлийн 3 жилийн байдлаар Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүх, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүх, Дүүргийн Эрүү, Иргэний хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх, Багахангай, Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүх, Багануур дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн иргэний хэрэгт тус тус хариуцагчаар оролцож байгаагүй болохыг тодорхойлов*" гэсэн.
5. Зээлийн мэдээллийн сангаас 2026 оны 08 сарын 20-ны өдөр авсан 100000054307148 дугаартай "Хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх лавлагаа"-аар "Шунхлай" ХХК-ийн 77 ширхэг зээл, төлбөрүүд нь бүгд хэвийн ангилалтай бөгөөд чанаргүй зээл байхгүйг тодорхойлсон байна.

Дүгнэлт: Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн голлох үйл ажиллагаа нь бүх төрлийн шатахуун импортлох, шатахууны бөөний худалдаа, жижиглэнгийн худалдаа байх тул тус ач холбогдол үзүүлэх гэрээ нь борлуулалтын гэрээ, худалдах, худалдан авах гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ, хөдөлмөрийн гэрээнүүд байна.

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн бусадтай байгуулдаг Худалдах, худалдан авах гэрээ, Зээлээр худалдах, худалдан авах гэрээ, Барьцааны гэрээ, Фидуцийн гэрээ, Хөдөлмөрийн гэрээ, Тээвэрлэлтийн гэрээ, Ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээний төслүүдийн агуулга нь Иргэний хуульд заасан шаардлагыг хангасан, талуудын гэрээний чөлөөт байдалд үндэслэсэн бөгөөд хууль тогтоомжийн зөрчилтэй нөхцөл байдал илрээгүй болно.

Үнэт цаас гаргагч нь сүүлийн 3 жилийн хугацаанд хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий 91 гэрээг байгуулснаас түүврийн аргаар 35 сонгон авч хууль зүйн дүгнэлт хийлээ. Эдгээр гэрээ, хэлцлүүдэд

Иргэний хууль болон бусад хууль тогтоомж зөрчсөн нөхцөл байдал илрээгүй, хэрэгжилттэй холбоотой аливаа хугацаа хэтэрсэн өр төлбөр, бусад үүргийн зөрчилтэй холбоотой ямар нэгэн шаардах эрх үүсээгүй, эвлэрүүлэн зуучлах ажиллагаа эхлээгүй, шүүхэд болон арбитрт нэхэмжлэл, шаардлага гаргаагүй, иргэний хэрэг үүсээгүй, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаагүй, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй байна.

3.5 Сүүлийн 3 жилийн дотор хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх:

Хуулийн фирм нь үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-иас ирүүлсэн баримт бичиг, мэдээлэлд үндэслэн 2023 оны 8 дугаар сараас 2026 оны 8 сар хүртэлх сүүлийн гурван жилийн хугацаанд их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулсан эсэх, байгуулагдсан хэлцэл нь хууль тогтоомжийн дагуу хийгдсэн эсэхэд дүн шинжилгээ хийлээ.

3.5.1. Их хэмжээний хэлцлийн тухайд

КтХ-ийн 87 дугаар зүйлд "**их хэмжээний хэлцэл**" гэдэгт дараах хэлцлийг ойлгохоор хуульчилсан байдаг. **Үүнд:**

- Хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл (компанийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй);

- Компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт;

Их хэмжээний хэлцэл хийх шийдвэрийг КтХ-ийн 88 дугаар зүйлийн 88.1[50]-т зааснаар Төлөөлөн удирдах зөвлөл, байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал санал нэгтэйгээр гаргана.

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлангаас харвал санхүүгийн балансын дүн доорх хэмжээгээр байх бөгөөд уг дүнд хамаарах их хэмжээний хэлцэлд тооцогдох хэлцлийн үнийн дүнг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт №19. Их хэмжээний хэлцлийн босго дүн

№	Хамаарах хугацаа	Санхүүгийн балансын дүн /тогтоогоор/	Их хэмжээний хэлцлийн дүн /тогтоогоор /
1.	2022 оны санхүүгийн тайлан	338,099,677,000	84,524,919,250
2.	2023 оны санхүүгийн тайлан	434,574,427,000	108,643,606,750
3.	2024 оны санхүүгийн тайлан	396,426,936,000	99,106,734,000.00
4.	2025 оны санхүүгийн тайлан	439,990,657,500	109,997,664,375.00

[50] КтХ-ийн 88 дугаар зүйлийн 88.1 "Их хэмжээний хэлцэл хийх шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ санал нэгтэйгээр гаргана."

61	2026 оны хагас жилийнх санхүүгийн тайлан	647,661,894,478	161,915,473,619.50

"Шунхлай" ХХК нь сүүлийн 3 жил буюу 2023 оны 8 дугаар сараас 2026 оны 8 сар хүртэлх хугацаанд их хэмжээний хэлцэл хийгээгүй тухай 2026 оны 08 сарын 28-ны өдрийн В/1360 дугаартай албан бичгийг хуулийн фирмд ирүүлсэн болно.

3.6.1. Сонирхлын зөрчилтэй хэлцлийн тухайд:

КтХ-ийн 89 дүгээр зүйлд зааснаар Компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанитай дор дурдсан харилцаанд орж компанитай эсхүл түүний хараат болон охин компанитай хийж буй хэлцэл нь сонирхлын зөрчилтэй хэлцэлд хамаарна. Үүнд:

- Хэлцлийн нөгөө тал, эсхүл хэлцэлд төлөөлөгч эсхүл зуучлагчаар оролцож байгаа;
- Хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл уг хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл энгийн хувьцааны 20-оос дээш хувийг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;
- Хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн толгой компанийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл уг компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;
- Хэлцлийн үр дүнд шууд болон шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа;

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-аас сүүлийн 3 жил буюу 2023 оны 08 сараас 2026 оны 08 сарыг дуустал хугацаан нийт 62 ширхэг сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулсан байна.

Эдгээрээс "Шунхлай Холдинг" ХХК, "Капитал групп" ХХК, "Эс ди сервис" ХХК, "Эс системс" ХХК, "Зеро технологи" ХХК, "Эс Ди Инженеринг Энд Констракшн" ХХК, "Эн Ти Ви броадкастинг" ХХК, "Медиагрупп" ХХК, "Оранж эйр" ХХК, "Сантранс ложистик" ХХК, "Шунхлай трейдинг" ХХК, "Хьюндай моторс монгол" ХХК, "Апу дэйри" ХХК, "Апу трейдинг" ХХК нартай байгуулсан 30 ширхэг сонирхлын зөрчилтэй хэлцлийг түүврийн аргаар сонгон холбогдох гэрээ, ТУЗ-ийн тогтоолыг хүлээн авч танилцлаа.

"Шунхлай" ХХК-тай хэлцэл хийгч "Эс ди сервис" ХХК, "Эс системс" ХХК, "Зеро технологи" ХХК, "Эс Ди Инженеринг Энд Констракшн" ХХК, "Эн Ти Ви броадкастинг" ХХК, "Медиагрупп" ХХК, "Оранж эйр" ХХК, "Сантранс ложистик" ХХК, "Шунхлай трейдинг" ХХК, "Хьюндай моторс монгол" ХХК, "Апу дэйри" ХХК, "Апу трейдинг" ХХК нь "Шунхлай Холдинг" ХХК-ийн КтХ-ийн 6 дугаар зүйлийн 6.3[51]-т заасан охин

[51] КтХ-ийн 6 дугаар зүйлийн 6.3 "Компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 50-аас дээш хувийг оор /толгой/ компани дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшдэг бие даасан компанийг охин компани гэнэ."

компани тул үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн хувьд мөн хуулийн 6.14[52], 6.15[53]-т заасан компанийн нэгдэлд хамаарах зэргэлдээ компаниуд байна.

Харин "Капитал групп" ХХК-ийн 100 хувийн хувьцааг "Шунхлай холдинг" ХХК-ийн хувьцаа эзэмшигч, үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн ТУЗ-ийн дарга, эцсийн өмчлөгч П.Батсайхан эзэмшиж байна.

Тиймээс "Шунхлай" ХХК, "Шунхлай Холдинг" ХХК, "Капитал групп" ХХК, "Эс ди сервис" ХХК, "Эс системс" ХХК, "Зеро технологи" ХХК, "Эс Ди Инженеринг Энд Констракшн" ХХК, "Эн Ти Ви броадкастинг" ХХК, "Медиагрупп" ХХК, "Оранж эйр" ХХК, "Сантранс ложистик" ХХК, "Шунхлай трейдинг" ХХК, "Хьюндай моторс монгол" ХХК, "Апу дэйри" ХХК, "Апу трейдинг" ХХК-ууд нь КтХ-ийн 99 дүгээр зүйлийн 99.1.2[54], 99.1.8[55]-т заасан нэгдмэл сонирхолтой этгээд, мөн хуулийн 89 дүгээр зүйлийн 89.1[56], 89.1.2[57], 89.1.4[58]-т заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд гэж үзэхээр байна.

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн ирүүлсэн гэрээ хэлцэл, ТУЗ-ийн тогтоолоос үзвэл КтХ-ийн 92 дугаар зүйлийн 92.1[59]-т зааснаар сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамд нийцэж байна. Хуулийн фирмээс сүүлийн 3 жилийн хугацаанд хийсэн 62 хэлцлээс түүврийн аргаар 30 хэлцлийн баримт бичгийг хүлээн авч шалгасан нь дээрх байдлаар хуульд заасан журмын дагуу байгуулагдсан байна. Тиймээс үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 жилийн хугацаанд хийсэн 62 ширхэг хэлцлийг хуульд заасан журмын дагуу байгуулагдсан гэж үзлээ.

Хүснэгт №20. Сонирхлын зөрчилтэй хэлцлийн жагсаалт

№	Гэрээний нэр, дугаар	Гэрээний тал	Гэрээний агуулга	Гэрээ байгуулах тухай тогтоол	Гэрээний хэрэгжилт

[52] КтХ-ийн 6 дугаар зүйлийн 6.14 "Толгой компани, түүнтэй энэ хуулийн 6.1, 6.3, 6.8-д заасан хамаарал бүхий компаниуд, нэг этгээд дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран хувьцааных нь хяналтын багцыг эзэмшдэг, эсхүл компанийн удирдлагын шийдвэрийг нь тодорхойлох боломжтой компаниудыг компанийн нэгдэл гэнэ."

[53] КтХ-ийн 6 дугаар зүйлийн 6.15 "Толгой компани, түүнтэй энэ хуулийн 6.1, 6.3, 6.8-д заасан хамаарал бүхий компаниуд, нэг этгээд дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран хувьцааных нь хяналтын багцыг эзэмшдэг, эсхүл компанийн удирдлагын шийдвэрийг нь тодорхойлох боломжтой компаниудыг компанийн нэгдэл гэнэ."

[54] КтХ-ийн 99 дүгээр зүйлийн 99.1.2 "Толгой компани, түүнтэй энэ хуулийн 6.1, 6.3, 6.8-д заасан хамаарал бүхий компаниуд, нэг этгээд дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран хувьцааных нь хяналтын багцыг эзэмшдэг, эсхүл компанийн удирдлагын шийдвэрийг нь тодорхойлох боломжтой компаниудыг компанийн нэгдэл гэнэ."

[55] КтХ-ийн 99 дүгээр зүйлийн 99.1.8 "оороо, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь хувьцааны хяналтын багцыг нь эзэмшдэг болон эрх бүхий албан тушаалд ажилладаг компани, уг компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогч компани болон гэдгээрийн хувьцааны хяналтын багцыг эзэмшигч болон эрх бүхий албан тушаалтан"

[56] КтХ-ийн 89 дүгээр зүйлийн 89.1 "Компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь оорийн ажиллаж байгаа болон хувьцаанд нь эзэмшиж байгаа компанитай дор дурдсан харилцаанд орсон бол компанитай, эсхүл түүний хараат болон охин компанитай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тооцогдоно:"

[57] КтХ-ийн 89 дүгээр зүйлийн 89.1.2 "хэлцлийн ногоо тал болон оролцож байгаа, эсхүл уг хэлцэлд толоологч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл энгийн хувьцааны /ногдол хувийн/ 20-ооc дээш хувийг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;"

[58] КтХ-ийн 89 дүгээр зүйлийн 89.1.4 "хэлцлийн үр дүнд шууд буюу шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа."

[59] КтХ-ийн 92 дугаар зүйлийн 92.1 "Энэ хуулийн 89.1-д заасан этгээдийн оорийн ажиллаж байгаа болон хувьцааных нь хяналтын багцыг эзэмшиж байгаа компанитай хийж байгаа хэлцлийг сонирхлын зөрчилтэй хэлцэл гэх ба сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай шийдвэрийг уг хэлцлийг хийх талаар сонирхлын зөрчилгүй голоолон удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-ийн гишүүдийн олонхын саналаар гаргана."

1	**2024.01.02** Үл хөдлөх эд хөрөнгө түрээслэх, түрээслүүлэх гэрээ №20240002, В/32	"Капитал групп" ХХК /Зэргэлдээ компани/	Үл хөдлөх эд хөрөнгө түрээслэх, түрээслүүлэх	ТУЗ-ийн 2023.02.16-ны өдрийн В/02 дугаартай тогтоол	Хэвийн. Гэрээ хэрэгжиж дууссан.
2	**2024.02.15** Хөгжүүлэлтийн бэлтгэл үе шатны гэрээ №В/43	"Зеро технологи" ХХК /Зэргэлдээ компани/	Хэрэглэгчийн урамшууллын мобайл аппликейшн төслийн хүрээнд бүтээгдэхүүний шаардлага болон хөгжүүлэлтийн төлөвлөгөөг хийж гүйцэтгүүлэх		Хэвийн. Гэрээ хэрэгжиж дууссан..
3	**2024.04.03** Хөгжүүлэлтийн бэлтгэл үе шатны гэрээ №73	"Зеро технологи" ХХК /Зэргэлдээ компани/	Хэрэглэгчийн урамшууллын мобайл аппликейшн төслийн хүрээнд бүтээгдэхүүний шаардлага болон хөгжүүлэлтийн төлөвлөгөөг хийж гүйцэтгүүлэх		Хэвийн. Гэрээ хэрэгжиж дууссан.
4	**2024.04.11** Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх үйлчилгээ үзүүлэх гэрээ № В/077	"Эс системс" ХХК /Зэргэлдээ компани/	Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийлгэх, сайжруулах төлөвлөгөө, тайлан авах, зөвлөмжийн дагуу зассан эсэхээ шалгуулах		Хэвийн. Гэрээ хэрэгжиж дууссан.
5	**2024.08.01** Хөгжүүлэлтийн үндсэн гэрээ № В/529	"Зеро технологи" ХХК /Зэргэлдээ компани/	Хэрэглэгчийн урамшууллын мобайл аппликейшн төслийн хүрээнд бүтээгдэхүүний шаардлагын дагуу дизайн гаргуулах, мобайл аппликейшн болон админ панелын хөгжүүлэлт хийлгүүлэх		Хэвийн. Гэрээ хэрэгжиж дууссан.
6	**2024.09.04** Ажил гүйцэтгэх гэрээ В/566	"Эс Ди инженеринг Энд Констракшн" ХХК /зэргэлдээ компани/	ХУД, 19-р хороо, Ээрмэлийн гудамж 28/1 хаягт байрлах "Шунхлай Холдинг" ХХК-ийн төв оффис төслийн гадна шугам сүлжээ, угсралтын ажлыг гүйцэтгэх		Хэвийн. Гэрээ хэрэгжиж дууссан.
7	**2024.09.12** Хөгжүүлэлтийн үндсэн гэрээ №В/593	"Зеро технологи" ХХК /зэргэлдээ компани/	B2B буюу Харилцагчийн худалдан авалтын системийн хөгжүүлэлтийн		Хэвийн. Гэрээ хэрэгжиж дууссан.

300

2026.08.31

ШУНХЛАЙ ХХК 2026 оны 09 сар 10 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2026-09-02 БҮРТГЭВ-03

			ажлыг хийж гүйцэтгэх		
8	**2024.10.14** Ажил гүйцэтгэх гэрээ В/602	"Эн Ти Ви Броадкастинг" ХХК /зэргэлдээ компани/	"SP APES" сагсан бөмбөгийн багийн реклам сурталчилгаа, хийц, гүйцэтгэл, видеонд шаардагдах үйлчилгээ, гүрээслэх ажлыг захиалагчтай тохиролцож баталгаажуулсан өгүүлэмж, шийдэл, хугацааны дагуу эвлүүлэг, дуу, дүрс, өнгөний өндөр түвшинд бэлтгэх		Хэвийн. Гэрээ хэрэгжиж дуусан.
9	**2024.11.15** Хамтран ажиллах гэрээ В/630	"Эн Ти Ви Броадкастинг" ХХК /зэргэлдээ компани/	NTV болон ОРОН НУТАГ сувгаар дамжуулагдах МҮБХ-ны "Монгол бөхийн өргөө"-нд зохион байгуулдаг барилдаануудын шууд дамжуулалт болон давталтын цацалтын тайлбарыг хийж гүйцэтгэх ба үүнтэй холбогдон гарах талуудын хоорондын харилцаа болон төлбөр тооцоог тооцох аргачлал, талуудын эрх, үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлж, хамтран ажиллах		Хэвийн. Үүргийн аливаа зөрчил байхгүй. Гэрээ хэрэгжиж байгаа.
10	**2024.11.28** Ажил гүйцэтгэх гэрээ В/566	"Эс Ди Инженеринг Энд Констракшн" ХХК /зэргэлдээ компани/	ХУД, 19-р хороо, Ээрмэлийн гудамж, 28/1 хаягт байрлах "Шунхлай Холдинг" ХХК-ийн төв оффис теслийн "Гадна шугам сулжээ угсралтын ажил"-ыг гүйцэтгэх		Хэвийн. Гэрээ хэрэгжиж дуусан.
11	**2024.12.24** Хөгжүүлэлтийн үндсэн гэрээ В/529	"Зеро технологи" ХХК /зэргэлдээ компани/	"B2C буюу хэрэглэгчийн урамшуллын мобайл аппликейшн" теслийн хүрээнд бүтээгдэхүүний шаардлагын дагуу UX/UI дизайн гарган, мобайл аппликейшн болон админ панелын		Хэвийн. Гэрээ хэрэгжиж дуусан.

УЛААНБААТАР ХОТ ШУНХЛАЙ ХХК

Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital Delivering diversity 1119289111 Улаанбаатар хот

			хөгжүүлэлтыг хийж гүйцэтгэх		
12	**2025.01.02** Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ В/5	"Медиагрупп" ХХК /зэргэлдээ компани/	Олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлэх мэдээ, мэдээлэл, нийтлэл, нэвтрүүлэг, реклам, зар сурталчилгааны үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, шаардлагатай зөвлөх үйлчилгээг үзүүлэн ажиллах		Хэвийн. Үүргийн аливаа зөрчил байхгүй. Гэрээ хэрэгжиж байгаа
13	**2025.01.02** Үл хөдлөх эд хөрөнгө түрээслэх, түрээслүүлэх гэрээ В/16	"Капитал групп" ХХК	ХУД-ийн 2-р хороо, Чингисийн өргөн чөлөө-48/1 хаягт байрлах оффисийн зориулалттай барилгын 0 давхрын 90 м.кв, 1 давхрын 250 м.кв талбайтай хэсгийн 2-р давхрын 76.04 м.кв, 3-р давхрын 629 м.кв талбайтай хэсгийн, нийт 1,045.041 м.кв талбайтай хэсгийг түрээслүүлнэ.	ТУЗ-ийн 2025.02.26-ны өдрийн В/15 дугаартай тогтоол	Хэвийн. Үүргийн аливаа зөрчил байхгүй. Гэрээ хэрэгжиж байгаа
14	**2025.01.23** Нислэгт бэлэн байлгах гэрээ В/11	"Оранж эйр" ХХК /зэргэлдээ компани/	Airbus EC145 загварын нисдэг тэргийг нислэгийн бэлэн байдалд байлгахад зориулсан хүний нөөцийг бэлэн байлгах		Хэвийн. Гэрээ хэрэгжиж дуусан.
15	**2025.03.06** Програм хангамж нийлүүлэх гэрээ В/44	"Эс системс" ХХК /зэргэлдээ компани/	Гэрээний хавсралт №1-д заасан программ хангамжийн лицензийг холбогдох баримт бичгийн хамт Захиалагчид иж бүрнээр нь хүлээлгэн өгч ашиглалтад оруулах ажлыг акт үйлдэн хүлээлгэн өгч, өмчлөлд нь шилжүүлэх		Хэвийн. Гэрээ хэрэгжиж дуусан.
16	**2025.05.13** Худалдах, худалдан авах ерөнхий гэрээ ХХК В/108	"Оранж эйр" ХХК /зэргэлдээ компани/	Худалдан авагчийн захиалсан Airbus H145 D3 MSN:21488 загварын нисдэг тэрэгний сэлбэг, хэрэгсэл, тоног төхөөрөмжүүдийг		Хэвийн. Үүргийн аливаа зөрчил байхгүй. Гэрээ хэрэгжиж байгаа

			Худалдан авагчийн хэрэгцээ шаардлагад үндэслэн Худалдан авагчид тогтмол нийлүүлэх		
17	**2026.08.06** "Дэмжлэг үйлчилгээний ерөнхий гэрээ" В/0251	"Зеро технологи" ХХК /зэргэлдээ компани/	Гүйцэтгэгч "Зеро технологи" ХХК нь захиалагчийн хэрэглэж буй программ гарсан алдаа, доголдыг засварлах, програмын хөгжүүлэлтийг өөрчлөх, шинэ хөгжүүлэлт хийх, программ жижиг засвар оруулах, сайжруулалт хийж захиалагчийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	ТУЗ-ийн 2026.03.03-ны өдрийн В/02 дугаартай тогтоол	Хэвийн. Үүргийн аливаа зөрчил байхгүй. Гэрээ хэрэгжиж байгаа.
18	**2026.08.06** "Байгууллагын ашиглалт үйлчилгээний гэрээ" В/0252	"Зеро технологи" ХХК /зэргэлдээ компани/	Үйлчилгээ үзүүлэгч "Зеро технологи" ХХК нь хэрэглэгчийн системийн тасалдалгүй хэвийн үйл ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийх		Хэвийн. Үүргийн аливаа зөрчил байхгүй. Гэрээ хэрэгжиж байгаа.
19	**2026.08.06** "Байгууллагын ашиглалт үйлчилгээний гэрээ" В/253	"Зеро технологи" ХХК /зэргэлдээ компани/	Үйлчилгээ үзүүлэгч "Зеро технологи" ХХК нь хэрэглэгчийн системийн тасалдалгүй хэвийн үйл ажиллагааг хангах, засвар үйлчилгээ хийх		Хэвийн. Үүргийн аливаа зөрчил байхгүй. Гэрээ хэрэгжиж байгаа.
20	**2026.08.06** "Дэмжлэг үйлчилгээний ерөнхий гэрээ" В/250	"Зеро технологи" ХХК /зэргэлдээ компани/	Гүйцэтгэгч "Зеро технологи" ХХК нь захиалагчийн хэрэглэж буй программ гарсан алдаа, доголдыг засварлах, програмын хөгжүүлэлтийг өөрчлөх, шинэ хөгжүүлэлт хийх, программ жижиг засвар оруулах, сайжруулалт хийж захиалагчийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх		Хэвийн. Үүргийн аливаа зөрчил байхгүй. Гэрээ хэрэгжиж байгаа.
21	**2026.08.10** "Тээвэр зуучийн гэрээ"	"Сантранс ложистик" ХХК /Зэргэлдээ компани/	Зуучлагч "Сантранс ложистикс" ХХК нь үйлчлүүлэгчид		Хэвийн. Үүргийн аливаа зөрчил байхгүй. Гэрээ

	B/245		тээвэр зуучлалын үйлчилгээ үзүүлэх		хэрэгжиж байгаа.
22	**2026.01.01** "Зэргэлдээ компаниудын менежментийн бодлого, үйл ажиллагаанд баримтлах гэрээ" B/0218	"Шунхлай трейдинг" ХХК /Зэргэлдээ компани/	Гэрээгээр "Шунхлай холдинг" ХХК-ийн охин компаниудын менежмент, үйл ажиллагаа, зохион байгуулалтыг тодорхойлох		Хэвийн. Үүргийн аливаа зөрчил байхгүй. Гэрээ хэрэгжиж байгаа.
23	**2026.06.22** "Нислэг, техникийн хамтын ажиллагааны гэрээ" B/190	"Оранж эйр" ХХК /зэргэлдээ компани/	Оператор "Оранж эйр" ХХК нь нисдэг тэрэгний үйлчилгээ үзүүлэх		Хэвийн. Үүргийн аливаа зөрчил байхгүй. Гэрээ хэрэгжиж байгаа.
24	**2026.05.22** "Хөгжүүлэлтийн үндсэн гэрээ B/157	"Зеро технологи" ХХК /зэргэлдээ компани/	Гүйцэтгэгч "Зеро технологи" ХХК нь систем хөгжүүлэлтийг ажил гүйцэтгэх		Хэвийн. Үүргийн аливаа зөрчил байхгүй. Гэрээ хэрэгжиж байгаа.
25	**2026.04.07** "Ажил үйлчилгээ үзүүлэх гэрээ" B/96	"Оранж эйр" ХХК /зэргэлдээ компани/	Оператор "Оранж эйр" ХХК нь нисдэг тэрэгний үйлчилгээ үзүүлэх		Хэвийн. Үүргийн аливаа зөрчил байхгүй. Гэрээ хэрэгжиж байгаа.
26	**2026.04.07** "Худалдах, худалдан авах гэрээ" B/95	"Оранж эйр" ХХК /зэргэлдээ компани/	"Оранж эйр" ХХК нь нисдэг тэрэгний сэлбэг нийлүүлэх		Үүргийн аливаа зөрчил байхгүй. Гэрээ хэрэгжиж дууссан.
27	**2026.03.09** "Худалдах, худалдан авах гэрээ" B/67	"Хьюндай моторс монгол" ХХК /зэргэлдээ компани/	Бараа худалдах, худалдан авах		Үүргийн аливаа зөрчил байхгүй. Гэрээ хэрэгжиж дууссан.
28	**2026.01.30** "Худалдах, худалдан авах гэрээ" B/37	"Апу дэйри" ХХК /зэргэлдээ компани/	Бүтээгдэхүүн худалдах, худалдан авах		Хэвийн. Үүргийн аливаа зөрчил байхгүй. Гэрээ хэрэгжиж байгаа.
29	**2026.01.30** Худалдах, худалдан авах гэрээ B/38	"Апу трейдинг" ХХК /зэргэлдээ компани/	Бүтээгдэхүүн худалдах, худалдан авах		Хэвийн. Үүргийн аливаа зөрчил байхгүй. Гэрээ хэрэгжиж байгаа.
30	**2026.01.02** "Захиалгат хүний нөөц бэлтгэх гэрээ"	"Оранж эйр" ХХК /зэргэлдээ компани	Нисдэг тэрэгний үйл ажиллагааг зохион байгуулахад	ТУЗ-ийн 2026.03.03-ны өдрийн B/02	Хэвийн. Үүргийн аливаа зөрчил байхгүй. Гэрээ

	B/65		шаардлагатай хүний нөөц бэлтгэх	дугаартай тогтоол	хэрэгжиж байгаа

Дүгнэлт: "Шунхлай" ХХК нь сүүлийн 3 жил буюу 2023 оны 08 дугаар сараас 2026 оны 08 дугаар сар хүртэлх хугацаанд их хэмжээний хэлцэл байгуулаагүй, 62 сонирхлын зөрчилтэй хэлцлийг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу байгуулсан байна.

3.6 Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин тогтолдор эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл буй эсэх:

3.6.1. <u>Үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухайд</u>

Монгол Улсад газрын тосны бүтээгдэхүүнийг импортлох, үйлдвэрлэх, худалдах, тээвэрлэх, хадгалах болон эдгээр үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангахтай холбоотой үүсэх харилцааг Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль болон Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулдаг.

Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.2 дахь хэсэгт "*газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл, бүх төрлийн шатахууныг импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох бүрэн эрхийг Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ*" хэмээн заасны дагуу бүх төрлийн шатахуун импортлох тусгай зөвшөөрлийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас олгохоор байна.

Зөвшөөрлийн цахим систем болох <u>www.license.mn</u> цахим хуудаст байршсан нээлттэй мэдээллийн сан, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн нээлттэй мэдээлэл <u>www.opendatalab.mn</u> цахим хуудас, үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээлэл, баримтууд, холбогдох гэрчилгээ, лавлагаа, тодорхойлолтоос үзвэл дараах тусгай зөвшөөрлийг эзэмшиж байна. Үүнд:

- Бүх төрлийн шатахуун импортлох тусгай зөвшөөрөл /2019.12.24-2030.12.24/
- Бүх төрлийн шатахууны бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл /2022.07.20-2030.07.20/
- 4-35кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ /2025.08.25- 2030.08.25/
- 220 кВ болон түүнээс дээш хүчдэлтэй цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх /2025.05.27-2030.05.27/,
- 100 МВт-аас дээш эрчим хүчний эх үүсвэр барих, угсрах, засварлах, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ барих /2025.05.27-2030.05.27/

Зөвшөөрлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 7.1.1 дэх хэсэгт "*Энэ хуульд заасан зөвшөөрөл хүссэн болон сунгуулах өргөдлийг хүлээн авах, өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг магадлан шалгах, шийдвэр гаргах үйл ажиллагааны явц болон зөвшөөрөл олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон шийдвэрийн талаарх мэдээллийг агуулсан зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан /цаашид*

"зөвшөөрлийн нэгдсэн сан" гэх/-тай байх бөгөөд уг сан нь цахим хэлбэртэй байна" хэмээн заасны дагуу зөвшөөрлийн нэгдсэн сан буюу www.license.mn цахим санд зөвшөөрлийн мэдээлэл нээлттэй байрлаж байна. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 07 сарын 05-ны өдрийн 251 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "*Зөвшөөрлийн нэгдсэн сангийн мэдээлэл, түүнийг бүрдүүлэх, уг санд зөвшөөрлийг бүртгэх, лавлагаа, мэдээлэл өгөх журам*"-ын 4.1-т "*Зөвшөөрлийн нэгдсэн сангаас олгох лавлагаа, мэдээлэл нь QR кодоор баталгаажсан байна*" гэжээ.

Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн тусгай зөвшөөрлийн тодорхойлолтууд нь тус тус дээрх журмын QR кодоор баталгаажсан байна. Иймд тусгай зөвшөөрөл нь хүчинтэй бөгөөд тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл байдал илрээгүй болно.

3.6.2. Оюуны өмчийн эрхийн тухайд

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК нь Улсын бүртгэлийн 40-0028092, Мэдүүлгийн бүртгэлийн 40-2023-0032777 дугаартай "ORANGE" гэх бичвэр бүхий барааны тэмдгийн гэрчилгээг эзэмшиж байх бөгөөд гэрчилгээнд "*Монгол Улсын Оюуны өмчийн газрын даргын 2023 оны 10 сарын 03-ны өдрийн А/122 тоот тушаалаар барааны тэмдгийг эзэмших онцгой эрхийг зөвшөөрч гэрчилгээ олгов*" гээд хүчинтэй хугацааг 2033 оны 02 сарын 16-ны өдөр гэсэн байна.

Энэхүү барааны тэмдэг нь Оюуны өмчийн газрын www.ipom.mn.publish.wipo.net барааны тэмдгийн мэдээллийн санд хүчинтэй харагдаж байна.

Иймд барааны тэмдэг эзэмших эрх нь хүчинтэй бөгөөд хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл байдал байхгүй байна.

Мөн үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК нь 2025 оны 10 сарын 13-ны өдрийн В/1731 тоот албан бичгээр ямар нэгэн зохиогчийн эрх, лиценз, патент эзэмшдэггүй тухай илэрхийлсэн байна.

Иймд, үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-г лиценз, зохиогчийн эрх, патент эзэмшдэггүй гэж үзнэ.

Дүгнэлт: Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК нь Бүх төрлийн шатахуун импортлох тусгай зөвшөөрөл /2019.12.24-2030.12.24/, Бүх төрлийн шатахууны бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл /2022.07.20-2030.07.20/, 4-35кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ /2025.08.25 - 2030.08.25/, 220 кВ болон түүнээс дээш хүчдэлтэй цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ эрхлэх /2025.05.27 - 2030.05.27/, 100 МВт-аас дээш эрчим хүчний эх үүсвэр барих, угсрах, засварлах, түүний туршилт тохируулга, дагалдах ажил, үйлчилгээ барих /2025.05.27 - 2030.05.27/ тусгай зөвшөөрлүүдийг эзэмшдэг нь хүчин төгөлдөр байх бөгөөд хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл байдал илрээгүй болно.

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК нь Улсын бүртгэлийн 40-0028092, Мэдүүлгийн бүртгэлийн 40-2023-0032777 дугаартай "ORANGE" гэх бичвэр бүхий барааны тэмдгийн онцгой эрхтэй байна. Тус барааны тэмдгийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл байдал байхгүй болно. Мөн үнэт цаас гаргагч нь өөрийн ирүүлсэн албан бичгээр дүгнэлт гаргах үсийн байдлаар лиценз, зохиогчийн эрх, патент эзэмшдэггүй болно.

3.7. Үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө омчлох эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн эсэх:

3.7.1. Үл хөдлөх эд хөрөнгө омчлох эрхийн тухай:

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК нь 20 ширхэг үл хөдлөх хөрөнгийг өмчилдөг болох нь "Шунхлай" ХХК-ийн 2026.08.21-ний өдрөөс 2026.08.24-ний өдрийн хооронд авсан Улсын бүртгэлийн ерөнхий газрын Үл хөдлөх хөрөнгийн лавлагаа, Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ тус бүрээр тогтоогдож байна.

Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан улсын бүртгэлийн ерөнхий газраас авсан үл хөдлөх хөрөнгө тус бүрийн "Үл хөдлөх хөрөнгийн лавлагаа"-наас "Шунхлай" ХХК-ийн хөрөнгүүд дараах байдлаар барьцааны болон холбогдох гэрээ, хэлцлүүдийн дагуу барьцаалсан болох нь харагдаж байна.

Хуулийн фирмээс холбогдох барьцааны гэрээнүүдийг хүлээн авч танилцан лавлагааны мэдээлэлтэй тулган үзсэн болно.

Хүснэгт №21. Өмчлөлд бүй үл хөдлөх эд хөрөнгө, түүнд барьцааны эрх үүссэн эсэх талаарх мэдээлэл.

№	Улсын бүртгэлийн дугаар, Хөрөнгийн төрөл	Хаяг байршил	Зориулалт	Хэмжээ /м²/	Өмчлөгчөөр бүртгүүлсэн огноо	Барьцааны эрх үүссэн эсэх, үүссэн хугацаа
1.	Y-1411000043	Төв Борнуур сум 4-р баг, Нарт	Шатахуун түгээх станц	15	2006.03.15	Тийм Худалдаа хөгжлийн банк 2019.11.25
2.	Y-2003009001	Дархан-Уул, Дархан сум, 4-р баг	Шатахуун түгээх станц	1500	2002.10.23	Тийм Худалдаа хөгжлийн банк 2025.03.31
3.	Y-2202009161	Улаанбаатар Чингэлтэй дүүрэг 19-р хороо, санзай зам шгс-48 тоот	Шатахуун түгээх станц	118	2004.12.24	Тийм Худалдаа хөгжлийн банк 2025.06.10

4.	Y-2204009619	Улаанбаатар Баянзүрх дүүрэг 14-р хороо Нарны зам гудамж, 271/3 тоот	Шатахуун түгээх станц	42	2000.12.25	Тийм Худалдаа хөгжлийн банк 2025.06.10
5.	Y-2204010980	Улаанбаатар Баянзүрх дүүрэг 6-р хороо Нарны зам гудамж, 292/1 тоот	Шатахуун түгээх станц	100	2002.10.23	Тийм Хаан банк 2025.04.01
6.	Y-1806000014	Хэнтий Жаргалтхаан сум 5-р баг, Төвийн	Шатахуун түгээх станц	160	2006.11.20	Тийм Худалдаа хөгжлийн банк 2025.03.19
7.	Y-2204015636	Улаанбаатар Баянзүрх дүүрэг 1-р хороо эрэл сургуулийн байр, эрэл сургуулийн хойд талд байрлалтай тоот	Шатахуун түгээх станц	20.16	2004.12.23	Тийм Худалдаа хөгжлийн банк 2025.07.30
8.	Y-2204023009	Улаанбаатар Баянзүрх дүүрэг 11-р хороо Товчоо 0 гудамж, штс-184 тоот	Шатахуун түгээх станц	28.7	2008.05.16	Тийм Худалдаа хөгжлийн банк 2025.06.04
9.	Y-2003010798	Дархан-Уул Дархан сум 15-р баг	Шатахуун түгээх станц	24	2005.01.14	Тийм Худалдаа хөгжлийн банк 2025.03.31
10.	Y-1018000824	Өвөрхангай Арвайхээр сум 5-р баг, Арвайхээр	Шатахуун түгээх станц	220	2002.10.25	Тийм Худалдаа хөгжлийн банк 2025.03.19
11.	Y-0814000935	Дундговь Сайнцагаан сум 7-р баг, Нарлаг	Шатахуун түгээх станц	2000	2008.03.03	Тийм 2025.03.26 Худалдаа хөгжлийн банк
12.	Y-0713001943	Дорноговь Сайншанд сум 3-	Шатахуун түгээх станц	1800	2004.12.27	Тийм

		р баг залуучуудын гудамж тоот				2025.04.25 Худалдаа хөгжлийн банк
13.	Y-0713002529	Дорноговь Сайншанд сум 4-р баг тоот	Агуулахын	6000	2006.03.13	Тийм Худалдаа хөгжлийн банк 2025.04.25
14.	Y-1315000142	Сэлэнгэ Цагааннуур сум 3-р баг, Тийрэг, тоот	Үйлчилгээ	32	2006.12.11	Тийм Худалдаа хөгжлийн банк 2025.04.23
15.	Y-0518001907	Говь-Алтай Есөнбулаг сум 1-р баг, Баянхайрхан	Шатахуун түгээх станц	1984.5	2011.12.01	Тийм Худалдаа хөгжлийн банк 2025.04.23
16.	Y-1017000244	Өвөрхангай Хархорин сум 2-р баг, Ганган-Орхон 1 байр, 0 тоот	Шатахуун түгээх станц	56	2002.06.28	Тийм Худалдаа хөгжлийн банк 2025.03.19
17.	Y-2206100593	Улаанбаатар Хан-Уул дүүрэг 19-р хороо Үйлдвэр /17042/ Ээрмэл гудамж, 28/1 тоот	Үйлдвэрлэл-Үйлчилгээний	3600	2025.06.18	Үгүй
18.	Y-2206090874	Улаанбаатар Хан-Уул дүүрэг 19-р хороо Үйлдвэр /17042Ээрмэл/ гудамж, 28/2 тоот	Контор, үйлчилгээний	3723.1	2025.06.18	Тийм Худалдаа хөгжлийн банк 2026.04.29
19.	Y-2201070793	Улаанбаатар Сонгинохайрхан дүүрэг 19-р хороо 21 хороолол 18081 Үйлдвэрчний эвлэлийн гудамж	Орон сууцны	36.76	2026.05.26	Үгүй

		90 в байр, 134 тоот				
20.	Y-2206108285	Улаанбаатар Хан-Уул дүүрэг 20-р хороо Үйлдвэр /17042/ Чингисийн өргөн чөлөө гудамж 45в байр, 61 тоот	Орон сууцны	69	2026.05.26	Үгүй

Түүнчлэн өөр бусад байдлаар үнэт цаас гаргагчийн үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийг үгүйсгэсэн аливаа баримт, мэдээлэл ирээгүй болно.

Дээрх байдлаар үнэт цаас гаргагчийн хүчин төгөлдөр өмчлөх эрх бүхий гэж үзсэн гурван үл хөдлөх хөрөнгөөс 17 нь Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1[60]-т зааснаар арилжааны банканд барьцааны эрх үүссэн боловч дүгнэлт хийх үед тэдгээртэй байгуулсан гэрээ болон хуульд заасан үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс хангуулах тохиолдол[61] үүсээгүй болох нь үнэт цаас гаргагчийн ирүүлсэн мэдээллүүд, хугацаа хэтэрсэн өр төлбөргүй, зээлийн ангилал хэвийн байгаа тухай лавлагаагаар[62] нотлогдож байна. Харин "Шунхлай" ХХК-ийн өмчлөлийн Y-2206100593, Y-2201070793, Y-2206108285 тоот бүртгэлийн дугаартай хөрөнгө нь аливаа гэрээ, хэлцлийн үүргийн гүйцэтгэлийг хангах арга хэрэгсэл болоогүй байна.

3.7.2. Эд хөрөнгө өмчлох эрхийн тухай:

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-иас хөдлөх хөрөнгө барьцаалж буй гэрээний мэдээллүүдийг ирүүлсэн.

Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн дээрх барьцааны гэрээний мэдээлэл нь олон нийтэд нээлттэй байрлах мэдээллийн сан буюу Улсын бүртгэлийн ерөнхий газрын цахим мэдээллийн сан (www.mpr.gov.mn)-д байрласан мэдээлэлтэй тохирч байна.

Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1[63]-т зааснаар хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцаа нь хуульд зааснаар, эсхүл барьцаалагч, барьцаалуулагчийн хооронд байгуулсан гэрээний үндсэн дээр үүсэж, мөн хуулийн 11 дүгээр зүйлд[64] зааснаар баталгааждаг. Баталгаажилт гэдэг нь мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1[65]-т зааснаар барьцааны эрх гуравдагч

[60] Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 "Барьцаа нь хуульд заасан үндэслэлээр, эсхүл барьцаалагч, барьцаалуулагчийн хооронд байгуулсан гэрээний дагуу үүсэн."

[61] Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн Наймдугаар бүлэг "Үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс хангуулах"

[62] Үнэт цаас гаргагчийн 2025.10.10-ны өдөр авсан 100000040769013 дугаартай "Хугацаа хэтэрсэн зээлийн ортэй эсэх лавлагаа"

[63] Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 "Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцаа нь хуульд зааснаар, эсхүл барьцаалагч, барьцаалуулагчийн хооронд байгуулсан гэрээний үндсэн дээр үүсэж."

[64] Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 11 дүгээр зүйл "11.1.Барьцааны гэрээнд барьцааны зүйлийг барьцаалагчийн эзэмшилд шилжүүлэхээр заасан бол барьцааны зүйлийг барьцаалагчийн буюу түүний итгэмжилсэн төлөөлөгчийн эзэмшилд шилжүүлснээр барьцаа баталгаажна. 11.2. Барьцааны зүйлийг барьцаалагчийн эзэмшилд шилжүүлээгүй бол энэ хуульд заасны дагуу барьцааны мэдэгдлийг цахим мэдээллийн санд бүртгүүлснээр барьцаа баталгаажна. 11.3. Хуульд зааснаар үүссэн барьцаа нь барьцааны мэдэгдлийг цахим мэдээллийн санд бүртгүүлсэнээр баталгаажна. 11.4. Баталгаажсан барьцааны эрхийг бусдад шилжүүлсэн нь барьцааны баталгаажилтыг дуусгавар болгох, эсхүл тухайн барьцааны эрхийн дараалыг оорчлох үндэслэл болохгүй. 11.5. Барьцааны эрх нь өөр хэлбэрээр тасалдалгүй баталгаажсан бол анх баталгаажсан үеэс баталгаажсанд тооцно."

[65] Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 ""баталгаажилт" гэж барьцааны эрх гуравдагч этгээдийн өмнө хүчин төгөлдөр байх, барьцааны зүйлээс шаардлагаа хангуулах барьцаалагчийн эрхийн дараалыг баталгаажуулсныг;"

ШУНХЛАЙ ХХК
2025 оны 08 сарын 1 өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2025 -09- 02
БҮРТГЭВ-03

этгээдийн омнө хүчин төгөлдөр байх, барьцааны зүйлээс шаардлагаа хангуулах барьцаалагчийн эрхийн дараалыг баталгаажуулсныг ойлгоно.

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК болон банк хооронд барьцааны гэрээ байгуулагдаж, баталгаажсан, гэрээг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлсэн байх тул Хөдлөх болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1[66], 35 дугаар зүйлийн 35.1[67], 37 дугаар зүйлийн 37.1[68]-т зааснаар Улсын бүртгэлийн ерөнхий газрын цахим мэдээллийн сан дахь мэдээлэл нь үнэн, зөв байна.

Хуулийн дүгнэлт гарах үеийн байдлаар Улсын бүртгэлийн ерөнхий газрын (www.mpr.gov.mn)-д цахим мэдээллийн сангаас үнэт цаас гаргагчийн регистрийн дугаараар хайлт хийж үзэхэд дараах илэрц гарч ирсэн болно. Үүнд:

Хүснэгт №22. Барьцааны мэдэгдлийн бүртгэлийн мэдээлэл

№	Барьцааны бүртгэлийн дугаар	Эхлэх огноо	Дуусах огноо	Төлөв	Барьцаа-лагч	Барьцаа-луулагч	Барьцаа хөрөнгө
1	1100598414	2025-06-27	2026-12-27	хэвийн	Ти Ди Би Секьюритис ҮЦК ХХК	1.Шунхлай ХХК	Харилцах данс
2	1100711961	2026-08-24	2029-08-24	хэвийн	Голомт банк	1.Шунхлай ХХК; 2. Шунхлай петролиум ХХК; 3. Шунхлай говь ХХК; 4. Шунхлай трейдинг ХХК;	ШУНХЛАЙ ХХК-ИЙН ШАТАХУУН-А-80,АИ-92, ДТ, АИ-95, БУСАД /ОНГОЦНЫ ТҮЛШ ГЭХ МЭТ/; ШУНХЛАЙ ГОВЬ ХХК-ИЙН ЭНЕРЖИ РЕСУРС ХХК, ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ ХК, ДАРХАН ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР ТӨХК, ТАВАН ТОЛГОЙН ТӨМӨР ЗАМ ХХК, БУСАД БАЙГУУЛЛАГАА С АВАХ АВЛАГА; ШУНХЛАЙ ПЕТРОЛИУМ ХХК-ИЙН ЭНЕРЖИ РЕСУРС ХХК, ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ ХК, ДАРХАН

[66] Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 "Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийг бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /цаашид "бүртгэлийн байгууллага" гэх/ энэ хуульд заасан журмын дагуу цахим мэдээллийн санд бүртгэж бүртгэлийн дугаар олгоно."

[67] Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 "Бүртгэлийн байгууллага нь хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийг бүртгэх цахим мэдээллийн сан /цаашид "цахим мэдээллийн сан" гэх/-тай байна."

[68] Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 "Цахим мэдээллийн сан нь барьцааны талаар мэдээлэл авах, хайлт хийхэд олон нийтэд нээлттэй байна."

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
ТТД 9531 ☎ 2028488

311

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering Diversity
Улаанбаатар хот

2026.08.31

							ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР ТӨХК, ТАВАН ТОЛГОЙН ТӨМӨР ЗАМ ХХК, БУСАД БАЙГУУЛЛАГАА С АВАХ АВЛАГА; ШУНХЛАЙ ХХК-ийн МОНГОЛРОСЦВЕТМЕТ ХХК, БАГАНУУР ХК, САУС ГОБИ СЭНДС ХХК, МАКС ГҮҮР ТРАНС ХХК, ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР, БУСАД БАЙГУУЛЛАГАА С АВАХ АВЛАГА; ШУНХЛАЙ ХХК-ийн ШУНХЛАЙ ТРЕЙДИНГ ХХК, ШУНХЛАЙ ГОВЬ ХХК, ШУНХЛАЙ ПЕТРОЛИУМ ХХК, ЭС ЖИ ШИВЭЭ ХҮРЭН ДЕПО ХХК, ЭС ЖИ ХАНГИ ГЭЙТ ХХК, ШУНХЛАЙ ОЙЛ ХХК, УБТЗ, БУСАД БАЙГУУЛЛАГАА С АВАХ АВЛАГА; ШУНХЛАЙ ГОВЬ ХХК-ИЙН ШАТАХУУН-А-80,АИ-92, ДТ, АИ-95, БУСАД /ОНГОЦНЫ ТҮЛШ ГЭХ МЭТ/; ШУНХЛАЙ ПЕТРОИУМ ХХК-ИЙН ШАТАХУУН-А-80,АИ-92, ДТ, АИ-95, БУСАД /ОНГОЦНЫ ТҮЛШ ГЭХ МЭТ/; ШУНХЛАЙТРЕЙДИНГ ХХК-ИЙН ШАТАХУУН-А-80,АИ-92, ДТ, АИ-95, БУСАД

							/ОНГОЦНЫ ТҮЛШ ГЭХ МЭТ/
3	1100485425	2024-12-11	2026-12-11	хэвийн	Худалдаа хөгжлийн банк	1. Шунхлай ХХК	Шунхлай ХХК-ийн Ирээдүйд дансаар болон борлуулалтаас орж ирэх мөнгөн хөрөнгө бүх төрлийн авлага; Шунхлай ХХК-ийн агуулахад болон замд яваа бүх төрлийн шатах тослох материал, тэдгээрийн үлдэгдэл -г 2024/12/03-ний №ЗЭНГ/СС240614003-29-1 тоот Зээлийн эрх нээх гэрээнд барьцаалав.
4	1100484296	2024-12-05	2027-12-05	хэвийн	Хаан банк	1.Шунхлай ХХК; 2. Шунхлай петролиум ХХК; 3. Шунхлай говь ХХК; 4. Шунхлай трейдинг ХХК;	Бараа материал, дансны авлага
5	1100430094	2024-07-08	2026-07-08	хэвийн	Худалдаа хөгжлийн банк	1. Шунхлай ХХК	Шунхлай ХХК-ийн Ирээдүйд борлуулалтаас орж ирэх мөнгөн хөрөнгө, авлага; Шунхлай ХХК-ийн агуулахад болон замд яваа бүх төрлийн шатах тослох материал, тэдгээрийн үлдэгдэл -г 2024/06/17-ний №ЗЭНГ/СС240614003-29 тоот Зээлийн эрх нээх гэрээнд барьцаалав.
6	1100362475	2024-02-23	2026-02-23	хэвийн	Худалдаа хөгжлийн банк	1.Шунхлай ХХК	Шунхлай ХХК-ийн ирээдүйд дансаар болон борлуулалтаас орж ирэх мөнгөн хөрөнгө; Шунхлай ХХК-ийн бараа материалын

							үлдэгдэл-г 2020/02/03-ны №ЗЭНГ/СС2002030-03-23 тоот Зээлийн эрх нээх гэрээнд барьцаалав.
7	1100360131	2024-02-14	2026-02-14	хэвийн	Хас банк	1.Шунхлай ХХК	2023 оны 12 сарын 04-ны БГ1540083121-01 барьцааны гэрээний 1 дугаар хавсралтаар ШУНХЛАЙ ХХК-ийн түлш шатахуун, замд яваа бараа материал, борлуулалтын болон бусад авлагуудыг эргэлтийн хөрөнгөөр тус тус барьцаалав.
8	1100341463	2023-12-07	2028-12-07	хэвийн	Хаан банк	1.Шунхлай ХХК 2.Шунхлай Говь ХХК 3.Шунхлай Трейдинг ХХК 4.Шунхлай Петролиум ХХК	УБ газрын тосны агуулахад буй бүх бараа материал; 4 компанийн дансны авлагууд; Замд яваа бүх бараа материал
9	1100698555	2026-06-29	2028-06-29	хэвийн	Хас банк	1.Шунхлай ХХК	2026 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн БГ1540083383-01 дугаартай Барьцааны гэрээний 3 дугаар хавсралтийн дагуу эргэлтийн хөрөнгө барьцаалав.
10	1100688785	2026-06-03	2029-06-03	хэвийн	Худалдаа хөгжлийн банк ХХК	1.Шунхлай ХХК	ирээдүйд дансаар болон борлуулалтаас орж ирэх мөнгөн хөрөнгө -г 2026/05/05-ны №ЗГ/СС260429026-20 тоот Зээлийн гэрээнд барьцаалав.
11	1100675885	2026-04-28	2029-04-28	хэвийн	ХААН БАНК ХХК	1.Шунхлай ХХК 2.Шунхлай Говь ХХК 3.Шунхлай Трейдинг	Бараа материал; Дансны авлага

ШУНХЛАЙ СЭХ он 2026 сар 09 өдөр 14 БҮРТГЭВ № 01

MONGOLIAN STOCK EXCHANGE 2026 -09- 02 БҮРТГЭВ-03

						ХХК 4.Шунхлай Петролиум ХХК	

Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1[69], 9 дүгээр зүйлийн 9.1[70]-т зааснаар арилжааны банкнуудад барьцааны эрх үүссэн боловч тэдгээртэй байгуулсан гэрээ болон хуульд заасан үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс хангуулах тохиолдол[71] үүсээгүй болох нь үнэт цаас гаргагчийн ирүүлсэн мэдээллүүд, хугацаа хэтэрсэн өр төлбөргүй, зээлийн ангилал хэвийн байгаа тухай лавлагаанаас[72] харагдаж байна.

Дээрх барьцаа бүхий зээлүүд нь зээлийн мэдээллийн сангийн 2025 оны 10 сарын 10-ны өдрийн байдлаарх "Хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх лавлагаа"-аар "сүүлийн таван жилийн хугацаанд зээлийн мэдээллийн санд нээлттэй зээл болон өр төлбөргүй болохыг тодорхойлов" гэх бөгөөд тус лавлагаа хүчин төгөлдөр байна.

Мөн үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК нь нийт 25 ширхэг тээврийн хэрэгсэл өмчилдөг болох нь Авто тээврийн үндэсний төвийн 2026 оны 08 сарын 19-ний өдрийн "Автотээврийн хэрэгсэл эзэмших, өмчлөх эрхийн лавлагаа"-гаар нотлогдож байна. Тус тээврийн хэрэгслүүдийг аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах арга хэрэгсэл болгохоор барьцаалаагүй болох нь үнэт цаас гаргагчийн ирүүлсэн мэдээлэл, Улсын бүртгэлийн ерөнхий газрын цахим мэдээллийн сан (www.mpr.gov.mn)-д байрласан мэдээллээр тогтоогдож байна.

3.7.3. Үнэт цаас өмчлох эрхийн тухай:

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн 2026 оны 08 сарын 28-ны өдрийн 01/952 дугаартай албан бичгээр үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийг "*... 2026 оны 08 сарын 28-ны өдрийн байдлаар 71-99055950, 130-3000782, 120-21049240 тоот данстай, үнэт цаас эзэмшээгүй байна*" гэж тодорхойлсон.

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК нь 8447225 регистрийн дугаартай "Шунхлай ойл" ХХК-ийн нэг бүр нь 5,000,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 100 ширхэг, 100 хувийн хувьцааг тус тус эзэмшиж байгаа бөгөөд уг эрх нь хүчин төгөлдөр болох нь уг компаниудын Улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн нээлттэй мэдээлэл www.opendata.burtgel.gov.mn цахим хуудаснаас харагдаж байна.

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн эзэмшлийн "Шунхлай ойл" ХХК-ийн хувьцаа нь аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээгээгүй тухай 2026 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн В/1342 дугаар албан бичгээр баталгаажуулсан.

---

[69] Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 "Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцаа нь хуульд зааснаар, эсхүл барьцаалагч, барьцаалуулагчийн хооронд байгуулсан гэрээний үндсэн дээр үүснэ."

[70] Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 "Гэрээний үндсэн дээр үүсэх барьцааны эрх нь барьцаалагч, барьцаалуулагчийн хооронд барьцааны гэрээг бичгээр, эсхүл цахим хэлбэрээр байгуулснаар үүснэ."

[71] Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн Наймдугаар бүлэг "Үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс хангуулах"

[72] Үнэт цаас гаргачийн 2025.10.10-ны өдөр авсан 100000040769013 дугаартай "Хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх лавлагаа"

ХАН-УЛААНБААТАР ХОТ ШУНХЛАЙ ХХК ТТ 3531 ☎ 2022468

Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital Delivering Diversity 1119269111 ☎ 5481559 Улаанбаатар хот

Хуулийн фирм нь дээрх хувьцаанд аливаа барьцааны эрх үүссэн эсэх, Улсын бүртгэлийн ерөнхий газрын цахим мэдээллийн сан (www.mpr.gov.mn)-д бүртгүүлсэн эсэхийг шалгаж үзэхэд Хуулийн дүгнэлт гарах үеийн байдлаар хувьцааг барьцаалсан тухай ямар нэг илэрц олдоогүй болно.

Иймд "Шунхлай" ХХК нь Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд бүртгэлтэй, нээлттэй болон хаалттай хэлбэрийн үнэт цаас эзэмшээгүй, эзэмшиж буй бусад хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцааг өмчлөх эрхүүд нь хүчин төгөлдөр байх бөгөөд аливаа үүргийн гүйцэтгэл хангуулах үүрэг хүлээгээгүй байна.

Дүгнэлт: Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК нь нийт 20 ширхэг үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхтэй болох нь үл хөдлөх хөрөнгө тус бүрийн лавлагаагаар тогтоогдож байна. Эдгээрээс 17 хөрөнгө нь үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар барьцаанд байх бөгөөд тус зээлийн гэрээний харилцаа хэвийн хэрэгжиж байгаа. "Шунхлай" ХХК-ийн өмчлөлийн нэг ширхэг үл хөдлөх хөрөнгө буюу 2206100593, Y-2201070793, Y-2206108285 дугаартай хөрөнгө нь аливаа хэлцлийн үүргийн гүйцэтгэлийг хангуулах арга хэрэгсэл болоогүй байна.

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн тодорхой хэд хэдэн үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгөд арилжааны банк болон бусад этгээдийн барьцааны эрх үүссэн боловч гэрээ болон хуульд заасан үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс хангуулах тохиолдол үүсээгүй, холбогдох зээлүүд нь төрийн байгууллагын мэдээллийн сайтад "хэвийн" ангилалтай байна.

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн өмчлөх эрхийг үгүйсгэсэн аливаа баримт, мэдээлэл байхгүй тул уг эрхийг хүчин төгөлдөр гэж үзнэ.

"Шунхлай" ХХК нь Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд бүртгэлтэй, нээлттэй болон хаалттай хэлбэрийн үнэт цаас эзэмшээгүй, "Шунхлай ойл" ХХК-ийн 100 хувийн хувьцааг эзэмших эрх нь хүчин төгөлдөр байх бөгөөд аливаа үүргийн гүйцэтгэл хангуулах үүрэг хүлээгээгүй байна.

3.8.Үнэт цаасыг бүртгүүлэх танилцуулгад тусгагдсан хууль зүйн мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх:

ҮЦЗЗтХ-ийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэгт "*Үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээллийн үнэн зөв, хүчин төгөлдөр эсэхийг энэ хуулийн 33.2.1-д заасан хууль зүйн зөвлөгөө үзүүлэх үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр, санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв эсэхийг энэ хуулийн 33.2.3-т заасан аудитын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр тус тус хянуулж, дүгнэлт гаргуулна*" гэж заасны дагуу үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээллүүдийг нягталж, нийтэд ил болсон мэдээлэл, төрийн болон эрх бүхий байгууллага, Үнэт цаас гаргагчийн зүгээс гаргаж өгсөн баримт бичигт тусгагдсан мэдээллүүдийг харьцуулсны үндсэн дээр ач холбогдол бүхий хууль зүйн мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэхэд дүн шинжилгээ хийв.

Хуулийн фирмээс дараах байдлаар үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хууль зүйн ач холбогдол бүхий мэдээлэл нь үнэт цаас гаргагчаас баталгаажуулагдсан, шаардлагатай тохиолдолд төрийн болон бусад эрх бүхий байгууллагуудын лавлагаа,

ШУНХЛАЙ
2026 оны 09 сар 1 өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2026 -09- 01
БҮРТГЭВ-03

мэдээллээр тодорхойлогдсон, хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомжид нийцсэн бөгөөд аливаа худал, ташаа, үнэнийг гуйвуулсан зүйл агуулаагүй, үнэн зөв байна гэж үзлээ. Тодруулбал, ҮЦЗЗтХ-ийн 10 дугаар зүйлийн 10.3[73], 10.5[74], 2021 оны 06 сарын 11-ний өдрийн 225 дугаартай тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 3.5[75]-т үнэт цаасны танилцуулгад заавал тусгах мэдээлэл, шаардлагыг заасан болно.

Танилцуулгын 1.1 "Үнэт цаас гаргагчийн товч танилцуулга" хэсэгт үнэт цаас гаргагчийн оноосон нэр, улсын бүртгэлийн дугаар бүртгэгдсэн огноо, регистрийн дугаар, оршин байгаа газрын хаяг, үйл ажиллагааны мэдээлэл, зэрэг мэдээллийг оруулсан нь ҮЦЗЗтХ-ийн 10 дугаар зүйлийн 10.5.1, 10.5.2 дахь хэсгийн шаардлагад нийцсэн байх бөгөөд хуулийн фирмд ирүүлсэн үнэт цаас гаргагчийн дэлгэрэнгүй лавлагаа, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм зэрэг баримт бичгийн мэдээлэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн олон нийтэд нээлттэй www.opendata.burtgel.gov.mn, www.opendatalab.mn цахим хуудаснууд дахь мэдээлэлтэй тохирч байна.

Танилцуулгын 1.3-т "Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчийн бүтэц" хэсэгт оруулсан үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн нийт гаргасан нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,657 ширхэг энгийн хувьцааг "Шунхлай Холдинг" ХХК

---

[73] Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 "Үнэт цаасны танилцуулга нь үнэт цаас гаргагчийн тухай, түүний хувьцаа эзэмшигчид, удирдлага, зохион байгуулалт, эрх бүхий албан тушаалтан, үнэт цаас гаргагчийн хөрөнгө, ор толбор, санхүүгийн байдал, оноогийн болон ирээдүйн төлөв, эрсдэл, гаргаж байгаа үнэт цаас, тухайн үнэт цаасаар гэрчлэгдсэн эрх, үнэт цаасыг арилжих журам, хөндлөнгийн дүгнэлт болон хөрөнгө оруулагч шийдвэр гаргахад шаардлагатай гэж Хорооноос үзсэн бусад мэдээллийг агуулсан байна."

[74] Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5 "Үнэт цаасны танилцуулгад дор дурдсан мэдээллийг тусгана: 10.5.1.үнэт цаас гаргагчийн оноосон нэр, оршин байгаа газрын шууданчийн болон холбоо барих хаяг, эрхэлж байгаа үйл ажиллагаа, хөрөнгийн биржид бүртгэлтэй эсэх тухай; 10.5.2.үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, бүртгэсэн он, сар, өдөр; 10.5.3.үнэт цаас гаргагчийн нолоо бүхий хувьцаа эзэмшигчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хуулийн этгээд бол оноосон нэр, улсын бүртгэлийн дугаар, тэдгээрийн дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмшиж байгаа хувьцааны тоо, хувь хэмжээ; 10.5.4.үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт, эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл, тэдгээрийн омчлол дэх хувьцааны тоо, хувь хэмжээний талаарх мэдээлэл; 10.5.5.үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, өмнө зарласан болон гаргасан, эргүүлэн худалдан авсан үнэт цаасны тоо, торол, нэрлэсэн үнэ болон өөрийн хөрөнгийн хэмжээ, бнет болон биет бус хөрөнгийн талаарх мэдээлэл; 10.5.6.үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан, түүний талаар аудитын байгууллагаас гаргасан дүгнэлт; 10.5.7.үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай этгэцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, хэлцэл, тэдгээрийн хэрэгжилтийн тухай; 10.5.8.үнэт цаас гаргагчийн холбогдох этгээдийн тухай; 10.5.9.нийтэд санал болгож байгаа үнэт цаасны тоо, хэлбэр, нэрлэсэн үнэ болон тэдгээрийг нийтэд санал болгох болон арилжих нөхцөл, журам, нөгөөл ашиг хуваарилах нөхцөл, журам, өрийн хэрэгслийн хувьд хугацаа, үндсэн толбор, хүү толох нөхцөл, журам; 10.5.10.нийтэд санал болгож байгаа үнэт цаасаар гэрчлэгдэх эрх, үүрэг; 10.5.11.үнэт цаас гаргаж хуримтлуулсан хөрөнгийг зарцуулах бизнесийн төлөвлөгөө; 10.5.12.хувьцаанд хөрвөх үнэт цаас бол тухайн үнэт цаасыг хувьцаанд хөрвүүлэх нөхцөл, журам; 10.5.13.үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэл, эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө; 10.5.14.тухайн үнэт цаасыг нийтэд санал болгох ажиллагаанд хамтран оролцож байгаа зохицуулалттай этгээд болон бусад мэргэжлийн үйлчилгээ үзүүлж байгаа этгээдийн тухай, тэдгээртэй байгуулсан гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг, хариуцлагын тухай; 10.5.15.өрийн хэрэгслийн тухайд эргэн толох баталгаа, барьцаа хөрөнгийн талаар; 10.5.16.сүүлийн нэг жилээс дээшгүй хугацааны дотор хийлгэсэн хөрөнгийн үнэлгээний тайлан; 10.5.17.Хорооноос үнэт цаасны танилцуулгад тусгах шаардлагатай гэж үзсэн бусад."

[75] СЗХ-ны 2021 оны 06 сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 3.5 "Энэ журмын 3.1.2-т заасан үнэт цаасны танилцуулгад Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.5-д зааснаас гадна дараах мэдээллийг тусгасан байна. 3.5.1. хувьцааг анхдагч зах зээлд байршуулах, захиалга авах, худалдах нөхцөл; 3.5.2. нийтэд санал болгон гаргах хувьцааны үнийг тогтооход ашигласан аргачлал, ашигласан түүхэн болон таамаглал тоо баримтууд; 3.5.3. үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон анх удаа гаргах нийт хувьцаанаас андеррайтерийн худалдан авах хувь хэмжээ; 3.5.4. үнэт цаас гаргагчийн хувьцааны үнийг тогтворжуулахтай холбоотой хүлээх үүрэг, хариуцлага, хэрэгжүүлэх хугацааны талаарх мэдээлэл; 3.5.5. үнэт цаас гаргагч болон мэргэжлийн үйлчилгээ үзүүлсэн хуулийн этгээдүүдийн хооронд үүсэж болзошгүй аливаа сонирхлын зөрчлоос сэргийлэх талаар гаргасан мэдэгдэл; 3.5.6. үнэт цаас гаргахтай холбоотой гаргасан зардлыг нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгөөс зарцуулах бол энэ тухай мэдээлэл."

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
ТУЗ-ийн 2026 оны 08 сарын 31-ний өдрийн 2026/468 дугаар шийдвэрийн хавсралт

317

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
1119209111 ☎ 5433580
Улаанбаатар хот

2026.08.31

нь 100 хувь эзэмшдэг тухай, толгой компани "Шунхлай Холдинг" ХХК-ийн оноосон нэр, улсын бүртгэлийн дугаар бүртгэгдсэн огноо, регистрийн дугаар, оршин байгаа газрын хаяг, үйл ажиллагаа, гүйцэтгэх захирал, үнэт цаас гаргагчийн эцсийн өмчлөгчөөр П.Батсайхан бүртгэлтэй тухай мэдээллүүд нь үнэт цаас гаргагчийн болон хувьцаа эзэмшигч "Шунхлай холдинг" ХХК-ийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм зэрэг баримт бичгийн мэдээлэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн нээлттэй www.opendata.burtgel.gov.mn, www.opendatalab.mn цахим хуудаснууд дахь мэдээллүүдээр баталгаажиж байна.

Танилцуулгын 1.4 "Үнэт цаас гаргагчийн хамаарал бүхий этгээдүүд" хэсэгт үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн 100 хувийн хувьцаа эзэмшдэг охин 1 компани, "Шунхлай Холдинг" ХХК-ийн эзэмшилд хамаарах үнэт цаас гаргагчтай нэгдмэл сонирхолтой зэрэгцээ компаниудын оноосон нэр, регистрийн дугаар, үйл ажиллагааны чиглэл, толгой компани "Шунхлай Холдинг" ХХК-ийн хувьцаа эзэмшлийн хувь хэмжээ зэргийг тусгасан нь эдгээр компаниудын улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн нээлттэй мэдээлэл зэрэг хүчин төгөлдөр баримтад буй мэдээлэлтэй нийцэж байна.

Танилцуулгын 1.5-т тусгасан "Үнэт цаас гаргагчийн бүтэц зохион байгуулалт" нь үнэт цаас гаргагч компанийн дүрэмд заасан болон баталсан бүтэц зохион байгуулалттай таарч байна.

Танилцуулгын 1.6-т тусгасан Үнэт цаас гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, эрх бүхий албан тушаалтнуудын мэдээлэл нь хуулийн фирмд ирүүлсэн эрх бүхий албан тушаалтны мэргэжил, боловсрол, ажилласан туршлагын мэдээлэл, диплом, гэрчилгээ, анкет, холбогдох лавлагаа, тодорхойлолтой нийцэж байна. Уг мэдээллийг танилцуулгад тусгасан нь ҮЦЗЗтХ-ийн 10 дугаар зүйлийн 10.5.4-т заасан шаардлагад нийцсэн байна.

Танилцуулгын 1.7-т тусгасан "Үнэт цаас гаргагчийн их хэмжээний, сонирхлын зөрчилтэй, хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 хувиас дээш дүнтэй хэлцлүүд" гэх мэдээлэл нь хуулийн фирмээс үнэт цаас гаргагч нь 2023 оны 08 дугаар сараас 2026 оны 08 сар хүртэлх гурван жилийн хугацаанд их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл, хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 хувиас дээш дүнтэй хэлцлүүд байгуулсан эсэх, байгуулагдсан хэлцэл нь хууль тогтоомжийн дагуу хийгдсэн эсэхэд хийсэн дүн шинжилгээтэй таарч байгаа болно.

Танилцуулгын 1.8 "Үнэт цаас гаргагчийн өмнө гаргасан үнэт цаасны мэдээлэл" хэсгийн үнэт цаас гаргагчаас 2022-2026 оны хооронд 6 удаагийн бондын хөтөлбөрөөр нийт 273.9 тэрбум төгрөгийг Биржийн бус зах зээл болон нээлттэй хүрээнд татан төвлөрүүлсэн тухай мэдээлэл Монголын Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны бүртгэлийн хорооны хурлын өрийн хэрэгслийг биржийн бус зах зээлийн үнэт цаасны бүртгэлд бүртгэх шийдвэр, СЗХ, МХБ-ын холбогдох тогтоол шийдвэрүүдэд тусгагдсан мэдээллүүдтэй таарч байна.

Танилцуулгын 3.1 "Олон нийтэд санал болгох үнэт цаасны тухай" хэсэг, түүнд тусгагдсан үнэт цаасны нөхцөлийн талаарх мэдээлэл нь хуулийн фирмд ирүүлсэн үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн ТУЗ-ийн 2026 оны 08 сарын 19-ний өдрийн В/14 дугаартай тогтоолтой таарч байна.

2026.08.31

ШУНХЛАЙ СЗХ 2026 .09. 10 БҮРТГЭВ № 01

2026 -09- 02 БҮРТГЭВ-03

Танилцуулгын 3.3 "Үнэт цаас гаргагчийн зээлжих зэрэглэл" хэсэг, түүнд тусгагдсан *"Монголын Хөрөнгө Оруулалтын Зэрэглэлийн Эжинси" ХХК (цаашид "Үнэлгээний компани" гэх) нь 2026 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн хяналтын хурлаар хэлэлцэж "Шунхлай" ХХК-ийн нээлттэй болон хаалттай хүрээнд гаргаж буй бондын зэрэглэлийг "А" буюу "Тогтвортой"'* гэж үнэлсэн байна.

Танилцуулгын 3.5-т тусгасан "Үнэт цаасаар гэрчлэгдэх эрх, үүрэг" нь ҮЦЗЗтХ-ийн 20 дугаар зүйлд заасан үнэт цаас гаргагчийн нийтлэг үүрэг[76], СЗХ-ны 2021 оны 06 сарын 11-ний өдрийн 226 дугаар тогтоолоор батлагдсан "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 7.1[77], 7.2[78], СЗХ-ны 2021 оны 06 сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 9.1 , 9.2 -т заасан үнэт цаас гаргагчийн эрх, үүрэгт нийцэж байна.

Үнэт цаасны танилцуулгын эхний хуудсанд "*Энэхүү танилцуулгад тусгасан өрийн бичгийг СЗХ болон МХБ бүртгэсэн нь уг үнэт цаасанд гаргасан аливаа баталгаа биш*

---

[76] Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 "Хуульд өөроор заагаагүй бол үнэт цаас гаргагч дараах нийтлэг үүрэгтэй байна: 20.1.1.үнэт цаас гаргах тухай шийдвэрийг эрх бүхий байгууллагын хурлаар хэлэлцэн гаргах; 20.1.2.үнэт цаасны арилжаатай холбоотой мэдээ, тайланг холбогдох аргачлал, маягтын дагуу үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд Хороонд хүргэх, нийтэд мэдээлэх; 20.1.3.Компанийн тухай хуульд зааснаас доошгүй тооны хараат бус гишүүнтэй байх; 20.1.4.тохиромжтой этгээдийг эрх бүхий албан гүшаалтнаар томилох буюу сонгох; 20.1.5.үнэт цаасны танилцуулгад заасан тослийн хэрэгжилт өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр нийтэд болон хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх; 20.1.6.санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан хугацаанд, мөн жилийн эцэсийн санхүүгийн тайланг Хороонд бүртгэлтэй аудитын байгууллагаар аудит хийлгүүлж, аудитын дүгнэлт гарснаас хойш аудитын дүгнэлтийн хамт ажлын гурван өдрийн дотор Хороо, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэх; 20.1.7.үйл ажиллагаа, санхүүгийн байдлыг талаарх мэдээллийг Хорооноос тогтоосон журмын дагуу нийтэд мэдээлэх; 20.1.8.хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг нийтэд нэн даруй мэдээлж, холбогдох баримт бичиг, мэдээллийг хурал хуралдсанаас хойш ажлын гурван өдрийн дотор Хороо, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэх; 20.1.9.үнэт цаасны хаяг, арилжааны хэмжээнд мэдэгдэхүйц нөлөөлж болох нөхцөл байдал үүсмэгц энэ тухай нийтэд нэн даруй мэдээлэх; 20.1.10.Хорооноос баталсан компанийн засаглалын зарчмыг үйл ажиллагаандаа дагаж мөрдөх."

[77] СЗХ-ны 2021 оны 06 сарын 11-ний өдрийн 226 дугаар тогтоолоор батлагдсан "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 7.1 "Бонд гаргагч дараах эрхтэй: 7.1.1. нээлттэй бонд гаргагч нь андеррайтераас гаргасан нарийвчилсан шинжилгээ, судалгаа, хийсэн үнэлгээ, дүгнэлтэд үндэслэн нийтэд санал болгох бондын үнэ, хүүгийн түвшинг тогтоох; 7.1.2. Хороонд бүртгэлд бүртгүүлэхээр гаргасан хүсэлт нь хэрхэн шийдвэрлэгдэж байгаа талаарх явцыг мэдээ, мэдээллээр хангагдах; 7.1.3. нийтэд санал болгон гаргах бондыг тодорхой үнэ, хувь хэмжээгээр худалдан авах эрхийг гэрчлэх варрант гаргах; 7.1.4. компанийн санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох эрх бүхий байгууллагаар зэрэглэл тогтоолгох; 7.1.5. бондын танилцуулга, гэрээнд заасан бол нийтэд санал болгон гаргасан бондыг хугацааны ханш, арилжааны хэмжээнд мэдэгдэхүйц нөлөөлж болох нөхцөл байдал үүсмэгц энэ тухай нийтэд нэн даруй мэдээлэх; 20.1.10.Хорооноос баталсан компанийн засаглалын зарчмыг үйл ажиллагаандаа дагаж мөрдөх."

[78] СЗХ-ны 2021 оны 06 сарын 11-ний өдрийн 226 дугаар тогтоолоор батлагдсан "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 7.2 "Бонд гаргагч нь дараах үүрэгтэй: 7.2.1. нээлттэй бонд гаргагч компани нь андеррайтертай гэрээ байгуулсан байх; /Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хороонд 2022 оны 68 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/ 7.2.2. санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох эрх бүхий байгууллагаар зэрэглэл тогтоолгох бол зэрэглэл тогтоохоо шаардлагатай үнэн зөв, бүрэн мэдээллийг тухайн байгууллагад гаргах өгөх; 7.2.3. Хорооноос бондыг бүртгэлтэй холбоотой аливаа мэдээлэл хүргүүлэхийг шаардсан бол тодруулга, нэмэлт баримт бичгийг бонд гаргагч нь заасан хугацаанд Хороонд хүргүүлэх; 7.2.4. нээлттэй бонд гаргач нь бондыг анхдагч зах зээлд амжилттай санал болгосон тохиолдолд ажлын таван өдрийн дотор тухайн гаргасан бондын үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болох эд хөрөнгө, эднийн бус хөрөнгийн барьцааны гэрээ эсхүл мэдэгдлийг улсын бүртгэлд бүртгүүлэх; 7.2.5. холбогдох хууль тогтоомж болон энэ журамд заасны дагуу мэдээллийн ил тод байдлыг тогтмол хангах, хөрөнгө оруулагчийн өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллах; 7.2.6. бондыг Хороонд бүртгүүлж, энэ журмын 6.2-т заасан хугацаа дууссанаас хойш тухайн бондыг нийтэд санал болгох тохиолдолд уг хугацаа дуусахаас ажлын 10 өдөрөс доошгүй хугацааны өмнө бондын танилцуулгыг шинэчлэн бүртгүүлэх хүсэлтийг арилжаа эрхлэх байгууллагад гаргаж, Хороонд мэдэгдэл хүргүүлэх; 7.2.7. нээлттэй бонд гаргач нь зэрэглэл тогтоолгосон бол хагас жил, бүтэн жил тутам зэрэглэлийг шинэчлэх; 7.2.8. бонд гаргачид гуравдагч этгээд баталгаа, батлан даалт гаргасан бол бондын танилцуулгад уг этгээдийн тодорхой, үнэн зөв, бүрэн, мэдээллийг тусгах; 7.2.9. Албан мэдэгдэл эсхүл бондын танилцуулга, гэрээнд заасан бол хөрөнгө оруулагчийн саналаар түүний бондыг хугацааны өмнө худалдан авах; 7.2.10. тухайн гаргасан бондыг бүртгүүлэхтэй холбоотойгоор Хороонд хүргүүлсэн баримт бичиг, түүнд хавсаргасан холбогдох дүгнэлт эрэг бусад баримт бичгийг бондын хугацаа дуусаж, үндэсэн болон хүүгийн толбөрийг бүрэн толж дуусах хүртэлх хугацаанд компани дээрээ хадгалах; 7.2.11. аймаг нийслэлийн Засаг дарга нь энэ журмын 6.15-д заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын гурван өдрийн дотор бондыг анхдагч зах зээлд санал болгосон тухай болон эргэн төлөлтийн хуваарийн талаарх мэдээллийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх."

Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital Delivering diversity 11192691111 5831589 Улаанбаатар хот

2026.08.31

богөөд түүний агуулсан мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн байдал болон аливаа эрсдэлийг СЗХ болон МХБ хариуцахгүй болохыг анхаарах нь зүйтэй. Энэхүү үнэт цаасыг худалдан авах замаар хөрөнгө оруулалт хийх нь хөрөнгө оруулагч таны хувьд ямагт эрсдэлтэй үйлдэл байдгийг онцгойлон анхаарч, өрийн бичиг гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна" гэж оруулсан нь СЗХ-ны 2021 оны 06 сарын 11-ний өдрийн 225 дугаартай тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 3.6, "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 3.4.10-т заасныг тус тус хангасан байна.

Танилцуулгын 6 дугаар хэсэгт тусгасан "Үнэт цаас гаргахад оролцсон байгууллагууд" хэсэг нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэхийг авч үзье.

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК нь регистрийн 5481589 дугаартай "Голомт Капитал ҮЦК" ХХК-тай 2026 оны 08-р сарын 21-ний өдөр "Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ"-г байгуулсан байна. Тус андеррайтерийн гэрээний хүрээнд Андеррайтер нь өрийн хэрэгслийг СЗХ, МХБ-д бүртгүүлж, олон нийтэд нээлттэй хүрээнд санал болгон хөрөнгө татан төвлөрүүлэхэд шаардагдах тооцоолол, судалгаа, бэлтгэл ажлуудыг гүйцэтгэх, зөвлөгөө өгөх, хөрөнгө оруулагч нарт Компанийг танилцуулах, санал болгох, санхүүжилт татаж өгөхөд Андеррайтерийн үйлчилгээ үзүүлнэ.

Түүнчлэн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн нээлттэй www.opendata.burtgel.gov.mn, www.opendatalab.mn цахим хуудаснууд дахь мэдээллүүдээр андеррайтер "Голомт Капитал ҮЦК" ХХК нь үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-тай КтХ-ийн 99 дүгээр зүйлийн 99.1[79] заасан нэгдмэл сонирхолтой этгээд, ҮЦЗтХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.30[80]-т заасан холбогдох этгээд, 4.1.31[81]-т заасан хуулийн этгээдийн нэгдэлд хамаарах этгээдэд болох тухай мэдээлэл, баримт илрээгүй болно. Тиймээс "Голомт Капитал ҮЦК" ХХК нь үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-тай "Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ" байгуулан андеррайтераар ажиллаж буй нь СЗХ-ны 2021 оны 06 сарын 11-ний өдрийн 225 дугаартай тогтоолоор батлагдсан "Үнэт

---

[79] КтХ-ийн 99 дүгээр зүйлийн 99.1 "Дараах хамаарал бүхий этгээдийг энэ хуульд заасан нэгдмэл сонирхолтой этгээд гэж тооцно: 99.1.1.тодорхой гэрээний үндсэн дээр хамтран тухайн компанийн удирдлагын шийдвэрийг тодорхойлох боломж бүхий бүлэг хүмүүс; 99.1.2.энэ хуулийн 6.14-т заасны дагуу тодорхойлсон компанийн нэгдэлд хамаарч байгаа компанийн хувьд компанийн нэгдлийн бусад оролцогч компани, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан; 99.1.3.компанийн удирдлагын шийдвэрийг хамтран тодорхойлох боломж бүхий компани болон хүн /бүлэг хүмүүс/; 99.1.4.нэг хүн /бүлэг хүн/ гаргах шийдвэрийг нь тодорхойлох боломж бүхий компани; 99.1.5.компани болон уг компанийн эрх бүхий албан тушаалтан; 99.1.6.нэг гэр бүлийн гишүүн, эцэг, эх, хүүхэд, ач, зээ пар ах дүү, бусад төрөл, садангийн хүн; 99.1.7.нэг хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчид; 99.1.8.өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь хувьцааны хяналтын багцыг нь эзэмшдэг болон эрх бүхий албан тушаалд ажилладаг компани, уг компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогч компани болон тэдгээрийн хувьцааны хяналтын багцыг эзэмшигч болон эрх бүхий албан тушаалтан; 99.1.9.уг этгээд ажил олгогч бол түүний ажилтан."

[80] Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.30 ""холбогдох этгээд" гэж дараах этгээдийг: 4.1.30.а.хувь хүний тухайд тухайн хүний эхнэр, нөхөр, хүү, охин, өргөмөл хүү, өргөмөл охин бүюу дагавар хүү, дагавар охин, хүргэн, бэр, ач, зээ, өөрийн болон түүний эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, хойд эцэг, хойд эх, ах, эгч, дүү, эцэг нэгтэй бүюу эх нэгтэй ах, эгч, дүү; 4.1.30.б.тухайн хүн эрх бүхий албан тушаалтнаар нь ажилладаг хуулийн этгээд; 4.1.30.в.энэ хуулийн 4.1.30-д заасан этгээд дангаар, эсхүл хамтдаа эзэмших саналын эрх бүхий хувьцааны 10 бүюу түүнээс дээш хувийг эзэмшдэг компани болон хуулийн этгээд; 4.1.30.г.тухайн этгээд ажил олгогч бол түүний ажилтан; 4.1.30.д.компани бол түүний толгой, хараат, охин, зэргэлдээ компани; 4.1.30.е.Санхүүгийн зохицуулах хороонооос "холбогдох этгээд" гэж тодорхойлсон бусад этгээд"

[81] Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.31 ""хуулийн этгээдийн нэгдэл" гэж үнэт цаасны зах зээлд оролцогчтой холбоотой дараах хуулийн этгээдийг: 4.1.31.а.үнэт цаасны зах зээлд оролцогчийн толгой компани, нөхөрлөл, бусад хуулийн этгээд; 4.1.31.б.үнэт цаасны зах зээлд оролцогчийн хараат, охин, зэргэлдээ компани, нөхөрлөл, бусад хуулийн этгээд; 4.1.31.в.үнэт цаасны зах зээлд оролцогчийн хараат, охин компанийн толгой компани; 4.1.31.г.үнэт цаасны зах зээлд оролцогчийн энэ хуулийн 4.1.31.а, 4.1.31.б-д заасан хуулийн этгээдийн хяналтын багцыг эзэмшиж байгаа этгээд."

цаасны бүртгэлийн журам"-ын 2.2-т "*Үнэт цаас гаргагчтай гэрээ байгуулан ажиллах үндсэн андеррайтер нь түүний холбогдох этгээд байж болохгүй ...*" гэж заасан шаардлагыг хангаж байна.

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК нь регистрийн 6659659 дугаартай "Монголын Хөрөнгө Оруулалтын Зөрэглэлийн Эжинси" ХХК-тай 2025 оны 11-р сарын 28-ны өдөр "Зээлжих болон компанийн үнэлгээ тогтоох үйлчилгээ үзүүлэх гэрээ"-г байгуулсан байна. Тус гэрээний дагуу ажил гүйцэтгэгч нь захиалагчийн зөрэглэлийг тогтоох, шинэчлэх үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээний төлбөр тооцоог гүйцэтгэх, гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой талуудын эрх, үүрэг, хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулна. Ажил гүйцэтгэгч нь Захиалагчийн дотоодын зах зээлд бонд гаргахад зориулан зөрэглэл тогтооно.

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК нь регистрийн 5271894 дугаартай Өмгөөллийн "Легал Полиси" ХХК-тай нь 2026 оны 08-р сарын 19-ний өдөр "Эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ"-г байгуулсан бөгөөд гэрээний дагуу хуулийн фирм нь "Шунхлай" ХХК-ийн өрийн хэрэгсэл гаргах үйл ажиллагаанд хууль зүйн дүгнэлт гаргах, эрх зүйн туслалцаа үзүүлэхээр тохиролцсон байна.

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК нь регистрийн "Нямазон аудит" ХХК-тай 2026 оны 07 сарын 27-ны өдөр "Аудитын үйлчилгээ үзүүлэх тухай гэрээ"-г байгуулсан. Тус гэрээний хүрээнд санхүүгийн тайлангууд нь СТОУС болон холбогдох хууль, журамд заасны дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд аудитын дүгнэлт гаргах үйлчилгээг гүйцэтгэсэн байна.

Дээрх байдлаар ҮЦЗЗтХ-ийн 10 дугаар зүйлийн 10.5.14-т зааснаар үнэт цаасны танилцуулгын 6 дугаартай "Үнэт цаас гаргахад оролцсон байгууллагууд" хэсэгт андеррайтерын чиг үүрэгтэйгээр оролцож байгаа "Голомт Капитал ҮЦК" ХХК, зээлжих зөрэглэл тогтоосон "Монголын хөрөнгө оруулалтын зөрэглэлийн эжинси" ХХК, хуулийн дүгнэлт гаргах чиг үүрэгтэйгээр оролцож байгаа Өмгөөллийн "Легал Полиси" ХХК, аудитор хийх чиг үүрэгтэйгээр оролцож байгаа "Нямазон аудит" ХХК-ийн танилцуулга, үзүүлэх үйлчилгээний цар хүрээ, тусгай зөвшөөрөл, үйлчилгээ үзүүлэх гэрээгээр хүлээсэн эрх үүрэг, дүгнэлтүүдтэй холбоотой оруулсан мэдээллүүд нь холбогдох хуулийн этгээдийн улсын бүртгэлийн болон тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээ, олон нийтэд нээлттэй мэдээлэл зэрэг хүчин төгөлдөр баримтуудаар нотлогдож байна.

Иймд танилцуулга нь ҮЦЗЗтХ-ийн 10 дугаар зүйлийн 10.3, 10.5, СЗХ-ны 2021 оны 06 сарын 11-ний өдрийн 225 дугаартай тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 3.5-т заасан шаардлагыг тус тус хангасан, тусгагдсан хууль зүйн мэдээллүүд нь хүчин төгөлдөр баримтуудаар нотлогдож байна.

Дурдсан хууль зүйн ач холбогдолтой мэдээллээс бусад үнэт цаас гаргагчийн санхүүгийн үзүүлэлт, бүтээгдэхүүн, үйлчилгээ, зээлжих зөрэглэл, борлуулалтын хэмжээ, ашиг, алдагдал зэрэг бизнесийн үйл ажиллагаа, маркетингийн мэдээлэл, үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны үндсэн чиглэлд хамаарах зах зээлд эзэлж буй байр суурь, салбарын макро эдийн засгийн болон олон улс, Монгол Улсын хэмжээнд дэх нөхцөл байдал, үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны тухай болон үнэт цаас гаргагчийн зах зээлийн судалгаа, төлөвлөгөө зэрэгт агуулагдсан эдийн засгийн ерөнхий мэдээлэл,

ШУНХЛАЙ
2026 09 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛ ҮНЭТ ЦААС БИРЖ
2026 -09- 02
БҮРТГЭВ-03

салбарын бусад үзүүлэлт, санхүүгийн төсөөлөл, үнэт цаас гаргагчийн талаар олон нийтэд ил, тодорхой үйл баримт, түүхэн замнал, ололт, амжилт, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд тусгагдсан баталгаажуулах боломжгүй тоон үзүүлэлт болон хараат бус байгууллагуудын хийсэн дүн шинжилгээ, санхүүгийн тооцоолол, үнэлгээ, үнэт цаас гаргаж хуримтлуулсан хөрөнгийг зарцуулах бизнесийн төлөвлөгөө, дунд хугацааны бизнес төлөвлөгөөний тойм, үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэл, эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө зэрэг мэдээлэлд хуулийн фирмээс дүн шинжилгээ хийгээгүй болохыг дурдаж байна.

Дүгнэлт: Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн үнэт цаасны танилцуулгад Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ-ны 2021 оны 06 сарын 11-ний өдрийн 225 дугаартай тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-д заавал тусгахаар заасан мэдээллүүд тусгагдсан байх бөгөөд хууль зүйн ач холбогдол бүхий мэдээлэл нь үнэн зөв, хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байна. Андеррайтер "Голомт Капитал ҮЦК" ХХК нь үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-тай нэгдмэл сонирхолтой этгээд, холбогдох болон хуулийн этгээдийн нэгдэлд тус тус хамаарахгүй байх тул "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 2.2-т "*Үнэт цаас гаргагчтай гэрээ байгуулан ажиллах үндсэн андеррайтер нь түүний холбогдох этгээд байж болохгүй ...*" гэж заасан шаардлагыг хангаж байна.

3.9. Компанийн толгой, охин, хараат, зэрэгцээ компанийн талаарх мэдээлэлд үндэслэн үнэт цаас гаргагч компанийн хяналтыг хэрэгжүүлэгч, эцсийн омчлогч этгээдийг тодорхойлох:

3.9.1. Үнэт цаас гаргагчийн толгой компанийн тухай:

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн 2026 оны 07 сарын 06-ны өдрийн В/11 дугаартай шийдвэрийн хавсралтаар батлагдсан "Шунхлай" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэм, 2026 оны 08 сарын 19-ний өдрийн Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан авсан Улсын бүртгэлийн Ерөнхий газрын "Хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа", "Хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч, гишүүний лавлагаа"-наас үзвэл компанийн 100 хувийн хувьцааг "Шунхлай Холдинг" ХХК эзэмшиж байна. Тиймээс КтХ-ийн 6 дугаар зүйлийн 6.3[82]-т зааснаар "Шунхлай холдинг" ХХК нь "Шунхлай" ХХК-ийн толгой компани, мөн хуулийн 56 дугаар зүйлийн 56.1[83]-т зааснаар хяналтын багц эзэмшигч байна.

3.9.2. Үнэт цаас гаргагчийн охин, хараат компанийн тухай:

КтХ-ийн 6 дугаар зүйлийн 6.3-т зааснаар компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 50-аас дээш хувийг өөр /толгой/ компани дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшдэг бие даасан компанийг охин компани гэнэ.

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК нь регистрийн 8447225 дугаартай, Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа /46100/, Бизнесийн төсөл хэрэгжүүлэх

[82] КтХ-ийн 6 дугаар зүйлийн 6.3."Компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 50-аас дээш хувийг өөр /толгой/ компани дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшдэг бие даасан компанийг охин компани гэнэ"
[83] КтХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1 "Компанийн гаргасан энгийн хувьцааны гуравны нэг буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг компанийн хувьцааны хяналтын багц гэнэ"

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
ТУА3531 № 2025408
Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
1119283111 ▲ 5401580
Улаанбаатар хот

/9410/ үйл ажиллагааны чиглэлтэй "Шунхлай ойл" ХХК-ийн нэг бүр нь 5,000,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 100 ширхэг, 100 хувийн хувьцааг эзэмшиж байна.

"Шунхлай ойл" ХХК нь үнэт цаас гаргагчийн охин компани байна.

КтХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1-т зааснаар компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 20-50 хувийг өөр /толгой/ компани дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа тохиолдолд уг компанийг хараат компани гэнэ. Үнэт цаас гаргагч нь дээрх охин компаниас өөр компанийн хувьцааг тодорхой хувь, хэмжээгээр эзэмшдэггүй байх тул "Шунхлай" ХХК-д хараат компани байхгүй байна.

3.9.3. Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компанийн тухай:

КтХ-ийн 6 дугаар зүйлийн 6.15-т зааснаар нэг толгой компанийн хараат болон охин компаниуд, эсхүл нэг этгээд дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран хувьцааных нь хяналтын багцыг эзэмшдэг компаниудыг зэргэлдээ компани гэнэ.

Түүнчлэн КтХ-ийн 6 дугаар зүйлийн 6.8-т зааснаар толгой компани нь гуравдагч компанийн хараат болон охин компани бол түүний хараат болон охин компани нь гуравдагч компанийн хувьд мөн хараат болон охин компани болох бөгөөд энэ зарчмыг үүнээс ч илүү үргэлжилсэн хэлхээ холбоонд ашиглан хамаарлыг тогтооно.

Тиймээс үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн толгой компани болох "Шунхлай Холдинг" ХХК-ийн охин, хараат компани болон тэдгээрийн охин хараат компани нь "Шунхлай" ХХК-тай зэргэлдээ компанид тооцогдоно.

Хуулийн фирмээс үнэт цаас гаргагч болон түүний толгой компани "Шунхлай Холдинг" ХХК-иас ирүүлсэн компаниудын гэрчилгээ, дүрмүүд, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн нээлттэй мэдээлэлд үндэслэн дараах байдлаар зэрэгцээ компаниудыг тодорхойлов.

Хүснэгт №23. КтХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.3-т зааснаар "Шунхлай Холдинг" ХХК шууд хувьцааг нь эзэмшдэг охин болон хараат компаниудын мэдээлэл

№	Компанийн нэр	Бүртгүүлсэн огноо	Үйл ажиллагааны чиглэл	Эцсийн омчлогч	Толгой компанийн нэр, хувь эзэмшил
1	**"Боршоон Буянт" ХХК**	2005.10.19	- Спирт, архи, пиво, ундаа, ус үйлдвэрлэл; - Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа;	П.Батсайхан	"Шунхлай Холдинг" ХХК-ийн охин компани
2	**"АПУ" ХК**	2005.10.12	- Архины үйлдвэрлэл; - Шар айрагны үйлдвэрлэл; - Спиртийн үйлдвэрлэл; - Ундаа, ус, жүүсний үйлдвэрлэл;	П.Батсайхан, Олон нийт	"Шунхлай Холдинг" ХХК-ийн охин компани

			- Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл; - Гадаад худалдаа; - Ахуйн хог хаягдлаас хоёрдогч түүхий эд, материал гарган авах үйл ажиллагаа; - Менежментийн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа; - Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх		
3	**"Ди Эс Жи" ХХК**	2016.03.21	- Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх; - Менежментийн зөвлөх үйлчилгээ; - Төлбөр эсхүл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа; - Бизнесийн зөвлөгөө өгөх;	П.Батсайхан	"Шунхлай Холдинг" ХХК-ийн охин компани
4	**"Дижитал Концепт" ХХК**	2020.02.06	- Хүнсний бөөний худалдаа; - Хүнсний дэлгүүр; - Менежментийн зөвлөгөө өгөх; - Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа; - Онлайн худалдаа; - Түргэн хоолны үйлчилгээ; - Катерингийн үйлчилгээ; - Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа; - Талх, нарийн боовны үйлдвэрлэл, худалдаа; - Бууз, баншны үйлдвэрлэл, худалдаа; - Худалдагч, кассчин мэргэшүүлэх түр сургалт;	П.Батсайхан	"Шунхлай Холдинг" ХХК-ийн охин компани

5	**“Хюндай моторс монгол” ХХК**	2009.09.16	- Автомашины худалдаа; - Автомашины сэлбэгийн худалдаа; - Автомашины түрээс; - Төлбөр эсхүл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа.	-	“Шунхлай Холдинг” ХХК-ийн охин компани
6	**“Жи Эс Би капитал ББСБ” ХХК**	2011.05.24	- Гадаад валютын арилжаа; - Зээлийн үйл ажиллагаа; - Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх; - Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх; - Санхүүгийн цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх.	П.Батсайхан	“Шунхлай Холдинг” ХХК-ийн охин компани
7	**“Жи Эс Би майнинг” ХХК**	2011.01.07	- Ашигт малтмалын хайгуул хийх; - Ашигт малтмал ашиглалт; - Гадаад худалдаа; - Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийх бөөний худалдаа.	П.Батсайхан	“Шунхлай Холдинг” ХХК-ийн охин компани
8	**“Киа Моторс Монгол” ХХК**	2010.11.29	- Авто машины түрээс; - Автомашины худалдаа; - Автомашины сэлбэгийн худалдаа; - Төлбөр эсхүл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа.	П.Батсайхан	“Шунхлай Холдинг” ХХК-ийн охин компани
9	**“Монголмо-торс групп” ХХК**	2011.03.14	- Автомашины худалдаа; - Гадаад худалдаа; - Автомашины сэлбэгийн худалдаа; - Автомашины түрээс.	П.Батсайхан	“Шунхлай Холдинг” ХХК-ийн охин компани

10	**"Эс Ди сервис" ХХК**	2013.03.12	- Төлбөр эсхүл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа; - Брилгын засвар; - Менежментийн зөвлөгөө; - Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа; - Орон сууц, албан байгууллага, барилгын болон засварын дараах цэврэлгээ ; - Фитнесс, бялдаржуулах төв.	П.Батсайхан	"Шунхлай Холдинг" ХХК-ийн охин компани
11	**"Медиа групп" ХХК**	2013.05.27	- Бизнесийн зөвлөгөө өгөх - Зар сурталчилгаа -Менежментийн зөвлөгөө өгөх -Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа	П.Батсайхан	"Шунхлай Холдинг" ХХК-ийн охин компани
12	**"Тэнгэр тек пти лтд" ХХК**	2021.06.24	- Менежмент консалтинг үйлчилгээ	П.Батсайхан	"Шунхлай Холдинг" ХХК-ийн охин компани
13	**"Монголиан рөуд констракшн" ХХК**	2010.12.15	- Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа; - Гадаад худалдаа.	П.Батсайхан	"Шунхлай Холдинг" ХХК-ийн охин компани
14	**"Пауэр юнит" ХХК**	2010.06.28	- Гадаад худалдаа; - Төлбөр эсхүл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа; - Цахилгаанаар зохицуулалттай хангах; - Цахилгаан түгээх; - 5-100 МВт-ын эрчим хүчний эх үүсвэр барих, угсрах, засварлах, туршилт тохируулга бусад дагалдах үйлчилгээ;	П.Батсайхан	"Шунхлай Холдинг" ХХК-ийн охин компани

			- 0.4-35 кВт-ын ЦДШ, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт, тохируулга, бусад дагалдах ажил үйлчилгээ; - Туршилт тохируулгын ажил үйлчилгээ.		
15	**"Сантранс ложистикс" ХХК**	2016.05.09	- Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа; - Бизнесийн зөвлөгөө өгөх	П.Батсайхан	"Шунхлай Холдинг" ХХК-ийн охин компани
16	**"Эс системс" ХХК**	2022.09.24	- Төлбөр эвсэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалда; - Мэдээлэл технологийн үйл ажиллагаа; - Дата төвийн үйлчилгээ; - Аюулгүй байдлын зөвлөгөө өгөх; - Интернэтийн үйлчилгээ; - Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх; - Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх	Шунхлай холдинг	"Шунхлай Холдинг" ХХК-ийн охин компани
17	**"Эс девелопмент" ХХК**	2011.04.18	- Бизнесийн зөвлөгөө өгөх; - Менежментийн зөвлөгөө өгөх; - Бизнесийн төсөл хэрэгжүүлэх; - Барилгын засал чимэглэлийн ажил гүйцэтгэх; - Аялал жуучлал; - Төлбөр эсхүл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа; - Барилгын засал чимэглэл, интерьерийн ажил.	Эс девелопмент Пи Ди Ар Эс Пийс стоун	"Шунхлай Холдинг" ХХК-ийн охин компани

18	**"Шунхлай трейдинг" ХХК**	2011.08.22	- Төлбөр эсхүл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа; - Шатахуун бөөний худалдаа; - Шатахууны жижиглэнгийн худалдаа; - Шатахуун тээвэрлэлт; - Шатахуун тосолгооны материалын шинжилгээний итгэмжлэгдсэн лаборатор.	П.Батсайхан	"Шунхлай Холдинг" ХХК-ийн охин компани
19	**"Шунхлай говь" ХХК**	2011.08.22	- Төлбөр эсхүл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа; - Шатахуун бөөний худалдаа; - Шатахууны жижиглэнгийн худалдаа; - Шатахууны тээвэрлэлт; - Шатахуун тосолгооны материалын шинжилгээний итгэмжлэгдсэн лаборатор.	П.Батсайхан	"Шунхлай Холдинг" ХХК-ийн охин компани
20	**"Шунхлай петролиум" ХХК**	2011.09.14	- Төлбөр эсхүл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа; - Шатахуун бөөний худалдаа; - Шатахууны жижиглэнгийн худалдаа; - Шатахууны тээвэрлэлт; Шатахуун тосолгооны материалын шинжилгээний итгэмжлэгдсэн лаборатор.	П.Батсайхан	"Шунхлай Холдинг" ХХК-ийн охин компани
21	**"Эс жи инвестмент энд**	2021.05.26	- Бизнесийн зөвлөгөө өгөх;	П.Батсайхан	"Шунхлай Холдинг" ХХК-ийн

	секюритиз"ХХК		- Үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа; - Мөнгөн хөрөнгийн орлого, зарлага номинал данс эзэмших		охин компани
22	**"Улаанбаатар синема" ХХК**	2006.09.14	- Гадаад худалдаа; - Өргөн дэлгэцийн кино театр; - Зоогийн газар; - Хүнсний дэлгүүр;	-Б.Бадамханд - С.Батболд - Б.Баттүшиг -Х.Отгонтуяа - Б.Самаади -Б.Цэрэндулам -П.Батсайхан	"Шунхлай Холдинг" ХХК-ийн охин компани
23	**"Скайтел" ХХК**	2005.10.21	- Үүрэн телефон, пейжерийн холбооны үйлчилгээ, үүрэн телефоны төгсгөлийн төхөөрөмжийн худалдаа үйлчилгээ эрхлэх	- П.Батсайхан	"Шунхлай Холдинг" ХХК-ийн охин компани
24	**"Зеро технологи" ХХК**	2022.11.28	- Программ хангамжийн үйл ажиллагаа; - Мэдээллийн технологийн үйл ажиллагаа; - Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх; - Веб сайтын үйлчилгээ; - Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа; - Бизнесийн зөвөлгөө өгөх; - Менежментийн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа	П.Батсайхан	"Шунхлай Холдинг" ХХК-ийн охин компани
25	**"Фандиа" ХХК**	2022.10.26	- Мэдээлэл технологийн үйл ажиллагаа; - Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа; - Вэб сайтын үйлчилгээ; - Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх; - Онлайн худалдаа	Б.Цэлмэг	"Шунхлай Холдинг" ХХК-ийн хараат компани

26	**"Эс ди инженеринг энд констракшн" ХХК**	2016.03.21	- Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх; - Барилгын засвар хийх; - Менежментийн зөвлөгөө өгөх; - Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа	П.Батсайхан	"Шунхлай Холдинг" ХХК-ийн охин компани
27	**"Оранж эйр" ХХК**	2022.11.14	- Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх; - Бизнесийн зөвлөгөө өгөх; - Аялал жуулчлал	П.Батсайхан	"Шунхлай Холдинг" ХХК-ийн охин компани
28	**"Бүүст интелиженс" ХХК**	2023.01.03	- Төсөл хөтөлбөр боловсруулах; - Компьютер програмчлал, зөвлөгөө болон түүнд холбогдох үйл ажиллагаа	Б.Лувсанбямба П.Батсайхан	"Шунхлай Холдинг" ХХК-ийн охин компани

Хүснэгт №24. КтХ-ийн 6 дугаар зүйлийн 6.8-т заасныг "Шунхлай холдинг" ХХК-ийн шууд бусаар буюу охин болон хараат компаниараа дамжуулан хувьцааг нь эзэмших охин болон хараат компаниудын мэдээлэл.

№	Компаний нэр	Үүсгэн байгуулагдсан огноо	Үйл ажиллагааны чиглэл	Эзэний өмчлөгч	Толгой компаний нэр, хувь эзэмшил
1	**"Спирт бал бурам"**	2006.02.22	- Спирт, архины үйлдвэрлэл; - Мал аж ахуй; - Талх нарийн боов, гоймон, гурил үйлдвэрлэл; - Хүнсний ногоо тариалалт; - Туслах аж ахуй;; - Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа - Сүү, сүүн бүтээгдэхүүн, бяслаг үйлдвэрлэл; - Уламжлалт технологиор үйлдвэрлэх согтууруулах ундаа	П. Батсайхан Б. Ганбат Б. Ганхөлөг Г. Оюун Х.Тунгалаг Б.Цэлмэг Б.Цэлмүүн-үжин П.Батсайхан	АПУ ХК-ийн охин компани

2	**"М би си ази пасифик"**	2005.11.03	- Гадаад худалдаа - Хүнсний болон жижиглэн худалдаа - Шар айраг үйлдвэрлэл	П.Батсайхан	АПУ ХК-ийн охин компани
3	**"Апу дэйри" ХХК**	2017.09.22	- Сүү ,сүүн бүтээгдэхүүн, жүүс, ундааны бөөний болон жижиглэнгийн худалдаа; - Жүүс ундаа үйлдвэрлэл; - Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл; - Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа	П.Батсайхан	АПУ ХК-ийн охин компани
4	**"Апу трейдинг" ХХК**	2006.12.26	- Гадаад худалдаа; - Хүнсний бөөний худалдаа;	П.Батсайхан	АПУ ХК-ийн охин компани
5	**"Жи эс би актив ТЗК" ХХК**	2022.10.19	- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах	П.Батсайхан	Жи эс би капитал ХХК-ийн охин компани
6	**"Амиланэ" ХХК**	2009.10.30	- Гадаад худалдаа; - Гэрэл зурагчин; - Хувцасны загвар зохион бүтээх; - Үсчин, гоо сайхан; - Бизнесийн зөвлөгөө өгөх	П.Батсайхан	"Медиа групп" ХХК-ийн охин компани
7	**"Монзах" ХХК**	2006.06.21	- Байр түрээслүүлэх үйл ажиллагаа; - Өвөрхангай аймгийн Арвайхээр болон дараах сумдад телевизийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх, Үүнд Бат-Өлзий, Баян-Өндөр, Баянгол, Баруунбаян-Улаан, Бүрд, Богд, Гучин Ус, Есөнзүйл, Зүүнбаян-Улаан, Нарийнтээл, Өлзийт, Сант, Уянга, Тарагт, Төгрөг, Хархорин, Хайрхандулаан, Хужирт		"Медиа групп" ХХК-ийн охин компани

8	**"Эн ти ви броадкастинг" ХХК**	2006.02.15	- Телевизийн өргөн нэвтрүүлэг бэлтгэх болон дамжуулах үйл ажиллагаа; - Улаанбаатар хотод хэт богино долгионы радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх; - Улаанбаатар хотод радио давтамж ашиглах	П.Батсайхан	"Медиа групп" ХХК-ийн охин компани
9	**"И Зэт Эф Эм" ХХК**	2024.08.01	- Гадаад худалдаа	П.Батсайхан	"Медиа групп" ХХК-ийн охин компани
10	**"Эс би ти эм" ХХК**	2016.03.18	- Төсөл хөтөлбөр боловсруулах; - Гадаад худалдаа; - Менежментийн зөвлөгөө өгөх	П.Батсайхан	"Эс девелопмент" ХХК-ийн охин компани
11	**"Пийс ривер" ХКХ**	2018.01.25	- Гадаад худалдаа; - Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх; - Аялал жуулчлал	П.Батсайхан	"Эс девелопмент" ХХК-ийн хараат компани
12	**"Сүрэн алт" ХХК**	2008.02.21	- Аялал жуулчлал; - Хүнсний дэлгүүр	П.Батсайхан	"Эс девелопмент" ХХК-ийн хараат компани
13	**"Эс жи коммодитис" ХХК**	2022.04.06	- Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа	П.Батсайхан	Шунхлай Говь ХХК-ийн охин компани
14	**"Скайстрим" ХХК**	2020.08.26	- Программ хангамжийн үйл ажиллагаа; - Мэдээлэл технологийн үйл ажиллагаа	П.Батсайхан	Скэйтел ХХК-ийн охин компани
15	**"Скайнэтворкс" ХХК**	2010.12.14	- Мэдээллийн технологи, интернэтийн үйлчилгээ - Мэдээлэл харилцаа холбооны шинэ техник технологи нэвтрүүлэх	С. Батболд П. Батсайхан Ж.Оджаргал	Скэйтел ХХК-ийн охин компани
16	**"Скаймедиа корпораци" ХХК**	2006.11.23	- Программ хангамжийн үйл ажиллагаа; - Мэдээллийн технологийн үйлчилгээ;	Скаймедиа корпорац Даблью Би эн Телемакс коммуникэйшн	Скэйтел ХХК-ийн охин компани

			- Программ хангамжийн түр сургалт		
17	**"Баянтээг" ХК**	2012.06.04	- Чулуун нүүрс олборлолт - Өргөн хэрэглээний барааны дэлгүүр	-	"Шунхлай Холдинг" ХХК-ийн хараат компани
18	**"Эс Жи Шивээ хүрэн депо" ХХК**	2022.02.07	- 46100 - Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа - 49230 - Авто машинаар ачаа тээвэрлэх	П.Батсайхан	"Шунхлай петролиум" ХХК-ийн охин компани
19	**Эс Жи Ханги гэйт**	2022.02.11	- 46100 - Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа - 49230 - Авто машинаар ачаа тээвэрлэх	П.Батсайхан	"Шунхлай петролиум" ХХК-ийн охин компани
20	**"Жи Эс Би актив хоёр ТЗК" ХХК**	2025.07.02	- 66300 - Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах	П.Батсайхан	Жи Эс Би Капитал ББСБ
21	**"Пабликмеди" ХХК**	2011.06.23	- Бизнесийн зөвлөгөө өгөх - Гадаад худалдаа - Веб сайтын үйлчилгээ - Реклам, зар сурталчилгаа	П.Батсайхан	"Медиагруп п" ХХК-ийн охин комапани
22	**"Скайхаб сольюшнс" ХХК**	2026.02.28	- 58200 - Программ хангамжийн үйлчилгээ - 63910 - Мэдээллээр үйлчлэх үйл ажиллагаа - 46510 - Компьютер, түүний дагалдах хэрэгсэлийн худалдаа - 62090 - Мэдээлэл технологийн үйл ажилагаа	П.Батсайхан	"Скайтел" ХХК-ийн охин компани
24	**"Оранж планет" ХХК**	2025.12.03	- 70200 - Менежментийн зөвлөгөө өгөх - 58200 - Программ хангамжийн үйл ажиллагаа - 82990 - Бизнесийн зөвлөгөө өгөх - 62090 - Мэдээлэл технологийн үйл ажиллагаа	П.Батсайхан	"Шунхлай Холдинг" ХХК-ийн охин компани

			- 82190 - Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх - 63120 - Вэб сайтын үйлчилгээ		
25	**"Эс Жи Пи И" ХХК**	2025.10.07	- 70200 - Менежментийн зөвлөгөө өгөх - 82190 - Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх - 82990 - Бизнесийн зөвлөгөө өгөх	П.Батсайхан	"Шунхлай холдинг" ХХК-ийн охин компаниуд хувьцааг нь хамтран эзэмшиж байна.
26	**"СББ трейд" ХХК**	2006.11.29	- 4610 - Гадаад худалдаа - 4669 - Бөөний худалдаа	П.Батсайхан	"АПУ" ХХК-ийн охин компани
27	**"Шунхлай инженеринг" ХХК**	2026.04.08	- 70200 - Менежментийн зөвлөгөө өгөх - 82190 - Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх - 82990 - Бизнесийн зөвлөгөө өгөх	П.Батсайхан	"Шунхлай Холдинг" ХХК-ийн охин компани
28	**"Шунхлай спортс" ХХК**	2026.07.21	- 85410 - Спортын сургалт зохион байгуулах - 82190 - Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх - 90000 - Спорт, урлагийн арга хэмжээ зохион байгуулах - 47630 - Спортын хувцас, хэрэглэлийн худалдаа - 73100 - Зар, сурталчилгаа хийх - 82990 - Бизнесийн зөвлөгөө өгөх - 70200 - Менежментийн зөвлөгөө өгөх	П.Батсайхан	"Шунхлай Холдинг" ХХК-ийн охин компани

Дээрх байдлаас үзвэл "Шунхлай холдинг" ХХК, түүний охин болон хараат нийт 56 компаниуд нь үнэт цаас гаргагчтай зэргэлдээ компани болох бөгөөд эдгээр компаниуд нь КтХ-ийн 6 дугаар зүйлийн 6.14, 6.16-т тус тус заасан компанийн нэгдэл, түүний оролцогчид гэж үзэхээр байна.

3.9.4. <u>Үнэт цаас гаргагчийн эцсийн өмчлөгчийн тухай:</u>

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6.а-д *"'Эцсийн өмчлөгч" гэж харилцагч нь хуулийн этгээд бол тухайн*

хуулийн этгээдийн хөрөнгийн дийлэнх хэсгийг дангаараа, эсхүл бусадтай хамтран өмчилж байгаа, эсхүл тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж, эсхүл өөрийн үйлдлийг бусдаар төлөөлүүлэн хийлгэж байгаа, эсхүл хуулийн этгээдийг болон уг хуулийн этгээдээс хийх аливаа хэлцэл, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдах замаар тухайн хуулийн этгээдийг өмчилж ур шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг" гэж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/208 дугаартай тушаалаар батлагдсан "Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам"-ын 6[1].9-т "*Энэ журмын 6[1].7-д заасан "хөрөнгийн дийлэнх хэсэг" гэж КтХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсэгт заасан тухайн компанийн нийт хувьцааны гуравны нэг буюу түүнээс дээш хэмжээний хувьцаа, Монгол банкны Ерөнхийлөгчийн 2019 оны А-26 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам"-ын 4.3-т заасан тухайн хуулийн этгээдийн хөрөнгийн 33, түүнээс дээш хувийг ойлгоно*" гэж тус тус заасан.

Үнэт цаас гаргагчийн "хөрөнгийн дийлэнх хэсэг" буюу КтХ-ийн 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсэгт зааснаар компанийн нийт хувьцааны гуравны нэг буюу түүнээс дээш хувийг "Шунхлай холдинг" ХХК эзэмшиж байгаа нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэл цахим сан www.opendata.burtgel.gov.mn-д байршсан мэдээлэл болон 2026 оны 08 сарын 19-ний өдрийн Улсын бүртгэлийн ерөнхий газрын "Хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа"-наас харагдаж байна.

Түүнчлэн П.Батсайхан нь 2020 оны 12 сарын 23-ны өдөр "Шунхлай" ХХК-ийн эцсийн өмчлөгчөөр, 2025 оны 09 сарын 08-ны өдөр нь толгой компани болох "Шунхлай холдинг" ХХК-ийн эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн байна.

Тиймээс П.Батсайхан нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6.а-д заасны дагуу "Шунхлай" ХХК-ийн эцсийн өмчлөгч мөн байна. Мөн энэ талаар үнэт цаас гаргагч нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын "Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн лавлагаа"-г авч ирүүлсэн байна.

Дүгнэлт: Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийн эцсийн өмчлөгчөөр П.Батсайхан 2020 оны 12 сарын 23-ны өдөр бүртгүүлсэн нь хүчинтэй байна. Үнэт цаас гаргагчийн толгой компани болох "Шунхлай Холдинг" ХХК-ийн компаниудын нэгдлийн нийт 56 компанийг үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компани гэж үзэхээр байна. Үнэт цаас гаргагч нь "Шунхлай ойл" ХХК-ийн хувьцааг дангаараа эзэмшдэг тул эдгээр нь үнэт цаас гаргагчийн охин компани байна.

3.10. Үнэт цаас гаргагч нь аж ахуйн үйл ажиллагааны эрэг гэмт хэрэг, иргэн, захиргааны хэрэгт хариуцагчаар татагдаж байсан эсэх:

3.10.1. Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК нь Эрүүгийн хэрэгт хариуцлага хүлээж байсан эсэх:

Цагдаагийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.10[84] -т зааснаар Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн хүрээнд гэмт хэрэг, зөрчил,

[84] Цагдаагийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.10 "гэмт хэрэг, зөрчил, тэдгээрт шийтгүүлсэн этгээдийн нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, лавлагаа гаргах"

ШУНХЛАЙ СЗХ 2026.09.10 БҮРТГЭВ № 01

2026-09-02 БҮРТГЭВ-03

тэдгээрт шийтгүүлсэн этгээдийн нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, лавлагаа гаргах бүрэн эрхийг хэрэгжүүлдэг.

Мөн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт "*Мэдээлэл хариуцагч нь хүн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үзүүлж байгаа үйлчилгээгээ төрийн үйлчилгээний нэгдсэн системийг ашиглан үзүүлнэ*" хэмээн заасны дагуу Төрийн үйлчилгээний нэгдсэн систем болох E-Mongolia системээр дамжуулан Цагдаагийн ерөнхий газрын 2026 оны 08 сарын 19-ний өдрийн "Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт", мөн өдрийн "Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт"-ыг тус тус авсан байна.

Үнэт цаас гаргагчийн дээрх байдлаар Төрийн үйлчилгээний нэгдсэн систем болох E-Mongolia системээр дамжуулан авсан тодорхойлолтуудаар эрүүгийн хариуцлага хүлээгээгүй байгаа нь тус тус харагдаж байна.

Дээрх тодорхойлолтууд нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 05 сарын 05-ны өдрийн 125 дугаар тогтоолоор батлагдсан "*Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангаас лавлагаа, мэдээлэл өгөх журам*"-ын 4.1[85], 4.2[86]-т заасны дагуу олгогдсон, хүчинтэй байгаа тул Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-ийг эрүүгийн хэрэгт хариуцлага хүлээж байгаагүй гэж үзнэ.

3.10.2. Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК нь иргэний хэрэгт хариуцагчаар оролцож байсан эсэх:

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2021 оны 02 сарын 26-ны өдрийн 20 дугаар тогтоолоор батлагдсан "Шүүхийн тусгай архивын дүрэм"-ийн 3.1.11[87]-т зааснаар Архивын үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг Шүүхийн тусгай архив хэрэгжүүлдэг.

Харин Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2016 оны 02 сарын 03-ны өдрийн 03 дугаар тогтоолоор батлагдсан "Шүүхийн архивын ажиллах журам"-аар архивын үйлчилгээ үзүүлэх харилцааг зохицуулдаг ба 10.1[88]-т архивын лавлагаа олгох үйлчилгээ төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотойгоос бусад нь нээлттэй байна гэж заасан.

Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК-д Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн тусгай архиваас 2026 оны 08 сарын 19-ний өдрийн 05/4698 тоот албан бичгээр "Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн *9011068082 хувийн хэргийн дугаартай "Шунхлай" ХХК /РД:2028468/ нь сүүлийн 3 жилийн байдлаар Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүх, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүх, Дүүргийн Эрүү, Иргэний хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх, Багахангай, Налайх дүүргийн Иргэний*

---

[85] Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 05 сарын 05-ны өдрийн 125 дугаар тогтоолоор батлагдсан "Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангаас лавлагаа, мэдээлэл өгөх журам"-ын 4.1 "Төрийн цахим үйлчилгээний E-Mongolia нэгдсэн системээс улсын бүртгэлийн лавлагааг тоон гарын үсэг ашиглан цахим хэлбэрээр авч болно"

[86] Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 05 сарын 05-ны өдрийн 125 дугаар тогтоолоор батлагдсан "Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангаас лавлагаа, мэдээлэл өгөх журам"-ын 4.2 "Энэ журмын 4.1-д заасан лавлагаа нь "QR" кодоор баталгаажих боломжтой Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12.10-т заасантай нэгэн адил хүчинтэй байна."

[87] Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2021 оны 02 сарын 26-ны өдрийн 20 дугаар тогтоолоор батлагдсан "Шүүхийн тусгай архивын дүрэм"-ийн 3.1.11 "Архивын үйлчилгээ үзүүлэх"

[88] Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2016 оны 02 сарын 03-ны өдрийн 03 дугаар тогтоолоор батлагдсан "Шүүхийн архивын ажиллах журам"-ын 10.1 "Архивын лавлагаа, хуулбар олгох, баримтыг сургалт, судалгааны зорилгоор ашиглуулах үйлчилгээ төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотойгоос бусад нь нээлттэй байна."

УЛААНБААТАР ХОТ ШУНХЛАЙ ХХК УГА0531 № 2028468

Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital Delivering diversity

хэргийн анхан шатны тойргийн шүүх, Багануур дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн иргэний хэрэгт тус тус хариуцагчаар оролцож байгаагүй болохыг тодорхойлов" гэсэн нь дээр дурдсан журмын дагуу, эрх бүхий байгууллагаас олгогдсон, хүчинтэй байх тул иргэний хэрэгт хариуцагчаар оролцож байгаагүй гэж үзнэ.

Мөн Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрын 2026 оны 08 сарын 20-ны өдрийн 4/2633 тоот албан бичгээр "*...Шунхлай" ХХК /РД:2028468/ нь 2026 оны 08 сарын 20-ны өдрийн байдлаар нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцоогүй болно*" гэж тодорхойлсон байна.

3.10.3. Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК нь захиргааны хэрэгт нэхэмжлэгч болон гуравдагч этгээдээр оролцож байсан эсэх:

Нийслэл дэх захиргааны хэргийн Анхан шатны шүүхийн тамгын газрын 2026 оны 08 сарын 20-ны өдрийн 746 тоот албан бичгээр "*Шунхлай" ХХК /Улсын бүртгэлийн 9011038082, Регистрийн дугаар 2028468/ нь захиргааны хэрэг хянан шийдвэр ажиллагаанд нэхэмжлэгч болон гуравдагч этгээдээр 3 жилд оролцож байгаагүй болно"* гэж тодорхойлжээ.

Уг тодорхойлолт нь эрх бүхий байгууллагаас зохих журмын дагуу олгогдсон, хүчинтэй байх тул үнэт цаас гаргагчийг захиргааны хэрэгт нэхэмжлэгч, гуравдагч этгээдээр оролцож байгаагүй гэж үзнэ.

Дүгнэлт: Төрийн үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia-аас 2026 оны 08 сарын 19-ний өдөр авсан "Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт", "Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт", Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн тусгай архивын 2026 оны 08 сарын 19-ний өдрийн 05/4698 тоот албан бичиг, Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрын 2026 оны 08 сарын 20-ны өдрийн 4/2633 албан бичиг, Нийслэл дэх захиргааны хэргийн Анхан шатны шүүхийн тамгын газрын 2026 оны 08 сарын 20-ны өдрийн 746 тоот албан бичиг зэрэг эрх бүхий байгууллагаас, холбогдох журмын дагуу олгогдсон, хүчинтэй тодорхойлолт, лавлагаагаар үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК нь эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй ба иргэний, арбитрын хэрэгт хариуцагч, захиргааны хэрэгт нэхэмжлэгч, гуравдагч этгээдээр оролцож байгаагүй болох нь тогтоогдож байна.

3.11. Татвар, нийгмийн даатгал болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт ор төлбөртэй эсэх:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2026 оны 08 сарын 19-ний өдрийн "Шүүхийн шийдвэрээр бусдад төлбөргүй эсэх тодорхойлолт (ААНБ)"-оор "*Регистрийн 2028468 дугаартай Шунхлай Хязгаарлагдмал хариуцлагатай компани нь шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд төлбөргүй болохыг тодорхойлов*" гэсэн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт зааснаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага улсын хэмжээнд иргэний шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй этгээдийн талаарх мэдээллийг цахим бүртгэлд оруулж, төлбөртэй этгээдийн бүртгэл хөтлөх үүрэгтэй байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, мөн зүйлийн 24.3, 32[1] дугаар зүйлийн 32[1].8 дахь хэсгийг тус тус заасны дагуу

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 03 сарын 15-ны өдрийн 100 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас хүн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны журам"-ын дагуу Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан "Шунхлай" ХХК-ийн "шүүхийн шийдвэрээр бусдад өр төлбөртэй эсэх" талаарх тодорхойлолтыг авсан тул уг тодорхойлолт нь хуульд заасны дагуу хүчин төгөлдөр тодорхойлолт байна. Иймд "Шунхлай" ХХК-ийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт өр төлбөргүй гэж үзнэ.

2. Татварын Ерөнхий газрын цахим системд 2026 оны 08 сарын 25-ны өдөр үүсгэсэн тодорхойлолтоор "Шунхлай" ХХК нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар болон холбогдох бусад албан татварын өр төлбөргүй, илүү төлөлттэй байна. Энэ нь ТЕГ-ын 2019 оны А/146 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан "Татвар төлөгчид тодорхойлолт, лавлагаа олгох журам"-ын дагуу олгогдсон, хүчинтэй тодорхойлолт байх тул татварын өр төлбөргүй гэж үзнэ.

3. Нийгмийн даатгалын ерөнхий газраас 2026 оны 08 сарын 21-ний өдөр гаргасан "Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа"-д Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийн дүн 00.00 буюу өргүй байна. Уг тодорхойлолт нь Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2015 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Нийгмийн даатгалын байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд мэдээлэл, лавлагаа олгох журам"-ын дагуу авагдсан, 30 хоногийн хүчинтэй хугацаатай тодорхойлолт байна.

4. Гаалийн ерөнхий газрын 2026 оны 08 сарын 19-ний өдрийн "*Гаалийн байгууллагад татварын өртэй эсэх тодорхойлолт (ААН)*"-оор Улсын бүртгэлийн 9011068082, РД 2028468-тай Шунхлай ХХК нь 2026 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн байдлаар гаалийн байгууллагад өртэй болно хэмээн тодорхойлжээ. Уг тодорхойлолт нь 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэгт импортын бараанд албан татвар ногдуулах журмыг заасан байна. Тус зүйлийн 16.2.5 дахь хэсэгт "*газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа, үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн импортоор оруулж байгаа компанийн нөөц бүрдүүлэхээс бусад Монгол Улсын 30 хоногийн хэрэглээтэй тэнцэх хэмжээний автобензин, дизелийн түлшинд ногдох нэмэгдсэн өртгийн албан татварыг 30 хоногоор хойшлуулан ногдуулна*" хэмээн заасны дагуу импортоор оруулсан бараанд ногдох нэмэгдсэн өртгийн албан татварыг 30 хоногоор хойшлуулан төлж байгаа талаар "Шунхлай" ХХК-иас 2026 оны 08 сарын 13-ны өдрийн В/1313 тоот албан мэдэгдлийг хуулийн фирмд ирүүлсэн болно. Тиймээс хойшлуулан төлж буй татвар нь Татварын Ерөнхий хуулийн 50 дугаар зүйлд заасан татварын өрд хамаарахгүй байна.

Гаалийн ерөнхий газар нь Гаалийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3[89]-т зааснаар гаалийн мэдүүлэгт үндэслэсэн гаалийн мэдээллийн санг бүрдүүлж, хөтлөх үүрэг хүлээдэг ба иргэн хуулийн этгээд мэдээлэл, лавлагаа авах эрхтэй байна. Иймд Гаалийн ерөнхий газрын 2026 оны 08 сарын 19-ний өдрийн "*Гаалийн байгууллагад татварын өртэй эсэх тодорхойлолт (ААН)*" тодорхойлолт нь эрх бүхий байгууллагаас гаргасан, хүчинтэй тодорхойлолт байна.

---

[89] Гаалийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 "Гаалийн удирдах төв байгууллага нь энэ хуулийн 13.1-д заасан мэдээллийг гаргах зорилгоор гаалийн мэдүүлэгт үндэслэсэн гаалийн мэдээллийн санг бүрдүүлж, хөтлөнө";

СЗХ
2026 оны 09 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№

SULIAN STOCK EXCHANGE
2026 -09- 02
БҮРТГЭВ-03

5. Зээлийн мэдээллийн сангаас 2026 оны 08 сарын 20-ны өдөр авсан №1000000543071148 дугаартай "Хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх лавлагаа"-аар "Шунхлай" ХХК-ийн 77 ширхэг зээл, төлбөрүүд нь бүгд хэвийн ангилалтай, чанаргүй зээл байхгүйг тодорхойлсон байна.

Дүгнэлт: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Шийдвэр гүйцэтгэх албаны 2026 оны 08 сарын 19-ний өдрийн тодорхойлолт, Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2026 оны 08 сарын 21-ний өдрийн лавлагаа, Гаалийн ерөнхий газрын 2026 оны 08 сарын 19-ний өдрийн тодорхойлолт, Татварын ерөнхий газрын 2026 оны 08 сарын 25-ны өдрийн тодорхойлолт, Зээлийн мэдээллийн сангийн 2026 оны 08 сарын 20-ны өдрийн лавлагаагаар үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, татвар, нийгмийн гаалийн байгууллагад өр төлбөргүй, зээлүүд нь хэвийн ангилалтай болох нь тогтоогдож байна.

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
УТА3531 ᠓ 2028466

339

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
1119289111 ☎ 5481589
Улаанбаатар хот

2026.08.31

ШУНХЛАЙ ХХК 2025.09.10 өдөр БҮРТГЭВ № 01

MONGOLIAN STOCK EXCHANGE 2026-09-02 БҮРТГЭВ-03

IV. ТАНИЛЦСАН БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Танилцсан баримт бичиг
1.	"Шунхлай" ХХК-ийн дотоод бүтэц.
2.	"Шунхлай" ХХК-ийн гэрчилгээ.
3.	"Шунхлай" ХХК-ийн дүрэм.
4.	"Монголын хөрөнгө оруулалтын зэрэглэлийн эжинси" ХХК-ийн 2025 оны 08 сарын 27-ний өдрийн хурлын 27 дугаар тогтоол, "Зээлжих зэрэглэлийн Үнэлгээний тайлан" "Шунхлай" ХХК.
5.	Компанийн эрх бүхий албан тушаалтнуудын иргэний үнэмлэхийн лавлагаа, анкет, боловсролын гэрчилгээ, сургалтын гэрчилгээ, "ажилд авах тухай" албан тушаал, шүүхийн шийдвэрээр бусдад төлбөргүй эсэх тодорхойлолт, хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөртэй эсэх лавлагаа, Эрүүгийн хэрэгт холбогдож байсан эсэх, байгаа эсэх тодорхойлолтууд.
6.	Өмгөөллийн "Легал Полиси" ХХК-ийн Улсын бүртгэлийн гэрчилгээ, үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх олгосон тогтоол;
7.	"Ниямазон" ХХК-ийн Улсын бүртгэлийн гэрчилгээ,
8.	"Ниямазон" ХХК-ийн аудитын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн гэрчилгээ
9.	"Шунхлай" ХХК-ийн хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа, Улсын бүртгэлийн гэрчилгээ
10.	"Эс Жи Ханги Гэйт" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ
11.	"Эс Жи шивээ хүрэн депо" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ
12.	"Шунхлай говь" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ
13.	"Шунхлай ойл" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ
14.	"Шунхлай петролиум" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ
15.	"Шунхлай трейдинг" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ
16.	Шунхлай ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2018 оны 10 сарын 25-ний өдрийн 15 тоот "Гүйцэтгэх захирал томилох тухай" тогтоол
17.	"Монголын хөрөнгө оруулалтын зэрэглэлийн эжинси" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ
18.	"Монголын хөрөнгө оруулалтын зэрэглэлийн эжинси" ХХК-ийн Санхүүгийн чадавхын зэрэглэл тогтоох тусгай зөвшөөрөл
19.	"Голомт капитал" ҮЦК" ХХК-ийн Улсын бүртгэлийн гэрчилгээ,
20.	"Голомт капитал" ҮЦК" ХХК-ийн татвар төлөгчийн гэрчилгээ
21.	"Шунхлай" ХХК-ийн 2026 оны 08 сарын 18-ны өдрийн В/1319 тоот албан бичиг;
22.	"Шунхлай" ХХК-ийн 2026 оны 08 сарын 28-ны өдрийн В/1360 тоот албан бичиг;
23.	"Шунхлай" ХХК-ийн 2026 оны 08 сарын 18-ны өдрийн В/1316 тоот албан бичиг;
24.	"Шунхлай" ХХК-ийн 2026 оны 08 сарын 18-ний өдрийн В/1315 тоот албан бичиг;
25.	"Шунхлай" ХХК-ийн 2026 оны 06 сарын 28-ний өдрийн В/1359 тоот албан бичиг;
26.	"Шунхлай" ХХК-ийн 2026 оны 08 сарын 21-ний өдрийн В/1341 тоот албан бичиг;
27.	"Шунхлай" ХХК-ийн 2026 оны 08 сарын 21-ний өдрийн В/1342 тоот албан бичиг;
28.	Үнэт Цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн 2026 оны 08 сарын 20-ны өдрийн 02/935 тоот тодорхойлолт;
29.	Авто тээврийн үндэсний төвийн 2026 оны 08 сарын 19-ны өдрийн "Автотээврийн хэрэгсэл эзэмших, өмчлөх эрхийн лавлагаа (ААН одоо эзэмшиж байгаа)";
30.	Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн тусгай архивын 2026.08.19-ний өдрийн 05/4698 тоот албан бичиг;
31.	Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Монголын Олон улсын Арбитрын 2026.08.20-ны өдрийн 4/2633 тоот албан бичиг;

УЛААНБААТАР ХОТ ШУНХЛАЙ ХХК ТТА3531 ОХ 2029468

Голомт капитал ҮЦК ХХК Golomt Capital Delivering diversity 1119289111 5881589 Улаанбаатар хот

32.	Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2026.08.19-ны өдрийн Хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч, гишүүний лавлагаа
33.	Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн тамгын газрын 2026.08.20-ны өдрийн 746 тоот албан бичиг;
34.	Цагдаагийн ерөнхий газрын 2026.08.19-ний өдрийн "Шунхлай" ХХК-ийн хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх болон байсан эсэх тухай тодорхойлолт;
35.	Гаалийн ерөнхий газрын 2026.08.19-ны өдрийн Гаалийн байгууллагад татварын өртэй эсэх тодорхойлолт;
36.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2026.08.19-ний өдрийн "Шүүхийн шийдвэрээр бусдад төлбөргүй эсэх тодорхойлолт (ААНБ)"
37.	"Шунхлай" ХХК-ийн 2026.08.20-ны өдөр авсан Зээлийн мэдээллийн сангийн лавлагаа;
38.	"Шунхлай" ХХК-ийн 2026.08.21-ний өдөр авсан Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт;
39.	Татварын ерөнхий газрын 2026 оны 08 сарын 25-ны өдрийн "Татварын өрийн үлдэгдлийн лавлагаа"
40.	Татварын ерөнхий газрын 2026 оны 08 сарын 19-ний өдрийн "Татварын өрийн үлдэгдлийн лавлагаа"
41.	Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2026 оны 08 сарын 21-ны өдрийн "Үл хөдлөх хөрөнгө бүртгэлтэй эсэх лавлагаа"
42.	Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2026 оны 08 сарын 19-ны өдрийн "Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн лавлагаа"
43.	Зөвшөөрлийн цахим систем дээр байрлаж буй "Шунхлай" ХХК-ийн "Бүх төрлийн шатахуун импортлох тусгай зөвшөөрөл";
44.	Зөвшөөрлийн цахим систем дээр байрлаж буй "Шунхлай" ХХК-ийн "Бүх төрлийн шатахууны бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл";
45.	"Шунхлай" ХХК-ийн 2608/25 дугаартай 0.4-35 кв цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт түүний туршилт, тохируулга дагалдах ажил, үйлчилгээ эрлэх тусгай зөвшөөрөл
46.	Монгол Улсын Оюуны өмчийн газрын Барааны тэмдгийн гэрчилгээ;
47.	Шунхлай ХХК-ийн ISO 14001:2015, ISO 45001:2018 гэрчилгээ
48.	Төрийн үйлчилгээний нэгдсэн систем дэх Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны 08 сарын 21-ний өдрийн "Үл хөдлөх хөрөнгийн лавлагаа (хуулийн этгээд)", үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээнүүд – 20 ширхэг.
49.	"Шунхлай" ХХК-ийн 2022 оны санхүүгийн аудитын тайлан.
50.	"Шунхлай" ХХК-ийн 2023 оны санхүүгийн аудитын тайлан.
51.	"Шунхлай" ХХК-ийн 2024 оны санхүүгийн аудитын тайлан.
52.	"Шунхлай" ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан
53.	"Шунхлай" ХХК-ийн 2026 оны 06 сарын 30-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлан
54.	"Шунхлай" ХХК-аас компанийн өрийн хэрэгсэл гаргаж буйтай холбоотой хууль зүйн дүгнэлтэд тусгагдсан сонирхлын зөрчилтэй хэлцлүүд
55.	"Шунхлай" ХХК-ийн хөдөлмөрийн гэрээний төсөл
56.	"Шунхлай" ХХК-ийн оффисын ажилтантай хийх хөдөлмөрийн гэрээний төсөл
57.	"Шунхлай" ХХК-ийн эрхлэгчтэй хийх хөдөлмөрийн гэрээний төсөл
58.	"Шунхлай" ХХК-ийн хөлсөөр ажиллах гэрээний төсөл
59.	"Шунхлай" ХХК-ийн ажил гүйцэтгэх гэрээний төсөл
60.	Газрын тосны бүтээгдэхүүн тээвэрлэх, тээвэрлүүлэх гэрээний төсөл

341

2026.08.31

61.	"Шунхлай" ХХК-аас компанийн өрийн хэрэгсэл гаргаж буйтай холбоотой хууль зүйн дүгнэлтийн 3.3 дахь хэсэгт дүгнэсэн, хүснэгтээр оруулсан дүрэм журмууд.
62.	"Шунхлай" ХХК-аас компанийн өрийн хэрэгсэл гаргаж буйтай холбоотой хууль зүйн дүгнэлтийн 3.7 дахь хэсэгт дүгнэсэн зээлийн гэрээнүүд.
63.	"Шунхлай" ХХК-аас компанийн өрийн хэрэгсэл гаргаж буйтай холбоотой хууль зүйн дүгнэлтийн 3.7 дахь хэсэгт дүгнэсэн барьцааны гэрээнүүд.
64.	"Шунхлай" ХХК-аас компанийн өрийн хэрэгсэл гаргаж буйтай холбоотой хууль зүйн дүгнэлтийн 3.4 дахь хэсэгт дүгнэсэн гэрээнүүд.
65.	"АПУ" ХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм.
66.	"Баянтээг" ХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм.
67.	"Бүүст интелиженс" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм.
68.	"Боршоонбуянт" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм.
69.	"Дижитал концепт" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм.
70.	"Ди Эс Жи" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм.
71.	"Фандиа" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм.
72.	"Жи Эс Би капитал ББСБ" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм.
73.	"Жи Эс Би майнинг" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм.
74.	"Хьюндаймоторс монгол" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм.
75.	"Киамоторс" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм.
76.	"Медиа групп" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм.
77.	"Монгол Моторс Групп" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм.
78.	"Монголианроуд констракшн" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм.
79.	"Оранж Эйр" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм.
80.	"Пауэр-Юнит" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм.
81.	"Эс девелопмент" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм.
82.	"Эс Ди инженеринг энд констракшн" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм.
83.	"Эс Ди сервис" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм.
84.	"Эс Жи инвестмент энд секьюритис" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм.
85.	"Шунхлай Холдинг" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм.
86.	"Скайтел" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм.
87.	"Сантранс ложистик" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм.
88.	"Tengri Tech" Pte.Ltd -ийн улсын бүртгэлийн гэрчилгээ.
89.	"Улаанбаатар синема" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм.
90.	"Зеро технологи" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм.
91.	"Эс Жи комидитис" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм
92.	"Пауэр юнит" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм
93.	"Ниямазон" ХХК-ийн 2026.08.28-ний өдрийн 08/28 дугаартай "Тодорхойлолт"
94.	"Шунхлай говь" ХХК-ийн аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн гэрчилгээ.
95.	"Шунхлай петролиум" ХХК-ийн аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн гэрчилгээ.
96.	"Шунхлай трейдинг" ХХК-ийн аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн гэрчилгээ.

342

2026.08.31

ШУНХЛАЙ ХХК 2026 09 10 БҮРТГЭЛ № 01

MONGOLIAN STOCK EXCHANGE 2026-09-02 БҮРТГЭЛ-03

V. ЭРХ ЗҮЙН ЭХ СУРВАЛЖ

1. Монгол Улсын Үндсэн хууль /1992 он/.
2. Иргэний хууль /2002 он/.
3. Компанийн тухай хууль /2011 он/.
4. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /2018 он/.
5. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль /2013 он/.
6. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль /2012 он/.
7. Өмгөөллийн тухай хууль /2019 он/.
8. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль /2015/.
9. Аудитын тухай хууль /2015 он/.
10. Хөдөлмөрийн тухай хууль /2021 он/
11. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль /2008 он/
12. Байгаль орчныг хамгаалах тухай хууль /1995 он/.
13. Зөвшөөрлийн тухай хууль /2022 он/.
14. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль /2005 он/
15. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль /2009 он/
16. Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль /2015 он/
17. Патентын тухай хууль /2021/
18. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль /2013/.
19. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль /2021 он/.
20. Татварын ерөнхий хууль /2019 он/.
21. Гаалийн тухай хууль /2008 он/.
22. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль /2015 он/.
23. Хууль зүйн сайдын 2013 оны 01 сарын 31-ний өдрийн А/12 тоот тушаалаар батлагдсан "Шүүхээр ял шийтгэгдсэн хүмүүсийн тоо бүртгэл хөтлөх, лавлагаа олгох заавар".
24. Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2021 оны 02 сарын 26-ны өдрийн 20 дугаар тогтоолоор батлагдсан "Шүүхийн тусгай архивын дүрэм".
25. Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2021 оны 10 сарын 01-ны өдрийн 56 дугаар тогтоолоор батлагдсан "Шүүхийн архивын ажиллах журам".
26. Засгийн газрын 2023 оны 03 сарын 15-ны өдрийн 100 дугаар "Журам, жагсаалт, загвар батлах тухай" тогтоол.
27. Засгийн газрын 2023 оны 07 сарын 05-ны өдрийн 251 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Зөвшөөрлийн нэгдсэн сангийн мэдээлэл, түүнийг бүрдүүлэх, уг санд зөвшөөрлийг бүртгэх, лавлагаа, мэдээлэл өгөх журам".
28. Засгийн газрын 2021 оны 125 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангаас лавлагаа, мэдээлэл өгөх журам".
29. Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 09 сарын 01-ний өдрийн А/219 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төлбөртэй этгээдийн бүртгэл хөтлөх тодорхойлолт, лавлагаа гаргах журам".
30. ТЕГ-ын 2019 оны 146 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан "Татвар төлөгчид тодорхойлолт, лавлагаа олгох журам".
31. Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2015 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Нийгмийн даатгалын байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд мэдээлэл, лавлагаа олгох журам".

УЛААНБААТАР ХОТ ШУНХЛАЙ ХХК ТЛА3631 ☎ 2028488

343

Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital Delivering diversity 1119289111 ☎ 5481589 Улаанбаатар хот

2026.08.31

32. СЗХ-ны 2021.06.11-ны өдрийн 226 дугаар тогтоолоор батлагдсан "Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам".
33. СЗХ-ны 2021.06.11-ний өдрийн 225 дугаар батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам".
34. СЗХ-ны 2022.03.23-ны өдрийн 145 тоот тогтоолоор батлагдсан "Компанийн засаглалын кодекс".
35. Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 179 дугаар тогтоолоор батлагдсан "Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам".

ШУНХЛАЙ ХХК
2026.09.10
БҮРТГЭВ
№ 01

2026-09-02
БҮРТГЭВ-03

VI. САНАМЖ:

Энэхүү хууль зүйн дүгнэлт нь үнэт цаас гаргагч компанитай холбоотой бүхий л мэдээллийг хамарсан гэж үзэх боломжгүй ба үнэт цаасаа олон нийтэд санал болгон гаргахтай холбогдон мэдээлэл хүлээж авах эрх бүхий холбогдох байгууллагуудад зориулагдсан болно. Дүгнэлтийг бусад гуравдагч этгээдэд зориулагдаагүй, өөр зорилгоор ашиглаж, хуулбарлан нийтэд тараахыг хориглоно.

Хууль зүйн дүгнэлтийг боловсруулах явцад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, эрх зүйн зх сурвалж, аливаа үйл баримт, өөрчлөгдсөнтэй холбоотой дүгнэлтийн утга агуулга, үндэслэл гажуудсан эсхүл хуурамч баримт бичиг ирүүлсэн тохиолдолд Хуулийн фирм ямарваа нэгэн хуулийн хариуцлага хүлээхгүй болно. Хууль зүйн дүгнэлтэд тусгагдсан эрх бүхий байгууллагаас олгогдог тодорхойлолтод үндэслэсэн хийж буй дүгнэлтийн хамаарах хугацаа тухайн тодорхойлолтын хүчинтэй хугацаагаар хязгаарлагдана.

БАТЛАСАН:

ӨМГӨӨЛЛИЙН "ЛЕГАЛ ПОЛИСИ" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ӨМГӨӨЛЛИЙН ЛЕГАЛ ПОЛИСИ ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
УЛААНБААТАР ХОТ

Б.ДАВААЖАНЦАН

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
ТТА3531 ☎ 2025406

345

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
1119289111 ☎ 5481589
Улаанбаатар хот

2026.08.31

VII."ШУНХЛАЙ" ХХК-ИАС ӨРИЙН ХЭРЭГСЭЛ ГАРГАЖ БУЙТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ

1. Өмгөөллийн "Легал Полиси" ХХК-ийн Улсын бүртгэлийн гэрчилгээ, үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх олгосон тогтоол;
2. "Шунхлай" ХХК-ийн 2026 оны 08 сарын 18-ны өдрийн В/1319 тоот албан бичиг;
3. "Шунхлай" ХХК-ийн 2026 оны 08 сарын 28-ны өдрийн В/1360 тоот албан бичиг;
4. "Шунхлай" ХХК-ийн 2026 оны 08 сарын 18-ны өдрийн В/1316 тоот албан бичиг;
5. "Шунхлай" ХХК-ийн 2026 оны 08 сарын 18-ний өдрийн В/1315 тоот албан бичиг;
6. "Шунхлай" ХХК-ийн 2026 оны 06 сарын 28-ний өдрийн В/1359 тоот албан бичиг;
7. "Шунхлай" ХХК-ийн 2026 оны 08 сарын 21-ний өдрийн В/1341 тоот албан бичиг;
8. "Шунхлай" ХХК-ийн 2026 оны 08 сарын 21-ний өдрийн В/1342 тоот албан бичиг;
9. Үнэт Цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн 2026 оны 08 сарын 20-ны өдрийн 02/935 тоот тодорхойлолт;
10. Авто тээврийн үндэсний төвийн 2026 оны 08 сарын 19-ны өдрийн "Автотээврийн хэрэгсэл эзэмших, өмчлөх эрхийн лавлагаа (ААН одоо эзэмшиж байгаа)";
11. Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн тусгай архивын 2026.08.19-ний өдрийн 05/4698 тоот албан бичиг;
12. Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Монголын Олон улсын Арбитрын 2026.08.20-ны өдрийн 4/2633 тоот албан бичиг;
13. Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2026.08.19-ны өдрийн Хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч, гишүүний лавлагаа
14. Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн тамгын газрын 2026.08.20-ны өдрийн 746 тоот албан бичиг;
15. Цагдаагийн ерөнхий газрын 2026.08.19-ний өдрийн "Шунхлай" ХХК-ийн хуулийн этгээдийн эрүүгийн харнуцлага хүлээж байгаа эсэх болон байсан эсэх тухай тодорхойлолт;
16. Гаалийн ерөнхий газрын 2026.08.19-ны өдрийн Гаалийн байгууллагад татварын өртэй эсэх тодорхойлолт;
17. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2026.08.19-ний өдрийн "Шүүхийн шийдвэрээр бусдад төлбөргүй эсэх тодорхойлолт (ААНБ)"
18. "Шунхлай" ХХК-ийн 2026.08.20-ны өдөр авсан Зээлийн мэдээллийн сангийн лавлагаа;
19. "Шунхлай" ХХК-ийн 2026.08.21-ний өдөр авсан Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт;
20. Татварын ерөнхий газрын 2026 оны 08 сарын 25-ны өдрийн "Татварын өрийн үлдэгдлийн лавлагаа"
21. Татварын ерөнхий газрын 2026 оны 08 сарын 19-ний өдрийн "Татварын өрийн үлдэгдлийн лавлагаа"
22. Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2026 оны 08 сарын 21-ны өдрийн "Үл хөдлөх хөрөнгө бүртгэлтэй эсэх лавлагаа"
23. Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2026 оны 08 сарын 19-ны өдрийн "Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн лавлагаа"
24. Зөвшөөрлийн цахим систем дээр байрлаж буй "Шунхлай" ХХК-ийн "Бүх төрлийн шатахуун импортлох тусгай зөвшөөрөл";

25. Зөвшөөрлийн цахим систем дээр байрлаж буй "Шунхлай" ХХК-ийн "Бүх төрлийн шатахууны бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл";
26. "Шунхлай" ХХК-ийн 2608/25 дугаартай 0.4-35 кв цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт түүний туршилт, тохируулга дагалдах ажил, үйлчилгээ эрлэх тусгай зөвшөөрөл
27. Оюуны өмчийн газрын Барааны тэмдгийн гэрчилгээ;
28. Шунхлай ХХК-ийн ISO 14001:2015, ISO 45001:2018 гэрчилгээ

ШУНХЛАЙ ХХК
2026-09-10
БҮРТГЭВ
№ 131

2026-09-02
БҮРТГЭВ-03

Шунхлай

Хаяг: УБ шуудан-101 040 128, Үйлдвэр-2-1, Чингисийн өргөн чөлөө-48/1, Улаанбаатар-17040, Хан-Уул дүүрэг, 19-р хороо, Капитал хаус, 3 дугаар давхар
Утас: 976-70073003, 976-91973003
И-мэйл: info@shunkhlai.mn, www.shunkhlai.mn

2026.08.28 № В/1358

танай _____-ны № _____

"САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО"-НД

Нэгдмэл сонирхол, бизнесийн ашиг сонирхлын талаар мэдэгдэл гаргах тухай

"Шунхлай" ХХК нь Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан "Шунхлай-4" нээлттэй өрийн хэрэгслийг гарган олон нийтэд санал болгохоор ажиллаж байна.

Манай компани уг үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцогч бусад талуудтай холбогдох хууль, журам болон талуудын хооронд байгуулагдсан гэрээ, хэлцлийн хүрээнд хамтран ажиллаж буй бөгөөд доор дурдсан этгээдүүдтэй уг үнэт цаасыг гаргахаас бусад аливаа асуудлаар нэгдмэл сонирхол, бизнесийн ашиг сонирхолгүй болохоо үүгээр баталгаажуулан мэдэгдэж байна.Үүнд:

1. Андеррайтер "Голомт Капитал ҮЦК" ХХК
2. Хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч "Өмгөөллийн Легал Полиси" ХХК
3. Зээлжих зэрэглэлийн компани "Монголын Хөрөнгө Оруулалтын Зэрэглэлийн Эжинси" ХХК
4. Аудитын компани "Ниямазон Аудит" ХХК

Хувийг: "Монголын Хөрөнгийн Бирж" ХК-д

Баталгаажуулсан,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ж.МӨНХНАРАН

ШУНХЛАЙ ХХК ГТА3531 ☎ 2028468

УЛААНБААТАР ХОТ ШУНХЛАЙ ХХК ГТА3531 ☎ 2028468

Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital Delivering diversity 1119289111 ☎ 5421589 Улаанбаатар хот

Үнэт цаасны танилцуулга

ШУНХЛАЙ ХХК
2026 09 1 өдөр
БҮРТГЭЛ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2026 -09- 02
БҮРТГЭЛ-03

Golomt Capital
Delivering diversity

Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Чингисийн өргөн чөлөө 24, Парк Плэйс
оффисын барилга, 4 давхар, 403 тоот,
Утас: 7012-1530, 7012-1529
И-мэйл: info@golomtcapital.com,
Вэбсайт: www.golomtcapital.com

2026.08.27 № ГК/26/545
_____ -ны № _____ т

"САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ ХОРОО"-НД

Нэгдмэл сонирхол, бизнесийн ашиг сонирхлын талаар мэдэгдэл гаргах тухай

"Голомт Капитал ҮЦК" ХХК нь "Шунхлай" ХХК-ийн гаргахаар төлөвлөж буй "Шунхлай-4" нээлттэй өрийн хэрэгслийг гарган олон нийтэд танилцуулах, санал болгох төсөлд андеррайтерийн үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

Манай компани энэхүү үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцогч бусад талуудтай холбогдох хууль, журам болон талуудын хооронд байгуулагдсан гэрээ, хэлцлийн хүрээнд хамтран ажиллаж буй бөгөөд доор дурдсан этгээдүүдтэй уг үнэт цаасыг гаргахаас бусад аливаа асуудлаар нэгдмэл сонирхол, бизнесийн ашиг сонирхолгүй болохоо үүгээр баталгаажуулан мэдэгдэж байна. Үүнд:

1. Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК
2. Хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч "Өмгөөллийн Легал Полиси" ХХК
3. Зээлжих зэрэглэлийн компани "Монголын Хөрөнгө Оруулалтын Зэрэглэлийн Эжинси" ХХК
4. Аудитын компани "Ниямазон Аудит" ХХК

Хувийг: "Монголын Хөрөнгийн Бирж" ХК-д

Баталгаажуулсан,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ А.НЯМСҮРЭН

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
11192091111 5481589
Улаанбаатар хот

000865

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
ТТА3531 эх 2028466

349

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
11192091111 5481589
Улаанбаатар хот

2026.08.31

ШУНХЛАЙ
СЭХ
2026 .09 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Үнэт цаасны танилцуулга

MONGOLIAN STOCK EXCHANGE
2026 -09- 02
БҮРТГЭВ-03

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД

NIYAMAZON AUDIT LLC
#406, Building of Trade Union Federation,
Choimbol street, Chingeltei district,
Ulaanbaatar 15172, Mongolia
Tel. (976) 70145906, 91005906
E-mail: audit@nmz.mn

2026.08.27 № 08/27

Нэгдмэл сонирхол, бизнесийн ашиг сонирхлын талаар мэдэгдэл гаргах тухай

Манай компани Шунхлай ХХК-ийн Монголын хөрөнгийн биржээр данжуулан "Шунхлай-4" нээлттэй өрийн хэрэгслийг гаргах үйл ажиллагаанд оролцогч бусад талуудтай холбогдох хууль, журам болон талуудын хооронд байгуулагдсан гэрээ, хэлцлийн хүрээнд хамтран ажиллаж буй бөгөөд доор дурдсан этгээдүүдтэй уг үнэт цаасыг гаргахаас бусад аливаа асуудлаар нэгдмэл сонирхол, бизнесийн ашиг сонирхолгүй болохоо үүгээр баталгаажуулан мэдэгдэж байна.Үүнд:

1. Шунхлай ХХК
2. Андеррайтер "Голомт Капитал ҮЦК" ХХК
3. Хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч "Өмгөөллийн Легал Полиси" ХХК
4. Зээлжих зэрэглэлийн компани "Монголын Хөрөнгө Оруулалтын Зэрэглэлийн Эжинси" ХХК

Хувийг: "Монголын Хөрөнгийн Бирж" ХК-д

Баталгаажуулсан,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ниямазон Аудит ХХК Улаанбаатар хот З.ЦЭЭНЭЭ

Улаанбаатар хот Шунхлай ХХК

350

Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital Delivering diversity 1119289111 Улаанбаатар хот

2026.08.31

ШУНХЛАЙ
СЗХ
2026 оны 10 сар элер
БҮРТГЭВ
№ 01

Үнэт цаасны танилцуулга
2026 -09- 02
БҮРТГЭВ-03

LEGAL POLICY
Law Firm

"САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО"-НД

ӨМГӨӨЛЛИЙН ЛЕГАЛ ПОЛИСИ ХХК

Монгол улс, Улаанбаатар, СБД, 8-р хороо, Бага тойруу 14200,
Сүхбаатарын талбай 5, Сити тауэр, 1304 тоот
Утас:+976 9907-7720, +976 9907-7721
И-мэйл: info@legal-policy.mn Цахим хуудас: www.legal-policy.mn

2026.08.24 № ЛП-АБ/26/49-1

танай _____-ны № _____

Нэгдмэл сонирхол, бизнесийн ашиг сонирхлын талаар мэдэгдэл гаргах тухай

Манай Өмгөөллийн "Легал Полиси" ХХК нь "Шунхлай" ХХК-иас Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан "Шунхлай-4" нээлттэй өрийн хэрэгслийг гарган олон нийтэд санал болгоход хууль зүйн дүгнэлт гарган ажиллаж байна.

Манай компани уг үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцогч дор дурдсан талуудтай холбогдох хууль, журам болон талуудын хооронд байгуулагдсан гэрээ, хэлцлийн хүрээнд хамтран ажиллаж буй бөгөөд үнэт цаасыг гаргахаас бусад аливаа асуудлаар нэгдмэл сонирхол, бизнесийн ашиг сонирхолгүй болохоо үүгээр баталгаажуулан мэдэгдэж байна.Үүнд:

1. Үнэт цаас гаргагч "Шунхлай" ХХК
2. Андеррайтер "Голомт Капитал ҮЦК" ХХК
3. Зээлжих зэрэглэлийн компани "Монголын Хөрөнгө Оруулалтын Зэрэглэлийн Эжинси" ХХК
4. Аудитын компани "Ниямазон Аудит" ХХК

Хувийг: "Монголын Хөрөнгийн Биржийн Зах зах" ХК-д

Баталгаажуулсан,
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.ДАВААЖАНЦАН

ӨМГӨӨЛЛИЙН ЛЕГАЛ ПОЛИСИ ХХК
УЛААНБААТАР ХОТ
9023091250

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
ТУХАЙ 3531 Ш. 2025 100

351

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
1119289111 5481589
Улаанбаатар хот

2026.08.31

ШУНХЛАЙ

СЗХ
2026 .08 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Үнэт цаасны танилцуулга

MONGOLIAN STOCK EXCHANGE
2026 .09 .12
БҮРТГЭВ-03

Mongolian Investment Rating Agency

+976 7774-7700
info@mira.mn
http://www.mira.mn
Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо,
Жамьян гүн гудамж, Даун таун бизнес,
11 давхар 1103 тоот

Монголын хөрөнгө оруулалтын зэрэглэлийн эхэнд ҮЦК ХХК
2026 оны 08 дугаар сарын 28-ны өдөр

No.: 114/2026

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД

Нэгдмэл сонирхол, ашиг сонирхлын талаар мэдэгдэл гаргах тухай

Тус компани нь "Шунхлай" ХХК-ийн гаргахаар төлөвлөж буй нэлтгэй өрийн хэрэгслийг олон нийтэд танилцуулах, санал болгох тесөлд зэлжих зэрэглэл тогтоогч байгууллагаар ажиллаж байна.

Манай компани уг үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцогч бусад талуудтай холбогдох хууль, журам болон талуудын хооронд байгуулагдсан гэрээ, хэлцлийн хүрээнд хамтран ажиллаж буй бөгөөд доор дурдсан этгээдүүдтэй уг үнэт цаасыг гаргахаас бусад аливаа асуудлаар нэгдмэл сонирхол, бизнесийн ашиг сонирхолгүй болохоо үүгээр баталгаажуулан мэдэгдэж байна. Үүнд:

1. **Үнэт цаас гаргагч:** "Шунхлай" ХХК
2. **Андеррайтерийн компани:** "Голомт Капитал ҮЦК" ХХК
3. **Хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч:** "Өмгөөллийн Легал Полиси" ХХК
4. **Аудитын компани:** "Ниямазон Аудит" ХХК

Хувийг: "Монголын Хөрөнгийн Бирж" ХК-д

Хүндэтгэсэн,

Золбаярын Дагмэдмаа
Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
УА3531 ☎ 2029488

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering Diversity
1119289111 ☎ 5481589
Улаанбаатар хот

2026.08.31

ШУНХЛАЙ

Үнэт цаасны танилцуулга

7.26 Бондын гэрээ

БҮРТГЭВ

№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE

2026 -09- 02

БҮРТГЭВ-03

БОНДЫН ГЭРЭЭ

2026 оны 8 дугаар сарын 27-ний өдөр Дугаар №.Х091-БГ26/31 Улаанбаатар хот

Энэхүү Бондын гэрээ (цаашид "Гэрээ" гэх -г Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай Монгол Улсын хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг үндэслэн,

нэг талаас Монгол Улс, Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, 24, Парк Плэйс оффисын барилга, 4 давхар, 403,404 хаягт байрлах "Голомт Капитал ҮЦК" ХХК, түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал А.Нямсүрэн, (цаашид "**Андеррайтер** гэх) болон

нөгөө талаас Монгол улс, Улаанбаатар хот, Чингисийн өргөн чөлөө 48/1, Капитал Хаус хаягт байрлах "Шунхлай" ХХК, түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Ж. Мөнхнаран нар нь (цаашид "**Бонд гаргагч**" гэх) энэхүү Гэрээг дор дурдсан нөхцөлөөр байгуулав.

1. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

1.1 Энэхүү Гэрээгээр Бонд гаргагчаас Өрийн бичиг (цаашид "Бонд" гэх)-ийг гаргахтай холбогдуулан бондын нөхцөл, төлбөрийг тооцоолох аргачлал, худалдах, худалдан авах нөхцөл, Бонд гаргагч хөрөнгө оруулагчдын өмнө үүргээ гүйцэтгэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад энэхүү Гэрээний зорилго оршино.

1.2 Энэхүү Гэрээг талууд бичгээр байгуулж, гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр хэрэгжинэ.

2. БОНДЫН НӨХЦӨЛ

2.1. Бонд гаргагч нь дараах нөхцөлөөр Бонд гарган нийтэд санал болгоно.

2.1.1	**Бондын төрөл**	Нэлтгэй өрийн хэрэгсэл (энгийн хүүтэй хөтөлбөртэй бонд);
2.1.2	**Бондын хөтөлбөр хэрэгжүүлэх**	Хэсэгчлэн гаргах үнийн дүнг Компанийн гүйцэтгэх захирал тухай бүрд шийднэ;
2.1.3	**Бондын арилжаа**	Монголын хөрөнгийн биржээр олон нийтэд нээлттэй хүрээнд;
2.1.4	**Бондын тоо ширхэг**	1,000,000 (нэг сая) ширхэг;
2.1.5	**Бондын нэрлэсэн үнэ, (ширхэг)**	100,000 (нэг зуун мянга) төгрөг;
2.1.6	**Бондын хөтөлбөрийн нийт дүн**	100,000,000,000 (нэг зуун тэрбум) төгрөг;
2.1.7	**Бондын хугацаа**	12 сар;

УЛААНБААТАР ХОТ ШУНХЛАЙ ХХК ТТА3531 ᠔ 2025468

Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital Delivering Diversity 11192891114481589 Улаанбаатар хот

2026.08.31

2.1.8	**Бондын хүү**	18 хувь, жилийн;
2.1.9	**Хүүгийн төлөлт**	Хагас жил тутам;
2.1.10	**Үндсэн төлбөр төлөлт**	Хугацааны эцэст;
2.1.11	**Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулах зорилалт**	Эргэлтийн хөрөнгийн санхүүжилт;
2.1.12	**Үнэт цаасны хүүгийн орлогын татвар**	5.0 хувь;
2.1.13	**Бондын эргэн төлөлт**	Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны эргэн төлөлтийг газрын тосны бүтээгдэхүүний борлуулалт буюу үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлогоор санхүүжүүлнэ.
2.1.14	**Үнэт цаас гаргагчийн Зээлжих зэрэглэлийн үнэлгээ**	Зээлжих зэрэглэлийн компани: Хөрөнгө Оруулалтын Зэрэглэлийн Эжинси ХХК Үнэлгээ: А тогтвортой;
2.1.15	**Хүүгийн төлбөр тооцох аргачлал**	Бондын хүүг хоёрдогч зах зээлийн арилжаа эхлэсэн өдрөөс эхлэн жилийн хүүг 365 хоногоор тооцно. Хэрэв хүү төлөх өдөр амралтын өдөр таарвал дараагийн ажлын өдөр төлөх ба энэ тохиолдолд амралтын өдрүүдэд хүүг нэмж тооцохгүй.
2.1.16	**Нийтэд санал болгох хугацаа**	2026 оны 3-р улирал;
2.1.16	**Үүргийн гүйцэтгэл хангах арга**	Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоолгосон тул барьцаа, баталгаа, батлан даалтгүй;

2.2. Бонд нь Хугацаанаас өмнө эргүүлэн дуудах болон хервех нөхцөлгүй байна.

3. БОНДЫН ЗАХИАЛГА

3.1. Талууд нь Санхүүгийн Зохицуулах хорооны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 226 тоот тогтоолоор батлагдсан "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ыг харгалзан анхдагч зах зээлийн үйл ажиллагааг Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан зохион байгуулна.

3.2. Анхдагч зах зээлийн арилжаа хаагдахад Бонд нь худалдан авсан хөрөнгө оруулагчийн нэр дээр бүртгэгдэнэ.

4. ТӨЛБӨРИЙН ТАСАЛДАЛ, ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ ТООЦОХ НӨХЦӨЛ

4.1. Бонд гаргагч нь Бондын хүү болон үндсэн төлбөрийг Үнэт цаасны танилцуулга болон бусад баримт бичигт заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүй нөхцөл үүссэх тохиолдолд төлбөрийн тасалдал болсонд тооцно.

4.2. Төлбөрийн тасалдал үүссэн нөхцөлд дараах арга хэмжээг Андеррайтер авна. Үүнд:

ШУНХЛАЙ СЗХ 2026 оны 09 сар 1 өдөр БҮРТГЭВ № 01

2026-09-02 БҮРТГЭВ-03

4.2.1. Төлбөрийн тасалдлын нөхцөл үүссэн тухай, түүний шалтгаан, төлөгдөөгүй төлбөрийн хэмжээ, хугацаа болон төлбөрийг барагдуулах арга хэмжээний төлөвлөгөөг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллага болон хөренгө оруулагчдад мэдээлэх;

4.2.2. Санхүүгийн чадавхыг сэргээх, хөренгө оруулагчдын өмнө хүлээсэн төлбөрийн үүргийг биелүүлэхэд чиглэсэн арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх;

4.3. Төлбөрийн тасалдал үүссэн нөхцөлд Бонд гаргагч дараах арга хэмжээг авна. Үүнд:

4.3.1. Өөрийн эзэмшилд байгаа мөнгөн хөренгө болон хөрвөх чадвартай хөренгийг ашиглах, шаардлагатай тохиолдолд авлага болон бусад хөренгийг мөнгөн хөренгөд хөрвүүлэх замаар төлбөрийн эх үүсвэр бүрдүүлэх;

4.3.2. Шаардлагатай тохиолдолд нэмэлт санхүүжилт болон дахин санхүүжилт татах;

4.3.3. Хувьцаа эзэмшигч, нэгдмэл сонирхолтой этгээд болон бусад холбогдох этгээдээс нэмэлт хөренгө оруулалт, санхүүгийн дэмжлэг авах;

4.3.4. Үйл ажиллагааны болон бусад зардлыг бууруулах, орлого болон үйл ажиллагааны мөнгөн урсгалыг нэмэгдүүлэх арга хэмжээ авах;

4.3.5. Дээр дурдсан арга хэмжээгээр хөренгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргийг бүрэн биелүүлэх боломжгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомж болон бондын нөхцөлд нийцүүлэн төлбөрийн үүргийг барагдуулах бусад арга хэмжээг авах.

4.4. Төлбөрийн чадваргүй болох нөхцөлийг хуульд зааснаар тодорхойлно.

4.5. Бонд гаргагч төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасан дараалыг харгалзах бөгөөд ямар ч тохиолдолд Бондын хүү болон үндсэн төлбөрийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахаас өмнө тэргүүн ээлжид барагдуулна.

5. БОНДЫГ ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ

5.1. Бонд гаргагч нь Бондыг хугацааны эцэст эргүүлэн худалдан авах буюу үндсэн төлбөрийг төлнө.

5.2. Бонд гаргагч нь Бондыг хугацаанаас өмнө эргүүлэн худалдан авах үүрэгтэй.

6. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

6.1. Бонд гаргагчийн эрх, үүрэг

6.1.1. Андеррайтер, бонд эзэмшигчээс хууль тогтоомж болон энэхүү гэрээнд заасан үүргээ биелүүлэхийг шаардах;

6.1.2. Андеррайтераас гаргасан нарийвчилсан шинжилгээ, судалгаа, хийсэн үнэлгээ, дүгнэлтэд үндэслэн нийтэд санал болгох бондын үнэ, хүүгийн түвшнийг тогтоох;

6.1.3. Үнэт цаасны тусгагдсан хугацаанд хүүгийн төлбөрийг болон хугацааны эцэст үндсэн төлбөрийг төлөх, энэхүү үүргээ биелүүлэхэд шаардлагатай бүхий л арга, хэмжээг авч ажиллах, андеррайтерийн өгсөн зөвлөмжид үндэслэн санхүүгийн чадавхыг сайжруулахтай холбоотой шаардлагатай арга хэмжээ авч ажиллах;

6.1.4. Татан төвлөрүүлсэн хөренгийг үнэт цаасны танилцуулгад тусгагдсаны дагуу үр ашигтай захиран зарцуулах;

6.1.5. Бонд гаргагчийн үйл ажиллагаа, санхүү болон бусад бодит байдлын талаарх мэдээллийг үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол уттагүй, бүрэн гүйцэд, тодорхой байх зарчмаар буюу хөренгө оруулалтын шийдвэр гаргахад хангалттай байдлаар мэдээлэх;

6.1.6. Андеррайтер шаардсаны дагуу бонд гаргалттай холбоотой мэдээллийг гаргаж өгөх;

6.1.7. Хууль, тогтоомжид болон энэхүү гэрээнд заасан мэдээллийг цахим шуудан, эсхүл олон нийтийн хэрэгслээр дамжуулан, хугацаанд нь бонд эзэмшигчид мэдээлэх;

6.1.8. Холбогдох хууль тогтоомж болон холбогдох журмуудад заасан дараах мэдээллийн ил тод байдлыг тогтмол хангаж, Бонд эзэмшигчийн өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлж

УЛААНБААТАР ХОТ ШУНХЛАЙ ХХК ТТА0531 ☎ 2025408

Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital Delivering Diversity 1119289111 – 3181569 Улаанбаатар хот

2026.08.31

СЗХ
2026 .09. 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2026 -09- 02
БҮРТГЭВ-03

ажиллана. Мэдээллийг Хороо болон Арилжаа эрхлэх байгууллагад цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлнэ. Үүнд:

Мэдээлэл	Давтамж
Улирлын тайлан	Улирлын тайланг дараа сарын 10-ны өдрийн дотор, хоёрдугаар улирлын тайланг дараа сарын 20-ны өдрийн дотор
Жилийн тайлан	Дараа оны 2-р сарын 10-ны өдрийн дотор
Санхүүгийн тайлан	Жилийн санхүүгийн тайланг Хороонд бүртгэлтэй аудитын байгууллагаар баталгаажуулан дараа оны 3-р сарын 10-ны дотор
Өөрийн гаргасан бондыг төлөгдөх хугацаанаас өмнө эргүүлэн худалдан авахаар шийдвэрлэсэн	Тухайн үйл явдал болсноос ажлын гурван өдрийн дотор
Бусад санхүүгийн байгууллага, хөренгө оруулагчаас зээл авсан, тэдний өмнө хүлээсэн нэмэлт үүрэг үүссэн	Тухайн үйл явдал болсноос ажлын гурван өдрийн дотор
ТУЗ, гүйцэтгэх удирдлага, хяналтын багц бүхий хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт орсон	Тухайн үйл явдал болсноос ажлын гурван өдрийн дотор
Эрх бүхий байгууллагын шийдвэрээр бонд гаргагчийн хөренгийг битүүмжилсэн, эсхүл хураасан	Тухайн үйл явдал болсноос ажлын гурван өдрийн дотор
Бонд гаргагч тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхдэх болсон, хугацааг сунгуулсан, эсхүл түүнийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон	Тухайн үйл явдал болсноос ажлын гурван өдрийн дотор
Бонд гаргагч нь гуравдагч этгээдийн өмнөөс баталгаа,батлан даалт гаргасан	Тухайн үйл явдал болсноос ажлын гурван өдрийн дотор
Бонд гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарсан	Тухайн үйл явдал болсноос ажлын гурван өдрийн дотор
Бондын үнэ ханшид нөлөөлж болохуйц аливаа үйл явдлын мэдээлэл	Нэн даруй буюу 24 цагийн дотор
Бусад	Холбогдох хууль болон журамд заасан мэдээллийг тухай бүр тогтмол мэдээлнэ.

6.1.9. Бондын нөхцөл, холбогдох баримт бичигт өөрчлөлт орсон, бондын үнэ ханшид нөлөөлж болохуйц аливаа үйл явдал бий болсон тохиолдолд нэн даруй Андеррайтер, олон нийт, Хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдэгдэж, холбогдох арга хэмжээг авах;

6.1.10. Бондыг бүртгүүлэхтэйгээр холбоотойгоор СЗХ-нд хүргүүлсэн баримт бичиг, түүнд хавсаргасан баримт бичгийг бондын хугацаа дуусаж, үндсэн болон хүүгийн төлбөрийг бүрэн төлж дуусах хүртэлх хугацаанд компанийн байранд, цаашид хуульд заасан хугацаанд хадгалах;

6.1.11. Хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас бонд эзэмшигчид учруулсан хохирлыг төлж барагдуулах;

6.1.12. Хууль тогтоомжид заасны дагуу үнэт цаас гаргагчид хориглосон үйл ажиллагаа хэрэгжүүлэхгүй байх;

6.1.13. Хууль тогтоомжид заасан бусад.

6.2. Андеррайтерийн эрх, үүрэг

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ
ТТД 0531 ☎ 2028468

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
1119289111 ☎ 5421588
Улаанбаатар хот

ШУНХЛАЙ СЭХ 2026 .09.10 өдөр БҮРТГЭВ № 01

2026 -09- 02 БҮРТГЭВ-03

6.2.1. Хөрөнгө оруулагчийн шийдвэр гаргахад шаардлагатай Бонд гаргагчийн талаарх хуулиар хориглосноос бусад бүхий л мэдээллийг бонд гаргагчаас гаргуулах авах;
6.2.2. Бондын танилцуулгыг бэлтгэх анхдагч зах зээлийн захиалгыг авах, хуваарилах, худалдан авах,байршуулах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;
6.2.3. Хувь хүний болон байгууллагын нууцтай холбоотой мэдээ, мэдээлэл, баримт бичгийг гуравдагч этгээдэд задруулахгүй байх;
6.2.4. Бонд гаргагчийн бондын хүүгийн болон үндсэн төлбөрийн эргэн төлөлтөд хяналт тавих;
6.2.5. Хөрөнгө оруулагчийн эрх, үүргийг зохих ёсоор хоёрдмол утгагүй танилцуулах;
6.2.6. Бонд гаргагч төлбөрийн чадваргүй болж хүүгийн болон үндсэн төлбөрөө төлөөгүй бол үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар шүүхэд нэхэмжлэх гаргах;
6.2.7. Хууль тогтоомжид заасан бусад;
6.3. Бонд эзэмшигч буюу хөрөнгө оруулагчийн эрх үүрэг
6.3.1. Бонд эзэмшигч, түүний хамтран эзэмшигч нь компанийн санхүүгийн тайлан, үнэт цаасны танилцуулгыг хөрөнгө оруулалтын зорилгоор судлан үзэж, бүрэн танилцсаны үндсэн дээр бонд худалдан авч, хөрөнгө оруулалт хийх шийдвэрийг бие даан гаргах;
6.3.2. Бондыг бирж дээрээс чөлөөтэй худалдан авах, хоёрдогч зах зээл дээр худалдах;
6.3.3. Санхүүгийн Зохицуулах Хорооны Үнэт цаасны мэдээллийн ил тод байдлын журамд заасны дагуу Бонд гаргагчийн мэдээллийг авах, бондын хоёрдогч зах зээлийн үнийн мэдээлэлтэй танилцах;
6.3.4. Бондын үнэ болон түүнийг худалдан авахтай холбоотой шимтгэл, хураамжийн үүргийг гүйцэтгэснээр Үнэт цаасыг эзэмшилдээ шилжүүлэхийг Бонд гаргагчаас шаардах;
6.3.5. Хугацааны эцэст бондыг нэрлэсэн үнээр худалдах, худалдан авах, хуримтлагдсан хүүг төлөхийг Бонд гаргагчаас шаардах эрхтэй ба хэрэв Бонд гаргагч нь энэ үүргээ биелүүлэхгүй бол гэрээнд заасны дагуу үүргийн гүйцэтгэл хангуулахыг шаардах;
6.3.6. Бонд гаргагч төлбөрийн чадваргүй болсон буюу үүргийн гүйцэтгэлийг хангах эд хөрөнгийн хэмжээ багассан, эсхүл эд хөрөнгөгүй болсон бол Бонд эзэмшигч нь тогтоосон хугацаанаас өмнө үүргээ нэн даруй гүйцэтгэхийг түүнээс шаардах;
6.3.7. Бонд эзэмшигч, түүний хамтран эзэмшигчийн бондын төлбөрт төлсөн мөнгөн хөрөнгө нь түүний хууль ёсны үйл ажиллагаанаас олсон орлого бөгөөд "Мөнгө угаах, терроризмтай тэмцэх тухай хууль"-ийн дагуу холбогдох шалгуурыг хангасан, эрх зүйн аливаа доголдолгүй, маргаангүй мөнгөн хөрөнгө болохыг бүрэн баталж, эрсдэл болон өгөөжийг бүрэн тооцоолж хөрөнгө оруулалтын шийдвэрийг бие даан гаргасан талаар баталгаа гаргаж Андеррайтераас гаргасан анхан шатны маягтыг үнэн зөв мэдээлэх болон түүнд орсон өөрчлөлтийг тухай бүр мэдэгдэх;
6.3.8. Мөнгөн хөрөнгөө урьдчилан байршуулах нөхцөлөөр өөрийн захиалсан бондын төлбөрийг төлөх, тийнхүү төлөөгүй бол захиалсан бондыг Андеррайтер худалдах эрхтэйг хүлээн зөвшөөрөх;
6.3.9. Монгол Улсын аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу бондын хүүгийн орлогоос татвар төлөх;
6.3.10. Хууль тогтоомжид заасан бусад
6.4. Энэхүү Гэрээгээр тохиролцсоноос бусдаар Бонд гаргагчид тусгайлан хориглох буюу заавал хэрэгжүүлэх тустай нөхцөл тогтоогүй болно.

7. Бонд гаргагчид хориглох зүйлс

7.1. Бонд гаргагчид хориглох зүйлс
7.1.1. Андеррайтерт урьдчилан бичгээр мэдэгдэхгүйгээр бондын үүргийн гүйцэтгэлд сөргөөр нөлөөлөхүйц хэмжээний шинэ өр, зээл, баталгаа, батлан даалт авахгүй байх;
7.1.2. Хөрөнгө оруулагчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хохироох холбоотой этгээдтэй давуу нөхцөлтэй хэлцэл хийхгүй байх;

УЛААНБААТАР ХОТ ШУНХЛАЙ ХХК ТТА3531 ᠔ᠠ 2028468

Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital Delivering diversity 1119289111 5481589 Улаанбаатар хот

2026.08.31

7.1.3. Бондын хөрөнгө татан төвлөрүүлсэн зорилгоос өөр зориулалтаар хөрөнгийг зарцуулахгүй байх;

7.1.4. Бондын үндсэн төлбөр, хүү болон бусад үүргээ биелүүлэхгүй үед Андеррайтерт урьдчилан бичгээр мэдэгдэхгүйгээр хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байх;

7.2. Дээр дурдсанаас бусад хууль, тогтоомж, гэрээ хэлцлээр хориглоогүй зүйлсийг бонд гаргагчид зөвшөөрнө.

8. Бусад зүйл

8.1. Гэрээ нь Талуудын эрх бүхий төлөөлөгч нар гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.

8.2. Талууд харилцан тохиролцсоноор Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно.

8.3. Гэрээний заалтын аль нэг зүйл хүчингүй болсон нь энэхүү гэрээ бүхэлдээ хүчин төгөлдөр бус болох үндэслэл болохгүй.

8.4. Энэхүү гэрээг Монгол хэлээр 2 хувь үйлдсэн бөгөөд тал тус бүр нэг хувийг хадгална.

8.5. Талуудын хооронд үүссэн аливаа маргааныг Монгол Улсын хуулийн дагуу Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Андеррайтер:	Бонд гаргагч:
"ГОЛОМТ КАПИТАЛ УЦК" ХХК:	"ШУНХЛАЙ" ХХК
А.Нямсүрэн	Ж.Мөнхнаран
Гүйцэтгэх захирал	Гүйцэтгэх захирал

СЭХ 2026 -09- 10 өдөр БҮРТГЭВ № 01

2026 -09- 02 БҮРТГЭВ-03

7.27 Үнэт цаас гаргагчийн 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайлан

ШУНХЛАЙ ХХК

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн

ТУСДАА САНХҮҮГИЙН ТАЙЛАН

(Хараат бус аудиторын тайлангийн хамт)

УЛААНБААТАР ХОТ ШУНХЛАЙ ХХК ТТД 3531 ш. 2028468

Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital Delivering diversity 1119289111 5681589 Улаанбаатар хот

ШУНХЛАЙ СЗХ 2026 .09. 10 өдөр БҮРТГЭВ № 01

2026 -09- 02 БҮРТГЭВ-03

Агуулга

	Хуудас
Удирдлагын Батламж Мэдэгдэл	1
Хараат бус Аудиторын Тайлан	2
Түсдаа Санхүүгийн Байдлын Тайлан	5
Түсдаа Ашиг, Алдагдал болон Бусад Дэлгэрэнгүй Орлогын Тайлан	6
Түсдаа Өмчийн Өөрчлөлтийн Тайлан	7
Түсдаа Мөнгөн Гүйлгээний Тайлан	8
Түсдаа Санхүүгийн Тайлангийн Тодруулга	9

УЛААНБААТАР ХОТ ШУНХЛАЙ ХХК ТТА 3531 ☎ 2028868

Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital Delivering diversity 1119289111 ☎ 5481589 Улаанбаатар хот

ШУНХЛАЙ ХХК
2026 сар 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Үнэт цаасны танилцуулга

MONGOLIAN STOCK EXCHANGE
2026 -10- 02
БҮРТГЭВ-03

Удирдлагын Батламж Мэдэгдэл

Компанийн удирдлага нь хуулийн дагуу шаардаагүй түсдаа санхүүгийн тайланг бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Шунхлай ХХК ("Компани" гэх)-ийн энэхүү хуулийн дагуу шаардаагүй түсдаа санхүүгийн тайлан нь СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартын дагуу бэлтгэгдсэн. Компанийн удирдлага нь энэхүү түсдаа санхүүгийн тайлан нь компанийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв илэрхийлсэн гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.

Компанийн удирдлага нь компанийн санхүүгийн байдлыг үндэслэлтэй, үнэн зөв илэрхийлж чадах, түсдаа санхүүгийн тайлангуud нь тодруулга 2 ба 3-т дурьдсан шаардлагуудад нийцсэн гэдгийг баталгаажуулах боломжийг хангах зөв зохистой нягтлан бодох бүртгэлийг хөтлөж байгаа гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.

Мөн компанийн удирдлага нь компанийн эд хөрөнгийг хадгалан хамгаалах, аливаа залиа мэх, эүй бус үйлдлээс сэргийлэх, нийм үйлдлийг илрүүлэхэд шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх ерөнхий үүрэгтэй.

Компанийн удирдлага нь түсдаа санхүүгийн тайланг бэлтгэхдээ тохиромжтой нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгож, туушлайгаар хэрэглэж, үндэслэлтэй, нягт нямбай тооцоолол, үнэлгээ хийж, бүх холбогдох нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдсөн гэж үзэж байна.

Компанийн удирдлагаас Шунхлай ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн түсдаа санхүүгийн тайланг зөвшөөрч батлав.

Ж. Мөнхжаргал
Гүйцэтгэх Захирал

С.Болортуяа
Санхүүгийн Газрын Захирал

Монгол Улс,
Улаанбаатар хот

2024 оны 6 дугаар сарын 20-ны өдөр

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
УБ3531 ☎ 2028408

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
1119289111 ☎ 5481589
Улаанбаатар хот

2026.08.31

ШУНХЛАЙ СЗХ
2026 -09- 10
БҮРТГЭВ
№ 01

Үнэт цаасны танилцуулга

2026 -09- 02
БҮРТГЭВ-03

Кэй Пи Эм Жи Аудит ХХК
Монгол Улс, Улаанбаатар-14240,
Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо,
Энхтайваны өргөн чөлөө 17,
Блю Скай Тауэр, 602 тоот

Утас: +976 7011 8101
Факс: +976 7011 8102
www.kpmg.com/mn

Хараат Бус Аудиторын Тайлан

Шунхлай ХХК-ийн Хувьцаа Эзэмшигч болон Төлөөлөн Удирдах Зөвлөлд:

Дүгнэлт

Бид Шунхлай ХХК (цаашид "Компани" гэх)-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх тусдаа санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн тусдаа ашиг, алдагдал болон бусад далгэрэнгүй орлогын тайлан, тусдаа өмчийн өөрчлөлтийн тайлан, тусдаа мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд ба бусад тайлбар мэдээллүүдийг агуулсан тодруулгуудаас бүрдсэн тусдаа санхүүгийн тайланд аудит хийлэв.

Бидний дүгнэлтээр, энэхүү тусдаа санхүүгийн тайлан нь Компанийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх тусдаа санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн тусдаа санхүүгийн гүйцэтгэл болон тусдаа мөнгөн гүйлгээг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс батлагдсан СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартууд (цаашид "СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартууд" гэх)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн Үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (цаашид "АОУС" гэх)-ын дагуу хийж гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн *Тусдаа Санхүүгийн Тайлангийн Аудитад Хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага* хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Дүрэм (Хараат Бус Байдлын Олон Улсын Стандарт үүнд хамаарна) (цаашид "НБЁЗОУСЗ-ийн Ёс зүйн Дүрэм" гэх) болон тусдаа санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой Монгол Улс дахь ёс зүйн зохих шаардлагуудын дагуу Компаниас хараат бус байж, НБЁЗОУСЗ-ийн Ёс Зүйн Дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт өгөхөд хангалттай бөгөөд зохих үндэслэл болно гэдэгт бид итгэж байна.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Тусдаа Санхүүгийн Тайланд Хүлээх Үүрэг Хариуцлага

Тусдаа санхүүгийн тайланг СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Алдаа, зальт ажиллагааны улмаас материаллагаар буруу илэрхийлэгдээгүй тусдаа санхүүгийн тайланг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх үүрэг хариуцлагыг мөн удирдлага хүлээнэ.

Тусдаа санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлагын зүгээс Компанийн тасралтгүй үйл ажиллагаа эрхлэх чадамжийг үнэлэн, шаардлагатай гэж үзвэл тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг тусдаа санхүүгийн тайланд тодруулж, Компанийг татан буулгах юм уу үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан тусдаа санхүүгийн тайлангаа бэлтгэх үүргийг Компанийн удирдлага хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хүлээнэ.

[illegible]

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
УБ0531 № 2025400

360

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
1119289111 5481589
Улаанбаатар хот

2026.08.31

ШУНХЛАЙ ХХК
2026 09 10
БҮРТГЭВ
№ 01

Үнэт цаасны танилцуулга

2026 09 02
БҮРТГЭВ-03

KPMG

Түсдаа Санхүүгийн Тайлангийн Аудитад Хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага

Түсдаа санхүүгийн тайлан нь залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс бүхэлдээ энгид эсэх талаарх үндэслэлтэй нотолгоог олж авах, бидний дүгнэлтийг агуулж буй аудиторын тайланг танилцуулах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт хэдий ч АОУС-ын дагуу гүйцэтгэсэн аудит нь бүхий л материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдааны улмаас үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ ут түсдаа санхүүгийн тайланд үндэслэн гаргах мэдээлэл хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөхөөр хүлээгдэж байвал материаллаг гэж үзнэ.

АОУС-ын дагуу аудит хийх үед мэргэжлийн үнэлэмж гаргах, мэргэжлийн ул итгэх үзлээр хандахыг аудитын ажлын явцад шаардлаг. Бид мөн:

- Түсдаа санхүүгийн тайланд залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн ут эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авдаг. Залилан нь хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах зэрэг явдлуудыг агуулсан байдаг тул залилангаас үүсэх материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдааны улмаас үүсэх буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг.

- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горимыг боловсруулахын түлд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.

- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын үндэслэл болон холбогдох тодруулгуудыг үнэлдэг.

- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн бид олж авсан нотолгоондоо тулгуурлан Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа эрхлэх чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Материаллаг тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл бид аудиторын тайланд түсдаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл энэхүү тодруулга нь хангалттүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Бид дүгнэлтээ аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд үндэслэн гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал нь Компанийг тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.

- Түсдаа санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц болон агуулгыг тодруулгуудын хамт үнэлж, түсдаа санхүүгийн тайлан нь холбогдох ажил гүйлгээнүүд болон үйл явдлуудыг үнэн зөв илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

ҮЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
ТҮА3531 2026408

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
1119289111 5481589
Улаанбаатар хот

2026.08.31

ШУНХЛАЙ
СЗХ
2026 .09. 10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Үнэт цаасны танилцуулга

MONGOLIAN STOCK EXCHANGE
2026 -09- 02
БҮРТГЭВ-03

KPMG

Түсдаа Санхүүгийн Тайлангийн Аудитад Хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага, Үргэлжлэл

Бид бүсад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн цар хүрээ, хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг.

КЭЙ ПИ ЭМ ЖИ АУДИТ ХХК
KPMG AUDIT LLC
Кэй Пи Эм Жи Аудит ХХК

Кэй Пи Эм Жи Аудит ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот
2024 оны 6 дугаар сарын 20-ны өдөр

Баталсан:

Жу, Сан Ён
Партнер

Энэхүү тайлан нь аудитын тайлангийн өдөр буюу 2024 оны 6 дугаар сарын 20-ны өдрөөр хүчин төгөлдөр үйлчилнэ. Аудитын тайлангийн өдөр болон энэхүү тайланг хэрэглэх хугацааны хооронд тохиолдож болох аливаа тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдал нь үг тусдаа санхүүгийн тайлан болон тодруулгад материаллаг нөлөө үзүүлж болох юм. Тиймээс аудитын тайланг хэрэглэгчид нь үг тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдлын нөлөөллийг дэрх аудитын тайланд тусгаагүй анхаарна уу. Энэхүү тайлан нь зөвхөн Компанийн Хувьцаа Эзэмшигч болон Төлөөлөн Удирдах Зөвлөлд зориулагдсан болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын аливаа үүрэг, хариуцлага хүлээхгүй болно.

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
ТТА3531 № 2023488

362

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering difference
1119289111 № 5481589
Улаанбаатар хот

2026.08.31

ШУНХЛАЙ СЭХ 2026 оны 1 дүгаар БҮРТГЭВ № 01

MONGOLIAN STOCK EXCHANGE 2026 -09- 02 БҮРТГЭВ-03

ШУНХЛАЙ ХХК
2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх
Түсдаа Санхүүгийн Байдлын Тайлан

(Мянган төгрөгөөр)	*Тодруулга*	*2023*	*2022*
Хөрөнгө			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	6	5,057,027	14,667,354
Дансны авлага	7	317,985,370	260,178,212
Бусад авлага	8	874,777	1,758,679
Бараа материал	9	74,403,140	44,415,339
Бусад хөрөнгө	10	2,526,551	10,447,960
Эргэлтийн хөрөнгийн дүн		400,846,865	331,467,544
Үндсэн хөрөнгө	11	32,084,619	5,616,621
Биет бус хөрөнгө	12	1,141,943	480,294
Охин компани дах хөрөнгө оруулалт	13	501,000	500,000
Хойшлогдсон татварын хөрөнгө		-	35,218
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		33,727,562	6,632,133
Хөрөнгийн дүн		434,574,427	338,099,677
Өр төлбөр			
Дансны өглөг	14	79,819,166	114,930,855
Бусад өглөг	15	4,991,283	11,055,859
Богино хугацаат зээл	16	253,273,516	197,706,896
Гаргасан бонд	17	50,000,000	3,962,636
Орлогын албан татварын өглөг		5,999,858	1,608,605
Түрээсийн өр төлбөр		587,800	337,708
Богино хугацаат өр төлбөрийн дүн		394,671,623	329,602,559
Урт хугацаат зээл	16	15,000,000	-
Хойшлогдсон татварын өр		9,489	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн		15,009,489	-
Өр төлбөрийн дүн		409,681,112	329,602,559
Эздийн өмч			
Хувьцаат капитал	18	165,700	165,700
Хуримтлагдсан ашиг	18	24,727,615	8,331,418
Эздийн өмчийн дүн		24,893,315	8,497,118
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн		434,574,427	338,099,677

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй бүрдэл хэсэг болно.

ХАНБАНК ХХК УЛААНБААТАР ХОТ 3531 2025.08.08

363

Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital Delivering diversity 1119289111 5451589 Улаанбаатар хот

2026.08.31

ШУНХЛАЙ ХХК
2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Тусдаа Ашиг, Алдагдал болон Бусад Дэлгэрэнгүй Орлогын Тайлан

(Мянган төгрөгөөр)	*Тодруулга*	*2023*	*2022*
Борлуулалтын орлого	*19*	1,197,679,060	1,075,443,126
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	*19*	(1,113,404,786)	(1,025,838,775)
Нийт ашиг		**84,274,274**	**49,604,351**
Борлуулалт, түгээлтийн зардал	*20*	(3,595,008)	(2,034,357)
Удирдлагын зардал	*21*	(14,467,035)	(10,665,705)
Дансны авлагын үнэ цэнийн бууралт	*7, 25*	(3,104,190)	(273,685)
Бусад орлого	*22*	28,732	48,810
Бусад зардал	*22*	(4,405,000)	(2,976,329)
Үйл ажиллагааны ашиг		**58,731,773**	**33,703,085**
Санхүүгийн орлого	*23*	282,502	1,688,486
Санхүүгийн зардал	*23*	(35,922,261)	(26,491,299)
Татварын өмнөх ашиг		**23,092,014**	**8,900,272**
Орлогын албан татварын зардал	*24*	(6,695,817)	(2,091,125)
Тайлант жилийн цэвэр ашиг		**16,396,197**	**6,809,147**
Бусад дэлгэрэнгүй орлого		-	-
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого		**16,396,197**	**6,809,147**

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй бүрдэл хэсэг болно.

ШУНХЛАЙ ХХК
2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Тусдаа Өмчийн Өөрчлөлтийн Тайлан

(Мянган төгрөгөөр)	Хувьцаат капитал	Хуримтлагдсан ашиг	Эздийн өмчийн дүн
2022 оны 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл	165,700	1,522,271	1,687,971
Тайлант жилийн ашиг	-	6,809,147	6,809,147
2022 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	165,700	8,331,418	8,497,118
2023 оны 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл	165,700	8,331,418	8,497,118
Тайлант жилийн ашиг	-	16,396,197	16,396,197
2023 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	165,700	24,727,615	24,893,315

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй бүрдэл хэсэг болно.

365

2026.08.31

ШУНХЛАЙ ХХК
2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Түсдаа Мөнгөн Гүйлгээний Тайлан

(Мянган төгрөгөөр)	*Тод-руулга*	*2023*	*2022*
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Тайлант жилийн татварын өмнех ашиг		23,092,014	8,900,272
Тохируулгууд:			
Элэгдлийн зардал	*11,21*	1,105,500	891,387
Хорогдуулгын зардал	*12,21*	127,899	193,176
Үндсэн хөрөнгө борлуулсны олз	*22*	(1,531)	(35,262)
Дансны авлагын үнэ цэнийн бууралт	*25*	3,104,190	273,685
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн (олз)/гарз	*23*	(43,133)	200,558
Хүүгийн зардал	*23*	33,208,881	26,290,741
Хүүгийн орлого	*23*	(239,369)	-
		60,354,451	36,714,557
Хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлт:			
- Дансны авлага		(60,972,324)	(85,582,981)
- Бусад авлага		1,059,786	886,541
- Бараа материал		(29,987,801)	(26,871,405)
- Бусад хөрөнгө		(697,688)	(10,507,517)
- Дансны өглөг		(35,267,991)	40,959,448
- Бусад өглөг		(7,676,793)	9,881,049
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		(73,188,360)	(34,520,308)
Төлсөн хүүгийн зардал		(30,833,020)	(25,921,398)
Хүлээн авсан хүүгийн орлого		29,781	-
Төлсөн орлогын албан татвар		(2,351,847)	(696,890)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		**(106,343,446)**	**(61,138,596)**
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Үндсэн хөрөнгийн худалдан авалт		(18,340,764)	(2,779,010)
Үндсэн хөрөнгийн борлуулалт		371,033	-
Худалдан авсан биет бус хөрөнгө		(106,493)	(6,000)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		**(18,076,224)**	**(2,785,010)**
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Хүлээн авсан зээл	*16*	1,870,078,939	1,500,623,182
Зээлийн эргэн төлөлт	*16*	(1,799,130,654)	(1,449,440,131)
Төлсөн түрээсийн өр төлбөр		(446,561)	(333,512)
Гаргасан бонд	*17*	51,722,629	23,952,000
Төлсөн бонд	*17*	(7,542,923)	(20,000,000)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		**114,681,430**	**54,801,539**
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр бууралт		**(9,738,240)**	**(9,122,067)**
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	*6*	14,667,354	23,749,537
Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө		127,913	39,884
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	*6*	**5,057,027**	**14,667,354**

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй бүрдэл хэсэг болно.

ШУНХЛАЙ СЗХ 2026 09 10 өдөр БҮРТГЭВ № 01

2026 -09- 02 БҮРТГЭВ-03

ШУНХЛАЙ ХХК

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн

Тусдаа Санхүүгийн Тайлангийн Тодруулга

1. **Ерөнхий мэдээлэл**

Шунхлай ХХК (цаашид "Компани" гэх) нь хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр Монгол Улсад үүсгэн байгуулагдаж, үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээд юм. Компани 1995 оноос үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд Компанийн албан ёсны хаяг нь Монгол Улс, Улаанбаатар хот 17040, Хан-Уул дүүрэг, Капитал Хаус болно.

Компанийн эрхэлж буй үндсэн үйл ажиллагаа нь Шунхлай Групп компаниудын өмнөөс түлшний худалдан авалт хийх болон түлш шатахууны бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд борлуулах явдал юм. 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр Компанийн хувь нийлүүлэгч нь Шунхлай Холдинг ХХК (100%) бөгөөд эцсийн шатны толгой компани юм.

2. **Санхүүгийн тайлагналын зарчим**

(а) Тайлагналын нийцэл

Энэхүү хуулийн дагуу шаардаагүй санхүүгийн тайланг компани сайн дурын үндсэн дээр бэлтгэсэн ба хуулийн эсвэл зохицуулагч этгээдийн шаардлагаар бус харин зөвхөн хувьцаа эзэмшигчид зориулан бэлтгэсэн. Компанийн энэхүү хуулийн дагуу шаардаагүй санхүүгийн тайланг СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандарт ("СТОУС")-ын дагуу бэлтгэсэн. Компанийн мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг доор тусгасан болно.

Энэхүү тусдаа санхүүгийн тайланг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт ("НББОУС") 27 буюу "Тусдаа Санхүүгийн тайлан" хэмээх стандартын дагуу бэлтгэсэн. Уг стандартаар хараат компани эсвэл хамтын хяналттай аж ахуйн нэгжид хөрөнгө оруулсан толгой компанийг хөрөнгө оруулалтаа санхүүжигчийн тайлагнасан үр дүн. болон цэвэр хөрөнгөд бус харин өмчийн шууд хувь оролцоонд үндэслэн нягтлан бодох бүртгэлд тусгахыг шаарддаг.

Компани нь гуреан охин компанитай ба эдгээр нь Эс Жи Шивээ Хүрэн Депо ХХК болон Эс Жи Ханги Гэйт ХХК болон Шунхлай Ойл ХХК юм. Эс Жи Ханги Гэйт ХХК, Эс Жи Шивээ Хүрэн Депо ХХК болон Шунхлай Ойл ХХК-ууд нь 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдөр, 2022 оны 02 дугаар сарын 07-ны өдөр болон 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр түс бүр үүсгэн байгуулагдсан.

Компанийн удирдлагаас Шунхлай ХХК-ийн санхүүгийн тайланг 2024 оны 6 дугаар сарын 20-ны өдөр нийтлэн гаргахыг зөвшөөрч батлав.

(б) Үнэлгээний суурь

Энэхүү санхүүгийн тайлан нь түүхэн өртгийн зарчимд үндэслэн бэлтгэгдсэн.

(в) Тасралтгүй үйл ажиллагаа

Санхүүгийн тайланг удирдлагын зохистой гэж үнэлсэн тасралтгүй байх зарчимд суурилан бэлтгэсэн.

(г) Үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг бэлтгэсэн валют

Энэхүү санхүүгийн тайланг бэлтгэж, тайлагнахдаа Компанийн үйл ажиллагаагаа эрхэлж буй эдийн засгийн орчны үндсэн валют бөгөөд Компанийн үйл ажиллагааны валют болох Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлсэн. Тусгайлсан хэсэгт онцлон зааснаас бусдаар санхүүгийн тайланг мянгачилж толилуулсан.

УЛААНБААТАР ХОТ ШУНХЛАЙ ХХК

Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital Delivering Excellence 1119289111 5481589 Улаанбаатар хот

367

2026.08.31

ШУНХЛАЙ ХХК 2026 -09- 10 БҮРТГЭЛ № 01

MONGOLIAN STOCK EXCHANGE 2026 -09- 02 БҮРТГЭЛ-03

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Тусдаа Санхүүгийн Тайлангийн Тодруулга

2. Санхүүгийн тайлагналын зарчим, үргэлжлэл

(д) Таамаглал, тооцоолол ба үнэлгээг хэрэглэх нь

Санхүүгийн тайланг бэлтгэх үйл явц нь таамаглал, тооцоолол болон үнэлгээ хэрэглэхийг удирдлагаас шаардаг ба энэхүү таамаглал, тооцоолол, үнэлгээ нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт болон бүртгэсэн хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын дүнг тодорхойлоход нөлөөлдөг. Гүйцэтгэлээрх үр дүн нь эдгээр тооцооллоос зөрүүтэй байж болно.

Үнэлгээ, тооцоолол түүнийг хийхэд хэрэглэсэн гол чухал таамаглал, төсөөлөл нь байнга хянаж шалгагдаж байдаг. Нягтлан бодох бүртгэлийн тооцоололд хийсэн өөрчлөлтийн нөлөөллийг тухайн өөрчлөлт хийгдсэн тайлант жил болон ирээдүйн тайлант жилүүдэд тусгадаг.

Санхүүгийн тайланд мэдэгдэхүйц нөлөө бүхий нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд хэрэглэсэн таамаглал, тооцоолол, үнэлэмжийн талаарх мэдээлэл болон дараагийн тайлант үед хамаарах материаллаг залруулгын нөлөө бүхий эрсдэлийн үндэслэл болон тооцооллын талаарх мэдээллийг доорх тодруулгуудад тусгасан:

- Тодруулга 7 – Дансны авлагын үнэ цэнийн бууралтын нөөц;

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд

Энэхүү санхүүгийн тайланг бэлтгэхэд баримталсан нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудыг доор хураангуйлан харуулав. Компани эдгээр нягтлан бодох бүртгэлийн бодлогуудыг тодруулга 2 болон 3-т тусгаснаас бусад тохиолдолд энд үзүүлсэн бүх тайлант жилүүдэд тууштай мөрдсөн болно.

Компани 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлогын Тодруулга (НББОУС 1 болон СТОУС Практик Мэдэгдэл 2-ын нэмэлт өөрчлөлт)-ын шаардлагыг мөрдсөн. Хадийгээр нэмэлт өөрчлөлтүүд нь Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогод аливаа өөрчлөлтийг оруулаагүй боловч уг нэмэлт өөрчлөлтүүд нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэлд нөлөөлж, санхүүгийн тайланд тодруулагдсан.

Нэмэлт өөрчлөлтүүд нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын "үндсэн" гэх үхагдахууныг халж, нягтлан бодох бүртгэлийн "материаллаг" бодлогуудыг тодруулахыг шаардсан. Нэмэлт өөрчлөлтүүд нь мөн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тодруулахад материаллаг байдлыг хэрхэн мөрдөх талаарх удирдамжийг агуулсан. Мөн уг нэмэлт өөрчлөлтүүд нь санхүүгийн тайлангийн мэдээлэл хэрэглэгчдийг санхүүгийн тайлангийн бусад мэдээллийг ойлгоход нь туслахуйц хэрэгцээтэй, тухайн байгууллагын онцлогийг тусгасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын талаарх мэдээллээр хангахад нь тухайн байгууллагад туслахад чиглэсэн.

(а) Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээ

Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлсийг тайлагналын өдрийн хаалтын ханшаар төгрөгт хөрвүүлж илэрхийлдэг. Хөрвүүлэлтээс үүссэн ханшийн зөрүүний олз, гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн ба түүхэн өртгөөр бүртгэгдсэн мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрийг уг хөрөнгө, өр төлбөрийг анх бүртгэсэн өдрийн ханшаар төгрөгт хөрвүүлдэг.

УЛААНБААТАР ХОТ ШУНХЛАЙ ХХК

368

Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital Delivering Diversity 1119289111 5481589 Улаанбаатар хот

2026.08.31

ШУНХЛАЙ ХХК
2026 .09. 1 өдөр
БҮРТГЭЛ
№ 91
2026 -09- 12
БҮРТГЭЛ-03

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд, үргэлжлэл

(б) Санхүүгийн хэрэглүүр

Компани үүсмэл бус санхүүгийн хөрөнгийг дараах ангиллын дагуу ангилдаг. Үүнд: хорогдуулсан өртгөөр хэмжсэн; бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнэ (БДОБҮЦ) болон ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр (ААБҮЦ) хэмжсэн санхүүгийн хөрөнгө зэрэг багтана. Компани үүсмэл бус санхүүгийн өр төлбөрийг хорогдуулсан өртгөөр хэмжсэн болон ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн өр төлбөр гэж ангилдаг.

(i) Үүсмэл бус санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр – хүлээн зөвшөөрөлт ба үл хүлээн зөвшөөрөлт

Компани дансны авлага болон өрийн үнэт цаасыг анх үүссэн өдөр нь хүлээн зөвшөөрнө. Бусад бүх санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг анх гэрээний нөхцөл Компанид хамааралтай болох тэр үед хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн хөрөнгийн мөнгөн гүйлгээнд хамаарах гэрээний эрхийн хугацаа дуусан эсвэл уг санхүүгийн хөрөнгийн мөнгөн гүйлгээг хүлээн авах гэрээний эрхийг шилжүүлсэн бөгөөд санхүүгийн хөрөнгийн эзэмшилтэй холбоотой бүх эрсдэл, өгөөжийг бараг бүтдийг нь шилжүүлсэн эсвэл шилжүүлээгүй бөгөөд эрсдэл, өгөөжийг хадгалаагүй бөгөөд хяналтыг авч үлдээгүй бол уг санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрдөг.

Компани нь санхүүгийн өр төлбөрийг гэрээнд тодорхойлсон үүрэг хариуцлага дуусгавар болсон, цуцлагдсан эсвэл хугацаа дуусгавар болсон үед санхүүгийн байдлын тайланд үл хүлээн зөвшөөрдөг. Компани нь санхүүгийн өр төлбөрийн нөхцөл өөрчлөгдөж, өөрчлөгдсөн өр төлбөрийн мөнгөн урсгал материаллаг хэмжээнд ялгаатай бөгөөд өөрчлөгдсөн нөхцөлд үндэслэн шинэ санхүүгийн өр төлбөрийг бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрсөн тохиолдолд өмнөх санхүүгийн өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрөх үед, дансны үнэ ба төлсөн төлбөр (үүнд шилжүүлсэн мөнгөн бус хөрөнгө эсвэл таамагласан өр төлбөр багтана)-ийн зөрүүг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

(ii) Үүсмэл бус санхүүгийн өр төлбөр

Компани үүсмэл бус санхүүгийн өр төлбөрийг хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн өр төлбөр, эсвэл ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн өр төлбөр гэж ангилдаг. Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн өр төлбөр гэдэгт арилжаалах зориулалтаар эзэмших нөхцөлийг хангасан эсвэл анх хүлээн зөвшөөрөх үед уг өр төлбөрийг ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр нь тодорхойлсон байвал энэ ангиллын санхүүгийн өр төлбөрт хамааруулна. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн өр төлбөр нь бодит үнэ цэнээрээ хэмжигдэх бөгөөд гарсан аливаа өөрчлөлтийг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн өр төлбөрөөс бусад үүсмэл бус санхүүгийн өр төлбөрийг бусад санхүүгийн өр төлбөрийн ангилалд хамааруулдаг. Анхны хүлээн зөвшөөрөлтийн өдөр бусад санхүүгийн өр төлбөрийг хорогдуулсан өртгөөр хэмждэг ба анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа үед бусад санхүүгийн өр төлбөрийг үр ашиг хүүгийн аргаар хорогдуулсан өртгөөр хэмждэг. Хүүгийн зардал, гадаад валютын ханшийн зөрүүгийн олз, гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Бусад цэвэр олз, гарзыг мөн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

(iii) Санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг цэвэр дүнгээр тусгах нь

Компани хүлээн зөвшөөрөгдсөн дүнг хооронд нь хааж, цэвэр дүнгээр тусгах, хууль, эрх зүйн үндэслэлтэй эсэх, мөн цэвэр дүнгээр нь төлбөр хийх эсвэл нэгэн зэрэг хөрөнгийг борлуулах, өр төлбөрийг барагдуулах зорилготой үед санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хааж санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр нь тусгадаг.

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
369
Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
1119289111 5481588
Улаанбаатар хот
2026.08.31

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд, үргэлжлэл

(в) Үнэ цэнийн бууралт

(i) Үүсмэл бус санхүүгийн хөрөнгө

Компани хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын санг (i) хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө, (ii) БДОБҮЦ-ээр хэмжсэн өрийн хөрөнгө оруулалт (iii) гэрээний хөрөнгийн хувьд хүлээн зөвшөөрдөг.

Компани алдагдлын санг 12 сарын хугацаанд хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын сангаар хэмжсэн дараахаас бусад хөрөнгийн хувьд уг хөрөнгийн эзэмших эрх дуусах хугацаанд хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын санг хэмждэг. Үүнд:

- Тайлангийн өдрөөр хүлээгдэж буй эрсдэлийг бага гэж тодорхойлсон өрийн үнэт цаас; болон
- Анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш тухайн хөрөнгийн эрсдэлд мэдэгдэхүйц өсөлт үүссэгүй бусад өрийн үнэт цаас болон банкны үлдэгдэл

Анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш тухайн санхүүгийн хөрөнгийн эрсдэлд мэдэгдэхүйц өсөлт үүссэн эсэхийг тодорхойлж, хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын санг тооцохын тулд Компани нь холбоотой бөгөөд аливаа нэмэлт зардал эсвэл хүчин чармайлт гаргахгүйгээр олж авах боломж бүхий үндэслэлтэй бөгөөд нотлогдохуйц мэдээллүүдийг харгалзан үздэг. Үүнд Компанийн түүхэн мэдээлэлд үндэслэн чанарын болон тоон үзүүлэлтэд шинжилгээ хийх, мэдээлсэн эрсдэлийн үнэлгээ болон ирээдүйн тоон мэдээлэл багтана. Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн алдагдлын санг тухайн хөрөнгийн нийт дансны үнээс хасна. БДОБҮЦ-шээр хэмжсэн өрийн үнэт цаасын хувьд алдагдлын санг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрч, санхүүгийн байдлын тайлан дах санхүүгийн хөрөнгийн дансны үнийг бууруулахгүй.

Компани авлагын үнэ цэнийн бууралтын талаарх боломжтой түүхэн мэдээлэл, үйл ажиллагаа явуулж буй бүс нутаг болон салбарын мэдээлэл, ирээдүйг чиглэсэн хүчин зүйлсээр тохируулсан түүхэн авлага цуглуулалтын туршин зэргийг харгалзан үзэж авлагын үнэ цэнийн бууралтыг тооцолоход матрицын аргачлалыг ашигладаг. Үнэ цэнийн бууралтын нөөцийг өөр өөр хувь ашигласан хугацаа хэтрэлтийн өдрүүдэд үндэслэн тооцно. Шаардлагатай тохиолдолд тодорхой харилцагчдын тусгайлсан нөхцөл байдлыг харгалзан үзэж нөөцийн санд тохируулга хийдэг.

Компанийн санхүүгийн хөрөнгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн нөхөх хангалттай хүлээлт байхгүй тохиолдолд санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнийг данснаас хасна. Данснаас хассан санхүүгийн хөрөнгө нь Компанийн эргэн төлөгдөх хугацаа нь болсон хөрөнгийг эргэн төлүүлэхтэй холбоотой гүйцэтгэдэг горимын дагуу албадлагын ажиллагааг хийх боломжтой.

(ii) Санхүүгийн бус хөрөнгө

Бараа материал болон хойшлогдсон татварын хөрөнгөөс бусад санхүүгийн бус хөрөнгүүдийн дансны үнэд хөрөнгийн үнэ цэнэ буурч болзошгүй болохыг илтгэх шинж тэмдэг байгаа эсэхийг тайлант үе бүрийн эцэст үнэлдэг. Хэрэв ийм шинж тэмдэг илэрвэл хөрөнгийн нөхөгдөх дүнг тооцоолдог.

Компани бие даасан хөрөнгийн нөхөгдөх дүнг тооцдог ба хэрэв хөрөнгийн бие даасан нөхөгдөх дүнг тооцоолох боломжгүй бол Компани хөрөнгөтэй хамааралтай мөнгөн хөрөнгө бий болгогч нэгжийн нөхөгдөх дүнг тодорхойлдог. Мөнгөн хөрөнгө бий болгогч нэгж гэдэг нь бусад хөрөнгө буюу хөрөнгийн бүлгээс орох мөнгөн орлогын урсгалаас ихэвхэн хамааралтай мөнгөн орлогыг үүсгэдэг хөрөнгийн тодорхойлж болох хамгийн бага бүлэг юм.

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
ТТА2531 ᠓ 2025 ᠓ 06

370

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
1119269111 ᠓ 5491509
Улаанбаатар хот

2026.08.31

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд, үргэлжлэл

(в) Үнэ цэнийн бууралт, үргэлжлэл

(ii) Санхүүгийн бус хөрөнгө, үргэлжлэл

Менгөн хөрөнгө бий болгогч нэгжийн хувьд нөхөгдөх дүн нь менгөн хөрөнгө бий болгогч нэгжийн борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнэ болон ашиглалтын үнэ цэнийн аль их нь байдаг. Ашиглалтын үнэ цэнийг тооцохдоо хөрөнгийн хувьд онцлог эрсдэл болон менгөний цаг хугацааны үнэ цэнийн одоогийн зах зээлийн үнэлгээг тусгасан татварын өмнөх хувь хэмжээг ашиглан хөрөнгийг тасралтгүй ашигласнаас болон ашиглагдахаар тооцсон хугацааны эцэст данснаас хасах үед үүсэхээр хүлээгдэж буй тооцоолсон ирээдүйн менгөн урсгалын өнөөгийн үнэ цэнээр хэмждэг. Үнэ цэнийн бууралтын гарзыг хөрөнгө эсвэл менгөн хөрөнгө бий болгогч нэгжийн дансны үнэ нь нөхөгдөх дүнгээс хэтэрсэн үед хүлээн зөвшөөрдөг. Үнэ цэнийн бууралтын гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг. Нөхөгдөх дүнг тодорхойлоход хийгдсэн тооцоололд өөрчлөлт орсон бол үнэ цэнийн бууралтын гарзыг буцаана. Үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд хөрөнгийн байх байсан дансны үнээс элэгдэл, хорогдлыг хассан цэвэр дүнгээс хэтрэхгүй хэмжээгээр буцаана.

(г) Бараа материал

Бараа материалын өртгийг жигнэсэн дундаж өртгийн аргаар тодорхойлдог ба бараа материалын өртөгт худалдан авалтын өртөг, хувиргалтын зардал болон одоогийн байршил ба нөхцөлд бараа материалыг авчрахтай холбогдож гарсан зардал багтдаг. Үйлдвэрлэсэн бараа материал, дуусаагүй үйлдвэрлэлийн өртөгт хэвийн хүчин чадлаар ажиллах үеийн үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлын зохих хэсгийг хуваарилдаг.

Бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар хэмждэг. Цэвэр боломжит үнэ цэнэ гэж бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад борлуулахаар тооцсон үнээс түүнийг иж бүрдэл болгохоор тооцсон зардал ба борлуулахад шаардагдах тооцсон зардлыг хассан дүн юм. Бараа материалын өртгийг цэвэр боломжит үнэ цэнэ хүртэл бууруулсан дүн болон бараа материалын аливаа алдагдлыг тухайн тайлант хугацаанд нь зардлаар хүлээн зөвшөөрдөг. Цэвэр боломжит үнэ цэнийн өсөлтөөс үүссэн бараа материалын бууралтын аливаа буцаалт нь тухайн буцаалт хийгдсэн тайлант хугацаанд зардал хэмээн хүлээн зөвшөөрч бүртгэсэн бараа материалын дүнгийн бууралтаар хүлээн зөвшөөрөгддөг.

(д) Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг анх өртгөөр нь илэрхийлэх ба анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа үндсэн хөрөнгийг түүний өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр тайлагнадаг. Үндсэн хөрөнгийн өртөгт тухайн хөрөнгийг худалдан авах, барьж байгуулахтай шууд холбогдон гарсан зардал, мөн удирдлагын зорилгоор үйл ажиллагаа явуулахад бэлэн болгож түүнийг байршуулах болон шаардлагатай нөхцөлийг хангахтай холбогдон гарсан бусад зардлууд, мөн тухайн хөрөнгийг задлах, зайлуулах болон байрлаж байсан талбайг нь сэргээн засварлахад гарах зардлуудыг хамааруулна.

Үндсэн хөрөнгийн мэдэгдэхүйц хэсэг нь тусдаа ашиглалтын хугацаатай бол тусдаа ангиллаар үндсэн хөрөнгийн дансанд бүртгэнэ.

Компани нь дараа үеийн зардлаас эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг хүртэх магадлалтай бөгөөд тухайн зардлыг үнэн зөв хэмжих боломжтой болсон үед түүнийг үндсэн хөрөнгийн дансны үнэ дээр нэмэгдүүлэх буюу эсвэл тусдаа хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Солигдсон эд ангийн дансны үнээр хөрөнгийн дансны үнийг бууруулна. Өдөр тутмын үйлчилгээний зардлыг тухайн зардал гарсан тайлант үеийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
ТТА3531 № 2025498
371
Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
Улаанбаатар хот
2026.08.31

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд, үргэлжлэл

(д) Үндсэн хөрөнгө, үргэлжлэл

Үндсэн хөрөнгийн элэгдлийг түүний ирээдүйд авчрах эдийн засгийн үр өгөөжөөс нь хамаарч ашиглах хугацаанд шулуун шугамын аргаар тооцон байгуулдаг. Үндсэн хөрөнгийн нийт өртгийн дунд багтсан гол бүрэлдэхүүн хэсгийн ашиглах хугацаа ялгаатай байгаа тохиолдолд тэдгээрт тусад нь элэгдэл байгуулдаг.

Үндсэн хөрөнгийг ашиглахаар тогтоосон хугацаа дараах байдалтай байна:

	Ашиглалтын жил
Барилга	40
Тавилга, эд хогшил	10
Тоног төхөөрөмж	10
Тээврийн хэрэгсэл	10
Компьютер болон дагалдах хэрэгсэл	3-10

Үндсэн хөрөнгийн дансны үнэ болон данснаас хассан цэвэр орлогын зөрүүгээр үндсэн хөрөнгийг данснаас хассаны олз, гарзыг тухайн жилийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

Элэгдэл тооцох арга, ашиглалтын жил болон үлдэх өртгийг санхүүгийн жил бүр хянаж үздэг ба шаардлагатай бол залруулдаг. Өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтөөр тайлагнадаг.

(е) Биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрч бүртгэх ба анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа түүний өртгөөс нь хуримтлагдсан хорогдуулга ба үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр бүртгэнэ.

Биет бус хөрөнгийн хорогдуулгыг тэдгээрийг ашиглах боломжтой болсон өдрөөс эхлэн ашиглалтын хугацааны туршид шулуун шугамын аргаар тооцдог. Биет бус хөрөнгийн үлдэх өртөг тэг байна.

	Ашиглалтын жил
Программ хангамж	3-5

Тодорхой ашиглагдах жил бүхий биет бус хөрөнгийн хорогдуулга тооцох арга, ашиглалтын жилийг санхүүгийн жил бүр хянаж үздэг. Хорогдуулга тооцдоггүй биет бус хөрөнгийн ашиглагдах жилийн хувьд тэдгээр хөрөнгийн тодорхой бус ашиглалтын жилийн үнэлгээг цаашид нотлох аливаа үйл явдал, нөхцөл байдал байгаа эсэхийг тодорхойлохын түлд санхүүгийн жил бүр хянаж үздэг. Өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтөөр тайлагнадаг.

Компани нь дараа үеийн зардлаас эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг хүртэх магадлалтай үед зардлыг капиталжуулдаг. Дотоодод бий болсон гүүдвилл болон брэндийн зардлыг хамруулсан бусад бүхий л зардлыг гарсан тухайн үед нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

2026 09 10
БҮРТГЭВ

2026 09 02
БҮРТГЭВ

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд, үргэлжлэл

(ё) Ажилчдын тэтгэвэр, тэтгэмж

(i) Ажилчдын богино хугацаат тэтгэмж

Холбогдох үйлчилгээ үзүүлсэн үед ажилчдын богино хугацаат тэтгэмжийг зардлаар бүртгэдэг. Компани нь ажилтны үзүүлсэн үйлчилгээний дагуу Компанид үүрэг хариуцлага үүссэнээс найдвартайгаар тооцоолж болох Компанийн төлөх ёстой дүнгээр өр төлбөрөө хүлээн зөвшөөрдөг.

(ii) Улсад төлөх тэтгэвэр, тэтгэмжийн төлөвлөгөө

Ажилчдын тэтгэвэр, тэтгэмж нь Монгол Улсын Нийгмийн Даатгалын Сан төлөрүүлэх хуулиар тогтоосон нийгмийн даатгалын шимтгэлээс бүрдэнэ. Тэтгэвэр, тэтгэмжийн хөтөлбөрт төлөрүүлэх шимтгэлийг түүнийг төлөх үүрэг хүлээсэн тайлант үеийн ажилчдын зардлаар бүртгэдэг.

(ж) Нөөц

Компани өнгөрсөн үйл явдлын үр дүнд өнөөгийн хуулиар хүлээсэн эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн, уг үүрэг хариуцлагын төлбөрийг барагдуулахад эдийн засгийн өгөөж бүхий нөөц шаардлагатай гэдэг нь тодорхой болсон ба үүрэг хариуцлагын дүнг найдвартай тооцоолох боломжтой болсон үед нөөцийг хүлээн зөвшөөрдөг.

Нөөцийн хамгийн сайн тооцооллыг хийхийн тулд үйл явдал, нөхцөл байдлын хүрээлэн байгаа эрсдэл, тодорхойгүй байдал зэргийг тус тус харгалзаж үзэх ёстой. Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ нь материаллаг нөлөөтэй бол нөөцийн дүн нь ирээдүйд хүлээгдэж буй мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ байдаг.

Нөөцийн төлбөрийг барагдуулахад шаардагдах зарлагыг бүхэлд нь эсвэл зарим хэсгийг нь өөр нэг талаас нөхөн авахаар хүлээгдэж байгаа үед, хэрэв Компани үүрэг хариуцлагынхаа дагуу төлбөрийг барагдуулсан үед нөхөн олгоор хүлээн авах нь тодорхой байх нөхцөлд л зөвхөн нөхөн олговрыг хүлээн зөвшөөрөх ёстой. Нөхөн олговрыг тусад нь хөрөнгө гэж үздэг.

Нөөцийн дүнг тайлангийн хугацааны эцэс бүрт давтан шалгаж, тайлангийн үеийн хамгийн сайн тооцооллыг тусгахын тулд тохируулж байдаг. Хэрэв үүрэг хариуцлагын төлбөрийг барагдуулахад шаардагдах эдийн засгийн өгөөж бүхий нөөцийн гадагшлах урсгал нь магадлал багатай бол нөөцийн дүнг буцаадаг.

(з) Хувьцаат капитал

Энгийн хувьцаа нь эздийн өмчийн хэсэгт ангилагддаг. Энгийн хувьцаа болон хувьцааны опцион (худалдан авах эрх) гаргахад шууд холбогдон гарах өсөн нэмэгдэх зардлыг аливаа татварын нөлөөллөөс цэвэр дүнгээр өмчийн дүнгээс бууран хүлээн зөвшөөрдөг.

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
ТТА3531 № 2022469

373

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering Diversity
1119289111 5481589
Улаанбаатар хот

2026.08.31

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд, үргэлжлэл

(и) Орлого

Орлого нь нефтийн бүтээгдэхүүний бөөний борлуулалт болон холбоотой түлшний компаниудад үзүүлэх менежментийн үйлчилгээний төлбөрөөс бүрддэг.

(i) Нефтийн бүтээгдэхүүний бөөний борлуулалт

Хэрэглэгчийн худалдан авалтын нөхцөлийг тодорхойлсон бөөний борлуулалтын гол баримт бичиг нь Худалдах, худалдан авах гэрээ юм. Борлуулалтын орлого нь нефтийн бүтээгдэхүүний борлуулалтаас хөнгөлөлтийг хассан дүнгээс бүрдэнэ. Худалдах, худалдан авах гэрээгээр үүсэх гүйцэтгэлийн үүргийг хэрэглэгчид барааны хяналт шилжсэн үед хүлээн зөвшөөрдөг ба энэ нь худалдан авагчид хяналт шилжихтэй давхцдаг. Орлогыг гэрээнд тохиролцсон гүйлгээний үнэ эсвэл тооцоолсон үнийн дагуу хэмжинэ. Бүтээгдэхүүний хүргэлт хийгдсэн үед харилцагчид нэхэмжлэх илгээнэ.

Худалдах, худалдан авах гэрээ болон холбогдох захиалгын хуудаснууд нь хууль ёсны дагуу хэрэгждэг ба СТОУС 15-ын дагуу гэрээний бүх шалгуурыг хангасан байдаг.

Борлуулалтын үнэ нь Компани бүтээгдэхүүнийг хэрэглэгчид шилжүүлсний үр дүнд хүлээн авахаар хүлээгдэж буй хөнгөлөлт ба бүцаалтын дараах цэвэр үнийг хэлнэ. Хэрэглэгчид барааны хяналт шилжих үед гүйцэтгэлийн үүрэг хангагдсанаар Компани борлуулалтыг хүлээн зөвшөөрдөг. Хэрэглэгч барааны хяналтыг авах үед Компани бараг шилжүүлдэг бөгөөд энэ нь барааны эрсдэл болон өгөөж шилжихтэй давхцдаг. Тиймээс барааны хяналт хэрэглэгчид шилжих үед Компани борлуулалтыг хүлээн зөвшөөрдөг.

(ii) Менежментийн үйлчилгээ

Менежментийн үйлчилгээг зохицуулдаг мөн гүйцэтгэлийн үүргийг тогтоодог гол баримт бичиг нь Үйлчилгээний гэрээ юм. Орлого нь холбоотой талууд болох шатахууны Компаниудад үзүүлсэн менежментийн үйлчилгээний төлбөрөөр илэрхийлэгдэнэ. Үйлчилгээг гүйцэтгэлийн үүргийг биелүүлсэн үед хүлээн зөвшөөрдөг бөгөөд үйлчилгээний гэрээнд тохиролцсон гүйлгээний үнийн дагуу хэмжинэ. Менежментийн үйлчилгээ авч буй холбоотой талуудад сар бүр нэхэмжлэх илгээнэ.

Холбоотой талуудад үйлчилгээг үзүүлсэн үед гүйцэтгэлийн үүрэг хангагдсанаар Компани орлогыг хүлээн зөвшөөрдөг. Холбоотой талууд үйлчилгээний үр дүнгийн хяналтыг авах үед Компани үйлчилгээг үзүүлсэнд тооцно.

(iii) Компани агент үүрэг гүйцэтгэх нь

Хэрэв Компани нь агентын үүрэг гүйцэтгэгч бол гүйцэтгэлийн үүрэг нь тодорхой бараа, үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах юм. Тиймээс орлогоо хүлээн зөвшөөрөхдөө өөрийн авахаар хүлээгдэж буй аливаа төлбөр, шимтгэлд харгалзах цэвэр дүнгээр илэрхийлэгдэнэ. Компанийн хүлээн авах төлбөр эсвэл шимтгэл нь бусад талуудад төлбөр хийсний дараа Компанид хадгалагдах цэвэр төлбөрийн дүн байж болно. Компани нь тухайн бараа, үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах үүргээ биелүүлсний дараа орлогоо хүлээн зөвшөөрдөг.

СЗХ
2026 .09 .10 өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2026 09 07
БҮРТГЭВ-03

ШУНХЛАЙ ХХК

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн

Тусдаа Санхүүгийн Тайлангийн Тодруулга

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд, үргэлжлэл

(й) Санхүүгийн орлого ба санхүүгийн зардал

Санхүүгийн орлого нь хүүгийн орлого ба ногдол ашгийн орлогоос бүрддэг. Хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргыг ашиглан ашиг, алдагдлаар хуримтлуулан хүлээн зөвшөөрдөг. Ногдол ашгийн орлогыг Компанид ногдол ашиг хүлээн авах эрх үүссэн үед нь хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Санхүүгийн зардал нь зээлийн хүүгийн зардлаас бүрддэг. Хөрөнгө худалдан авах, бүтээн босгох болон бэлтгэл шаардагдах хөрөнгийг бий болгоход гарсан шууд ногдох зардалд ордоггүй зээлийн хүүгийн зардлуудыг үр ашигт хүүгийн аргыг ашиглан ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

Гадаад валютын ханшийн зөрүүний олз, гарзыг цэвэр дүнгээр нь санхүүгийн орлого эсвэл санхүүгийн зардлын аль нэгэнд нь тухайн гадаад валютын хөдөлгөөний олз, гарзад нөлөөлөх цэвэр үр дүнд нь тулгуурлан тайлагнадаг.

(к) Орлогын татвар

Орлогын татварын зардал нь тайлант үеийн татвар болон хойшлогдсон татвараас бүрддэг. Орлогын татварын зардлыг өмчийн дансанд шууд хүлээн зөвшөөрдөг зүйлстэй холбоотойгоос бусад тохиолдолд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

(i) Тайлант үеийн татвар

Тайлант үеийн татвар гэдэг нь өмнөх жилүүдийн татварын өрийн тохируулга болон тайлант үеийн эцэст хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан эсвэл мөрдөгдөж байгаа татварын хувь хэмжээг ашиглан тухайн жилийн татвар ногдох ашиг, татварын алдагдалд суурилан хүлээгдэж буй татварын өр эсвэл авлага юм. Татвар ногдох ашгийг тооцохдоо ирээдүйн тайлант үеийн татвар ногдох ашиг (татварын алдагдал)-ийг тодорхойлоход хэрэглэгдэх татвар ногдох орлого эсвэл татвараас хасагдах зардлаар тооцогдох түр зөрүү, мөн нягтлан бодох бүртгэлийн ашгийн татвар ногдохгүй орлого, татвараас хасагдахгүй зардал зэргийг харгалзан үздэггүй учраас татвар ногдох ашиг нь нягтлан бодох бүртгэлийн ашгаас ялгаатай байдаг.

(ii) Хойшлогдсон татвар

Хойшлогдсон татварыг хөрөнгө-өр төлбөрийн аргыг ашиглан хүлээн зөвшөөрч бүртгэдэг бөгөөд энэ арга нь санхүүгийн тайлангийн зорилгоор хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ болон татварын зорилгоор ашиглагдах дүн хоёрын хоорондох түр зөрүүн дээр үндэслэдэг арга юм. Бүх татвар ногдох түр зөрүүнд хойшлогдсон татварын өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөг.

Гэвч дараах түр зөрүүнүүдэд хойшлогдсон татварыг хүлээн зөвшөөрдөггүй. Үүнд гүүдвиллийн анхдагч хүлээн зөвшөөрөлт, эсвэл бизнесийн нэгдэл биш бөгөөд ажил гүйлгээ гарах үед нягтлан бодох бүртгэлийн ашиг болон татвар ногдох ашиг, татварын алдагдлын аль алинд нөлөөлөхгүй ажил гүйлгээн дэх хөрөнгө буюу өр төлбөрийн анхдагч хүлээн зөвшөөрөлт.

Хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг тайлант хугацааны эцэс бүрт дахин хянаж үздэг ба хойшлогдсон татварын хөрөнгийн бүх эсвэл зарим өгөөжийг хүртэх хангалттай хэмжээний татвар ногдох ашиг олох магадлал үгүй болох үед Компани хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг бууруулдаг.

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
1119289111 5491309
Улаанбаатар хот

ШУНХЛАЙ СЭХ 2026.09.10 өдөр БҮРТГЭВ № 01

MONGOLIAN STOCK EXCHANGE 2026-09-12 БҮРТГЭВ-03

ШУНХЛАЙ ХХК
2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн
Тусдаа Санхүүгийн Тайлангийн Тодруулга

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд, үргэлжлэл

(к) Орлогын татвар, үргэлжлэл

(ii) Хойшлогдсон татвар, үргэлжлэл

Тайлант үеийн эцэст хучин төгөлдөр болсон эсвэл хучин төгөлдөр мөрдөж байгаа татварын хувь хэмжээ (татварын хууль)-нд үндэслэн хөрөнгө нь хэрэгжих бүюу өр төлбөрийг төлөх тайлант үед мөрдөгдөхөөр хүлээгдэж буй татварын хувь хэмжээгээр хойшлогдсон татварын хөрөнгө болон өр төлбөрийг хэмждэг. Тайлант үеийн эцэст Компани нь хойшлогдсон татварын өр төлбөр болон хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг нөхөх бүюу барагдуулах арга хэлбэрээс үүсэж байгаа татварын үр нөлөөг хойшлогдсон татварын өр төлбөр болон хойшлогдсон татварын хөрөнгийн хэмжилтэд тусгадаг.

Компани нь тайлант үеийн татварын өр төлбөрийг тайлант үеийн татварын хөрөнгөөр суутган тооцох хууль ёсны хучин төгөлдөр эрхтэй байх, орлогын татвараар тооцоо хийдэг ижил татварын албатай харьцдаг ба тайлант үеийн татварын өр төлбөр болон хөрөнгийг цэвэр суриар барагдуулахаар төлөвлөсөн тохиолдолд хойшлогдсон татварын өр төлбөр болон хөрөнгийг цэвэр дүнгээр тооцдог.

(л) Түрээс

Гэрээг анх байгуулах үед Компани нь тухайн гэрээ нь түрээсийн гэрээ юу эсвэл түрээс агуулсан гэрээ юу гэдгийг үнэлдэг. Хэрэв гэрээ нь тодорхой төлбөр хүлээн авснаар тухайлсан хөрөнгийн хэрэглээг тодорхой хугацаанд хянах эрхийг олгож байвал тухайн гэрээ нь түрээсийн гэрээ эсвэл түрээсийг агуулсан гэрээ гэж үзнэ. СТОУС 16-ын дагуу түрээсийг 'тодорхой хугацаанд хөрөнгө ашиглах эрхээ төлбөрийн солилцоогоор шилжүүлэх гэрээ эсвэл гэрээний нэг хэсэг' гэж тодорхойлсон.

Түрээсийн бүрэлдэхүүнийг агуулсан гэрээг эхлэх эсвэл өөрчлөх үед Компани гэрээнд тусгасан үнийг үндэслэн түрээсийн бүрэлдэхүүн хэсэг бүрт хуваарилдаг. Оффисын түрээсийн хувьд Компани нь түрээсийн бус бүрэлдэхүүн хэсгүүдийг салгаагүй ба түрээсийн болон түрээсийн бус бүрэлдэхүүн хэсгүүдийг нэг бүрэлдэхүүн хэсэг гэж бүртгэдэг.

Компани нь түрээс эхлэх өдөр ашиглах эрхтэй хөрөнгө болон түрээсийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөг. Ашиглах эрхтэй хөрөнгийг анх өртгөөр нь хэмжих бөгөөд үүнийг түрээсийн эхний өдөр болон түүнээс өмнө хийсэн түрээсийн төлбөрөөр тохируулсан түрээсийн өр төлбөрийн анхны дүн, аливаа анхдагч шууд зардлууд болон хөрөнгийг салгаж буулгах, сэргээн засварлахад түрээслэгчээс гарах аливаа тооцоолсон болон түрээсийн урамшууллыг хассан дүнгээр илэрхийлдэг.

Ашиглах эрхтэй хөрөнгийг гэрээ эхэлсэн өдрөөс дуусах өдөр хүртэл шугаман шугамын аргаар элэгдүүлнэ. Мөн ашиглах эрхтэй хөрөнгийг цаашид үнэ цэнийн бууралт байгаа тохиолдолд тайлант хугацаанд бууруулж бүртгэх ба түрээсийн өр төлбөрийн дахин хэмжилтээс шалтгаалан тохируулагдана.

Түрээсийн өр төлбөрийг анх хэмжихдээ түрээсийн эхний өдрөөрх төлөгдөөгүй түрээсийн төлбөрүүдийг түрээст агуулагдсан нууцлалт хүүгийн хувь хэмжээ эсвэл уг хувь хэмжээг тодорхойлох боломжгүй бол Компанийн өсөн нэмэгдэх зээлийн хүүгийн хувь хэмжээг ашиглан дискаунталсан өнөөгийн үнэ цэнээр хэмжинэ.

Компани нь өсөн нэмэгдэх зээлийн хүүгийн хувь хэмжээг хэд хэдэн хөндлөнгийн санхүүгийн эх үүсвэрээс хүүгийн хувь хэмжээг авах замаар тодорхойлдог бөгөөд түрээсийн нөхцөл, түрээсэлсэн хөрөнгийн төрлийг илэрхийлэх тодорхой тохируулгуудыг хийдэг.

УЛААНБААТАР ХОТ ШУНХЛАЙ ТТ 2026.08.08

Голомт Капитал ҮЦК ХХК Golomt Capital Delivering diversity 1119289111 5481589 Улаанбаатар хот

3. Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд, үргэлжлэл

(л) Түрээс, үргэлжлэл

Түрээсийн өр төлбөрийн хэмжилтэд багтсан түрээсийн төлбөрт дараах зүйлүүд багтана:

- тогтмол төлбөр (мөн чанарын хувьд тогтмол төлбөр хамаарна);
- индекс эсвэл хувь хэмжээнээс хамаарах хувьсах түрээсийн төлбөр, эхний өдөр индекс эсвэл хувь хэмжээг ашиглан хэмжсэн анхны хэмжилтээр
- үлдэх өртгийн үнэ цэнийн баталгааны хүрээнд хүлээгдэж буй өглөгийн дүн
- компанийн худалдан авах сонголтоо хэрэгжүүлэх нь үндэслэлтэйгээр тодорхой бол үг сонголтыг хэрэгжүүлэх үнэ. Үүнд компани түрээсийг сунгана гэж үзвэл сунгалтын нэмэлт төлбөр, түрээсийн хугацааг эрт цуцлах торгууль.

Түрээсийн өр төлбөрийг үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр хэмждэг. Хэрэв индекс эсвэл хувь хэмжээнээс шалтгаалан Компанийн ирээдүйн түрээсийн төлбөр өөрчлөгдөх, үлдэх өртгийн үнэ цэнийн баталгааны хүрээнд хүлээгдэж буй өглөгийн дүнд өөрчлөлт орсон тохиолдолд худалдан авалт хийх, сунгах эсвэл цуцлах эсэхэд өөрчлөлт орсон эсвэл үндсэн түрээсийн төлбөрийг шинэчилсэн тохиолдолд дахин хэмждэг.

Түрээсийн өр төлбөрийг ийм байдлаар дахин хэмжихэд ашиглах эрхтэй хөрөнгийн дансанд холбогдох тохируулгыг хийх ба хэрэв ашиглах эрхтэй хөрөнгийн дансны үнэ тэг болж бүрсэн тохиолдолд ашиг, алдагдал бүртгэдэг.

Компани нь санхүүгийн байдлын тайланд ашиглах эрхтэй хөрөнгийг 'үндсэн хөрөнгө'-ийн ангилалд, түрээсийн өр төлбөрийг 'бусад өглөг'-ийн ангилалд бүртгэдэг.

Богино хугацааны түрээс, бага өртөг бүхий түрээс

Компани бага үнэтэй хөрөнгийн түрээс болон богино хугацаат түрээсийн хувьд ашиглах эрхтэй хөрөнгө болон түрээсийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй байх аргыг сонгосон. Компани эдгээр түрээстэй холбоотой түрээсийн төлбөрүүдийг түрээсийн хугацааны турш шулуун шугамын аргаар зардлаар хүлээн зөвшөөрдөг.

УЛААНБААТАР ХОТ
ШУНХЛАЙ ХХК
ТТА3331 2026 09 09

377

Голомт Капитал ҮЦК ХХК
Golomt Capital
Delivering diversity
1119289111 5401589
Улаанбаатар хот

2026.08.31

4. **Шинэ болон шинэчлэгдсэн Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд**

Тайлант жилд хэрэгжиж эхэлсэн СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудад орсон шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд

Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс гаргасан 2023 оны 01 дүгээр 01-ний өдөр болон тухайн өдрөөс хойш хэрэгжиж эхэлсэн СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудын шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүдийг Компани тайлант жилд хэрэгжүүлсэн.

Хэрэгжиж эхэлсэн хугацаа	Шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд
2023 оны 01 дүгээр сарын 01	• СТОУС 17 Даатгалын гэрээ • НББОУС 1 ба СТОУС Практик Мэдэгдлийн 2-т оруулсан нэмэлт өөрчлөлтүүд - Нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулга • НББОУС 8-ын нэмэлт өөрчлөлт - Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын тодорхойлолт • НББОУС 12-ын нэмэлт өөрчлөлт - Дан ганц ажил гүйлгээнээс үүссэн хөрөнгө, өр төлбөрт хамаарах хойшлогдсон татвар • СТОУС 17 болон СТОУС 9-ийн анхны хэрэгжүүлэлт - Харьцуулагдах мэдээлэл (СТОУС 17-ын нэмэлт өөрчлөлт)
2023 оны 5 дугаар сарын 23	• Олон Улсын татварын шинэчлэл – Хоёр баганат моделийн зарчим – НББОУС 12-ын нэмэлт өөрчлөлт

СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудын шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд нь тайлант жилд Компанийн санхүүгийн байдал болон гүйцэтгэл, санхүүгийн тайлангийн тодруулгуудад материаллаг нөлөө үзүүлээгүй болно.

378

2026.08.31

5. Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудад орсон шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд

Компанийн санхүүгийн тайланг батлан гаргах үед батлагдсан байсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудын шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүдийг дор тодруулсан болно. Компани эдгээрийг хэрэгжиж эхлэхээр хүлээгдэж буй үеэс дагаж мөрдөнө.

Компани санхүүгийн тайланд эдгээр шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд томоохон нөлөө үзүүлэхгүй гэсэн хүлээлттэй байна.

Хэрэгжиж эхлэсэн хугацаа	Шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд
